

**Эрнст Рифгатович Мулдашев:** анагаах ухааны доктор, профессор, Оросын нүдний эмчилгээний болон нөхөн суулгавар мэс заслын төвийн захирал (Уфа хот), Америкийн нүд судлалын академийн гишүүн, Мексикийн итгэмжлэгдсэн нүдний эмч, Олон улсын шинжлэх ухааны академийн гишүүн, спорт аялалын мастер, ЗСБНХУ-ын гурван удаагийн аварга.



Э. Р. Мулдашев - “найджаргүй” болсон өвчинг ( харааны мэдрэлийн үхжилт сахарын шижин өвчнөөс үүссэн эвэрлэгийн өвчин, несөөт эвэрлэгийн өвчин гэх мэт) анагаадаг мэс заслын биоматериал “аллоплант”-ыг зохион бүтээсэн юм.

Э. Р. Мулдашев - дэлхийд алдартай оросын нэрт эрдэмтэн билээ. Тэрбээр 70 гаруй нүдний болон нөхөн сэргээх мэс засал хийсэн. Орос болон гадаадын улсуудад 300 гаруй эрдэм шинжилгээний ажил хэвлүүлэн гаргасан ба Орос, АНУ, ХБНГУ, Франц, Швейцарь, Итали зэрэг орнуудад 52 удаа зохиогчийн эрх авчээ. Түүний ажлууд нь Олон улсын үзэсгэлэнгээс алтан медаль хүртэж байсан юм. Дэлхийн 40 гаруй оронд лекц болон үзүүлэх мэс засалд уригдаж байв.

Тэрээр жилд 300-400 хүнд мэс засал хийдэг байна.

Э. Р. Мулдашев шинжлэх ухааны хүнд төвөгтэй асуудлыг хялбар аргаар тайлах арга билэгтэй хүн юм. Уран зохиолын аястай боловч шинжлэх ухааны гүн агуулга бүхий энэхүү хэний ч сонирхол татах номыг уншигч та бүхэнд санал болгож байгаадаа таатай байна.


Анагаах ухааны доктор, профессор Р.Т.Нигматулин



*Катманду хот дахь буддын сүм дээрх ер бусын нүд  
(Непал)*



*Шинжилгээний ангийн оросын талын оролцогчид  
(зүүнээс баруун): В. Лобанков, В. Яковлева, Э.  
Мулдашев, В. Гафаров, С. Селиверстов*




## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**Офтальмогеометр -  
хүн төрөлхтний  
түүхэн үйл явцыг  
судлах шинэ арга**

Нэгдүгээр хэсэг  
**Бид яагаад бие биенийхээ  
нүд рүү нь ширтдэг вэ?**

Хоёрдугаар хэсэг  
**«Статистикийн дундаж нүд»  
Хүн төрөлхтөн дэлхийгээр  
тархсан нь**

Гуравдугаар хэсэг  
**Төвдийн сүмүүд дээрх нүд  
хэний нүд вэ?**



Нэгдүгээр хэсэг

## **Яагаад бид бие биенийхээ нүд рүү нь ширтдэг вэ?**

Миний нэг найзыг Лобанов гэдэг. Тэрээр угийн маш ичимтгий хүн бөгөөд ярианы үеэр голдуу харцаа буулган газар ширтдэг. Нэгэн удаа би түүний гэрлэлтийн тухай хүндхэн ярианы гэрч болж, сүйт хүүхнийх нь хэлсэн үгэнд анхаарлаа хандуулсан юм.

- Миний нүд рүү хараач, Юра! Яагаад харцаа бууруулаад байгаа юм бэ? Юм нуугаад байгаа юм уу?!

“Тэр яагаад Лобановыг нүд рүүгээ хараач гээд байгаа юм бол оо? - гэж би гэнэт бодов. – Магадгүй тэр түүний нүднээс үгээрээ хэлээгүйг нь олж унших гэсэн юм байлгүй...”

### **Хүний харц**

Үнэндээ ч хүмүүс “Дурласан нүдтэй”, “Нүдэнд нь аймшиг хурсан”, “Гунигтай нүдтэй”, “Нүдэндээ баясгалантай” г.м. байнга ярьдаг. Дуунд хүртэл “Өмнөөс ширтэх энэ нүд...” гэж гардаг.

Нүдний эмчээр ажилладаг учир би өдөр бүр хүний нүд рүү хардаг. Тэгэх болгондоо нүдээр нь дамжуулж нэмэгдэл мэдээлэл хүлээж авах чадвартайгаа анзаардаг.



Бид хүний нүднээс ямар мэдээлэлийг хүлээж авдаг юм бэ? Энэ сэдвээр би ном зохиолд хийсэн судалгаа олсонгүй. Уг асуултанд хариулах зорилгоор би хоёр туршилт хийсэн юм.



Би өндөр боловсролтой хоёр хүнийг тасралтгүй нэгнийхээ хөл рүү ширтээд яриа өрнүүлэхийг хүссэн юм. Хэрвээ яриа нэг их онцгой анхаарал татахуйц бус бол хэдийгээр харилцагчийнхаа нүд рүү харах хүслээс үүдсэн ая тухгүй байдал бий болж байсан ч хүмүүсийн хооронд ойлголцол үүсч байлаа. Харин би сэдвээ сэтгэл хөдөлгөсөн ямар нэгэн сэдвээр солиход “хөл хөлөө ширтсэн” байрлал дахь яриа тэсэхийн аргагүй болж байлаа.

- Би түүний нүдээр ярианых нь үнэн эсэхийг хянах ёстой, - гэж нэг нь санаагаа хэлэв.

“Нүд нүдээ ширтсэн” байрлалд туршилтанд орж буй хоёр тал сэтгэл хөдөлгөсөн сэдэв болон ердийн хүүрнэлийн аль алинд нь маш тухтай ойлголцож байлаа. Энэ туршилтаас би ярилцагчийнхаа нүднээс олж авч буй мэдээлэл нэлээд ач холбогдолтой юм гэсэн дүгнэлт гаргасан.

Хоёр дахь туршилтаараа би нэртэй жүжигчид, улс төрийн зүтгэлтнүүд болон эрдэмтдийн зургийг духны, нүдний болон хамар амны гэсэн гурван хэсэгт хуваасан юм. Алла Пугачёва, Михаил Горбачёв, Олег Даль, Арнольд Шварцнеггер, Альберт Эйнштейн, София Ротару, Владимир Высоцкий, Леонид Брежнев болон бусад нэр төртэй хүмүүсийн фото зураг байлаа.

Тэгээд би долоон хүнд тус тусад нь энэ хүмүүсийн зурагны духны хэсгийг өгч хэн нь хэн болохыг танихыг хүссэн юм. Туршилтанд орогсад бүгд сандарцгааж, ганцхан тохиолдолд л өвөрмөц мэнгээр нь Михаил Горбачёвын дух гэж танив.



Яг ийм маягаар туршилтанд орогсад зурагнуудыг амны хэсгээр таньж чадсангүй. Мөн л ганцхан оролцогч Брежневийг үнсэлцэж байхыг нь насан туршдаа мартахааргүйгээр тогтоосноо ярьж инээгээд түүнийг танив.

Нүдний хэсгээр нь ихэнх тохиолдолд туршилтанд орогсад шууд биш ч гэсэн таньж байлаа. “Энэ Пугачёва байна, энэ Брежнев байна, энэ Высоцкий ...” гэж тэд нүдний хэсгийн зургийг үзэнгээ ярьж байлаа.

Яагаад ч юм бүгдээрээ София Ротаругийн нүдийг танихад бэрхшээлтэй тулгарч байв.

Энэ туршилтаас бид чухам хүний нүдний хэсгээс л бие хүний тухай хамгийн их мэдээллийг авдаг гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Бид нүдний хэсгээс чухам ямар мэдээллийг авдаг юм бэ? Хүний харц нь “задлагч” туяа мэтээр ажиллаж, юм харах үедээ харцаараа объектийг хөндлөн тууш зурсан маш жижиг хөдөлгөөн хийдэг гэдэг нь тодорхой. Чухам ингэж задалсан мэдээлэл хүлээж авдаг нь бидэнд харж буй зүйлийнхээ эзлэхүүн, хэмжээ болон бусад олон зүйлийн тухай ойлгох боломж олгодог.



Нүдний алим нь анатомийн эрхтэн учраас харагдах түвшинд үндсэн дөрвөн хэсгээс тогтоно. Энэ нь бөөрөнхий тунгалаг эвэрлэг, цагаан цөцгий, хүүхэн хараа болон солонго юм. Эдгээр өгөдөл нь хүний оршин байгаа төлөвөөс хамааран өөрчлөгддөггүй. Тийм ч учраас нүдний алимыг задлаж харах нь дээрх асуултанд хариулахуйц хангалттай мэдээлэл өгч чадахгүй.

Үүнд үндэслээд бид хүний нүдний орчмоос нэлэнхүйд нь задалсан мэдээлэл хүлээж авдаг юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм.

Нүдний орчим гэдэгт зовхи, хөмсөг, цох болон нүдний булан ордог бөгөөд эдгээр нь нүдний геометрийн төвөгтэй дүрсүүд үүсгэж хүний оршин буй төлөв байдлаас (өвдөлт, сэтгэл санааны байдал) хамааран байнга өөрчлөгдөж байдаг аж.



Үүнээс үүдээд бид нүдний орчмын геометрийн дүрсүүдийн өөрчлөлтийг ажиглах гэж бие биенийхээ нүд рүү ширтдэг юм байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

Эдгээр задлагдсан офтальмогеометрийн мэдээлэл нүдээр дамжин их тархины хальсан доорхи төвүүдэд очин боловсордог. Боловсорсон мэдээлэл цааш их тархины бор гадаргуунд дүр төрх болон очдог. Эдгээр дүр төрхөөр бид ярилцагчийнхаа тухай ерөнхий төсөөлөл авдаг.

Ямар дүр төрх байж болох вэ? Үүнд юуны түүрүүнд бид ярилцагчийнхаа нүднээс олж хардаг баяр баясгалан, уйтгар гуниг, идэвхи сонирхол г.м. юм. Нүдээр нь бид тухайн хүний яс үндэсний (япон хүн, орос хүн, мексик хүн г.м.) тухай төсөөлөл авч болдог. Мөн зарим нэгэн сэтгэцийн тодорхойлолтуудыг (сэтгэлийн тэнхээтэй, аймхай хулчгар, энэрэнгүй, хор шартай зэрэг) олж харж болдог. Эцэст нь задалсан офтальмогеометрийн мэдээллээс эмч нар өвчтөний биеийн байдал буюу хабитусын тухай ойлгоцтой болдог.

## Офтальмогеометрийн ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өвчний оношийг хабитусаар тодорхойлох арга оношлогооны сайн тоног төхөөрөмж байгаагүй өнгөрсөн зуунд ихээхэн дэлгэрсэн байлаа.

Тэр үеийн эмч нар хүний нүдийг хармагцаа зөв онош тогтоож чаддаг болохын тулд зориуд нүдээ дасгалжуулдаг байжээ.

-За ах минь та ч сүрье тусаж дээ, - гэж тэр үеийн эмч нар нүд рүү нь хараад л хэлдэг байлаа.

Би ч мөн адил эмчийн хувьд зарим нэгэн тохиолдолд өвчний онош болон өвчтөний биеийн байдлын талаар гүйлгэн хараад л нэлээд оновчтой мэдэж болдгийг анзаараад гайхдаг байсан. Ийм тохиолдлуудад бүрэн үзлэг хийлгүйгээр зөвхөн нүд рүү нь харахад хангалттай байдаг.



Эдгээр ажиглалт нь нүдний орчмын өөрчлөлтийн судалгаа нь маш олон асуудлын (сэтгэцийн өвчний оношлогоо болон зарим мэргэжлийн объектив шалгаруулалт г.м. ) хувьд ихээхэн хувь нэмэртэй байж болзошгүйг харуулсан. Гэвч ямар аргаар нүүрний энэ хэсгийг судлах вэ?

Би энэ асуудлаар зарим судлаач эрдэмтдийн сонирхолыг татаж чадсан

Нүүрний нүдний хэсгийг компьютерээр шинжлэх бөгөөд эхний удаад 1500 хүнд судалгаа хийгээд байна.

Хүний "задлагч" харц нүд орчмын геометрийн мэдээллийг авдаг гэж санасны үндсэн дээр бид уг хэсгийн зургийг авч нүдний завсар, зовхи, цох болон хөмсөгний ажиллагааны геометрийн зарчмыг нээхийг хүссэн боловч ерөнхий үзүүлэлт олдсонгүй.

Бид слайд дээр зургийг нь авч, ханан дээр дүрсийг нь буулгаж, мөн зургийг олон дахин томруулсан нөхцөлд судалгаа хийсэн боловч бас л ерөнхий зүйл олдсонгүй.

Цаашлаад бид компьютерийн программ зохиож, нүдний хэсгийг дэлгэцэн дээр буулган энэ хэсгийг тусгай программ ашиглан судалсан юм. Энэ арга нь нүдний геометрийн үзүүлэлтүүдийг илүү нарийвчлалтай гаргаж, санах ойд хадгалж байсан учир хэрэглэхэд илүү тохиромжтой байлаа. Гэвч мөн л ерөнхий зарчим олдсонгүй.


Бид судалгаагаа хэсэг хугацаанд зогсоов. Геометрийн дүрсүүдийг судлах нь маш нуршуугаас гадна тэдгээрийг зөвхөн харьцангуй тоогоор л хооронд нь харьцуулж болох учир статистикийн (тогтсон) мэдээлэлд оруулах боломжгүй байлаа. Энэ санааны төгсгөл нь ойртож байлаа.

Гэвч азаар нэг удаа би офтальмогеометрийн (нүдний дүрс зүйн) судалгаанд ямарч хамаагүй мэт санагдам нэгэн сонин зүйлийг анзаарсан юм.

Би 5 настай жаахан охиныг үзэж байлаа. Тэрээр 28 настай ээжийнхээ өвөр дээр сууж ээж нь түүнийг тайвшруулан эмчийн үзлэгт туслахаар чихэнд нь шивнэж байх зуур би охины нүдний угийг дурандсаар ядраад, толгой өндийн тэр хоёрыг харав. Энэ агшинд би тэр хоёрын нүдний эвэрлэгийн хэмжээ нь биеийн хэмжээ ялгаатайгаас хамааралгүйгээр ижил байхыг анзаарлаа. “Тэдний эвэрлэгийн хэмжээ яагаад адил байна? Логикоор бол жаахан охины нүдний эвэрлэгийн хэмжээ ээжийнхээсээ бага байх ёстой ш дээ!” – гэж бодов.

Гайхшаа бараад би охиныг үзэж дуусгаад, онош тавьж, дүгнэлт бичээд хагалгаа товлов. Дараачийн өвчтөн ээлжээ хүлээн өрөөний босгон дээр зогсож байлаа. “Энэ хүний ч гэсэн нүдний эвэрлэгийн хэмжээ жаахан охиныхтой адилхан байх юм гэж үү?” – гэж би бодон охины нүдийг санан байж түүнийг үзэв.

Түүний эвэрлэгийн хэмжээ мөн л ижил юм шиг санагдсанд тэсэлгүй нарийн бичгийн даргаа дуудан эмнэлгээс өндөр нам, янз бүрийн нас, хүйсийн 20 хүн цуглуулж өгөхийг хүслээ. Хүмүүс цугларахад би дурангаа аван тэдний нүдийг нэг нэгэнтэй нь харьцуулан бүгдийг нь үзэв. Хүмүүсийн нас хүйс, том багаас





шалтгаалахгүйгээр эвэрлэгийн хэмжээ бүгдэд адилхан гэсэн санаа маань батлагдаж байв.

“Сонин юм даа, - гэж би бодоод, - эвэрлэгийн хэмжээ нь хүний биеийн тогтмол (constant) буюу биеийн хэмжилтийн абсолют нэгж болдог юм шиг!”

Миний хажууд манай мэс заслын эмч болох Венера Галимова гэдэг жижигхэн биетэй хөөрхөн эмэгтэй сууж байв. Би түүний хөлийг хараад:

- Венера чи хэдэн размерын гутал өмсдөг вэ?, - гэхэд,


- 35, яасан?

- Харин би 45-ийг өмсдөг. Хоёулаа толинд нэг хараадахъя!

Бид толинд харахад ижил хэмжээний эвэрлэгтэй 2 хос нүд биднийг ширтэж байлаа.

“Сонин юм даа. Хүний биеийн бүх хэмжээ харьцангуй байдаг: хөл, гар, нүүр, биеийн хэмжээ бүгд адилгүй, бүр дотор эрхтэний - элэг, бөөр, ходоод гээд бүгд өөр өөр хэмжээтэй. Тархи хүртэл заримынх нь том заримынх нь жижиг хэмжээтэй. Харин нүдний эвэрлэг л бүгдэд нь ижил байх юм! Эрдэмтдээс хэн нь ч урьд нь үүнийг анзаарч байгаагүй юм байх даа!”

Би тусгай ном хэвлэл шүүсэн боловч энэ сэдвээр дурьдсан юм олсонгүй. Дараа нь би мэс заслын тусгай гортиг ашиглан микроSCOPOOP тавхайн хэмжээ болон гарын алгатай харьцангуйгаар эвэрлэгийн хэмжилтийг олныг хамруулан хийсэн юм. Энэ хэмжилтээрээ бид янз бүрийн түвшин үүсгэж, статистикийн боловсруулалтанд оруулж, тавхай болон алгатай харьцангуйгаар нүдний эвэрлэгийн хэмжээ нь абсолют тогтмол буюу  $10 \pm 0.56$  мм байдгийг олж тогтоов.



Хэт авиагаар шинжлэхэд нүдний алимны хэмжээ нь (нүдний хөндлөн тэнхлэгийн хэмжээ) төрснөөс хойш байнга нэмэгдэж, 14-18 нас хүрэхэд дундаж хэмжээ буюу 24мм болдог. Харин эвэрлэгийн хэмжээ төрснөөс хойш 4 нас хүртэл л тун ялимгүй хэмжээгээр нэмэгдэж, энэ цагаас хойш тогтмол болдог. Өөрөөр хэлбэл нүдний алимны өсөлт нь эвэрлэгийн диаметрийн насны өөрчлөлтөөс түрүүлж явагддаг. Тийм ч учраас хүүхдийн нүд насанд хүрсэн хүнийхээс том санагддаг юм байна.

Яагаад эвэрлэгийн диаметр тогтмол байдаг вэ? Энэ асуултанд хариулахад хэцүү боловч энэ абсолют хэмжигдэхүүнийг офтальмогеометрийн судалгаанд нэгж болгон ашиглаж болох нь тодорхой.

Эвэрлэгийн хэмжээний тогтмолыг офтальмогеометрийн ерөнхий үзүүлэлтүүдийг тодорхойлоход тулгуур цэг болгон ашиглах санаа анх эвэрлэгийн хэмжээ ижил гэдгийг анзаарахад төрсөн юм. Гэвч энэ санаа статистикийн судалгаа болон эвэрлэгийн тогтмолыг тооцоолж нүдний орчим геометрийн дүрс олох оролдлогын дараа эргэлт буцалтгүй бэхэжсэн.



*Нүдний эвэрлэгийн диаметрийн хэмжээ нүүрний хэмжээнээс шалтгаалдаггүй*

компьютер зурагны туршилтанд оролцохыг хүслээ. “Тэдний нүүр царай нь ийм өөр юм чинь нүд нь юугаараа ялгаатай байх бол?” гэж бодогдов.

Бид ерөнхий гинекологич болон Лена Воронинагийн нүүрийг, мөн нэмж хамтран ажиллагч Ольга Ишмитовагийн 14 настай хүүгийн зургийг компьютерийн санах ойд оруулав. Ингээд, бид дээд доод зовхийг шүргэсэн шулуун татахад үүссэн геометрийн дүрсийг шинжлэх ажилд орлоо. Үүссэн дүрс нь том (зовхины гадна муруйг шүргэсэн шулуунуудыг холбож үүссэн), жижиг (зовхины дотор муруйг шүргэсэн шулуунуудыг холбож үүссэн) 2 дөрвөн өнцөгт байлаа. Эдгээр дөрвөн өнцөгтийн хэлбэр болон хэмжээ нь туршилтанд орогсдод бүгдэд нь адилгүй байв. Харин том дөрвөлжин дотор байгаа эвэрлэгийн хэмжээ бүгдэд нь ижил байлаа. Эндээс эвэрлэгийн хэмжээг том жижиг дөрвөн өнцөгтүүдийг болон тэдгээрийн хоорондын харьцааг нь шинжлэх математикийн шинжилгээнд нэгж болгон ашиглах санаа төрсөн юм. Энэ нь эцэстээ дөрвөн өнцөгтүүдийн математик шинж чанарыг тодорхойлох тэгшитгэл болж, энэ тэгшитгэлийн хариугаар уг хүний офтальмогеометрийг илэрхийлсэн нэг тоо гарсан юм.

Ерөнхий гинекологич, Лена Воронина болон хүүгийн эдгээр “офтальмогеометрийн тоо”-г хооронд нь харьцуулахад үлэмж ялгаатай байлаа. Ерөнхий гинекологич 3474 гэсэн тоотой, Лена Воронина 2015, хүү 2776 гэсэн тоотой байв.

Том жижиг дөрвөлжнүүдийн хувийн шинж чанарыг хүн болгоны нүүрний төрхтэй нийцүүлж болох уу? Бид ерөнхий гинекологичийн нүүрний хэлбэрийг янз бүрийн геометрийн дүрсээр илэрхийлэн зурав. Дээрх аргаар Лена болон хүүгийн нүүрийг зурав. Дараа нь бид уг геометрийн дүрснүүд болон том жижиг дөрвөлжнүүдийн хооронд математик уялдаа, зохицол байгаа эсэхийг олохыг


Энэ үед манайд Уфа хотын эмэгтэйчүүдийн эмнэлгийн ерөнхий эмч ирсэн байв. Түүний гадаад төрх буурь суурьтай байдал нь эргэлзээ төрүүлэмгүй: өндөр нуруу, том гэдэс, буржгар сахалтай аварга зууван нүүр ба эрэг духтай. Түүнтэй бараг нэгэн зэрэг миний мэс заслын сувилагч, жижигхэн биетэй, хөөрхөн, Лена Воронина орж ирэв. Тэс өөр энэ хоёр хүнээс би

офтальмогеометрийн

оролдов. Энэ уялдаа нь маш тодорхой байсан болхоор ерөнхий эмчийн дөрвөн өнцөгтүүдийг ашиглан түүний нүүрийг дахин бүтээхэд эх хувьтайгаа тун төстэй гарлаа. Мөн Лена, хүү хоёр дээр үүнийг амжилттай хийж чадав.

Ерөнхийдөө бид хүний нүүрний дүр төрхийг нүдний геометрийн шинж чанараар нь сэргээн босгох зарчмыг ойлгож мэдлээ.


Дараа нь 1500 хүний материал дээр уг зарчмыг батласан боловч хангалттай нарийвчлал тогтоож чадсангүй. Яагаад? Учир нь бид 22 офтальмогеометрийн үзүүлэлт байдгийг тогтоосон боловч дөрвөн өнцөгтүүд нь эдгээрийн дөнгөж 2 нь байлаа. Гэвч 22 үзүүлэлтийг нэгэн зэрэг шинжлэх нь бидний хүч хүрэмгүй хүнд асуудал байсан.



*Нүдний хэсгийн офтальмогеометрийн үзүүлэлт*

Түүнээс гадна эдгээр үзүүлэлт нь хүний сэтгэл хөдлөл, биеийн байдал болон өвдөлт зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр байнга өөрчлөгдөж байдаг.

Хүний их тархины угт байрладаг офтальмогеометрийн мэдээлэл боловсруулагч бяцхан зангилаанууд ямар агуу их тооцоолон бодох хүчин чадалтай байх нь ойлгомжтой. Эдгээр зангилаа мэдээллийг хормын дотор боловсруулж их тархины гадарт дүр төрх, сэрэл мэдрэмж болгон дамжуулдаг. Эдгээр бөөмсийн хэмжээ нь (1 см орчим) орчин үеийн компьютерийн хэмжээтэй харьцуулшгүй жижиг. Тархины энэ тооцоолон бодох гайхамшгийг бүтээсэн Бурхан юутай агуу!



*Офтальмогеометрийн мэдээллийг хүний тархи боловсруулж байгаа нь*

Харин бид оршин буй 22 үзүүлэлтээс зөвхөн 2-г л боловсруулж чадлаа. Гэвч энэ өчүүхэн математик ололт офтальмогеометрийн шинж чанар нь мэнгэ шиг цэвэр бодгалийн шинж чанартай гэж зоригтойгоор хэлж чадахуйц болгосон юм. Уг офтальмогеометрийн “мэнгэ” нь сэтгэлийн хөдөлгөөн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр байнга хувирч байдаг боловч ерөнхийдөө төрөлхийн бодгаль шинж чанараа хадгалсаар байдаг.

Үүнтэй зэрэгцээд офтальмогеометрийн үзүүлэлтүүд нь нүүрний геометрийн шинж тэмдэгүүдтэй болон биеийн зарим хэсгүүдийн шинж тэмдэгтэй холбоотой. Ийм учраас хүний дүр төрхийг түүний нүдний хэсгийн геометрийн шинж

чанараар нь дахин бүтээж болно. Үүнтэй холбоотойгоор бид хүний нүд рүү хараад түүний тухай их юм хэлж чаддаг ажээ.

Эцэст нь хэлэхэд хүний биеийн цорын ганц тогтмол болох эвэрлэгийн диаметр нь офтальмогеометрийн бүдүүвчинд байрласан нь офтальмогеометрийн хэмжилтийн цорын ганц нэгж бол энэ юм гэж хэлэх мэт.

Нүдэнд хүний бие махбодь болон тархинд болж байгаа бүх зүйл тусгагддаг. Энэ “бүх зүйл” нь нүдний орчмын 22 (магадгүй түүнээс ч олон) үзүүлэлтийн өөрчлөлтөөр илэрдэг. Мэдээж ирээдүйд офтальмогеометрийг маш сайн судалж, энэ нь анагаах ухаан болон сэтгэл зүйн маш олон асуултанд хариулт өгөх болно. Байгаль өөрөө үүнийг шаардаж байна.

Офтальмогеометрийг хүний сэрэл мэдрэмжийн математик дүрслэл гэж тодорхойлж болно.


Хүний харц “задлагч” туяа мэт ажиллаж, хөмсөг, зовхи нүдний алим зэргийн үл ялиг хөдөлгөөнөөр бидний сэрэл мэдрэмж болон хувь хүний шинж чанар нь харагддаг нүдний хэсгийн мэдээллийг буулгадаг.

Бид бие биенийхээ нүдийг (өөрөөр хэлбэл нүдний орчмыг) хардаг нь сэрэл мэдрэмжийн тусламжтайгаар хувь хүний шинж чанарыг мэдэх гэсэн зорилготой байдаг.

Нөгөө талаас бид нэгнийхээ нүднээс телепатын шинжтэй мэдээлэл хүлээж авдаг байж болзошгүй. Тийм байсан ч бид нүдний хэсэг дэхь офтальмогеометрийн мэдээлэл солилцоог үгүйсгэж болохгүй.

## Офтальмогеометрийг хэрэглэх нь

Офтальмогеометрийг практикт доорхи байдлаар хэрэглэх боломжтой. Бие хүнийг тодорхойлох, хүний дүр төрхийг сэргээн бүтээх, бие хүний сэтгэцийн шинж чанарыг тодорхойлох, хүний сэрэл мэдрэмжийн объектив шинжилгээ, сэтгэцийн өвчний оношлогоо, биеийн өвчний оношлогоо, яс үндэс болон ... хүний үүсэл гарлыг тодорхойлох г.м.



*Хувь хүнийг офтальмогеометрийн үзүүлэлтээр тодорхойлох*

1. Бие хүний тодорхойлолтын хувьд: офтальмогеометрийн үзүүлэлтээс хоёроор (22-оос) нь хувь хүний зөвхөн өөрийнх нь шинж чанарыг илэрхийлсэн тодорхой тоотой гардгийг баталсан хангалттай баримт бий. Статистикийн судалгаагаар уг тоо нь офтальмогеометрийн компьютерийн давтан зураг

авалтаар гарсан тооны давтамжтай таарсан учир энэ нь уг хүний индивидуаль (хувийн) тоо мөн болох нь батлагдсан. Миний бодлоор офтальмогеометрийн үзүүлэлтийн тоо нэмэгдэхэд индивидуаль тооны магадлал бас нэмэгдэнэ.

Бие хүнийг тодорхойлох зорилгоор офтальмогеометрийн компьютерийн зураг авах үедээ сэтгэлийн хөдөлгөөний хүчин зүйлийг багасгахын тулд шинжилж буй хүнээ тайван тогтвортой төлөв байдалд байлгах шаардлагатай.

Бие хүнийг тодорхойлох нүүрний зураг авалт болон дактилоскопын гэсэн 2 үндсэн арга байдаг. Офтальмогеометрийн аргаар бие хүнийг тодорхойлох арга нь эдгээр аргын нэмэлт болж болох бөгөөд хүн гадаад төрхөө өөрчилж, хуруугаа гэмтээсэн тохиолдолд хэрэглэхэд үр дүнтэй арга юм. Цэрэг, цагдаа, банк зэрэг байгууллага ирээдүйд энэ аргын хэрэглэгч нь болж магадгүй.



2. Офтальмогеометрийн өгөгдөхүүнээр хүний дүр төрхийг бүтээх аргыг хэдхэн хүн дээр туршсан боловч хангалттай магадлалтай нь харагдсан. Яагаад бид энэ талын судалгаагаа үргэлжлүүлэхгүй байна вэ гэвэл түвдийн сүм дээр зурагдсан нүдний өгөгдөхүүнээр уг хүний дүр төрхийг бүтээх явцдаа бид цаашдын бүх судалгаагаа хүний үүсэл гаралд хандуулахад хүргэсэн маш сонирхолтой үр дүнд хүрсэн юм. Гэвч энэ тухай жичдээ бичих болно.




3. Хүний сэтгэцийн шинж чанарыг тодорхойлох офтальмогеометрийн арга нь нисгэгч, сансрын нисгэгч, мэс засалч зэрэг мэргэжлийн хүмүүсийг сонгоход маш тохиромжтой. Амьдрал дээр шалгуур байдаг боловч энэ нь объектив бус субъектив шинж чанартай. Өөрөөр хэлбэл шалгуулагчаасаа хамаардаг.

Уг аргыг судлахын тулд бид дараахь шинж чанар илт илэрсэн хүмүүсийг сонгон авч судалгаанд хамруулсан. Үүнд: сэтгэлийн тэнхээтэй, энэрэнгүй, хулчгар, хор шартай; Эдгээр бүлэг тус бүрд 6 хүн авсан. Жишээ нь: эрч хүчтэй хүмүүсийн бүлэгт тэдэнд уг чанар бий гэдгийг бид сайн мэдэх 6 хүнээ оруулсан. Бусад “хулчгар”, “энэрэнгүй”, “хор шартай” гэсэн хүмүүсийн бүлгийг мөн л энэ зарчмаар сонгож оруулсан. Офтальмогеометрийн үнэлгээ нь дээр өгүүлсэн том жижиг 2 дөрвөн өнцөгтийн шинжилгээ юм. Үүнээс дараах зүй тогтол илэрсэн:

“Сэтгэлийн тэнхээтэй” хүмүүсийн том жижиг дөрвөн өнцөгтүүд нь ижил талтай, өнцгүүд нь шинжээрээ хоорондоо маш төстэй байсан бөгөөд жижиг дөрвөн өнцөгт нь том дөрвөн өнцөгтийнхөө төв хэсэгт нь байрласан байв.

“Хулчгар” бүлгийн хүмүүсийн том дөрвөн өнцөгт нь сууриараа доош харсан гурвалжинтай төстэй, харин жижиг дөрвөн өнцөгт нь сууриараа дээш харсан гурвалжинтай төстэй байсан. “Сэтгэлийн тэнхээтэй” болон “Хулчгар” бүлгийн хоорондын ялгаа статистикийн баталгаагүйгээр тодорхой байлаа.

“Энэрэнгүй” бүлгийн хүмүүсийн том дөрвөн өнцөгт нь ромбо хэлбэртэй, жижиг дөрвөн өнцөгт нь мөн өнцгөн дээрээ тогтож буй ромбын хэлбэртэй бөгөөд том дөрвөн өнцөгтийнхөө төвд байрласан байв.

**СЭТГЭЛИЙН ТЭНХЭЭ****ХУЛЧГАР****САЙХАН СЭТГЭЛ****ХОР ШАР**

“Хор шартай” бүлгийн хүмүүсийн том дөрвөн өнцөгт нь нарийсч, жижиг дөрвөн өнцөгт нь сууриараа дээш харсан гурвалжинг үүсгэдэг. “Энэрэнгүй” болон “Хор шартай” хүмүүсийн хоорондын ялгаа нь маш тодорхой харагдаж байлаа.

Эдгээр судалгаа нь мэдээж бүрэн төгс биш бөгөөд судалгаанд хамрагдсан хүний тоо цөөнөөс шалтгаалан бүдүүн баараг юм. Гэсэн ч эдгээр баримт нь дараах шалтгааны улмаас маш их сонирхол татаж байлаа. Нэгдүгээрт, сэтгэлийн тэнхээтэй хүмүүс ихэнхдээ энэрэнгүй байдаг гэсэн ойлголт төрсөн. Хоёрдугаарт, ихэнх аймхай хүмүүс хор шартай байдаг (ижилхэн жижиг дөрвөлжин) бөгөөд ихэнх хор шартай хүмүүс аймхай гэсэн дүгнэлт гаргаж болно.

Мэдээж энэ дөрвөн шинж чанараас гадна завсрын маш олон шинж байдаг бөгөөд тэдгээрийг мөн офтальмогеометрийн аргаар тодорхойлж болно. Үүнээс гадна хүний сэтгэцийн маш олон шинжийг энэ аргаар тодорхойлж болно.

4. Сэрэл мэдрэмжийн объектив судалгааг өнгөц хэлбэрээр явуулсан боловч үр дүн нь ихээхэн сонирхол татахуйц болсон.

Мэдрэмж гэж юу вэ? Энэ бол хайр, үзэн ядалт, сэтгэл дундуур, хангалуун байдал гэх мэт юм. Зохиолч, яруу найрагчид хүний мэдрэмжийг илэрхийлдэг. Хэдийгээр өвдөж буй бие махбодид мэдрэмжийн элемент байнга оршдог боловч

эмч нар хүний мэдрэмжийг голдуу орхигдуулдаг. Эх хүн хүүхдийнхээ өвчнийг хайраараа эмчилдэг гэсэн зүйр цэцэн үг хүртэл байдаг.

Офтальмогеометрийн аргаар хүний дурласан эсвэл зэвүүцлийн түвшинг хэмжиж болно гэж үү? Офтальмогеометрийн шинэ шинэ үзүүлэлт компьютерийн шинжилгээнд орохын хэрээр ингэх боломж бүрдэнэ гэж би бодож байна.

22 үзүүлэлтийн зөвхөн 2-оор нь шинжилгээ хийж буй одоо үед энэ судалгаа нь нарийвчлал багатай учир хэрэглэхэд тохиромжгүй.

Сэрлийг (өвдөлт, сул байх, эрч хүчтэй байх г.м.) дээр дурьдсан хоёр үзүүлэлтээр хангалттай нарийвчлалтайгаар тогтоож болно. Гэвч тодорхой стастистикийн судалгаа хийх санаа дутсанаас бид уг судалгааг хийж чадсангүй.

Ямар ч байсан манай төв бол мэс заслын клиник учир ихэнх цаг зав, эрч хүч маань мэс заслын бэлтгэл болон үйл ажиллагаанд зарцуулагддаг.



Гэхдээ сэрэл мэдрэмжийн офтальмогеометрийн шинжилгээ нь АУ-аар ч зогсохгүй шинжлэх ухааны бусад салбарт шинэ зорилтыг нээх боломж олгоно. Сэтгэц судлалд энэ нь өвөрмөц онцгой ач холбогдолтой. Сэтгэц судлал нь цаашдаа математик офтальмогеометрийн аргуудыг гаргууд эзэмшсэн салбар болох магадлалтай.

5. Сэтгэцийн өвчний оношлогоог хийхдээ бид шизофрени гэсэн оноштой хэд хэдэн хүнд шинжилгээ хийсэн. Том дөрвөн өнцөгтийн хувьд ижил төстэй өөрчлөлт олсонгүй. Харин жижиг дөрвөн өнцөгт нь шинжилгээ хийлгэсэн бүх хүнд сууриараа дээш харсан гурвалжинтай төстэй хэлбэртэй болсон байсан. Гэвч зөвхөн жижиг дөрвөн өнцөгтийн өөрчлөлтөөр шизофрения гэсэн онош тавих нь утгагүй. Багцаалж үзсэн ч математикийн онцгой ажиллагаа шаардах офтальмогеометрийн илүү олон үзүүлэлтийг судлах хэрэгтэй байлаа.

Сэтгэцийн гажгийг офтальмогеометрийн аргаар оношлох нь миний бодлоор их ирээдүйтэй. Учир нь орчин үеийн оношлогоо нь асуулт хариултанд үндэслэсэн цэвэр субъектив аргыг үндсэн арга барилаа болгодог. Уг субъективизм нь дэлхий даяараа сэтгэцийн эмгэгтэй эсэхэд эргэлзэхэд хүргэж байна (Сталины үеийн репресс болон олон зуун эрүүгийн баримтыг эргэн сана даа).

Офтальмогеометрийн аргыг уг салбарт нэвтрүүлэх нь сэтгэл мэдрэлийн өвчний оношлогоонд тус болохуйц нэмэлт объектив мэдээлэл авах боломжтой болгоно.

6. Офтальмогеометрийн аргаар биеийн өвчний оношилгоог тогтоохдоо элэгний хатууралтай дөрвөн өвчтөн, мөн өмөн үүгийн сүүлийн шатан орсон дөрвөн хүн дээр судалгаа явуулсан. Хавдартай хүмүүст том жижиг дөрвөн өнцөгтөд нь ямар нэгэн өөрчлөлт байсангүй. Харин элэгний хатууралтай

хүмүүсийн жижиг дөрвөн өнцөгт нь сууриараа дээш харсан гурвалжин хэлбэртэй болсон байсан. Энэ нь элэгний хатуурлын оношлогооны шинж тэмдэг болж чадах уу? Мэдээж чадахгүй. Жижиг дөрвөн өнцөгт нь гурвалжин болох үзэгдэл “аймхай”, “хор шартай”, “шизофреник” гэсэн гурван бүлгийн хүмүүст мөн ажиглагдсан. Энэ тухай бодоод үзье л дээ! Энэ хүмүүсийн хувьд нийтлэг шинж гэвэл ямар нэг сөрөг цэгийн илрэлтэй: биеийн (элэгний хатуурал), сэтгэцийн өвчин (шизофрени) эсвэл сэтгэцийн сөрөг шинж тэмдгүүд (хулчгар байдал, уур хилэн) байв. Эндээс жижиг дөрвөн өнцөгт нь сэтгэцийн ямарваа нэгэн сөрөг энергийг таниулагч индикаторын үүрэг гүйцэтгэдэг юм уу гэсэн таамаглал гаргаж болно.


Уг судалгааг хийж байх үедээ би дорно дахины анагаах ухааны эмчилгээний үндэс нь биеийг сэтгэцийн сөрөг энергээс чөлөөлөх явдал юм гэдгийг мэддэггүй байлаа. Дорно зүгт тэгтлээ их номлодог хайр, өрөвч сэтгэл зэрэг нь зөвхөн хулчгар байдал болон уур хилэнг эсэргүүцэх хамгаалалт болоод зогсохгүй мөн өвчин үүсэхийг эсэргүүцэх чадвартай гэдгийг гадарласан ч үгүй. Мөн тэр үед хүн сэтгэцийн сөрөг энергээсээ ангижирч чадвал самади буюу амьд хүний биеийг хэдэн мянган жилээр хадгалах гайхамшигт чадварт хүрч болдгийг хамгийн уран зөгнөлт зүүдэндээ ч зүүдэлж байсангүй.

Биеийн өвчлөлийг офтальмогеометрийн аргаар оношлох тухайд би одоохондоо юу ч хэлж чадахгүй. Судалгааг үргэлжлүүлэх хэрэгтэй.

7. Хүний яс үндсийг офтальмогеометрийн аргыг ашиглан зөв тодорхойлж болдог нь харагдсан. Том жижиг дөрвөн өнцөгтийн шинжээр хятадуудыг европчуудаас, негрүүдийг индонезчүүдээс ялгаад зогсохгүй илүү нарийвчлалтай тодорхойлолт гаргаж болно.

Бид дэлхий дээр орших олон ястан үндэстний дунд шинжилгээ хийх үедээ энэ асуудалд нилээд дэлгэрэнгүй хандсан. Харин үүнийг шинжлэх болсон шалтгаан нь бид хүний үүсэл гарвалыг офтальмогеометрийн үүднээс авч үзэхээр шийдсэнд оршино. Энэ тухай дараагийн бүлэгт жич авч үзнэ.

Энэ бүлгийн төгсгөлд хэлэхэд: Бид зөвхөн сониуч зандаа хөтлөгдөн нэгнийхээ нүд рүү ширтдэггүй. Ярилцагчийнхаа нүднээс тухайн хүний сэрэл



*Шизофрени*



*Элэгний хатуурал*



мэдрэмжийг тусган хором тутамд өөрчлөгдөн хувирч байдаг нүдний орчмын офтальмогеометрийн үзүүлэлтээс мэдээлэл авч байдаг. Бид дотоод ухамсарынхаа түвшинд уг мэдээллийн геометрийн дүрсүүдэд шинжилгээ хийснээр ярилцагчийнхаа эрүүл мэнд, бодол санаа, сэрэл мэдрэмжийн тухай өөрийнх нь ярианаас хамааралгүй нэгэн сэтгэгдэлтэй үлддэг. Ийм учраас хэрвээ та нууц бодолгүй нээлттэй хүн баймаар байвал хар нүдний шил зүүлгүйгээр үргэлж ярилцагчийнхаа нүд рүү нь харж байгаарай. Тэгвэл та хүнд хүчтэй, шударга гэсэн сэтгэгдэл төрүүлэх болно.



*Зорилго нэгтнүүд*

Хоёрдугаар хэсэг


## **“Статистикийн дундаж нүд” Хүн төрөлхтөн дэлхийгээр тархсан нь**

Өмнөх бүлэгтээ би офтальмогеометрийн аргаар хүний яс үндсийг судалж болдог тухай дурдсан.

Үндэстэн арьстан хэрхэн үүссэн нь маш сонирхолтой асуулт юм. Хүн дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт амьдардгаас шалтгаалан хүний гадаад төрх өөрчлөгдөх зүй тогтолтой юу? Хүний үүслийн төв нь хаана байдаг вэ? Бид хэнээс үүссэн бэ?

Эдгээр асуултанд маш олон эрдэмтэн хариулахыг оролдож иржээ. Зарим нь хүнийг бурхан бүтээсэн гэж батлахыг хичээсэн (идеалистууд) байхад нэг хэсэг нь сармагчингаас үүссэн гэж үздэг (дарвинист-материалистууд). Сүүлчийн эрдэмтдийн дунд янз бүрийн үндэстэн арьстан сармагчны өөр өөр төрөл зүйлээс гаралтай гэж үздэг хүмүүс ч бий.

Хүний үндэстэн арьстны олон янзын ангилал байдаг. Францын эрдэмтэн Кювье цагаан, хар, шар гэсэн 3 төрлийн арьстныг ялгасан байдаг бол Деникер (1902) дэлхий дээр 29 төрлийн арьстан байдаг гэж үздэг байжээ. Британий нэвтэрхий тольд (1986) 16 төрлийн арьстныг ялгаж бичсэн байдаг. Миний бодлоор бүрэн дүүрэн суурь ангиллыг зөвлөлтийн эрдэмтэн А. Ярхо (1935,1936)



хийсэн. Тэрээр хүн төрөлхтний 35 арьстан үндэстнийг ялгаж, уг судалгаандаа үндэстэн нэг бүрийн төлөөлөгчийн зургийг хавсаргажээ.

Хүний үүслийг судалж эхлэхдээ бид А. Ярхогийн номон дээрээс бүх 35 арьстны зургийг буулгаж аваад, нүдний хэсгийг нь хайчилж авсан юм. Дараа нь бид эдгээр зургаа сканнерын тусламжтайгаар компьютерт оруулан офтальмогеометрийн шинжилгээ хийв. Өөр өөр арьстны офтальмогеометрийн ялгаа үлэмж байгаа нь харагдаж байлаа. Гэвч энэ дундаас ямар нэгэн математик зүй тогтол олж болох уу?

### **“Статистикийн дундаж нүд”**

Уг асуултанд хариулахын тулд бид бүх зурагны “статистикийн дундаж нүд”-ийг олохыг оролдов. Эвэрлэгийн тогтмол нь уг тооцоог абсолют тоо болгох боломж олгож байсан нь сайн хэрэг. Тооцоогоо дууссаны дараа бид үнэхээр гайхав. “Статистикийн (харьцангуй тогтмол)

дундаж нүд” төвд үндэстнийх гэдэг нь тодорхой болов!

- Николай Рерихийн зөв юм гэж үү?-гэж би дуу алдав.

Би багаасаа Рерихийг уншдаг, түүнийг оросын шинжлэх ухааны шүтээн гэж боддог байсан. Тэрээр хүн төрөлхтөн Төвдэд үүсч тэндээсээ дэлхийн бөмбөрцгөөр тархсан гэсэн таамаглал дэвшүүлсэн хэд хэдэн Түвд Гималайн шинжилгээний ангийг (экспедици) 1925-1935 оны хооронд зохион байгуулсан.

А.Рерих үүнийг түүхийн болон шашны баримтуудад үндэслэн гаргаж ирсэн.

Харин бид олон арьстан үндэстний нүдэнд математикийн шинжилгээ хийхэд нүдний офтальмогеометрийн статистикийн дундаж мөн л төвд үндэстний нүд



Н. К. Перух

болон давхцав. Энэ зүгээр тохиолдол уу? Эсвэл үүнд ямар нэгэн шууд хамаарал байна уу? Энэ сэдвээр хэлэлцэж байхдаа өөр өөр үндэстний нүдний математик утга нь статистик дундаж нүдэнд ойртсон түвшингээр нь хуваарилах гэж оролдсон боловч эхэндээ ер болсонгүй. Дэлхийн олон арьстны нүдний офтальмогеометрийн




Түвд нүд  
«Статистикийн дундаж нүд»

үзүүлэлтүүд нь нэг шугамд жагсаж өгөхгүй байлаа. Төвд үндэстний “статистик дундаж” нүднээс дөрвөн үндсэн зүгт хуваарилахад л энэ зорилтоо биелүүлж чадсан юм.

Өөрөөр хэлбэл армены, памирын, өмнөд азийн, палеосибирийн гэсэн дөрвөн төрлийн арьстанууд “статистикийн дундаж” нүдэнд тоон утгаараа ижил түвшинд дөхөж очсон.

Бусад гурван төрлөөсөө армен нь төвд үндэстний нүдтэй тоон утгын ойртолтын түвшингээрээ бага байсан боловч уг төрлийг төвд үндэстний хажууд



байрлуулахгүйгээр дэлхийн үндэстнүүдийг “статистикийн дундаж” нүдэнд тоон утгын ойртолтын түвшингээр нь хуваарилсан бүдүүвч гаргаж болохооргүй байсан.

Ингээд 4 үндэс нь тодорхой болсоны дараа хүн төрөлхтний арьстныг үүнийхээ дагуу “статистикийн дундаж” нүдэнд тоон утгын ойртолтын түвшингээр хуваарилахад маш эвтэйхэн систем үүсэв.

Дараа нь бид эдгээр хүмүүсийн зургийг газрын зураг дээр түүхэн амьдарч байсан газар нь байрлуулж, тоон шинж чанарын хувьд дөхсөн түвшнийх нь дагуу шулуунаар холбоход дэлхийн бөмбөрцөг дээрх хүн төрөлхтний нүүдлийг харуулсан офтальмогеометрийн бүдүүвч зураг гарч ирэв.

### **Дэлхийн бөмбөрцгөөр хүн төрөлхтөний нүүдэллэсэн замууд**

Тэгэхээр, офтальмогеометрийн баримтаас үзэхэд (энэ нь хүн төрөлхтөний арьстаны цэвэр тоон шинжилгээ юм) хүн төрөлхтөн Төвдөд үүсч, тэндээсээ дараахь 4 чиглэлээр тархсан байна.

- А чиглэл: Сибирь – Америк – Шинэ Зеланд
- В чиглэл: Тайланд – Индонези – Австрали
- С чиглэл: Памир – Африка
- D чиглэл: Кавказ – Европ – Исланд.

Хүн төрөлхтөн Төвдөөс нүүдэллэн тарсан эдгээр чиглэл бүрийн арьстны төрөл болгоны нүдний офтальмогеометрийн үзүүлэлтүүдийн “статистикийн дундаж нүдэнд” тоон шинж чанарын хувьд ойртох түвшний өөрчлөлтөд нарийн зүй тогтол ажиглагдаж байлаа. Өөрөөр хэлбэл эдгээр чиглэл бүрт хүн төрөлхтний арьстан үндэстний төлөөлөгч бүр хоёр талынхаа төлөөлөгчидтэй офтальмогеометрийн үзүүлэлтээр хамгийн ойролцоо байхаар байрласан бөгөөд төвдөөс холдох тусмаа төвдийн нүднээс тоон шинж чанарын ялгаа өсөж байхаар байрлуулсан.


Харин одоо нүүдлийн чиглэл бүрийг дэлгэрүүлэн зарим нэгэн түүхийн баримттай харьцуулж үзье.

### **Нүүдлийн А чиглэл**

Бидний судалгаагаар нүүдлийн энэ чиглэл нь хамгийн том (Сибирь – Америк – Шинэ Зеланд) бөгөөд үүнд Төвдийн дараа палеосибирийн, урал-алтайн, лапаноидын, балтийн, өмнөд сибирийн, төв азийн, эскимосын, манжуур-солонгосын, атлантын, өмнөд америкийн, палеоамерикийн, патагоны, номхон далайн, төв америкийн болон полинезийн гэсэн арьстан үндэстэн орно.


Мөн нүдний өөрчлөлтийн үндсэн чиглэлээс хэд хэдэн салаалсан чиглэл үүссэнийг жагсаавал: Урал-алтайн үндэстнүүдээс лапаноидын ба балтийн үндэстнүүд (нүдний өөрчлөлтийн дагуу цувран) үүссэн. Өмнөд сибирийн

ТҮВДЭС НҮҮДЭЛЛЭСЭН ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ  
НҮҮДЛИЙН ЗУРАГ



Э. Мулдашев (1996)

## НҮҮДЛИЙН А ЧИГЛЭЛ




- |      |                      |      |                    |
|------|----------------------|------|--------------------|
| A1   | - палеосербийн       | A4   | - атлантын         |
| A2   | - уралоалтай         | A5   | - өмнөд америкийн  |
| A2/1 | - лапаноидийн        | A6   | - палеоамерикийн   |
| A2/2 | - балтийн            | A7   | - патагоны         |
| A3   | - өмнөд сибирийн     | A7/1 | - номхон далайн    |
| A3/1 | - төв азийн          | A8   | - дундад америкийн |
| A3/2 | - эскимос            | A9   | - полинезийн       |
| A3/3 | - манжуур-солонгосын |      |                    |

үндэстнүүдээс төв азийн, эскимосын болон манжуур-солонгосын үндэстэнүүд (тус тусдаа) үүссэн бөгөөд патагоны үндэстнүүдээс номхон далайн үндэстнүүд үүссэн байна.

Би түүхч биш, шинжлэх ухааны хийсвэр шинжлэхүйн эрхэнд л миний хувьд мэргэжлийн бус энэ салбарыг хөндөх болсон зүгээр л нэг нүдний мэс заслын профессор хүн. Тийм ч учраас одоо үед эдгээр үндэстнүүдэд ямар ямар яс үндэстэн харъялагдагийг би нарийн хэлж чадахгүй. Юутай ч Төвдөөс хүн төрөлхтний нүүдэллэсэн эдгээр болон бусад замуудыг товчхон бичихээр зориглоё. Миний цаашид гаргах алдаануудыг түүхч эрдэмтэд маань өршөөх буй заа!


А чиглэлийн дагуу хүн төрөлхтөн Төвдөөс хойд зүгт нүүдэллэхэд амьдралын шинэ орчин гадаад төрх, ялангуяа нүдний хэсэгт ул мөрөө үлдээжээ

## НҮҮДЛИЙН А ЧИГЛЭЛ





## НҮҮДЛИЙН А ЧИГЛЭЛ (үргэлжлэл)



(палеосибирийн). Палеосибирийн уг үндэстнүүдээс одоогийн алтайчууд болон башкир үндэстнүүд болох урал-алтайн үндэстнүүд үүссэн.

Урал-алтайн үндэстнүүд нь баруун зүгийн мухар салбар лапаноидыг (лопари) болон балтийн арьстан үндэстнүүдийг үүсгэсэн. Миний бодлоор балтийн арьстан үндэстнүүдийн орчин үеийн төлөөлөгч нь финнчүүд бөгөөд тэд мөн одоогийн татарчуудын өвөг дээдэс (магадгүй лапаноидчуудтай ижлээр) байх боломжтой. Мөн уг мухар салбарт нь одоогийн унгар, эстончууд хамаарна.

Уг системийн офтальмогеометрийн өөрчлөлтийн дараагийн үе шат нь Сибирь болон Казахстаны нутгаар өргөн тархсан өмнөд сибирийн үндэстнүүд юм. Миний үзэж байгаагаар уг үндэстний орчин үеийн төлөөлөгч нь казахчууд болон хойд зүгийн олон ард түмэн (ненци, якут, чукча г.м.) юм. Өмнөд сибирийн арьстан үндэстнүүд төв азийн, эскимосын болон манжуур-солонгосын гэсэн бие даасан гурван мухар салбарыг үүсгэсэн. Төв азийн салбарын төлөөлөгч нь минийхээр бол одоогийн монголчууд юм. Манжуур-солонгосын салбарын үндэстнүүд нь өнөөгийн япон, солонгосчууд болон хойд хятадуудын өвөг дээдэс нь болжээ. Эскимосын мухар салбарын үндэстнүүд Чукотка, Аляска болон Канад, Гренландын хойд эргийн дагуу тархжээ.

Өмнөд сибирийн арьстан үндэстнүүд мөн Америк тив рүү тархаж тэндээ атлантын үндэстнүүдийг (хойд америкийн индианууд) үүсгэсэн. Хүн төрөлхтөн Америк тивд хойноос урагш тархах үед арьстан үндэстнүүдийн шилжилт явагдсан. Офтальмогеометрийн баримтаар бол атлантын үндэстнүүдээс өмнөд америкийн үндэстнүүд Хойд Америкт үүсэж, тэндээсээ ямар нэгэн өөрчлөлтгүйгээр тус тивийн Өмнөд хэсэг рүү нүүдэллэсэн. Өмнөд америкийн үндэстнүүдээс палеоамерикийн үндэстнүүд, тэднээс патагоны үндэстнүүд үүсч, тэр нь номхон далайн үндэстнүүдийн мухар салбарыг үүсгэсэн. Офтальмогеометрийн баримтаар патагоны үндэстнүүд нь өмнөд хэсгээс төв Америкт шилжин суурьшсан төв америкийн үндэстнүүдийг үүсгэсэн нь одоогийн мексикчүүд (ацтекүүд, майя) юм.

Нүдний өөрчлөлтийн дэс дарааны системээр бол төв америкийн үндэстнүүдээс полинезийн арьстан үндэстэн үүсжээ. Тэр нь хөвөх төхөөрөмж бүтээж түүгээрээ Номхон Далайг гэтлэн холын Шинэ Зеландад хүрч чадсан байна. Үүнд Номхон Далайг зэгсэн завь "Ра"-гаар гаталж болдгийг баталсан Тур Хейрдалаг дурсахгүй байхын аргагүй. Ингэхээр Шинэ Зеландын аборигенчүүд дэргэдэх Австралиас биш харин (офтальмогеометрийн судалгаагаар) холын Өмнөд Америкаас ирсэн болж таарлаа.

Мөн Шинэ Зеландын лоло овог Төвдөд очсон тухай би уншсан юм байна. Ингээд тойрог битүүрлээ.

Офтальмогеометрийн бүдүүвч нь түүхийн баримтуудтай таарах болов уу? Түүхчид улс үндэстнийг тэдний хэл соёлын онцлогоор нь авч үздэг. Гэвч миний бодлоор энд нэг учир дутагдал байна. Хэлийг ойр зэргэлдээ харилцдаг улс

үндэстнүүдээс авч болно. Жишээ нь: Ихэнх оросын бага ястнуудын хувьд орос хэл гол, бүр цорын ганц хэл нь болсон байдаг (Чувааш, Мордва, Коми болон бусад олон ястан зөвхөн оросоор ярьж орос хэлийг эх хэлээ гэж үздэг). Улс үндэстнүүдийн хоорондын ойр дотно харьцааны улмаас тус тусын соёлд ч бас өөрчлөлт ордог.

Үндэстэн арьстан, ард түмний талаарх ойлголт бол маш ээдрээтэй асуудал. Ямар ч гэсэн харьцуулалт хийх гээд оролдъё.

Москвэд би хэдэн финн болон япон хүмүүстэй тааралдаад, тэднийг улс үндэстний ярилцлаганд оролцохыг урьсан юм. Өндөр цайвар үстэй финн ба намхан хар үстэй япон эрс сониучирхан нэг нэгнийгээ ажиглан, магадгүй хэн нь хэнээс үүссэн тухай бодож суув.

- Ноёдоо, - гэж би ярилцлагыг эхлээд, -дэлхийн янз бүрийн улс үндэстнүүдийн нүдийг математикийн аргаар нарийвчлан шинжлээд танай хоёр улс нэгэн эх үндэстэй гэдгийг олж тогтоосон юм. Анхааралтай нэгнийгээ ажиглаад та хоёрын дунд ямар нэгэн нийтлэг зүйл байгаа эсэхийг хэлээд өгнө үү?


Финн япон хоёр удтал нэгнийгээ ширтсэний эцэст эвтэй нь аргагүй нэгэн зэрэг хөхрөлдөв.

- Бидний дунд хоёулаа хүн л гэдгээс өөр ямар ч нийтлэг зүйл алга даа гэж япон хэлэв.

- Битгий яар, ноёдоо, - гээд би үргэлжлүүлэн, - дэлхийн янз бүрийн үндэстнүүд дөрвөн үндсэн арьстнаас үүссэн. Та хоёр хоёулаа ерөнхий нэг үүсэл гаралтай. Төвдөөс хүний нүүдлийг харуулсан офтальмогеометрийн зургийг хар даа! Нэгдүгээр үндсэн чиглэл нь хүний нүүдлийн хэд хэдэн салаа гаргасан. Нэг салаа нь финнчүүд, та нар дээр төгсдөг ( Балтийн үндэстэн). Нэг нь япончууд та нар дээр төгсдөг (Манжуур солонгосын үндэстэн). Гэхдээ та хоёрын үүслийн эх сурвалж нь нэг. Тийм ч учраас эртний ч гэсэн та хоёрын дунд нийтлэг зүйл байх ёстой. Энгийн ахуйн (ус, гал, гэр, газар гэх мэт) үгсийг японоор болон финнээр хэлээд үзээч! Магадгүй үгийн үндэс нь ижил эсвэл бүр адилхан үг ч байх юм билүү! Мөн та хоёр маш эртний заншлуудаа хооронд нь харьцуулахыг оролдоод үзээч!

Тэр хоёрын хооронд муухан орос хэлээр хоёр цаг шахуу үргэлжилсэн сонирхолтой яриа өрнөв. Эхэндээ би тэдний ярианаас ижил төстэй үгнүүдийг бичиж авч, эртний уламжлалуудынх нь ерөнхий шинж, утгыг ойлгохыг оролдсон боловч яриандаа улайрсан хоёр ямар нэгэн үг бичиж авахаар түр азнахыг гуйсан миний хүсэлтийг тун цөөхөн биелүүлж байснаас би энэ ажлаа орхихоос өөр аргагүйд хүрсэн.

Тийм ч учраас одоо нэлээд хэдэн жил өнгөрсний дараа тэдний яриаг эргэж сэргээхэд хүндрэлтэй байсан.



- Хараач, - гэж илүү шалмаг япон эр хэлээд, нээрээ л бид хоёрын хооронд ижил төстэй зүйл байна шүү! Бид хоёр эртний цусан ах дүүс юм байна шүү дээ!

- Дашрамд хэлэхэд, - гээд финн эр үргэлжлүүлэн, - та энэ судалгаагаа илүү өргөн хүрээнд явуулах хэрэгтэй. Энэ чинь бүх дэлхийг хамарсан асуудал болох болно. Одоо бол бүгд л ари үндэстнийг дэлхийд тэргүүлэгч гэж үздэг.

Япон эр бид хоёр бидний хэл, соёл, ёс заншилд ерөнхий ижил төстэй зүйл үнэхээр ихийг оллоо. Хэдийгээр тэр надтай ер адилгүй ч би одоо түүнийг өөрийн цусан ахаа гэж үздэг боллоо..

- Негр бид хоёрын хооронд адил төстэй зүйл бий юу хэлээд өгнө үү? гэж япон эр асуухад нь би:

- Байхгүй л болов уу, харин негр памир үндэстнүүдийн хооронд ижил төстэй зүйл бий гэж хариулав.

Би энэ хоёр хүний яриаг шинжлэх ухааны үндэстэй гэсэн баталгаа өгч чадахгүй нь ойлгомжтой. Ямартаа ч энэ хоёр хүн үнэхээр ихээхэн ижил төстэй зүйл олсон нь сонирхолтой баримт юм. Харамсалтай нь хяналтын судалгаа (жишээ нь: япон хүнийг негр хүнтэй уулзуулах) хийж чадсангүй. Хүн төрлөхтний нүүдлийн замыг баталж буй бас нэгэн түүхэн баримт бол америкийн индиануудыг азиас үүсэлтэй тухай, мөн шинэ зеландын аборигенчууд америкаас үүссэн тухай таамаглалууд болон Чукотка Аляскийн аборигенчуудын хоорондын уялдаа холбооны талаарх баримтууд юм.

Мэдээж бидний судалж буй уг зүйл нь балар эрт үе рүү үндсээрээ гүн шигдсэн учир маш маргаантай асуудал юм. Бусад бүх салбарын адилаар шууд баримт олох боломжгүй. Үүнийг харгалзаж үзэлгүйгээр офтальмогеометрийн судалгаагаар олж авсан хүн төрлөхтний нүүдлийн бусад замыг тодорхойлон бичье.

Бидний судалснаар зүүн урагш чиглэсэн нүүдлийн замд төвд үндэстний дараа өмнөд азийн, папуагийн, меланезийн, веддо-энэтхэгийн болон австралийн гэсэн үндэстнүүд дараалан үүсчээ. Нүдний өөрчлөлтийн үндсэн шугамаас нэг салаа үүссэн бөгөөд энэ нь папуа болон ази-пигмейн үндэстнүүдийг төрүүлж энэ нь цаашид дравид, айн үндэстнүүдийг үүсгэжээ.


## Нүүдлийн В чиглэл

Балар эртний үед В чиглэлийн нүүдлийн замын дагуу хүн төрөлхтөн Төвдөөс зүүн урагш нүүдэллэсэн. Байгалийн нөхцөл байдал хүмүүсийн гадаад төрхөнд өөрчлөлт оруулж, өнөө үеийн вьетнам, кампучи, тайланд, өмнөд хятад зэрэг өмнөд азийн үндэстнүүдийг үүсгэжээ.

Өмнө зүгийн арлууд дээр (Филиппин, Индонези) тархсан нүүдэл нь папуагийн үндэстнүүдийг үүсгэж, энэ нь Индонезидээ ази-пигмейн үндэстнүүдийг төрүүлжээ.

Бидний төсөөллөөр бол папуас пигмейчүүд нь хүний зэрлэгшлийн туйлд хүрсэн. Би Индонезид очиж байсан боловч цэвэр цусны пигмей болон папуастай ер харьцаж үзээгүй учраас тэдний оюун ухааны талаар ямар нэгэн төсөөлөл алга.


### НҮҮДЛИЙН В ЧИГЛЭЛ



B1 - өмнөд азийн  
B2 - папуасын  
B2/1 - ази-пигмейн  
B2/2 - дравидын

B2/3 - айны  
B3 - меланезийн  
B4 - ведо-индонезийн  
B5 - австралийн

### НҮҮДЛИЙН В ЧИГЛЭЛ



Эрт дээр үед папуас, гвинейчүүд ямар байсныг хэн ч үл мэднэ. Магадгүй тэр үедээ хөгжиж байсан боловч эдгээр үндэстний соёлын ухралт, зэрлэгшил нь сүүлд явагдсан байж болзошгүй.

Офтальмогеометрийн баримтаас харахад ази-пигмейн үндэстнүүд нь дравидын ба айны гэсэн бие даасан хоёр салаа болсон байна. Дравид үндэстнүүд нь миний бодлоор одоогийн Энэтхэгийн өмнөд нутгийн ард түмэн юм. Би Энэтхэгт очихдоо үнэхээр л өмнөд нутгийн хүмүүс хойд нутгийнхнаас буржгар үс хар царайгаараа ихээхэн ялгаатайг анзаарсан. Хойд Энэтхэгийн ард түмний өвөг дээдэс нь Төвдүүд, өмнөд нутгийнхных нь дээр дурьдсанчлан дравид үндэстнүүд нь юм шиг санагдсан.

Нэгэн удаа Энэтхэгт болсон хуралдааны үеэр бүх талаараа өмнөд нутгийн хүний шинжийг агуулсан нэгэн эмчээс би:

- Эрт дээр үед Энэтхэгийн өмнөд нутгийн ард түмэн хаанаас ирсэн болохыг хэлээд өгөхгүй юу?- гэж асуухад,

- Миний эцэг өвгөд Полинезийн арлуудаас Энэтхэгт ирж суурьшсан гэж ярьцгаадаг гэж эмчийг хариулахад нь

- Таарлаа шүү гэж би хэлэв.

Мөн уг хуралдаан дээр би нэгэн төвд үндэстний шинжийг агуулсан эмчийг олж уулзав.

- Уучлаарай гээд түүнд хандаад, Энэтхэгийн хойд өмнөд нутгийн хүмүүс гадаад төрхөөрөө хоорондоо их ялгагддаг. Таны бодлоор өмнөд Энэтхэгийн ард түмэн өөр газраас энд ирж суурьшсан уу, эсвэл тэд энд үргэлж амьдардаг байсан уу гэхэд минь

- Би баттай хэлж мэдэхгүй байна. Дээр үед хаанаас ч билээ, энд ирж суурьшсан гэж сонссон юм байна гэв.

- Тэгвэл та гээд үргэлжлүүлээд, – гадаад төрхөөрөө хойд Энэтхэг хүн. Танай эцэг өвгөд бас хаанаас ч юм өөр газраас Энэтхэг нутагт ирж суурьшсан уу гэж намайг асуухад,

- Үгүй, бид энд үргэлж амьдардаг байсан гэв.

“Үнэхээр тэр зөв ярьж байна. Төвд Энэтхэг 2 хил залгаа оршдог.” гэж би бодов.

Офтальмогеометрийн баримтаар дээр дурьдсан ази-пигмейн үндэстнүүд нь айн үндэстнийг үүсгэсэн. Одоо айнчууд хойд Японд амьдардаг бөгөөд бусад Япончуудаас гадаад төрхөөрөө ялгардаг. Японд байх үед надад жинхэнэ айн хүнийг олж уулзах боломж олдсон.

- Та айн уу? гэж намайг асуухад

- Үгүй. Би япон хүн гэв.

- Би таны иргэншлийн тухай яриагүй. Харин таны удам судрыг чинь асууж байна. Таны эцэг өвгөд айнчууд уу?

- Тийм.

- Айнчуудын үүслийн талаар танай ард түмэн юу ярьдаг вэ? Японы нутагт хаанаас ирж суурьшсан юм бол?

- Одоо үед цөөхөн үлдсэн манай ард түмэн дээр үед холын Полинезээс усан онгоц бүтээн, түүгээрээ хөвж ирсэн гэж ярилцдаг гэж бусад Япончуудаас гадаад төрхөөрөө илт ялгарах айн эр хэлэв.

Би айны ард түмний төлөөлөгчтэй болон энэтхэг эмч нартай хийсэн ярилцлагуудын шинжлэх ухааны нарийвчлалд мөн л баталгаа өгч чадахгүй. Төвдөөс хүний нүүдэллэсэн офтальмогеометрийн бүдүүвчтэй харьцангуйгаар давхцсаны хувьд эдгээр ганц нэг тохиолдол ч гэсэн сонирхууштай баримт.

Нүүдлийн В чиглэл Австралид төгсдөг. Австралийн аборигенчуудын нүд Шинэ Зеландийн аборигенчуудын нүднээс үлэмж ялгаатай байсан ч тэдний нүд нь офтальмогеометрийн өөрчлөлтөөрөө нүүдлийн В чиглэлийн төгсгөлийн шатанд орж байгаа юм. Тийм ч учраас офтальмогеометрийн бүдүүвчээр бол, австралийн аборигенчууд тэнгисийн хоолойгоор дамжин дэргэдээ орших Шинэ Зеланд рүү очиж чадаагүй. Харин Полинезийн арлуудаас ирсэн болж байна. Харин Шинэ Зеландын аборигенчууд номхон далайг гатлан ариун арлуудад хүрч чадсан боловч хөрш орших Австралид тархаж чадаагүй.

Австрали бол маш эртний тив. Зарим эрдэмтэн Австралийг домогт Атлантидын хэсэг гэж үздэг бөгөөд түүний хосгүй ургамал амьтны аймаг нь Атлантидын үеэс хадгалагдан үлджээ. Австралид Полинезийн арлуудаас (офтальмогеометрийн бүдүүвчээр) нүүдэллэн ирсэн болон Атлантидаас үлдсэн олон омог байдаг. Гэвч үүний талаар дараа ярилцана.

## Нүүдлийн С чиглэл

Нүдний тоон чанарын ойртолтын түвшингээрээ уг чиглэлд төвдийн дараа памир, эфиоп, негр, африк-пигмеоидын болон бушмен үндэстнүүд ордог. Памирын үндэстнүүдээс хойд кавказын үндэстнүүдийн салаа үүсдэг.


Уг чиглэл нь Түвдээс хар арьстай хүний нүүдэллэсэн урсгал юм. Бидний судалгаагаар хар арьстан үндэстнүүд нь (эфиопын, негр, африк-пигмеоидын болон бушмены зэрэг) Памир үндэстнээс гаралтай бөгөөд Памирчүүдийн өнөөгийн төлөөлөгчид нь Таджик тэргүүтэй Памирын бусад үндэстнүүд юм. Памирын үндэстнүүд мөн өнөөгийн төлөөлөгчид нь кавказын ард түмэн болох хойд кавказын үндэстнүүдийг үүсгэжээ.

Нүүдлийн уг чиглэлд яагаад арьсны өнгөний өөрчлөлт үүсэх болов? Цаг агаарын хүчин зүйлийн нөлөөг үгүйсгэж болохгүй. Учир нь нүүдлийн В чиглэлд ч мөн адил цаг уурын нөлөөллийн улмаас арьсны өнгөнд өөрчлөлт орж байсан. Жишээ нь: Төвд үндэстний шар арьснаас






## НҮҮДЛИЙН С ЧИГЛЭЛ



- C1 - памирын
- C1/1 - хойт кавказын
- C2 - эфиопын
- C3 - негрийн
- C4 - африк-пигмеоидын
- C5 - бушмений

## НҮҮДЛИЙН С ЧИГЛЭЛ



австрали үндэстнүүдийн бор арьс, папуагийн салаанд (дравид үндэстэн) бүр хар болтлоо хувирсан.

Гэвч Африкийн ард түмнүүдийн арьсны илт хар өнгө нь хүн төрөлхтөн африкт мөн нэгэн зэрэг үүссэн бөгөөд угийн хар арьстай байсан гэсэн таамаглалаар тайлбарлагдаж болох талтай. Магадгүй Африк, Төвдийн хүний үүслийн эх сурвалж нь холилдсон байж болно.

Үүнээс гадна зарим нэгэн ном зохиолд урьдах Атлантуудын соёл иргэншил нь хар болон шар хүмүүс болж хуваагддаг байсан гэж баталсан байдаг. Тэгвэл Африкийн негрүүд хүчирхэг Хар Атлантуудын үр сад биш биз? Уг асуултанд хариулахад маш хүндрэлтэй. Дараагийн бүлгүүдийг унших үедээ уншигчид маань энэ тухай сонирхолтой эргэцүүлэл болон баримтуудыг олох болно.

## Хүний нүүдлийн D чиглэл

Офтальмогеометрийн баримтаар уг замд төвдийн дараа арменоид, динар болон хойд зүгийн үндэстнүүд үүсчээ.

Арменоид үндэстэн нь газрын дундад тэнгисийн, динар үндэстэн нь альпын үндэстнүүдийн салааг тус тус төрүүлсэн.

Гэвч нүдний тоон чанарын ойртолтоороо арменоид үндэстнүүд нь палеосибирийн өмнөд азийн болон памирын үндэстнүүдээс хол жагсаж байгаа юм. Ийм учраас бидэнд төвд болон арменоид үндэстнүүдийн хооронд А.Ярхогийн бүтээлд дурьдагдаагүй өөр нэгэн үндэстэн байх ёстой гэсэн таамаг төрсөн. Чухам ямар үндэстэн байж болох вэ? Би Иранд хэд хэдэн удаа очсон боловч очих болгондоо “Рамаданы үеэр хоол идэж байгаа хүнийг баривчилдаг. 40 хэмийн халуунд хоёр давхар зузаан хиджапаар нүднээсээ бусдыг тагласан эмэгтэйчүүд” гэх мэт хэт туйлширсан исламын ёс заншлыг гайхдаг байлаа.

Иранчууд хар үстэй бараан а р ь с т а й . Е р ө н х и й д ө ө азербайджанчуудтай төстэй боловч тэдний дунд хаяахан шаргал үстэй, цайвар царайтай хүмүүс бас тохиолддог.

- Эдгээр шар үстэй хүмүүс ямар хүмүүс вэ гэж намайг асуухад нүдний эмч иран залуу:

- Персүүд гэж хариулав.

- Персүүд чинь хар үстэй бараан царайтай биш гэж үү?

- Ираны хүн амын 40%-ийг азербайджанчууд, мөн цөөнгүй хувийг Курдууд, Белуджи болон



Иран бүсгүйчүүл

бусад үндэстэн эзэлдэг. Тэд бүгд хар үстэй бараан царайтай. Харин жинхэнэ персүүд бол цайвар царайтай, шаргал үстэй байдаг. Үнэндээ тэд бусад үндэстэнтэйгээ маш их холилдсон ч жинхэнэ персүүд бусад үндэстнээс ялгардаг.

Би нэгэн (нэрийг нь одоо санахгүй байна) номонд Гитлер ари үндэстнүүдийн цусан ах дүүг персүүдийг гэж үзээд, герман улсыг шинэчлэх зорилгоор герман персүүдийн хооронд гэрлэлт зохион байгуулдаг байсан тухай уншсан. Германчууд Персүүдтэй нэгэн эх үндэстэй гэж үзсэн нь Гитлерын зөв байсан гэж үү?

Иранд хүн үзэж байхдаа өвчтэй хүүхдийн ээж болох нэгэн шаргал үстэй перс эмэгтэйтэй таарсансан.

- Та цэвэр цусны перс хүн үү гэж намайг асуухад

- Тийм, юу гэж?

- Та цусныхаа цэвэр байдлыг яаж хадгалж үлдэж чадсан юм бэ?

- Персүүд бид ч бас бусад үндэстний адил цусаа цэврээр нь хадгалж үлдэхийг эрхэмлэдэг.

- Би таны нүдний зургийг авч болох уу?

- Яах гэж?

- Таны хүүхдийн нүдийг харьцуулж төрөлхийн шинжийг нь тогтоох гэсэн юм гэж шашны ёс зүйд нүдний зураг авах нь тааламжгүй зүйл гэдгийг ойлгосон би худал залав.

Би түүний зургийг аваад орост ирсэн хойноо офтальмогеометрийн шинжилгээнд өгөв. Уг нүд нь офтальмогеометрийн шинж чанарын хувьд нүүдлийн D чиглэлд Төвд болон Арменоид үндэстнүүдийн дунд нь таарлаа.

Тохиолдлын нэгэн эмэгтэйн нүд нь А.Ярхогийн ангилалд багтсан үндэстнүүдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн нүдний зураг биш ч офтальмогеометрийн бүдүүвчээр арменоид үндэстнийг перс үндэстэн төрүүлсэн гэдэг нь харагдсан бөгөөд одоо ч оршин тогтносоор байна. Энэ тохиолдолд нүүдлийн D чиглэлд орсон үндэстнүүд маш нарийн зүй тогтолтойгоор жагсав.


Хүний нүүдлийн офтальмогеометрийн зургаар персүүд нь үнэхээр D чиглэлийн замд харьяагдаж, бусад иранчууд нь нүүдлийн C замд харьяагддаг (хойд кавказын үндэстнүүд). Өөрөөр хэлбэл тэд гарал үүслийн хувьд өөр өөр учир энэ нь тэдний гадаад төрхөд үлэмж ялгаа болон тусчээ.

Ингээд бидний баримтаар перс үндэстнүүд нь арменоид (армянууд) үндэстнийг төрүүлж, тэр нь эргээд өмнөд славянчууд буюу украин, югослав зэрэг үндэстнийг төрүүлсэн хэмээн эрдэмтэд баталдаг динар үндэстний өвөг дээдэс болсон юм. Үүнээс гадна арменоид үндэстэн нь мухар салаа болгож, газрын дундад тэнгисийн үндэстнүүдийг буюу өнөөгийн итали, румын, еврей, араб, грек, испани, гүрж болон түркчүүдийн нэгэн хэсгийг үүсгэжээ.

Динар үндэстэнүүд нь альпын (франц болон итали, испаничуудын нэгэн хэсэг) болон хойд зүгийн (герман, англи, голланд, норвеги, исланд, швед) үндэстнүүдийг үүсгэжээ.


Нүүдлийн уг зам нь Тяньшань, Кавказ, Европ болон Газрын Дундад Тэнгисээр дайрч өнгөрөн хойд европын викингүүд нүүдэллэн очсон Исландад төгссөн байна. Шашин нэлээд хожуу үүссэн болхоор нэг үндэстний дотор ч шашны олон урсгал бий болж эхэлжээ. Үндэстний шинж чанарын нэг нь болсон хэл энд

### НҮҮДЛИЙН D ЧИГЛЭЛ



- D2 - арменойд
- D2/1 - газрын дундад тэнгисийн
- D3 - динарын
- D3/1 - альпийн
- D4 - хойд

## НҮҮДЛИЙН D ЧИГЛЭЛ



утгаа алдсаны шалтгаан нь олон арван дайн тулааны улмаас нэг хэл давамгайлж нөгөө хэл устаж байсанд оршино.

Европчууд бидний хувьд офтальмогеометрийн баримтаас харахад орчин үеийн европчуудаас гадаад төрхөөрөө нэн ялгаатай армянчууд бидний өвөг дээдэс болж буй нь тун хачирхалтай. Гэвч армянчууд эртний өвөг дээдсээ шаргал үстэй цэнхэр нүдтэй байсан гэдэгт итгэдэг бөгөөд орчин үеийн армянчуудийн дүр төрх нь кавказын бусад ард түмэнтэй холилдсоны үндсэн дээр бүрэлдэн тогтсон гэж үздэг.

Офтальмогеометрийн бүдүүвчээр Арменоид үндэстэн нь цэвэр европчуудаас гадна газрын дундад тэнгисийн үндэстнүүдийг үүсгэсэн бөгөөд тэдгээр нь Газрын Дундад Тэнгисийн эрэг орчмоор тархан италичууд, арабууд гэх мэт харьцуулашгүй өөр өөр ард түмний эх үндэс болжээ. Янз янзын хэл, шашин, ёс заншилтай ч тэдний нүд гарал үүслийн хувьд нэг юм. Би юуг ч баталж чадахгүй ч биологийн шинж чанараараа тэд ижил, харин шашин болон хэл соёлын нөхцөл байдал нь сүүлд бүрэлдэн тогтсон гэж бодож байна.

Дашрамд дурдахад хойд өмнөд италичууд хоорондоо ялгардаг. Миний үзэж байгаагаар өмнөд италичууд нь газрын дундад тэнгисийн үндэстнүүдийн цэвэр төлөөлөгч байхад хойд италичууд нь газрын дундад тэнгисийн болон хойд зүгийн, альпын үндэстнүүдийн хольц юм.

Мөн л Арменоид үндэстнээс үүссэн динарчуудын бие төлөөлөгч нь эрдэмтдийн үзэж байгаагаар өмнөд славяны ард түмэн (Украин, Болгар, Югослав г.м.). Тэр дундаа бусад ард түмнээс гадаад төрх болон нүдний бүтцээрээ үлэмж ялгардаг оросууд нь славян үндэстнүүдийн дийлэнх хувийг эзэлдэг.

Оросууд гэж хэн бэ? Би оросуудын нүдийг судалж үзсэнийхээ хувьд тэд офтальмогеометрийн шинж чанараараа динар үндэстний лапениан болон Балтийн (Эстон, Коми, Финн, Татаар г.м.) үндэстнүүдтэй ойролцоо буюу хүний нүүдлийн А чиглэлд үүссэн үндэстнүүдийн холимог гэж хэлж чадна.

Бидний гаргасан бүдүүвчээр динар үндэстэн альпын (франц, хойд испанчууд) болон хойд зүгийн (герман, англи, швед) үндэстнүүдийг бас төрүүлсэн болохоор францчууд, англичууд болон германчуудийн хувьд славянчууд бид хамгийн ойрын цусан төрөл нь юм. Гитлер славянчуудыг устгалд хамруулах шаардлагатай хүний хөгжлийн төгс бус хэсэг гэж үзээд, персүүдийг цусан төрлөө гэж үзсэнээрээ алдсан. Славян болон персүүд нь арьстны генетикийн үндсээрээ нүүдлийн D чиглэлийн ижил түвшинд байрлаж байна.

Тэдний газар нутаг нь Синайн арал дээр оршдогоос үүдээд еврейчүүд газрын дундад тэнгисийн үндэстэнд багтдаг. Тийм ч учраас уг ард түмний арай ойрын “цусан төрөл” нь араб, грек, өмнөд итали болон испаничууд юм.

## **Еврей үзэгдэл**

Гэвч уг ард түмэн нь гадаад төрхийн хувьд европын цайвар төрхтэй еврейүүдээс авахуулаад эфиопын хар арьстан хүртэл олон янз байдаг. Үүний шалтгаан нь юу вэ?

Еврейн ард түмэн газар нутгаа алдаад, түүхийн удаан хугацааны турш дэлхийн өнцөг булан бүрд тархсан ч цус холилдож гэрлэхийг шашны ёс зүйгээр хориглох замаар үндэстнээ хадгалсаар ирсэн. Мэдээж уг хоригийн биелэлтийг 100% гэж хэлж чадахгүй ч үйлчлэлийг нь үгүйсгэх аргагүй. Тийм ч учраас тэд үндэснийхээ онцлогийг хадгалан үлдсэн хэдий ч (соёл, ёс заншил) газар зүйн зарчмаар гадаад төрхөөрөө үлэмж ялгаатай байгаагийн шалтгаан нь ойлгомжгүй юм. Бухарын еврейчүүд узбекчүүдтэй, кавказын еврейчүүд кавказ үндэстнүүдтэй, германы еврейчүүд германчуудтай, мароккогийн еврейчүүд мароккочуудтай, эфиопын еврейчүүд эфиопчуудтай төстэй болсон байдаг. Байнга тохиолддог холимог гэрлэлт нь тэгтлээ нөлөөлөх ёсгүй. Учир нь уг хүчин зүйлийн нөлөө үнэхээр тийм хүчтэй байсан бол еврей үндэстэн уусаж алга болсон байх ёстой.

Өөр өөр улс үндэстний хүмүүс нэгнийхээ амин орны (биополе) хүрээнд нөлөөлснөөр гадаад төрхийг нь өөрчилжээ гэж би уг асуудлыг тайлбарламаар байна. Амьтан, ургамал, шувууны амин орноор хийсэн туршилтын тухай доктор А.В. Цзяны (Хабаровск хот) бүтээлийг уншсаны дараа над энэ санаа орж ирсэн юм. Доктор А.В. Цзян нугасны дэгдээхэйн амин орны цацрагийг тахианы өндөгөнд тусгаснаар нугасан хөлт тахианы дэгдээхэйг гаргаж авсан байна. Мөн уг аргаараа тэрээр лийрэн алим, амтат гуан өргөст хэмх г.м. генетикийн холимог төрлүүдийг гаргаж авчээ.

Үүнээс үзэхэд Бухарын еврейчүүдийн гадаад төрхний хувирал нь хаяахан тохиолддог холимог гэрлэлтээс бус, харин узбекчууд ба еврейчүүд үр хөврөл байх үеийн амин орны харилцан үйлчлэлээс болж узбекчуудтай адилхан болж өөрчлөгддөг. Мөн уг зарчмаар кавказын бараан царайт, эфиопын хар царайт, германы цайвар царайт еврей үүсч, ард түмнүүдийн харилцан үйлчлэл явагддаг байх.

Мэдээж хүний биеийн бүх хэсгийн (элэг, тархи, зүрхний үйл ажиллагаа г.м.) үйл ажиллагааны генетик мэдээлэл амин орноор дамжин түгэхгүй ч гадаад дүр төрхөнд ул мөрөө үлдээх бүрэн боломжтой.

Уг таамаглал ойлгомжтой хэдий ч шинжлэх ухаан-туршилтын баталгаа шаардагдаж байгаа бөгөөд амин орны үйлчлэлийг илүү судалсны дараа ирээдүйд уг таамаглалыг шалгах бүрэн боломжтой.

## **Өнгөөр ялгаварлах үзэл ба ард түмнүүдийн эв нэгдэл**

Энгийн хүмүүсийн хувьд “арьс өнгө” гэсэн энэ үг голцуу сөрөг утгыг агуулж, германы арьс өнгөөр ялгаварлах үзэл болон уг үзлийн ашиг тусын тулд фашистуудын өдөөсөн дайны тухай сануулдаг. Давтан хэлэхэд хүн төрөлхтний соёл иргэншлийн (биднээс өмнө атлантын болон лемурын соёл



иргэншлүүд оршин тогтнож байсан) өнөө үеийг арийн үндэстэн гэж нэрийддэг ба Гитлер болон түүний өмнөх үеийн сурталчид бүх хүн төрөлхтний нэрийн өмнөөс герман үндэстнийг тодруулах зорилгоор зөвхөн германчуудад уг нэрийг үзүүсэн билээ.

Гэвч “арьстан үндэстэн” гэсэн үг нь биологи-хүн судлалын ойлголт болохоос биш улс төрийн ухагдахуун биш. Үүнд ямар арьстан үндэстний бүлэгт багтаж байгаагаас шалтгаалсан оюун ухааны болон бүтээлч ур чадварын хамаарал байхгүй. Үүнээс гадна офтальмогеометрийн тооцоогоор нүдний нарийн уялдаа холбоотой өөрчлөлт нь Төвдөөс нүүдлийн 4 үндсэн чиглэлээр явагдсан нь харагдсан учир аль нэгэн үндэстнийг онцгойлон тодруулах шаардлагагүй боллоо. Мөн нүүдлийн чиглэл бүрийн эцсийн үндэстэн нь хөгжлөөрөө илүү гэж үзэж болохгүй. D ба B нүүдлийн замын эцсийн үндэстнүүдийг харьцуулья л даа. D замын эцсийн үндэстэн нь өндөр хөгжилтэй хойд зүгийн арьстан үндэстнүүд байхад B замын эцсийн үндэстэн нь австралийн хагас зэрлэг арьстан үндэстэн юм.

Үндэстэн болгоны хөгжлийн түвшин нь биологи-хүн судлалын шинж чанараас биш харин хурц ухаан, сайхан сэтгэл, санаачлага, ард түмнээ хөгжилд удирдан чиглүүлэх болон ирээдүйд хөгжих нөхцөлийг (ардчилал г.м.) бүрдүүлэх чадвартай удирдагчдыг төрүүлэн гаргасан нөхцөл байдлаас шалтгаална.

Түүхийн энэ завсарт хойд зүгийн үндэстнүүдийн (герман, англи, америк болон бусад) хөгжил нь динар үндэстний (славянчууд) хөгжлөөс илүү байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэгвэл нэгдүгээр Петр хааны үеийг эргэн санацгаая. Орос орон нэгдүгээр Петрийн үеэс хойш маш удаан хугацааны турш хөгжлийн өндөр шатанд байсан бөгөөд Октябрийн хувьсгал гараагүй бол Орос орон хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэх байлаа. Үүнийг Япон улсын тухайд ч хэлж болно. Хөгжлийн гуравдагч үе шатанд байсан улс ухаалаг удирдагчийн зөв бодлогын хүчээр өнөөдөр дэлхийд тэргүүлэгч орны тоонд оржээ.

Мэдээж Австралийн аборигенчуудаас ч юм уу, Индонезийн папуасчуудаас эдийн засгийн гайхамшигийг горьдох нь утгагүй зүйл. Учир нь түүхийн ямар нэгэн үе шатанд хөгжлөөр доройтох нь хүмүүсийг зэрлэгшилд хүргэж, тухайн үндэстний оюун ухааны хүчин чадалд нөлөөлчихдөг.

Тийм учраас миний бодлоор аливаа үндэстний хөгжил нь түүхэн хөгжлийнхөө шинж чанараар тодорхойлогддог. Үндэстэн хөгжлийн замаар хэдий чинээ удаан явна төдий чинээ өндөр хөгждөг. Удаан хугацааны турш тогтмол байдалд байгаад байдаггүй. Тогтмол байдал нь аажимдаа доройтол болж хувирдаг. Бурхан хүнийг бүтээхдээ байнгын хөгжлийн эхлэл маягаар бүтээсэн учир хүн байнга хөгжих хувь заяатай. Эсрэг тохиолдолд доройтож, зэрлэгшдэг.

Тэгэвч энэ талын олон шинжилгээ таамаглал, тэр дундаа офтальмогеометрийн судалгаа нь хүн төрөлхтөн нэгэн эх үүсвэрээс буюу өвөг дээдсийн нэгэн ижил генээс үүссэн гэдэгт хүргэж байна. Түвдэд үүсээд хүн

төрөлхтөн дэлхийн бөмбөрцгөөр нэг тархсан. Иймээс генетик биологийн шинж чанараараа хүн төрөлхтөн нэгдмэл бөгөөд бүх хүн хоорондоо төрлийн холбоотой.

Хөгжлийн ухралтанд орж, зэрлэгшсэн ард түмэн илүү хөгжилтэй улс үндэстэнд шахагдан гарсаар ирсэн, шахагдсаар ч байх болно. Үүнд тэд өөрсдөө л буруутай учраас өрөвдөх хэрэггүй. Гэвч хүн төрөлхтөн удахгүй нэгэн нэгдмэл хэлтэй, нэгдмэл гариг улсыг байгуулах болно. Энэ шаардлагыг эрүүл ухаан хэлээд зогсохгүй генетик-биологийн хүчин зүйлүүд баталж байна.

Гуравдугаар хэсэг

## Төвдийн сүмүүд дээрх нүд хэнийх вэ?

Ингээд үндэстэн арьстны нүдийг шинжилснээр бид өнөө үеийн хүн төрөлхтөн төвд гэсэн нэг эх үндэстэй гэсэн дүгнэлтэнд хүрэв. Тэгээд чухам хэн хүн төрөлхтөнийг Төвдэд төрүүлсэн юм бэ? гэсэн асуулт гарах нь гарцаагүй. Орчин үеийн хүн төрөлхтний эцэг өвгөд нь хэн бэ?

Дэлхий дээр хүн төрөлхтөн үүссэн тухай олон таамаг байдаг. Материалист үзэлтэй ихэнх эрдэмтэн дэлхий дээр хүн сармагчнаас үүссэн гэдэгтэй санал нийлдэг. Үүнийхээ баталгааг тэд балар эртний хүмүүсийн археологийн үлдэгдэл болон хөдөлмөрийн зэмсэгнээс (чулуун сүх г.м.) олдог. Хүн дүрст сармагчнаас өнөөгийн хүн хүртэлх хөгжлийн нарийн зүй тогтол ажиглагдаж байгаа учир итгэхгүй байхын аргагүй мэт.

Гэвч уг хөгжлийн зүй тогтолыг эсрэгээр нь хүнээс сармагчин үүсэхийг мөн л адил нарийвчлалтайгаар төсөөлж бас болно. Үүний баталгаа алдарт Дарвиний онолоос ч дутахгүй олон. Дэлхий дээр хүнтэй төстэй гэхээсээ илүү сармагчинтай төстэй түвшинд очтолоо зэрлэгшсэн олон омог байдаг. Ийм учраас сармагчнаас хүн үүссэн гэх онол нь анх санасанчлан тийм ч үнэмшилтэй биш.

Зарим эрдэмтэн хүн төрөлхтний эх үүслийг цасны хүнтэй (хүн хар гөрөөс) холбож тайлбарладаг. "Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ?" гэдэг шиг цасны хүн үнэхээр байдаг байх. Ихэнх ард түмэнд түүний тухай үлгэр домог олон байдаг (Түвдэд-йети, Якутад-чучуна). Гэвч цасны хүн болон хүний (homo sapiens) хоорондын уялдаа холбоог шинжлэх ухааны түвшинд одоохондоо гаргаж ирэх боломжгүй.



Хүний үрийг харь гаригийнхан авчирсан гэдэг санаа байдаг ч энэ талаар ямар нэгэн нотолгоо байдаггүй.

Боловсролтой хүн болгон эрт балрын үед дэлхий дээр амьдарч байсан хүчирхэг атлантуудын тухай үлгэр домгийг сонссон байх. Тусгай ном зохиолд (Е.П.Блаватскаягийн, дорнын шашин, бусад) урьд өмнө дэлхий дээр биднээс хөгжлийн түвшнээрээ хамаагүй илүү хэд хэдэн соёл иргэншил байсан тухай бичсэн байдаг. Магадгүй дэлхий даяар галав юүлэх үед сөнөсөн атлантчууд орчин үеийн хүн төрөлхтний эхийг тавьсан ч юм бил үү? Магадгүй хүн төрөлхтөн Төвд үлгэр домогт гардагчлан, мөн л Төвдөд оршдог нууцат Шамбалтай холбоотой ч юм бил үү? Магадгүй Бурхан хүнийг сүнс нягтруулах замаар бүтээж, соёл иргэншлийн олон үе шатаар хөгжүүлсээр өнөөдрийг хүрсэн гэж үздэг шашны зөв ч юм бил үү?

Эдгээр асуудалд би хөдлөшгүй баттай шууд баримт олохгүй гэдгээ мэдсээр хирнээ шинжлэх ухааны зүгээс хандах хандлагаа хадгалахыг хичээв.

Бид уг асуудлыг нүд шинжлэлийн үүднээс авч үзэж эхэлсэн бол уг чиглэлээ л барих хэрэгтэй гэж үзэж байна. Үүгээр бол “статистикийн дундаж нүд” нь Төвд хүнийх бөгөөд төвд үндэстний нүдний анатомийн хувилбар тохиолдлын чанартай зүйл үү, эсвэл нууц, гүн утга санааг агуулж байна уу? Эрт цагийн хүмүүс офтальмогеометрийг мэддэг байсан учраас тэдний дүр төрхийг эргээн сэргээж болох нүдний дүрс ч юм уу ямар нэгэн нотолгоо, ул мөрийг Төвдөд үлдээсэн байж болзошгүй. Хүн төрөлхтний гол асуулт болох бид хэнээс үүссэн бэ гэдэгт хариулах гол гогцоо, түлхүүр нь “статистикийн дундаж нүд” юм болов уу?

Гэвч энэ олон таавар судлаач хүний сониуч занг минь ер хангасангүй. Баримт олох шаардлагатай байлаа.

## **Түвдийн сүмийн нэрийн хуудас**

Миний найз, офтальмогеометрийн судалгааны хамтран зүтгэгч, Валерий Лобанков (уг номны эхэнд дурдагдсан Лобановтай андуурахгүй байхыг сануулж байна) Гималайн оргилуудын нэгэнд авирахаар Төвд рүү явахаар зэхэж байв. Явахынх нь өмнө би түүнд:

- Валера, овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ гэдэг. Хүн төрөлхтний “статистикийн дундаж нүд” Төвдөд бий... Чи тэндхийн сүм дуганд нь ороод нүдний ямар нэгэн дүрс байна уу үзээдхээрэй гэлээ.

Сарын дараа Валерий Лобанков Төвдөөс ирмэгцээ над руу утасдаж:

- Эрнст, ёстой догь юмаа, чиний зөв байсан байна шүү!

- Яасан бэ?

- Чи урьд нь Төвд сүмүүдийн “нэрийн хуудас”-ны талаар сонсоогүй юу?

- Үгүй, тэр чинь юу юм бэ? Би Төвдөд очиж үзээгүй...

- Төвдийн сүм болгонд яг л “нэрийн хуудас” болж буй мэт аварга том ер бусын нүдний дүрс байна гэж Лобанков хэлээд үргэлжлүүлэн,- Аварга том! Ер бусын! Яг л сүм тэр аяараа чамайг харж буй мэт харж байдаг...



*Түвдийн сүм дээрх ер бусын нүд*

- Учир нь дэлхийн хаана ч ийм юм байхгүй ш дээ. Дэлхийн аль ч сүм дуганд нүдний дүрслэл байдаггүй байхад зөвхөн “статистикийн дундаж нүд” буй Төвдөд байж байдаг...

- Чи лам нараас энэ хэний нүд вэ гэж асуусан уу?

- Тэгэлгүй яах вэ! Зарим нэгэн, голдуу бага цолтой лам нар энэ бол Буддагийн нүд гэх юм. Харин дээгүүр цолтой ламаас нь сайн асуусан юм уу?

- Чи тэгээд дээгүүр цолтой ламаас нь сайн асуусан юм уу?

- Асуусан, маш сайн асууж шалгаасан. Юу ч хэлэхгүй, ярианы сэдвийг л өөр тийш нь өөрчлөөд байсан. Энэ нүдний нууц тэдний хувьд маш чухал гэдэг нь мэдрэгдээд байна. Энэ ямар нэгэн маш ерөнхий юмны бэлэг тэмдэг байх гэж Лобанков хэлэв

- Чи тэр нүднүүдийн зургийг нь авсан уу?

- Мэдээж! Бас видеокамераар бичлэг хийсэн.

Тэр өдөртөө би Лобанковтай уулзаж, Валентина Яковлеватай цуг гурвуул уг хачин нүдний зургийг компьютерт оруулж, офтальмогеометрийн өнцгийн шаардлагын дагуу бүдүүвч хийх шинжилгээндээ оров. Номын эхэнд хүний нүдийг ашиглан дүр төрхийг нь сэргээн бүтээж болдог тухай өгүүлсэн. Бид Төвдийн сүмүүдийн ханан дээр дүрсэлсэн тэр хүний дүр төрхийг нүдийг нь ашиглан сэргээхийг оролдлоо.


- Ямар нүд юм бэ?

- Ер бусын! Хүнийхтэй огт адилгүй! Тэгээд бас офтальмогеометрийн судалгаанд бидний хамруулдаг яг тэр хэсэг дүрслэгдсэн байдаг. Итгэмээргүй давхцал! Би анх хараад бүр гайхсан. Бидний хүмүүст судалж байсан яг тэр хэсэг, офтальмогеометрийн бүх үзүүлэлтүүд байгаа ч нүд нь тэс ондоо.

- Сонин л юм гээд би исгэрэв.

- Тэгээд сонирхолтой нь Төвд сүм болгон ийм нүдний зурагтай. Хананы талыг эзэлсэн аварга том зураг! Үнэхээр л нэг нь энэ дүрсийг шүтээн болгож үлдээсэн мэт, гээд Лобанков үргэлжлүүлэн, - Нээрээ мундаг болсон байна шүү, “статистикийн дундаж нүд”-ийг тооцоолж олчихоод, зүгээргүй гэж бодсон чинь нээрээ л ...

- Тиймээ, “статистикийн дундаж нүд” чинь нэг л нууцлаг байсан юмаа! Шинжлэх ухааны хийсвэр сэтгэлгээ зөв байж ...



*Буддын сүм (Катманду хот)*

## Түвдийн сүмүүдийн ханан дээрх зураг юуг өгүүлнэ вэ?


Төвд сүмүүдийн ханан дээрх нүдний дүрсээр уг хүний дүр төрхийг бүтээх арга зүйн жижиг сажиг зүйлийг өгүүлж, цэвэр тоон шинжилгээгээр толгойг чинь эргүүлэхээ болиод зөвхөн дараах зүйлийг онцлон тэмдэглэе.

Нэгдүгээрт, энгийн нүдний зурганд байнга байдаг хамрын уг байхгүй нь анхаарал татаж байна. Хамрын уг байхгүй нь юуг хэлнэ вэ? Өнөөгийн хүний хувьд хамрын уг нь дотоод харах талбайн талыг хаадаг бөгөөд гаднах харах талбай 80-90 хэм байхад дотор харах талбай 35-45 хэмийн өнцөгтэй байдаг. Тиймээс орчин үеийн хүн бүх талаасаа 80-90 хэмийн бус, харин 35-45 хэмийн дурангийн хараатай (эд юмс хүртэлх зай болон тэдгээрийн эзэлхүүнийг харах хоёр нүдний хараа). Энэ байдал нь өдрийн гэрлийн нөхцөлд мэдрэгддэггүй бөгөөд хиймэл гэрэлтэй үед илүү мэдрэгдэж, чийдэнгийн улаан гэрэлд харах үйлд саад учруулж орон зайн зүг чигийн баримжаа алдагдахад хүргэдэг. Хамрын уг байхгүй тохиолдолд хүн 80-90 хэмийн дурангийн хараатай болох ба энэ нь улаан гэрлийн нөхцөлд орон зайн баримжааг бүрдүүлнэ.

Төвдийн ер бусын нүдний эзэн улаан гэрлийн нөхцөлд амьдардаг байсан юм болов уу? Харах үйлийн чухлыг харгалзан хамгийн сайн харахад хүргэдэг дасан зохицох механизм байдаг учраас энэ таамаглал үнэн байх магадлалтай. Хамрын уг байхгүй болох дасан зохицлын механизм нь жирийн өдрийн гэрлийн нөхцөлд чухал үүрэггүй боловч улаан гэрлийн нөхцөлд зайлшгүй шаардлагатай.




Тэгээд би далдыг харагч аугаа Нострадамусын номыг (1555 он) авч өмнөх атлантчуудын соёл иргэншил нь улаан хүрэн өнгөн дунд амьдарч байсан (тэнгэр улаан, моднууд хүрэн байсан г.м) тухай уншив. Үүнээс Төвд сүмүүд дээр домогт атлантчуудын соёл иргэншлийн хүний нүд дүрслэгдсэн гэсэн дүгнэлт хийж болно.



а - түвдийн сүм дээрх нүдний бүдүүвч  
б - өнөөгийн хүний нүдний бүдүүвч

Одоо бол тэнгэр цэнхэр өнгөтэй бөгөөд бид үүндээ дасан зохицсон нүдтэй. Миний бодлоор дэлхий эргэлтийнхээ тэнхлэгийг өөрчлөхөд тэнгэрийн өнгө өөрчлөгдөх ёстой. Мөн л Нострадамусийн номонд би атлантчуудыг хөнөөсөн дэлхий



даяарх гамшигийн үед дэлхийн эргэлтийн тэнхлэг өөрчлөгдөж, туйлууд солигдсон тухай олж уншив.

Хоёрдугаарт, Төвдийн сүмүүд дээрх нүдний дээд зовхины ер бусын нугалаа анхаарал татаж байгаа юм. Өнөөгийн хүний нүдний дээд зовхи нь тод нум хэлбэртэй байдаг бол уг нүдний дээд зовхи нь төв хэсэгтээ доош төвийж эвэрлэгийнхээ дээр унжсан маягтай байна.


Энэ юуг баталж байна вэ? Юуний түрүүнд аних үед доош төвийж унжсан дээд зовхины улмаас нүдний завсар бүрэн хаагдахгүй бөгөөд энэ үед нүд эвэрлэгийн хажуу хэсгээрээ захын хараатайгаа байх болно. Хамрын уг байхгүй бөгөөд харааны бүх талбайд, тэр дундаа захын хэсэгтээ ч, дуран харааны шинж чанартай учир уг

ер бусын төвд нүдний эзэн нүдээ аниатайдаа ч харах чадвартай. Ийм харах чадвар нь их сайн биш ч орон зайг баримжаалахад хангалттай.

Орчин үеийн хүний нүд аниастай үедээ харах “баримжаалах хараа” байхгүй. Учир нь (хамрын угаас болоод) захын дуран хараагүй бөгөөд дээд зовхи зөвхөн эвэрлэгийн гадарга хэсгийн ихэнхийг бүрхэн, захын бусад хэсгүүдийг үлдээн анигдах чадваргүй.

Ер бусын Төвд нүдний аниастай ч “баримжаалах хараа”-тай үлдэх чадвар нь бас нэгэн дасан зохицох механизмыг үүсгэсэн нь дотогш доош сунасан урт нүдний булан юм. Энэ нь нүдний завсар дутуу хаалттай үед нүдний чийглэгийг хадгалах үүрэгтэй илүү хүчтэй нулимс ялгаралтыг (лакримаци) хангадаг.

Нүдний завсрын дутуу анилт болон “баримжаалах хараа” нь ямар ач холбогдолтой вэ? Үүнд бид усан дотор хурдан хөдлөх үед эмзэг эвэрлэгийг хамгаалах үүрэгтэй гэдгээс өөр тайлбар олоогүй. Түвдийн сүмэн дээр дүрслэгдсэн хүн амархан гэмтдэг эвэрлэгээ нүдний дээд з о в х и н ы т у с л а м ж т а й г а а р



*Ер бусын нүдтэй тэр хүн хагас усны амьдралтай байв.*



хамгаалан усан дотор хурдан сэлэх чадвартайн зэрэгцээ “баримжаалах хараа”-гаа хадгалах чадвартай байсан байна. Нүдний ийм зохион байгуулалт нь энэ хүмүүс хагас усны амьдралтайг гэрчилж байна.

Нострадамусын номонд атлантчууд тэр үед олон байсан арлууд дээр амьдарч усан доторх тариалангийн талбайдаа далайн хоолоо тарьдаг байсан тухай бичжээ.

Энэ дүгнэлтээс бидэнд атлантчуудын дүр төрхийн талаар тэд удаан шумбахад агаарын нөөцтэй байхад зориулагдсан маш сайн хөгжсөн цээжний хөндий, уушигтай байх ёстой гэсэн бас нэг таамаг төрсөн.


Логик сэтгэлгээгээр бодож олж болох байсан ч уг тооцооны үед атлантчуудын бас нэгэн онцлог шинж болох хөл гарын хуруунуудын сарьсны тухай таамаглаж чадаагүй нь харамсалтай. Атлантчууд сарьстай байсан тухай баримтыг төвдөд шинжилгээний ангиар явах үедээ л олсон юм.

Гуравдугаарт, Төвд сүмүүд дээрх дүрс нь хамрын оронд ороомог хэлбэрийн сариутай байв. Энэ нь юу вэ? Атлантчууд хагас усны амьдралаар амьдардаг байсныг нь тооцож үзээд уг сариа нь хавхлаг хэлбэрийн амьсгалын сүв болдог гэж тааварласан. Иймэрхүү амьсгалын сүвний бүтэц усанд байх үед амьсгалын замаар ус нэвтрэхийг энгийн амьсгалын сүвтэй харьцуулахад илүү хорьдог учир далайн зарим амьтанд үүнтэй төстэй бүтэц (дельфин, халим г.м.) тохиолддог.

Бид “сариа”-г хагас усны амьдралд зориулагдсан амьсгалын сүв гэдгээс өөр ямар нэгэн тайлбар олсонгүй. “Сариа”-д ойлгомжгүй үлдсэн хоёр хэсэг бий. Яагаад хавхлаг хэлбэрийн амьсгалын сүв нь ороомог хэлбэртэй байгаа болон яагаад амьсгалын сүв доош завсар маягаар үргэлжлэв? Тэр үед бид Ананта Кришнатай уулзаагүй байсан ба уг “сариа” нь авиа үүсгэх үүрэгтэй гэдгийг мэдээгүй. Мөн тэр үед Венер Гафаров үр хөврөлийн бүтцийн судалгаагаа явуулаагүй байсан ба хагас усны хүмүүст заламгайн төрлийн зүйл байх магадлалтайг мэдээгүй. Энэ тухай хожим дахин сөхөж ярих болно.



Дөрөвдүгээрт, Төвд сүмийн нүдний дээхнэ талд дусал хэлбэрийн толбо байдаг. Уг толбо нь Энэтхэг эмэгтэйчүүдийн тавьдаг гоо сайхны толботой ойролцоо байрлалд дүрслэгдсэн байдаг. Энэ юу вэ? Дусал хэлбэрийн толбо нь “гурав дахь нүд” гээчийг илэрхийлж буй юм гэж таамаглаж болох аж. Дээр үеийн хүмүүст уг “гурав дахь нүд” нь байсан бөгөөд тэр нь одоо бидэнд тархины гүнд байдаг боргоцой хэлбэрийн булчирхай маягаар үлдэц эрхтэн болж хувирчээ. “Гурав дахь нүд” нь хүний биоэнергийн (телепати г.м.) эрхтэн болж байсан ба энэ нь орон




зайд бодол санааг дамжуулах, таталцлын хүчинд нөлөөлөх, өвчнийг анагаах г.м. гайхамшиг бүтээх чадвартай байжээ. Энэтхэг эмэгтэйчүүд уг толбыг гайхамшигийг бүтээгч эрхтэний дурсгал болгон тавьдаг байх.

Би Нострадамусын номыг нээн домогт атлантчууд “гурав дахь нүд”-ээрээ дамжуулдаг дотоод энергийн тусламжтайгаар асар том эд зүйлсийг хөдөлгөж, харцаараа аварга том байгууламжийг (пирамид г.м.) босгох чадвартай байсан тухай уншив.




Пирамидыг хэн барьсан тухай хэлэхэд хэцүү. Өнөөгийн хүний эрин үе эхлэхээс өмнө атлантчууд барьсан ч байж магадгүй. Мексик, Египетийн ард түмэн пирамидыг тэдний өвөг дээдэс босгоогүй гэж хэлбэл бүү гомдоорой. Магадгүй тэдний өвөг дээдэс чулуун пирамидын нутагт нүүдэллэн ирж, чулуун аваргуудтай зэрэгцэн амьдарсан байж болох.

Энэ бүхний үндсэн дээр бид Төвд сүмүүдэд өмнөх эриний хүн буюу атлантчуудын нүдийг дүрсэлсэн гэсэн таамаг дэвшүүлэв. Уг нүдийг шинжилснээр бид атлантчууд нь маш аварга



биетэй, өндөр нуруутай байсан ба хагас усны амьдралаар амьдарч, ахуйн үйл ажиллагаандаа “гурав дахь нүд”-хээ хүч чадлыг хэрэглэдэг байсныг ойлголоо.

Хүн төрөлхтний “статистикийн дундаж нүд” нь Төвдөд байгаа болон чухам



энэ газар домогт атлантчууд тэдний ерөнхий дүр төрхийг олж авч болох нүднийхээ хэлбэрээр дурсгал үлдээж давхцсан нь бидний гайхлыг төрүүлж барахгүй байлаа.

## Ананта Кришна

Уг логик дүгнэлтэнд бид итгэх, үл итгэх хослон байлаа. Гэвч тун удалгүй бидний зөв гэж Ананта Кришна гэгч эр зоригжуулсан юм.

Энэ явдал 1995 онд Крымд болсон бага хурлын үеэр болсон. Уг хурал “Экологи болон хүний сэтгэлзүйн эрүүл мэндийн үндэс” гэсэн сүртэй нэрийн доор явагдсан. Үүнд оролцогчид нь гаж судлахуйг (паранаука) сонирхдог хүмүүс байлаа. Голцуу шидтэн, шулмас, хэт мэдрэмжит хүмүүс (экстрасенсууд), илбэчид гэх мэтийн янз бүрийн чадвартан цугларснаас гадна дэлхийн олон орноос ирсэн уг асуудлуудыг судалдаг эрдэмтэд оролцсон.

Уг хуралдаанд надад илтгэл тавих боломж олгосон. Би слайданд буулгасан илтгэлээ “Бид яагаад бие биенийхээ нүд рүү нь ширтдэг вэ?” гэсэн асуултаар эхлэн, судалгаагаа логик үндэслэлтэйгээр тайлбарлахад гол анхаарлаа чиглүүлж оньсогот атлантчуудын дүр төрхийг дүрсэлснээр төгсгөв. Би англиар ярьж, өгүүлбэр бүрээ оросоор тайлбарлаж байсан учир танхим тэр аяараа намайг маш сайн ойлгож байлаа.



*Ананта Кришна*

Илтгэл ихээхэн анхаарал татсан тул надад асуулт тавин шүүн хэлэлцэв. Хурлын танхимын гадаа энэтхэг хувцастай нэг хүн надад ойртон ирж, барууны эрдэмтэн цэвэр логик аргаар Дорнын гол нууцыг нээхэд хүрэх юм гэж санасангүй хэмээн маш тодорхойгоор надад хандаж хэлэв.

- Төвд сүм дээрх нүдний дүрс тэгээд Дорнын гол нууц юм уу гэж би асуув.

- Яг ч тийм биш л дээ. Энэ бол нууцуудын нэг нь. Гэхдээ хамгийн гол нь биш гэж уг энэтхэг хувцастай хүн хариулав.

- Гол нууц нь тэгээд юу юм бэ гэж асуучихаад энэ хүн энэ хонгилд тэр нууцаа дэлгэхгүй нь ойлгомжтой гэсэн бодлоосоо болон би цочих шиг болов.

- Та Төвд лам нарын нууц гэж сонссон уу гэж тэрээр хариуд нь асуув.

- Тэгсэн. Тийм юм байдаг гэж сонссон. Гэвч тэрнээс цаашгүй.

- Нууц гэдэг чинь хүнд мэдэгдүүлэхгүйн тулд л нууц байдаг юм хэмээн уг энэтхэг эр жоготой хэлэв.

- Таныг хэн гэдэг вэ?

- Би мастер Ананта Кришна байна.

Бид нэрийн хуудсаа солилцоод, орой буудалд уулзахаар тохиролцов.

- Мастер гэсэн чинь юу гэсэн үг вэ гэж би буудалд уулзсан хойно асуухад,

- Дорны шашны зарим нэг нууцад нэвтрэх эрхтэй шашны онцгой зүтгэлтнийг

Мастер гэж нэрлэдэг юм.

- Ямар нууцад?

- ...

- Гэсэн ч ?

- Эртний хүмүүсийн нууц...

- Та энэ тухайгаа ярьж өгч чадахгүй юм уу?

- Та Елена Блаватскаягийн “Нууц бичээс”-ийг уншаарай. Миний ойлгосоноор та энэ номыг уншаагүй.

- Үгүй, уншаагүй.

- Оросууд та нар азтай хүмүүс. Танай оронд дэлхийн аугаа Гэгээн Блаватская төрсөн. Уг номноос та эртний хүмүүсийн нууцын талаар их зүйлийг мэдэж авах болно. Тусгай бурханы сэтгэлгээгээр бичсэн учир ойлгоход хэцүү нь үнэн л дээ.

Гэвч та хэрвээ Дорны гүн ухаан болон хийсвэр сэтгэлгээнд нэвтэрч чадах юм бол Блаватскаяг ойлгох болно.

- Илэн далангүй ярилцаад үзвэл яасан юм бэ гэж намайг зүтгэхэд,

- Оролдоод үзье л дээ. Гэвч танд Дорны мэдлэг дутах болно. Та чинь барууны эрдэмтэн хүн гэж Ананта Кришна хариулав.

- Та эртний хүмүүсийн тухай Дорны мэдлэгийг товч тодорхой болгож өгч чадна биз дээ?

- Мэдээж бололгүй яах вэ...

Ингээд Ананта Кришна “Энэрэнгүй сэтгэл”, “Өрөвч сэтгэл”, “Зовлон”, “Муу үйл” зэрэг үгсээр өвч хачирласан яриагаа эхлэв. Үнэндээ би юу ч ойлгоогүй ч эелдэгээр толгой дохин ямар нэгэн логик утга агуулга олохыг оролдсон боловч бүтсэнгүй. Би Ананта Кришнаг хэрэгтэй юм ярьж байна гэдэгт нь итгэж байсан ч “Энэрэнгүй сэтгэл”, “Өрөвч сэтгэл”, “Зовлон”, “Муу үйл” зэрэг ухагдахууны энгийн ахуйн ойлголтууд түүний ярианы угт нэвтэрхэд минь саад болж байлаа.

Арга тасарсан би яриаг өөртөө ойлгомжтой барууны шинжлэх ухааны хэлбэрт шилжүүлэн:

- Ноён Кришна, Төвд сүмүүд дээрхи нүдний дүрсэд хийсэн миний шинжилгээ зөв болсон уу?

- Тиймээ, зөв болсон.

- Тэр нүд Атлантын нүд мөн үү?

- Бид эртний хүмүүсийг өөрөөр нэрлэдэг.

- Тэгээд хэний нүд гэж хэмээн намайг шалгаасанд,

- Энэ бол Түүний нүд.

- Тэр гэдэг чинь хэн юм бэ?

- Тэр бол Бурхны хүү. Тэрбээр одоо дэлхий дээр амьдарч буй хүн төрөлхтнийг үүсгэж, мэдлэгийг зааж, яаж хөгжихийг сурган мөхөлд өртүүлээгүй юм. Чухам түүний зааж сургасан хүмүүс л дэлхийгээр тархсан.

- Бурханы хүү тэгээд хаанаас ирсэн юм бэ?

- ...

- Хэлээд өгөөч?

- Газар дэлхий дээр Бурханы Хүүхдүүдийн том омог амьдарч байсан, амьдарсаар ч байгаа.

- Амьдарсаар байгаа? Хаана? Шамбалын оронд уу?

- ...

- Дашрамд хэлэхэд энэ Аугаа хүмүүсийн хамрын оронд байгаа “сариа” нь амьсгалын сүвний үүрэг гүйцэтгээд зогсохгүй мөн дуу авианы эрхтэн болдог байсан гэж Ананта Кришна ярианы сэдвийг өөрчлөв.

- Тэд чинь хоолойгоороо биш хамраараа ярьдаг байсан юм уу гэж асуухад,

- Тиймээ, тэгэхдээ бүүр хэт авианаас спектрийн хэт улаан туяаны хоорондох авианы өргөн үелзлээр ярилцдаг байсан. Тийм учраас тэдний яриа нь биднийхээс

хамаагүй баялаг байсан. Тэд мөн телепатын хэлийг ашигладаг, тэдний толгой илүү том байсан. Мөн тэд зөвхөн зөөлөн хоол хэрэглэдэг байсан. Маш тод “So”, “Hm” гэсэн хоёр гол авиаг үнэнчээр хадгалж, “SoHm” -ын хуулиар амьдардаг байсан.

- “SoHm” гэж юу юм бэ? Ямар учраас эдгээр авиа гол нь байсан юм бэ?

- Та “SoHm”-ын учрыг олохгүй л байх даа. Энэ бол бүхэл бүтэн гүн ухаан гэж Ананта Кришна хариулав.

Би Ананта Кришнагаас дахиад нэлээд хэдэн зүйлийг асууж шалгаасан боловч тэрээр маш их юмыг ярилгүй тойрч байв. Тэгээд ч надад ойлгоход хэцүү байлаа.

Тэр үед би эртний гүн ухаанд гүехэн ч гэсэн нэвтрэхийн тулд ямар их хүч чармайлт гаргана гэдгээ мэдээгүй. Мөн тэр үед би “SoHm” гэсэн сүүлчийн Аугаа илгээмжийн манай соёл иргэншлийн хувь заяаг тодорхойлох үүргийн чухлыг ойлголгүй, зөвхөн ямар сонин авиа вэ гэсэн бодол толгойд минь эргэлдэж байлаа.

Тэр үедээ би Төвд сүмийн хананд дүрсэлсэн нүд нь атлантчуудийн нүд биш, харин Ананта Кришнагийн бурханы хүү хэмээсэн дэлхийн бүүр ч нууцлаг эртний соёл иргэншилд хамаарагдана гэдгийг төсөөлөө ч үгүй явжээ. Энэ дүгнэлтэнд би нэлээд хожуу номоо бичих явцдаа хүрсэн болохоор энэ номын ихэнх хэсэгт би уг Төвд сүмийн нүдийг атлантын нүд гэж нэрлэх болно.


Үүнтэй зэрэгцээ түүхийн харьцангуй хожуу энэ үед дэлхий дээр эртний соёл иргэншлийн төлөөлөгч хаанаас гараад ирэв ээ гэдэг асуулт Төвд сүмүүд дээр дүрслэгдсэн нүдний шинжилгээг дуусгах үед надаас хариу нэхэн зовоож байлаа. Тэд чинь аль дээр мөхчихсөн биш бил үү?

### ***Эртний соёл иргэншлийн хүмүүс дэлхий дээр үлдсэн үү?***

Дэлхий дээр биднээс ч өмнө хүний соёл иргэншилт нийгэм байсан гэдэг нь үнэн байх. Тэд техникийн асар өндөр хөгжилд хүрэн хүчээ муу үйлэнд ашиглаж байсан нь тэднийг үйлийн үрээ эргэн төлөх буюу соёл иргэншлүүд устахад хүргэж байлаа. Дараа нь сөнөсөн соёл иргэншлийн орон дээр шинэ нь үүсэх маягаар үргэлжилсээр ирсэн.

Хэрвээ өнөөгийн хүн төрөлхтөн болох Арийн соёл иргэншлийн одоогийн хөгжлийн түвшинд хүчирхэг улсуудын (АНУ, ОХУ) хэн нэг тэргүүлэгч нь цөмийн дайны товчлуур дарахад хүн төрөлхтөн мөхөж, туяажсан хүйтэн дэлхий (цөмийн өвөл болно) амьдралд хэрэгцээгүй болно.

Хорт муу санаа асар их хүчтэй. Хорт муу санаа нь техникийн хүчин чадлыг нуралт устгал руу эргүүлж соёл иргэншлийг мөхөлд хүргэх хүчтэй. Одоохондоо бид сайн муу санааны мөн чанарыг төдийлөн сайн мэдэхгүй байгаа ч үүнд асар их хүч чадал оршдог нь маргаангүй. Сайн санааг шүтэх нь хөгжил дэвшилд, муу



санаа, эрх мэдлийг шүтэх нь дайн дажинд хүргэдэг нь цаанаа учиртай. Тийм учир хүний нийгмийн оюун ухаан, шашны хөгжил нь бүхэлдээ маш их утга учиртай бөгөөд бүр бодит байдалд шилжих чадвартай.

Миний бодлоор Япон улс шашин өндөр хөгжсөн орнуудын нэг (би японд 3 удаа очиж үзсэн болохоор байдлыг шүүн тунгааж чадна гэж бодож байна) бол АНУ энэ талаар нэлээд ядуу орнуудын нэг (би мөн л олон удаа очиж үзсэн бөгөөд байдлыг мэднэ гэж бодож байна). Япон улс нь дэлхийн хоёрдугаар дайны үед сүйтгэгдэж эзлэгдсэн байсныг үл харгалзан одоо хүн амын нэг бүрт жилд 35 мянган ам. долларын орлого ноогдож байхад, АНУ дайны үед дэлхийн хөрөнгийн ихэнхийг банкууддаа хураасан ч одоогийн хүн амын нэг бүрт оногдох орлого нь жилд 19 мянган ам. доллар байна. Үндэстний хөгжилд шашны хүчин чадлын үүрэг нь илүү байна.

Хүн төрөлхтөн сайн муугийн дэнсэн дээр тэгтлээ хэлбэлзэж байдаг юм гэж үү? Дэлхийн гамшиг болсны дараа дэлхий дээрх амьдарлыг баталгаажуулдаг бүх ертөнцийн зүй тогтоц байдаггүй гэж үү? Дэлхийн соёл иргэншлүүдийн оюуны болон бодит баялаг нь тэднийг устмагц эргэлт буцалтгүй алга болдог юм гэж үү?

Логикоор бол бүх дэлхийг хамарсан гамшигийн дараа дэлхий дээр амьдрал үргэлжлэхийг баталгаажуулдаг ямар нэгэн механизм байх ёстой.

Төвдөд Бурханы Хүү хаанаас гараад ирэв? Тэр чинь “тэнгэрээс унаад” ирээгүй биз дээ?



Тэр хаанаас ирэв?

Бурханы Хүүгийн зураг Төвдийн сүмүүд дээр дүрсэлсэн байгаа юм чинь манай иргэншлийн хүмүүс түүнийг бодитоор харж, түүнтэй харьцаж байсан байх нь. Тэр хаанаас ирсэн юм бол?

Өмнөх иргэншлүүдийн хүмүүс хадгалагдаж, тэндээсээ гаран бидний дунд үзэгддэг, нэгэн хадгаламжийн тухай бодол өөрийн эрхгүй төрж байна. Ямар хадгаламж байж болох вэ? Шамбалын орон уу?

Эдгээр асуулт намайг болон нөхдийг маань зовоож байлаа. Эдгээр асуултанд хариу олохын тулд бид Гималайн шинжилгээний аянд явсан юм.

Тэр үедээ бид уг шинжилгээний ангийн амжилтанд бидний Төвд сүм дээрх нүдийг шинжилснээр гаргаж авсан нууцат атлантын зураг (эсвэл Бурхны Хүүгийн?) гол үүрэг гүйцэтгэнэ гэдгийг мэдээгүй байлаа.



## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **“SoHm”- Хүн төрөлхтөнд зориулсан сүүлчийн илгээлт (Энэтхэгийн нээлтүүд)**

1-р хэсэг

**Хүн төрөлхтний үүсэл гарлын талаарх эрэл хайгуул, шинжилгээний олон улсын байгууллага**

2-р хэсэг

**Хүн төрөлхтний үүслийн талаар жирийн хүмүүс юу мэддэг вэ?**

3-р хэсэг

**Гитын сүмд**

4-р хэсэг

**Мастертай уулзсан уулзалт**

5-р хэсэг

**Онсогот самади**

## 1-р хэсэг

# Хүн төрөлхтний үүсэл гарлын талаарх эрэл хайгуул, шинжилгээний олон улсын байгууллага

Дэвшүүлсэн таамгаа зөв эсэхийг нь батлахын тулд бид Оросын гишүүдээс гадна Энэтхэг, Балбын төлөөлөгчид оролцсон олон улсын шинжилгээний анги зохион байгуулсан юм. Уг ангийг НҮБ-ийн Олон Улсын Шинжлэх Ухааны Академийн тэтгэлгээр байгуулсан. Олон улсын Нобелийн шагналтнууд, тэргүүлэх эрдэмтэд гишүүнд нь багтдаг уг байгууллага бидний судалгааг маш их сонирхсон.

Крымд болсон олон улсын хуралдааны үеэр уг хуралдаанд оролцсон Олон Улсын Шинжлэх Ухааны Академийн хэд хэдэн гишүүн ихэд сонирхон надтай хэлэлцэж, мөн уг байгууллагын гишүүн нь болох надад энэ байгууллагын тэтгэлгээр шинжилгээний анги зохион байгуулахыг зөвлөсөн юм.

Үнэнийг хэлэхэд барууны болон эх орны хүндэт эрдэмтэд нотлоход хэцүү уг сэдвийг харьцангуй хялбараар хүлээж авсан нь миний хувьд нэлээд санаанд оромгүй зүйл байлаа. Би ертөнц дээрх бүх юм харьцангуй байдгийн улмаас бараг тохиолддоггүй хөдлөшгүй баримтыг шинжлэх ухаан шаарддаг гэдэгт, шинжлэх ухааны хуучинсаг үзэлд болон орчин үеийн шинжлэх ухаан мэдрэмжид тулгуурласан логик шинжилгээний арга замыг хүлээж авдаггүй ба өнөөгийн шинжлэх ухааны түвшинг ягшмал номлол гэж үзээд, үүнээс логик замаар гажихыг муу шинж гэж үздэгт дассан байжээ.





*Энэтхэгт болсон нүд судлалын бага хурал дээр*

Тэр үед би мэдрэмжинд тулгуурласан логик нь шашны ухамсарыг тодорхойлогч тал нь болдог, бидний уулзах шашны мастеруудын хувьд уг логик сэтгэлгээ нь бидэнд лам, хамба (свами) нарын зарим нэгэн нууц мэдлэгийг нээх гол итгэлийн тулгуур нь болно гэдгийг мэдээгүй байлаа. Мөн хүний эерэг хөгжлийн 5 шинжийн нэг нь хийсвэр сэтгэлгээ байсныг мэдээгүй. Энэ шинжилгээний анги нь Олон Улсын Шинжлэх Ухааны Академийн нэрийн дор яваа нь ихээхэн ач холбогдолтой хэрэг гэж би бодож байлаа.

Бидний хамгийн их эмээж байсан зүйл бол бидэнд итгэхгүй байх гэсэн болгоомжлол байсан юм. Орчин үеийн шинжлэх ухаан болон шашны мэдлэгийн хоорондох зарим нэгэн сөргөлдөөнтэй талууд нь бидний ажлыг хүндрүүлж магадгүй байлаа. Бясалгал, йог мэтийн орчин үеийн шинжлэх ухаанаар тайлбарлахад хэцүү шашны төлөв байдлуудыг хүний төгс оршихуйн нэгэн арга хэмээн үздэг Балба, Энэтхэгийг дутуу үнэлж болохгүй байлаа. Биднийг тэнэг сурагчид шиг хүлээн авч, ямар ч гүн нарийн компьютерийн шинжилгээ танилцуулсан ч бидэнтэй энгийн болхи хэлээр ярьж магадгүй байлаа.

Тийм учраас бид Энэтхэг, Балбын нүд судлалын төвүүдтэй холбогдож тэдний тусламжтайгаар Энэтхэг, Балбын хэд хэдэн хотод уулзалт, хуралдаан, орон нутгийн эмч нарт үзүүлэх хагалгаа зохион байгуулсан юм. “Аллоплант” гэх өөрийнх нь эдийг (цусны судас, тунгалаг эвэрлэг, арьс г.м.) эргэн ургуулах арганд үндэслэсэн нөхөн суулгавар материалыг ашиглаж хийсэн хагалгаа маань найдваргүй болсон өвчтөнүүдэд тусладгаараа арав гаруй жил дэлхийн нүд судлаачдын дунд онцгой анхаарлыг татаж байгаа юм. Зарим хотын тэргүүлэх



*Энэтхэгт болсон нүд судлалын бага хурал дээр*

нүдний эмч нар тэндээ удирдах ажилтнаас ч илүү халдашгүй нэр төртэй байдгийг бид туршлаганаасаа мэднэ.

Цөөнгүй улсын хэлэнд нүдийг “сэтгэлийн толь” гэдэг учир тухайн улсын тэргүүлэх нүдний эмч нар биднийг шашны мастерууддаа танилцуулах нь ихээхэн ач холбогдолтой байж болох юм.

Бидний сонгож авсан зам нь Энэтхэг, Балбын шинжлэх ухааны үүднээс сонирхол татууштай индуист болон буддист сүм дуганы ихээхэн төвлөрөлтэй олон хотоор дайрч өнгөрөх байлаа. Уг хотууддаа бид шашны түүх судлаач эрдэмтэдтэй уулзахаар төлөвлөсөн. Мөн Балбын алс холын уулсад байрлах жижиг дугануудаар орж даянч лам нартай уулзах төлөвлөгөөтэй байлаа. Энэтхэг рүү Сергей Селиверстов, Венер Гафаров бид гурав явж, тэндээс Балбад биднийг хүлээж буй Валерий Лобанков, Валентина Яковлева хоёр луу нисэв. Энэтхэг, Балбад ирэхэд манай шинжилгээний ангийн Энэтхэгийн (Пасрича эмч) болон Балбын (Шесканд Ариэль, Кирам Буддаачарайя) төлөөлөгчид бидэнтэй нэгдсэн. Азаар бид бүгд олон улсын харилцааны хэл болсон англи хэлийг сайн муу янз бүрийн түвшинд эзэмшсэн байсан ба энэтхэг балбын төлөөлөгчид маань орон нутгийн хэл болох хиндү, балба хэл мэддэг байлаа.





Э. Р. Мулдашев  
Шинжилгээний ангийн  
дарга




В. М. Лобанков  
Даргын орлогч



В. Г. Яковлева



С. А. Селиверстов



В. Г. Гафаров



Доктор Пасрича  
(Энэтхэг)



Ш. Ариэль  
(Непал)



К. Буддаачарайя  
(Непал)

2-р хэсэг

## Хүн төрөлхтний үүслийн талаар жирийн хүмүүс юу мэддэг вэ?

Хэрвээ Орос, Америк, Герман зэрэг орны жирийн хүмүүст ийм асуулт тавих юм бол зарим нь хүн сармагчнаас үүссэн гэж шууд хэлж, зарим нь Дэлхий дээр хүний үрийг харь гаригийнхан авчирсан гэж хариулах бөгөөд ихэнх нь чамайг хачирхан харж “мэдэхгүй” гэгчихээд, юун үүнтэй манатай өнөөдөр дэлгүүр явах,



*Намбагүй төрлүүд маань мөн үү?*



*Эгэл жирийн хүмүүс хүн бурхнаас үүсэлтэй гэдэгт үнэн голоосоо итгэдэг*


хүндэтгэл төрүүлдэггүй бололтой. Харин үхэр бол тэдний хувьд ариун амьтан гэнэ.


Эдгээр орны хүн ам нь хүн төрөлхтнийг бурхан үүсгэсэн гэдэгт итгэдэг. Энгийн хүмүүс үүнийг яг сайн тайлбарлаж чадахгүй л дээ. Тэд зүгээр л хүүхэд байхаасаа Буддын энэ сургаалыг тогтоосон байдаг. Гэсэн ч “билгийн нүд”, “нигүүлсэнгүй сэтгэл”, “бясалгал” гэх мэтийн үгсийг мэддэг. Эдгээр орны жирийн хүмүүс юун түрүүнд ертөнцийн мөн чанарын тухай шашны агуу сургааль болон сэтгэл оюуныг дээдлэх хэрэгтэй гэдэгт үнэн голоосоо итгэдэг хэдий ч шашны сургаалийн мөн чанарын тухай яригдахад голцуу үг яриа нь эвлэрч өгөхгүй “Энэ ч ярвигтай зүйл” гэх вий.

Миний үзэж байгаагаар Буддын шашин нь дэлхийн бусад шашнаас илүү энгийн хүн байтугай үзэл бодол нь хэт бодитжсон эрдэмтэд ч ойлгоход бэрх шинжлэх ухааны гүн утга агуулгатай. Жирийн Тай (Тайланд) юм уу, Энэтхэг хүний ярих Москвагаас Бомбейд очвол Бомбейд очсоноосоо болж зовдог, Москвадаа буцвал Бомбейгээс явсанаасаа болж зовдог гэх мэт ертөнцийн зовлонгийн үүслийн тухай хүүрнэлийг өнөөгийн эрдэмтэд хэзээ ч ойлгохгүй.

ногоо суулгах, өрөө төлөх гэх мэтийн хар мянган ажил байхад гэсэн аятай яваад өгнө. Дарвинархуу нэг онолд хүмүүсийн янз бүрийн бүлэглэл өөр өөр төрлийн сармагчингаас үүсэлтэй гэдэг бөгөөд энэ талаар хүмүүсийг хатгаж асуухад ихэнх нь макаки шимпанзе хоёрын алинаас нь үүссэнээ сонгож ядахдаа төрлийнхөө намбагүй байдлыг голж Дарвины онолыг буруутгадаг.

Энэтхэг, Балбад энэ зэвүүн асуулт зөвхөн хүмүүсийн инээдийг хүргэх бөгөөд нэг ч хүн сармагчнаас үүссэн гэж дурьдахгүй. Тэдэнд байшингийн дээвэр дээр үсчин дэвхцэж, хогийн савны байнгын жижүүр байдаг сармагчингууд нь энд бидний хувьд хэрээ, тагтаа, болжмор шиг санагдан эцэг өвгөдөө гэсэн ямар нэгэн






Энэ мэт бүдүүн бойрог тайлбар байдаг байлаа ч сэтгэл оюуныг дээдлэх үзэл үр шимээ ямагт өгдөг. Жишээ нь бараг тэрбум хүн амтай энэтхэгт хүн амын 40% орчим нь манай хамгийн ядуучуудын зүүдэнд ч оромгүй ядуу амьдралаар амьдардаг боловч гэмт хэрэг, ялангуяа бүдүүлэг аллага юм уу хүчингийн хэрэг гардаггүй. Өдрийн цагаар явахад ч аюултай байдаг Нью-Йоркийн хүн амын 40% нь тансаг орд харшнаасаа гаран уранхай цаас, даавууны өөдсөөр дээвэр хийж, үхрийн баасаар шалыг нь цутгасан овоохойд амьдрах юм бол Америк юу болохыг би төсөөлж байна. Шашингүй үзэл цэцэглэж байсан хуучны коммунист орнуудын тухай бол яриад ч

хэрэггүй.

Буддын шашны бараг бүх урсгалд амьдрал үхлийн эргэлтийг бэлгэдсэн хүрд байдаг. Энгийн хүмүүс сүнс сэтгэлийн мөнх байдлыг амьдрал үхлийн мөчлөгтэй уялдуулан мэдрэх гэж сүм дугануудад байрласан эдгээр хүрдийг эргүүлдэг. Дорны хүмүүс араас нь дахин өөр амьдрал ирнэ гэдэгт итгэдэг учраас үхлээс айдаггүй. Энэ нь зарим талаараа Энэтхэг Балбын жолооч нарын машин жолоодох арга барилаас харагддаг. Энд зам нь нарийхан муугаас гадна хурдны хязгаар байхгүй. Аварга том “Тат”-аас эхлээд зуушны лаазнаас томгүй “Марути” хүртэл бүх машин асар их хурдтай явж, гурав дөрвөн машиныг гүйцэж түрүүлэн давхидаг. Өөрийн эрхгүй эх орныхоо өнөө муу замын цагдааг сайнаар дурсдаг. Яг л халз дайралтанд орж байгаа юм шиг сэтгэгдэл төрж байсан. Үхэж магадгүй шүү дээ гэхэд жолооч толгой сэгсрэн бүхий л байдлаараа үнэхээр тэгж магадгүй гэдгийг харуулж байв. Энэтхэг Балбын 1000 километр замыг арай л гэж туулсан. Ямар ч байсан бид амьдралтай тийм ч амархан салах ёс хийчихэж сураагүй аж.

Би янз бүрийн шашны гол ёс заншлыг бишгүйдээ л нэг харж байсан. Ялангуяа лалын шашинт улсууд болох Иран, Йемен, Иордан, Арабын Эмират, Бахрейнд явж байхдаа би шатаж үхэм халуунд нүүрнээсээ эхлээд таглаж болох



*Сүнсний мөнх, амьдрал үхлийн эргэлтийг бэлгэдсэн хүрд*

бүх л зүйлээ тагласан хар хиджап өмсөх ёстой эмэгтэйчүүдийг нь хараад өрөвдөж байсан. Магадгүй тэдэнд ч гэсэн өгөрсөн хиджапаасаа салж, шинэ даашинз өмсөж, уруулаа будан, нүдээ хүрээлмээр л санагддаг байх. Эрчүүдийнх нь сэтгэлд ч бас дарсгүй хурим гэх мэт үйл ажиллагаа тэгтлээ их нийцдэггүй л болов уу. Ихэнхдээ эдгээр улсад шашны хэт сүжиг бишрэл нь улс төрийн бодлоготойгоо нийцдэг нь магадгүй хэн нэгэнд эрх мэдлээ хадгалан үлдэхэд нь нэмэр болдог байх.

Буддын шашин нь хүний амьдралын бүх үйл ажиллагаанд ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүйгээрээ маш нигүүлсэнгүй шашин юм. Нийтэд нөлөөлөх хөшүүрэг нь огт өөр байдаг. Буддын

шашин хүнийг хэзээд гэсгээж болох амьдралын хязгаарлалтыг тахин шүтэх бус, харин ухамсар, нигүүлсэнгүй сэтгэл, бясалгал зэрэг ойлголтоороо хүний сэтгэлийг тахин шүтдэг. Сэтгэлдээ гүнзгий нэвтрэх, таних зорилготой байгуулсан сургалтын сүлжээ ч байдаг. Миний бодлоор ийм үйлчлэлийн нийтэд үзүүлэх хүч нь ер бусын юм. Бид зөвхөн ганц л удаа Энэтхэгийн баруун хойд нутаг дахь сикхийн сүмд сүжигтэнүүд дуганы шатыг ихэд сүсэглэн үнсэж байхтай таарсан нь ойлгомжтой шалтгаанаар халдвар тархаах аюултай байлаа.

Буддын шашны сэтгэлийг тахиx үзэл нь бага ч гэсэн боловсролтой байхад л хүн төрөлхтний үүсэл гарлын тухай бидний таамгыг маш амархан хүлээж авах шалтгаан болж байв. Ялангуяа Энэтхэгт олон удаа зохион байгуулсан уулзалт, үдэшлэг дээр энэ сэдвээр хийсэн ярилцлага бүгдэд нь сонирхолтой байдаг болохоор ёс юм шиг биднийг дагацгаан элдвийг ярьдаг байлаа. Бүх сонсогчийн сэтгэл хөөрөөд, энэ талаар юу мэддэгээ ам уралдан ярцгаадаг бөгөөд бид ёс болгон бичиж тэмдэглэдэг боловч их ач холбогдол өгдөггүй байсан. Гэхдээ хамгийн тэмдэглүүштэй нь орчин үеийн материалист шинжлэх ухааны түвшинд хэмжиж, тэмтрэх боломжгүй зүйлийг хийсвэр сэтгэлгээний түвшинд ухамсарлаж болно гэдэг нь хэн ч эргэлзэж байгаагүй. Учир нь тэндхийн хүн бүр дээд хүчин байдаг гэдэгт, дээд хүчинтэй харьцуулахад хүний мэдлэгийн түвшин болон хүчин чадал харьцуулшгүй өчүүхэн, зөвхөн хийсвэр сэтгэлгээний хүчээр мэдэхгүйд нэвтэрч болно гэдэгт итгэдэг.



*Бясалгалын багш*

Бараг хүн болгон looking inside (дотогшоо харах) гэсэн гол үүрэгтэй “билгийн нүд” буюу “гурав дахь нүд” байдаг гэдэгт итгэдэг. Зарим нь доод зовхины шүргэгч шулуунууд дээр байрладаг хамрын гол цэгийн тухай яриуц уг цэгийн үүргийг нь хэлж мэдэхгүй байв. Ихэнх хүн Будда өмнөх соёл иргэншлийн мэдлэгийг бидэнд авчирсан гэж үзэж байв.

Орос хүн хүрээлэн буй ертөнцийг нэлээд бодитой төсөөлдөг. Тэдний сонирхлыг сүнс, сэтгэл гэх мэтэс бараг татдаггүй атлаа хүний үүсэл гарал болон хааяа зурагтаар гардаг хадаасан дээр хэвтэх зэрэг үзүүлбэр сонирхолыг нь маш их татдаг. Мэдээж Оросуудыг ерөөсөө шүтлэггүй гэж болохгүй ч тэд зөвхөн

хүний гараар бүтсэн зүйлийг бодитойд тооцдог. Жишээ нь манай гишүүн Сергей Селивестров Катмандуд оросын уулчдын багтай таарсан бөгөөд тэдний нэг нь манай шинжилгээний ангийн тухай нийтэлсэн “Аргументы и факты” сонинг барин:

- Яасан, танай ахлагч чинь хийх юмаа олж ядаа юу? Нүднийхээ хагалгааг л хийж байхгүй....-гэжээ

Үнэнийг хэлэхэд энэ үгийг сонсоод би гомдох шиг болсон. Яагаад гэвэл би жилдээ 300-400 хүндээс хүнд хагалгааг гардан явуулдаг. Мэдээж бидний санаачлан зохиож, найдваргүй гэгдэж байсан хэдэн сая өвчтөнд аль хэдийнээ үр дүнгээ өгсөн “аллоплант” сүүлийн үеийн судалгаагаар биоэнергийн онцгой шинж чанартай гэдгээ харуулж, гагцхүү “биологийн болон сэтгэлийн энерги” гэдэг ухагдахууныг гүнзгий ойлгосноор бид өвчтнүүдэд тус болж болох эмчилгээний шинэ арга зүйг ахин боловсруулах боломжтой болно гэдгийг түүнд тайлбарлах аргагүй. Мөн найдваргүй гэгдсэн өвчтөн шинжлэх ухаан шалдаа хүрсэн туушич үзлээрээ түүнийг аврах шинэ арга боловсруулах цагийг хүлээхийг хүсэхгүй байгаа бөгөөд эрүүл мэнд, нүдний хараагаа өнөөдөр л эргүүлэн авахаар тэмүүлэх нь ойлгомжтой. Хүн төрөлхтний талаас илүү хувь нь Буддын шашинд итгэдэг нь учиртай бөгөөд уг эртний мэдлэг нь урьд өмнөх илүү хөгжилтэй соёл иргэншлийн мэдлэгийн нэгээхэн хэсэг байж болох ба үүнийг өнөөгийн шинжлэх ухаантай хослуулснаар адаглаад анагаах ухааны олон нууцуудаас нэгийг нь ч гэсэн нээх боломжтойг хуучинсаг үзэлтэй хүн тэр бүр ойлгохгүй.





*Найдваргүй болсон өвчтөн  
өнөөдөр хараатай болохыг  
хүсч байгаа*


Гэвч, ерөнхийдөө орос хүн коммунист нийгмийн үеийн бурхангүй хүмүүжлээр өссөн ч америкчуудаас илүү уян хатан, шинийг хүлээн авах чадвартай байдаг гэж би боддог. Америк нийгмийн долларыг шүтэн бишрэх ужиг үзэл нь цөөн хэдэн хүнээс бусдыг нь зөвхөн мөнгө олох шинэ боломжийг хүлээн авах чадвартай болгож хувиргасан.

Хүмүүс олон янз байдаг бөгөөд амьдралын бодит болон оюунлаг талыг тусгаж авах чадвараараа ч мөн ялгаатай. Юутай ч хүмүүс ядахдаа л үүсэл гарал нэгтэйгээрээ адил. Өөрсдийн амьдралын хүрдэнд ахуйн түмэн асуудлын хүрээнд эргэлдэж буй энгийн хүмүүс энэ тухай бодол болдоггүй ч, хамгийн бага боловсролтой ч бай хүн бүхэнд бид хэнээс үүссэн нь сонин байдаг.

3-р хэсэг

## ГИТЫН СҮМД

Энэтхэгийн жижиг хотуудын нэгэнд (Карнал хот) байдаг Гитын сүм хашааг нь дагуулан чимэглэсэн янз бүрийн хөшөө, хашаан доторх мөн л амьдралын ямар нэгэн дүр төрхийг бүрдүүлсэн хөшөөнүүд, сүм дэх олон арван зураг нь уг цогцыг туйлаас төгс төгөлдөр харагдуулсан маш үзэсгэлэнтэй газар байлаа.



*Гитын сүм*

Эх гэлэнмаагийн нөхөр болох нэгэн өвгөн биднийг угтсан. Тэрээр Гитын сургаал бол хүний мэргэн оюуны тухай сургаал бөгөөд гол зангилаа нь хүн эрх мэдлээ алдаж эхэлсэн ч хадгалан үлдээх бүрэн дүүрэн сонирхолтой байх үедээ хэрхэн дайтаж эхлэхгүй байх тухай номлол юм гэж бидэнд яриу.

Эх Деялтай хийсэн ярилцлагаа бид энэтхэг эмэгтэйчүүдийн духандаа тавьдаг гоо сайхны толбын талаар эхэлсэн юм. Энэ нь эмэгтэй хүний каст буюу нийгмийн байр суурийг илэрхийлдэг тэмдэг огт биш бөгөөд заримдаа эмэгтэйчүүд нөхөрт гарсны илэрхийлэл болгон тавьдаг хэмээн тайлбарлаж өгөөд, гэхдээ эрт дээр үед уг толбыг хүмүүс (эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай) өөрийн дотоод сэтгэлээ ойлгож байгаагийн баталгаа болгон тавьдаг байсан гэв.

- Ийм энэтхэг толбыг дээр үед байсан “гурав дах нүд”-ний дурсгал болгон тавьдаг уу?- гэж намайг асуухад,

- Би яг сайн мэдэхгүй. ... Шашны сударт тодорхой юм байхгүй. ... Гэхдээ “гуравдах нүд” байсан, байсаар ч байгаа гэдгийг би мэдэж байна.

- “Гуравдах нүд” ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? – гэхэд,

- Манай шашин “гуравдах нүд”-ийг үндсэн 3 үүрэгтэй гэж үздэг. Эхнийх нь inside vision (дотоод хараа) буюу дотогшоо харах, дотор эрхтэнээ харах г.м., хоёр дахь нь meditation vision (бясалгалын хараа) буюу сэтгэлээ харах чадвар, гурав дахь нь intellectual vision (оюуны хараа) буюу өөрийн болон ярилцагчийнхаа оюуны мэдлэг боломжийг мэдрэх чадвар юм.

Тэр мөчид би “билгийн нүд”-ний нэг дэх үүргийг нэлээд сайн мэдэрч байсан бөгөөд эмчийн үүднээс хүний биеийг нэвт гэрэлтүүлдэг рентген төхөөрөмж шигээр төсөөлж байлаа. Ямар ч хүн ямар нэгэн аргаар үгийн баялаг сайн мууг нь үл харгалзан тэнэг хүнийг ухаалаг хүнээс ялгаж чаддаг нэгэн мэдрэхүйтэй байдаг



*Деял эх Гитын сүмд*

учир гурав дахь үүрэг нь мөн адил ойлгомжтой. Харин хоёр дахь үүргийг нь ойлгоход хэцүү байв. Би үүний цаана хамгийн сэтгэл догдлом оньсого болох бодит байдалд шилжсэн бясалгал буюу самади нуугдаж буйг гадарласан ч үгүй.

Дараа нь бид үлгэр домогт гардаг атлант хүний “хачин хамар”-ыг дурсан хамрын тухай ярианд шилжив. Эх-гэлэнмаа хүний хамар нь амьсгалын, үнэр мэдрэхүйн үүрэгтэй бөгөөд хүндэтгэлийн шинж чанартай хэмээн хариулав. Хэрвээ хүнийг хамраас нь бариад авбал энэ нь доромжилсон хэрэг болдог гэж сүүлийн үгээ тайлбарлав.



- Энэтхэг мастер Ананта Кришна өмнөх иргэншлийн хүний хамар нь хэт авианы болон хэт улаан туяаны үелзлээр дуу авиа гаргах үүрэгтэй байсан болохоор илүү чухал эрхтэнд тооцогддог байсан гэж хэлсэн. Магадгүй тийм учраас хамрыг эртнээс эрхэм эрхтэн гэж үздэг байсан юм болов уу гэж би асуув.

- Ананта Кришнагийн зөв байхаа гэж эх хариулахад нь би,
- Та эртний хүмүүсийн талаар юу мэдэх вэ гэж асуув.
- Их олон зүйлийг мэднэ...
- Бидэнтэй хуваалцаач?
- Энэ бол нууц мэдээлэл гэж эх хариулав.

Бидэнд өөр юм хэлэхгүй юм байна гэдгийг би ойлгов. Би Венер Гафаров руу харахад тэрээр цаашдын асуулга ямар ч хэрэггүйг илтгэн толгой сэгсэрч буй



*Гитын сүмний дотоод байдал*

харагдав. Яагаад бидэнд итгэхгүй байгаа юм бол? Судалгааны баримтаа яаж үзүүлвэл дээр вэ? Тэр үед би шашны томчууд сэтгэлгээний хувьд биднээс өөр, компьютерт оруулсан судалгааны материал маань тэднийг биднээс улам түлхэх юм гэж бодсонгүй. Барууны эрдэмтэдтэй харьцаж байсан туршлагадаа дулдуйдан судалгааны логик аргыг илүүтэй дурьдаагүй маань алдаа болж чухам энэ логик сэтгэлгээг ярьсан бол тэдний сэтгэлийг нээх байсныг ойлгоогүй явж.

- Өмнөх иргэншлийн хүмүүс голдуу So(соу), Hm(хм) гэсэн хоёр авианы хүрээнд ярьдаг гэсэн мэдээлэл бий. Энэ үнэн үү гэж арга тасарсан би асуувал,

- “So” “Hm” хоёр бол агуу үгнүүд юм гэж эх гэнэт хариулав.

- Юу юм бэ гэж би зориг муутайхан дуугарвал,

- “SoHm” бол сүүлчийн илгээлт.

- Сүүлчийн?

- Last message (сүүлтийн илгээлт), гэж эх тодоос тод хариулав.

- Хэний?

- Дээд Оюун Ухааны.

- Хэнд зориулсан?

- Хүн төрөлхтөнд.

- Яагаад сүүлчийн илгээлт гэж байгаа юм бэ?

- Дахин хэзээ ч тусламж ирэхгүй...

- Ямар тусламж?

- Энэ бол нууц.

Бид эхэд талархлаа илэрхийлж, цуг зургаа авахуулаад, зочид буудал руугаа явах замдаа дөнгөж сая болж өнгөрсөн ярилцлагын талаар тал бүрийн таамаг дэвшүүлцгээж явав.

Хэрвээ цаашдаа ч гэсэн гол гол газар нь энэтхэгийн шашны зүтгэлтнүүд “Энэ бол нууц” гээд байх юм бол бид юу ч мэдэж авч чадахгүй нь гэж би шантарч эхэлж байлаа. Яаж тэднийг жоохон ч гэсэн тэр нууцаасаа ярьдаг болгох вэ?

---

## 4-р хэсэг

# Мастертай уулзсан уулзалт

Энэтхэгийн дараагийн хот биднийг аагим халуунаараа төөнөн угтав. Тэнд бусад хотод хийсний адил үзүүлэх хагалгаа, хурал зохион байгуулж, хурлын төгсгөлд хүний үүслийн талаарх өөрсдийн таамгаа слайдан дээр үзүүлээд, шашны тэргүүнүүдийн хэнтэй нь уулзвал илүү үр дүнтэй талаар санал асууж явав.

Маш олон нэр дурдагдсан боловч хүн болгон Сабва Манаям гэдэг мастерыг онцгойлон нэрлэж байлаа. “Тэрбээр гэгээнтний уддисыг эзэмшсэн хүн бөгөөд ярианы үедээ зайн гипнозоор үйлчилдэг. Мөн түүний удирдсан Рама Кришнагийн сургууль нь Энэтхэгтээ л дээгүүрт тооцогддог. Энэ мастер маш өвөрмөц мэдлэг ухааныг өвлөн авсан хүн.” гэцгээж байлаа.

Энэ хүнтэй уулзах уулзалтыг түүнийг биечлэн таньдаг энэ хотын нүдний тэргүүлэгч эмчийн аав нь зохион байгуулж өгөв. Тус сургууль руу явж байх замдаа бид түүнээс мастер, хамба (свами) гэсэн хоёр нэр томъёны учрыг лавласан юм. Мастер гэдэг нь шашны гүн мэдлэгийг эзэмшиж уг мэдлэгийг ямар түвшинд хэнд өвлүүлэх вэ гэдгээ өөрөө шийдэх эрхтэй хүнийг хэлнэ. Дээд Оюун Ухаан мастеруудаар дамжуулан хүмүүст нөлөөлдөг гэж үздэг. Харин свами гэдэг бол индуист шашны мастерт өгч болох хамгийн дээд цол юм.

- Мастер та нарын зорилгыг мэдэж байгааг бодолцоорой - гэж эмчийн аав нь хэлээд - Тэр өөрийнхөө сургаалийн үеэр та нарыг зайнаас ховсдох гэж оролдох учир түүний сургаалийг богинохон байлгахыг хичээгээрэй. Мөн харцыг нь дааж гарахыг хичээгээрэй. Учир нь харцыг нь дааж гарахгүй бол тэр та нарыг сэтгэлийн тэнхээгүй сул хүмүүс байна гэж бодоод юм хэлж өгөхгүй л болов уу. Мастер хүн хэнд ямар мэдлэг үлдээхээ өөрөө шийддэг гэв.



*Рама Кришнагийн ашрам*

Рама Кришнагийн сургууль нь хатуу өнгө төрхөөрөө онцгой сэтгэгдэл төрүүлж байлаа. Илүү дутуу юу ч байхгүй энгийн шал, хана, таазтай, хананд шашны тэргүүнүүдийн зураг өлгөөтэй байсан. Бүх юм ганцхан улбар шар өнгөтэй.

Мастер ч мөн адил улбар шар хувцастай байлаа. Түүнтэй цуг 5 хүн бараа болж байв. Ширээний нэг талаар бид, нөгөө талаар мастер бараа бологсдынхоо хамт суув. Яг түүний өөдөөс харан Венер Гафаров сууж, Венерийн зүүн талд Сергей Селивестров, баруун талд нь би сууж таарав. Мастерын өөдөөс харан суух нь юутай хүнд сорилт болохыг Венер тэр агшинд мэдсэнгүй.

- Та бүгд гүн мэдлэгийг олж авахаар ирсэн гэж би сонссон юм байна гэж мастер асуухад нь,

- Бид таны мэдлэгийг өөрсдийнхтэйгээ жишиж үзэхээр ирсэн юм гэж би хариулав.

- Таны мэдлэгээ? Ямар? гэж мастер над руу гүйлгэн харангаа асуугаад, - хүмүүс ч юм ойлгож эхэлсэн байна шүү...

- Бидний судалгааны гол үр дүн энэ байна гээд би атлантын зургийг үзүүлэхэд мастер авахаар гараа сунгаснаа хармагцаа эргээд гараа татчихав.

Би хажуу тийш маш эвгүй сунан зургийг түүний өмнө тавилаа. Тэр дахин нэг хялайж харсан боловч гартаа авсангүй.

Нам гүм болов.

- Та үүнийг хаанаас мэдэв гэж аниргүйг эвдэн мастер асуухад,

- Янз бүрийн үндэстнүүдийн нүдний судалгааны үр дүн. Судалгааг товчхон тайлбарлахыг зөвшөөрнө үү?

- Та Төвдөд очиж үзсэн үү?

- Үгүй ээ, үзээгүй.

- Төвд лам нартай уулзаж байсан уу?

- Үгүй.

- Энэ тухай төвд лам нар илүү мэддэг.

За, товчхон тайлбарлаж өгнө үү?

- Би шинжилгээний материалуудаа гарган бидний судалгааны мөн чанарыг болон нүдний компьютерийн шинжилгээгээ арай түлхүү тайлбарлан мастер дэлгэрэнгүй ярьж өгөв.

Мастер анхааралтай сонсож байснаа гэнэт:

- Компьютер чинь сэтгэлгүй. Оросууд та нар яг л Америкчууд шиг ярьж байна. Энэтхэг өндөр оюуны хөгжилтэй орон учраас америкчууд биднийг үзэн яддаг. Сэтгэлгүй Америк хүн ертөнцийг мөхөлд хүргэх болно.

- Би гаргаж авсан үр дүнгээ...

- Оюун ухаан гэдэг бол дан ганц тархи биш, - хэмээн мастер намайг сонсоогүй мэт үргэлжлүүлэн, - бие гэдэг нь утга учраараа сэтгэлээс бага юм. Сэрэхүйг ойлгох нь чухал. Бид юу харж байгаагаа дүгнэж, сэрэхүйгээ нэмэгдүүлэн хүчтэй болгох нь чухал. Учир нь зөвхөн хүчтэй сэрэхүй л зөв байж чадна. Шашин гэдэг нь хэсэг бус, харин бүтэн сэрэхүй юм. Хувь хүний оюун ухааныг ертөнцийн оюун ухаанаас ялгаж сурах хэрэгтэй. Миний сэрэхүй бол ертөнцийн оюун ухаанаас үүдэлтэй...

Мастер алдарт сургаалиа эхэлжээ гэдгийг би ойлгов. Тэрээр видеокамераар бичлэг хийж байсан Сергей рүү нэг, дараа нь над руу нэг хараад, (би толгойгоо бөхийлгөн тэмдэглэл хөтөлж байсан юм) өөдөөс нь харан сууж, нүд рүү нь ширтэж байсан Венер Гафаров дээр харцаа тогтоов. Бидэн дээр азаар тусаагүй тэр харцны хүндийг Сергей бид хоёр тэр даруйд нь мэдрэв. Ямар нэгэн хүнд зүйл дарж, бидний тархи толгойг онгичин, эс болгоноор нь задалж буй мэт мэдрэмж төрөв. Би тэмдэглэлээ хөтлөн бүр доош харж, Сергей бичлэгээ тасралтгүй хийсээр байлаа.



*Мастер*



- Сэтгэл оюуны хөгжил нь маш чухал үүрэгтэй, - гэж мастер үргэлжлүүлээд, - Рама Кришнагийн сургаалиар бол сэтгэлийн хөгжил нь бодит шинж чанартай бөгөөд хамар нүд болон бусад эрхтний хэлбэрээр илэрхийлэгддэг. Хүний шар нүд илүү...

Түүний харцанд төөнүүлсэн Венер Гафаров хааяа нүдээ анин, хүчээр арай ядан нээж, дахин нүд рүү нь ширтсээр суув. Духан дээгүүр нь хөлс бурзайн, нүүр нь улайж зовхи нь хавдан, хуруунуудаа атгаж тавьсаар байв. Сергей бид хоёр түүнийг мастериин ховсыг эсэргүүцэж ядан буйг ойлгож байлаа. Бид арай дээр байдалд байсан юм.

Мастер арай гэж яриагаа дуусгав. Энгийн бүр дулаахан гэмээр харцаар биднийг харахад нь

- Юм асууж болох уу?- гэж би асуув.

- Болно.

- Дөнгөж сая та зөвхөн нүдээрээ маш онцгой үйлдэл хийлээ. Үүнийг “гуравдагч нүд”-ний үйлчлэл гэж хэлж болох уу?

- Бараг л болно доо.

- Оросын алдарт эрдэмтэн Николай Рерихийн хайж байсан Шамбал гэж юу вэ?

- Энэ бол цэвэр сэтгэхүйн ойлголт. Бодит зүйл биш учир үүнийг хайгаад хэзээ ч олохгүй. Энэ бол дээд төрөлтний амьдардаг нутаг бөгөөд дээд төрөлтөн нь сэтгэл оюуны хувьд жирийн хүний хүршгүй хөгжлөөрөө ялгардаг.

- Мастераа,- гээд би үргэлжлүүлэн,- “Гайхамшигтай болгон энгийн байдаг.” гэсэн бурхны нэг зарчим байдаг. Учир нь байгаль дэлхийн хууль, зүй тогтоц гайхамшигтай энгийн. Харамсалтай нь энгийн гайхамшигийг бид тэр бүр ухамсарладаггүй учир “дээд оюун бол та нарын хүрэхгүй зүйл...” гэх мэтийн ерөнхий өгүүлбэрээр халхавч хийдэг. Үүнтэй холбоотойгоор би нэгэн зүйлийг асуух гэсэн юм. Та Шамбалын тухай ямар нэгэн тодорхой зүйл мэддэг үү?

- Би мэднэ...

- Юуг?

- Шамбал гэдэг нь яг ч оносон нэр биш. Түвдийн хэдэн лам нараас дэлхийгээр тарж, Рерихийн ном гарсны дараа нийтэд танил болсон үг. Та нарын Шамбал гэж нэрлэдэг юм байдаггүй. Харин дээд оюуныг ухамсарлахад хүргэдэг биеийн болон сэтгэлийн төлөв байдал гэж байдаг. Уг төлөв байдлыг бид маш сайн ойлгодог. Түүнд хэрхэн хүрэхийг бид заадаг гэж мастер хариулав.

- Энэ нь ямар төлөв байдал юм бэ?

- Сэтгэлийн энергийн хүчээр биеийн бодисын солилцоо тэгтэй тэнцүү болох төлөв байдал юм.

- Тэгээд үүнд чинь Дээд Оюун ямар хамаатай юм бэ?

- Учир нь уг төлөв байдалд байгаа хүн өөрийгөө өөртөө бус, харин бүх хүн төрөлхтөнд, газар дэлхий дээрх амьдралд зориулдаг.

- Тайлбарлаад өгнө үү?

- ...

- Юу гэж ойлгох вэ?

- ...

Бид бас л нэгэн том нууцад дөхөж очжээ гэдгийг, мөн мастерт бид үнэхээр таалагдсан ч тэр бидэнд юу ч хэлэхгүй нь гэдгийг би ойлгов.

- Бидний судалгаагаар хүн төрөлхтөн Гималайд үүсээд тэндээсээ дэлхийгээр тархсан,- гэж би нөгөө талаас нь эхлэхээр шийдээд,- Тэгвэл дээд оюунтан гэж төвд үндэстнийг хэлж болох уу?

- Маш эрт дээр үед Гималайн хүмүүс дэлхий дээрх дээд төрөлтөн байсан ба Гималайн бүс сэтгэл оюуны өндөр хөгжилтэй газар байсан. Гэвч одоо тэр цаг үе өнгөрч, өнөөгийн төвдүүдийн талаар мөн зүйлийг хэлэхийн аргагүй болсон гэж мастер хариулав.

- Тэгэхээр эртний төвдүүд бодисын солилцоогоо тэгтэй тэнцүү болгож, өөрийгөө хүн төрөлхтөнд зориулж чаддаг байсан юм уу?

- Чаддаг байсан.

- Яаж?

- ...

- Үүнд “гуравдагч нүд”-ний үүрэг нь юу юм бэ?

- ...

- Хамрын үүрэг нь?

- Юу ч биш.

Би маш их ядарсанаа мэдрэв. Венер Сергей хоёр ч мөн хоёр цаг үргэлжилсэн ярилцлагын дараа туйлдсан шинжтэй харагдаж байлаа. Би гадаа гарч тамхилах зөвшөөрөл авав. Толгой дотор янз бүрийн асуулт эргэлдсээр. Яриаг цааш нь яаж өрнүүлэх вэ? Яаж яривал дахиад л дуугаа хураах юм уу, гайтай “нууц” гэсэн үгтэй тулгарахгүй байх вэ? Бодисын солилцоогоо тэгтэй тэнцүүлдэг тэр төлөв байдал хичнээн ач холбогдолтой болохыг би тэр үед мэдээгүй байсан гэдгийг л урьдчилаад хэлчихье.

Венер Гафаров мастерт ховсдуулж байх үеийн мэдрэмжээсээ хуваалцав.

- Миний тархи буцалчих юм шиг л санагдаж байсан,- гэж тэр яриад,- эхлээд би унтмаар санагдаж арай гэж өөрийгөө хүчлэн барьж байсан. Бүр өөрийгөө сэрүүн байлгахийн тулд чимхэж байсан гээд бод доо. Дараа нь миний нүүр хөөж памбайгаад, нүд хавдаж, дагзны хэсэгт хэн нэгэн тархийг минь шахан гаргах гээд байгаа юм шиг, тархи маань удахгүй зад тавин цацагдах гэж байгаа юм шиг хүчтэй өвдөж эхлэсэн.

- Тэсээд гарсан Венер минь чи ёстой мундаг!

- Тэрэнд тэгэх ямар хэрэг байсан юм бол? Шалгаж байгаа юм байх даа?



*Кришнага дагалдагсдын зураг*

- Ингэхэд, сургаалийнхаа үеэр тэр байнга атлантын зураг руу харж байсныг та нар анзаарсан уу? - гэж Сергей хэлээд,- Зураг түүнд маш хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. Тэр атланчуудын талаар бүгдийг мэддэг байх ёстой.

Хэлэлцээрийн ширээндээ эргэн ирэв. Тэгтэл би “Шинжлэх ухаанд бид мэдрэмжид үндэслэсэн хийсвэрлэн сэтгэх (логик) аргыг өргөн хэрэглэдэг ба дараа нь гаргаж авсан бодлын хэлхээгээ өөр өөр аргаар батлахыг хичээдэг (компьютерийн дүн шинжилгээ г.м.)” гэж өөрийн мэдэлгүй хэлчихэв.

- Учир нь шинжлэх ухаан хийсвэрлэн сэтгэх аргад тэглээ итгэдэггүй, -хэмээн би үргэлжлүүлээд,- харин математик тооцоо, компьютерийн дүн шинжилгээ гэх мэт баримтанд тулгуурладаг.

- Сэтгэл санаа оюун ухааныг авч үздэггүйгээрээ математик нь маш сул шинжлэх ухаан юм,- гэж мастер эрсхэн хэлээд, -Хийсвэр сэтгэлгээ бол мэдрэмжид тулгуурладаг. Харин мэдрэмж гэдэг чинь “билгийн нүд”-ний үйл ажиллагааны илрэл юм. Орчин үеийн шинжлэх ухааны түвшинд батлашгүй зүйлийг хийсвэр сэтгэлгээний аргаар мэдэж авч болно. Жишээ нь электронийг барьж үзэж болохгүй ч түүний байдгийг тогтоож болно. Шашин нь хийсвэр сэтгэхүйг дэмждэг. Та үүнийг олж авахын тулд үнэхээр хийсвэр сэтгэлгээг хэрэглэсэн гэж үү? – гээд мастер нүдээрээ атлантын зурагны зүг дохив.

- Тиймээ, компьютерийн шинжилгээ зөвхөн баталж өгсөн.

- Сонин л юм...

Мастерын харц зөөлрөн, бидэнд илүү дотно хандлагатай болохыг бид мэдэрлээ. Сонин л юм, хийсвэр сэтгэлгээнд итгэдэг хирнээ компьютерт итгэдэггүй байна шүү гэж бодогдож байлаа.

- Энэтхэг эмэгтэйчүүдийн гоёлын толбо нь өмнөх иргэншлийн хүмүүст байсан “билгийн нүд”-ний дурсгал мөн үү гэж шууд асуулт тавихуйц зоригжсон би асуув.

- Тэд маш өндөр хөгжилтэй “билгийн нүд”-тэй байсан бөгөөд амьдралын үйл ажиллагаанд нь маш их үүрэг гүйцэтгэдэг байсан. Хөгжлөөр дутмаг боловч өнөөгийн хүнд ч бас бий. Та нар тэр зурагнуудыг хар даа гээд мастер Кришнагийн дагалдагсдын хөргийг заагаад,- Тэгээд нэвт харж, “билгийн нүд”-ийг нь олж харахыг оролдоорой гэв.

Бид гэрэл зурагнуудад ойртон очиж анхааралтай ажихад “билгийн нүд”-ийг хамгийн түрүүнд Сергей олж харан, дараа нь Венер бид хоёр ч олж үзэв. Духан дээр нь цохны хэсэгт хоёр зураастай дундаа цэгтэй өндгөн хэлбэртэй дүрс тодорч эхлэсэн юм. Бидэнд бүгдэд нь нэгэн адил зүйл харагдсан байлаа.

Харсан зүйлээ цаасан дээр буулгаад мастерт үзүүлж зөв харсан эсэхээ асуухад, “Зөв харжээ.” гэж тэр хариулав. Тэгээд тэр “билгийн нүд”-ийг нүд гэж бүү ойлго, энэ бол анатомийн ухагдахуун биш. Өмнөх иргэншлийн хүмүүст энэ нь тодорхой бүтцийн шинж чанартай байсан ч нүд шиг харагдаж байгаагүй гэдгийг хэлэв. “Билгийн нүд”-ний үүрэг нь боргоцой хэлбэрийн булчирхайтай хамаатай.

- Францын алдарт үзмэрч Нострадамус өмнөх иргэншлийн хүмүүс “билгийн нүд”-нийхээ тусламжтайгаар таталцлын хүчинд биоэнергээр үйлчлэн, асар том чулуун гулдмай зэргийг орон зайд шилжүүлж, түүгээрээ пирамид болон бусад чулуун байгууламж хийдэг байсан гэж бичсэн байдаг. Та үүний талаар юу гэж бодож байна?

- Би үүнтэй санал нэг байна. Бидэнд ч бас ийм мэдээлэл байдаг, - гэж мастер хариулаад,- Үүнээс гадна уг хүч нь хүн төрөлхтний хөгжилтэй зэрэг өсөх болно. Оюун санааны энерги гэдэг бол мөн хүний биеийн энерги юм. Пирамидыг барьсан тэр хүч бол чиглэсэн хүч бөгөөд чиглүүлээгүй хүч нь сүйтгэгч хүч болж хувирдаг.

- Тэгэхээр атлантчуудын соёл иргэншил нь уг оюун санааны энергээ эерэг тал руу чиглүүлж чадахгүй байсаар мөхсөн юм болов уу? – гэж намайг асуухад,

- Оюун санааны энерги нь төвд чиглэсэн хэлбэрээс төвөөс зугтаасан хэлбэрт шилжсэний улмаас тэд сөнөсөн.

- Юу гэсэн үг вэ?

- Та нарын судалдаг анагаах ухаанд “регенераци”, “дегенераци”, гэсэн ухагдахуунууд байдаг. Регенераци гэдэг нь бодисын солилцооны чиглэсэн энерги бөгөөд энэ нь хүний биеийг өсөлтөнд хүргэдэг бөгөөд биеийн амьдралын үндэс нь болдог, харин дегенераци гэдэг нь бодисын солилцооны чиглээгүй энерги бөгөөд эд эсийг мөхөлд, биеийг үхэлд хүргэдэг. Физикт чиглэсэн энерги нь онгоц, галт тэргийг хөдөлгөж, чиглээгүй нь дэлбэлдэг. Үүнтэй нэгэн адил оюуны энерги нь мөн төвөөс зугтаасан төдийгүй төвд тэмүүлсэн байж болно. Оюуны энерги нь



*Мастертай цуг*

бодисын солилцооны болон физик, энергийн хуулиудад мөн адил захирагддаг. Оюуны энерги нь физик болон бодисын солилцооны энергиэс хүчтэй бөгөөд хүн төрөлхтөнд маш том нөлөө үзүүлж чаддаг. Гэвч оюуны энергийн нэгэн хууль бий. Энэ нь уг энерги төврүү чиглэсэн, дотогшоо чиглэлтэй байх ёстой гэсэн хууль. Будда ч бай, Мухаммед ч бай, Исүс ч бай, бүх гэгээнтэн оюуны энерги дотогшоо чиглэсэн байх ёстой гэсэн нэгэн зүйлийг номлодог байсан. Энэ нь тэдний сургаалийн гол мөн чанар.

- Тодруулж өгөхгүй юу?

- Сталин юм уу, Гитлерийг аваад үз л дээ. ЗСБХНУ-д Сталин бурхан шиг байсан (нэг хүнийг тахин шүтэх үзэл). Гитлер Германд бурханыг орлосон. Сталин ч тэр, Гитлер ч тэр шашны мэдлэггүйн улмаас ард түмнийхээ оюуны энергийг дотогш буюу хүн болгон сэтгэл рүүгээ өнгийн харж, өөрийгөө таних тал руу нь чиглүүлж чадаагүй. Харин ч дэлхийг ноёрхох хүсэлдээ автан, ард түмнийхээ оюуны энергийг төвөөс зугтах буюу дайн дажин, сүйтгэх чиглэлд хандуулж байсан. Хүн өсэтгэл санаандаа өдөр тутам шинжилгээ дүгнэлт хийж, өөртөө гүн гүнзгий орох тусмаа улам бүр хэмжээлшгүй хүч чадалыг бий болгодог. Тэгээд хүний дотроос задран гарч төвөөс зугтах чиглэлтэй болсон энэ хүч бүр дэлхийг бүхэлд нь гамшигт хүртэл хүргэж болдог. Өнөөгийн энэ түвшинд би америкчуудаас л их болгоомжилж байна. Тэд ногоон доллараас өөр бурхангүй улс. Хэрвээ тэд ядуурч эхэлбэл хүмүүсийнх нь оюуны энерги төвөөс зугтаах шинж чанартай болно.

- Татах хүчинд ч нөлөөлж чаддаг атлантчуудын оюун санааны энерги сэтгэлээс нь гаран төвөөс зугтах шинжтэй болоход юу болсныг төсөөлөхөд ч бэрх байна, - гэж Сергей үг нэмэв.

- Оюун санааны энерги бол сансрын биетэд ч нөлөөлөх хүчтэй гэж мастерийг хэлэхэд

- Бурхан тусалж чадахгүй юм гэж үү гэсэн асуулт би тавив.

- Бурхан бол хүчинд хамаагүй. Тэр хүчийг яаж ч чадахгүй хэмээн мастер хариу өчив.

- Тэгээд Бурхан зөвхөн гэгээнтэнүүдээр дамжуулан үйлчилдэг юм уу?

- Гэгээнтэнүүдээр болон шашнаар. Гол нь хүний оюун санааны энергийг дотогш нь сэтгэл рүү нь хандуулах явдал. Тэгээд ч сүүлчийн илгээлт болох "SoHm"-ийн утгын нэг хэсэг нь ийм юм.

- Та тэр сүүлчийн илгээлтийн тухай тодорхой ярьж өгөөч?

- "SoHm" гэдэг бол аугаа утга санааг илэрхийлсэн үгс юм, - гэж мастер эхлээд, - зөвөөр бол So (соу) биш Sa(са), Hm(хм) биш OuHm(ыхм) гэж уншдаг. So гэдэг нь "Би өөрөө", Hm гэдэг нь "Би мөн" гэсэн утгатай бөгөөд нийлээд "SoHm" гэдэг нь, - гээд мастер хуруугаа гозойлгон, - "ӨӨРСДӨӨ БОЛОВСОР!" гэсэн утгатай.

- Өөрсдөө боловсор? Хэн?

- Хүмүүс. Тэгээд бүр хүн бүхэн бие даан боловсрох ёстой. "SoHm" гэсэн сүүлчийн илгээлт нэгэн зэрэг бүх Гэгээнтнээр дамжин хүн төрөлхтөнд тархсан. Сүүлчийн илгээлт нь хүн болгоны сэтгэлд шингэх ёстой. "SoHm"-ын зарчмыг бодит болгон биелүүлж чадсан хүн л аз жаргалтай амьдрах болно. Хүн төрөлхтөн "SoHm"-ын зарчмыг биелүүлж чадвал мөхлөөс аврагдах болно. Би бүх насаараа "SoHm"-ын зарчмыг биелүүлж явна.

- Яагаад энэ илгээлт сүүлийнх гэж?

- Эцсийн гэж хэлвэл арай зөв байх.

- Яагаад эцсийнх гэж би асуув.

- Яагаад гэвэл Дээд Оюун Ухаан дэлхий дээрх хүмүүст их тусалдаг байсан ч соёл иргэншлүүд устсаар байсан. Гэгээнтнүүд ч мөн адил бидний соёл иргэншлийн оюун санааны энергийг төвөөс зугтаах биш төв рүү тэмүүлэх шинж чанартай байлгахгаар амьдрахыг номлодог. Дээд Оюун Ухаанаас манай иргэншилд өгч буй энэ тусламж нь хүрэлцээтэй байж чадах болов уу? Хэрвээ энэ тусламж ч багадвал... Бурхан ч туслахгүй. Гүйцээ! Манай соёл иргэншил өөрөө бие даан боловсрох ёстой. Зөвхөн бие дааж л боловсрох ёстой гэж мастер хариулав.

- Манай соёл иргэншил, жишээ нь: дэлхийн гуравдугаар дайнаас болоод ч юм уу сөнөх юм бол энэ нь дэлхий дээрх сүүлийн соёл иргэншил болно гэсэн үг үү?

- Магадгүй. Тийм ч учраас бид зөвхөн өөрсдөө л боловсрох ёстой.

Нам гүм болов. Хүн болгон дор бүрнээ саяны яриаг тунгаан бодож байлаа. Хар дарсан зүүд шиг сэтгэл нэг л түгшүүртэй.

- Баруун нүд улцгар байх нь биеийн байдлыг тодорхойлогч болдог гэж гэнэт мастер хэлэв.

- Юу?

- Үүнийг зөвхөн мастерууд бид л мэддэг.

- Бидний гаргаж авсан атлантын зургийг та нэг хараач, - гэж би яриагаа шилжүүлэн хэлээд,- Атлантын нүд нь яг ийм байсан уу?

- Миний мэдэж байгаагаар ийм л байсан. Тэдний нүд нь биднийхээс илүү бас том байсан ба амархан өвддөггүй байжээ.

- Тэдний хамар нь бидний дүрсэлсэнчлэн ийм байсан уу гэж би асуув.

- Тэд иймэрхүү мөртлөө маш жижигхэн хамартай, тэр нь их өвчлөмтгий байсан,- гэж мастерыг хариулахад нь би:

- “Билгийн нүд” нь ямар байсан бэ?

- Тэдний “Билгийн нүд” нь маш сайн хөгжилтэй байсан боловч духан дээр нь нүх байгаагүй.

- Та энэ бүхнийг хаанаас мэддэг юм бэ?

- Самади...

- Самади гэж юу юм бэ?

- ... - Мастер бүхий л байгаа байдлаараа яриа дуусах болсныг илтгэв.

- Уучлаарай, сүүлийн асуулт. Гэгээнтнүүд бүгд өмнөх иргэншлийн хүмүүс байсан уу?

- Бүгд бишээ. Жишээ нь Рама бол Кришнагийн жирийн эмэгтэйгээс гарсан хүүхэд. Тэгээд ч ер нь, - гэж мастер яриаг төгсгөхөд бэлдэн,- та нартай ярилцахад маш таатай байлаа. Маш олон судлаачид Шамбалын орныг хайж байсан. Та нарт ч мөн адил амжилт хүсье. Хэрвээ та нар нууцыг тайлах юм бол энэ нь сайн гарт очих естой шүү. Шамбалын орон хамгаалагдах чадвартай. Муу санаатай хүмүүсийг онцгой хүчний тусламжтайгаар устгах болно.

Мастер бидний зургийг гартаа аван атлантыг дахин нэг харснаа холдон одлоо.

## 5-р хэсэг

# Онъсогот самади

Энэтхэгийн дараагийн хот болох Амритсард бид хамба Дарам Радже Бхарти мастертай уулзах тодорхой зорилготой ирсэн юм.

Бид Делийн их сургуульд байхдаа олон түүхч эрдэмтэн, шашны зүтгэлтний ярианаас түүний тухай мэдэж авсан. Учир нь энэ хүн шашны өндөр цол хэргэмтэй ч аль нэг сүм хийдийн хамба лам биш. Харин амьдралаа Дорнын шашин судлалын шинжлэх ухаанд зориулсан хүн юм. Эрдэмтэн хүн шашны ийм өндөр цол хэргэм хүртэнэ гэдэг нь маш ховор явдал. Дарам хамба мастер нь хэд хэдэн хэлийг, тэр дундаа санскрит хэлийг эзэмшсэн бөгөөд 700-аад эртний ном судар уншиж судалсан. Өөрөө ч маш олон ном бичсэн, шашны болон эрдэмтэдийн хүрээнд маш их нэр төртэй, хотынхоо хүндэт иргэн хүн байлаа.



*Свами Дарам*

Хамбатан Дарам мастертай уулзах уулзалтыг Энэтхэгийн ерөнхий нүдний эмч зохион байгуулж өгсөн юм. Уулзалт сүмд биш харин эмнэлэгт, эмнэлгийн өрөөнүүдийн нэгэнд болж өнгөрсөн.

Свами Дарам мастер намхан нуруутай, унжсан зовхин доороос том хөнхөр нүд биднийг ширтсэн бүр яагаад ч сайхан гэж хэлэхээргүй нэг л





сонин дүр төрхтэй хүн байв. Хүн болгоны магтаж шагшаад байсан сэтгэлийн их хүч энэ сүргүй хүний хаана нь багтсан юм бол гэхээс авцалдаж өгөхгүй гайхаш төрүүлнэ.

Гэхдээ шашны шинжлэх ухааны тухай ярьж эхэлмэгц түүний нүд нь дулаан сайхан туяа цацруулан гэрэлтэж, нүүрний хувирлаараа товчхон яриагаа тодотгон амь оруулж, илэн далангүй инээмсэглэл нүүрэнд нь тодров. Бидний өмнө атаархамгүй дүр төрхийг нь үл

анзаарвал “Юндэн Гөөгөө” шиг эрчүүдээ хаян хүүхнүүд татагддаг ийм нэг эр сууж байв. Урьд өмнөх уулзалтуудыг бодвол энэ уулзалт дэлгэрэнгүй сонирхолтой болно гэдгийг шууд мэдэрсгээв.

- Дэлхий дахин шашны шинжлэх ухааны үүргийг дутуу үнэлж байна,- гэж Дарам хамба яриад,- Шашин гэдэг бол хөгжлөөрөө илүү өмнөх соёл иргэншлүүдийн тухай мэдлэг юм. Манай иргэншлийн хөгжингүй бус байдал нь шашны мэдлэг ёсыг бүрэн утгаар нь ойлгоход садаа болж шашныг нийт нийгмийн эерэг хөгжлийн тусын тулд бүх номлолоо үг бүрчлэн цээжлүүлэхэд хүргэж байна. Орчин үеийн шинжлэх ухааны хөгжлийн түвшинд хүний биеийг хангалттай нарийн судлах боломж байгаа бол сэтгэлийг тэгж нарийн судлах арга алга. Агуу сүртэй оюун санааны энергийг хэмждэг арга одоохондоо алга байна. Би бүтээлдээ орчин үеийн болон шашны мэдлэгийг нэгтгэхийг оролддог. Шашин нь мухар сүсэг бус харин судлагдахуун байгаасай гэж хичээж явна. Хичнээн олон сэтгэл догдлуулсан нууц байдаг гэж санана....

Оршил яриагаа дуусгаад Дарам хамба сонсоход бэлтгэв. Би мэдрэмжид тулгуурласан хийсвэр сэтгэлгээгээр олж авсан таамаглалаа математик компьютерийн аргаар батласнаа онцгойлон тэмдэглээд, гаргасан таамаглалаа танилцуулав. Урд өмнө танилцуулахдаа гаргаж байсан алдаагаа анхааран нүдний компьютерийн шинжилгээнд их ач холбогдол өгч дурссангүй.

- Мэдрэмж гэдэг бол ухаанаас ургасан цэцэг. Хийсвэр сэтгэхүй гэдэг нь шинжлэх ухааны гол зам. Гэхдээ математикийг хийсвэр сэтгэхүйтэй хослуулвал маш гүн рүү, бүр сэтгэлийн гүн рүү ч харж болно гэж. свами Дарам миний үгийг таслан хэлэв.

Материалаа танилцуулж дуусаад би атлантын зургийг түүнд өгөв.

Тэр зураг руу нэг харснаа харцаа бидэн рүү хандуулан чангаар:

- "Самади!" гэв.

- Тэр чинь юу вэ?

- Та нар биеийг нь уулнаас олсон уу гэж миний хэлэхийг огт сонсоогүй мэт Дарам хамба асуув.

- Үгүй.

- Далайгаас уу?

- Үгүй.

- Тэгээд хаанаас олсон юм бэ?

- Бид ямар ч бие олоогүй. Энэ зургийг төвд сүмийн ханан дээрх нүдний дүрсэнд офтальмогеометрийн шинжилгээ хийснээр гаргаж авсан юм гэж би хариулсан юм.

- Үүнд чинь нэг л юм таарахгүй байна даа гэж свами Дарам бувтнав.

- Тэгээд самади гэдэг чинь юу гэсэн үг вэ?

- Та энэ зургаа нэг хар даа. Нүд нь хагас аниастай, үхсэн амьдын хооронд буй мэт байна. Самади гэдэг нь миний бие чулуу мэт хөдөлгөөнгүй ч амьд байдаг төлөв байдлыг хэлдэг. Чулуу мэт хөшүүн боловч амьд бие...

- Тэгэхээр төвд лам нар самадид буй түрүүчийн соёл иргэншлийн хүнийг зурдаг хэрэг үү гэж асуув.

- Тийм.

- Төвд лам нарт түрүүчийн соёл иргэншлийн хүний нүдний тухай мэдээлэл хаанаас бий болсон юм бол?

- Тэд түүнийг харсан.

- Хаана?


- Ууланд.

- Хэзээ?

- Саяхан шахуу!

- Самадийн талаар дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу гэж бүр гайхаж хоцорсон намайг гуйвал,

- Нэгэн түүхийн баримтаас иш татья. Рама Кришна мастер 1893 онд Бенгальд самадид орохыг зааж сургадаг ёгын сургууль байгуулсан юм. Нэгэн удаа Рама Кришна эмчийн дэргэд самадид орох болжээ. Эмч түүний биеийг үзээд үхсэн гэсэн дүгнэлтэнд хүрсний дараа тэрээр эргэн амьдарсан байна. Түүнээс хойш нэг биш удаа эмч нар самадид байгаа хүнийг үзэхэд судасны лугшилт, зүрхний болон тархины цахилгаан бичлэг бүгд бичигдэхгүй, бие хөрсөн байдаг байж. Хүмүүс самадид ороод хэдэн жилийн дараа эргэн ирж байсан маш олон тохиолдол бий. Тэд эргэж



ирсэнээрээ хүмүүсийн айдас гайхал хоёрыг нэгэн зэрэг төрүүлдэг.

- Самади гэдэг чинь ичээнд унтаж (летаргический сон) байгаатай адил байдал уу?

- Биш ээ. Ичсэн амьтадын зүрх, тархи ажиллаж, бодисын солилцоо хадгалагддаг. Харин самадийн үед бие чулуужин хөдөлгөөнгүй байдалд ордог.

- Чулуун-хөшингө байдал гэдгийг юу гэж ойлгох вэ гэж намайг асуувал,

- Бие нь ер бусын хатуу хүйтэн болдог. Үхсэн хүний бие ч мөн адил амьд хүнийхээс хатуу байдаг боловч самадийн үед хүний бие үхсэн хүнийхээс ч илүү олон дахин хатуурдаг. Жишээлж хэлбэл бие яг л чулуу шиг болдог.

- Тайлбарлаад өгөөч!

- Чулуун-хөшингө байдал (stone-still stale) гэдэг бол самадийг судалдаг шашны эрдэмтдийн нийтээр хэрэглэдэг үг хэллэг. Энэ нь хүний махбодь жинхэнэ чулуу болж хувирна гэсэн үг биш нь мэдээж. Зүгээр л хүний бие маш хатуу болохыг хэлж байгаа юм гэж свами Дарам хариулав.

- Самадийн үед хүний бие яагаад хатуурдаг юм бэ?

- Хүн бодисын солилцоогоо тэг хүртэл бууруулж энэ байдалд хүрдэг.

- Үхлийн дараа тодорхой хугацаанд хүний биеийн бодисын солилцоо үргэлжлэн явагддаг бөгөөд эд эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар үүн дээр тулгуурладаг. Энэ нь миний хувьд маш энгийн ойлгомжтой зүйл. Үхлийн дараа мөн задлагч ферментүүд идэвхжиж эд эсийг задалдаг. Ямар замаар бодисын солилцоо тэгтэй тэнцэж хүн нэг ёсны хадгалалтанд ордог юм бэ гэж би асуув.

- Энэ бол биеийн шингэний тусламжтайгаар явагддаг онцгой үйл ажиллагаа юм гэж Дарам хамба хэлэв.

- Самадид буй хүний бие бичил биетний нөлөөнд автдаг уу?

- Бараг үгүй. Гэхдээ л цэвэр орчин сонгосон нь дээр.

- Дулааны нөлөө ямар байдаг вэ?

- Сэрүүн орчинд илүү сайн байдаг.

- Биеийнхээ шингэнд яаж нөлөөлөхөөр бодисын солилцоо тэгтэй тэнцэх вэ?

- Амин орноор дамжуулж бясалгалын тусламжтайгаар, - гэж Дарам хамба хариулаад,- Биеийн амин орон, биеийн шингэн хоёр хоорондоо холбоотой. Гэвч хүн үр дүнтэйгээр бясалгаж, амин орон биеийн шингэнд нөлөөлж, цаашид бодисын солилцоонд нөлөөлдөг болгож сурах хэрэгтэй. Самади бол бясалгалын дээд хэлбэр юм. Хүн болгон бясалгалын замаар самадид орж чадахгүй, самадид орсон хүн болгон олон жилээр үргэлжилдэг гүн самадид орж чадахгүй.

- Самадид орсон үед сүнс хаачих вэ?

- Самадийн сургаалд ОВЕ (out of body experience) гэдэг ойлголт байдаг ба энэ нь "биеэс гарах туршлага" гэсэн утгатай үг буюу чи биеэ хажуунаас нь ажиглаж болох байдал юм. Самадийн үед сэтгэл сүнс нь биеийн гадна байдаг. Хүн биеэ



*Самади*

хадгалж үлдээгээд, амьдралаа үргэлжлүүлж байгаад, эргэн биедээ орох боломжтой. Самадийн тусламжтайгаар сүнсний амьдралыг ойлгож болно. Хүн үхсэн мэт хөдөлгөөнгүй буй биеэ харж нэгэн зэрэг амьд буйгаа мэдрэх явдал юм. Самадийн үед хүн биегүй амьдарч болдгийг ойлгодог.

- Тэгэхээр нэг талаас хүн биегүй амьдарч болдгийг үзүүлэх, нөгөө талаас биеэ хэдэн жилээр хадгалах боломжтой болгоход самадийн үүрэг оршдог гэж хэлж болох уу? Биеэ дараа хэрэг болно гээд орхих... гэж хэлэхэд,

- Бие нь хэдэн зуу, хэдэн мянга, бүүр хэдэн сая жилээр хадгалагдаж болно гэж Дарам хамба хариулав.

- Сонин юмаа,- гэж би уулга алдан,- Тэгвэл самади гай гамшиг, бүр дэлхийг бүхэлд нь хамарсан гай гамшигийн үед хүний авралын зам болж болох юм байна шүү дээ. Хүний биеийг самадийн байдалд хадгалж болох нь *Хүний генийн санг* байгуулах үндэс байж болох юм. Тийм үү?

- ...

- Бүх дэлхийн гамшиг болоход зориулж хүний биеийг хадгалах шаардлага бий юу?

- Зарим нэгэн шашны адилаар хүний бие махбодийг тоохгүй байж болохгүй. Хүний бие нь маш урт удаан хугацааны түүхэн хөгжлийн (эволюцийн) үр дүнд бий болсон гэж свами Дарам хэлэв.

- Миний бодлоор байгаль дээр ч самадийн сонгодог жишээнүүд бий. Жишээ нь амьтдын өвлийн ичээ. Хойд нутгуудад хүрэн баавгай жилийн 7-8 сард нь ичээнд байдаг ба үүр нь тийм ч дулаан биш. Магадгүй, баавгай самадийн адилаар өөрийн бодисын солилцоогоо удаашруулдаг. Самадид орж чадахгүй байгааг нь гань баавгай гэдэг. Үүнээс гадна тарвага, зурам, могой, мэлхий, шавьж гээд маш олон амьтад ичдэг. Самади маягийн ийм байдал нь хойд нутгийн нөхцөл байдалд дасан зохицох нэг арга зам байж болох юм.

- Би өөрөө дулаан орны хүн болохоор таны ярьж буй зүйл зүй тогтолтой эсэхийг баталж чадахгүй ч таны зөв байж магадгүй гэж Дарам хамба хариулав.

- "Ер нь сүнс хаана байдаг юм бэ?" гэж би шалгаасаар байлаа.

- Сүнсийг ард түмэн зүрх гэж ярьдаг. Харин зүрх гэдэг бол ердөө л шахуурга. Харин "сүнс-зүрх" гэдэг бол хүйсний хавьд байдаг.

- Анагаах ухаанд "амьд хүүр" гэсэн ойлголт байдаг. Энэ нь зүрх ажиллаж, бодисын солилцоо явагдаж, харин хүн өөрөө ухаангүй байдаг байдал юм. Энэ нь сүнсэнд бие нь таалагдахгүй



байгаагаас ч юм уу эсвэл бие нь хэтэрхий гэмтсэн ч юм уу, уг биедээ эргэж орохийг хүсэхгүй байна гэсэн үг мөн үү? гэж би асуув.

- Тийм ээ. Бие сүнсгүй амьдрах боломжтой боловч тэр угтаа амьд хүүр мөн. Хэрвээ сүнс эргээд биедээ ирэх юм бол буцаад хүн болно.

- Самадийн үед хүний бие болон сүнсний харьцаа ямар байдаг вэ?

- Хэрвээ самадийн үед сүнс нь биеийн гадна байвал бие нь хадгалагдсан хэлбэртээ л байх болно. Сүнс нь биедээ эргэж ирвэл самадийн байдлаас гаран тав, арав, зуу, мянга, олон мянга, хэдэн сая жилийн дараа эргэн амьдарна гэж Дарам хамба хариулав.

- Сүнсийг хэн бие рүү нь илгээдэг юм бэ?

- Дээд Оюун Ухаан. Самадийн үед хүн сүнсний явдлыг мэдэрч, Дээд Оюун Ухааны үүргийг ойлгон, дахин амилахдаа зандалч бус харин илүү сүжигтэй номын болдог учир самадид байх нь маш ашигтай. Хүмүүс самадид байнга ордог байсансан бол дэлхий дээр үргэлж энх тайван орших байсан.

- Сүнс гэж юу вэ?

- Сүнс гэдэг бол ертөнцийн энергийн нэгэн хэсэг ба тусгайлан зурагдсан орон зайд байрладаг. Сүнсний энерги гэдэг нь электрон, протоноос гадуурх энерги боловч энэ нь таталцалын хүчинд нөлөөлөх чадвартай, маш хүчтэй. Олон сүнсний энерги нийлвэл туйлын аугаа хүчин чадлыг үүсгэнэ. Сүнсний эерэг болон сөрөг энерги гэж байдаг ба эдгээр нь зэрэгцэн оршино. Сүнсний энерги нь бүтээх ч, сөнөөх ч чадвартай. Ленин, Сталин, Гитлер нар сүнсний сөрөг энергийг ихээр хуримтлуулсан нь хүмүүсийг хөнөөх дайн болон урссан. Сайн муу хоёр үргэлж зэрэгцэн оршдог. Сүнсний сөрөг энерги нь сансрын хөнөөгч биетүүдийг татах, байгальд нөлөөлөх чадвартай бөгөөд тийм ч учраас дайн мөргөлдөөнийг солир унах, газар хөдлөлт зэрэг гамшигт үзэгдлүүд дагалддаг.

- Сүнсний сөрөг энерги сансрын биетүүдийг татдаг нь тэнгэр дуугарч, цахилгаан цахих нь гүйдэлд татагддагийн адил хэрэг үү гэж Венер Гафаров асуув.

- Барагцаалвал тийм. Гэхдээ энд физикийн өөр хуулиуд үйлчилдэг гэж Дарам хамба хариулав.

- Сонирхолтой л юм...

- Та нар судалгаагаа нүднээс эхэлсэн болохоор, - гээд хамба үргэлжлүүлэн, - нүд бол сэтгэлийн толь гэдгийг мэднэ биз дээ. Бид өөр хоорондоо зөвхөн хэлээрээ бус бас нүдээрээ ярилцдаг. Учир нь нүд бол сэтгэлийн цонх. Хараа нь шууд сэтгэлд тусдаг. Учир нь харахуй бол бидний хамгийн гол мэдрэхүй юм. Та нар харьцуул даа. Бид хэдэн километрийн цаадахыг харж, хэдэн метрийн цаадахыг сонсдог мөртлөө хэл, хуруугаараа зөвхөн хүрч мэдэрдэг. Сохор хүмүүс амьдралдаа дан ганц биеийн төдийгүй сэтгэлийн хувьд маш их зүйлийг алддаг.

- Энэ нь сүнсний энерги нүдээр дамжин үйлчилдэг гэсэн үг мөн үү?

- Тиймээ, мөн та нарын судалгаанд би эвэрлэгийн хэмжээ нь хүн болгоны хувьд тогтмол гэдэг маш чухал зүйлийг анзаарсан. Энэ нь шашны үзэлтэй таарч

байгаа бөгөөд бурхан бүгдэд нь өөрийгөө боловсруулах тэнцүүхэн боломж олгоснийг гэрчилж байна.


- Сонирхолтой л санаа байна...

- Чухамхүү нүдний эвэрлэг л сүнсний өөрийгөө боловсруулах цонх болдог. Би та нарт сэтгэлийн энергийг илүү судал гэж зөвлөмөөр байна. Жишээ нь физикийн сүүлчийн ололт амжилтуудыг ашиглан энэ энергийг нүднээс гарах үед нь хэмжиж болно гэж хамба хэлэв.

Энд сэдвээсээ жаахан хазайж, сүнс болон оюун санааны энергийн талаарх орчин үеийн физикийн үзэл бодлоос манай шинжилгээний ангийн гишүүн орон зайн физикийн мэргэжилтэн, оросын томоохон физикчдийн нэг Валерий Лобанковын бэлтгэсэн материалыг танилцуулахыг зөвшөөрнө үү.


*Бодит болон нарийн гэсэн хоёр ертөнц байдаг. Бодит ертөнцөд матери (од, гариг г.м.), цахилгаан соронзон орон зай болон таталцлын орон зай багтдаг. Нарийн ертөнц нь психофизикийн үзэгдлүүдийг (сэтгэлийн энерги, биоэнерги г.м.) багтаадаг. Нарийн ертөнц нь хэт өндөр давтамжид тулгуурладаг.*

Үүнээс гадна бас торсийн орон зай буюу эргэн (мушгиа) орон зай гэж байдаг ба бодит ертөнцөд үүний илрэл нь инерци байхад нарийн ертөнц дахь илрэл нь сэтгэл санаа юм. Сэтгэл санаа гэдэг нь эргэлдсэн орон зай хэлбэрийн энергийн бөөгнөрлүүд юм. Энэ мушгиа орон зайн дотор хүний биеийн үйл ажиллагааны (астрал бие) талаар болон сэтгэн бодох чадварын (ментал бие) талаар мэдээлэл



оршдог. Сэтгэн бодох үйл явц нь уг орон зайг эргүүлдэг бөгөөд сайн бодол санаа нэг тийшээ эргүүлдэг байхад сөрөг муу бодол нөгөө тийшээ эргүүлдэг.

*Бүх сүнс оюун нь бидний Дээд Оюун Ухаан гэж нэрлэдэг Ерөнхий Мэдээллийн Орны нэгэн хэсэг болдог. Е.Блаватская болон Рерих г.м. хэдхэн хүн Ерөнхий Мэдээллийн Оронд холбогдож бидэнд хачирхалтай санагддаг мэдлэгийг олж авах чадвартай байдаг. Уг мэдээллийн орон зайд зөвхөн биднийхээр зогсохгүй өмнөх соёл иргэншлүүдийн мэдлэг хуримтлагдсан. Манай Ертөнцийн орон зай нь битүү учир Ерөнхий мэдээллийн орон зайд холбогдсоноор өнгөрсөн болон ирээдүйг харах чадвартай болдог.*



Хамгийн анх ганцхан орон зай - Абсолют (Абсолют хоосон) буюу ирээдүйн зүйлсийн эх төлөвлөгөө л оршдог байсан. Орон зай гэдэг нь саармагжсан матери болон антиматери (эсрэг матери) бөгөөд тэнд матери, антиматери байнга үүсэж нэгнийгээ дарангуйлан саармагжиж байдаг. Абсолют нь саармагжих үйл явцыг зогсоодог учир матери ба антиматери үүссэн ч нэгнийгээ саармагжуулахгүй болсон байна.

Эхлээд нарийн ертөнц үүсч, дараа нь бодит ертөнц үүссэн. Бодит ертөнцөд материйн нягтаршил болж од

гаригс үүссэн. Нарийн ертөнцийн нягтаршил нь сүнсийг бий болгосон.

Дэлхий дээр сүнснүүд нягтаршин аажимдаа бодит биет болж байлаа. Эхэндээ биет нь нягт биш байсан бөгөөд юмыг нэвт гардаг чадвартай байжээ. Дараа нь нягтаршин өнөөгийн шинж чанартай болсон байна. Ингэж хүн, амьтан, ургамал үүссэн. Эхэндээ хүний оюун ухаан үргэлж Ерөнхий мэдээллийн орон зайд холбогдож чаддаг байсан ба өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчууд сэтгэл оюуны сөрөг энерги буюу сөрөг чиглэл рүү эргэсэн торсийн орон зайг их хуримтлуулсны улмаас энэ чадвар нь одоо алдагдсан байна.

Сүнс янз бүрийн бодит биед ээлжлэн орж амьдран, сэтгэлийн сөрөг эерэг энергийг хуримтлуулдаг гэсэн кармын хууль байдаг. Муу карматай хүн сайн үйлийн хүчээр, сөрөг эргэсэн орон зайнаас ангижран илүү аз жаргалтай болохын тулд сөрөг торсийн орон зайгаа эерэг болгон задлах хэрэгтэй. Сүнс болгонд өөрийгөө боловсруулах боломж ижил хэмжээнд өгөгдсөн байдаг.

Дараа нь Дарам свамитай өмнөх иргэншлүүдийн талаар ярилцав.


- Газар дэлхий дээр 22 соёл иргэншил байсан,- гэж Дарам свами шууд хэлээд,- Тэд үнэхээр техникийн асар өндөр түвшинд хүрээд мөхдөг байжээ. Мөхөл нь дэлхийг хамарсан гамшгийн эсвэл сэтгэлийн сөрөг энергийн нөлөөгөөр сансрын биетэд үйлчилсний улмаас үүссэн сансрын мөргөлдөөний хэлбэрээр явагддаг байжээ. Эдгээр гамшгаас болоод дэлхий дээр уур амьсгал өөрчлөгддөг байжээ. Дэлхийн уур амьсгал амьдрахад таатай болмогц дараагийн соёл иргэншил болох хүмүүс үүсч, хөгжин, техникийн өндөр түвшинд хүрээд мөхдөг байсан.

- Өмнөх соёл иргэншлүүдийн хуримтлуулсан мэдлэг тэдэнтэй цуг устсан нь харамсалтай гэж би үнэн голоосоо харамсан өгүүлэв.



- Үгүй, тэдний мэдлэг устаагүй. Тэдгээр мэдээллийн эерэг (эерэг чиглэлд эргүүлсэн торсийн орон зай) нь Дээд Оюун Ухаанд (Ерөнхий мэдээллийн орон зайд,- Э.М.) орсон. Мастер эсвэл Блаватская г.м. Дээд Оюун Ухаанд нэвтэрч чаддаг хүмүүс эдгээр мэдээллийг авах боломжтой. Орчин үеийн бидний мэдээлэл өмнөх иргэншлүүдийнхээс маш их ялгаатай. Бидний мэдлэг тартагтаа тултал материалжсан.

- Та Дээд Оюун Ухаанд орж чадах уу?



- Чадна гэж свами Дарам тодхон хариулав.
- Атлантчуудын соёл иргэншлийн талаар ярьж өгөөч гэж намайг гуйхад,
- Энэ соёл иргэншил бол маш хөгжингүй байсан бөгөөд далайд живж мөхсөн.

Тэр үед уур амьсгал маш дулаан чийглэг байсан. Дэлхий тэр аяараа арлын шинжтэй байсан. Усан доор маш олон ургамал ургадаг. Атлантчууд усан доор тариалангийн талбайтай, усанд их сэлдэг байжээ. Тэнгэр улаан өнгөтэй байсан. Тэд таталцлын хүчинд нөлөөлж чаддаг гайхамшигтай нисдэг төхөөрөмжүүдтэй байснаас гадна сэтгэлийн чиглэсэн энергитэй байсан. Харамсалтай нь энэ соёл иргэншил маш их сөрөг энерги хуримтлуулсан бөгөөд тэр нь мөргөлдөөнд хүргэжээ. Энэ соёл иргэншил дэлхий дээрх хамгийн хөгжингүй соёл иргэншлүүдийн нэг байсан. Гэсэн ч тэд сэтгэлийн сөрөг энергийн хуримтлалаас өөрсдийгөө аварч чадаагүй юм. Үр дүнд нь галав юулж, төгсгөл ирсэн хэрэг. Дэлхий тэнхлэгээ өөрчилж, хот тосгон хүн төрөлхтнийг урсган живүүлсэн далайн аварга том давалгаа дэлхийг тойрчээ.

- Бид атлантчуудаас үүссэн үү?

- Тиймээ, бид атлантчуудаас үүссэн,- гэж хамба Дарам хариулаад, -Дэлхийн хамгийн өндөр оргил болох Гималайд далайн давалгаа хүрээгүй учир атлантчууд тэндээ самадид орон өөрсдийн биеийг хадгалсан байна. Ус татарч, амьдрах нөхцөл бүрдмэгц тэд эргэн биедээ орж шинэ соёл иргэншлийн үндсийг тавьсан. Амьдрахад туйлийн бэрх, хатуу ширүүн байснаас тэдний гадаад төрх дэлхий дээрх амьдралын нөхцөлд аажмаар зохицон өөрчлөгдөж өнөөгийн хүний дүр төрхийг олжээ.

- Танд энэ бүхэн байж боломгүй мэт санагдахгүй байна уу?

- Боломжгүй зүйл гэж байдаггүй. Одон орон судлаачид саран дээр очоод сарны хөрснөөс дээж авч шинжлэхэд тэнд хадгалагдсан бичил биетнүүд байсан. Хэрвээ саран дээр тохиромжтой нөхцөл бүрдсэн бол эдгээр бичил биетэн амь орох байсан. Самадид байгаа хүн үүнтэй адил хадгалагдсан байдалд байдаг. Дорны шашны мастеруудын хувьд самади нь та нарт Ньютоны хууль ямар ойлгомжтой энгийн зүйл билээ яг тийм юм. Соёл иргэншлүүдийн мөхөх цагт самади бол цорын ганц аврагдах зам. Самадид орж хэдэн мянга, сая жилээр хадгалагдаж байгаа хүмүүс бол соёл иргэншлүүд мөхөхийн цагт хүн төрөлхтний амьд гарах боломжийг хангах хамгийн гол бөгөөд ариун үүрэгтэй хүмүүс юм.

- Самадид буй бие хаана хадгалагддаг юм бэ?

- Гурван газар хадгалагдах боломжтой,- гээд хамба Дарам үргэлжлүүлэн,- Эхнийх нь ус. Ус бол дэлхий дээр амьдрал үүсэхэд гарцаагүй шаардлагатай бодис юм. Ус гэдэг бол газар агаар хоёрын дундах төлөв байдал (нягтынхаа хувьд). Хүний биеийн 66%-ийг ус эзэлдэг. Далайн ус болон хүний биеийн усны давсны найрлага нь ижил. Тийм учраас хүний бие самадийн үед далай дотор

удаан хугацааны турш хадгалагдаж болно. Самадийн үед бодисын солилцоогоо өөрчлөх үйл явц нь биеийнхээ усны шинж чанарыг өөрчлөснөөр явагдана.

- Уучлаарай, - гэж би тэсэлгүй түүний яриаг таслан, - бид хэдэн жилийн турш хүний биеийн усыг судалж байгаа бөгөөд энэ ус нь хүний биеийн эд эсийн нөхөн төлжилтөнд маш чухал үүрэг гүйцэтгэдэг мэдээллийг тээгч болдгийг олж тогтоосон.

- Усны тээж буй тэр мэдээлэл хүний сүнстэй холбоотой гэж хамба Дарам хэлэв.

- Далайн гахай (дельфин) далайд самадигаас гарч түүхэн хувьслын явцад далайн амьдралд дасан зохицсон атлантчууд юм биш биз гэж Венер Гафаров асуугаад, - Үүний баталгаа нь далайн гахайн оюун ухааны өндөр хүчин чадал, хэт авианы үелзлэлээр харьцах чадвар (атлантчуудын нэгэн адил), амьсгалын сүвний хэлбэр болон бусад олон шинж юм.

- Мэдэхгүй юм аа. Миний бодлоор хүн далайгаас гарсан гэж Дарам хамба хариулав.

- Хүмүүс самадийн байдалд хадгалагдаж болох нөгөө хоёр газар нь юу вэ?

- Энэ бол мөсөн зорь бас агуй. Жишээ нь Гималайн ууланд мөсөн зорьноос хөлдөөд хэдэн сая жил болсон загас олдсон нь хайлмагцаа сэлээд яваад өгсөн гэсэн. Самадид байгаа хүнд ч ийм зүйл тохиолдож болно. Агуй бол самадид орсон биеийг хадгалахад таарсан тогтмол хэмтэй газар. **(103-2)**

- Цибилов бил үү, Рерих ч бил үү, Оросын нэг судлаач Төвдийн агуйгаас хүний маш том духан дээрээ нүдний ухархайтай төстэй нүхтэй гавлын яс олсон гэж би уншсан юм байна.

- “Билгийн нүд” бол нүд шиг байгаагүй. Тэр нүх чинь гэмтлийн улмаас үүссэн байж магадгүй, - гэж свами Дарам хэлээд, - Дашрамд хэлэхэд би та нарт агуйгаас самадид байгаа хүнийг хайсны хэрэггүй гэж зөвлөмөөр байна.

- Яагаад?

- Энэ нь та нарт аюултай.

- Юугаараа аюултай гэж?

- Самадид буй атлантчуудын байгаа агуйнууд хүний нүднээс далд, хүрэхэд маш хэцүү газарт байдаг. Хүмүүсийг үхүүлэхгүйн тулд хэргээр ийм газруудыг сонгодог. Учир нь тийм агуйнд хүнийг үхүүлэгч үл таних хүчнүүд байдаг. Эдгээр хүч самадид байгаа атлантын тайван байдлыг хангахад зориулагдсан, биоэнергийн шинжтэй ба атлантчуудын хүчтэй адил таталцлын хүчинд нөлөөлж чулуун байгууламжийг хөдөлгөн пирамид барих чадалтай учир манай иргэншлийн хүмүүс эдгээр хүчийг эсэргүүцэх чадваргүй. Атлантчуудын соёл иргэншил биднийхээс хамаагүй хүчирхэг байсныг мартаж болохгүй.

- Самадид буй атлантчуудын сүнстэй харьцаж болох уу?

- Болохгүй л болов уу. Атлантчуудын сүнс нь биднийхийг бодвол хамаагүй өндөр хөгжилтэй. Тэд та нарын сайн санаанд итгэхгүй л болов уу. Атлантчуудын

амгалан тайван байдлыг үймүүлэх зөвшөөрлийг хаан ч тэр, ерөнхийлөгч ч тэр, хамгийн агуу эрдэмтэн ч тэр өгч чадахгүй гэдгийг битгий мартаарай. Үүнийг самадид байгаа тэр хүмүүс л өгч чадна.

- Атлантчуудын бие мөсөн хонгилд ч байсан, далай дотор ч байсан мөн ийм зүй тогтол ажиглагдах уу?

- Тийм гэж Дарам хамба тодхон хариулав.

Чив чимээгүй боллоо. Нууцын хөшиг нээгдсэн боловч уг нууцыг бүрэн нээнэ гэдэг боломжгүй зүйл гэдгийг ойлгож байлаа.

- Гэгээнтэн гэж ямар хүмүүс байсан юм бэ?- гэж би аниргүйг эвдэн асуув.

- Гэгээнтэн гэдэг нь өмнөх соёл иргэншлүүдийн мэдлэгийг эзэмшиж, түүнийгээ хүмүүст дамжуулдаг байсан хүмүүсийг хэлдэг. Ихэнхдээ жирийн хүмүүс байсан юм... гэж хамба Дарам хариулав.

- Гадаад төрхөөрөө биднээс ялгаатай өмнөх иргэншлийн хүн Гэгээнтэн байсан байж болох уу?

- Хэрвээ орчин үеийн хүмүүс үүсэн шинэ орчин нөхцөлд дасаад өнөөгийн дүр төрхөө олчихсон хойно нь тэр самадигаас гарсан бол байж болно.

- Та ядарч байгаа гэдгийг би ойлгож л байна, - гэж би хэлээд, - Гэсэн ч “SoHm”-ын тухай яриад өгөөч.

- Танд энэ тухай урьд нь ярьж өгч байсан юм уу?

- Тиймээ, - гээд би урьд нь бидэнд ярьж өгсөн зүйлийг товчхон танилцуулахад,

- Нэмж хэлхэд, - гэж свами Дарам хэлээд, - “SoHm” гэдэг бол хамрын авиа юм. “So” гэдэг нь амьсгал авах авиа бөгөөд “Hm” гэдэг нь амьсгал гаргах авиа юм. Энэ нь өмнөх иргэншлээс үүсэлтэй. Тэд үнэхээр хамраараа ярьдаг байсан. “SoHm”-ын үүрэг маш их. “SoHm” бол хамрын авиа. Энэ бол амьдрал үхлийн авиа. Хүүхэд анх төрөхдөө “амьд хүүр”-ийн байдалтай байдаг. Анхны амьсгалаа авахад нь сүнс бие рүү нисэн ордог. Өөрөөр хэлбэл амьсгал авах (“So”) бол “амьдрал”, хүн үхэхдээ сүүлчийнхээ амьсгааг гаргах үед хүний сүнс биеээс нисэн гарч, амьсгал гаргах (“Hm”) бол “үхэл” юм. Амьсгал авах нь амьдрал, амьсгал гаргах нь үхэл. “SoHm”-ын зарчим амьдрал үхлийн мөн чанарыг илэрхийлж, хамгийн гол нь дэлхий амьдралаас гадуур байдгийг илтгэдэг. “Ум” болон бусад иймэрхүү үг бүгдээрээ “SoHm”-ын хувилбар юм.

- Яагаад “SoHm”-ыг сүүлчийн илгээлт гэдэг юм бэ?

- Яагаад гэвэл энэ нь хүн амьдралынхаа туршид сайн үйл бүтээж өөрөө өөрийгөө боловсруулах ёстой гэсэн сануулга юм. Өмнөх иргэншил сайн чиглэлээс гадна бас муу чиглэл рүү зэрэг хөгжсөн. Атлантчууд Дээд Оюун Ухаанд хялбархан нэвтэрдэг байсан бөгөөд тэндээс олж авсан мэдлэгээ зөвхөн сайн үйлэнд бус саар үйлэнд ч бас ашигладаг байжээ. “SoHm” гэдэг нь дараагийн соёл иргэншил буюу манай соёл иргэншил нь “ертөнцийн мэдлэгийн сан” -гаас авсан мэдлэгээ муу үйлэнд ашиглахгүй гэсэн баталгаа байхгүй учир Дээд Оюун Ухаанд нэвтрэх



эрхгүй. Эхний болон эцсийн амьсгалынхаа хооронд, өөрөөр хэлбэл Дэлхий дээрх амьдралынхаа туршид өөрөө боловсор гэсэн үг юм.

-Хүмүүсийг “ертөнцийн мэдлэгийн сан” – д нэвтрүүлэх нь дэндүү аюултай. Жишээ нь энергийн өөр төрлийн тухай мэдээллийг тэндээс авах нь манай соёл иргэншлийн хувьд үхэл болж болох юм, - гэж би хэлээд,- “SoHm” -ын зарчим нь Дээд Оюун Ухаан хүмүүс Нийтийн мэдлэгт амархан нэвтэрдгийг хаасан нь хүмүүсийг өөрсдөө боловсрон мэдлэгээ хуримтлуулаг гэсэн утгатай юм байна.

- “Тийм. Яг зөв.” гэж свами Дарам хариулав.

- Гэхдээ зарим хүмүүс Ертөнцийн Мэдээллийн Оронд нэвтрэх эрхтэй байдаг шүү дээ. Энэ хүмүүсийн сайн санаанд эргэлзэх хэрэггүй буюу тэдний торсын орон нь илт эерэг

чиглэл рүү эргэсэн байдаг учир тэд нэвтрэх эрхтэй болдог гэдгийг би ойлгож байна. Тэгээд тэд магадгүй Гэгээнтэн, том эрдэмтэн болдог боловч маш олон хүний сөрөг чиглэл рүү эргэсэн энергийн оронтой тэмцэх болдог учир тэдний амьдрал маш хүнд байдаг.

- Тийм хүмүүс бол мастерууд юм гэж хамба Дарам хэлэв.

- Би танд нэгэн сонин түүх ярьж өгье, - гэж би цааш нь үргэлжлүүлэн, - Ертөнцийн Мэдээллийн Орноос хоёр үзмэрч эмэгтэйн авсан мэдээллийн дагуу Гитлерийн цэргүүд нисдэг таваг хийж байгаа тухай баримтат кино үзэх завшаан надад олдсон юм. Дайн төгсөхийн алдад Гитлерчүүд тавгаа хийж дуусган, таваг нь нисэж байсан боловч хэзээ ч түүгээрээ нисэж чадаагүй. Учир нь бэлэн болсон нисдэг тавагнууд үл мэдэгдэх аргаар алга болжээ. Миний бодлоор бол гитлерчүүдэд өмнөх соёл иргэншлийн нисдэг тавагны тухай мэдээллийг дамжуулсан нь “SoHm”-ын “өөрсдөө боловсор” гэсэн зарчмыг шууд зөрчсөн хэрэг. Тэгвэл яагаад энэ мэдээлэл дамжих болов? Муу муухай санаатай нь эргэлзээ төрүүлэмгүй байсан Сталины эсрэг болохоор зөвшөөрөгдсөн хэрэг үү?

- Магадгүй, - гэж хамба Дарам хэлээд,- Гэхдээ Муу Муухайн Агуу Сүнс байдгийг битгий мартаарай. Эерэг болон сөрөг энерги нь хоорондоо холбоотой.


Сайн санаа, Хорон санаа хоёр зэрэгцэн оршдог. Сэтгэлийн сөрөг энергийн үүргийг үгүйсгэж хэзээ ч болохгүй.

- Ертөнцийн Мэдээллийн Орон алдаагаа засна гэж байх уу? Магадгүй энэ нь нисдэг таваг нууцлагаар алга болохын шалтгаан болсон юм уу?

- “SoHm”-ын зарчим зөрчигдөхөд Дээд Оюун Ухаан хүчнээс гадуур учир хүч хэрэглэн үйлчилж чадахгүй. Гэхдээ тэр хүмүүсийн сэтгэл санаанд нөлөөлж чадна. Нисдэг таваг хийж буй хүмүүсийн оюун ухаанд нөлөөлж, бүтээсэн зүйлийг нь устгуулж чадна. Сайн үйл ялах ёстой. Үгүй бол дэлхий сөнөнө.

- Хорон санаатай, эрх мэдэлд дуртай атлантчуудаас болж манай соёл иргэншил Ертөнцийн Мэдээллийн Орноос тусгаарлагдсан нь гомдмоор л юм гэж би үнэн голоосоо хэлэв.

- Мэдээж атлант болгон муу санаатай байгаагүй л дээ. Гэхдээ тэдний соёл иргэншилд сөрөг энерги ялсан. Манай соёл иргэншилд юу болохыг,



сайн үйл ялах үгүйг харж л байя. Тийм ч учраас бүх шашин “SoHm” буюу би өөрөө сайн тал руугаа боловсорч байна гэсэн утгатай умыг (эсвэл төстэй үгсийг) байнга давтаж байхыг номлодог гэж хамба Дарам хэлэв.

- Манай иргэншил сөнөхөд хэрвээ Ертөнцийн Мэдээллийн Орон самадид орсон байгаа хүмүүсийн сүнсийг илгээхээс татгалзвал манай иргэншлийн хувьд “SoHm” нь сүүлийн илгээлт болох юм байна.

- Магадгүй...

- Уучлаарай, сүүлийн асуулт, - гэж би хэлээд, - Ярилцлагын эхэнд би танд атлантын зургийг



үзүүлэхэд та биднээс түүнийг харсан эсэхийг асуусан. Өнөө үед түүнийг харж болох юм уу?

- Болно. Тэд өнөөдөр ч самадийн байдалд байх ёстой. Зөвхөн тэд ч биш...

- Өөр хэн гэж?

- ....

Бид Дарам мастерыг гэрт нь хүргэж өгөн маш халуунаар салах ёс хийцгээв. Энэ хүнээс сэтгэлийн маш их хүч чадал, сайн санаа цацарч байлаа. Явмааргүй байсан. Сергей Венер хоёр ээлжээр түүнтэй гар барин би зураг авч байв. Свами Дарам цагаахнаар инээмсэглэнэ.

- Энэ мэдлэгээ сайн үйлст зориулаарай гэж тэр эцэст нь хэлэв.

---

Ингээд, Энэтхэгт хийсэн шинжилгээгээр бид гаргасан таамгаа үндсэндээ баталгаажууллаа. Манай хүн төрөлхтөн Төвдөөс үүссэн болон атлантын дүр төрх, соёл иргэншлүүдийн мөхөл зэрэг нь шинжилгээгээр явахаас өмнө бүдэг, бадаг, эргэлзээтэй мэт санагдаж байсан юм. Шинжилгээний ангийн шугамаар энэтхэгийн хамба лам нартай уулзахад энэ нь тэдний хувьд энгийн мэдээжийн асуудал юм байна гэдгийг ойлголоо.

Бид шинэ нээлт хийчихэв үү? Ямар нэгэн хэмжээнд тийм. Энэ бол шинжлэх ухаан дангаараа гаргаж авсан баримт түүх-шашны мэдээлэлтэй таардаг тохиолдлуудын нэг. Ихэнх хүний үлгэр домог гэж эсвэл оюуны номлол гэж үздэг шашин бол Дарам хамбын хэлсэнчлэн өмнөх иргэншлүүдийн гүн утга санаатай мэдлэг ажээ.

Үүнээс гүнзгийрсэн шашны мэдлэгийг муу үйлэнд ашиглахаас сэрэмжилэх цорын ганц шалтгаанаар олон түмэнд тараагддаггүй буюу нууц байдгийг бид ойлголоо.

Эдгээр мэдлэгийг бид муу хүчинд өгчих юм биш биз? Бидэнд чинь чамгүй олон нууцыг задалсан шүү дээ! Үгүй. Сөрөг хэлбэрээр ашиглаж болох зарим асуудлыг бид орхиж бичсэн. Тэдгээрийг бид хэзээ ч дэлгэхгүй. Бид зөвхөн өмнөх хүний дүр зургийг бодож олсноороо итгэл хүлээгээгүй, бас сайн санаанд хөтлөгдсөн хийсвэр сэтгэлгээний судалгааны хүчээр итгэл хүлээсэн юм. Эдгээр нууцын хөшиг нээгдэх цаг нь болсоных ч байж магадгүй.

Бидний хувьд сүүлийн илгээлт “SoHm” ба самадийн тухай ойлголт хамгийн их сэтгэл догдлуулсан. Хүн төрөлхтнийг аврах арга зам гэдэг үүднээсээ самади анхаарал татан, сэтгэл хөдөлгөж байлаа.

Бид эрлээ цаашүргэлжлүүлэн Төвд, Балбыг чиглэн явсан юм. Одоо бид асуултын тодорхой хүрээтэй боллоо. Төвд лам нар юу гэх бол?



ГУРАВДУГААР БҮЛЭГ

## Балба, Төвдийн лам нар юу гэж яриув?



Нэгдүгээр хэсэг  
**Самадид хэрхэн орох вэ?**

Хоёрдугаар хэсэг  
**Хүн эргэж амьдрах боломжтой юу?**

Гуравдугаар хэсэг  
**“Билгийн нүд”-ний тухай дахин нэг ярихад**

Дөрөвдүгээр хэсэг  
**Дараагийн удаа арай нухацтай хандах болно**

Тавдугаар хэсэг  
**Бумба ламын илэн далангүй яриа**

Зуравдугаар хэсэг  
**Будда гэж хэн байсан бэ?**

Долдугаар хэсэг  
**Лемурчууд болон атлантчууд гэж хэн бэ?**

Наймдугаар хэсэг  
**Самади-агуйд**

Есдүгээр хэсэг  
**Өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрх**

Аравдугаар хэсэг  
**300 жил амьдарч буй хүн**



Нэгдүгээр хэсэг

## Самадид хэрхэн орох вэ?

Бид Делигээс Балбын нийслэл болох Катманду хотод ирэв. Онгоцны буудал дээр биднийг энд ирээд арваад хонож буй Валерий Лобанков, Валентина Яковлева нар угтав. Тэдэнтэй цуг манай шинжилгээний ангийн Балба гишүүн балбын нэрт физикч, Балбын их сургуулийн багш Шесканд Ариэль мөн цуг угтав. Түүнийг төвдийн шашныг сайн мэддэг, шашны баримтыг орчин үеийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах чадвартай хүн гэж төвдийн судалгааны төв бидэнд зөвлөмж болгон өгсөн юм. Тэр англиар сайн ярина.


Валерий Валентина Шесканд 3 нэлээд хэдэн сонирхолтой хүнийг бидэнтэй уулзуулахаар бэлдсэн байлаа. Төвд лам нартай илэн далангүй ярилцах маш хэцүү гэдгийг тэд нэмж хэлэв. Учир нь ихэнх томоохон цол хэргэмтэй лам нар



*Катманду хотод*

1949 онд Төвд, Хятадтай нэгдсэний улмаас Төвдөөс дүрвэн Балбад ирсэн хүмүүс байлаа. Хятадын коммунистуудын зүгээс Төвдийн шашны зүтгэлтнүүдэд үзүүлдэг байсан гашуун дарамт нь тэдний мах цусанд шингэж, өнгөрсөнтэй нь холбоотой мэдлэгийг сонирхсон хүн бүхэнд үл итгэх ул мөрийг үлдээжээ. Бүх нийтийн эрх тэгш байдал гэдэг уриан доор нуугдаж байсан худал хуурмагаас үхтлээ айдаг айдсын улмаас манай эцэг өвгөдийн хувьд ч мөн энгийн амьдралын хир хэмжээнээс гарсан бүхэн эргэлзээ төрүүлдэг байсантай энэ тохиолдол адил бизээ.

Эхлээд бид Катмандугийн бясалгалын төвийн тэргүүн бясалгалын багш Шамбу Тхапатай уулзлаа. Шескандын хэлснээр энэ хүн лам нарт байдагчлан шашны талаарх гүн мэдлэг байхгүй ч өдөр болгон бясалгал явуулж хүмүүсийг самадид оруулдаг учир энэ талаарх бодит (практик) мэдлэг өндөртэй хүн. Ноён Шамбу Тхапа уулзалтыг гэртээ зохион байгуулав. Уулзалтын эхний мөчөөс эхлэн



*Бясалгалын багш Тхана Шамба В. Лобанковтай хамт*

тэр бидэнтэй яг л бясалгалын сурагчтайгаа харьцаж буй мэт харьцаж эхлэв. Яриа судалгааны хэлэлцүүлгийн хэв маягт оруулахыг зорьсон боловч нэг л амжилттай болохгүй байлаа. Бясалгалын багш маань шууд л “Мэргэн ухааны нүд өөрийгөө дотроос нь танин, тайван байх ёстой, амьдралын зорилгоо ойлгох үүднээс бүх юмны мөн чанарыг таних чадвартай” гэх мэт ойлгоход бэрх хүнд өгүүлбэр урсган, бясалгалын ашиг тусын талаар яриа хийж эхлэв.

Эхлээд би хэлсэнийг бичиж авахыг оролдсон боловч бясалгалын багшийн бодлын явцыг гүйцэхгүй байснаас энэ ажлаа орхихоор шийдэв. Ингэхдээ багш байнга “Do you follow my mind?” буюу “чи миний бодлыг дагаж байна уу?” гэж асуун, ингэж асуухдаа тэрээр нүд рүү эгц ширтэн хариулт нэхдэг байлаа. Эхэндээ

би асуух болгонд нь “yes”-”тийм” гэж хариулан мөн л нүд рүү нь харж байсан боловч уг хорон (шимэгч) асуулт нэг өгүүлбэрт хэд хэд давтагдаж байсан тул би хариулахаа болив. Жишээ нь орос хэлний тэгэхээр, тэгвэл (значит) гэдэг үг шиг хүмүүсийн ярианд хорон үг маш их хэрэглэгддэгийг би мэднэ л дээ. Гэвч ийм урт хорон өгүүлбэр, тэгээд бүр хариу шаардсан хорон өгүүлбэртэй би анх удаа таарлаа.

Намайг тэгтлээ залхаасан “Do you follow my mind?” гэсэн асуулт хорон өгүүлбэр биш, харин хүний анхаарлыг сарниулалгүйгээр багшийн бодлыг дагуулж бясалгал хийлгэх гэсэн арга болохыг би хожуу ойлгосон юм. Гэвч би бясалгал хийхийг биш, бясалгалыг самадид орох арга гэдэг үүднээс учрыг нь олох хүсэлтэй байсан юм. Тэгээд би ярианы төлөвийг өөрчлөхийн тулд багшийн аргыг өөрт нь хэрэглэхээр шийдэв. Боломж тааруулан би багшид асуулт тавиад, араас нь “Do you follow my mind?” гэж асуун нүд рүү нь ширтэхэд, энэ удаад багш “yes” гэж хариулахаас өөр аргагүй болов. Үүнийг хэд хэдэн удаа давтсаны дараа би сургаалийн явцыг өөрчлөн яриаг шинжлэх ухааны урсгалд оруулж чадав.

Бясалгалын багш бидэнд бясалгалын аргаар самадид орж болно гэж хэлэв. Бясалгалын тухай сургаал Төвдөд үүсч, тэндээсээ дэлхийгээр тархсан юм. Анхаарлаа ямар нэгэн объект дээр эсвэл объектгүйгээр төвлөрүүлснээр бясалгалын байдалд орно. Бие даан бясалгах хэцүү. Тусгай сургуульд хамрагдах хэрэгтэй.



*Бясалгалын хичээл*

Бясалгал хийх явцдаа хүн сэтгэл дотроо ордог. Ингэхдээ хүн биеийнхээ хэсэг болгоныг мэдрэх чадвартай. Бүр биеэ бүхлээр нь нэгэн зэрэг мэдэрч биеийнхээ дотор нэгэн хормын дотор болж буй өөрчлөлтийг ч ажиглах боломжтой болдог. Бясалгалын байдалд хүн амьдралыг илүү гүнзгий таньж, амьдралд эзлэх байр сууриа олж, бие бол хүний сүнсний зэмсэг л юм гэдгийг ойлгож чаддаг. Бясалгал хийснээр хүн амьдралын ихэнх материаллаг талаас болж (жишээ нь мөнгөнөөс) сэтгэлээр унан гутрах хэрэггүй юм гэдгийг ойлгосноор илүү эв найрамдлыг эрхэмлэгч болдог. Эв найрамдлыг эрхэмлэдэг болгох нь бясалгалын гол зорилгын нэг юм.

Энд сэдвээсээ түр хазайн Пуна хотын (Энэтхэгийн) Ошо сургуульд ажилладаг Сингха ноёноос авсан бясалгалын тухай мэдээллийг иш татахыг зөвшөөрнө үү.

*Бясалгалын 112 төрөл байдаг. Хүн болгонд өөр өөр бясалгалын төрөл таардаг. Бясалгал гэдэг нь нэг орон зайгаас нөгөөд шилжих шилжилт юм.*

*Бясалгалд “дуугаа хураах” болон “нүх” маш их үүрэг гүйцэтгэдэг. Ярианы үед дуугүй байж, өөрийн аниргүй байгаадаа анхаарлаа төвлөрүүлж суух юм бол “нүх”-ийг мэдэрч болно. Хэрвээ “нүх” 4-5 секунд үргэлжлэх юм бол зөн совинг (интуиция) мэдэрч болно. Зөн совин 100% үнэн байдаг бөгөөд энэ бол бодох үйл биш харин сэм хэлж буй тусламж юм. Хэрвээ “нүх” 28 секундээс дээш үргэлжилбэл хүн өөрийн биеийг хажуугаас харж эхлэн, биеэ нэгэн сайхан тогтолцоо гэж хүлээж авдаг буюу самадийн байдалд дөхөж очно.*

*Бясалгалийг голдуу Буддагийн байрлалаар хийдэг ба бясалгалын явцыг хөнгөлж өгөх олон арга байдаг.*

Дараа нь багш бясалгалын гурван үе шат байдгийг нэрлэв:

1. Селла, гүн ухамсарт хүрэх шат
2. Самади, бие чулуун хөшингө байдалд орж сүнс биенээс гарах шат
3. Пражна, амьдрал болон ертөнцийн танин мэдрэхүйн жинхэнэ мэргэн ухаанд хүрэх шат.

- Самадид орох үеийн бясалгалын онцлог юу вэ? Do you follow my mind? – гэж би асуув.

- Yes,- гэж багш хариулаад, - Самадид орохын тулд сэтгэлийн сөрөг энергээсээ ангижрах хэрэгтэй. Бие болон сэтгэл сөрөг бүхнээс ангижрах нь маш чухал. Америкт хүний биеийг олон жилээр хадгалж, дараа нь эргээж амьдруулах боломж хайж байгаа боловч тэд самадийн аргаар бие хадгалах нь сөрөг энергээсээ ангижирсан цагт л боломжтой гэдгийг ойлгохгүй байна.

- Сэтгэлийн сөрөг энергээс ангижирах үйл явц нь ямар байдаг вэ?

- Энэ үйл явц нь амьсгалаа авах гаргах үедээ оюун ухаанаа төвлөрүүлэхтэй холбоотой. Амьсгал бол дотогш, гадагш чиглэсэн хөдөлгөөн. Үүнд анхаарлаа

төвлөрүүлэн амьсгал авах нь амьдрал, гаргах нь үхэл. Харин чи өөрөө амьдрал үхлийн эргэлтэнд оршдог гэж өөртөө итгүүлэх хэрэгтэй.

- Хамраараа амьсгалахтай холбоотой “SoHm”-ын агуу их зарчмын арга мөн үү гэж би үгийг нь таслан асуувал,

- Би “SoHm”-ын талаар муу мэднэ. Үүний тухай Энэтхэгт илүү сайн мэддэг гэж багш хариулав.

- “SoHm”-ын гол учир нь хувь хүн дангаараа болон бөөнөөрөө “өөрсдөө боловсор” гэсэн сүүлийн илгээлтэнд оршино, - гэж би мөчөөгөө өгөхгүй үргэлжлүүлэв,- Самадид орох зорилгоор бясалгал хийх үед оюун ухаан газар дэлхий дээрх амьдралын (амьсгал авах) үед болон үхлийн (амьсгал гаргах) дараа ч тэр өөрөө боловсрох дээр төвлөрдөг юм бол уу? Өөрөөр хэлбэл хүн “Би өөрөө боловсорч байна. Амьдралын үед ч тэр, үхлийн дараа ч тэр би дээд зорилт болох нирваанд хүрэхээр өөрөө боловсорч байна.” гэж бодохдоо амьдралыг амьсгал авахтай холбож, үхлийг амьсгаа гаргахтай холбож боддог.

- Тийм, яг зөв,- гэж багш хэлээд,- Бид үнэхээр амьсгал авахыг амьдралтай, амьсгал гаргахыг үхэлтэй холбож үздэг. Үнэн хэрэгтээ бид өөрсдийгөө боловсруулахыг хичээдэг. Учир нь хүний өөрөө боловсорсны дээд хэлбэр бол нирваанд хүрэх явдал юм. Харин нирваанд (сэтгэлдээ шинжилгээ хийх чадвар) хүрэх зам бол зөвхөн самади юм.

- Судасны цохилт зогсож, бодисын солилцооны энерги тэгтэй тэнцэж, бие чулуун хөшингө болж самадид орох хэцүү юу?

- Маш хэцүү, - гэж багш хэлээд,- хүн болгон самадид орж чаддаггүй. Үүнийг онцгой сонгомол хүмүүс л хийж чаддаг.

- Яагаад? Хэн тэднийг сонгодог юм бэ?

- Бясалгалын сургуулиудад хүмүүс өдөрт 3 удаа самадид орж, нэг удаа орохдоо нэг цагаас хэтэрдэггүй. Аль хир удаан самадид байж чадахыг чинь самади өөрөө тодорхойлоод өгнө.

- Самади өөрөө хугацаагаа тодорхойлоод өгнө гэсэн чинь юу гэсэн үг вэ?

- Биеэсээ салсан сүнс бусад сүнстэй харьцаж Дээд Оюун Ухаантай холбогддог. Тэнд уг хүн аль хир удаан самадид байж чадах нь тодорхойлогддог гэж багш хариулав.

- Самадийн хугацааг сунгахад хүний биеийн эрүүл мэнд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

- Хүний бие тодорхой үүрэг гүйцэтгэдэг ч гол нь орчны температур. Сэрүүн орчинд бие удаан хадгалагдаж чаддаг. Хамгийн гол нь хүний бие сөрөг бүхнээсээ ангижирсан байх ёстой. Сүнс нь сөрөг энергээсээ салсан байх ёстой. Сөрөг бүхнээсээ салсан хүн л самадийн байдалд удаан байх эрхтэй. Ер нь бол хүний бие сүнсний зэмсэг болдгоороо үүрэг багатай. Do you follow my mind? – гэж багш асуув.

- Yes, -гэж би хариулаад,- Таны ярьсан юм маш чухал байна. Самадийг хэдэн мянга, хэдэн сая жилээр сунгаснаар галав юүлэхэд хүн төрөлхтний генийн сангийн үүргийг гүйцэтгэнэ. Урт хугацааны гүн самадид орсон хүн галав юүлсний дараа дэлхийн шинэ нөхцөл байдалд дасан зохицож, өөрийгөө шинэ хүн төрөлхтний эх эцэг болох үйлсэд зориулж байдаг юм байна. Do you follow my mind?

- Yes,- гэж багш хариулав.

- Мэдээж,- гээд би үргэлжлүүлэн,- Шинэ иргэншлийн суурийг тавих зорилготой урт удаан хугацааны гүн самадид хүн болгон орох чадваргүй. Хүн төрөлхтний генийн сангийн төлөөлөгч байна гэдэг чинь дэндүү хариуцлагатай хэрэг! Тийм хүмүүсийн сүнс нь сэтгэлийн сөрөг энергээс буюу сөрөг чиглэлд эргэсэн торсын орон зайгаас чөлөөлөгдсөн байх ёстой бөгөөд энэ хүмүүсийн бие нь эрүүл, өвчингүй байх ёстой. Яагаад гэвэл өвчин нь сэтгэлийн торсын орон зайг сөрөг тийш нь эргүүлдэг. Үүний баталгааг бид хорон муу санаа болон өвчин хоёрт ерөнхий буй офтальмогеометрийн (жижиг гурвалжин) үзүүлэлтээс харж болно.


Дээд Оюун Ухаан тухайн хүний сүнснийг, биеийн байдалтай нь цуг үзээд гүн самадид ороход тохирох хүн эсэхийг шийддэг байж болно. Гүн самадид орж, хүний генийн сангийн төлөөлөгч болох нь хүний дээд үүрэг юм. Тийм учраас зөвхөн тохирох хүн л гүн самадид орох эрхтэй гэдэг нь ойлгомжтой.

- Тийм, - гэж багш хариулаад, - Үүнээс гадна бясалгалын дээд хэлбэр буюу пражнагийн үед хүн дотогш харах буюу өөрийн дэлхий дээр биелүүлэх ёстой үүргээ ойлгодог. Do you follow my mind?

Ингээд тэрээр европ сэтгэхүйтэй надад ер ойлгогдмооргүй хийсвэр үг өгүүлбэрээр өвч чимсэн урт яриа өрнүүлэв.

- Клиник үхлийг самади гэж ойлгож болох уу гэж би эцэст нь асуув.

- Клиник үхлийн үед сүнс үнэхээр биеэс холдон явдаг боловч самадигаас ялгаатай нь бие удаан хугацаагаар



хадгалагдахад бэлэн бус байдаг гэж бясалгалын багш хариулав.

Дараа нь би багшид миний ажил дээр болсон нэгэн сонирхолтой түүх ярьж өгөв. Хүрээлэнгийн захирал над дээр манай байгууллагын оёдолчин ирэв. Тэрээр долоо хоногийн өмнө харшлын шоконд орсны улмаас клиник үхлийн байдалд орж, тэр үедээ өнгөрсөн, ирээдүйг харснаа ярив. Тэрээр үүнтэй холбоотойгоор далдыг харагчийн сургалтанд явах зөвшөөрөл гуйв. Би зөвшөөрөөд, тоглоом болгон доорхи тушаалыг гаргасан юм. “Иванова.Л.-ын албан тушаалыг хүрээлэнгийн далдыг харагч болгон сольж цалингийн хэмжээг хэвээр хадгалсугай. Ерөнхий нягтлан болон судалгаа эрхэлсэн орлогч захиралтай зөвлөсүгэй.”

Тушаалыг боловсон хүчин рүү шилжүүлчихээд цаашид юу болохыг хүлээн суув. Боловсон хүчний хэсгийн эрхлэгч болох дээд боловсролтой, ухаалаг эмэгтэй тушаалыг хэвлэж ирээд ганцхан асуулт асуув:

- Иванова.Л.-ыг хүрээлэнгийн аль салбарт далдыг харагчаар хуваарилах вэ гэв.

- Ерөнхий нягтлан болон судалгаа эрхэлсэн орлогч захиралтай зөвлө гэж би хариулав.

Хэдэн минутын дараа ерөнхий нягтлан утсаар холбогдон асуулт тавив:

- Хүрээлэнгийн далдыг харагчийн цалинг аль төсвөөр тогтоох вэ? Нэг ч төсөвт ийм мэргэжил алга?

Уг асуудлаа судалгаа эрхэлсэн орлогч захиралтай нийлж шийд гэсэн хариулт өгчихөөд хүлээж байтал хагас цагийн дараа судалгаа эрхэлсэн орлогч захирал над дээр ирэн:

- Та далдыг харагч оёдолчинг миний хэсэгт томилох гээд байгааг чинь мэдэрч байна. Би түүний далдыг харах чадварт эргэлзэж буйгаа шууд хэлчихье. Тэгээд ч түүний тэр чадвар чинь манай нүдний судалгааны ажилд саад болох болно. ...

Тэгээд би тоглоом хийснээ хүлээхэд бүгд инээлдэв. Европ маягийн захиран тушаах арга барилтай манайхны нөхцөлд даргын үг, тушаалыг үг дуугүй хүлээж авдаг нь сонин байлаа. Хэн ч нүд судлалын хүрээлэн далдыг харагчаар яах гэж байгаа юм бол гэж бодсонгүй. Хагалгаа амжилттай болох уу үгүй юу гэдгийг харах юм уу?

Нөгөө талаас манай хүмүүсийн шашны мэдлэг дутагдаж буй нь харагдаж байв. Тэд “далдыг харагч” гэсэн үгийг “зохицуулагч” гэдэгтэй холбоотой мэт ойлгодог. Яагаад оёдолчин энэ албан тушаалыг авах болсон нь л эргэлзээ төрүүлж байлаа.

- Далдыг харагчаар ажилладаггүй. Харин далдыг харагч байдаг юм гэж бясалгалын багш хэлэв.

Миний ярьсан шог яриаг тэр үнэндээ бүрэн ойлгосонгүй бололтой. Бид ч хаяа түүнийг ойлгодоггүйн адил биднийг Дорнын шашны зүтгэлтэн ойлгосонгүй.



---

- Самадид шилждэг бясалгал хийж үзүүлэхгүй юу гэж би түүнээс гуйхад, багш:

- Үүнийг захиалгаар хийх боломжгүй гэв.

Одоо бол бид түүнийг бага ч атугай ойлгож байлаа.

Ингээд уг уулзалтаар бид зөвхөн цэвэр, хүчтэй хүмүүс гүн самадид ордог тухай, мөн самадид орох аргуудыг тодруулж авсан юм. Мөн самади болон клиник үхлийн хоорондын ялгааг ойлгов.

Эмч хүний хувьд надад хүнийг эргээж амьдруулах зорилготойгоор бие болон сүнсэнд нь нөлөөлж болох эсэх нь сонин байлаа.

Хоёрдугаар хэсэг

## Хүн эргэж амьдрах боломжтой юу?

Бид бүгдээрээ Исүс Христ зөвхөн гараа даллахын төдий хүний өвчнийг илааршуулж, эргээж амь оруулж байсан тухай кино үзсэн биз ээ. Орчин үеийн шинжлэх ухааны ололт болон бидний шинжилгээний явцад олж авсан мэдлэгийн үүднээс үүнийг хэрхэн тайлбарлах вэ?

Түрүүчийн соёл иргэншлийн хүний сүнс болох сэтгэлийн энергийн хүчин чадал ихтэй Исүс Христ хүчирхэг эерэг чиглэлтэй торсын орныхоо тусламжтайгаар үхэл, өвчний үе дэхь сөрөг торсын оронг буцааж эерэг чиглэлд эргүүлж байсан байж болох. Буддын шашны үг хэллэгээр бол тэр хүний сүнс болон биеийг сэтгэлийн сөрөг энергээс ангижруулдаг. Сүнсний астрал биеийг сөрөг чиглэлд эргэсэн торсын оронгоос ангижруулах нь эдийн бодисын солилцоонд шууд нөлөөлснөөр бие эрүүлжинэ. Хэрвээ бие махбодийн эвдэрч сүйдсэн нь их биш бол түүнийг орхин одсон сүнсийг нь эргээж авчран дахин амьдруулах боломжтой. Экстрасеанс зэрэг анагаагчид ч үүнтэй адил зарчимд тулгуурладаг бололтой.

Исүс Христ ямар хүчийг ашиглаж сөрөг энергитэй тэмцдэг байсан юм бол? Самадигаас гарах болон эргэн амьдрах хоёр юугаараа ялгаатай вэ? Сүнс биед буцаж ирэхийн шалтаг болон явц нь ямар байдаг вэ?

Манай шинжилгээний хэсгийн Балба гишүүн Шесканд Ариэль эдгээр асуултанд хариулт авахын тулд ноён Мин Бахадур Шакьятай уулзахыг зөвлөсөн юм. Түүнийг нигүүлсэхүйн ухааны хамгийн том мэргэжилтэн гэдэг ажээ. Тэр үед би ахуйн талаас улиг болсон нигүүлсэхүй гэдэг нь анагаахын, бүр үхэл амьдралын асуудалд маш том үүрэг гүйцэтгэдгийг ойлгоогүй явлаа.

- Нигүүлсэхүй үүнд чинь ямар хамаатай юм бэ? - гэж би Шескандаас асуувал,

- Нигүүлсэхүйн ухаан гэдэг бол Дорны томоохон сургаалиудын нэг. Энэ нь маш олон янзын үзэл баримтлалтай. Та түүнтэй уулзаад л ойлгох болно гэж Шесканд Ариэль хариулав.

Ноён Мин гэж дунд зэргийн нуруутай, англиар цэвэрхэн сайн ярьдаг, эелдэг хүн байв. Бид нигүүлсэхүйн ухааныг судлах зорилт тавиагүй тул товчхон тодорхой асуулт тавьж байлаа. Ноён Мин ч товч, тодорхой хариулж байв.

Бид таамаглалынхаа утга учрыг танилцуулж атлантын зургийг үзүүлтэл ноён Мин дуу алдан:

- Тэр шаналж буй нүдтэй юм. Тэр шаналж байна...

- Яагаад?

- Би шаналж буй нүдийг шууд танина. Би маш их туршлагатай. Нүдний мэргэжилтнүүд та нарт ч юуг нь заах вэ дээ. Би юу мэдэрч байгааг та нар ойлгож байгаа байх. Түүний нүд нь хагас аниатай, догшин болж байна... Нээрээ та нар “догшин жижиг гурвалжин”-гийн тухай ярьж байсан. Би түүнийг чинь бараг харж байна. Гэхдээ түүний догшин байдал нь нөхцөл байдлын шинжтэй юм. Зовлонгоос үүдсэн сэтгэл дундуур байдал гэвэл арай дээр болов уу?

- Энэ бол танай улсын сүмүүд дээр дүрсэлсэн нүдний зурганд шинжилгээ хийснээр гаргаж авсан хүний дүр төрх. Энэ хэн юм бэ? Будда юу?- гэж намайг асуухад,

- Үгүй энэ бол Будда биш,- гэж ноён Мин хариулаад,- Энэ бол эртний, маш эртний хүн.


- Тэгвэл тэр яагаад зовж байгаа юм бэ? Юунаас болоод шаналаад байгаа юм бэ? Тэр олон мянган жилийн дараа самадигаас гараад газар дэлхий, хүн төрөлхтөний өөрчлөлтийг харсан юм болов уу? Магадгүй, тэр эртний гэгээнтнүүдийн нэг нь байсан юм болов уу?

- Самади гэдэг бол мөн л зовлон гэж миний асуултыг ойлгоогүй мэт ноён Мин үргэлжлүүлэв.

Тэр атлантын зургийг дахин гартаа авч сайтар хараад,

- Энэ бол шаналж буй биш, харин өрөвдөн нигүүлсэж буй харц байна. Энэ хүн дөнгөж самадигаас гарсан эсвэл самадид буй хүн бөгөөд маш хүчтэй, сэтгэлийн асар хүчтэй хүн байна. Нигүүлсэхүйн асар их хүчтэй хүн.

-Нигүүлсэхүйн хүч гэж юу юм бэ?



*Мин Бахадур Шакья*



- Нигүүлсэхүйн хүч гэдэг бол хүний сайхан сэтгэлийн хамгийн хүчирхэг нь юм. Энэ хүч хүний амьдрал, сайн үйлст нь маш их үүрэгтэй гэж ноён Мин хэлэв.

- Исүс Христ хүнийг амьдруулж эсвэл өвчин эдгээхдээ нигүүлсэхүйн хүчийг ашигладаг байсан гэж ойлгож болох уу гэж би асуув.

- Тийм ээ, зөвхөн нигүүлсэхүйн хүчний тусламжтайгаар хүний сэтгэлээс сөрөг энергийг зайлуулж болдог. Дэлхийн бүх хүнийг нигүүлсэхүйн ухаанаар хүмүүжүүлэх нь хүн төрөлхтнийг дэлхий дээр авран үлдээхэд маш их үүрэг гүйцэтгэнэ гэж ноён Мин хариулав.

- Та нигүүлсэхүйн сургаалийн үндсэн хэсгээс хэлж өгөхгүй юу.

- Нигүүлсэхүйг мэргэн ухаантай нигүүлсэхүй, мэргэн ухаангүй нигүүлсэхүй гэж хоёр үндсэн хэсэг болгодог, - гэж ноён Мин хэлээд, - Хоёр дахь нь хардалт, атаархал болон уур хилэнг дагуулдаг. Хардалтаас болж олон дайн гарсан.

- Тэгвэл самади болон нигүүлсэхүйн хоорондын уялдаа холбоо юу вэ?

- Бие, сэтгэлийн бүх сөрөг хүчийг хөөн зайлуулсны дараа бясалгалын аргыг хэрэглэн самадид ордог. Харин сөрөг хүчийг нигүүлсэхүйн хүчний тусламжтайгаар хөөн зайлуулдаг. Энэ нь маш чухал. Бие, сэтгэлийн сөрөг энергийг хөөн зайлуулж, бие, сэтгэлээ хоёуланг нь гэгээрүүлэх учиртай.

- Хэнийг нигүүлсэх вэ?

- Нигүүлсэхүй нь тодорхой субъектыг нигүүлсэхүй болон ерөнхий нигүүлсэхүй гэсэн хоёр төрөлтэй. Тодорхой субъектыг нигүүлсэхүй нь хүнийг эмчилж, амьдруулж эсвэл богино хугацааны самадид оруулах чадвартай. Хоёр дахь төрөл нь хүн төрөлхтөн болон хүн төрөлхтөний хувь заяаг ерөнхийд нь нигүүлсэхүй ба энэ нь биеийг хэдэн мянга, сая жилээр хадгалах гүн самадид оруулах чадвартай юм.

- Тэгэхлээр, - гэж би хэлээд,- нигүүлсэхүйн сайхан сэтгэл нь эмчилгээний хүчин зүйл болж, хүний сүнсийг биед нь буцаан, амьдруулж, Хүн Төрөлхтний Генийн Санд хадгалуулахаар гүн самадид оруулах гэх мэт маш олон талын ашигтай шинж чанартай юм байна. Нигүүлсэхүйн хүч нь сэтгэлийн сөрөг чиглэлтэй торсын оронг эерэг чиглэлд эргүүлэх чадвартай юм уу? Эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэхийн тулд нигүүлсэхүйн хүчийг хэрхэн ашиглах вэ?

- Үүний тулд жинхэнэ нигүүлсэхүйг хуурамч нигүүлсэхүйгээс ялгаж чаддаг байх ёстой, - гэж ноён Мин хэлээд, - Ихэнх хүмүүс нигүүлсэн өрөвдөж буй мэт дүр үзүүлдэг нь хуурамч тул эмчилгээний болон сэтгэл заслын үр дүнгүй. Жинхэнэ нигүүлсэл бол асар эелдэг сайхан сэтгэлийн далай юм. Сургуульдаа би нигүүлсэхүйг заадаг. Үнэн сэтгэлээсээ өрөвдөн нигүүлсэж сурсан миний сурагчид орчин тойрныхоо хүмүүсийг анагаах, эерэг үйлчилгээг үзүүлж, тэдэнтэй цуг байхад сайхан байдаг.

- Таны зөв,- гэж би хэлээд,- Хүн болгон нигүүлсэхүйн хүчний (мэдээж үнэн сэтгэлийн) үйлчилгээтэй таарсан байдаг. Мэс заслын эмчийн туршлагаасаа би гэрийнх нь өрөвдөн хайрладаг хүмүүсийн шарх нь хүртэл түргэн эдгэж, хагалгааны үр дүн илүү байдгийг мэднэ. Нигүүлсэнгүй сайхан сэтгэл нь өвчний улмаас үүдсэн торсын сөрөг оронг эерэг чиглэл рүү эргүүлэх чадвартай байдаг байх.

- Намайг хүүхэд байхад,- гээд Валентина Яковлева үргэлжлүүлэн, - Манай ээж хэзээ ч намайг эмээр эмчилдэггүй байсан. Тэр намайг сайхан сэтгэл шингэсэн нүдээрээ харан: "Охин минь би чамайг хайраараа эдгээнэ" гэж хэлдэг байсан юм.




**«Охин минь, би чамайг хайраараа эмчилнээ!»**

- Яг зөв. Энэ чинь л жинхэнэ нигүүлсэхүйн илрэл гэж ноён Мин хариулав.

- Хүнийг эргээн амьдруулах боломж,- гэж би хэлээд,- эмч хүний хувьд бидний сонирхолыг маш их татаж байгаа юм. Таны ярианаас үзэхэд чин сэтгэлээсээ нигүүлсэхүй нь үхсэн бие махбодоос ч сэтгэлийн сөрөг энергийг зайлуулснаар дахин амьдруулдаг юм байна. Манай хотын нэртэй оточ, экстрасеанс Олег Адамов үхсэн махбодь нь экстрасеансуудын мэдэрдэг амин оронг цацруулдаг гэж ярьдаг байсан. Түүний ярьснаар хүний үхсэн махбодоос жинхэнэ эмгэг энерги ялгаран

**Хэрэв бие махбодь хэт их гэмтсэн бол сүнс хэзээ ч биедээ эргэж орохгүй. Учир нь дэндүү их зовиур шаналал ирэх болно.**



цацарч байдаг. Үүнээс үзэхэд биеийн үйл ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангадаг сэтгэлийн зарим элемент (астрал бие) биеийг шууд орхин оддог байжээ. Нигүүлсэнгүйн хүчний тусламжтайгаар үхсэн хүний эмгэгтэй болсон амин орныг засаж, сүнсийг нь буцааж биед нь оруулах буюу амьдруулах боломжтой гэж үү?

- Танд хүнийг эргэн амьдруулах боломжтойг итгүүлэхийн тулд би нэгэн жишээ татья гэж ноён Мин хэлэв.

- Уучлаарай,- гэж би түүний яриаг таслаад,- та 3-5 минут үргэлжилдэг

клиникийн үхлийн үеийн сэхээн амьдруулахыг хэлж байна уу, эсвэл арай урт хугацааны дараа эргэн амьдрахыг хэлж байна уу?

- Клиникийн үхлийн үед сэхээн амьдруулах нь анагаах ухаанд тодорхой зүйл. Миний ярих гэж буй зүйл бол үхсэний дараа 4 хоногийн дотор эргэн амьдарсан явдал.

- Та ямар жишээ хэлэх гэсэн юм бэ?

- Пабмасанбута мастер нүдээрээ үзсэн, Энэтхэг, Балба, Төвдөд алдаршсан нэгэн түүхийг ярья. Түүний бичсэнээр Балбын ёгын сургуулиудын мөн чанарыг судлах зорилготой нэг эмэгтэй Катмандуд иржээ. Энэ өөрөө ёга хүн байжээ. Хотын нэгэн нэртэй хүний хүү цагдаа нарт зодуулсны улмаас өчигдөр нас барсан гэж түүнд хэлэхэд тэр азаар, байшингийн хүйтэн гүн хонгилд хадгалж байсан үхдэлд ойртон очиж ёгын хүчээр үйлчилжээ. Миний бодлоор энэ үед тэр хүчирхэг нигүүлсэхүйн хүчээ ашигласан. Үүний дараа мөнөөх залуу амь орсон байна. Дараа нь тэр залуу шархаа эдгээх гэж маш удаан өвдсөн гэсэн.

- Гэмтлээс үүдсэн өвдөлтийн шоконд орсоноосоо болоод тэр хүн үхсэн байж магадгүй, - гэж би хэлээд,- Магадгүй түүнд цусны томоохон судас хагарах ч юм уу, тархины гэмтэл ч юм уу биеийн үйл ажиллагааг хангагч эд эрхтэний хүнд органик гэмтэл байхгүй байсан учир сүнс нь эргэж ирсэн байх.

- Хэрвээ бие махбод өвчний улмаас, эсвэл гэмтлийн улмаас хэтэрхий гэмтэж үйл ажиллагаа явуулах чадваргүй болбол сүнс эргэн ирэхгүй. Бие гэж юу юм бэ? Бие бол сүнсний зэмсэг юм. Уг зэмсгийг “засаж” чадвал сүнс эргэн ирж болно. Хэрвээ зэмсэг маань эргэшгүй эвдэрвэл сүнс хэзээ ч биедээ эргэж ирэхгүй. Учир нь ингэхэд хэтэрхий их энэлдэг. Биеэсээ гарсан сүнс эргэн ирэх тийм ч амар биш. Сүнс ер нь биеийг нэг их үнэлдэггүй, чөлөөтэй. Учир нь сүнс мөнх бөгөөд маш олон амьдралтай буюу хувиралтай. Европчууд та нар хүн гэдэг бол юуны түрүүнд бие махбод бус сүнс юм гэдгийг ойлгодоггүй... гэж Мин ноён хэлэв.

- Гэвч биеийн үүргийг үгүйсгэж болохгүй! Бие түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид бүрэлдэн тогтсон бөгөөд та нарын хэлээр ярих юм бол маш үнэтэй, төвөгтэй бүтэцтэй зэмсэг юм...

- Самадийн үед биеийн үүргийг үгүйсгэж болохгүй гэж ноён Мин миний үгийг таслан хэлэв.

- Самадид сөрөг энергээс чөлөөлөгдсөн эв эрүүл биетэй хүний хамгийн сайн сүнс шалгардаг. Үүнээс гадна самадид орж буй хүний бие Дээд үүрэг болох хүний генийн сангийн нөөцөд ордог гэж би хэлэв.

- Ялгаатай нь самадид байгаа хүний сүнс өөр биед ордоггүй ба биедээ эргэн орох цагаа хэдэн мянга, сая жилээр хүлээж, энэ бүх хугацаанд зөвхөн уг биетэйгээ холбоотой байдаг. Сүнс эргэн биедээ ирэх үед бие нь амь ордог гэж ноён Мин хэлэв.

- Сүнс хэзээ биедээ эргэж ирэхийг хэн шийддэг вэ?

- Дээд Оюун Ухаан. Ингэхдээ газар дээрх амьдралын нөхцөл байдал, биеийн байдал зэрэг маш олон хүчин зүйлийг харгалзана. Сүнс үүнд маш их үүрэг гүйцэтгэнэ.

- Ер бусын зүйлсийг судлах шинжлэх ухааны (occultive science) зарим ном зохиолд (Е.Блаватская), сүнсийг үхсэн биетэй тодорхой хугацаанд холбодог “мөнгөн утас” гэдэг ойлголт байдаг.

- “Мөнгөн утас” тасрахад сүнс нь биеэ олж чаддаггүй. “Мөнгөн утас” нь самадийн үед хэдэн мянга хэдэн сая жилээр тасрахгүй хадгалагдаж чадна гэж үү?- гэж Валерий Лобанков асуув.

- Чадна. Самадийн үед сүнс биетэй самади үргэлжлэх бүх хугацааны туршид холбоотой байдаг, - гэж ноён Мин хэлэв.

- Физик үхлийн үед сүнс хэдий хугацааны туршид биетэйгээ холбоотой байдаг вэ?

- Энэ асуултанд хариулахад надад хүндрэлтэй байна,- гэж Мин ноён хариулаад,- Гэхдээ үхсэний дараа дөрөв хоногийн дотор эргэж амьдруулж болдгийг би мэднэ. Ингэхдээ шарил хадгалах газруудад шарилыг хөлдөөдөг шиг хөлдөөгөөгүй мөн хэт дулаанд байлгаагүй тохиолдолд ингэх боломжтой.

Хөлдөх үед биеийн эд эс мөсний талст болж гэмтдэг. Дулаан орчинд задралт явагддаг.

- Эргэж амьдруулна гэсэн найдвартайгаар биеийг хэдэн хэмийн дулаанд хадгалах хэрэгтэй вэ? – гэж Лобанков асуув.

- Тэгтэй ойрхон хэмд...

- Оросын алдарт нүдний эмч Владимир Петрович Филатов нүдний үүл авах мэс заслыг хийхдээ 3-4 хоног +4 хэмтэй орчинд хадгалсан цогцосны нүдний эвэрлэгийг шилжүүлэн суулгаж байсан. Тэр таны ярьсан энэ зарчмыг ашигладаг байсан юм болов уу? Ер нь бол В.П.Филатов шашны дээд зэргийн боловсролтой хүн байсан л даа.

- Магадгүй,- гэж ноён Мин хариулаад, - Тэгтэй ойролцоо хэм нь Самадийн нөхцөлд биеийг хадгалахад заавал шаардлагатай нөхцөл болдог.

- Филатов самадийн тухай мэддэг байсан юм болов уу?- гэж би бодоод,- Ийм нөхцөлд хадгалсан нүдний эвэрлэг өвөрмөц хэлбэрийн эс эдийн самадид ордог учраас өөр биед шилжүүлэн суухад эргэн амьдрах чадвар илүү байдаг байсан юм болов уу?

- Би нүдний мэс заслын талаар нэг их мэдэхгүй гэж ноён Мин хэлэв.

- Гэсэн ч, - гэж би зөрөөд үргэлжлүүлэн, - самади болон эргэн амьдруулалтын

хооронд уялдаа холбоо ажиглагдаж байна. Самадийн үед бие сөрөг энергээс ангижирсан буюу торсын орон нь эерэг чиглэлд эргэсэн байдаг. Харин үхлийн үед бие нь сөрөг энергээр чигжигдсэн байдаг (экстрасеанс Олег Адамовын хэлснээр). Сэтгэлийн эерэг энергийн тусламжтайгаар үхлийн сөрөг чиглэлд эргэсэн торсын оронг эерэг чиглэлд эргүүлвэл үхсэн бие нь самади маягийн байдалд орох ба сүнс эргэн ирэх боломжтой болно. Хүн бүр метастазтай хавдар, тархины үхшил зэрэг органик гэмтэлээс болж үхээд байдаггүй. Бие махбодид явагдаж буй өөрчлөлт нь эргэх боломжтой байдаг харшил, өвдөлт, хордолт зэргээс үүдсэн шокоос болж үхэх нь элбэг. Эсвэл цахилгаан шокоос үүдсэн зүрхний зогсолт... Харин зүрхний булчингийн



үхшилтээс үүдсэн үхлийн үед зүрхний булчингийн үхшилтийн шинж чанар үргэлж ажиглагддаггүй. Ийм тохиолдлоор үхсэний дараах 4 хоногийн дотор +4 хэмд



хадгалан, хүнийг эргэн амьдруулах арга хэмжээ авах нь зүйтэй байхсан. Гэхдээ ямар хүчээр үхсэн хүний торсын оронг эргүүлж болох вэ?

- Нигүүлсэхүйн хүчээр гэж ноён Мин хариулав.

- Хүний нигүүлсэхүйн хүчний чадал хангалттай юу?

- Нигүүлсэхүйн хүчийг бясалгалын аргаар нэмэгдүүлж болно.

- Гэхдээ Дорно дахины анагаах ухаанд хүнийг эргээж амьдруулсан тийм ч олон тохиолдлын тухай бичсэн байдаггүй...

- Тиймээ.

- Нигүүлсэхүйн эерэг энергийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд хэт өндөр давтамжийн өсгүүр зохион бүтээх шаардлагатай юу? Харамсалтай нь манай соёл иргэншил уг өсгүүрийн үүргийг гүйцэтгэж байсан “билгийн нүд”-нийхээ үйл ажиллагааг алдсан,- гэж Валерий хэлэхэд би түүнийг дэмжин,- Биоэнергийн асар их хүчин чадалтай, сайн үйл ажиллагаатай “билгийн нүд”-тэй байсан өмнөх соёл иргэншлийн хүмүүс төрөл төрөгсдөө илүү үр дүнтэйгээр амьдруулж чаддаг байсан байх. Тэдний үед хүнийг 4 хоногийн дотор эргэн амьдруулах нь бидний хувьд үхлийн дараа 3-5 минутын дотор сэхээн амьдруулахтай адил байсан бизээ.


- Би хүн төрөлхтний түүхийг сайн мэдэхгүй. Танай Их Гэгээрсэн Е.Блаватскаягийн “Нууц бичээс” номонд энэ тухай дэлгэрэнгүй бичсэн байгаа гэж ноён Мин хэлэв.

- Таны хэлснээс ургуулан бодоход,- гэж би мөчөөгөө өгөлгүй үргэлжлүүлэн,- хүнийг үхсэний дараа тэгтэй ойролцоо хэмд 4 хоногийн дотор хадгалахад эд эрхтнийг нь шилжүүлэн суулгаж болно. В.П. Филатовын суут оюун ухааныг биширч байна. Харин элэг, зүрх зэрэг томоохон эрхтнийг шилжүүлэн суулгахад сүнс яах вэ? Эдгээр эрхтэн амин орны элементийг агуулдаг биз дээ?


- Энэ бүхэн сүнсний хүчтэй эсэхээс хамаарна,- гэж ноён Мин яриагаа эхлээд,  
- Эрхтэн шилжүүлэн суулгуулсан хүний сүнс нь сул дорой бол шилжүүлэн суулгасан эрхтний амин орон маш хүчтэй нөлөө үзүүлдэг. Манай сургаалд “сүнс шилжүүлэх” гэсэн ойлголт байдаг. Номонд бичсэн нэг түүхийг иш татья. Төвдийн алдартай йогч Минерапа нэг удаа түүний багш Марпын хүү автын осолд орон нас барахыг харжээ. Марпын хүүгийн бие нь маш их бэртэж гэмтэн эргэж амьдрахад тохиромжгүй болсон байна. Тэгээд Марпа хажуугаар өнгөрч байсан нэгэн тариачны биед нь хүүгийнхээ сүнсийг оруулсан байна. Нэг ёсондоо тариачин нь Марпын хүү болсон байна. Тариачны сүнс илүү сул дорой байсан учир биеэсээ хөөгджээ. Өөр дүр төрхтэй болсон Марпын хүү өөрийгөө тариачин бус харин йогч багшийн хүү гэж төсөөлж байлаа.

- Тэгэхээр Марпа хүүгийнхээ сүнсэд зориулж тариачны сүнсийг чөлөөлөн түүнийг алсан хэрэг үү?

- Амьдралд тариачны гүйцэтгэх үүрэг нь Марпын хүүгийн гүйцэтгэх үүргээс бага учир тэрээр түүний сүнсийг чөлөөлөн дээш явуулсан юм.



Төрөлт



Манай соёл иргэншил. Сүнс Нөгөө Ертөнцийн мэдлэгээс тасарч буй нь

- Мөн өөр нэгэн мэдээ байдаг,- гэж Валентина Яковлева хэлээд,- Сталин Ленин хоёрыг нэг сүнстэй гэж ярьдаг. Ленины бие нь хэрэггүй болох үед тэрээр Сталины сул дорой сүнсийг хөөж гарган биед нь шингэсэн байна. Гэхдээ энэ нь Муу Муухайн Агуу сүнсний илрэл байгаа юм. Учир нь Сталин Ленин хоёр 9 жил 9 сар 9 өдрийн (Нострадамусынхаар) буюу буруу харсан гурван зургаагийн тооний зөрөөтэйгээр төрсөн байна.

- Магадгүй л юм, - гэж Мин хариулав.

Энд би Валентина Яковлева, физикч Валерий Лобанков болон өөрийнхөө цуглуулсан шинжлэх ухааны судалгааны материалаас иш татъя.


Төрөх, үхэх, самади гурав нэг зарчимтай бөгөөд мөн эсрэг тэсрэгийн шинж чанарыг агуулна.

**Төрөх үед** хүүхдэд эхээс нь бие махбодийг амьд хүүр маягаар ажиллуулахад хангалттай доод давтамжийн орон буюу сүнсний зарим нэгэн (астрал бие, эфир бие зэрэг) хэсгүүд уламжлагддаг.

Анхны амьсгал авахтай зэрэг нярайн биед сүнс нисэн орж ментал бие (сэтгэн бодох чадвар) болон сүнсний кармын хэсэг (өмнөх амьдралуудын тухай) зэргийг ажиллуулна. Тархи ажиллаж эхлэн сүнсний торсын орныг эргүүлж эхлэдэг. Тэгснээр нярай нь хүн болж эхлэдэг.

Таны хүүхэд арайхан таны хүүхэд биш. Ямар сүнс түүнд шингэснээс шалтгаална.

Хүн сүнсний хөгжлөө тэгээс эхлэдэг. Яагаад? Өмнөх соёл иргэншил болох атлантчууд Ертөнцийн мэдээллийн оронд (Нөгөө ертөнц) нэгдэн олж авсан



Үхэл



Самади

мэдээллээ зөвхөн сайн үйлст бус мөн муу үйлст зориулж (Е.П.Блаватская. “Нууц бичээс”, 1937, 2-р боть, 378-р хуудас) байснаас манай иргэншлийн хүний сүнс биедээ ормогцоо Ертөнцийн мэдээллийн орноос салдаг. Энэ бол “SoHm”-ын өөрөө боловсор гэсэн зарчмын илрэл юм. Орчин үеийн хүний сүнс зөвхөн урд төрлийнхөө үйлийн үрийг тээж ирдэг. Гайхамшигт хүүхдүүд төрөх нь Ертөнцийн мэдээллийн орноос бүрмөсөн салаагүй сүнс өнөөгийн хүүхдийн биед орж буй үзэгдэл мөн. Өөрөөр хэлбэл ямар нэгэн хэмжээнд “SoHm”-ын зарчмыг зөрчиж буй явдал.

**Үхэх үед** хүний биеийг хамгийн түрүүлээд сүнс орхиж явсан ч 40 хоног орчим биетэйгээ холбоотой байдаг. Энэ холбоог “мөнгөн утас” гэдэг ба энэ холбоогоор сүнс эргэн биеэ олох боломжтой. “Мөнгөн утас” гэдэг нь Дээд Оюун Ухааны сүнсэд эргэн биедээ орох найдвар олгох зарчим юм. Гүн нойрны үед хүний сүнс нь “зугаалж” явдаг ба биетэйгээ “мөнгөн утас”-аар холбоотой байдаг. Тийм учраас хүнийг гэнэт сэрээж болохгүй. Учир нь сүнс биедээ эргэн ирж амжихгүй төөрнө. Иймээс унтаж буй хүүхдийг сэрээхийг цээрлэдэг.

Үхсэнээс хойш 3 хоногийн дараа сүнсний эфир бие явж, 9 хоногийн дараа астрал бие нь явдаг. Сүнс эргэн ирвэл бие дахин амь орно. Сүнсний торсын орныг эргүүлдэг тархи сүнсгүй бол ажиллахгүй. Биеийг, тэр тусмаа тархийг +4 хэмийн дулаанд хадгалах боломжтой. Агүй +4 хэмийн дулаантай байдаг. Энэ температурт ус нь илүү нягт болдог.

**Самадийн үед** бие сүнс хоёрыг холбодог “мөнгөн утас” хэдэн мянга хэдэн сая жилээр хадгалагдах боломжтой.


Самадийн үргэлжлэх хугацаа нь зөвхөн биеийн байдлаас шалтгаалахгүй. Бас Дээд Оюун Ухаан “мөнгөн утас”-ыг хадгалах эсэхээс шалтгаална.

Агуй болон усан дотор +4 хэмийн дулаантай үед урт хугацааны гүн самадид орж болно. Биеийн чулуун хөшингө байдал эс эдийн усны нягтаас шалтгаалдаг. Үүнд зөвхөн усны нягтарших дулаан төдийгүй усны өөр нэг төлөвт шилжих хэм маш их үүрэг гүйцэтгэнэ. Ус хатуу, шингэн, хий гэсэн гурван төлөв байдалтай. Валентина Яковлевагийн үзэж байгаагаар самадийн үед ус нь одоогоор шинжлэх ухаанд мэдэгдээгүй байгаа нэгэн шинэ төлөв байдалд ордог бололтой. Чухам эдийн усны энэ дөрөв дэх төлөв байдал л бодисын солилцооны үйл явцыг зогсоож хүний эдийг гэмтээлгүйгээр хатуу төлөв байдалд оруулдаг. Бясалгалын хүчээр сүнсний эерэг чиглэлд эргэсэн торсын орон зай нь биеийн шингэнийг ийм төлөв байдалд оруулснаар усны дөрөв дэх төлөв байдалд орсон болон үүнтэй холбоотойгоор биеийн бодисын солилцоо зогссоныг илэрхийлсэн мэдээлэл дамждаг.

Ус хэрхэн мэдээлэл дамжуулдаг вэ? Энэ талаар маш олон янзын таамаг байна. Мэдээлэл дамжуулах маш өвөрмөц зам байдаг байх. Ертөнц ихэнхдээ устөрөгчөөс тогтдог. Ертөнцийн Мэдээллийн Орон долгионы шинж чанартай бөгөөд мөн л уснаас тогтдог бололтой. Иймээс усны мэдээллийг устөрөгчийн тусламжтайгаар дамжуулдаг гэж үзэж болно. Торсын орон ч мөн усан дахь устөрөгчөөр дамжуулан нөлөөлдөг байх.

**Сүнс шилжих үед** илүү сул дорой нэг нь хөөгдөж, оронд нь илүү хүчтэй нь шингэдэг.

- Ноён Мин, би танаас нэгэн зүйлийг лавлах гэсэн юм,- гэж би хэлээд,- Амьтад самадид орж чадах уу? Эргэн амьдарч удмаа үргэлжлүүлэх боломжийг зөвхөн хүнд л олгоогүй байлтай. Самади бол байгалийн төрөл зүйлийг хадгалан үлдээх чухал арга байх ёстой гэж би үзэж байна. Тэгвэл Сибирт жилийн 7-8 сар ичдэг хүрэн баавгайн ичээг өөрөөр тайлбарлаж болох уу? Баавгай самади маягийн байдалд орж бодисын солилцоогоо бууруулж чаддаг байх аа? Иймэрхүү маягаар зурам, могой, мэлхий зэрэг амьтан ч ичдэг.




Сүнс шилжих

- Учир нь,- гэж ноён Мин хариулаад, -хүйтний улирал эхлэхээр амьтад зовж шаналдаг. Гэтэл бидний мэдэж байгаагаар самади маягийн байдалд ороход сэтгэлийн сөрөг энергээсээ чөлөөлөгдсөн байх ёстой. Зовлон шаналал нь сөрөг энергээс ангижруулдаг. Үүнд дан ганц зовлон үүрэг гүйцэтгэж байгаа юм биш. Амьтад ч гэсэн “билгийн нүд”-тэй бөгөөд түүнийхээ тусламжтайгаар хүйтэн болох үед бясалгалын журмаар анхаарлаа төвлөрүүлж самадид ордог буюу бодисын солилцоогоо багасган ичдэг. Жишээ нь анхаарлаа төвлөрүүлж чулуужин хөшсөн байдалд орж амждаггүй учраас могойг зун хүйтэн газар байлгавал үхнэ. Учир нь Байгалийн хүйтрэлийн үед могой нүхэндээ орон нуугдаж, маш удаан хугацааны туршид анхаарлаа төвлөрүүлсний эцэст бүтэн өвлийг давахаар самади маягийн байдалд ордог.

- Амьтны “билгийн нүд”-ний хөгжил хэр зэрэг вэ?

- Амьтдын “билгийн нүд” хангалттай хөгжилтэй . Үүний илрэл нь амьтан, ургамлын хэл юм. Жишээ нь ургамал аюулыг мэдрэх чадвартай байдаг. Сүх барьсан хүний бараанаар мод хариу үйлчилгээ үзүүлдэг. Бясалгалыг эзэмшсэн хүн амьтан, ургамлын хэлийг ойлгож сурдаг. Энэ тохиолдолд хүн зэрлэг араатны



*Н.К. Рерих «Бид айхгүй байна»*

дунд ч аюулгүйгээ мэдэрдэг. Энэ санааг Николай Рерихийн “Бид айхгүй байна.” гэдэг хоёр ламыг нэг баавгайтай цуг дүрсэлсэн зураг илэрхийлдэг.

- Таны бодлоор бол, - хэмээн би асуугаад,- орчин үеийн хүнд юу дутагдаж байна вэ?

- “Билгийн нүд”...

Гуравдугаар хэсэг

**“Билгийн нүд”-ний тухай  
дахин нэг ярихад**

Нэгэн үдэш Валерий Лобанков, Валентина Яковлева, Венер Гафаров, Сергей Селиверстов бид нар Катманду хотоор зугаалахаар гарав. Бидэнтэй цуг Балбад амарч байсан “шинэ орос” нэгэн залуу явсан юм. Гайгүй халчихсан “шинэ орос” бидний эрэл хайгуулын утга учрыг нэлээд сонирхож явав.

- Та нарт сурталчилгаа хэрэгтэй байгааг би ойлгож л байна л даа,- гэж тэр ярин,- тийм ч учраас та нар хоёр долоо хоногийн дараа атлантчууд сууж байгаа агуйг хайж олохоор алсын уулс руу явна. Тэд чинь сууж л байг л дээ. Та нарт ямар хамаатай юм бэ... Хичнээн багаж хэрэгсэл авснаа хараач. Тэгээд бүгд импортынх шүү! Хэн ивээн тэтгэсэн юм бэ дээ? Өөрсдийнхөө мах цусаар олж аваа юу? Та нарт тэгээд энэ сурталчилгаа чинь ямар хэрэгтэй юм бэ? Сайндаа л Мул-да-шев, Ло-бан-ков гэж ганц хоёр хашгирцгаана биз... Тэгээд юу гэж? Өнөөдрөөр л амьдрах хэрэгтэй ш дээ залуусаа, өнөөд-рөө-рөө... Би л гэхэд энд амрахаар ирсэн. Энэ амралтаа ч өөрөө хөдөлмөрөөрөө олж авсан... Та нар наймаа огт сонирхдоггүй гэх нь үү? Эндхийн энэ хямдхан чулуунуудыг сонирхдоггүй гэх нь үү? Битгий зал! Би бол шууд л, би энэ наймааг сонирхдог гэдгээ хэлчихье! Би энд зүгээр л амрах гэж ирсэн гэж бодож байна уу? Канарын арлууд, Испани хаачсан хэрэг вэ тэгвэл.....?

- Чи нэг л юм ойлгохгүй байна,- гэж Валера Лобанков тэвчээртэй нь аргагүй тайлбарлан, - шинжлэх ухаан гэдэг чинь их сонирхолтой эд. Бид чинь эрдэмтэд. Ойлгож байна уу, эрдэмтэд...шинжлэх ухааны мөн чанарыг эрж олох маш хэцүү. Заримдаа мөнгө байтугай бүх амьдралаа зориулах хэрэг гардаг... Бид энд хүн

төрөлхтөн мөхсөн тохиолдолд хүн төрөлхтнийг эргэн сэргээх зорилготой генийн сан гэж байдгийг мэдэж авлаа...

- Та нар бодь сэтгэлтэнүүд гэж өөрсдийгөө хэлэх гээд байна уу? – гэж “шинэ орос” хэлээд, - залуусаа өнөөдрөөрөө амьдрах хэрэгтэй ш дээ, өнөөд-рөө-рөө... Хүүхдүүдээ бодох хэрэгтэй, хүүхдүүдээ. Тэдэнд чинь суурь хэрэгтэй, суурь. Валера чи л гэхэд...

Энэ чалчаа үгс намайг нэлээд залхаасан тул би толгой сэгсрэн тэднээс зайдуухан явж байлаа. Миний өмнө европ дүр төрхтэй гурван бүсгүй гарч ирэхэд нь эгцлэн ширтвэл... Бүгдийнх нь духан дээр жинхэнэ сормуус, зовхитой “гурав дахь нүд” зураастай байлаа.

- Hello, Та нар “гурав дахь нүднийхээ” сормуусыг нь будахаа мартчихсан байна ш дээ, - гэж намайг хэлтэл хүүхнүүд саатаж яриа өрнөв. Тэд Израилиас ирсэн. Бүгдээрээ Израилийн армид алба хаачихаад, одоо амралтын эрх аван Балбад ирчихээд байгаа нь энэ байв. Тэд англиар муугүй ярьж байлаа.

- Зүгээр л юм, - гэж “шинэ орос” тэднийг оросоор ойлгодоггүй гэж бодсон юм уу хэлээд, - Эрнст, наадуулын чинь хэн нь ч оросоос дүрвээгүй юу?

- Би асуув. Тэдний хоёр нь баруун европын уугуул, нэг нь израилийн уугуул байв.



*Израиль бүсгүйчүүл*

-Харамсмаар л юм байна. Тэрнээс биш би араас нь нэг яваад үздэг юм уу гэсэн юм,- гэж “Yes, No”-ийн түвшинд англи хэлтэй хирнээ олон улсын бизнес хийдэг “шинэ орос” хэлэв.

- Охидуудаа,- гэж би асуугаад,- та нарын духан дээрээ зурсан наад нүд чинь тоглоом болгож зурсан юм уу,

эсвэл өөр ямар нэг утга санаатай юм уу?

Бүсгүйчүүд эндээс холгүй оршдог “Билгийн нүд” хэмээх нэгэн хоолны газар “гурав дахь нүд”-ний зураггүй бол оруулдаггүй юм гэв. “Гурав дахь нүд”- ний зураг зурах будаг байхгүй байсан бид уг ресторанд духан дээрээ нүд зуралгүй оров.

Ресторанд бидний духанд нэг их анхаарал тавьсангүй бүгдийг нь нэг том ширээнд цуг суулгав. Тэр ширээнд санаа нь зовсон байртай инээмсэглэн нэгэн



Ирланд бүсгүй сууж байв. Өөр суудал байхгүй байсан учир бид цуг суухаас аргагүй болов.

- За, танилцацгаая, - гэж Сергей Селиверстов хэлээд шинжилгээний зорилтоо онцгойлж тэмдэглэн бид бүгдийг танилцуулав. Мөн “шинэ орос”-ийг оросын томоохон бизнесмений нэг хэмээв.

- Өө,- гэж Ирланд бүсгүй дуу алдаад,- та нар өмнөх соёл иргэншлүүдийг судалж байгаа юм байна шүү дээ. Манай оронд маш олон хүн энэ асуудлыг сонирхдог. Ихэнх хүмүүс “билгийн нүд”-ээ хөгжүүлэхийн тулд тусгай бясалгалын сургуульд явдаг. Харин би мөнгө цуглуулан, эх дэлхийгээр бясалгал тараасан энэ оронд бясалгал сурахаар ирсэн. Би “билгийн нүд”-ээ хөгжүүлэхээр энд ирсэн. Бүр ийм нэртэй зоогийн газарт хүртэл ордог. Та нар шинжилгээнийхээ тухай арай дэлгэрэнгүй яриач!

- Тэгээч, яриад өгөөч!-гэж израиль бүсгүйчүүд бас гуйв.

Идээ ундааны завсраар бид шинжилгээний ангийнхаа гол гол ололтыг тоочин ярьж өгөв.

- Ямар сонирхолтой юм бэ! – гэж ирланд бүсгүй хэлээд,- Та энэ шинжилгээний ангийн ивээн тэтгэгч нь үү? – гэж тэр “шинэ орос”-оос асуусанд,

- Тийм,- гэж залахаас өөр аргагүй байдалд орсон “шинэ орос” хэлэв.

- Тэгээд таны “билгийн нүд”-ний чинь хөгжил юу болж байна даа гэж би ирланд бүсгүйгээс асуув.

- Нэг их биш дээ гэж тэр хариулав.

- Та нар ер нь “билгийн нүд” гэж юу болохыг мэдэж байна уу? - гэж Венер Гафаров асуув.

- Би мэднэ гээд нэг израиль бүсгүй нүд зураастай байгаа нэг найзынхаа духыг заав.

- Буддын шашин 5 төрлийн нүдийг ялгаж үздэг гэснээр би ярьж эхлэв:

**1. Махан нүд** (fleshly eye) буюу бидний жирийн хоёр нүд.

**2. Зөн совингийн нүд** (divine eye) буюу цаг хугацаа,орон зайд хол хардаг. Өөрөөр хэлбэл энэ нүдний тусламжтайгаар Ертөнцийн Мэдээллийн оронд харж, үүний үр дүнд далдыг харж болдог нүд.

**3. Мэргэн ухааны нүд** (wisdom eye) – сэтгэл доторхоо тольдон харж, дүн шинжилгээ хийж, амьдралын гол учир утга юу болох, хүн бол юуны түрүүнд сүнс болохоос бие биш гэдгээ мэдэрдэг.

**4. Дхаммын нүд** (Dhamma eye) – Буддын сургаалийг биелүүлэхэд тусалдаг нүд. Өөрөөр хэлбэл ойлгоход хүнд Буддын сургаалийг ойлгох чадвар.


**5. Буддын нүд** (Buddha eye) буюу багшийн нүд. Үүнийг өмнөх соёл иргэншлүүдийн мэдлэгт нэвтэрсэн хүний нүд гэж ойлгож болно .

- Тэгэхээр нэг хүнд таван янзын нүд байдаг хэрэг үү гэж Израиль бүсгүйг асуухад нь,

- Миний бодлоор “Буддын шашинд нүд гэдэг ойлголтоор хүн амьдралынхаа сүнсний хэсгийг ойлгож, түүндээ дүн шинжилгээ хийх чадварыг хэлнэ” гэж би хэлэв.

- Будда ямар нүдтэй байсан юм бол израиль бүсгүй шалгаав.

- Төвдийн нэгэн нэрт эрдэмтний хэлснээр бол ганцхан Будда л “билгийн нүд”-тэй байсан. Хүмүүсийн билгийн нүд муу хөгжилтэй. “Билгийн нүд” нь Буддад ч нүд шиг харагддаггүй байсан. Гэхдээ хүмүүс Буддагийн духнаас гарсан гэрлээр түүний нүдийг мэддэг байжээ. Тэрээр энэ гэрлийн туяагаараа тариачдыг сургаалд дууддаг. Буддагийн духнаас гардаг гэрэл нь цагаан, цэнхэр, ногоон, шар ба улаан гэсэн таван өнгөтэй байжээ.



*Сэтгэлийн энергийг гэрлийн энерги болгож буй нь (Будда)*

- Тэр ч ёстой гайхамшигтай харагддаг байсан байх даа гэж Израиль бүсгүй асуув.

Валентина Яковлевагийн орчуулсныг анхааралтай сонсож суусан “шинэ орос”:

- Буддагийн толгой дээр тэгээд гэрлийн үүсгэвэр байсан юм уу?

- Миний бодлоор,- гэж Валерий Лобанков хариулаад, - энэ бол сэтгэлийн энергийг гэрлийн энерги болгож буй үзэгдэл юм. Та нар телекинез гэж сонссон байлгүй. Сэтгэлийн энергийн тусламжтайгаар аягыг ширээн дээрээс хөдөлгөж болдог үзэгдлийг хэлдэг. Энэ нь сэтгэлийн энергийг механик энерги болгож буй үзэгдэл юм. Үүнтэй адилаар сэтгэлийн энергийг гэрлийн энерги болгож болно.

- “Билгийн нүд”-ний тухай дэлгэрэнгүй ярьж өгөөч! Ямар ч байсан би энд тэрнийг хөгжүүлэх гэж ирсэн.

- “Билгийн нүд” бол тархины нэгэн хэсэг, - гэж Валерий Лобанков ярьж эхлээд, - Хэрвээ тархи нь сүнсний торсын талбайг эргүүлэгч нь байдаг бол “билгийн нүд” нь сүнсний янз бүрийн торсын орны төрөл бүрийн давтамжид тааруулагч болдог байна. “Билгийн нүд”-ний үндсэн гурван үүрэг байдагт:

- *Мэдлэгийн үүрэг* буюу энэ нь Дээд Оюун Ухаантай адил давтамжтай таардаг. Гэгээнтнүүд (жишээ нь Елена Блаватская) хөгжил сайтай “гурав дахь нүд”-нийхээ тусламжтайгаар Ертөнцийн Мэдээллийн оронтой давтамжаа тааруулдаг.

- *Бясалгалын үүрэг* буюу сүнснийхээ янз бүрийн түвшинд торсын орны давтамжинд тааруулах үүрэг. 112 янзын бясалгал байдаг нь өөрт таарсан давтамжид тааруулан сонгож байгаа хэрэг юм.

- *Дотоод харааны үүрэг* буюу янз бүрийн эрхтний торсын орны давтамжид тааруулан тэдгээр эрхтнийхээ байдлыг харж болно.

- Хүүхдэд үлдэц эрхтэн болсон байдаг “билгийн нүд” нь түрүүчийн соёл иргэншлийн хүнд маш өндөр хөгжилтэй байсан гуравдагч нүдний дурсгал юм. Атлантчууд харцаараа асар том чулуун хавтанг хөдөлгөдөг байсан тухай эртний ном зохиолыг эргэн сана даа. Үүнийг юу гэж ойлгох вэ? Тэд өөрсдийн гурав дахь нүдний тусламжтайгаар чулуунуудын торсын орны эргэлтийг задлан таталцлын хүчний эсрэг хөдөлгөх торсын орны давтамжтай тааруулж эргүүлдэг байна. Ингэснээр чулуу хөнгөхөн болж, дахин торсын орны эргэлтын чиглэлийг өөрчлөхөд хөдөлдөг байжээ.

- Эрнст, израиль бүсгүйчүүдийг харцаараа шилэн аяга хөдөлгө гэж хэлээч! Тэд чинь “билгийн нүд”-тэй ш дээ, - гэж “шинэ орос” хошигнов.

- “Мэдээж, би харцаараа чулуу хөдөлгөж чадахгүй л дээ. Гэхдээ бясалгалаар хичээллэсний дараа сүнсээ илүү их мэдэрдэг болсон юм шиг байна. Одоо би манай бодит ертөнц хамгийн гол зүйл биш, сүнс гол нь юмаа гэдгийг ойлгодог болсон. Яагаад манай иргэншлийн “гурав дахь нүд” ухарч, хөгжихөө больсон юм бол гэдэг нь надаа их сонин байна?” хэмээн ирланд бүсгүйг сонирхоход, би:

- Та Елена Блаватскаяг уншиж үзсэн үү? –гэж асуув.

- Үгүй, харин энд, Балбад бясалгалын сургуулиуд дээр түүнийг Аугаа Гэгээрсэн Хүн гэж ярьж байсан.

- Гурав дахь нүд хэрхэн хөгжиж хэрхэн хөгжил нь буурсан тухай энэ асуултанд чинь хариулахын тулд хүн төрөлхтний арьстан үндэстний түүхийг мэддэг байх шаардлагатай. Энэ талаарх ном зохиолууд бараг бүгд л адил төстэй юм бичсэн байдаг. Зөвхөн Елена Блаватскаягийн “Нууц бичээс” номонд арай дэлгэрэнгүй бичсэн байдаг. Үндэстэн гэсэн ухагдахууны дор Блаватская хүний үндэстэн ястныг бус харин хүн төрөлхтний соёл иргэншлийг хэлсэн байдаг. Жишээлбэл эхний үндэстэн гэдэг нь дэлхий дээрх эхний соёл иргэншил юм. Мөн уг номондоо Блаватская түүнд ямар нэгэн дуу хоолой энэ бүх мэдээ баримтыг хэлж өгөн бичүүлдэг байсан гэж бичсэн байдаг. Дээд Оюун Ухаан түүгээр дамжуулан хүн

төрөлхтний соёл иргэншлүүдийн түүхийг өнөөгийн хүн төрөлхтөнд хүргэхээр зорьсон гэдэгт тэр огтхон ч эргэлздэггүй байжээ. Түүний бичсэн зүйлс бусад шашны ном, сударт болон шинжлэх ухааны бүтээлүүдэд бичсэнтэй тохирч байгаа учраас түүнд итгэхгүй байх үндэсгүй юм. Энэ бол дэлхий дээрх хамгийн том суурь бүтээл юм. Ингээд Блаватская манай иргэншлээс өмнө дөрвөн соёл иргэншил байсан бөгөөд манай соёл иргэншил бол тав дахь нь юм...

- Уучлаарай, манай ресторан хаах цаг боллоо гэж дөхөж ирсэн үйлчлэгч хэлэв.

- Ямар азгүй юм бэ? – гэж ирланд бүсгүй хэлэв.

- Санаа бүү зов,- гэж “шинэ орос” түүнийг тайвшруулаад үйлчлэгчид 20 ногоон сарвайн, - Валя, бид энд хичнээн л бол хичнээн хугацаагаар байх болно гэдгийг хэлээд үүнийг өгчих! Тэгээд бас хүүхнүүддээ дарс нэмээд авчих. Бид хэнээс үүссэн нь надаа ч гэсэн сонин байна. Би ч бас найзууддаа хүн сармагчнаас үүсээгүй гэж нотолдог юм...

Үйлчлэгч баяртайгаар 20 долларыг аван танхимын нөгөө өнцөгт ёсорхуу нь аргагүй бидний харц бүрийг амдан зогсоно.

- Балба бол ядуу орон. Тэдний хувьд 20 доллар гэдэг нь бүхэл бүтэн хөрөнгө юм.

- Хараач тэр,- гэж “шинэ орос” хэлээд,- 20 доллараар бүхэл бүтэн ресторан худалдан авч болдог байна шүү! Москвад бол энэ мөнгөөр аяга кофе ч авахгүй шүү! Москвагийн үйлчлэгчид ийм үйлчилгээнийхээ төлөө хамгийн багадаа 300 ногоон шаардах байх даа... Тэгсэн чинь энд авч орхидог байна шүү! Орост ийм үйлчилгээтэй болоосой!

- За, тэгэхлээр,- гэж би хэлээд үргэлжлүүлэн,- Е.Блаватскаягийнхаар бол дэлхий дээр хүн төрөлхтний таван үндэстэн байсан бөгөөд манай соёл иргэншил тав дахь нь юм. Материйн нягтаршлын аргаар олон сая жилийн өмнө амьдрал үүссэн. Хүн, өвс ургамал, ан амьтан бүгд нэгэн зэрэг үүссэн. Үндэстэн болгон өмнөх үндэстнээсээ үүссэн.

**Хүн төрөлхтний эхний үндэстэн** бол “өөрөө төрөгсөд” гэдэг нэртэй байсан ба нарийн ертөнц буюу сэтгэлийн энерги нягтарших аргаар дэлхий дээр үүссэн эфирэн биетэй хүмүүс байсан. Тэд хана туурга зэрэг хатуу зүйлсийг нэвтрэн гарч чаддаг сүнс маягийн хүмүүс байсан байна. 40-50 метр өндөртэй хэлбэр галбиргүй сарны гэрэл мэт харагддаг байжээ. Тэдний анхдагч сийвэн нь өнөөгийн бидний биенээс маш их ялгаатай долгионы шинж чанартай байсан. Тэд духандаа ганц нүдтэй. Нүдний үүргийг “билгийн нүд” маягийн бүтэц гүйцэтгэдэг байсан нь орчин тойрныхонтойгоо болон Дээд Оюун Ухаантай телепат холбоотой байжээ. Анхны иргэншлийн хүмүүс хуваагдаж бас нахиалж үрждэг байсан байна. Харилцааны хэл яриа гэж байгаагүй бөгөөд тэд хоорондоо “бодлоо дамжуулах” зарчмаар харьцдаг байжээ. Ямар ч хэмийн дулаанд амьдрах чадвартай байсан байна.

**Хүн төрөлхтний 2 дахь үндэстэн** болох “хожуу төрөгсөд” буюу “ясгүй хүмүүс” нь эхний үндэстний дараа үүссэн байна. Энэ хүмүүс мөн л сүнс маягийн байсан ч түрүүчийн иргэншлийн хүмүүсийг бодвол арай нягт биетэй байжээ. Нэг нүдтэй байсан ба өндрөөрөө эхнийхээсээ намхан буюу 30-40 метр хүрдэг байжээ. Нахиалж спор үүсгэн үрждэг алтан шаргал өнгөтэй байсан. 2-р соёл иргэншлийн сүүл үед завсрын хос бэлэгтэн буюу эр эм бэлэг нэгэн биед оршдог хүмүүс үүсч эхэлжээ.

**Хүн төрөлхтний 3 дахь үндэстэн** болох, “ясгүйчүүдийн” дараа үүссэн “Лемурчууд”-ыг эртний болон хожуу үеийн лемур гэж ангилна.

Эртний лемур нь 20 метр өндөртэй сүнс маягийн биетэй гэж хэлэхээргүй төрхтэй болсон байлаа. Тэд ясжиж эхэлсэн байна. Хос бэлэгтнүүдэд зарим тохиолдолд эр шинж тэмдэг давамгайлдаг болсноор хүйсний ялгаа гарч бэлгийн үржил үүссэн байна. Эртний лемурчууд 2 нүүртэй, 4 гартай байсан. 2 нүд нь урд талдаа “3 дахь нүд” нь ардаа буюу 2 нүүртэй мэт байжээ. 2 гар нь биенийхээ урд хэсэгт үйлчилдэг. Нөгөө 2 гар нь ард хэсэгтээ үйлчилдэг байжээ. Урд талын хос нүд нь бодит харааны үүргийг гүйцэтгэж ард талын нэг нүд нь сэтгэлийн харааны үүргийг гүйцэтгэдэг байжээ. Тэд алтан шаргал өнгөтэй байсан ба “бодол санаагаа дамжуулах” аргаар харилцдаг байсан. Хожуу үеийн лемурчууд буюу лемур-атлантчууд бие сэтгэхүйн өндөр хөгжилтэй байсан бөгөөд технологийн асар өндөр түвшинд хүрсэн байв. Тэдний амжилт, бүтээлүүдэд Египетийн сфинкс, Солусбергийн аврага нуранги (Их Британи), Өмнөд Америкийн зарим нэгэн хөшөө орно. Хожуу үеийн лемурчууд 7-8 метрийн өндөртэй 2 нүдтэй, 2 гартай байв. “3 дахь нүд” нь гавал дотор орсон байна. Шар болон улаан өнгийн арьстай байжээ. Дэлхийн бөмбөрцгийн зүүн өмнөд хэсгийн ард түмний хэл ярианд одоо ч хэрэглэгдсээр байгаа нэгэн хэлийг тэднээс үүсэлтэй гэдэг. Эрт үеэс тусгаарлагдсан Австрали тив дээр амьдран зэрлэгших чиглэл рүүгээ хөгжсөн Австралийн хавтгай



4 гартай 2 нүүртэй хүний зураг

толгойт аборигенчуудыг Е.Блаватская хожуу үеийн лемурчуудын үр сад гэж үзсэн байна.

**Хүн төрөлхтний 4 дэх үндэстнийг** Атлантчууд гэдэг байсан ба урдаа 2 нүдтэй, 3 дахь нүд нь гавлын дотор гүн шигдсэн ч үйл ажиллагаагаа маш сайн явуулдаг байжээ. Тэд 2 гартай 3-4 метрийн өндөртэй байсан ч уг соёл иргэншлийн сүүлийн хэсэгт бие нь жижгэрч эхэлсэн байна. Атлантчуудын зарим нь улаан, зарим нь шар, зарим нь хүрэн, зарим нь хар өнгөтэй байжээ.

Уг соёл иргэншлийн сүүлийн хэсэгт хар болон шар атлантчууд дийлэнх нь болсон бөгөөд байнга хоорондоо байлддаг байжээ. Эхэндээ атлантчууд өнөөгийн өмнөд америкийн зэрлэг омгуудын хэлэнд хадгалагдан үлдсэн бүдүүлэг хэлтэй байсан ба сүүл үе рүүгээ тэдний хэл нь орчин үеийн олон хэлний үндэс нь болсон өндөр хөгжилтэй хэлтэй болжээ. Уг өндөр хөгжсөн хэл нь өнөөгийн гэгээнтнүүдийн нууц хэл болсон санскрит хэлний суурь аж.

Атлантчуудын соёл иргэншил нь ч бас хангалттай өндөр хөгжилтэй соёл иргэншил байсан байна. Тэд Ертөнцийн Мэдээллийн оронд нэвтрэх замаар мэдлэг олж авдаг ба таталцлын хүчинд нөлөөлж, ховсын ухааныг эзэмшин, өөрсдийн гэсэн нисдэг тавагтай (вимана) байсан бөгөөд тэд Пасхийн арлууд дээрхи чулуун хөшөө, египетийн пирамид болон бусад олон оньсогот хөшөө дурсгалын зүйлсийг бүтээжээ.

Хүн төрөлхтний тав дахь соёл иргэншил буюу нууцлаг ухааны ном зохиолд (эзотерическая литература) арийн үндэстэн гэж илэрхийлдэг манай соёл иргэншил нь хожуу үеийн атлантчуудын үед үүсч эхэлсэн байна. Аричуудын ихэнх нь зэрлэгшин өөрсдийн хөгжилдөө атлантчуудын мэдлэгийг ашиглаж чадаагүй байна. Эхэндээ тав дахь соёл иргэншлийн хүмүүс 2-3 метрийн өндөр биетэй байсан ч яваандаа жижгэрчээ. “Гурав дахь нүд”-ний үүрэг бүрмөсөн алга болсноор Ертөнцийн Мэдээллийн Оронтой холбоо тасарсан тул тэндээс авах мэдлэгийг ашиглах боломжгүй болжээ. Аажимдаа тав дахь соёл иргэншлийн хүн орчин үеийн хүний дүр төрхийг олсон байна.

- Сонин л юм, гэхдээ төвөгтэй юм аа,- гэж “шинэ орос” хэлээд,- “Гурав дахь нүд”-ээрээ дахиад захиалах хэрэгтэй гэж мэдэрч байна. Валя, дахиад дуудаач...

- Ийм маягаар эхний хоёр үндэстнүүд ,- гээд би үргэлжлүүлэн,- ганц нүдтэй буюу “гурав дахь нүд”-тэй байж, амьдралдаа зөвхөн түүнийг ашигладаг байжээ. Гурав дахь иргэншил (хоёр нүүртэн) нь “билгийн нүд”-нээсээ гадна бас урд талдаа хоёр махан нүдтэй болсон ба үүгээрээ бодит ертөнцийг харан “гуравдагч нүд”-нийхээ туслахаар ашигладаг байсан. Дөрөв дэх иргэншилд (атлантын) “гуравдагч нүд” нь гавлын дотор орсон боловч үүргээ алдаагүй байна. Тав дахь иргэншилд (манай) энэ эрхтэн нь үлдэц болон үлдсэн ба гавлын дотор боргоцой хэлбэрийн булчирхай болон хувирчээ. Гэхдээ (Е.Блаватскаягийн таамагласнаар) манай иргэншилд “билгийн нүд”-ээ дахин хөгжүүлэх хандлага гарна. Атлантчууд ч мөн адил “гуравдагч нүд”-нийхээ хөгжлийг ухарч байгааг анзаармагцаа үйл



ажиллагааг нь хиймлээр идэвхжүүлэхийг оролддог байжээ. Манай үед ч гэсэн “гурав дахь нүд”-ний үйл ажиллагааг хөгжүүлэх зорилготой бясалгалын сургуулиуд бий болж байна. Жишээ нь “гуравдагч нүд”-нийхээ үйл ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд энд ирсэн та байна - гэж би ирланд хүүхэнд хандан хэлэв.

- Би дэлхий нийтийн тэргүүнд алхаж яваагаараа бахархаж байна гэж ирланд бүсгүй хариулав.

- Бүсгүйчүүд уйдаад байна, - гэж “шинэ орос” израиль хүүхнүүдийн нэг рүү дохин хэлээд, - Хөгжөөхийн тулд өөр сэдвээр юм ярьж өгөхийг зөвшөөрнө үү... Саяхан манай Орос залуучууд энд, Катмандуд дугуйт тэрэгчдийн уралдаан зохиосон юм. Эрнст орчуул даа... Төсөөл дөө, манай залуучууд чинь том биетэй, тэргэнд нь суухад жижигхэн биетэй балбачууд дугуйгаа байдаг хурдаараа жийн, гүрийж байна

гэж... Маш их сонирхолтой байсан шүү! Миний найз Витя түрүүлсэн. Дугуйт тэрэгчдийг өрөвдөж л байна л даа. Гэхдээ бид тэдэнд зүүдэнд нь ч оромгүй хөлс төлсөн л дөө.

- Тэрэгчид өрөвдмөөр юм гэж израиль бүсгүйчүүдийн нэг нь хэлэхэд Венер Гафаров,

- Тэднийг өрөвдөөд хэрэггүй. Мэд чинь зүсэм талхныхаа мөнгийг олох хэрэгтэй. Бардам зан тэдэнд огт ч хэрэггүй.

- Бардам зан гэснээс, - гэж би хэлээд, - Е. Блаватская хүмүүс өөрсдийгөө бараг л бурхан мэт санан бардамнаснаар “гуравдагч нүд” нь ажиллагаагүй болж, Ертөнцийн Мэдээллийн Орноос тэднийг салгасан гэж бичсэн байдаг.

- Гавал дотор байдаг атал “гурав дахь нүд”-ийг яагаад нүд гэдэг юм бэгэж ирланд бүсгүй асуув.

- Бүтэц судлаачид хүний үр хөврөлийн хөгжлийн явцад “гурав дахь нүд”-ний хөгжил нь нүдний хөгжлийн адилаар явагддаг гэдэг. Эхний соёл иргэншлүүд цорын ганц “ гурав дахь нүдтэй” байсан болохоор ингэх нь ч ойлгомжтой.

Е.Блаватская ч мөн ийм зүйл хэлсэн байдаг. Хүний оюун ухаан хэдий хэр хөгжсөн байна боргоцой хэлбэрийн булчирхай буюу “гуравдагч нүд” нь төдий чинээ хөгжилтэй байна.

- Гайхалтай энэ оройг бэлэглэсэнд баярлалаа. “Билгийн нүд” ресторанд билгийн нүдний талаар их юм мэдэж авлаа гэж ирланд бүсгүй хэлэв.

“Шинэ орос” мөнгө гаргахаар халаасаа ухсан хүн болгониог эрс шийдэмгий хөдөлгөөнөөр зогсоогоод бүх хүний өмнөөс тооцоо хийн, үйлчлэгчид ч мөн цайны мөнгө өгөхөө мартсангүй.

- За, тэгээд сонирхолтой байв уу?- гэж “шинэ орос”-оос Сергей Селивестров асуугаад,- Амьдралд өөрөөсөө хойш ямар нэгэн юм үлдээх хэрэгтэй л дээ. Зөвхөн мөнгө, машин байшин ч биш, харин ямар нэгэн сэтгэлийн юм үлдээх хэрэгтэй. Хүүхдийн боргоцой хэлбэрийн булчирхай нь илүү хөгжилтэй байдаг учир тэд сэтгэл оюуны үйлийг маш сайн мэдэрдэг. Тийм учраас эцэг эхчүүдийн сэтгэл санааны байдал нь...

- “Би наадхыг чинь ойлгож байна. Үнэхээр ч хүүхдүүддээ зөвхөн байшин, машин үлдээгээд зогсохгүй эцэг эхийнхээ сэтгэл оюуны хөгжлөөр бахархдаг болгох хэрэгтэй. Нээрээ мартсанаас, Сергей, рестораныг бүтэн шөнийн тал 20-хон доллараар барьж болдог байна шүү!” гэж “шинэ орос” шогшров.



Дөрөвдүгээр хэсэг

## Дараагийн удаа арай нухацтай хандах болно

“Шинэ орос” хэмээгдэгчид нь коммунист үзлээсээ салаагүй уран сэтгэмжит улс төрчид маань зах зээлийн эдийн засгийн хамгийн доод түвшин болох “зэрлэг зах зээл”-ийг үүсгэн азгүй шилжилт хийсний доожоогүй үр дагавар юм. Энэ үед улс үндэстний дээд зэргийн төлөөлөгчид бус, харин гэмт хэргийн сэтгэхүйтэй, соёлын түвшнээр доогуур, зэрлэг, нийгмийн амьдралд дасан зохицсон нэг нь улс орны нүүр царайг илтгэнэ. Жишээ нь шууд хэлэхэд өнөөгийн нийгэмд ямар нэгэн асуудлыг шийдэхийн тулд гарцаагүй шаардлагатай байдаг авилгал өгч, авалцах нь өндөр боловсролтой соёлч хүнд маш хүнд байхад энэ нь шинэ оросын ухамсартай арцалдахгүй зүйл учир “шинэ орос” үүнийг энгийн нэгэн байх ёстой зүйл мэт үзэн тоох ч үгүй хийдэг. Энэ тохиолдолд мэдээж “шинэ орос” илүү ашигтай байдалд очих ба харин соёлч хүн маань хоногоо гүйцтэл үнэнийг эрэн эргэлдсээр байх болно.



Хэрвээ нэр төр, сайхан сэтгэл, энэрэнгүй үзэл, ухамсар зэрэг зүйл сэтгэлийг нь зовоодоггүй хүмүүсээр удирдуулсан нийгэмд бүдүүлэг нийгмийн хууль удаан үйлчлэх юм бол үндэстний зэрлэгшил явагдаж эхэлнэ. Би урьд өмнө хэзээ ч “зэрлэгшил” гэдэг ухагдахууныг түүх, улс төрийн талаас бодож үзэж

байгаагүй. Гэвч судалгааныхаа эцэст бид хөгжлийн эсрэг ухагдахуун болох зэрлэгшил нь зөвхөн манай соёл иргэншлээр зогсохгүй өмнөх иргэншлүүдийн үед ч мөн нэг бус удаа давтагдаж байсныг мэдсэн юм. Гэхдээ энэ тухай бид номныхоо төгсгөлд бичих болно. Одоохондоо “шинэ орос”-ууд манай ирээдүйн зэрлэг орны (бүү үзэгд!) анхны зэрлэгүүд биш байгаасай л гэж хэлмээр байна.

Хилийн чанадад Орос орны нэр төр хуучны цэргийн сүр хүчээ алдсанаас бус, манай удирдагчдын таагүй царай зүснээс ч бус, харин хилийн цаана манай улсыг дээр дурдсан “шинэ оросууд” төлөөлөх болсноос огцом унасан юм. Дуунаас хурдан онгоц нээсэн, сансрыг эзэмшсэн, дэлхийд дээгүүрт орох боловсролын тогтолцоог бий болгосон зэрэгтэй энэ “шинэ оросууд” огт авцалдаж өгөхгүй л байна даа. Гэхдээ хүн улс орны түүхэн ололт амжилтын талаар огт бодолгүйгээр тэр улсын төлөөлөгчтэй хийсэн агшин зуурын уулзалтаар энэ улсын талаар дүгнэлт хийж болохгүй л дээ.

Дээрх “Оросын алдарт төлөөлөгчид” алс холын Балбад хийж буй шинжилгээний ажилд маань ямар нэгэн хэмжээгээр нөлөөлнө гэж бид төсөөлсөн ч үгүй. Учир нь өвөрмөц хурдтайгаар баяжсан тэдэнд мөн л өвөрмөц хурдтайгаар сэтгэлээ хөгжүүлэх санаа төрдөг хэрэг. Тэгээд л энэ залуучууд худал үнэн хэлэн, Катмандугийн сүмүүдийн тэргүүлэгч лам нартай уулзаж, чанга чанга ярин инээлдэж, тэврэлдэн зургаа авахуулна. Маш гайхмашигтай! Бүр өөрийн биеэр ламтай цуг шүү! Залуус ч ёстой нэг атаархана даа!

Ер нь бол сүсэг бишрэлийн ойлгомжгүй талыг сонирхож байгаа нь магтууштайн дээр зураг авахуулах нь ч гэсэн буруу хэрэг биш боловч өөртөө итгэл төгс нэгэн гадаад эр ламыг багынхаа хамыг мөрөн дээр нь алгадаж буй мэтээр алгадан, бас ч үгүй “булцгархан юм гээч!” гэж үглэх харьцаа нь миний бодлоор лам нарт ойлгомжгүй, бас таатай бус байсан болов уу.

Дээр өгүүлсэн явдлын уршгаар хоёр ч том ламтай хийсэн судалгаа-уулзалт маань азгүйтэх дөхсөн шүү. Уг хоёр лам хоёулаа Катмандугийн буддын томоохон сүмүүдийг тэргүүлдэг байсан ба эдгээр сүмэд манай “төрөл” лав очсон байлгүй. Манай шинжилгээний анги олон улсын шинжтэй ч түүний онцлох бүрэлдэхүүн нь оросууд байлаа. Бид ч үүнийгээ нуудагүй байв. Лам нартай уулзаж сайн ярилцах нь бидний хувьд зайлшгүй чухал байв! Зөвхөн лам нар л “нууц” мэдлэгээ дэлгэх үгүйгээ шийдэх эрхтэй. Лам нар л эртний хүмүүсийн нууцад нэвтэрсэн хүмүүс. Зөвхөн лам нар урт хугацааны гүн самадийн байдлаар хадгалагдах хүний Генийн сангийн тухай бодит баримтыг хэлж өгч чадах байв. Өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг тодруулж чадах самадид буй атлантчуудын биед хүрэх замыг мэддэг хүмүүсийг лам нар л зааж өгч чадна.

Ер нь лам нарыг итгүүлэх бүх үндэслэл бидэнд байсан юм. Бидний тооцоолсон атлантын дүр төрх өмнөх иргэншлийн хүмүүсийн талаарх энэтхэгийн хамба нарын төсөөлөлтэй үндсэндээ таарч байсан. Хамба лам нар болон

эрдэмтэдээс олж авсан мэдээлэл нарийн уялдаа холбоотой гинжин хэлхээ болон жагсаж байсан. Бидний нутаг нэгтнүүдийн найзан дундаа харьцаа бидний хамгаас их болгоомжилж байсан таглаас, бул чулуу болсон гэдэгт итгэхэд ч бэрх байлаа.

Шесканд Ариэль Балбын их сургуулийн захирлаар дамжуулан Ринбучи ламтай уулзахаар тохирч, судалгааны зарим нэгэн материалыг урьдчилан илгээсэн байлаа. Ринбучи лам биднийг сурагч, дагалдагсдын хамт болзсон цагтаа хүлээн авав. Герман, дани, америк зэрэг үндэстний 20-30 дагалдагсдын дунд байлаа. Бүгд шалан дээр суун, зарим нь нүдээ анин, зарим нь амандаа юм шивнэн, зарим нь дуугүй, тасралтгүй багшийгаа ажин зарим нь сониучирхан биднийг харна. Эд бүх насаа Дорнын шашныг судлахад зориулж, энд маш олон жил амьдарч буй хүмүүс бөгөөд бүгд Балба хэлээр ярьцгааж байсан.



*Ренбучи лам шавь нартайгаа*

Биднийг ламын өмнөх зөөлөн дэрэн дээр суулгав. Миний хажууд шаргал үстэй Дани эр сууж өөрийгөө Бонпо ламын орчуулагч нь гэж танилцуулав. Лам англиар маш сайн ярьдаг нь мэдрэгдэж байсан ч тэрээр яагаад ч юм бэ орчуулагчаар дамжуулан бидэнтэй харьцах болсон юм. Англиар нэлээд муухан ярьдаг дани эр балбаар бүр ч муу ярьдгийг балба хэл мэдэхгүй би хүртэл мэдэрч байлаа.

Хүний үүслийн талаарх таамгаа дэвшүүлэхдээ би ойлгомжтой болгохын тулд англиар ярьсан яриагаа хамгийн энгийн түвшинд хүргэн тайлбарлах нь маш эвгүй, дарамттайг мэдэрч суулаа. Лам миний яриаг хагас дутуу сонсож, дани

эрийн орчуулгыг бүр огтхон ч сонирхохгүй байлаа. Тэрээр байнга хүмүүст аравнайлсан хадаг хүзүүнд нь уяж өгч, ариулсан идээгээр дайлж байлаа. Дани эр чихэн дээр балбаар бувтнан, байнга мөрнөөс минь угзчин үгээ давтахыг хүсэхэд би дуртай дургүй арай хүнд англи үгийг сонгож байлаа.

Эцэст нь энэ болгоноос залхаад би атлантын зургийг ламд үзүүлэн шууд:

- Ийм дүр төрхтэй хүнийг та ер нь харж байсан уу?

- Хүний гадаад дүр төрх гэдэг бол түүний сэтгэлийн бодит тусгал юм, - гэж англиар гэнэт сайн ярьдаг болсон лам өгүүлээд,- Хүний дүр төрхийн гол толь нь болсон нүдэнд хүний мэргэн оюун илэрдэг. Буддизмын “мэргэн оюуны нүд” гэдэг нь



*Дани эр*

хоёр талтай байдаг: мэдрэмжийг дэмжих болон шинжилгээний үед харах ухамсарлах ба мэдрэмжийн эрхтэний уялдаа холбоог тооцож үзэх ёстой....

- Уучлаарай,- гээд үнэн хэрэгтээ бидний анхаарлыг үгийн цуглуулганд хандуулах гэж байгааг ойлгон, зүүн чихний дэргэд дани эр бувтнахаа больсоноор бардам зангаа тайвшруулан,- энэ зураг чинь танай Сваямбунатхын сүм дээр дүрслэгдсэн нүдний зургаар үүсгэсэн хүний төрх шүү дээ. Валерий Лобанков чухам энэ сүмийн хананаас авсан зурганд хийсэн офтальмоматематикийн шинжилгээгээр энэ нүдний эзний дүр төрхийг гаргасан юм. Энэ хэний нүд болохыг хэлээд өгөөч?

- Энэ бол мэргэн ухааны нүд,- гэж лам үргэлжлүүлэн,- Нүдний илэрхийлэх ёстой бүхнийг, зорилго, хатуу хүсэл эрмэлзлийг илэрхийлж байна. Гадаад хэлбэр нь мэргэн ухаан болох чанарыг бүх юманд олж харах хэрэгтэй гэж Будда сургадаг юм.

Би золтой л “Мэргэн ухааны нүд гэж юу юм бэ?” гээд асуучихсангүй, араас



*Сваямбунатх дуган дээрх ер бусын нүд*

нь бид юу ч ойлгохгүй үгээр бөмбөгдүүлнэ гэдгээ ойлгоод цагаа олж зогсов.

-Энэ тэгээд Буддагийн нүд юм уу,- гэж би гэнэхнээр асуув.

-Будда 32 хэмжигдэхүүн 60 чанартай байсны нэг нь түүний нүд нь байсан юм. Зураачид зориуд түүний оюун ухааныг илтгэхийн тулд сүмүүдийн ханан дээр зурсан байна. Мэргэн ухаан нь зөвхөн нүднээс бус мөн зүрхнээс гардаг...- гэж лам хэлэв.

- Та ийм хамрын талаар юу хэлэх вэ гэж би атлантын зургийг заан асуухад,

- Ер бусын хамар нь ер бусын хүчин чадлын илрэл болдог гэж лам хариулав.

- Миний мэдэж байгаагаар бол сэтгэлийн хүч нь нүднээс гардаг...

- Хамраас ч бас.

- Сэтгэлийн хүч нь бодит илрэлтэй байж болох уу, жишээ нь биетийг хөдөлгөх ч юм уу...

- Болно.

- Хамар ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

- Маш том үүрэг гүйцэтгэдэг.

- “Билгийн нүд”-ний талаар та юу гэж хэлэх вэ гэж би атлантын зургийг заан асуухад,

- Энэ бол хөмсөгнөөс авсан туг үс гэж лам жуумалзан хариулав.

Лам надаар тоглоом тохуу хийж эхэлснийг би ойлгов. Дани залуу ч бас намайг жуумалзан харав.

- Будда газар дэлхий рүү хэний мэдлэгийг авчирсан юм бэ гэж би тэвчээр заан асуулаа.

- Будда гэдэг бол өөрөө эрх чөлөө. Чи хэрвээ өөрийн биеэс чөлөөлөгдөх юм бол чи ертөнцийг таних болно. Өөрийгөө биеэсээ гадуур байгаагаар төсөөлөх нь маш чухал...

- Будда тэгээд хэний мэдлэг оюуныг авчирсан юм бэ дээ?

- Буддад бүх мэдлэг байсан.

- Уучлаарай, - гэж би хэлээд,- сүүлийн хоёр асуулт. Эхнийх нь, энэ хүн танд самадид орсон атлантыг санагдуулахгүй байна уу?

- Та нар самадийн талаар хаанаас мэддэг юм бэ?- гэж лам асуугаад, яг эгц өөдөөс ширтэв.

- Энэ тухай бидэнд энэтхэгийн лам нар ярьж өгсөн. Бид нэлээд итгэлтэйгээр Төвдөд, тогтмол хэмийн дулаантай агуйнуудад зөвхөн манай иргэншлийн төдийгүй өмнөх иргэншлүүдийн хүмүүсийн чулуун - хөшингө бие одоо хир хадгалагдсаар байх ёстой гэж үзэж байна. Энэ бол эрхэм лам таны үүрэг болох хүн төрөлхтний Генийн санг хадгалах зориулалттай юм.

Нөгөө талаас сүүлийн илгээлт болох “SoHm” байгаа юм. Яагаад сүүлийнх гэж? Үүнийг хүн төрөлхтний энэ соёл иргэншил ч бас устах юм бол хүний Генийн сан хэрэггүй болж, хадгалагдсан хүмүүс самадийн байдлаас гарахгүй бөгөөд

шинэ соёл иргэншил үүсэхгүй юм гэсэн сануулга гэж ойлгож болно. Тийм учраас эрхэм ламтан минь хүн төрөлхтөнд манай соёл иргэншил сүүлчийнх нь болж магадгүйг сануулах цаг нь болсон гэж би бодож байна. Дэлхий дээр хичнээн их зэвсэг байгааг хараач! Хүмүүсийн баяжих хүсэл голлосон ахуйн бодит хөгжил нь сэтгэл оюуны хөгжлөө түрж байгааг хараач! Мөнгөний төлөө хүн юу ч хийхээс буцахгүй болсон байна... Хөгжилтэй орнуудаас ирсэн хэдхэн хүн л, -гээд би танхимд сууж буй түүний шавь нар болох гадаадуудыг зааж, - өөрсдийн сэтгэл оюуны хөгжлийг урьтал болгосон байна. Гэхдээ тэд үүнийг зөвхөн өөрсөддөө л зориулж хийхээс хэтрэхгүй байна. Харин хүмүүст шашинд жинхэнээсээ итгэдэг болохын тулд шинэ баримтууд, шинэ мэдлэг хэрэгтэй байна. Хүмүүс шашинг нэгэн сайхан үлгэр мэт хүлээж авдаг гэдэгт тангараглахад ч бэлэн байна...

Нам гүм болов. Лам хуруугаараа өвдгөө тогшино. Дани эр төөнөсөн харцаар намайг ширтэнэ.



*Сүмийн тагтан дээр*

- Самади хамгаалагддаг, -гэж лам гэнэт хэлээд, - Тэнд хүч байдаг. Чулуу болгон... Энэ бол зөвхөн миний ч үүрэг биш...Нээрээ, таны хоёр дахь асуулт чинь юу юм бэ?

- Та сүүлчийн илгээмж болох "SoHm"-ийн талаар юу мэдэх вэ?

- Таны мэдэж байгааг л мэднэ, - гэж лам хариулав.

Би ламыг ер бусын аварга том нүдний зурагтай дугуй цамхаг руу харсан тагтан дээр дуудан гаргав. Чухам энэ нүдний дүрсэнд бид судалгаа хийсэн бөгөөд чухам энэ нүд л бидний атлант гэж таамаглаж буй ер бусын хүний дүр төрхийг сэргээх үндэс нь болсон юм. Чухам яагаад энэ нүд Төвд, Балбын сүмүүдийн бэлэг тэмдэг нь болдог юм бэ? Энэ нүд юуг бэлэгддэг юм бэ? Энэ нүд мэргэн оюуныг бэлэгддэг гэсэн яриа миний сэтгэлийг хангахгүй байлаа. Эртний мэдлэгт ч бас бидний офтальмогеометртэй төстэй ойлголт байсан хийгээд тэд нүдний дүрсээр нүдний эзнийх нь дүр төрхийг

кодлосон ч байж болох юм. Магадгүй энэ бол манай соёл иргэншлийн өвөг эцгийн нүд ч юм бил үү. Магадгүй энэ нь хүн төрөлхтөн мөхсөн тохиолдолд хүний генийн сангаас гарах ирээдүйн аврагчийн нүд ч юм бил үү? Ирээдүйн аврагчийн нүд... Байж болох л юм... Гэхдээ лам бидэнд юу ч хэлсэнгүй. Тооцоолон гаргасан “статистикийн дундаж нүд” нь төвд үндэстнийх ба Төвдийн бүх сүм ер бусын нүдний дүрстэй байсан нь сонин байв.

Бид ламтай цуг зургаа авахуулав. Дани залуу ч бас хажууд байлцлаа.

- Та энэ нүдний нууцыг мэддэг нь ойлгомжтой! – гэж би хэлээд цамхаг руу заав.

- Миний эрүүг хар даа. Чамд миний дух харагдахгүй байгаа биз. Дух руу хараад чи миний эрүүг харахгүй. Нэг нүдийг харахад чи нөгөөг нь харахгүй. Нөгөөг нь харвал эхнийхийг нь харахгүй гэж ламтан хэлэв.

- Гэхдээ хүний нүд чинь задлагч туяа мэт ажилладаг шүү дээ!

Жижигхэн биетэй ламтан над руу дөхөн ирж, дээш сунан мөрийг минь хүчтэй гэгч нь алгадав.

- Бүү шантар гэж хэлээд, дахин алгадаад чанга инээв.

Надад тун таагүй байлаа. Дани эр нөгөө хэвээрээ намайг духаараа ажсаар л байв.

- Та яагаад миний мөрийг алгадаж, чанга хөхрөхгүй байгаа юм бэ? – гэж лам асуув.

- ...

- Танай оросууд чинь энд ирэхээрээ надтай цуг байгаа хүмүүсийг үл тоон чанга чанга ярилцан хөхрөлдөж, надтай цуг зургаа авахуулчихаад, мөрөн дээр алгадаад байдаг юм. Яагаад,- гэж ламтан танхимд сууж буй хүмүүсийг заан,- яагаад эдгээр герман, америк, англи, голландчууд миний өмнө өвдөг дээрээ сөхөрч байхад танай оросууд... Би эртний мэдлэг ухаан, мэргэн оюун болон өвөг дээдсийнхээ өмнө хүлээсэн хүндэтгэл, энэ болгоныг төлөөлж байгаа шүү дээ! Энэ хүн л гэхэд,- гээд тэрээр дани эрийг заан, - Балбад 22 дахь жилдээ амьдарч бясалгал, эртний мэдлэг сурч байна.

Дани эр толгой дохив.

- Энд ирж байсан оросуудын өмнөөс би хариуцлага хүлээж чадахгүй гэж би хариулав.

- Та нарыг тэдэнтэй адилгүй. Үнэхээр эрдэмтэд гэдгийг мэдэж л байна,- гэж лам хэлээд,- Гэвч би биднийг зөвхөн бүдүүлэг, сонирхолтой зүйл гэж хүлээж авч буй баян орны төлөөлөгчдөд эртний мэдлэгээ хэрхэн итгэж өвлүүлэх билээ. Тэр хүмүүст чинь бидний эртний сургаалийг хүндлэх нэг ч грамм хүндэтгэл, сонирхол байхгүй шүү дээ! Тэд чинь мөнгөтэй л бол бүгдийг худалдан авч болдог гэж боддог хүмүүс. Балба маш ядуу орон. Орос бол баян орон. Гэхдээ Балба, Төвд хоёрт дэлхийн өөр хаана ч байхгүй эртний мэдлэг оюуны сан хөмрөг бий. Бид танай

шинжлэх ухаан боловсролыг хүндэтгэдэг шиг та нар ч бидний шашин шүтлэгийг хүндлэгтүн! Нэг орос залуу надтай зургаа авахуулчихаад гарт минь 100 доллар атгуулахыг оролдсон удаатай. Сайн хүмүүс бол хандив өргөдөг юм.

- Би тэдний өмнөөс уучлалт л гуйж чадах юм байна гэж би бувтнасан болов.

- Таны уучлалтаар ч би яах вэ дээ! Та эх орондоо очоод тэр хүмүүст хандан зурагтаар хэлээрэй! Хэрвээ манай эртний өв уламжлалт мэдлэг тэдний гарт орвол тэд түүнийг муу үйлст ашиглах болно. Хэрвээ тийм хүмүүс самадид байгаа хүнийг ч юм уу, өөр ямар нэгэн зүйлийг олвол, тэд амьтны хүрээлэн мэт үзмэрт тавьж, үзүүлснийхээ төлөө мөнгө авах болно. Хятадын коммунистууд Төвдийн сүм дуганыг нураан сүйтгэж, эртний үнэт зүйлээр тоглон тохуурхсан. Аз болоход самадийг тусгай хүчнүүд хамгаалдаг юм. Эдгээр хүчтэй эн зэрэгцэн өрсөлдөх хүч өнөөдөртөө үгүй. Танай орон цэргийн асар их хүчин чадалтай орон. Гэхдээ цөмийн зэвсэг ч эдгээр хүчинд нөлөөлж чадахгүй. Танай орон ч ялгаагүй бурхнаа үгүйсгэж, тэргүүлэгчдээ бурханчлан шүтсэн коммунист орон!

- Манай орон коммунист байсан.

- Ялгаагүй. Танай оронд энд ирдэг шиг тийм баячууд байгаа л бол та нарт итгэх аргагүй. Дэлхийг одоо мөнгө удирдаж байна. Тэд чинь шинжлэх ухаан, шашин шүтлэгийг ч тэр зүгээр шахуу худалдан аваад баллан сүйтгэх болно.

- Гэхдээ улс болгонд л ийм хүмүүс байдаг шүү дээ.

- Тийм л дээ.

- Танд нэгэн зүйлийг тайлбарлахыг зөвшөөрнө үү. Орос орон маш хүнд байдалд байгаа. Улс төр чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцад шинжлэх ухаан, боловсрол хог дээр гарч дэлхийд нэртэй байсан эрдэмтэд оросын хамгийн бага орлоготой хүмүүсийн тоонд орж, авсан зарснаасаа ашгаа л бодож дөнгөхтэйгээ боловсрол багатай нэг нь баяжиж, бүх юмийг худалдаж авч болдог гэж боддог болсон. Эдгээр баян боловч боловсрол багатай хүмүүсийг орос “шинэ оросууд” гэж нэрлэдэг. Чухам эд нар л дэлхийгээр нэг тэнүүчилж, энэ хүмүүсээр л орос орныг төсөөлж байна. Гэхдээ орос хүн бүр “шинэ оросууд” шиг биш.

- Гэхдээ одоогийн танай улсын тэргүүнүүд чинь яг л тийм хүмүүс байгаа биз дээ гэж лам асуулаа.

- Харамсалтай нь энэ үнэн. Уг байдал удаан үргэлжлэхгүй байх гэж найдаж байна. Улс төр гэдэг бол тааж хэлэхийн аргагүй зүйл. Дани эр яагаад ч юм, дахин миний дэргэд ирэн миний хэлснийг балбаар орчуулж, ойлгомжгүй үгээ бүр тохой ёврон асууж эхлэв.

- Шинжлэх ухаан гэдэг бол олон улсын шинжтэй зүйл,- гэж би түүний орчуулга огт хэрэггүй гэдгийг дани эрд харуулах байдалтайгаар хэлээд яриагаа үргэлжлүүлэн,- “шинэ оросууд”-аас болж орос орны нэр хүнд тэгтлээ унасанд оросын эрдэмтэд бид буруугүй. Би мэс заслын эмч, эрдэмтэн, дэлхийн 40 гаруй





орноор явснаар барахгүй, нэг газартаа олон дахин очиж үзсэн. Яагаад би зүсэн зүйлийн улсаар явж, лекц уншин, шинэ хагалгаагаа үзүүлдэг юм бэ? Газар нутгийг сонирхох сонирхол маань аль эрт буурсан. Зохиосон анагаах ухааны шинэ ололтоо их мөнгө болгож нэг баян фирмд зарах ч юм уу, орлогын ихэнх нь өөртөө ордог хувийн эмнэлэг байгуулах нь хавьгүй хялбар байхсан бизээ. Эрхэм ламтан минь, учир нь шинжлэх ухаан гэдэг чинь Бурханаас үндэслэлтэй юм. Бурхан чамд шинэ юм зохион бүтээх чадвар хайрласан бол энэ нь хувийн сэтгэл ханамжийг авчирах бурхны нэгэн бэлэг. Гэвч уг бүтээлээ эхлээд хотдоо, дараа нь улсдаа, тэгээд бүх дэлхийд дэлгэрүүлэх гэсэн эрдэмтэн яван явсар бүтээлийнхээ

боол нь болдог. Энэ үедээ эрдэмтэн болгон ашиг хонжооны талаар боддоггүй гэдэгт минь итгээрэй! Ер нь ихэнхдээ ашиг орлого гэж огт байдаггүй. Чиний санааг өөр хэн нэгэн шүүрэн авч, шинэчлэн дэлгэрүүлж, санаачлагч нь харин ар талд нь сүүдэрт үлддэг. Аль болох удаан хугацаагаар шинэ хагалгааныхаа аргыг хэнд ч харуулахгүйгээр зөвхөн гайхам үр дүнг нь гайхуулаад явж байх нь илүү ухаалаг байхсан. Гэвч жинхэнэ эрдэмтэн хүн ингэх нь ховор байдаг. Учир нь энэ бүтээл бол чинийх биш. Энэ бол бүх хүнд зориулагдах ёстой. Харин чи бол зөвхөн ур чадварынхаа боол нь. Бүтээх болон бүтээлээ дэлгэрүүлж бусдад түгээх үйлийн зэмсэг нь юм гэдэг мэдрэмж сэтгэлийн гүнээс чинь гардаг. Мөн уг мэдээлэл ертөнцийн мэдээллийн орноос үүдэлтэй ба эргээд ертөнцийн мэдээллийн орноо нөхөж байдаг. Тийм ч учраас эрхэм ламтан минь энд аль улсын иргэн болох, тэр тусмаа уг улс орны дээд зэргийн бус төлөөлөгчид болох "шинэ оросууд" ямар ч хамаагүй хэрэг.

- Та яагаад Америк рүү гараагүй юм бэ? – гэж лам асуугаад, - Америк бүх дэлхийгээс оюун ухааныг худалдаж аван шинжлэх ухаан хөгжих нөхцлийг бүрдүүлж өгдөг.

- Би Америкт олон удаа очиж байсан бөгөөд энэ улсыг маш сайн мэднэ,- гэж би хариулаад,- Намайг ч гэсэн худалдаж авах санал тавьж байсан. Би хоёр шалтгаанаар зөвшөөрөөгүй. Эхний шалтгаан бол ухамсар юм. Оросын нэрт найруулагч Тарковский ухамсар нь хиртсэн хүмүүс үхдэг нэгэн онцгой бүсийн тухай, хүний хамгийн хүчтэй мэдрэмж болох ухамсарын тухай “Сталкер” гэдэг кино хийсэн. Шинжлэх ухаанд хэзээ ч ганцаарддаггүй. Хамтран зүтгэх нөхөд гэж үргэлж байдаг. Надад ч мөн адил судалгаа шинжилгээний хүнд замыг цуг туулсан хамтран зүтгэгч нөхөд минь бий. Ухамсар минь намайг зовоох учраас би тэднийгээ хэзээ ч орхиж чадахгүй.

Хоёр дахь шалтгаан нь миний ажигласнаар Америк рүү дүрвэн гарсан эрдэмтэд “унтарч” эхэлдэг. Учрыг нь нарийн хэлж чадахгүй ч миний үзэж байгаагаар долларын араас хөөцөлддөг америк нийгэм тэдний урам зоригийг унтраадаг бололтой. Шинжлэх ухаан юуны түрүүнд сэтгэл шаарддаг.

- Таны зөв, шинжлэх ухаан юуны түрүүнд сэтгэл шаарддагаараа шашинтай төстэй гэж ламыг хэлэхэд нь би,

- Чухам тийм учраас л эрхэм ламтан минь, би танд шинжлэх ухааны чанартай олон асуулт тавьсан. Харин та, уучлаарай, цээжлээд, улиг болсон гудамжны хүүхдэд уншдаг сургаалиараа хариулсан гэв.

- Дараа арай ухаалаг байх болно гээд ламтан үнэн голоосоо хөхрөөд, та ч мөн адил намайг ойлгоорой хэмээв.

- Танд гүн ухааны шинжтэй нэг асуулт тавья,- гээд би,- Дэлхийн бөмбөрцгийн энэ бүс нутгийн оюуны хөгжил нь ямар ч эргэлзээ төрүүлдэггүй хирнээ яагаад танай улсад шинжлэх ухаан хөгжөөгүй юм бэ?

- Манай орон бол ядуу орон, харин шинжлэх ухааныг хөгжүүлэхийн тулд их мөнгө хэрэгтэй.

- Яагаад танай улс ядуу юм бэ? – гэж би шалгаан,- Таны шавь нарт ч бас,- гээд би танхимд сууж буй гадаадуудыг заан, - гуйлгачингүй баян оронд амьдрах нь таатай биш гэж үү?

Дуугаа хураасан дани эр толгой дохив.

- Манай орон маш олон гуйлгачинтай. Төрөлт харьцангуй өндөр. Ард түмэн амьдралын туйлийн ядуу нөхцөлд амьдарч, нэн даруу хоол хүнс хэрэглэсээр сурчихсан. Үүнээс илүү амьдарч болдог тухай төсөөлөл багатай. Ядуу зүдүү сэтгэлгээ хэвшин тогтчихсон газар.

- Миний бодлоор,- гэж би хэлээд, - шалтгаан зөвхөн үүнд ч бус. Танай улсын ядуурлын гол шалтгаан нь шашин юм гэж бодож байна.

- Шашин?

- Индуист болон буддын шинж чанартай шашны сургаалиуд нь миний мэдэж байгаагаар сэтгэлийг бодит зүйлсээс илүү гэж номлодог. Бясалгалын сургууль болон бусад шашны төвүүдэд ингэж зааж сургадаг. Шашны сургаалиар бол бодит

эхлэл нь сэтгэлийн эхлэл нягтрах замаар үүссэн гэдэгтэй би санал нэгддэг учир сэтгэлийн хүчин зүйлийн давуу талд эргэлзэхгүй байна л даа. Гэвч сэтгэлийн хүчин зүйлийн үүргийг хэт дөвийлгөх нь танай орны сүсэгтэн олон газар дэлхий дээрх амьдралыг чухал биш, түр зуурын юм гэж үзэн амьдралынхаа чанарыг нэмэгдүүлэхийн тулд хүчин чармайлт гаргахгүйд хүрч байна. Бие бол сэтгэлийн нэгэн төгс төгөлдөр зэмсэг бөгөөд түүнээс салгах нь харамсмаар хэрэг. Тийм ч учраас шашны сургаалийг олон түмэнд номлоход алтан дунджийг баримтлах нь зүйтэй гэж бодож байна.

- Гэхдээ бид шашны ариун судруудыг өөрчлөж чадахгүй шүү дээ! – гэж ламтан зөрөв.

- Гэгээнтнүүдээр дамжин манай ертөнцөд уламжлагдан ирсэн шашны судар бичээсүүдийг юуны түрүүнд өндөр боловсролтой, өндөр соёлтой хүнд зориулсан гэж би бодож байна. Үүнээс гадна, шашны сургаал амьдралын нөхцлийг даган ямар нэгэн хэмжээнд хувирч болдог уян хатан шинж чанартай гэдгийг та мэднэ. Эрхэм ламтан минь, жишээ болгон хэлэхэд, хэрвээ та хүн болгон сэтгэлээ хөгжүүлэхийн зэрэгцээ маш их хөдөрмөрлөж, эрдэм боловсрол олж, өөртөө болон гэр бүлийнхээ амьдралын нөхцөл байдлыг хангаж өгөх хэрэгтэй гэж номлож эхэлвэл шашны зүтгэлтэн та нар улс орондоо асар том нэр нөлөөтэй байдаг учраас үр дүн нь маш хурдан гарна.

- Тийм л юм...

- Танай шашны дагуу Будда энх амгалангийн ба уур хилэнгийн гэсэн хоёр төрхтэй байсан. Юм бүхэнд зөвхөн энхийн аргаар хандаж, бүхнийг бүтээх боломжгүй. Хаяа ч гэсэн уур хилэнгээ гаргаж, нутаг нэгтнүүдээ илүү хөдөлмөрлөж, улс орноо баяжуулахыг шаардаж болно. Тэгвэл л шинжлэх ухаан хөгжих нэг нөхцөл байдал бүрдэнэ. Шинжлэх ухаан маш их үүрэгтэй. Шашин гэж юу юм бэ? Шашин гэдэг бол өмнөх соёл иргэншлийн хүмүүсийн шинжилгээ судалгаагаар олж авсан мэдлэг. Тийм учраас шинжлэх ухааныг хөгжүүлж түүгээрээ Ертөнцийн Мэдээллийн орныг баяжуулах нь ариун үйлс. Чухам шинжлэх ухаан нь л шашны дутууг нь гүйцээж, алдааг нь засаж, цаашид хөгжүүлж чадна. Бэлэн зүйл гээд Ертөнцийн Мэдээллийн Орноос авсан мэдээллийг үргэлж ашиглаад байж болохгүй шүү дээ. Нөхцөл байдалдаа тааруулан баяжуулж, засах хэрэгтэй.

- Таны зөв байхаа гэж лам хэлэв.

- Ариун үүрэгтэйд нь эргэлзэж боломгүй шинжлэх ухааны хөгжлийг саатуулах түвшинд хүртэл нь бодит ертөнцийн үүргийг үгүйсгэж болохгүй шүү дээ,- гээд би үргэлжлүүлэн,- Самадийг аваад үзээч! Самадийн үед сүнс биетэй холбоотой хэвээр боловч биеийг орхин оддог. Болисын солилцоогоо тэгтэй тэнцүүлж хэдэн сая жилээр биетэйгээ харьцдаг. Хэрвээ сүнс голлох үүргийг гүйцэтгэдэг юм бол биеийг тэгж хэдэн сая жилээр хадгалах ямар шаардлага байна? Хариулт нь маш амархан. Хүний бие махбод урт хугацааны хөгжлийн үр дүнд үүссэн байхад

түүнийг үл тоомсорлох ямар ч утгагүй. Дахин шинээр бий болгохын оронд байгаагаа хадгалсан нь дээр.

- Гэхдээ л хүмүүс сэтгэлийн хүчин зүйлийг эзэмшихийг улам ихээр хүсэх болсон шүү дээ гэж лам хэлэв.

- Та шавь нараа нэг хар даа. Тэдний харц нь энэ ертөнцөөс тасран одсон мэт байна. Бодит амьдралаас тасарсан энэ хүмүүс нийгмийн сэтгэл оюуны хөгжлийг дээшлүүлэхэд ямар нэгэн тус болж чадахгүй л болов уу. Сайндаа л тэд өөрсдийн амар амгалангаас сэтгэл ханамжыг олох болно.

Дани эр миний тохойноос татан, яагаад ч юм бэ ямар нэгэн зүйлийг балба хэлээр асуув.

- Англиар яриач!

- ...

- Бид, - гээд лам үргэлжлүүлэн, - сэтгэл оюуны хөгжлийг илүүд тавьж үздэг нь материаллаг бүхнийг илүүд үздэг хөгжилтэй ертөнцийн бусад хэсгийг эсэргүүцэх гэсэн санаа юм.

- Таны зөв байх аа. Дэлхий ертөнц тэнцвэрт байдалд байх шаардлагатай. Таны үгийг баталсан нэгэн жишээ татья. Та Гэгээрсэн Е.Блаватскаяг мэдэх үү?

- Мэднэ, надад түүний зарим нэг ном байдаг.

- Е.Блаватскаягийн номоос “Египетийн пирамидууд нь маш олон үүрэгтэйгээр баригдсан бөгөөд тэдгээрийн нэг нь самадид буй хүний биеийг хадгалах зориулалттай” гэж уншсан санагдана. Египетийн фараоны биеийг Хеопсын пирамидаас олсон бөгөөд олдворыг Британий музейд байрлуулсан. Магадгүй тэр амьд байсан бөгөөд египетийн хүний биеийг занданшуулах тухай яриа бүгд үлгэр байсан ч байж болохыг хэн мэдэх юм бэ? Магадгүй египетийн фараон гүн самадийн байдалд байгааг нь мэдэлгүй биеийг нь одоо ингэж үзүүлэн болгож тавьснаар температурын зохих горимыг алдагдуулж, сүнсийг нь биедээ эргэж ирэхээргүй болгосон болов уу. Ламтаан, яагаад ер бусын хүчин чадал фараоныг хамгаалаагүй юм бол?

- Миний бодлоор пирамидад тийм хүчнүүд байдаггүй.

- Яагаад?

- Мэдэхгүй.

- Нийтийн шашин шүтлэгийн асуудлыг дахин нэг сөхье,- гэж би хэлээд,- Дэлхий дээрх янз бүрийн шашны талаар ярилцъя. Миний бодлоор шашин шүтлэг дотроос хамгийн тохиромжтой хэлбэр нь католик шашин. Уг шашинд хүний эрх чөлөөг боон хорилгүй ёс суртахууны хатуу зарчимтай хослуулсан байдаг. Тийм ч учраас католик шашинтай улсууд Дэлхий дээрх хамгийн хөгжилтэй улсуудын тоонд орж байна. Католик шашныг лалын шашинтай харьцуулахад лалын шашны харгис хэрцгий дүрэм журам нь хэтэрхий их болохоор эрх чөлөө илэрхий дутагдаж байдаг. Үүний үр дүн нь илхэн байна. Лалын шашинт орнууд католик

шашинтай орнуудаас хөгжлөөрөө хамаагүй дутуу байна. Тэгвэл үнэн алдартны шашинг католик шашинтай харьцуулж үзвэл үнэн алдартны шашин эрх чөлөө ихтэй боловч хөгжлөөрөө католик шашинтай орнуудаас бага байна. Тэгвэл католик шашныг буддын болон индуист шашинтай харьцуулж үзвэл түүнд багтдаг Энэтхэг, Балба, Бутан болон хөрш зэргэлдээх орнуудынх хөгжлийг харахд ихэвчлэн сэтгэлийн талаа илүүд үзэн хөгжүүлж, амьдралын материаллаг талыг үгүйсгэсэн байдаг. Үр дүн нь мөн л тодорхой байна. Сэтгэл оюуны асар өндөр хөгжилтэй хирнээ эдгээр орон үнэхээр атаархамгүй эдийн засгийн байдалтай байдаг. Буддизмын олон хувилбар дотроос сэтгэл оюуны хөгжлийг бодит амьдралын хатуу зарчимтай хослуулснаараа япон орны буддизм онцлог. Үр дүнд нь япон улс хөгжлөөрөө илэрхий давамгайлж байна.

- Тиймээ, таны зөв байх аа...

- Бид бүгдээрээ бурхан бол нэгдмэл гэдгийг мэднэ,- гэж би хэлээд,- Тэгвэл яагаад ядахдаа л шашнуудын улс орны эдийн засагт нөлөөлсөн түүхэн баримтыг анхааралдаа аван өөрийн шашны хэлбэрийг жаахан өөрчлөн засаж болохгүй гэж? Дэлхий дээр шашны янз бүрийн урсгалуудыг үүсгэсэн олон Гэгээнтэн байсан. Эдгээр Гэгээнтэн хэнийх нь зөв байсныг харуулсан. Бурхан нэгдмэл гэдэгт үндэслэн шашин бүрийн тэргүүнүүд нэгдэн нэгэн шашны сургаал номлолыг үүсгэх цаг болсон гэж бодож байна. Та одоо ч зарим нь үргэлжилсээр байгаа (Израиль, Югослав зэрэг) олон арван шашны дайныг эргэн санаач!

- “Маш сонирхолтой яриа боллоо. Баярлалаа” гэж лам хэлэв.



*Ренбучи ламын хамт байгаа нь*

- Эрхэм ламтан минь та хэзээ бидэнтэй шинжилгээ судалгааны талаар арай нухацтай ярилцах боломжтой вэ? Өчигдөр Валерий Лобанков Тэнга ламтай уулзсан боловч үр дүн гарсангүй. Тэрээр та эхэндээ бидэнтэй яаж харьцсан шиг үл итгэсэн байдалтай харьцсан. Бид чинь уул нь эрдэмтэд шүү дээ...

-Дараагийн удаа нухацтай ярилцана гэдгээ амлаж байна,- гэж лам хэлснээ,- Нээрээ, байзаарай! Та нар Бумба ламтай уулзсан чинь дээр байх. Бумбын шашин бол дэлхийн

хамгийн эртний шашин бөгөөд, бумба лам мэдлэгээрээ надаас хамаагүй илүү. Тэр бол агуу хүн. Тэрбээр хятадын коммунистуудын мөрдлөгөөс зугтаан Түвдээс Балба руу дүрвэж ирсэн. Одоохондоо түүнд өөрийн том сүм байхгүй боловч түүний мэдлэг агуу. Бумба лам нэлээн настай хүн. Би маргааш түүн рүү утасдаад та нарын тухай хэлье. Тэр та нарыг хүлээн авч, илэн далангүй уулзах болно гэдгийг би амлаж байна. Маргааш оройны долоон цагийн үед хүрээд ирээрэй.

- Танд баярлалаа.

Лам танхимд өвдөглөн сууж байсан шавь нараа харцаараа тойруулаад, тэднийг тойрон биднийг гаргаж өгөв.

Би эргэж харлаа. Дани залуу уруу царайлсан харцаараа биднийг үдсэн юм.

## Тавдугаар хэсэг

# Бумба ламын илэн далангүй яриа

Ринбүчи ламтан үнэхээр л хэлсэн үгэндээ хүрчээ. Тэрээр Бумба лам руу утасдаад, бидэнтэй уулзуулах талаар тохирчихсон байлаа. Тэрээр дагалдах захиа хийж өгөөд, Бумба лам бидэнтэй илэн далангүй ярилцахад бэлэн гэв.

Бумба лам Балбын баруун хэсэг дэх жижигхэн хотод амьдардаг ажээ. Эхлээд бид золтой л машин хөлслөөд замд гарчихсангүй. Азаар Шесканд “Балбын зам нь их муу. Зам таглан ургадаг цэвэрлэхэд туйлын хэцүү мөлхөө ургамал ихтэй учир машинаар явбал замдаа бүтэн долоо хоног ч болж магадгүй.” гэж анхааруулж, бид жижигхэн онгоц түрээслэхээс өөр аргагүй болов. Нислэгийн турш онгоцыг эгээ л далайд хөвж яваа зомгол мэт сэгсэрч байсан шуурганд өртөж, газардахын өмнөхөн уулын ангалд тойрч нисэхийн аргагүй аадрын үүлэн дунд орчихов. Арай гэж нэг юм газардсаныхаа дараа нисэгчдийн хувхай цайсан царайнаас ямар аюулаас аврагдсанаа ойлгоцгоосон билээ. Хуучин цэргийн нисгэгч байсан Сергей Селивестров уулын цаг агаарыг урьдчилан тааварлах аргагүй. Бидний аз дайрч, онгоцны их бие агаарын ширүүн урсгалыг давж гаран, мөндөр онгоцны хөдөлгүүрийг гэмтээлгүй өнгөрлөө гэж тайлбарлав. Мөн оросын онгоц эдийн засгийн хэмнэлт багатай ч бат бөх чанараараа хамаагүй илүү гэдгийг нэмж хэлэв.

Бид буудлаас Бумба лам руу утасдав. Маргааш өглөө уулзахаар тохиролцлоо.

Өглөө нь бид хотын захдуу уулын бэлд байдаг мөн л ер бусын нүдний дүрстэй жижигхэн сүмрүү шороон замаар өгсөн оров. Уламжлалт улаан хүрэн өмсгөлтэй лам нар биднийг угтан авч, Бумба лам руу аваачив.



*Бумба лам*

Бумба лам 70 орчим насны мөн л улаан хүрэн өнгийн хувцастай, дорны сонгодог аялгатай ч англи хэлээр сайн ярьдаг хүн байлаа.

Намуухан хоолой, дулаахан харцтай нүд нь анхаарал татаж байлаа. Бид өөрсдийгөө танилцуулав. Энэ үед арын хаалган дээр европ төрхтэй нэг эмэгтэй хоёр эрэгтэйн хамтаар хүрч ирэв.

- Энэ миний нөхөд, эрдэмтэд,- гэж лам тэднийг танилцуулав.

- Та нар тэгээд ламын шавь нар нь юумуу, эсвэл эрдэмтэд юм уу?

- "Дорнын шашин судлаач, түүхч эрдэмтэд. Бид энд сар гаруй амьдарч, хамгийн

эртний шашин болох Бумбын шашны үүслийг судалж байна. Бумба лам маш их мэдлэг, соёлтой хүн. Тун их зүйлийг цээжээр мэддэг. Харамсалтай нь бүх ном нь төвдөд үлдсэн бөгөөд тэрээр төвдөөс дүрвэхээс өөр аргагүй болсон аж. Ноён, Бумба ламтан бол энэ эртний Бумбын шашны үлдсэн цөөхөн төлөөлөгчдийн нэг. Бид уг шашны түүх, соёл ул мөргүй үүрд алга болчихоос айж байна." гэж америк эр ярив.

- Миний ойлгосноор та нар АНУ-гаас ирцгээсэн үү гэж америк аялгыг нь гадарлаад асуухад.

- Тиймээ бид их сургуулийн эрдэм шинжилгээний ангийг төлөөлж яваа.

- Харин бид офтальмологи буюу анагаах ухааны нүд судлалын салбарыг төлөөлж явна...

- Нүд судлал аа? Өө, та нарыг хүний гарал үүслийг судалж яваа олон улсын шинжилгээний ангийнхан гэж сонссон юм байна! гэж америк эр дуу алдав.

- Дэлхийн улс үндэстнүүдийн нүдийг судлах судалгаа маань түүхийн тал дээр үргэлжлэхээс аргагүй болсон юм гэж би хариулав.

- Та нар Оросоос ирсэн гэл үү гэж америк эр асуув.

- Тийм.

- Өө, тэгвэл ч Оросууд шинжлэх ухааныхан ч ийм ер бусын харьцуулалтыг хийхдээ гарамгай хүмүүс дээ. Оросын шинжлэх ухаан ч хүчтэй шүү.

- Ийм харьцуулалтын нэг нь одоо бидний сууж байгаа сүмийн ханан дээр дүрсэлсэн ер бусын нүд юм гэж би хэлэв.

- Маш сонирхолтой юм. Таны америк аялгыг сонсоход та Америкт удаан амьдарч байсан юм аа даа гэж нэг нь надаас асуув.

- Америкчуудтай харьцах хэрэг нэлээд гарч байсан юм.

- Бумба ламтай хийх уулзалтын үеэр чинь бид байлцаж болох уу?





*Бумба ламтай хийсэн ярилцлага*

Энэ сүмийн эзэн би биш бөгөөд америкчүүд ч мөн буурьтай эрдэмтэд шиг санагдаж байв.

- Хэрвээ Бумба лам татгалзахгүй бол та бүхэн тааллаараа бологтун гэв.

- Үгүй ээ надад татгалзах юм юу байх вэ та бүхэн суугтун хэмээн ламтан айлдаад бүгдийг том ширээнд урив.

- Эрхэм Бумба лам минь, таны ярианы зарим хэсгийг америк нөхдөөсөө лавлаж байж болох уу? Учир нь дорны аялгатай англи хэлнээс америк аялгатай англи хэл нь надад илүү ойлгомжтой. Харин америк нөхөд минь унаган хэлтэйн хувьд дорны аялгатай яриаг ойлгоход бэрх биш байх болов уу?

- Тэг, тэг, тэгэлгүй яахав гэж хоёул зөвшөөрөв.

Дорны шашны олон тэргүүнтэй хийсэн урьд өмнөх уулзалтынхаа туршлагаар, бид энэ удаад эхлээд асуултаа асуучихаад, дараа нь таамаглалынхаа мөн чанарыг ярихаар шийдэв.

- Эрхэм Бумба ламтан, гэж би түүн рүү хандан яриагаа эхлээд,- Таныг Төвдөөс Балба руу дүрвэн ирсэн гэдгийг бид мэднэ. Төвд Балба лам нарын хооронд ямар нэгэн ялгаа байдаг уу?

- Ямар ч ялгаа байдаггүй, - гэж Бумба-лам хариулаад,- Зөвхөн тодорхой эрэмбэ л байдаг нь Далай лам, Банчин лам, Ринбучи лам болон энгийн лам нар гэсэн. Эх нутаг Төвддөө би Банчин лам байсан.

- Бумба гэдэг цол тань Буддын шашны нэгэн төрөл гэдгийг илэрхийлж байгаа юм уу?

- Тиймээ.

- Буддын шашинд эртний ямар ямар урсгалууд байдаг вэ?

- Буддын шашны эртний 4 урсгал байдаг: Бумба, Гэлэгпа, Нямапа болон Тарний.

• Бумбын шашин нь Төвдийн баруун хэсэгт өргөн дэлгэрсэн, эерэг сөрөг аль ч энергийг шинжлэн судалдаг, хамгийн олон нууцтай шашин юм.

• Нямапагийн шашин нь Төвдийн зүүн хэсэгт төвлөрсөн бөгөөд хорио цээр ихтэй хэрцгий шашин. Энэтхэгийн сингхүүдийн шашны нэг урсгал болох Гужрунан нь өвөрмөц хатуу ёс жаягаараа онцлог бөгөөд угтаа төвдийн Нямапагийн шашны сэтгэлийн тал дээр үндэслэсэн.

• Гэлэгпагийн шашин нь Төвдийн баруун хэсгээр ихэд тархсан бөгөөд эерэг сэтгэлийн энергийг илүү судалж үздэг. Одоогийн Далай лам шашны энэ урсгалаас төрөн гарсан.

• Тарнийн шашин нь Төвдийн зарим нутгаар тархсан байдаг ба бусад шашныг бодвол нөлөө багатай.

- Бумбын шашны талаар арай дэлгэрэнгүй ярьж өгөөч гэж би гуйлаа.

- Урьд нь хэлсэнчлэн Бумбын шашин бол дэлхийн хамгийн эртний шашин,- гэж Бумба лам хариулаад,- Сүүлчийн Будда дэлхий дээр 2044 жилийн өмнө ирсэн байхад, Бумба Будда 18013 жилийн өмнө дэлхий дээр иржээ. Бумбын шашин “үхэл- амьдрал- үхэл- амьдрал” гэсэн хүрдэнд буюу сүнс болгон нэг бус амьдралыг агуулдаг гэдэгт итгэдэг. Бумбын шашны гол зорилго нь манай иргэншлийн хүмүүсийн “билгийн нүд”-ийг хөгжүүлэх явдал юм.

- Үүнийг яагаад ингэж их чухалчилдаг юм бэ?

- Манай иргэншлийн хүмүүст энэ нүд нь үлдэц эрхтэн (боргоцой хэлбэрийн булчирхай) төдий үлдсэн. Аажимдаа манай иргэншил материаллаг чиглэлдээ хөгжиж эхэлсэн. Хүн төрөлхтөн физик энергийн хичнээн төрлийг эзэмшсэнийг та нар хараач! Дулааны, цахилгааны зэрэг олон энергийг, мөн сансрыг эзэмдэж, хүний биеийг эмчлэх үр дүнтэй эмчилгээ гэх мэтийг бий болгосон. Харин сэтгэлийн энерги болон сэтгэл оюуны талын судалгааны хувьд өнөөгийн нийгэм янз бүрийн сэтгэлтэй хүний янз бүрийн ааш араншинг шинжилснээс цаашилсангүй. Орчин цагийн шинжлэх ухаан шашныг амьдралаас тасархай зүйл гэж хүлээж аван, хими физикийн олон нууцыг тайлж болох шинэ шинэ энергийн төрлүүдийг нээж, хүний сэтгэлийн энергийг зөв чиглэлд залан хүн болон нийгэмд нөлөөлөх шашны асар өндөр хүчин чадлын нөлөөг үл тоож байна. Үүний тулд хүн бүхэн маш өндөр хэмжээнд хүртэл нь “гурав дахь нүд”-ээ хөгжүүлэх хэрэгтэй.

- Би дөнгөж сая таны хэлснийг “билгийн нүд”-ээ янз бүрийн шинж чанарын долгионы хэсгүүд дээр тохируулдаг эрхтэн болгон ашигласнаар физик, химийн урвалууд болон байгалийн бусад үзэгдэлд хүн сэтгэлийн энергээрээ нөлөөлж болно гэж ойлгож болох уу? Одоо үед сэтгэлийн энерги нь ихэнхдээ төвөөс зугтах шинжтэй болсноор маш хангалтгүй ашиглагдаж, зориулалтаараа бус, харин ч

сөрөг аурыг (хүний гэрлэн давхраа) үүсгэн хүмүүст хортойгоор нөлөөлөх нь илүү болжээ. Миний бодлоор хүний сэтгэлийн энерги маш хүчтэй бөгөөд үй олон хүнийх нийлэхээр бүр ч их хүчтэй болох болно. Хэрвээ нийгэмд ийм сөрөг энерги их хуримтлагдвал хүмүүс сайн сайхны тухай бодоход хэцүү болж, ямар ч сөрөг үзэгдэл давамгайлж сонирхол татах нь ердийн үзэгдэл болно. Энэ үед ёс юм шиг нийгмийн хөгжил ухралтанд орж зэрлэгшинэ. Нийгэмд сэтгэлийн эерэг энерги хуримтлагдах юм бол нийгмийг хөгжил дэвшилд хүргэдэг.

- Та яг зөв ярьж байна.- гэж Бумба лам хариулаад,- сэтгэлийн энерги нь асар их хүчтэй. Харамсалтай нь энэ хүч үнэхээр дэлбэрэлт хэлбэртэй буюу төвөөс зугтах шинжтэй байгаа бөгөөд энэ нь манай иргэншлийн түүхэнд байнга нүүрлэдэг дайн, гай гамшиг мэтээр илэрдэг. Хүмүүсийн сэтгэлийн энергийг төвд тэмүүлэх чиглэл рүү нь буюу хөгжлийн чиглэлд залж өгөх ёстой. Чухам “билгийн нүд”-ий тусламжтайгаар л сэтгэлийн энергийг чиглүүлж, тааруулж болдог. Сэтгэлийн энерги нь сайн бодол санааны чиглэлд буюу эерэг зүгт чиглэгдсэн байх нь чухал.

- Та ямар аргаар “билгийн нүдний” хөгжлийг идэвхжүүлдэг юм бэ?

- Хүнд дотоод орчны эрх чөлөөг мэдрүүлдэг “цэвэр хараа”-г хөгжүүлэх бясалгалын аргаар идэвхжүүлж болно. “Билгийн нүд”-ий хөгжлийн хэд хэдэн үе шат байдаг. Хамгийн



өндөр шатанд хүрсэн үед самадид орж болно. “Билгийн нүд”-ийг духан дээрээ дүрслэх нь бэлэг тэмдэг төдий юм л даа. Үнэн хэрэгтээ энэ нь гавлын дотор боргоцой хэлбэрийн булчирхай болон гүн суусан байдаг.

- Танай шашин “билгийн нүд”-ийг хөгжүүлэх тал дээр ямар амжилтанд хүрсэн бэ?

- Харамсалтай нь, бидний ололт амжилт их биш ээ. Үүнд хангалттай хөдөлмөр зарцуулахгүй байгаа шашны зүтгэлтнүүд бидний буруугаас гадна мөчлөгийн байдалтай хөгждөг хүн төрөлхтний өнөө үеийн хөгжил нь материаллаг хөгжлийнхөө оргил үед буюу сэтгэлийн үүргийн уруудах үед байгаа нь бас нэг шалтгаан болж байна. Гэсэн ч бид байнга “билгийн нүд”-ээ хөгжүүлэхийг оролдож байх ёстой бөгөөд эс тэгвээс сэтгэл оюуны хөгжил уруудах чиглэлдээ үргэлжилсээр байх болно.

- Та тэгвэл орчин үеийн хүн гүн самадид орох хэмжээнд “билгийн нүд”-ээ хөгжүүлж чадахгүй гэж хэлэх гээд байна уу гэж би асуув.

- Яг одоо бол үгүй. “Билгийн нүд”-ний ухралт түүхэн замналаар явагдсан болохоор зөвхөн ганц нэг йогчид хэдхэн жилийн л самадид орох чадвартай. Гэхдээ ирээдүйд гүн самадид орох боломжтой болно гэдгийг үгүйсгэх аргагүй гэж Бумба лам хариулав.

- Тэгэхээр ирээдүйд хүн гүн самадид орох боломжтой болно гэсэн үг үү?

- Тиймээ.

- Яагаад дэлхийн бөмбөрцгийн чухам энэ бүсэд шашин нь материаллаг хөгжилд ч хохиролтойгоор сэтгэлийн хөгжлийн тал руугаа хазайсан юм бэ?

- Энэ бол маш чухал! Энэ бүс нутгийн орнуудын ард түмэн хүн төрөлхтнийг бүхэлд нь аврах ёстой юм. Учир нь Европт ч тэр, Америкт ч тэр, бүр Африкт ч тэр материаллаг ертөнцийн үүргийг дөвийлгөн, сэтгэлийн үүргийг үгүйсгэх хандлага их байна. Жишээлэхэд Европын ихэнх эрдэмтэн “сэтгэлийн энерги”, “сүнс”, “сэтгэл” зэрэг ойлголтыг хүлээж авахаас татгалздаг. Тийм ч учраас дэлхийн бөмбөрцөг дээрх материаллаг болон сэтгэлийн ертөнцүүдийн тэнцвэрийг барихын тулд дорны улс орнууд, ялангуяа Төвд Гималайн бүсийн ард түмнүүд сэтгэлийн хүчин зүйлийн үүргийг дөвийлгөж материаллаг ертөнцийг үгүйсгэхээс өөр аргагүй. Энэ шалтгаанаар эдгээр улс орон материаллаг тал дээрээ туйлаас ядуу боловч сэтгэл оюуны хөгжлөөрөө бусад орноос өндөрт байгаа юм. Сайн муу үйл, сэтгэлийн болон материаллаг ертөнц гээд бүх юм тэнцвэрт байдалд байх ёстой...

- Хүндэт Бумба лам минь! Гималай болон Төвдийн ард түмнүүдийг та хүн төрөлхтөний аврагчид гэлээ. Үүнийг нэг талаас нь энэ хүмүүс сэтгэлийн хүчин зүйлийн нөлөөг нэмэгдүүлж Барууны улс орнуудын материаллаг ертөнцийн



*Цаст Гималайн сэтгэл санааны ирээдүй*

өндөр хөгжилтэй тэнцүүлэхийн тулд материаллаг тал дээрээ ядуу амьдралыг туулан золиосонд гарч байгаа хэрэг гэж ойлгож болох юм. Гэвч нөгөө талаас хүн төрөлхтний эргэн төрөх магадлалыг нэмж өгдөг Хүн Төрөлхтний Генийн Сан болох самадид сэтгэлийн асар өндөр хөгжилтэй тохиолдолд л орж болно.

Бумба-лам намайг цоо ширтэн:

- Таны зөв байх аа. Самадийн үүрэг маш өндөр. Үүний тулд золиослогдохоос яах вэ... гэв.

- Үүнээс гадна, эрхэм ламтан минь, та түрүүн дэлхийн бүх улс үндэстэнд сэтгэлийн ертөнцийн хүчин зүйлийн үүрэг нэмэгдэнэ гэж хэлсэн. Энэ нь сэтгэлийн энергитэй холбоотой технологи хөгжихийн сацуу Дорны улс орнууд хүчээ аван цэцэглэх болно гэсэн үг үү?

- Мэдээж. Хүн төрөлхтний сэтгэлийн хэсэгт нөлөөлөх эртний арга барилаа алдахгүйн тулд хэрхэн хүч гарган зууралдаж байгааг минь хар даа! Энэ уйгагүй байдал маань амжилтанд хүрэх л ёстой. Чиглэсэн сэтгэлийн энергийн тусламжтайгаар таталцлын хүчинд нөлөөлснөөр барилгын салбарт эргэлт хийж болно. Сэтгэлийн энергитэй төстэй энергийн тусламжтайгаар агаарт хөвөх шинэ зарчмыг эзэмшиж болно. Хүний биеийн амин оронд нөлөөлдөг болж биохимийн урвалуудад өөрчлөлт оруулснаар хүнийг анагаах эмчилгээний олон шинэ арга нээгдэнэ.

- Оросын эмч доктор Цзян “биотрон” хэмээгч нэгэн төхөөрөмжийг зохиосон. Үүгээр амьтан, ургамлын амин оронг нэмэгдүүлж, түүнийхээ тусламжтайгаар өвчтнийг эмчилж эхэлсэн байна. Эмчилгээний үр дүн нь нэлээд найдвар төрүүлэхүйц болсон. Энэ нь таны зорьж буй ирээдүйн анагаах ухааны эмчилгээний гэх арга зам мөн үү гэж би асуув.

- Хүний сэтгэлээр дамжуулж хүнийг эмчлэх нь ирээдүйн анагаах ухаан төдийгүй бас эртний анагаах ухаан юм,- гэж Бумба-лам хэлээд,- Төвдөд харамсалтайгаар орхиод ирсэн Бумбын ном судраас эртний эмчилгээний гайхамшигт аргуудын тухай олон баримт олж болно. Одоогийн материаллаг ертөнцийн хөгжлийн оргил үед ч тэр ихээхэн үүрэг гүйцэтгэж болох сэтгэлийн хөгжлийн талаарх эртний сургаалиудыг үгүйсгэн гээх хэрэггүй юм.

- Би таныг бүрэн дүүрэн ойлгож байна, хүндэт Бумба-лам минь,- гэж би хэлээд,- Дорнын шашинтан та нар, хүн төрөлхтний амьдралд ариун дээд үүргийг гүйцэтгэж байгаа билээ. Дорныхны зүгээс гаргасан хүчин чармайлт байгаагүй бол шинжлэх ухааны сэрэл мэдрэмжийн замыг үгүйсгэн өөрсдийгөө бурхан мэт боддог хуучны үзэлт барууны эрдэмтэд хүн төрөлхтний сэтгэлийн ертөнцийн хөгжлийг ухраан, шинжлэх ухаанд засагдашгүй хор хөнөөл учруулах байсан биз ээ. Биологийн болон сэтгэлийн энергитэй холбоотой технологийн хөгжилд маш их ирээдүй байгаа бөгөөд тун удахгүй Дорны улсууд энэ чиглэлд тэргүүлнэ гэдэгт би итгэлтэй байна.

- Манай АНУ-д сэтгэлийн ертөнцийг судлах нь маш их шүүмжлэлд өртдөг учир энэ талаар судалгаа хийдэг хүн тун цөөхөн байдаг. Тэр цөөхөн хүмүүсийн нэг хэсэг нь бид гэж америк эр дуугарав.

- Одоогоор зөвхөн зарим Гэгээрсэн хүн л Ертөнцийн Мэдээллийн Оронд холбогдох чадвартай байдаг бол хүн төрөлхтний сэтгэлийн ертөнц хөгжихөд бүгд ийм чадвартай болно. Магадгүй, “SoHm”-ын зарчим эвдэгдэх ч юм бил үү. Тэгвэл манай соёл иргэншил ч мөн адил Ертөнцийн Мэдээллийн Оронд холбогдон, тэндээс мэдээлэл хүлээж авах боломжтой болно. Нээрээ, “SoHm”-ын зарчмыг Бумбын шашинд юу гэж үздэг вэ?

- “SoHm”-ын зарчмын талаар Бумбын шашинд зарим нэг баримт бий ч индуист шашинд үүний тухай дэлгэрэнгүй бичсэн байдаг.- гэж Бумба-лам хариулаад, – Хүний амьдрал дахь сэтгэлийн хүчин зүйлийн үүргийн тухайд гэвэл энэ нь түүхэн хөгжлийн явцад батлагдсан бөгөөд Бумбын шашнаар бол хүн сүнс нягтрах замаар үүссэн матери хоёрдогч болж байгаа биз.

*Энэ талаар Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 143-р хуудас) номонд “Хүн хамгийн эхлээд гэрэлтгэгч дүрсгүй нэгэн хэлбэр мэт үүсэн, үүний дээр бодит хэлбэр нь үүсчээ...” гэж бичсэн байна.*

- Эрхэм Бумба лам минь! Дэлхий дээр урьд өмнө оршин тогтнож байсан өмнөх иргэншлийн хүмүүсийн тухай ямар нэгэн баримт эртний Бумбын шашинд байдаг уу гэж би асуув.

- Өмнөх иргэншлийн хүмүүсийн тухай баримтууд бумбын шашинд маш олон байдаг,- гэж Бумба-лам хариулаад,- Эрт дээр үеэс уламжлагдан ирсэн өмнөх иргэншлүүдийн хүмүүсийн амьдралын тухай бичсэн бүхэл бүтэн том том боть байдаг. Манай соёл иргэншил Төвдэд яаж үүссэнийг маш дэлгэрэнгүй бичсэн байдаг. Эдгээр номоос үзвэл манай өмнөх соёл иргэншил буюу Баруунд атлантын соёл иргэншил хэмээн нэрлэдэг хүмүүс сэтгэлийн энергийг эзэмшсэний үндсэн дээр гайхамшигтай технологиудыг бий болгон асар өндөр хөгжилд хүрсэн соёл иргэншилтэй байжээ. Харамсалтай нь нарийн зүйлүүдийг нь санахгүй байна.

- Уучлаарай, танд энэ номнууд чинь одоо байгаа юу?

- Үгүй, Төвдөд үлдсэн. Устгачихсан байх гэж айж байна гэж Бумба лам гунигтайгаар өгүүлэв.

- Арай дэндүү юм болжээ! гэж америк эр нэмэрлэв.

- Ямар ч байсан манай соёл иргэншлийн хүмүүс хэнээс үүссэнийг хэлээд өгөөч гэж би асуув.

- Өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчуудаас үүссэн. Би Бумбын номоос энэ тухай уншсанаа маш сайн санаж байна гэж Бумба лам хариулав.

- Дорнын шашны номонд дүрсэлсэн Буддын дүр төрхөд орчин үеийн хүний дүр төрхтэй таарахгүй зүйл маш их байдаг. Будда тэгвэл самадигаас гарсан өмнөх иргэншлийн хүн юм биш үү? – гэж би асуув.

- 2044 жилийн өмнө дэлхий дээр ирсэн Будда үнэхээр жирийн хүн шиг харагддаггүй байжээ. Шашны бүх төрлийн номонд түүнийг 32 онцлогтой буюу орчин үеийн хүнээс 32 онцгой шинжээр ялгардаг гэж бичсэн байдаг. Гэхдээ түүний онцлог шинж бүр нь удамшиж ирээгүй бөгөөд түүний сэтгэлийн дасгалаас үүдэлтэй, - гэж Бумба лам хэлэв.

- Тайлбарлаад өгөөч!

- Энэ бол дорно дахинд ихэд тархсан цогц ойлголт юм.

- Ийм нэрийн дор Дорны их нууц хадгалаастай байдгийг би ойлгож байна л даа. Хүн төрөлхтөний эргэн амьдрах хүчин зүйл болохынхоо хувьд самади бол тэдгээр нууцын нэг. Хэдэн мянга, сая жилээр агуйд хадгалагдсан эртний хүмүүсийн шилдэг хэсэг дахин төрж дэлхий дээр хүн төрөлхтнийг үүсгэх юм. Мөн бий болсон соёл иргэншлийн үед эдгээр эртний хүмүүс нь самадигаас Гэгээнтэн хутагт хувилгаадын дүрээр тодрон гарч уг соёл иргэншлийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж өгч болно. Тийм учраас бидний таамагласан атлантын дүртэй тун ч төстэй ер бусын дүр төрхтэй Будда дэлхийн энэ буланг соён гэгээрүүлэхийн тулд самадигаас гарсан сүүлийн атлантчуудын нэг байж болох талтай. Сэтгэлийн энергид үйлчлэх атлантчуудын мэдлэг нь хүмүүст нөлөөлөхөд нь нэмэр болдог байсан бололтой. Уг дүгнэлтэнд хийсвэр сэтгэлгээний аргаар хүрч болох ба Дорны сургаалиар бол мэдрэмжид үндэслэсэн хийсвэр сэтгэлгээний дүгнэлт нь үргэлж үнэн байдаг гэдэг гэж би хэлэв.

- Таны дүгнэлт чинь зөв байна гэж Бумба-лам хэсэг зуур бодолхийлснээ хариулав. Бумбын шашинд таны хэлсэнтэй дүйх зүйл маш олон байдаг. Бумбын шашин ч мөн адил өнөөгийн хүнтэй харьцуулахад ер бусын дүр төрхтэй дэлхийн анхны Буддагаас үүссэн юм.

- Анхны Буддагийн талаар дэлгэрэнгүй ярьж өгөөч.

- Анхны Будда буюу Бумба - Буддаг Тонпа - Щенраб гэдэг байсан. 18013 жилийн өмнө дэлхий дээр ирсэн. Төвдийн нутаг дахь Шамбалын оронд анх тодорсон ба дэлхий дээр 82 жил амьдраад дараа дараачийн Будда нарын (Гэгээнтнүүд) ашигладаг байсан Аугаа сургаалийг үлдээсэн. Түүний дүр төрхийн

### Анхны Будда

дэлхий дээр

**18 013**

жилийн өмнө заларчээ



### Сүүлийн Будда

дэлхий дээр

**2 044**

жилийн өмнө заларчээ

нарийн дүрслэлийг би санахгүй ч тэрбээр ер бусын дүр төрхтэй байсныг л санаж байна. Бумба-Буддын сургаал 30000 жил үргэлжлэх ёстой бөгөөд 18000 жил өнгөрсөнийг нь тооцох юм бол 12000 жил үлдсэн байна.

- Бумба - Буддын сургааль яагаад заавал 30000 жил үргэлжлэх ёстой гэж?

- Учир нь Дээд сургаалийн хүн төрөлхтөнд үйлчлэх хугацааг 30000 жил гэж Дээд Оюун Ухаан тодорхойлсон юм. 30000 жилийн дараа энэ сургаалийн хүч нь буурдаг. Манай соёл иргэншил маш эрт үүссэн бөгөөд 30000 жил тутам Дээд Сургаал шинэчлэгдэж байх ёстой юм. Үүнээс гадна хүний ямар ч соёл иргэншил үргэлж хөгжил дэвшлийн замаар явдаггүй. Хааяа бүрэн зэрлэгших хүртлээ доройтдог. Тийм учраас тус 30000 жилийн дотор Дээд Сургаалийг шинэчилж хүмүүсийг зөв амьдралд сургах Гэгээнтэн маш олон төрнө,- гэж Бумба-лам хариулав.

*Мөн баримтыг бид Е.П.Блаватскаягийн номноос (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 544-р хуудас): “...Манай тав дахь соёл иргэншил 1000000 орчим жил оршин тогтнож байгаа бөгөөд өмнөх дөрвөн дэд үндэстэн нь 210000 орчим жил амьдарсан.Төрөл үндэстэн бүхэн 30000 орчим жилийн настай байдаг болохоор европчуудын өмнө нэлээд хэдэн арван мянга жилийн нас байна” гэж бичсэнийг олсон юм.*

- 30000 жилийн дараа тэгээд юу болох юм бэ?

- 30000 жилийн дараа Буддын сургааль хүчингүй болох харанхуй үе эхэлнэ.

Харин дараа нь өөр сургаальтай гучин мянган жилийн мөчлөг эхэлнэ.

- Энэ 30000 жилийн хугацаанд хичнээн Гэгээнтэн төрөн гардаг юм бэ?

- Эртний Бумбын шашнаар бол дэлхий дээр 1002 Гэгээнтэн үүснэ гэж Бумба-лам хариулав.

- 2044 жилийн өмнө дэлхий дээр үүссэн Будда хэд дэхь нь байсан юм бэ?

- Би яг нарийн хэлж чадахгүй ч түүнийг Бумба-Буддын шавь байсан гэдгийг хэлж чадна. Дараагийн Будда болох Майдар бурхан ч мөн Бумба Буддын шавь нь байх юм.

- Майдар бурханы тухай би мэднэ. Түүний тухай Рерихийн зураг хүртэл байдаг. Гэхдээ таны ярьсан чинь боломжгүй биш үү? Та Бумба-Буддаг 18013 жилийн өмнө үүсээд дэлхий дээр 82 жил амьдарсан гэж хэлээгүй бил үү, Түүний үхлээс хойш сүүлчийн Будда үүсэх хүртэл 16000 жил өнгөрнө. Тэгэхээр Бумба-Будда яаж түүний багш нь байх юм бэ? –гэж би гайхширав.

- Би Исүс Христ, Моисей, Мухаммед болон бусад Гэгээнтэн бүгдээрээ Бумба-Буддын шавь нар байсан гэдгийг хэлж чадна,- гэж Бумба-лам итгэлтэй нь аргагүй хэлээд, - Тэд бүгд номлолоо эхлэхийнхээ өмнө Төвдөд сурч байсан тухай хөдлөшгүй үнэн баримтууд байдаг.





- Тэд хэнээс сурсан гэж?

- Бумба Буддагийн үүсгэсэн Шамбалын оронд суралцсан. Бумбын Шашинд бол Шамбалыг өөрөөр буюу Олмо-Лунг-Ринг гэж нэрлэдэг. Бумба Буддагийн агуу сургаал Шамбалын орноор дамжин түгдэг.

- Гэгээнтнүүд хэнээс суралцдаг байсан юм бэ?

- Бумба- Буддагийн бодит үхэл ямар ч хамаа байхгүй. Сүнс бол мөнх гэдгийг та нар мэднэ. Сургаал нь 30000 жил үргэлжлэх агуу Бумба-Буддагийн сүнс ч мөн адил мөнх юм. Сэтгэлийн хувьд

Шамбалын оронд очиж үзсэн Гэгээнтнүүд бүгд мөнхийн Бумба Буддагийн шавь нар нь байдаг.

- Шамбалын орны тухай домог яриа европын орнуудад их байдаг, – гэж би хэлээд,- Таны хэлснээс самадид байх хугацаандаа сүнс биеэс тасарч бусад сүнстэй харьцаж, Шамбалын оронд очин суралцсанаар дээд мэргэн ухаан буюу “пражна”-г олж, хүн төрөлхтнийг хөгжил дэвшлийн замд хөтлөхөөр эргэн биедээ ирдэг гээд маш олон хийсвэр дүгнэлт хийж болох нь ээ. Гэхдээ яг одоо Шамбалын орны тухай дэлгэрэнгүй ярихыг хүсэхгүй байна. Энэ сэдвээр хожим эргэн ярилцахыг зөвшөөрнө үү?

- Тэгэлгүй яахав.

- Гэгээнтнүүдийн тухай таны ярьснаас хүн төрөлхтний хөгжлийг ухралтанд оруулж хүнийг зэрлэгшлээс аврахын тулд тэд үе үе дэлхий дээр тодордог гэсэн сэтгэгдэл надад төрлөө. Гэгээнтнүүдийн гадаад төрх янз янз байсан. Жишээ нь Будда орчин үеийн хүнтэй харьцуулахад ер бусын гадаад төрхтэй байсан бол Исүс Христ жирийн хүнтэй адилхан байсан. Буддаг самадигаас гарсан атлант гэж үзэж болох бол Исүс Христийг манай иргэншлийн эрт үеийн самадигаас гарсан хүн гэж таамаглаж болох нь. Тэд хоёул самадид ороход шаардлагатай сэтгэлийн маш өндөр хүчтэй, гэгээнтэн болоход хангалттай өндөр мэдлэгтэй байжээ. Гэгээнтэн болгон өөр өөр шашин үүсгэсэн нь ойлгомжтой. Гэхдээ тэд чинь бүгд л Шамбалын оронд Бумба-Буддагийн шавь болон суралцагсаан. Тэгвэл яагаад шашны ийм олон төрөл байдаг юм бэ? Хүн төрөлхтний түүх шашны дайнаар дүүрэн байдаг шүү дээ.



*Н. К. Перих Майдар (1932)*

- Гэгээнтнүүд Бумба Буддагийн сайн шавь байснаасаа гадна очсон газрынхаа хүмүүсийн амьдралын нөхцөл байдалд тааруулан өөрийн санаагаар үйл ажиллагаагаа явуулдаг хувь хүн байсан юм гэж Бумба лам хариулав.

- Миний бодлоор нэгдмэл нэг шашин байгуулах нь зүйтэй. Бурхан ганцхан шүү дээ, - гэж би хэллээ. - Энэ нь маш хүнд асуудал гэдгийг би мэдэж байна л даа. Гэсэн хэдий ч орчин үед шинжлэх ухааны үндэслэлтэй шашин нь хүнд илүү үйлчлэх болов уу? Шашныг нийгмийн сүүлийн байранд тавьдаггүй АНУ-д хүртэл, - гээд би америкчүүд рүү харав, - жинхэнэ бурхны үүргийг доллар гүйцэтгэж байна. Зах зээлийн эдийн засаг нь хүмүүсийг хөдөлмөрлөхийг шаарддагаараа хөгжингүй боловч материаллаг сайн сайхны төлөө бүхий л аргаа хэрэглэн ухамсар, хүн чанар, ёс зүйгээ гээчихээд байвал нийгэм бүхэлдээ маш том гажуудалд орох болно. Сэтгэлийн хүчин зүйлсээ алдсан нийгэм зайлшгүй мөхөлд хүрэх болно. Гэтэл орчин үеийн хөгжингүй нийгэмд Бурхан, Сүнс байдаг гэдэгт чин сэтгэлээс нь итгүүлж болно гэж үү? Орчин үеийн хүн үлгэрт итгэхгүй л болов уу. Харин шинжлэх ухааны үндэслэлтэй ямар ч зүйл өнөөгийн хүний итгэлийг төрүүлнэ. Тийм учраас би хэдийгээр өнөөгийн шинжлэх ухаан Дээд Оюун Ухааны далайтай харьцуулахад дуслын төдий хэмжээтэй ч орчин үеийн шинжлэх ухааны хөгжлийн түвшинд шашныг тайлбарлах цаг болсон гэж үзэж байна. Ийм судалгааны арга замыг мэдрэмж - хийсвэр сэтгэлгээний арга гэж шашин өөрөө хэлээд өгч байна. Уг аргыг туршилтанд тулгуурладаг эрдэмтэд хүлээж авахдаа муу байдаг боловч орчин үеийн шинжлэх ухаанд хэдийнээ (Эйнштейний

харьцангуй онол, Шиповын бодит вакумын онол зэргээр) өөрийн гэсэн байр сууриа эзэлжээ. Шашныг ийн номлох нь янз бүрийн шашны урсгалуудад итгэх итгэлийг гүнзгийрүүлж, нэгдмэл нэгэн шашин бий болгоход нөлөөлнө. Тэгвэл ямар нэгэн шашныг эрх мэдлээ тогтоон барих, шашны дайн гаргах зэрэгт ашиглах боломжгүй болох юм.

- Та яг зөв ярьж байна,- гэж америк эр хэлээд ширээ алгадав.- Түүхч эрдэмтэд бид ч гэсэн ийм дүгнэлтэд хүрээд хүн төрөлхтний ирээдүйд их санаа зовж байдаг. Гэхдээ бидний зөв гэдгийг хүмүүст батлах их хэцүү байх болно. Маш хэцүү! Бид хэрвээ ямар нэгэн зүйлийг томоохон хэвлэлд нийтлүүлвэл тэр дороо л хэн нэгэн нэртэй эрдэмтэн биднийг баталгаа багатай шашны номлол хэвлүүлээ гэж буруутган шүүмжлэх болно. Шинжлэх ухааны хуучинсаг үзэл Америкт газар авч, бүр шинэ зоригтой судалгааны тоог үлэмж хэмжээгээр багасгахад хүргээд байгаа. Америкийн шинжлэх ухаан одоохондоо бүх дэлхийгээс худалдан авсан оюун ухаан дээр тогтож байгаа ч тэр эрдэмтэд ч ялгаагүй ужгиран хүрээгээ тэлсээр буй хуучинсаг үзлийн дор унтарч байна. Хуучинсаг үзэл шинжлэх ухааныг бутарган хэдийн тодорхой болсон баримтуудыг “дахин боловсруулах”-д хүргэж байна.

- Тэр шинжлэх ухааны хуучинсаг үзэл чинь миний эрдэм шинжилгээний ажлын дэвшилтийг мөн ч их саатуулсан даа! гэж би дуу алдаад,- Орост шинжлэх ухааны хуучинсагууд цөөнгүй шүү! Харамсалтай нь зүсэн бүрийн илбэчин, ид шидтэн, хар домчид бас зүгээргүй сэтгэл мэдрэлийн гажигтай хүмүүс шашин болон оккульт шинжлэх ухааныг ихэд сонирхон, найдваргүй болсон хүмүүсийг үүндээ ашиглан залилан мэхэлж, хуучинсаг үзэлтэнүүдийн гарт зэвсэг атгуулж байна. Шашин судлаач эрдэмтэд ийм сэтгэцийн гажигтай хүмүүсээс хамаагүй өөр гэдгээ ямагт нотолж байх хэрэгтэй болдог.

- Манай Америкт шашин судлаачид өөрсдийгөө мэхлэгч-шидтэнтэй ямар ч хамаагүй гэдгээ шүүхээр батлах тохиолдол ч гарч байсан шүү! –гэж америк эр хэлэв.

- Та нарыг яриаг сонсоод би,- гэж Бумба-лам хэлээд,- шинжлэх ухааны үндэслэлтэй нэгдмэл



«...Шашныг орчин үеийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах цаг болжээ...»

шашин байгуулах санааг зүйтэй гэж бодлоо. Та хоёр, хоёр их гүрний эрдэмтэд, бие биеэ төвөггүй ойлголцож санал зэрэх зүйл гараагүйтэй адил оршин тогтнож буй шашны урсгалууд ч нэгдмэл шашинтай зөрөлдөх зүйлгүй байх ёстой. Бурхан бол ганцхан байдаг.

- Үүнийг сонсоход таатай байна гэж америк эр хэлэв.

- Дэмжсэнд баярлалаа, - гэж би хэлээд, - одоо харин яриагаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө үү? Манай соёл иргэншил үүсээд аль хир хугацаа өнгөрсөн гэж та бодож байна?

- Энэ нэлээд хэцүү асуулт байна. - гэж Бумба-лам хариулаад, - Бумбын номоор бол манай иргэншил маш эрт дээр үед үүссэн. Манай соёл иргэншлийн хүмүүс түрүүчийн соёл иргэншил цэцэглэж байх үед үүссэн гэдгийг мэднэ. Энэ нь ертөнцийн их галав юүлэлтээс өмнөх үе юм. Галав юүлэлтийн үед манай болон өмнөх соёл иргэншлийн ихэнх хүмүүс үхсэн. Дараа нь нэлээд хэдэн удаа манай соёл иргэншил эргээд үүссэн боловч тэр даруйдаа мөхөх юм уу хөгжлийг хангахааргүй зэрлэг омгууд болон хувирч байлаа. Эцэст нь манай соёл иргэншил 18000 жилийн өмнө үүссэн.

*Төстэй баримтыг Е.П.Блаватская номондоо ("Нууц бичээс" 1937, 2-р боть, 495-р хуудас) "аричүүд 200000 жилийн өмнө, анхны Их "Арал" буюу их газар живэх үед оршин тогтнож байсан..."; "...хожуу үеийн арлынхан буюу атлантчуудын дийлэнх нь 850000-700000 жилийн өмнө мөхсөн..." гэж бичжээ.*

- Тэгэхээр галав юүлэх үед сөнөсөн манай соёл иргэншлийг эргэн төрүүлэх хэд хэдэн бүтэлгүй оролдлого гарч байсан байх нь. Самадигаас гарсан хүмүүс манай соёл иргэншлийг дахин үүсгэхийг оролдож байсан бололтой. Тэд азгүй өвгөд дээдэс маань байсан юм байна. 18000 жилийн өмнө л энэ оролдлого амжилтанд хүрч хүн төрөлхтөн хөгжлийн замаар явж эхэлсэн байна. Энэ нь Их Бумба-Будда болон бусад Гэгээнтний мэргэн ухааны үр дүн юм. Тийм биз дээ?

- Таны зөв ...

- Хүн төрөлхтөн дэлхийн бөмбөрцгийн хаана нь үүссэн юм бэ? Би 18000 жилийн өмнөх хүн төрөлхтний үүслийн талаар ярьж байна.

- Төвдөд, - гэж Бумба-лам итгэлтэйгээр хариулаад, - Джума-Тама гэдэг газар үүссэн нь тодорхой.

- Яагаад заавал энэ газар үүссэн гэдэг юм бол?

- Яагаад гэвэл тэндхийн уулнуудад агуй олон байдаг. Тэдгээр агуйнд хүмүүс амьдардаг...

- Амьдардаг?

- Тэд амьд...

- Та самадид байгаа хүн амьд гэж хэлэх гээд байна уу?

- Тийм.

- Тэдэнд хүрэхийг оролдох нь ариун шүтээнээ бузарлахтай адил гэдгийг би мэднэ.- гэж хэлэхэд Бумба-лам,

- Тийм ээ. Үүнээс гадна тэдгээр агуйг олох боломжгүй, хаалттай байдаг. Тэдний тухай зөвхөн Онцгой хүмүүс л мэддэг. Тэд хэнд ч хэлэхгүй. Харин агуйд орсон хүнийг цээрлэл хүлээх болно. Энэ нь аминд аюултай.,- гэв.

- Би ойлголоо... Тийм л байх ёстой...

- Тийм байх хэрэгтэй.

- Ямар ч байсан,- гэж би сонин хөшүүн байдлаас гаран хэлээд,- агуйнуудад манай соёл иргэншлийн хүмүүс болон атлантчууд байж болно гэж таамаглаж болох нь ээ. Атлантчууд яг мөн! Үхлийн аюул авчирдаг тэр хүчийг өөр хэн дуудаж чадах билээ? Атлантчууд биш гэж үү? Тэд чинь л хүний сэтгэлийн энергид нөлөөлөх хүчтэй байсан ба эртний барилгууд болох пирамид зэргийг барьдаг байсан (атлантын зургийг үзүүлтлээ самади болон агуйн талаарх яриаг би хэргээр хойшлуулав.) Таны бодлоор бол египетийн пирамидыг хэн барьсан бэ?

- Египетийн пирамидыг уу? – гээд Бумба-лам бумбын номыг эргэн санаж байгаа бололтой бодлогошров.- Египетийн пирамидыг тархины хүчний тусламжтайгаар барьсан. Тархи нь бидний ашиглаж чадахгүй байгаа асар их хүчийг агуулж байдаг юм.

- Та дөнгөж сая бид тархины хүчийг ашиглаж чаддаггүй гэж хэллээ. Тэгвэл хэн ашиглаж чаддаг байсан юм бэ? Өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчууд уу?- гэж би асуув.

- Эртний номонд манай иргэншлийн өмнөх хүмүүс хөгжил сайтай “гурав дахь нүд”-нийхээ тусламжтайгаар сэтгэлийн энергийг механик энерги болон бусад энергид шилжүүлэх чадвартай байсан тухай дэлгэрэнгүй бичсэн байдаг. Мөн уг номонд тархины хүчний (сэтгэлийн энерги) тусламжтайгаар пирамид барьж буй явц дэлгэрэнгүй бичигдсэн байдаг. Харамсалтай нь би сайн санахгүй байна л даа. Хүмүүс бөөнөөрөө цугларч аварга том чулуунууд руу сэтгэлийн энергээ чиглүүлэн жингүй хөнгөн болгодог байсан шиг санаж байна,- гэж Бумба-лам хэлэв.

- Үүнээс үзэхэд египетийн пирамидыг атлантчууд барьсан болох нь ээ?

- Тийм.

*Е.П.Блаватскаягийн номноос (“Нууц бичээс” 1937, 2р боть, 536, 537-р хуудас) дээр хэлсэний баталгааг олж уншсан юм:”... атлантчуудын соёл иргэншил нь египетийнхээс хөгжлөөрөө давуу байсан.. Чухам тэдний үр удам болох Атлантидын Платоны ард түмэн энэ улсад анхны пирамидуудыг барьсан байна. Энэ нь мэдээж Геродотын нэрлэснээр “Дорны эфиопчууд” буюу Египетийн .(өөрөөр хэлбэл египетийн одоогийн ард түмэн - Э.М.) дайралтаас өмнө болсон юм.”*

- Орчин үеийн ном зохиолд египтийн пирамидыг 4000-5000 жилийн өмнө барьсан гэж үздэг. Таныхаар бол пирамидуудыг хэзээ барьсан бэ гэж би асуув.
- Пирамидууд хамаагүй эрт дээр үед баригдсан гэж Бумба лам хэлэв.

*Үүний нотолгоог бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”1937,2р боть, 540,541-р хуудас) номноос олж уншив. “...Энэ нь Египет уснаас гарсаны дараа, Их Пирамидын Үеэс өмнө болсон юм. Ямар эрт дээр үе вэ... Бид Христийг мэндлэхээс өмнөх 4000-5000 жилийн тэртээ Их Пирамидууд баригдсан гэж боддог байсан. Үнэн хэрэгтээ энэ нь 78000 жилийн өмнө баригдсан юм”.*

- Эртний Египетчүүд ямар хүмүүс байсан юм бэ? Та тэдний талаар ямар нэгэн зүйл мэдэх үү?
- Би энэ талаар их зүйлийг мэдэхгүй. Гэвч тэд бол ямар ч маргаангүй манай иргэншлийн хүмүүс байсан юм.

*Мөн зүйлийн нотолгоог бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937,2-р боть, 540, 541-р хуудас) номноос олж уншив “Менесээс эхэлсэн Египетийн нэн эртний Их гүрний хүмүүс атлантчуудын бүхий л мэдлэгийг эзэмшсэн байсан боловч тэдний судсанд атлантын цус ч байхгүй байлаа...”*

Миний бодлоор эртний египетчүүд манай соёл иргэншлийн хүмүүсийг үүсгэсэн амжилттай оролдлогуудын нэг байсан. Тэднээс холгүй Атлантын далайд Платоны арал дээр сүүлийн атлантчууд амьдарч байсан нь тэдний аз юм. Өндөр хөгжилтэй атлантчуудтай харьцаж байсан нь тэднийг өсөж дэвжиж, хөгжингүй соёл иргэншлээ үүсгэхэд нь нөлөөлсөн байна. Тэд яагаад сөнөсөн юм бэ? Үүнийг хэлж мэдэхгүй юм байна. Нострадамусын болон бусад ном зохиолд бичсэнээр бол Дэлхий Тифоны солиртой мөргөлдөх үед Платоны арал дээрхи сүүлийн атлантчууд сөнөсөн байж магадгүй. Тэдэнтэй цуг эртний Египетчүүд ч мөн сөнөсөн. Эсвэл атлантчуудын хөгжингүй нийгмийн тусламж, удирдамж үгүй болоход тэд аажимдаа зэрлэгшиж эхэлсэн. Эртний Египетчүүд өнөөдөр пирамидын нутагт амьдарч байгаа египетчүүдээс асар их ялгаатай байсан гэж би бодож байна гэхэд,

- Магадгүй л юм. Тун ч магадгүй.
- Эртний египетчүүд атлантчуудын нэгэн адил сэтгэлийн энергийг ашиглаж чаддаг байсан уу?
- Одоо үүнийг хэлэхэд хэцүү байна.

- Ирээдүйд сэтгэлийн энергийг ашиглах бодит аргачлал боловсруулж их пирамид шиг байгууламж босгож чадах болов уу? Та юу гэж бодож байна гэж би асуув.

- Энэ чинь л бүхэлдээ манай шашны зорилт нь болж байгаа юм,- гэж Бумба лам шалавлан хэлээд, - Бид тархины хүч буюу сэтгэлийн энергийг эзэмшихийг зорьж байгаа. Үүний цаана ирээдүй, хүн төрөлхтний хөгжлийн үндэс, хүмүүст агуу хүчин чадлаа харуулж чадахуйц бодит хүч болон хувирах хүн төрөлхтний сэтгэл оюуны их хөгжил оршиж байгаа юм.

- Пирамидууд ямар зорилготой баригдсан гэж та бодож байна вэ?

- Хэмжээ болон санаагаараа агуу эртний энэ байгууламжууд нь хүний сэтгэлийн хүчийг гайхуулах, сэтгэлийн энергийн чадлыг харуулах зорилгоор баригдсан. Өнөөг хүртэл хүн төрөлхтөн адил төстэйг нь ч барьж чадаагүй байна. Агуу пирамидыг хараад л хүний сэтгэлийн хүчний хэмжээлшгүй чадлыг, сүнсний хүчийг өөрийн биеэр мэдрэх болно.

- Зөвхөн сэтгэлийн хүчин чадлыг хүмүүст гайхуулах гэсэндээ пирамидуудыг барьсан гэж бодохгүй байна. – гэж би хэлээд,- Пирамидуудыг барьсан өөр ямар нэгэн шалтгаан байгаа болов уу?

- Одон оронтой холбоотой зорилтын талаар би сайн мэдэхгүй учир ярихаа больё. Харин дэлхийн өнцөг булан бүрт пирамидуудыг мэргэн оюуныг хадгалах зорилгоор барьсныг л мэднэ.

- Тайлбарлаад өгөөч!

- Би сэтгэлийн дээд мэргэн ухаан болох пражнагийн талаар ярьж байна.

- Байзаарай, байзаарай! Дорны шашны зүтгэлтнүүд бидэнд сэтгэлийн дээд мэргэн ухаан болох пражнад зөвхөн гүн самадигийн тусламжтайгаар хүрч болно гэж ярьж байсан. Зөвхөн самадигаар л дээд мэргэн ухаанд хүрч болно,- гэж би хэлээд,- Энэ нь пирамидууд агуйн нэгэн адилаар самадид буй хүнийг хадгалах газар болдог гэсэн үг мөн үү?

- Тун ч магадгүй.

- Би Хеопсын пирамид дотор орж, Тутанхамоны биегүй бунханд орж үзсэн юм. Тэндхийн дулаан нь агуйн дулаан, +4 хэмтэй буюу самадид ороход зайлшгүй шаардлагатай хэмтэй ойролцоо байсан. Тутанхамон үхсэн бус, харин самадид байсан юм болов уу?

- Магадгүй л юм.

- Тэгэхээр пирамидууд ч гэсэн хүний генийн санг хадгалах газар болж болох юм байна...



- Пирамидууд онцгой дээд мэргэн ухааныг хадгалахаар баригдсан гэж Бумба лам хэлэв.

- Миний мэдэж байгаагаар онцгой дээд мэргэн ухааныг атлантчууд, тэр тусмаа (ном зохиолд бичсэнээр) эртний атлантчууд эзэмшсэн байсан. Эндээс пирамидуудад зөвхөн манай иргэншлийн хүмүүсээр зогсохгүй мөн атлантчууд ч самадигийн байдалд байж болох нь. Тийм үү?

- Магадгүй л юм. Би сайн мэдэхгүй байна.

*Бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2р боть, 440-р хуудас) номноос мөн зүйлийг уншсан юм. “Гурав дахь иргэншлийн Адепт буюу “Мэргэн” хүмүүс (Лемурчууд, Э.М.), Дөрөв дэхь иргэншлийн хүмүүс (Атлантчууд, Э.М) нь пирамидтай төстэй байгууламжинд газар доор амьдардаг байсан. Дэлхийд дөрвөн өнцөгт пирамид шиг байгууламж байдаг бус уу”*

- Тэгээд яагаад пирамид дотор атлантчуудыг олоогүй юм бол оо? Тутанхамоны хатингар шарилыг л олсон шүү дээ!

- Пирамидуудын талаар би сайн мэдэхгүй байна. Харин Төвдийн агуйнууд дахь Дэлхийн хамгийн эртний хүмүүсийг олоход маш хэцүү. Бараг боломжгүй.

- Яагаад?

- Учир нь тэд газар доор гүнээс гүнд байдаг...

- Тэгвэл тэд чинь пирамидад биш, харин пирамидын доор нь байгаа юм болов уу?

- Магадгүй.

*Мөн зүйлийг бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2р боть, 547-р хуудас) номноос олов. “... Пирамидуудын доор олон янзын хонгил, хоргодох байрыг ер бусын мэдрэмжээрээ ойртон буй үерийн аюулыг мэдэрсэн эртний хүмүүс барьж, үүнийхээ тусламжтайгаар эртний ариун ёс заншлаа хадгалахын тулд өөр өөр газруудад барьсан байдаг...”*

- Самадид буй нэн эртний хүмүүсийг агуйгаас олоход маш хэцүү гэж та хэлсэн. Тэд чулуугаар хаалттай байдаг юм уу?

- Тиймээ.

- Тэд үүдийг нь чулуун хавтангаар хаасан агуйн хонгилд байгаа гэж бодоход “эргэн амь орох” үедээ яаж тэндээсээ гарах юм бэ гэж би асуув.


- Тэдний хувьд чулуу бол саад биш гэж Бумба лам хариулав.



- Атлантууд асар том чулуун хавтангуудаар пирамид барьсны нэгэн ижил таталцалын хүчинд сэтгэлийн энергээрээ нөлөөлж чаддаг байсныг та хэлэх гээд байна уу?

- Тэдний хувьд чулуу бол саад биш...

- Хэн ч агуйнуудад атлантуудыг олоогүй нь одоо л ойлгомжтой боллоо, - гэж би өөрөө өөртөө хэлээд, - Тэд чинь зөвхөн сэтгэлийн энергийн тусламжтайгаар л хөдөлгөж болох чулуун хавтан хаалтаар хамгаалагдсан байдаг юм байна. Бас



*«Чулуу тэдний хувьд саад биш»*

нэгэн асуулт тавихыг зөвшөөрнө үү, - гээд би Бумба-лам руу харан,- Египетийн Сфинксийг хэн барьсан юм бол?

- Мэдэхгүй. Гэхдээ энэ нь бүр эртний үед баригдсан.

*Бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2р боть, 158-р хуудас) номноос нарийн баримтыг олсонгүй.Тэрээр зөвхөн “...Зуун зууны нууц Египетийн Сфинкс!” гэж бичсэн байлаа.*

- Эрхэм хүндэт Бумба лам минь! Би танаас Египетийн пирамидын талаар нэлээд зүйлийг асуулаа. Бид харин одоо Египетэд бус Балбад байна. Би таныг өөрсдийн судалгааны мөн чанартай танилцуулж, нэгэн зүйлийг үзүүлж, самадийн талаар илүү дэлгэрэнгүй ярьж өгөхийг хүсэх гэсэн юм. Одоо хэрвээ таныг дургүйцэхгүй бол хэсэг завсарлаж болохсон болов уу гэж би санал болгов.

Завсарлагааны үеэр манай залуучууд америкчуудтай их л сонирхолтой яриа өрнүүлэн байгаа харагдана. Би тагтан дээр гарч Гималайн уулсын дүр зургийг харан зогслоо. Энэ сүрлэг уулсын нууц сэтгэл догдлуулна. Энд хаа нэгэнтээ нэгэн агуйд дэлхийн агуу нууцын нэг нуугдана. Дэлхийн нөгөө өнцөгт сүндэрлэх их пирамидууд ч мөн л нууцыг хадгалдаг. Эдгээр нь хоорондоо нэгэн зорилгоор нэгдмэл юм. Энэ зорилго бол Хүн Төрөлхтний Генийн Сан. Ийм тодоос тод бодол санаа миний оюун санааг эзэмдэж энэ агуу нууцыг тойрсон болгон ариун дагшин алдартай байдгийг тайлбарлана.

Завсарлагын дараа би атлантын зургийг гарган Бумба ламд үзүүлээд “Энэ хэн бэ? “ гэж асуув.

- Нүд нь надаа танил юм байна,- гэж Бумба лам хариулаад,- харин нүүр нь... Та нар агуйд очсон юм уу?

Би дуугарсангүй.

- Та нарт хамба лам нар ярьж өгөө юу. Эсвэл та нар өөрсдөө олоо юу?

- Энэ бол бидний судалгааны үр дүн юм.

- Ямар судалгааны?

Бид офтальмогеометр гэгч шинэ чиглэл боловсруулснаа ярин Төвд сүмүүд дээрх нүдний зурагнаас эзнийх нь дүр төрхийг тодорхойлсон эрдэм шинжилгээний ажлын тухай яриу.

- Энэ чинь маш сонин юм байна гэж Бумба лам хэлэв.

- Та өөрөө агуйд орж үзсэн үү гэж би Бумба ламаас асуухад,


- Үгүй. Гэхдээ би мэднэ.

- Энэ Буддагийн нүүр, нүд мөн үү?

- Үгүй.

- Тэгээд хэнийх юм бэ?

- Бүр эртний хүнийх. Дээд мэргэн ухаанд хүрсэн бөгөөд Бурхан шиг хүн байсан юм гэж Бумба лам хэлэв.



Гималай

*Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2р боть, 278-р хуудас) номоос бид “... Тэд бодит зүйлсийн болон орон зайн саад гэж байхгүй далдыг харах чадвартай төрдөг. Өөрөөр хэлбэл тэд Попол Вухад бичсэнээр Дөрөв дэх иргэншлийн хүмүүс байсан бөгөөд тэдний хараа нь хязгааргүй, тэд эд зүйлсийг агшин хормын дотор таних чадвартай байсан. Өөрөөр хэлбэл тэд Сүнсний Хаадын их гүрнийг эзэмшигч анхны Лемуро-Атлантчууд буюу Бурхны хүүдүүд байжээ...”*

- Та Елена Блаватскаягийн тухай сонссон уу?

- Сонссон. Тэр бол агуу Гэгээрсэн хүн. Түүний номнууд нь Дорно дахинд маш их дэлгэрсэн.

- Елена Блаватская атлантчууд болон лемурчуудыг дүрслэхдээ лемуро – атлантчуудыг Бурхны Хүүдүүд гэж нэрлэн тэдний хөгжингүй байдал болон мэргэн оюуныг онцгойлон тэмдэглэсэн байдаг. Бид лемурчууд, лемуро-атлантчууд болон атлантчуудын гадаад төрхийн талаар ном зохиолуудыг (юуны түрүүнд Е.П.Блаватская ) шинжилсний дараа твдийн сүмүүд дээрх нүдний дүрснээс эргэн сэргээсэн хүнийг,- гээд би зургаа үзүүлээд,- лемуро-атлант гэсэн урьдчилсан дүгнэлтэнд хүрээд байна. Е.П.Блаватскаягийнхаар бол сүүлийн атлантчууд 850000 жилийн өмнө сөнөсөн бол лемуро-атлантчууд харьцангуй эрт үед буюу ойролцоогоор 1-3 сая жилийн өмнө амьдарч байсан байна. Энэ бүх хугацаанд тэд самадийн байдалд хадгалагдаж чадна гэж үү?

- Гүн самади нь ямар ч урт удаан хугацаагаар үргэлжилж болох юм гэж Бумба лам хэлэв.

- Тэднийг, эдгээр лемуру-атлантыг - гээд би зургаа харуулаад,- одоо хүртэл пирамид болон агуйнуудаас олж болох уу?

Бумба лам намайг анхааралтай гэгч нь хараад дуугарсангүй.

- Тэгвэл нэгэн асуулт тавихыг минь зөвшөөрнө үү?- гээд би мөчөөгөө өгөлгүй үргэлжлүүлэн,- Төвд, Балбын сүмүүд дээрх нүдний эзэн нь энэ мөн үү?- гээд би дахин зургийг заан,- Үүнийг зураачид нь зүгээр л бодож олсон юм болов уу?

- Ариун зүйлс нь хэзээ ч хүний уран сэтгэмжийн үр дагавар байдаггүй гэж Бумба лам хариулав.

- Энэ нүдний дүрсийг эртний ном судраас авсан уу?

- Яг ч тийм биш л дээ...

- Тэгвэл хэн нэг нь агуйд самадийн байдалд байхад нь түүний нүд, нүүрийг харсан юм болов уу?

- Магадгүй.

- Энэтхэгийн нэгэн өндөр цол хэргэмтэй хамба энэ зургийг хармагцаа “Самади!” гэж дуу алдаад, самадид байгаа хүн ингэж харагддаг юм гэж тайлбарлаж өгсөн юм,- гээд үргэлжлүүлэн, -Бумба лам минь! Самадийн тухай дэлгэрэнгүйгээр ярьж өгөөч! –гэж би шалав.

- Миний ойлгосноор бол та нар самадийн тухай сайн мэдэх юм байна. – гэж Бумба-лам хэлээд.- Та нар самадид орохын тулд сэтгэлээ сөрөг энергээс ангижруулах ёстой гэдгийг мэдэх байх. Гүн самадийн үед хүний биеийн бодисын солилцоо тэг хүртэл буурч, бие чулуужсан-хөшингө байдалд орж хэдэн мянга, хэдэн сая жилээр хадгалагдаж болно.

- Хүн төрөлхтний түүхэнд самади ямар үүрэгтэй вэ?

- Самади гэдэг бол хүн төрөлхтний аврал. Учир нь зөвхөн самадийн тусламжтайгаар хүний биеийг олон мянган жилээр хадгалж, хэрэгцээтэй тохиолдолд “амь оруулан” хүн төрөлхтний шинэ соёл иргэншлийг үүсгэх юм гэж Бумба лам хариулав.

- Тэгвэл хэдүүлээ тунгаан бодоцгоё! – гэж би санал болгоод,-Шашин болгон сэтгэлийн хүчин зүйлийн голлох үүргийн талаар номлодог ба хүний хүчин чадал нь биеэс бус харин сэтгэлээс хамаардаг гэж үздэг. Үүнтэй холбоотойгоор биеийг самадийн байдалд хадгалах ямар ч шаардлага байхгүй гэж хэлж болно.



*Бумба лам*

Жишээлэхэд хэрвээ хөгжлийн дээд түвшинд хүрсэн сүнс бүдүүлэг нэгэн биед жишээ нь, зэрлэг хүний биед, орвол энэ сүнс уг хүнийг шинэ соёл иргэншлийн өвөг эцэг болж чадахуйц гайхамшигт хүн болгож чадах уу? Энэ боломжтой юу?

- Үгүй, энэ бол боломжгүй зүйл. Бие, тэр тусмаа уураг тархи асар их үүргийг гүйцэтгэдэг. Самади гэдэг бол хүн төрөлхтний амь аврагдах маш эртний арга юм. Самади нь хүн төрөлхтөн бүрмөсөн сөнөсөн байсан ч дахин төрүүлэх бололцоог олгодог юм. Самадид орж буй хүний бие, ялангуяа уураг тархи нь хөгжлөөрөө сэтгэл оюунтайгаа ижил түвшинд байх ёстой юм гэж Бумба-лам хариулав.

- Үнэхээр ч, - гэж би эхлээд, - хүй нэгдлийн бүдүүлэг хүн гайхамшигтай оюун ухаантай байна гэж төсөөлөхөд ч бэрх юм. Биед орж байгаа сүнс нь ямар нэгэн хэмжээнд өөрийн түвшинд таарсан биеэ сонгох сонголтын эрхтэй байдаг бололтой. Тархины хөгжил нь онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг юм шиг байна. Учир нь уураг тархи сэтгэлийн болон сүнсний торсын оронг эргүүлж хүчин чадлыг нь илрүүлдэг. Өөрөөр хэлбэл, зэрлэг хүний “торсын орон”-ыг эргүүлэх чадвар сул учраас уураг тархи нь хөгжлийн дээд түвшинд хүрсэн сүнсний хүчин чадалтай нийцдэггүй. Тийм ч учраас өндөр хөгжилтэй соёл иргэншлүүдийн төлөөлөгчдийн биеийг самадийн байдалд хадгалах нь маш чухал ач холбогдолтой юм байна.

- Түүнээс гадна, - гэж Бумба лам нэмээд, - бодит ертөнцийг Үүсгэгч нь хүний биеийг эволюцын он удаан хугацааны турш сүнс нягтруулах аргаар үүсгэсэн юм. Гагцхүү ингэж үүссэн төгс төгөлдөр бие махбодь л хүн төрөлхтний шинэ иргэншил үүсэх хүнд хэцүү үеийг даван туулж чадах учраас түүнийг (самадийн байдалд!) хадгалах ёстой юм. Өвчин эмгэгтэй сул биетэй хүн гүн самадид орж чаддаггүйн учир нь түүний бие махбодь нь найдваргүйд байдаг.

*Мөн уг сэдвээр бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 364, 366-р хуудас) номонд “... Ахура Мазда... Бодит ертөнцийн агуу бүтээгчээ! Чи бол ариунаас ариун юм... Түүнд “хаалттай газар” буюу Вара, Арча буюу Хорго барих тушаал өгсний дараа Ахура Мазда Гурван Иргэншлийг бэлэгдэгч Иама буюу Газрын сүнсэнд өгсөн тушаалыг уншигтун.*

*Тэр газар руу (Вара руу) чи Дэлхий дээрх хамгийн сайн сайхан, агуу омгуудаас шилсэн эрс эмс-ийн үрийг авчирч мөн тийшээ бүх төрлийн мал адуус зэргийн үр тус бүрээс хоёр хоёрыг авчран эдгээр хүмүүс Варад очтол хадгалах хэрэгтэй...” гэжээ.*

- Самадигаас гарсан хүн аав, ээж болж, үр удмаа үлдээж чадах уу гэж би асуув.

- Чадалгүй яах вэ. Төвдөд самадид ороод хэдэн жилийн дараа сэргэсэн хүмүүс (ёгчид) хүүхэдтэй болж байсан тохиолдлууд байдаг гэж Бумба лам хариулав.

- Эрт дээр үеийн хүмүүс хүний болон амьтдын үрийг хадгалж, хиймлээр үр тогтоох болон өсгөх нууцыг мэддэг байсан болов уу? Энэ нь уг нь байх ёстой зүйл юм. Учир нь хүн төрөлхтөн үүсэн бий болох үедээ мал адгуусаар дутагдах болно. Харин үхэр самадид байна гэж төсөөлөгдөхгүй л байна.

- Би үүнийг сайн мэдэхгүй байна,- гэж Бумба-лам хэлээд,- тэд манай соёл иргэншлээс илүү хөгжилтэй байсныг нь л мэднэ.

- Хүндэт Бумба лам минь! Та самадиг хүн төрөлхтний авралын эртний арга зам гэж хэлсэн. Харин Е.Блаватскаягийнхаар бол самади буюу "Вара" нь хүн төрөлхтний сүүлийн гурван иргэншлийг хамгаалах үүрэгтэй бүтээгдсэн. Тэдний хамгийн эртний иргэншил болох лемурчууд, мөн лемуро-атлантчууд нь хэдэн сая жилийн өмнө амьдарч байсан. Лемуро-атлантчууд эсвэл лемурчууд хүн төрөлхтний генийн сангийн нэгэн хэсэг болж одоо хүртэл агуйнуудад байсаар байдаг юм гэж үү?

- Байдаг гэж бодож байна.

- Үүнээс үүдээд, эрхэм Бумба лам минь,- гээд би үргэлжлүүлэн,- Төвдийн сүмүүд дээр дүрслэгдсэн нүдний зургийн эзэн нь маш эртний хүн (магадгүй лемуро-атлант) бөгөөд түүнийг хэн нэгэн харсан байх ёстой. Нэн эртний тэр хүнийг агуйд бодитоор нь одоо ч гэсэн харж болно гэж үү? Хүн төрөлхтний генийн санг хамгаалагч систем ажиллахгүй юм гэж үү?

- Түүнийг олж харахын тулд зөвшөөрөлтэй байх ёстой.

- Ямар зөвшөөрөлтэй? Хэн тэр зөвшөөрлийг өгдөг хэрэг вэ?

- ...Самадид байгаа хүмүүс.

- Юу? Тэдгээр хүмүүс чинь хадгалагдсан байдалд байгаа шүү дээ!

- Самадид байгаа хүн бол амьд хүн.

- Самадид байгаа хүн ярьж чаддаг гэж үү?

- Самадид байгаа хүнтэй харьцахын тулд ярих албагүй. Түүний тулд чинь л бясалгал байдаг, сүнс байдаг юм гэж Бумба-лам хариулав.

- Хэрвээ би таныг зөв ойлгосон бол,- гээд би,- бясалгалын үед хүний сүнс "биен тушаа"-наасаа гарч самадид байгаа хүний сүнсстэй харьцдаг.

- Та зөв ярьж байна.

- Самадид байгаа хүнтэй харьцаж чаддаг хүмүүс одоо байдаг уу?

- Байдаг.

"Тэд чинь ямар хүмүүс юм бэ? Тэдэнтэй уулзаж болох уу?" гэж би асуумаар санагдсан боловч энэ хоёр улсад ийм хүмүүс зөндөө байдаг болохоор Бумба лам үүнийг хэлэхгүйг ухаараад би цагаа олж зогсов.

- Хүн төрөлхтнийг Төвдөд үүссэн гэж та хэлсэн. Тэгэхээр Төвд Гималай хоёр хүн төрөлхтний Генийн сангийн төв нь гэж хэлж болох уу? Өөрөөр хэлбэл самадид байгаа хүн энэ бүс нутагт л байдаг гэж үзэж болох уу?

- Самади гэдэг бол нийт хүн төрөлхтнийг хамарсан үзэгдэл. Тийм учраас дэлхийн бөмбөрцгийн аль ч хэсэгт, тэр дундаа тэнгис далайд ч тэр самадид

байгаа хүмүүс байж болох юм. Гэсэн ч дийлэнх нь Гималай болон Төвдөд байдаг гэж Бумба лам хариулав.

- Яагаад заавал Гималай болон Төвдөд төвлөрсөн байдаг юм бэ? Энэ нь дэлхий бөмбөрцөгт галав юүлэх үед уснаас ил гарах хамгийн өндөрлөг газар учраас уу?

- Тийм ээ. Гималай болон Төвд өндөр уулсын орон гэдэг нь нэг шалтгаан нь мөн. Гэсэн ч зөвхөн энэ ч бус...

*Самадид байгаа хүмүүсийг голдуу өндөр уулсын оронд байдаг гэдгийн шууд бус нотолгоог Е.П.Блаватская ("Нууц бичээс" 1937, 2-р боть, 556, 557-р хуудас) "... Мэргэн Оюуны Дээд багш нараас гадна үүнийг (хүн төрөлхтний түүхийг) мэддэг хүмүүс уг асуудлын талаар тэдний дээр сүндэрлэх цаст оргил адил дуугаа хураана..." гэж бичжээ.*

- Өөр нэг шалтгаан нь юу вэ?

- Манай шашинд Хойд туйлыг бурхдын буудал гэж үздэг. Харин эрт дээр үед Гималай болон Төвд нь Дэлхийн туйл байсан юм гэж Бумба лам хариулав.

*Мөн энэ талаар бид Е.П.Блаватскаягийн ("Нууц бичээс" 1937, 2-р боть, 365-р хуудас) номноос дараах зүйлийг олж уншсан. "Бүтээгдсэн болон эс бүтээгдсэн гэх соён гэгээрүүлэгчид байдаг.Тэнд ("Вара" баригдаж буй Арьяна-Ваэдждо) од, сар, нар бүгд жилд нэгэн удаа гийж, нэг жил нь нэгэн өдөр мэт байдаг. Энэ нь "Бурхдын орон" буюу одоогийн Туйлын нутгийн шинж тэмдэг юм... Эртний номлолоор бол Дэлхийн тэнхлэг гай гамшигтай харьцангуйгаар шилжиж байдаг."*

- Нэгэн нэртэй зохиолд Говийг мөн хүний үүслийн өлгий гэж бичсэн байдаг. Та Говийн талаар юу мэдэх вэ? Тэнд ч гэсэн самадид буй хүмүүс байдаг юм болов уу?- гэж би асуув.

- Би Говийн талаар сайн мэдэхгүй юм байна. Магадгүй л юм. Тэр чинь Төвдтэй тун ойрхон байдаг шүү дээ гэж Бумба лам хариулав.

*Ямартаа ч бид Е.П.Блаватскаягийн номон дээр атлантчууд самадийн байдалд Говьд ч мөн байж болох тухай зарим нэгэн баримтыг олсон юм.*

*("Нууц бичээс" 1937, 2-р боть, 446, 8276-р хуудас) "...Ариун арал нүглээс болоод харлаж алга болоход амьд үлдсэн цөөхөн Мөнх хүмүүс Их Говийн элсэн цөлд авралаа олж одоо ч тэндээ Сүнсний Цэргүүдээр хамгаалуулан үл үзэгдэх байдлаар амьдарсаар байгаа..."*

“... Адам болон түүний эрхэм гэргий Евагаас ч эрт дээр үед одоогийн давст нуур болон амьд амьтангүй элсэн цөл байсан газар Ихэмсэг Гималайн оргил болон түүний баруун хэсгээс Дундад Азиар дайран өнгөрч Хойд нутаг хүртэл үргэлжилсэн дотоод тэнгис байдаг байжээ гэж домог ярианд өгүүлдэг бөгөөд агуу номд (Дзианы ном) ч бичсэн байдаг. Тэр тэнгист дэлхийд хосгүй нэгэн арал байдаг бөгөөд уг арал нь манай иргэншлийн өмнөх Үндэстнээс үлдсэн цөөхөн хүмүүсийн амьдрах газар нь байжээ... Энэ арал нь одоо ч хүний хөлийн мөр гарсан түүхгүй Их Говийн элсэн цөлөөр хүрээлэгдсэн баян бүрд байдлаар оршсоор байдаг...”

- Тэгэхээр бид, - гэж би хэлээд, - тодорхой хэмжээнд итгэлтэйгээр Гималай, Төвд болон Говь нь хүн төрөлхтний Генийн сангийн хадгалагдах үндсэн газрууд болдог гэж таамаглаж болох нь. Харин одоо ямар хүмүүс хүн төрөлхтний Генийн сангийн үүргийг гүйцэтгэж болох талаар эргэн нэг ярьцгаая.

- Тэгье л дээ.

- Өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчууд, бүр лемуро-атлантчууд ч хүн төрөлхтний генийн сангийн үүргийг гүйцэтгэн одоо хүртэл самадийн байдалд байж болох юм. Соёл иргэншлийн залгамжлах дэс дараагаар бол өнөөгийн хүмүүс л хүн төрөлхтний генийн сангийн үүргийг гүйцэтгэх ёстой байтал яагаад манай иргэншлийн хүмүүс л ийм маягийн урт хугацааны самадид байдаггүй юм бэ?

- Манай соёл иргэншлийн хүмүүсийн “билгийн нүд” маш муу хөгжилтэй болохоор урт хугацааны гүн самадид ороход хүндрэлтэй,- гэж Бумба-лам хариулаад,- Дээр үеийн соёл иргэншлийн хүмүүсийн “билгийн нүд” илүү хөгжилтэй байсан болохоор тэд гүн самадид хялбархан ордог байсан.

- Тийм ч учраас танай шашин манай иргэншлийн хүмүүсийн “билгийн нүд”-ийг хөгжүүлэхийг хичээдэг юм байна. Хэрвээ үүнийг хийж чадахгүй бол манай соёл иргэншил устсан тохиолдолд шинэ соёл иргэншлийн эх нь дахиад л атлантчууд юм уу, лемурчууд болох нь ээ?

- Тийм ээ. Гэхдээ шалтгаан нь зөвхөн орчин үед материализмыг хэт дэмжиж байгаагаас бус мөн хүн төрөлхтөн одоогоор Бурхны мөчлөгийн бодит (материаллаг) үе шатанд оршиж байгаатай холбоотой.

*Төстэй баримтыг бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 228,376,377-р хуудас) номоос олсон юм.”...Эволюц нь Мөчлөгийн хэлбэрээр явагддаг. Долоон Үет Их Манвантрын Мөчлөг нь Эхний Үедээ эрдэс бодис, амьтан ургамлаас эхлээд мөчлөгөө уруудагч муруйн дагуу дөрөв дэх үеийн төгсгөл хэсэгт дөрөв дэх иргэншлийн дунд мухар цэгт хүрдэг. Уруудагч муруйн дагуу хийсвэр юм болгон аажимдаа материаллаг байдалд*



*шилждэг. Голын шугаманд нь материаллаг болон хийсвэр ертөнц тэнцдэг бол өгсөгч муруйн дагуу хийсвэр ертөнц дахин хүчээ авч эхэлдэг. Иийм ч учраас манай тав дахь соёл иргэншил голын шугамыг хэдийнээ давсан бөгөөд хийсвэр ертөнц хүчээ авч эхэлж байгаа ч манай зарим дэд үндэстэн сүүдэрт уруудагч хэсэгтээ байгаа юм...”*

- Бурхны мөчлөг маргаангүй чухал үүрэгтэй л дээ,- гээд би,- гэхдээ хүмүүсийн самадид орох чадвар нь хүн төрөлхтний гаргасан хүчин чармайлтаас, мөн бясалгалын сургуулиудаас ихээхэн шалтгаалах ёстой.

- Тэгэлгүй яах вэ.- гэж Бумба лам дуу алдаад,- Тийм ч учраас бид энэ чиглэлд ихээхэн чармайлт гаргаж байгаа юм. Түүхэн замналаараа бол “бясалгал-самади-пражна”-гийн сургууль нь аажимдаа суларч өнөө үеийн хүмүүсээс ганц нэг нь л гүн самадид орж чадахуйц болсон. Хэдийгээр Бурхны мөчлөгөөр материаллаг ертөнц өсөж байсан ч манай соёл иргэншлийн эртний хүмүүс гүн самадид илүү хялбархан орж чаддаг байсан. Өмнөх иргэншилд

ч мөн адил материаллаг эд баялгийн сүр хүч нэмэгдэж, энэ талын ололт амжилт ч чамгүй их байсан боловч тэд бясалгал болон самадийн сургуулиудыг ариун чанадаар хайрлан хамгаалсаар байсан юм.

- Химийн бодисыг ч юм уу ашиглан биеийг хиймлээр хадгалах буюу самадид оруулж эргээн амьдруулах боломжтой юу?

- Самадид гол нь хүний сэтгэлийн хүчин зүйл байдаг учир энэ нь боломжгүй зүйл гэж бодож байна.

- Түүхэнд хиймлээр самадид орох оролдлогууд гарч байсан уу?

- Яг сайн санахгүй байна. Байсан байх аа...

- Өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчууд өвддөг байсан уу?

- Манай шашны баримтаар бол бурхан манай иргэншлийн хүнийг гэсгээн өвчин зовлон илгээсэн гэдэг. Түрүүчийн иргэншлийн хүмүүс эрүүл аз жаргалтай байсан.



*Энэ тухай баримтыг бид мөн л Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 514, 515-р хуудас) номоос оллоо: “...Кармын Хууль*

*атлантчуудын үндэстнийг шийтгэн физиологи, ёс зүй, оюун ухаан, болон биеийн тал дээр Гуравдугаар Үндэстний үед амьд болгоны хаан байлгаснаа манай Тав дахь иргэншлийн үед биеийн болон удмын өвчний үүр болсон хөөрхийлөлтэй амьтан болгон хувиргасан юм.*

- Яагаад би танаас өвчин эмгэгийн талаар асуух болсон бэ?- гэвэл,- самадид зөвхөн бие болон сэтгэлээрээ эв эрүүл л хүн орж болох нь тодорхой. Таны ярьснаас мөн ном зохиолоос үзэхэд өмнөх иргэншлийн хүмүүс хамаагүй эрүүл байсан ба манай соёл иргэншлийн хүмүүсээс цоо эрүүл хүнийг олоход нэн хэцүү. Тэгэхээр хэрвээ бид самадид буй хүмүүстэй агуй руу орлоо гэж бодоход (уран

зөгнөл байг л дээ) тэнд зөвхөн өмнөх соёл иргэншлийн хүмүүс болох атлантчууд юм уу, лемуро-атлантчуудыг л олж харна гэсэн үг үү?

- Яг ч тийм биш л дээ. Гүн самадийн байдалд манай иргэншлийн хүмүүс ч мөн байгаа. Манай соёл иргэншил ч мөн маш эрт дээр үеийнх юм гэж Бумба лам хэлэв.

- Манай иргэншлийн хүмүүс хэдийнээс гүн самадид орох болсон юм бэ? Тэд уг байдалдаа аль хир удаж байгаа вэ?

- Газар дэлхий дээрх бараг бүх хүнийг устгасан Их Үерийн үед Дээд Оюун ухаан тэднийг самадид оруулж эхэлсэн юм.

**5 дахь иргэншлийн хүн  
-  
арчаагүй дорой амьтан**



*Энэ талаар бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 158-р хуудас) номоос шууд бус ч баримт олсон юм. “...Энэ нууцын далбаан дор манай Тав дахь Иргэншил нь эртний үнэн мөний бэлэг тэмдгээр ирээдүй хойч үедээ үлдээсэн Шашны Нууцыг эргэн сэргээхээр илгээгдсэн юм”.*

- Е.П.Блаватскаягийнхаар бол их үер нь 850000 жилийн өмнө болсон. Манай соёл иргэншлийн хүмүүс энэ удаан хугацаанд самадид байж чадна гэж үү? – гэж би асуув.

- Яагаад болохгүй гэж гэж Бумба лам сөргөөв.

- 12000 жилийн өмнө Тифон солир Газарт унасны дараа эртний египетчүүдийн төлөөлөгчийг мөн самадид оруулсан уу?

- Би үүнийг мэдэхгүй.

- Их Үерийн үед олон атлантчууд самадид орсон уу?

- Би олон хүмүүсийн тухай ярьж чадахгүй нь. Учир нь самадид зөвхөн дээд, бурханлаг хүмүүс л ордог.

*Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 439-р хуудас) номонд бичигдсэн атлантчуудын өөр өөр бүлэглэлийн хооронд болсон дайны тухай бүлэгт дараах зүйлийг тэмдэглэжээ. “... Бурханлиг номч багш нар нь сүүлчийн аврагч ирэх “Ариун Арал” руу явсан эдгээр Сонгомол хүмүүс л хүн төрөлхтний нэг хэсэг нь нөгөөгөө устгахаас сэргийлж байлаа”.*

- Тэгэхээр хүн төрөлхтний генийн сан лемурчууд (эсвэл лемуро-атлантчууд), атлантчууд болон манай соёл иргэншлийн хүмүүс гэсэн гурван соёл иргэншлийн төлөөлөгчдөөс бүрддэг гэсэн урьдчилсан дүгнэлтэнд хүрч болох нь. Гурвалсан хяналт гэх юм уу даа. Тэднийг агуйгаас олж болох уу? Та юу гэж бодож байна?

- Энэ бол... Том нууц.

- Тэгвэл агуйн тухай ярилцъя,- гэж би санал болгов.- Самадид байгаа хүмүүс агуйд л хадгалагдах ёстой юу?

- Зөвхөн агуйд ч бус, бас усанд ч хадгалагдаж болно.

- Бид одоо байгаа дэлхийн энэ бүс нутагт зөвхөн агуйн тухай л ярьж болно. Самадид байгаа хүн хадгалагдаж болохуйц агуй олон байдаг уу?

- Олон,- гэж Бумба-лам хариулав.

- Тэгээд яагаад одоо хүртэл хэн ч самадид байгаа агуйн хүнийг хараагүй юм бол?

- Харсан.

- Самадид байгаа хүнтэй агуйг олоход хэцүү юу?

- Маш хэцүү. Эдгээр агуйнууд нь хаалттай байдаг ба үүд нь нууц байдалд байдаг.Нөгөө талаас ууланд зөндөө агуй байдаг. Агуйд олон тооны салаа салбартай болохоор агуйгаас ямар нэгэн зүйл олох бараг боломжгүй. Бүр агуйн сүм байдаг ч түүний талаар Онцгой хүмүүсээс өөр хэн ч мэдэхгүй.

*Төстэй баримтыг Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс” 1937, 2-р боть, 272-р хуудас) номонд: “ Хэдийгээр өнө эртний боловч европын хүн бүхэн мэдэх агуйн талаар яриагүй нь ойлгомжтой. Энэ оронд газар доорхи хонгилгүй, тэр хонгил нь эргээд бас өөрийн салаа салбар агуйгүй, ганц ч агуйн сүм байдаггүй нь Энэтхэгийн Гэгээрсэн брами нар болон ялангуяа Ёгчдод ойлгомжтой. Сөнөсөн Атлантид тэр үед байгаагүйг хэн мэдэх вэ?”*

- Агуйн сүм гэж та яг юуг хэлж байна вэ? Буддын сүм доор байдаг агуйг уу, эсвэл газар доорх сүмийг үү?- гэж би асуув.

- Газар доорх сүмийг гэж Бонпо лам хариулав.

- Ямаршуу байдалтай байдаг юм бол?

- ...

- Тэр чинь Шамбалын орон гэгч нь мөн үү?

- ...

- Агуйн сүм болон самадид буй хүнтэй агуйн талаар мэддэг тэр Онцгой хүмүүс чинь хэн юм бэ? Шашны зүтгэлтнүүд үү?

- Заавал шашны зүтгэлтэн байх албагүй...

- Энэ хүмүүс самадид байгаа хүнтэй агуй болон агуйн сүмийн байгаа газрын талаар мэдээллийг хадгалдаг юм уу?

- Тэд тэнд очдог юм!

- Яах гэж?

- Хамгаалдаг...

- Тэд чинь дуганы лам нар юм уу?

- Магадгүй, - тэдний зарим нь ...Дуганыг голдуу лам юм уу, удирдагч гээд нэртэй хүмүүст зориулж барьдаг гэж Бумба лам хариулав.

- Эдгээр Онцгой хүмүүстэй уулзаж болох уу?

- Болно. Гэхдээ нэмэргүй. Тэд бүгдээрээ л танд “Би үүнийг Бурханд ч хэлэхгүй!” гэж хариулна.

- Эдгээр хүмүүсийг худалдаж авах оролдлого гарч байсан уу?

- Гарч байсан байх аа.

- Тэгээд?

- Ямар ч нэмэргүй. Манай хүмүүс, тэр тусмаа тийм Онцгой хүмүүс газрын амьдрал, мөнгө зэргийг Эрхэм Дээдэстэнтэй харьцуулшгүй гэж үздэг. Тэд Заримдаа Түүнийг хардаг! Тэд Түүний эрхэнд захирагддаг! Тэд бол Түүний зарц нар! Онцгой хүмүүсийн хувьд мөнгө авна гэдэг нь шүтээнээ бузарлаж буй зүйл. Тэр ба мөнгө гэдэг чинь хоорондоо харьцуулашгүй зүйлс!

- Би таныг ойлгож байна. Маш сайн ойлгож байна,- гэж би сэтгэл хөдлөн хэлээд,- америкчууд ч юм уу европчууд мөнгөөр бүхнийг худалдаж авч болдог гэж боддог. Гэхдээ энэ нь мөнхийн амьдрал, хүн төрөлхтний генийн сан зэрэгтэй харьцуулах юм бол юу ч биш. Мөнгө санал болгох нь хүртэл бузар явдал!

- Тиймээ, яг зөв, – гэж Бумба лам хариулаад,- Онцгой хүмүүс үүнийг маш сайн ойлгодог. Газар дэлхий дээрх амьдрал гэж юу юм бэ? Энэ бол нэгэн агшин, нэгэн хором. Мөнгөнөөс болж ... болно гэж үү?Тэгвэл энэ нь дааж давшгүй их нүгэл болно!

- Эрхэм Бумба лам минь, хэрвээ Онцгой хүмүүс дотор хэн нэгэн ухамсар доогуур таарч, тангаргаа зөрчвөл юу болох вэ, хэлээч? Хэрвээ тэр хэн нэгнийг агуй руу оруулвал яах вэ?

- Тэгвэл тэр алуурчин болно.

- Алуурчин? Хэний?

- Агуйд орох хаалгыг заалгаж, агуй руу орсон хүнийг үхэл хүлээж байгаа. Түүнд үүдийг нь зааж өгсөн хүн түүнийг үхэл рүү илгээсэн болно!

- Ер бусын хүчний үйлчлэл байдгийг би ойлгож байна...Орох эрхийг зөвхөн Тэр өгч чадна...

- Анхааралтай сонсоод тогтоож авцгаа,- гэж Бумба-лам хэлээд,- Онцгой хүмүүс гэдэг бол Түүний зарц төдий л хүмүүс. Бүхнийг зөвхөн Тэр шийддэг! Орох эрхийг ч мөн зөвхөн Тэр л өгдөг!

- Түүнтэй холбоо тогтоож болох уу?

- ...

- Гэсэн ч,- гээд би хачин хөшүүн байдлаасаа салан,- түүх гэдэг чинь санамсаргүй тохиолдлоор дүүрэн байдаг. Ямар нэгэн шалтгаанаар “Орох эрх”-ийн зарчим зөрчигддөг тохиолдлууд түүхэнд бишгүй л байсан байлгүй. Санамсаргүй зүйл огт тохиолдож байгаагүй гэх боломжгүй шүү дээ! Ийм явдал тохиолдож байв уу?

- Байсан. Бүр нэг биш удаа.

- Боломжтой бол энэ талаараа ярьж өгөөч!

- Энэ сэдвээр маш олон янзын домог яриа байдаг,- гэж Бумба-лам яриагаа эхлээд,- Жишээ нь, ийм нэгэн түүх домог болон яригддаг юм. CI-р зуунд Энэтхэгт аймшигт ган болсон юм. Энэтхэгийн удирдагч Агуу хүчит эртний хүн байсан Ариун агуу руу орж, түүнээс тусламж хүсэхээр шийджээ. Агуйд жинхэнэ болоод хий могойнууд, түүний бие болон сэтгэлд нь ямар нэгэн хүчин\* алсаас нөлөөлж амьсгал нь боогдох зэрэг янз бүрийн аюул түүнийг отоож байлаа. Тэгээд Энэтхэгийн удирдагч бясалгал хийн Агуу хүчит эртний хүний сүнстэй харьцахаар шийджээ. Агуу хүчит эртний хүн түүнийг зөвхөн сайн санааны үүднээс ард түмнийхээ төлөө тусламж гуйхаар ирснийг нь ойлгомогцоо орох эрхийг өгчээ. Агуй маш том байсан ба 12 тасалгаанаас тогтсон байв. Энэтхэгийн удирдагч уг агуйн өрөө тасалгаануудын нэгэнд нь сүнс эргэн тойронд эргэлдсэн самадийн байдалд буй Эртний хүн байхыг олжээ. Түүний бие нь хатсан боловч амьд байлаа. Энэ хүн агуйд 1 сая 600 мянган жил байсан ажээ. Тэр нүдээ нээв. Энэтхэгийн удирдагч түүнээс тусламж эрэн санскрит хэлээр ярьж эхэлсэн байна. Хатсан хүн түүнийг ойлгон нүдээрээ дохиж байлаа.Тэрээр хананд өлгөөтэй байгаа нэгэн зүйл рүү нүдээрээ заав. Энэ нь шидэт цагираг байв. Энэтхэгийн удирдагч цагирагыг аван үүд рүү явжээ. Өөр нэгэн тасалгаанд нь тэрээр бас нэгэн самадид буй 5-р зууны үед энэ байдалд орсон сикхуудын удирдагчтай (тэрээр 18-р зуунд эргэн хэвийн амьдралд орсон баримт бий) таарав. Агуйгаас гарах үедээ тэрээр 8 могойтой таарсан байна. Могойнуудын нэг нь шидэт цагираг дээр нь цусаа дусаатал энэ дусал нь

тэнгэр өөд өгсөн удалгүй бороо оржээ. 1637 онд мөн энэ агуй руу Девендра Поундэль гэдэг хүн орсон ба одоо хүртэл тэндээ самадийн байдалд байгаа. Түүнээс хойш энэ агуй руу хэн ч орж байгаагүй.

- Сонирхолтой л түүх байна,- гэж би хэлээд,- Та бидний ярьсантай яг таарч байна.

- Иймэрхүү домог маш олон байдаг гэж Бумба лам хэлэв.

- Домгоос өөр иймэрхүү баримт байдаг уу? Агуйд самадид буй хүнийг харсан хүн байдаг уу?

- Байдаг. Жишээ нь, Хойд Төвдийн нутагт Мозе Сал Дзянг гэдэг хүн самадийн байдалд байдаг. Төвдийн энэ бүс нутгийн шашны зүтгэлтнүүд Онцгой хүмүүс биш боловч үе үе түүнийг хардаг. Зүгээр энгийн хүмүүс хүртэл. Самадид буй энэ хүнээс орох эрх авах шаардлагагүй. Сайн санаатай байхад л хангалттай. Зураг авч, ярьж болохгүй. Энэ нь бузар хэрэг.

- Мозе Сал Дзянг бол хүн төрөлхтөний генийн сангийн төлөөлөгч болох учир ариун гэдгийг нь би ойлгож байна.

- Тийм ээ.

- Гэсэн ч түүнийг үзэж болох болов уу?

- Болно. Хэрвээ Төвдийн тус бүс нутгийн шашны зүтгэлтнүүд зөвшөөрч агуйг зааж өгөх юм бол болно. Гэхдээ...Төвдөд одоо хятадууд байгаа. Шашны тэр зүтгэлтнүүд амьд эсэхийг би сайн мэдэхгүй байна. Бараг л буудуулчихсан байхаа даа. Хятадууд самадид байгаа хүний тухай мэдсэн бол түүнийг шоронд хорьсон эсвэл алсан байх гэж бодож байна хэмээн Бумба лам гунигтай нь аргагүй хэлэв.

- Хятадууд самадид байгаа хүнийг ариун гэгээн гэдгийг нь ойлгодоггүй гэж үү...

- Тэд чинь коммунистууд шүү дээ!

- Хм...Тийм дээ. Би ч өөрөө хуучин коммунист байсан орны хүн. Миний элэнц өвөө мөн л шашны зүтгэлтэн байсны улмаас буудуулсан. Харин өвөө маань шашны зүтгэлтний хүү гээд 13 жил Сталины шоронд хоригдсон. Аав минь хэдийгээр сайн дураараа дайнд явж, Сталинградын дэргэд тулалдаж, одонгоор шагнуулж, герман бөмбөгний 16 хэлтэрхий биедээ зоолгож явсан ч удаан хугацааны турш эсэргүүний хүү гэж ад үзэгдэж явсан гэж би хэлэв.

- 1957 онд Төвдийг хятадууд эзэлснээс хойш голдуу лам, шашны зүтгэлтэн нийлсэн 100 000 хүн эх орноо орхиход хүрсэн. Би ч гэсэн сүм, ном судар хамаг юмаа орхиод наашаа ирсэн,- гэж Бумба лам гашуунаар хэлээд, - 1959 онд 23 настайдаа Далай лам өөрөө Энэтхэг рүү явахаас аргагүй болсон. Хятадууд 1 сая 200 мянган хүнийг алж, сүм дуганыг нурааж,

алтан бурхдыг Хятад руу авч явсан. Хүмүүсийг хөлнөөс нь таазанд дүүжлэн, бөөн бөөнөөр нь шоронд хорьж, тэнд тэр хөөрхий хүмүүс үхэж байлаа. Энэ бол аймшигтай явдал! Төвд чинь хүн төрөлхтний үүссэн өлгий шүү дээ! Төвдийн ард түмэн агуу самадийн тухай мэддэг (уучлаарай, мэддэг байсан), нүдний цөцгий мэт үнэнчээр хамгаалдаг байсан шүү дээ! Төвдийн ард түмний үүрэг эртний, нэн эртний сэтгэлийн үнэт зүйлсийг хадгалахад оршдог! Төвд хүн хүн төрөлхтөнд, хүн төрөлхтний ирээдүйд маш чухал үүрэгтэй!

- Надад хэлэх ч зүйл алга...

- Надад ч мөн адил. Төвдүүд бол түүхэндээ маш дайчин хүмүүс байсан байх. Маш олон газар нутгийг эзэлж явсан,- гээд Бумба лам үргэлжлүүлэн, - 800 гаруй жилийн өмнө гэнэт гэрэл тусаж түүнээс хойш улс төрийн бодлого өөрчлөгдөн, шашныг их хэмжээгээр нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Дайчдын оронд лам нар ихсэж, маш олон зуун сүм дуган баригдаж эхэлжээ. 6000 гаруй сүм дуган байсан. Хятадууд ирэхээс өмнө 6000 дээд цол хэргэмтэй ламтай байсан. Төвдийн айл бүрээс нэг хүү нь үүрд гоонь эр явахаа тангараглаад, лам болохоор явдаг байлаа. Төвдийн шашны гол хөдөлгөгч хүч нь бодь сэтгэл болон гэгээрлийн номлолууд юм. Төвд хүн материаллаг хэрэгцээгээ хамгийн бага анхааран юуны түрүүнд сэтгэл оюунаа дээд зэргээр боловсруулахад суралцдаг. Төвдийн нийт сан хөмрөгийн 75% нь сүм дуганы барилга, шашны боловсрол, гэгээрэл болон байгалийн шинжлэх ухаанд зориулагдаж байлаа. 800 жилийн турш Төвд цэргийн хүчгүй оршсоор ирсэн юм.

- Цэргийн хүчгүй яаж оршин тогтнох вэ?


- Улс орноо хамгаалах арга нь маш энгийн арга байсан. Төвдийн дээд цол хэргэмтэй лам нар дэлхийн түвшинд маш өндөр нэр хүндтэй байсан ба тэд янз бүрийн улс орноос ирсэн, өөр өөрийн улсдаа зохих нэр хүндтэй шавь нартай байснаас хэний ч толгойд багшийнхаа улсыг дайлаар мордох санаа төрж байсангүй. Төвд бол дэлхийн бүх шашны өлгий гэдгийг, Гэгээнтнүүд бүгд энд суралцаж байсныг битгий мартаарай. Бүх мөнгөө шашинд зориулдаг дэлхий дээрх цорын ганц орон бол Төвд гэдгийг битгий мартаарай. Гагцхүү хятадын бурхангүй коммунистууд л Төвдийг гутаан доромжилж байна!

- Одоо бол зөвхөн харамсах, Дэлхийн Хамтын Нийгэмлэг НҮБ-д найдах хоёр үлджээ... Гэсэн ч оройтсон л доо...

- Харин тиймээ...

- Хятадууд самадийн талаар мэдэх үү?

- Хятадын цэргийн нэлээд олон боловсролтой офицер үүнийг ойлгох болсон. Учир нь хятадын цэргийн хөгшин офицерууд хувьсгалаас өмнө



*Н. К. Рерих «Төвдийн өндөрлөг»*

буддизмийн үндсийг суралцдаг байсан ба хүн төрөлхөнд самадийн гүйцэтгэх үүргийг ойлгодог байсан бололтой. Бурхангүй коммунист болсныхоо дараа тэд Агуу Хорон Муу Сүнсний номлогч болж онцгой идэвхитэйгээр бурханы гэсэн болгоныг сүйтгэж эхэлсэн юм. Нөгөө талаас Төвдийн шашны зүтгэлтнүүд үхэхийнхээ өмнө ч ариун болгонд хүүхдийн гэнэн сэтгэлээр итгэж “Миний үхэл бол юу ч биш! Агуйд байгаа хүмүүсийг хамгаалаарай! Тэд хүн төрөлхөнд хэрэгтэй шүү!” гэж хэлдэг байсан. Тэд сайн сайхан ялна гэдэгт эцсээ хүртэл итгэдэг байсан ба муу муухай бодол санааг агуулж болно гэдгийг, муу муухайн сүнс бүхнийг, тэр тусмаа бурхны бүтээсэн болгоныг сүйтгэх хүсэлтэй гэдгийг ойлгоогүй байсан юм гэж Бумба лам хэлэв.

- Тэгээд хятадууд агуйд орж самадид байгаа хүмүүсийг устгаж байсан юм уу?

- Хятадууд самадид буй хүнийг олох хүсэлдээ автан олон агуйг нэгжсэн. Миний бодлоор Агуу Хорон Муу Санаа бурханы гэсэн болгоныг сөнөөх хүсэл нь тэдний хувьд дуудлага болсон юм. Хятадын коммунистууд өөрсдөө үүнийгээ ёгыг эзэмшсэн олон Тавд хүн агуйд орж самадийн байдлаар нуугддаг гэдгээр тайлбарлаж байлаа. Үнэхээр ч маш олон лам нар коммунистуудаас нуугдан агуйд самадид ордог байсан. Миний үеэлийн ярьснаар түүний нэг танил лам 1960 онд ойрхон орших нэгэн агуйд самадид орж 1964 онд тэндээсээ гарчээ. Түүний нөхөд нь энэ тухай мэддэг байсан ба энэ 4 жилийн хугацаанд хэд хэдэн удаа түүнийг харахаар очин, түүнийг



Буддын суудлаар суун чулуун-хөшингө байдалд байна гэсээр ирцгээдэг байлаа. Гэсэн ч хятадын коммунистууд түүнийг олж шоронд хийжээ. Шоронд ламын бие нь аажимдаа зөөлөрсөөр тэр амь орсон байна. Тэгээд түүнийг чанга дэглэмтэй шоронд 1964-1987 оны хооронд хорьж байгаад дараа нь тавьж явуулсан гэсэн. Одоо амьд эсэхийг би мэдэхгүй.

- Тэгэхээр коммунистуудаас зугтаан самадид орохдоо тэр хүн өөрт нь хүрэхийг хориглосон сэтгэлийн хүчний хаалт (ер бусын хүч) хийж чадаагүй гэсэн үг байх нь, – гэж би хэллээ. - Хэдэн зууны турш самадид байгаа Мозе Сал Дзянгийг тухай дээр өгүүлсэн түүх ч тэр сэтгэлийн хүчний хаалт байхгүй байгааг харуулж байна. Үүнээс үүдээд манай иргэншлийн самадид буй хүмүүс ямар нэгэн сэтгэлийн хүчний хаалт хийх чадваргүй бөгөөд зөвхөн өмнөх иргэншлийн сэтгэл оюуны хөгжлөөрөө илүү хүмүүс л самадид байх хугацаандаа өөрийгөө ер бусын хүчээр хамгаалуулж чаддаг гэж хэлж болох уу?

- Тэр ч тийм л дээ. Гэхдээ нэг нөхцөлтэй юм,- гэж Бумба-лам хариулаад, - “Билгийн нүд”-ний хөгжлөөс бүх зүйл шалтгаална. Өмнөх иргэншлүүдийн хүмүүс маш өндөр хөгжилтэй “билгийн нүд”-тэй байсан ба түүнийхээ тусламжтайгаар тэд сэтгэлийн энергээ тодорхой орон зайд тохируулж түүгээрээ чиглүүлэн үйлчилж чадна (“чадна” гэсэн үгийг тэрээр одоо цаг дээр хэрэглэв,- Э.М.). Манай соёл иргэншлийн хүмүүс ихэнхдээ муу хөгжсөн “билгийн нүд”-тэй байдаг учир түүгээрээ сэтгэлийн энергээ өөр зүйл дээр төвлөрүүлж чаддаггүй. Гэхдээ манай соёл иргэншлийн зарим хүмүүс, ялангуяа эртний төлөөлөгчид нь маш сайн хөгжсөн “билгийн нүд”-тэй байдаг учир сэтгэлийн хүчний найдвартай хаалт хийж чаддаг.

- Хамгаалалтын хаалтны мөн чанар нь самади-агуйд орж ирсэн хүнд зайны ховсоор үйлчилдэг гэж ойлголоо. “Орж ирсэн хүний талаар самадид байгаа хүний сүнс яаж мэддэг юм бэ?” гэсэн асуулт тавья. Орчин үеийн физикийн үүднээс тайлбарлавал сүнсний торсын орон эргэн тойрондоо маш өргөн хүрээнд тархдаг. Тийм ч учраас агуйд орж ирж буй хүний торсын орон нь самадид буй хүний торсын оронтой харилцан үйлчлэлцдэг. Мөн сайн санаа бодол нь торсын оронг нэг тал руу нь эргүүлж, сөрөг муу санаа бодол нь нөгөө тал руу нь эргүүлдэг. Үүний үндсэн дээр самадид буй хүний сүнс нь орж ирж буй хүний санаа бодлыг шинжлэх чадвартай байдаг. Шамбалын оронд гагцхүү сайн санаа өвөрлөн орж болно гэж хэлсэн Николай Рерихийн үгийг санацгаая! Гүн самадын байдалд сэтгэлийн сөрөг энергээс буюу сөрөг чиглэлд эргэсэн орноосоо салсны үндсэн дээр л орж болно гэдгийг санацгаая!

- Тийм ээ, таны зөв. Үргэлжлүүлээч гэж Бумба лам хэлэв.


- Тэгэхээр, самадид буй хүний сүнс агуйд орж ирж буй хүний бодол санааг шинжилснийхээ дараа оруулах эсэхээ шийддэг, – гээд би үргэлжлүүлэн,- Муу санаагүй ч зүгээр нэг сониуч зан “орох эрх”-ийг олж авахад хангалтгүй. Үүний тулд, домогт гарсан Энэтхэгийн удирдагч улс орныхоо төлөө бороо гуйж явсан шиг л ноцтой шалтгаантай байх хэрэгтэй. Хүн төрөлхтний генийн сангийн тав тух алдагдаж байгаа шүү дээ! “Орох эрх”-ийг олж авахын тулд эхлээд бясалгалд орж, самадид буй хүний сүнс тэй харьцах хэрэгтэй. Зөвхөн энэ нөхцөлийн дор агуйд орох асар их шаардлагатай л бол “орох эрх”-ийг авч болно.

- Таны зөв,- гэж Бумба лам хэлээд,- Самадид байгаа хүнийг хамгаалдаг Онцгой хүмүүс хүртэл сард 1-2 удаа агуйд орохдоо бясалгал хийж орох зөвшөөрөл авдаг.

- Эрхэм Бумба лам минь, бидэнд орох зөвшөөрөл өгөх болов уу? Бидний санаа бодол цэвэр, зорилт маань хүн төрөлхтний генийн санг судлах. Энэ чинь маш чухал шүү дээ!

- Нэгдүгээрт бясалгал хийж сурах ёстой,- гээд Бумба лам инээмсэглэн,- Үүнд багагүй хугацаа шаардагдах болно. Та нарын хүн төрөлхтний генийн санг судлах зорилт чинь үнэхээр сайхан юм. Та нарт орох зөвшөөрлийг шууд биш ч өгөх байх гэж би бодож байна.

- Эргэцүүллээ үргэлжлүүлэхийг зөвшөөрнө үү?- гэж би асуугаад үргэлжлүүллээ.- Самадид байгаа хүний сүнс орж ирсэн хүнд орох зөвшөөрөл өгөхгүйгээр хамгаалах хаалтыг ажиллуулахаар шийджээ гэж бодоход уг хаалт ямар байх вэ? Самадид буй хүний сүнсний хүчирхэг



*Торсын орнуудын харилцан үйлчлэл*

торсын орон нь орж ирсэн хүний сэтгэлийн орны давтамжинд тааруулснаар аймшиг, түгшүүр, уур хилэн зэрэг элементийн торсыг сөрөг чиглэлд нь эргүүлж, уг хүнийг орох хүсэлгүй болгодог. Муу санаа болон өвчин хоёр сэтгэлд адилхан нөлөөлж хоёул торсын орныг сөрөг чиглэлд нь эргүүлдгийг саная. Тийм учраас орж ирсэн хүн аймшиг түгшүүрээ давж гарч чадсан ч удалгүй өвдөлтийн хүчин зүйлд автаж, самадид байгаа хүний сүнс дахиад жаахан дарамтлах л юм бол үхэх болно. Ийм маягаар агуйг хамгаалах механизм ажилладаг. Би зөв ярьж байна уу?

- Шинжлэх ухааны үүднээс хоёулаа өөр өөр хэлээр ярьж байгаа ч таны зөв гэж би бодож байна гэж Бумба лам хариулав.

- Ийм зүйлсийг хийхэд самадид байгаа хүний сэтгэлийн энерги хангалттай гэж үү?

- Мэдээж! Самадид зөвхөн маш хүчирхэг цэвэрхэн сэтгэлтэй хүн л орж чадна шүү дээ!

- Зайнаас ховсдох аргаар хүчирхэг сэтгэлийн энергитэй нэг хүн 100-500 хүнийг унтуулах чадвартай байдаг гэдгийг нэмж хэлмээр байна. Манай физиологийн багш, профессор Петровский хичээл дээр 300 оюутныг зайнаас ховсдох аргаар бүгдийг нь унтуулж байсныг санаж байна.

- Сэтгэлийн энерги бол маш хүчирхэг гэж Бумба лам хэлэв.

- Хүний сэтгэл болон сүнс чинь тархины торсын оронг эргүүлэх үйл ажиллагаанд үндэслэн ажилладаг гэдэг нь тодорхой. Өөрөөр хэлбэл үүнд тархины үйл ажиллагаанд зарцуулагдах энерги хэрэглэгдэнэ (глюкоз, хүчилтөрөгч, уураг г.м). Самадид байгаа хүний сүнс хаанаас энергээ авдаг юм бэ? Самадийн үед тархи биеийн бусад хэсгийн нэгэн адил үйл ажиллагаагаа бараг зогсоодог биз дээ гэж би асуув.

- Таны асуултанд асуултаар хариулахыг зөвшөөрнө үү?- гэж Бумба лам хариулаад,- Тэгвэл Нөгөө Ертөнц яаж амьдардаг хэрэг вэ? Нөгөө ертөнцөд мөнхийн сүнс болон сэтгэл амьдардаг гэдгийг үгүйсгэхгүй байх гэж бодож байна.

- Мэдээж үгүйсгэхгүй.

- Тэгвэл Нөгөө Ертөнцөд буй сэтгэл, сүнснүүд ямар энергээр үйл ажиллагаагаа явуулдаг юм бэ? Сансрын энергийн тусламжтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг гэсэн ганц хариулт байна. Учир нь сүнс болон сэтгэл сансрын хувьслын явцад макрокосмосоос микрокосмос болох хүн үүсэхэд зэрэг бий болсон юм.

*Мөн зүйлийг бид Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 363-р хуудас) номоос олов: “...тэгэхээр дэлхий дээрх хүн гэдэг бол макрокосмосоос микрокосмос үүссэний үр дүн юм...”*

- За, тэгвэл самадид байгаа хүний сүнс сансрын энергээр хооллодог байх нь ээ гэж би өгүүлэв.

- Тиймээ.

- Самадид байгаа хүний бие рүү сайн санаатай ч бай хүнийг оруулахгүй хамгаалах нь биологийн хувьд ямар ач холбогдолтой юм бэ?

- Самадид байгаа хүний амгалан тайван байдлыг алдагдуулахгүйн тулд. Хэрвээ өөр сүнсний үйлчлэл дор самадид байгаа хүний амгалан тайван байдал алдагдах юм бол самадид байгаа хүний бие зөөлөрч эхэлнэ гэж Бумба лам хариулав.

- Самадид орох үед бие чулуун-хөшингө байдалд ордог нь сэтгэлээ бүр мөсөн сөрөг энергээс чөлөөлөх буюу сүнсний торсын оронг бүр мөсөн тууштайгаар эерэг чиглэлд эргүүлэх аргаар хүний биеийн ус дөрөв дэх хэлбэрт шилждэгтэй холбоотой гэж би ойлгож байна. Өөр хүний сэтгэлийн орон нь эерэг чиглэлд эргэсэн ч бай самадид байгаа хүний сэтгэлийн торсын орны эргэлтийг тэнцвэргүйжүүлдэг. Торсын орны эргэлтийн тэнцвэр алдагдах нь усны дөрөв дэх төлөв байдал алдагдаж, үүнээс үүдээд биений чулуун-хөшингө байдал ч мөн алдагдаж бие нь зөөлрөхөд хүргэдэг. Онцгой хүмүүсийг сонгохдоо самадид байгаа хүмүүсийн торсын оронтой таарах эсэхийг нь харж байж сонгож авдаг гэсэн таамаг төрж байна. Энэ зөв үү?

- Хүн болгон Онцгой хүн болж чадахгүй.- гэж Бонпо-лам хэлээд,-Онцгой хүмүүс агуйд орохдоо бясалгал хийж түүнийг оруулах эсэхийг нь асуудаг.

- Үзэн ядалт нь туйлдаа хүрсэн хэсэг хүн агуйн хамгаалалтын хаалтыг нь даван Сэтгэлийн хүчирхэг энергитэй өмнөх иргэншлийн хүн, жишээ нь атлант байгаа агуйд хүчээр нэвтрэх боломжтой юу? Сөрөг сэтгэлийн энерги, тэр тусмаа олон хүний сөрөг энерги нь эерэг энергийг давж болно биз дээ гэж намайг асуухад,

- Хэрвээ самадид байгаа хүн сэтгэлийн хүч ихтэй бол ингэх нь боломжгүй асуудал. Самади-агуйд орох хүсэлтэй хүмүүсийн тоо энд ямар ч хамаагүй. Хэрвээ өмнөх иргэншлийн хүн нь сэтгэлийн хүчээр тааруу бол энэ нь боломжтой зүйл л дээ. Манай иргэншлийн хүмүүс сэтгэлийн энерги султай учир манай иргэншлийн хүн буй самади-агуйд ороход тийм ч хэцүү биш. Учир нь тэдний сэтгэл оюун нь найдвартай хамгаалалтыг үүсгэж чаддаггүй гэж Бумба лам хариулав.

- Үзэн ядалтаар дүүрэн хүмүүс хамгаалах хаалтыг даван самадид буй өмнөх иргэншлийн хүнийг тойрон бүчвэл уг хүн яах вэ?

- Өмнөх иргэншлийн хүн сөрөг энергийн үйлчлэл доор үхнэ, эсвэл эргэн амь орно гэж Бумба лам хариулав.

- Тэгэхээр , - гээд би үргэлжлүүлэн,- сөрөг чиглэлд эргэсэн торсын орон нь эсвэл самадидын байдлыг бүрмөсөн тэнцвэргүйжүүлж самади дахь хүнийг

үхэлд хүргэнэ, эсвэл самадигаас гарахыг нь идэвхжүүлж самадигаас гаргана.

- Ер нь тийм юм болдог.

- Самадид буй хүмүүстэй агуйн хамгаалах хаалтыг нь даван гарсан түүх байдаг уу?

- Харамсалтай нь Хятадууд Төвдийг эзэлсэнээс хойш ийм тохиолдол нэлээд гарах болсон,- гэж Бумба лам арга ядсан шинжтэй хариулаад,- жишээ нь Умард Төвдийн агуйн нэгэнд хүмүүс таазнаас хүзүүгээрээ дүүжлүүлсэн ер бусын, маш том биетэй хүмүүсийг харсан байна. Үүний өмнөхөн тус агуйгаар хятадын цэргийн хороо дайран өнгөрсөн байжээ.

- Хм...аврага биет атлантчуудыг хятадуудтай тулалдаж байна гэж зөвхөн уран зөгнөлт кинонд л төсөөлж болно,- гэж би урам муутайхан хэлээд,- Тэд чинь өөрсдөө ч үүссэн хүн төрөлхтний генийн санг устгаж байна шүү дээ. Ямар нэг юм хийх хэрэгтэй!!!

- Хагас тэрбум хятадыг яах хэрэгтэй гэж...

- Энэ чинь аймшигтай юм! НҮБ яагаад...

- Гэхдээ,- гээд Бумба ламын нүд нь гэрэлтэн,- агуйн хамгаалалтаас болж хятадууд үхсэн баримт дийлсэнээсээ илүү олон байдаг. Одоо тэд агуй руу орохоосоо айдаг болсон! Тэд ч мөн амьдрахыг хүсэж байгаа! “Соёлын хувьсгал”-ын он жилүүд өнгөрсөн. Эртний хүмүүс хятадуудаас илүү хүчирхэг! Эртний хүмүүс өөрсдийгөө болон хүн төрөлхтнийг хамгаалж чадна! Харин хамгийн эртний хүмүүсийг хятадууд хэзээ ч олохгүй. Тэднийг чулуу хамгаалдаг!

- Та жишээ татан ярьж өгөхгүй юу?

- Мөн л Умард Төвдийн нутаг дахь самади агуйнуудын нэгний үүдэнд нүүр царай нь аймшигийг илтгэн үхсэн хятадын цэргийн бүхэл бүтэн хороо байхыг олсон байна. Тэдний биенд ямар нэгэн шарх, гэмтэл байсангүй, тэднийг эртний хүмүүсийн сүнсний хүч алсан байжээ.

*Энэ талаар Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 466-р хуудас) номонд ийн бичсэн байна: “...тэд (атлантчууд) тэр л газартаа бусад хүн орохоос Дайчин Сүнсний бүхэл бүтэн цэргээр хамгаалуулан одоо хүртэл оршсоор байгаа...”*

- Энэ бол цорын ганц тохиолдол биш гэж бодож байна...

- Ийм жишээ зөндөө байдаг, – гээд Бумба лам үргэлжлүүлэн,- Нутгийн ардууд хэдэн арван хятад цэрэг толгой, гэдэснээсээ барилан орилж

хашгиран гүйж байсныг харсан байна. Солиорсон цэргүүд ар араасаа үхэцгээсэн. Тэд бүгд нууц агуйд орж үзсэн байжээ.

- Хамгийн эртний хүнийг (лемуро-атлантыг) чулуу хамгаалж байдаг гэж та ярьж байсан. Өнөөдрийн ярианаас тэдний биеийг чулуун хавтан хааж байдаг учраас тэднийг агуйд олох боломжгүй гэж би ойлголоо. Үүнээс гадна таны “чулуу бол тэдний хувьд саад биш” гэсэн үгнээс үзвэл тэд самадигаас гарах үедээ сэтгэлийн энергийн тусламжтайгаар таталцлын хүчинд нөлөөлж уг чулууг хөдөлгөж чаддаг байна. Мөн эдгээр сэтгэл оюуны асар өндөр хөгжилт эртний хүмүүс сэтгэлийн хүчээрээ агуйн үүдэнд хамгаалалтын хаалт босгох боломжтой. Тийм үү гэж би асуув.

- Тиймээ, бид энэ тухай ярилцсан.

- Эдгээрээс үзэхэд самадид буй хүнтэй агуйг хамгаалах гурван арга байдаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. Сэтгэлийн энергийн хаалт
2. Чулуун хаалт
3. Агуй руу орох нууц хаалга

- Өөр бас нэгэн зүйлийг бүү мартаарай,- гэж Бумба лам хэлээд,- Самадид буй хүнтэй агуйн байрлал нь дээд зэргийн нууц байдалд байдгийг бүү мартаарай. Үүнд шашны зүтгэлтнүүдийн гавъяа оршино. Энэ тухай бид зөвхөн ёгт үг хэрэглэн ярилцдаг.

- Гэхдээ хятадууд энэ тухай мэдчихсэн биз дээ! Тэд самадийн ариун газрыг бузарлачихсан шүү дээ!

- Нууцыг хадгалах тийм ч амар байгаагүй.

*Үүний тухай Е.П.Блаватская номондоо(“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 158-р хуудас):”Оккульт болон Шашны ёс жаягийг Нэвтэршгүй нууцын хөшгөөр 12000 жилийн тэртээ атлант үндэстний сүүлчийн төлөөлөгч живж үхсэний дараа үл бүтэх хүмүүсийн гарт орж бузарлагдахаас сэргийлэн хамгаалжээ” гэж бичсэн байна.*

- Хүмүүст хүн төрөлхтний Генийн сангийн тухай мэдлэгийг түгээхийн тулд самадийн нууцыг дэлгэх цаг болсон гэж би бодож байна,- гэж хэлэв.- Хүмүүст агуйн байрлал, нэр ус зэргийг дэлгэрэнгүй зааж өгөхгүй нь ойлгомжтой. Гэсэн ч хүмүүс газар дэлхий дээр хүн төрөлхтний Генийн сан байдгийг мэддэг болвол энэ нь их чухал ач холбогдолтой болох юм. Тэгвэл Хятадыг юунд гараа сунгасныг нь бусад улс орнууд мэдмэгцээ хүчтэй нөлөөлж болно. Тэд өөрсдийнхөө элэнц эцэг өвгөдөө доромжлон гар

далайсан шүү дээ! Хятадын төрийн бодлого өөрчлөгдсөн учир Хятадын төр засаг ойлгон ямар нэгэн арга хэмжээ авч болох юм.

- Тиймээ, тийм, таны зөв гэж Бумба лам хариулав.

- Эрхэм Бумба лам минь, хэрвээ бид энэ урт ярианыхаа төгсгөх гэж байгаа бол,- гэж би хэлээд,- самадид буй хүнтэй гурван төрлийн агуй байдаг гэж дүгнэж болно. Үүнд:

1. Манай соёл иргэншлийн хүнтэй самади-агуй.

2. Өмнөх иргэншлийн хүмүүс болох атлант болон лемурот-атлантуудтай самади-агуй (хамтдаа эсвэл тус тусдаа).

3. Манай соёл иргэншлийн болон өмнөх соёл иргэншлийн хүнтэй “холимог” самади агуй.

Миний бодлоор манай соёл иргэншлийн хүмүүс өмнөх иргэншлийн хүний буй самади агуйд орвол сэтгэлийн энергийн найдвартай хамгаалалтанд орох учир ийм агуйд орохыг хүсдэг ч энэ нь тэр бүр бүтдэггүй байх. Холимог самади-агуй нь хүн төрөлхтний генийн сангийн бүрэн бүрэлдэхүүнийг илтгэх учир илүү үнэ цэнэтэй юм.

- Хүн төрөлхтний генийн сан гээд та гоё тодорхойлолт өгчээ гэж Бумба лам хэлэв.

- Эцсийн асуултаа тавихыг зөвшөөрнө үү? Шамбал гэж юу вэ?

- Бид Шамбалын орон байдаг гэдэгт итгэдэг. Энэ зөвхөн цэвэр сэтгэл оюунтан нэвтэрч болох ариун дагшин орон.

- Тэр харав уу! -гэж би дуу алдан,- Шамбалын оронд зөвхөн цэвэр ариун бодол санаатай бол орж болно. Та бидний ярьсанчлан хүн төрөлхтний Генийн санг агуулсан агуй руу ч мөн адил бүрэн цэвэршиж ариуссан оюун санаатайгаар л орж болно. Бичгийн болон аман эх үүсвэрүүдээс үзэхэд хүн төрөлхтний хувьд Шамбалын орон нь маш их ач холбогдолтой. Хүн төрөлхтний

Генийн сангийн үүрэг ач холбогдол ч мөн маргаангүй зүйл. Шамбал нь сэтгэлийн орон. Хүн төрөлхтөний Генийн санг хадгалагч агуйд гол хөдөлгөгч хүч нь хадгалагдаж буй биетэй сүнснүүд юм. Энэ бүхнээс үзэхэд,- гээд би идэвхтэйгээр цааш үргэлжлүүлэн,- хүн төрөлхтний Генийн сангийн оршин буй газрыг (агуйн



*Бумба ламтай хамт*

сүмүүд, агуйнууд, пирамидууд зэрэг) л Шамбалын орон гэж нэрийдэж болох нь ээ.

Бумба лам намайг цоо ширтэнэ. Анир чимээгүй болов.

- Би тантай ганцаараа уулзмаар байх юм гээд би Бумба лам руу харав.

Бид босон арын хаалгаар өөр өрөөнд орцгоолоо. Америк эр мөрөнд минь хүрээд "Good luck!" (Амжилт хүсье!) гэж хэлэв.

Бумба лам бид хоёр юу ярьсан бэ? Энэ асуултанд би самади-агуйд орох эрхтэй Онцгой хүмүүсийн үг болох "Үүнийг би Бурханд ч хэлэхгүй!" гэсэн үгээр хариулна.

Бид Бумба ламтай дотноор тэврэлдэн салах ёс гүйцэтгэв. Венер Гафаров аяархнаар:

- Ямар нэг өөрчлөлт гарах уу гэж асуув.

Би дуугарсангүй. Америк эр бидний араас:

- Good luck!- гэж хашгирсаар үдлээ.



Зургадугаар хэсэг

## Будда гэж хэн байсан бэ?

Дорны улс орнуудын дэлгүүр болгоноос Буддагийн бяцхан баримлыг худалдан авч болно. Гэхдээ үнэ нь маш өндөр. Учир нь энэ орнуудад ирсэн гадаадын хүн болгон дэлхийн бөмбөрцгийн хүн амын тал нь шүтэн биширдэг хүний баримлыг авахыг боддог.

Буддагийн шинж төрхийг барималч зөв гаргаж чадсан гэж итгэх юм бол энэ нь гэнэн хэрэг болно. Бидний уулзсан лам болгон барималч зураачид Буддагийн дүр төрхөд аварга том унжсан чих гэх мэт маш олон гажуудлыг оруулсан гэж ярьж байсан.

**Будда ямар төрхтэй байсан бэ?** Эрдэм шинжилгээний ангиар явахын өмнө шашны номнуудаас бид Буддаг ер бусын дүр төрхтэй гэдгийг мэддэг байсан. Гэвч Буддагийн дүр төрхийн талаархи эртний баримтыг Балбад байхдаа ноён Минээс л олж авсан юм. Эдгээр баримт бусад лам нарын бидэнд хэлсэн түүний онцлог шинжтэй ерөнхийдөө таарч байлаа. Янз бүрийн эх сурвалжаас олж авсан Буддагийн онцлог шинжүүд хоорондоо таарч байсан нь тэдгээрт итгэх үндэслэлийг өгсөн юм.

Эртний эх сурвалжаас үзвэл Будда нь түүний дүр төрхийг тодорхойлдог орчин үеийн хүнээс ялгаатай 32 шинжтэй байжээ. Уншигчдад эдгээр шинжийг мэдэх нь сонин байх болов уу.

1. Мутар өлмий нь хүрдэн тэмдэгт
2. Буддагийн хөлийн өлмий нь яст мэлхийнийх шиг хавтгай, махлаг, зөөлхөн байсан (Өлмий нь яст мэлхий мэт).



*Будда (хөшөө)*

3. Буддагийн хөл гарын хуруунууд нь дундаа хүртэл сарьсан таславчаар холбоотой байсан байна. Гар хөл нь галууных шиг байжээ (Хурууд нь тороор холбогдсон).

4. Буддагийн мутар бойв нь зөөлөн залуу мяраатай байсан.

5. Буддагийн бие нь долоон төвгөр, таван хотгортой байсан. Хоёр төвгөр нь хөлийн уланд, хоёр нь мөрөнд, нэг нь ар дагзанд байдаг байжээ (түүний лагшин нь долоон өндөрт).

6. Буддагийн гар хөлийн хуруунууд нь маш урт байжээ (хуруу урт).
7. Буддагийн өсгий уужим буюу 1/4фут байжээ (өсгий уужим).
8. Будда нь маш гуалиг том биетэй байсан ба түүний биеийг 7 шоогоор хэмждэг бөгөөд бөгтөргүй байжээ (лагшин нь үлэмж бөгөөд шударгуу).
9. Буддагийн хөлийн тойг нь илэрхий бус байжээ.
10. Буддагийн биений үс болгон нь дээш ургадаг байжээ (шар үс нь нижгээд нижгээдчилэн дээш ургасан).
11. Буддагийн хөлийн шилбэ нь Энаяа хэмээх бодь гөрөөснийх шиг гөлгөр шулуун байжээ.
12. Буддагийн мутар нь урт сайхан байсан хийгээд өвдгөндөө хүрдэг байжээ (мутар нь урт бөгөөд үзэсгэлэнтэй).
13. Буддагийн эр бэлэг эрхтэн нь хүлэг морь мэт дотогшоо далдарсан байдаг. Түүнийг олж харах боломжгүй байсан (нууц нь дотогшоо далдарсан).
14. Буддагийн арьс нь алтлаг өнгөтэй байсан. Энэ нь түүний өнгөнөөс болсон бус харин алт мэт цэвэрхэн өнгөлөг байснаас ийнхүү нэрлэжээ (арьс нь алтан өнгөтэй).
15. Буддагийн арьс нь нимгэн зөөлөн байжээ.
16. Буддагийн биений хэсэг бүрт баруун тийш ургадаг нэг ширхэг үс байсан (үс нь нижгээдчилэн зөв эргэсэн).
17. Буддагийн дух нь 6 онцлог шинжтэй үсээр чимэглэгдсэн байлаа. Үүнд: толигор, цагаан, дуулгавартай, 3 кьюбитсээр сунах чадвартай, баруунаас зүүн рүү буржийж үзүүрээрээ дээш харсан хийгээд үс нь бүхэлдээ амбала-жимсийг санагдуулам байжээ (нүүр нь сангийн үсэн чимэгт мэт).
18. Буддагийн цээж нь арслан мэт байсан.
19. Буддагийн мөрний толгой дугариг.
20. Буддагийн цээж нь өргөн бөгөөд мөрнүүд нь хоорондоо хавтгай байжээ (дэлгэр мөрт).
21. Буддагийн хэл нь хий, шар, бадгана гэсэн 3 өвчнөөр өвдөөгүй байсан тул тэрээр амтыг илүү мэдэрдэг байжээ. Нэгэн удаа мөргөлч түүнд эвгүй амт орсон адууны мах өгснийг Будда хэлэн дээрээ тавиад эргүүлэн өгтөл тэр нь хосгүй сайхан амт чанартай болсон байжээ (ам нь амттаны дээдийг амссан мэт).
22. Буддагийн бие нь үндэс, гол, мөчир нь ижил хэмжээтэй Tadrota мод шиг байжээ(лагшин нь нааягорда модон мэт эн тураг сацуу).
23. Буддагийн толгой дээр нар зөв эргүүлэгтэй бөөрөнхий төвгөр байдаг байсан (тэргүүн нь үснэр лүгээ төгөлдөр).
24. Будда чихэндээ төдийгүй үснийхээ захад хүрдэг урт сайхан хэлтэй байжээ (Хэл нь урт бөгөөд үзэсгэлэнтэй).

25. Буддагийн яриа нь 5 онцлогтой байжээ: хүн болгон ойлгодог, бүх яриа нь нэгэн аялгатай, маш гүн гүнзгий бөгөөд хүн бүхэнд тустай, сэтгэл татам уянгалаг байсан ба үгс нь цэвэрхэн, алдаагүй, зөв байсан байна (зарлиг нь эсэруагийн эгшигт).

26. Буддагийн хацар нь бамбагар махлаг байжээ. Хэлбэр нь мөргөлийн толийг санагдуулам (хацар нь арслангийнх мэт).

27. Буддагийн шүд нь цав цагаан байжээ (шүд нь машид цагаан).

28. Буддагийн бүх шүдний урт нь тэнцүүхэн байжээ (шүд нь хэмжээ тэгш).

29. Будда хоорондоо завсаргүй шүдтэй байсан (жигд нягт сайн шүдэт).

30. Будда 40 шүдтэй байжээ (дөчин тоо гүйцэд шүдэт).

31. Буддагийн нүд нь индранил мэт гүн хөх өнгөтэй байсан байна (мэлмий нь хөхөмдөг эрдэнэ мэт).

32. Сормуус нь сүргийн манлай мэт.


Буддагийн онцгой шинж чанарыг төвд сүмүүд дээрх нүдээр бүтээсэн атлантын дүр төрхний онцгой шинжүүдтэй харьцуулж үзье.

	Төвд сүмийн зургаар сэргээсэн атлант	Будда
Толгой	Том	Толгой дээрээ нар зөв эргэсэн эргүүлэг маягийн өндөрлөгтэй, духаа сунах чадвартай цагаан үсээр чимсэн
Нүд	Том, дээд зовхины ер бусын хэлбэр	Гүн хөх өнгөтэй, шулуун цэвэрхэн сормуустай
Хамар	Хавхлаг хэлбэрийн сариа	Энгийн
Хацар	Нүүрний доод хэсэг бүхэлдээ жижигхэн	Бамбагар махлаг
Ам	Жижиг, магадгүй хамрын сүвний босоо завсартай холбоотой.	Энгийн
Шүд	Хэлэхэд хэцүү	Дундаа завсаргүй, цав цагаан 40 шүдтэй
Хэл	Хэлэхэд хэцүү	Чихэндээ болон үсэндээ хүрдэг маш урт хэлтэй
Хүзүү	Маш хүчирхэг, ар дагзны хэсэгтээ ялгарах булчинтай	Толгойн ард хонхорхойтой (энэ нь хүзүүний арын булчингуудын хөгжил сайтайг гэрчилнэ)
Цээж	Маш том	Арслангийнх мэт өргөн
Мөр	Хүчирхэг дугуй	Махлаг дугуй
Гар	Урт, урд ард талын булчингууд дундаа хонхорхойтойгоор ялгардаг	Мөрөндөө хонхорхойтой, өвдгөө хүрсэн урт гартай
Гарын сарвуу	Хүрэн, том	Маш урт, дундаа хүртэл сарьсан

	(магадгүй сарьсан таславчтай байсан байх )	таславчтай урт хуруутай, галууны сарвуутай төстэй
Хөл	Урд, ард талын булчин нь дундаа хонхорхойтой хөгжсөн	Шагайндаа хонхорхойтой
Хөлийн ул	Сэлүүр маягийн	Яст мэлхийн хөл шиг зөөлхөн, хавтгай, бамбагар, гэхдээ төвгөргүй
Бэлэг эрхтэн	Хэлэхэд хэцүү	Морьных шиг далд байдаг, харагдахгүй
Арьс	Толигор	Аптлаг өнгөтэй, нимгэн, толигор
Биеийн өндөр	Маш өндөр	Бие нь гуалиг өндөр, долоон шоогоор хэмжигддэг, бөгтөр биш

**Будда ба төвдийн  
сүмүүд дээр нүдийг нь  
дүрсэлсэн хүн**

Уг хүснэгтээс үзэхэд төвдийн сүмүүд дээрх нүдний зургаар сэргээж дүрсэлсэн хүний дүр төрх маш олон зүйл дээр Буддагийн дүр төрхтэй таарч байгаа юм. Аль алиных нь биений онцлог нь (сэлүүр хэлбэрийн хөл, сарьсан таславчтай гар, усан доор эвэрлэгийг хамгаалах зориулалттай дээд зовхины өвөрмөц нугалаа, удаан хугацаагаар усанд шумбахад зохицсон маш том цээж, сэлэх үед толгойг барьж байх зориулалттай хүчирхэг дагзны булчингууд, хавхлаг хэлбэртэй хамар зэрэг) тэднийг хагас усны амьдралтай байсныг гэрчилнэ.



Сүүлчийн Буддагийн дүр төрхийг Төвдийн сүмүүд дээрх нүдний дүрснээс сэргээсэн хүний төрхтэй харьцуулсан нь

Уг харьцуулалтыг хийсний дараа бидний сэтгэл ямар нэгэн хэмжээнд ханав. Учир нь офтальмогеометрийн болон логик-анатомийн шинжилгээ нь нэгэн ер бусын, Буддаг харсан хүмүүсийн дүрсэлсэн онцлог шинжүүдтэй гадаад төрхөөрөө төстэй хүний дүр төрхийг бүтээхэд хүргэсэн юм. Нөгөө талаас Буддагийн дүр болон нүдний зургаар эргэн сэргээсэн хүний дүр төрхийн хоорондын ялгаа нь анхаарал татаж байна. Юуны түрүүнд энэ нь Буддад сариа хэлбэрийн хамар үгүй юм. Уг эх сурвалжаас авсан баримт нь (төвд сүм дээрх зураг) Буддагийн онцлог шинжүүдэд дурдагдаагүй байна. Үүнээс гадна Буддагийн онцлог шинжид дурдаагүй бас нэгэн зүйл бол дээд зовхины өвөрмөц нугалаа юм.

Үүнээс үүдээд, төвдийн сүмүүд дээрх нүдний зураг бол Буддагийн нүд бус харин өөр нэгэн мөн л өвөрмөц дүр төрхтэй хүний нүдний зураг болох нь тодорхой боллоо. Энэ хэн юм бэ? Уг асуултанд Бумба лам “Энэ бол Буддагаас ч эртний хүний нүд” гэж хариулсныг саная. Энэ бол дэлхийн хамгийн эхний Будда болох Бумба Буддагийн нүд юм болов уу?

Ямартаа ч Будда болон төвдийн сүмүүд дээр нүдийг нь дүрсэлсэн хүний дүр төрхийг орчин үеийн хүнтэй харьцуулж үзэхэд хоёулаа манай соёл иргэншлийн хүмүүс биш байсныг харж болно. Түүхийн эх сурвалжаас үзэхэд манай иргэншлийн хамгийн эртний хүний дүр төрх нь орчин үеийн хүнийхээс ялимгүй ялгаатай байсан байна. Дэлхийн бөмбөрцгийн аль ч хэсэгт амьдарч буй манай иргэншлийн хүний хувьд сэлүүр хэлбэрийн хөл, сарьсан таславч, өвөрмөц нугалаатай том нүд, тэр тусмаа сариа хэлбэрийн хамар нь маш ер бусын зүйл юм. Далайн эрэг орчим амьдардаг хүмүүс далайн хишгийг хүртдэг боловч хэн нь ч хагас усны амьдралаар амьдарч, усан доор тариалангийн талбайг эрхэлдэггүй.

Магадгүй тэд харь гаригийнхан юм болов уу? Гэхдээ энэ нь маш маргаантай асуудал учир шинжлэх ухааны үүднээс энэ тухай ярихад эрт байна. Будда болон сүмүүд дээр дүрслэгдсэн хүмүүс хүн төрөлхтний генийн сан болох самадигаас гарч дэлхий дээр үүссэн өмнөх соёл иргэншлийнхний төлөөлөгчид гэж таамаглах нь илүү дээр байхсан. Уг номонд бичсэн бүхнээс үзэхэд уг таамаг харь гаригийнхны тухай санаанаас илүү үндэслэлтэй.

Будда болон төвд сүмийн ханан дээр нүдийг нь дүрсэлсэн тэр хүн хэн байсан бэ? Тэд самадигаас гарсан уу? Эхээс төрсөн үү? Эдгээр асуултанд хариулахийн тулд бид Буддагийн төрсөн түүхийг сайтар судлах шаардлагатай боллоо. Түвдийн ханан дээр нүдийг нь дүрсэлсэн хүний талаар баримт мэдээлэл бараг байхгүй байсан.

Буддагийн төрсөн түүхийг судлах асуудлыг хэтэрхий ээдрээтэй юм гэдгийг нь бид удалгүй ойлгосон. Ээж аав нь хэн байсныг, ер нь байсан эсэхийг ойлгоход хүндрэлтэй байлаа. Жишээ нь, ноён Мин энэ талаар дараах зүйлийг яриу: “Будда дэлхий дээр төрсөн бөгөөд урьд өмнө нь маш олон удаа гэрлэж явсан. Тэрээр өндөр нуруутай сайхан залуу байсан ба эртний гүн мэдлэгтэй, газар дэлхий

дээр болж байгаа үйл явдлыг маш сайн ойлгодог байжээ”. Ноён түүхч Прадхан: “ Будда эзэн хаан Тару болон Мари авхайн хүү болж Люмбини (Балба) гэдэг газар нуурын усанд мэндэлсэн юм” гэж яриу.

Түүний гарал үүслийн талаарх бусад баримтаар “сүнсний чанартай төрсөн”, “хууль бус гэрлэлтээс гарсан” зэрэг мөн л иймэрхүү шинжтэй байлаа. Өөрөөр хэлбэл ээж аав хоёрынх талаар тодорхой юу ч хэлж болохгүй байв. Зөвхөн ноён Прадханы хэлснээр Буддагийн аав нь тару омгийн хаан байсан гэж таамаглаж болох байлаа.

## Тару омог

Таручууд гэж хэн бэ? Тару омгийн талаар мэдээлэл цуглуулж явахдаа бид Катманду дахь Оросын Соёлын төвийн захирал Владимир Павлович Ивановтай уулзсан юм. Тэрээр Люмбини гэдэг газраас

холгүй өөрсдийгөө тару омгийнхон гэж хэлдэг хүмүүс үнэхээр байдаг гэж яриу. Тэр биднийг тару омгийн түүхийн талаар мэдэх хүнтэй уулзуулж өгөв. Үүнээс гадна тэрээр Люмбинид азийн олон улс орон болон европ АНУ-гийн буддизмийн нийгэмлэгүүдийн ивээн тэтгэлэгээр олон улсын Буддизмын төвийн барилга баригдаж эхэлж байгаа гэж ярьсан юм. Энэ төв нь олон улсын буддистуудын мөргөлийн төв болох юм. Будда нь Индуист шашны кастын ёс дэглэмийн торыг авч хаян бүх дэлхийн хүртээл болгож Буддизмыг үндэслэсэн юм. Буддагаас өмнө индуизм нь зөвхөн кастын хүрээнд тархаж болох байлаа.

Бидэнд тару омгийн талаар ярьж өгсөн хүмүүс нь шашны томоохон зүтгэлтэн, эсвэл эрдэмтэн биш байсан нь тэдний өгсөн мэдээлэл үнэн зөв эсэхэд эргэлзэхэд хүргэж байсан. Гэсэн ч тэдний өгсөн мэдээлэл нь Делийн их сургуулиас бидэнд тохиолдлын чанартай мэдээлэлд болгоомжтой ханд гэж сануулсныг нь мартахад хүргэхүйц сонирхолтой зүйлс байв.

Ойлгомжтой шалтгаанаар нэрийг нь дурьдахыг хүсэхгүй байгаа нэг хүн надаа дараах зүйлийг ярьж өгсөн юм. Тару омгийнхон Гималайн хил дээр ширэнгэн ойд амьдардаг бөгөөд тэдний амьдардаг бүсээс хойд зүгт зарим нэгэн баримтаар манай соёл иргэншлийн хүн төрөлхтөн үүссэн гэгдэх Джумла бүс байдаг. Тару омгийн хүмүүс нь дэлхий дээр халуун хумхын эсрэг дархлаатай цорын ганц хүмүүс гэдгээрээ алдаршсан. Тару омог нь 1 сая орчим хүн амтай бөгөөд тус омог нь энэ нутагтаа 3 мянга гаруй жил амьдарч байгаа гэнэ. Хамгийн сонирхолтой нь таручуудын гадаад төрхний дүрслэл байлаа. Тэд жижигхэн нүүртэй, маш жижигхэн хамар, том цээжтэй, богинохон бүдүүн хүзүүтэй, хөлийн тавхай нь өргөн хавтгай, нумгүй гэж бидэнд тару омгийнхонийг дүрсэлсэн юм. Өөрөөр хэлбэл эдгээр шинжид Буддагийн онцгой шинжүүдээс ямар нэг хэмжээгээр туссан байв.

Бидэнд энэ омгийн хүмүүстэй уулзаж, дээрх дүрслэлийн үнэн зөвийг өөрийн нүдээр харах хүсэл төрсөн нь ойлгомжтой. Хэрвээ энэ нь үнэн гэж батлагдвал тару омгийнхныг дэлхий дээр үлдсэн Буддагийн үр удам гэж хэлж болохоор байлаа.

В.И.Иванов Катманду дахь энэ омгийн цорын ганц эрдэмтэн, профессорыг олж уулзуулав. Найдан хүлээж байсанчлан онцлог гадаад төрхтэй бус жирийн нэгэн дорно зүгийн хүнтэй хүрч ирэхэд нь бидний урам нэлээд хугарав. Харин манай шинжилгээний ангийн хоёр гишүүн Лямбини гэгч газарт очин тару омгийн нэгэн тосгонтой таарч, тэнд бүтцийн судалгаа хийгээд, тару омгийн хүмүүс жирийн л төрхтэй юм гэдгийг баталсан юм.

Бидний цаг зав, мөнгө хөрөнгийг нэлээд үрсэн тару омгийн энэ тохиолдол бидэнд их сургамж боллоо. Шашны өндөр хэргэм зэрэг юм уу, эрдэмтний зарчимч байдлаар өөрийгөө зовоодоггүй ярилцагч нь чиний сонирхолыг дагуулан үнэмшилтэйгээр ярьж эхлэхэд чи өөрийн таамгаа үнэн зөв баталгаатай боллоо гэж баярлаж эхлэдэг. Дараа нь таамагласан бүхэн чинь үнэн болж тараад бүх юм нэг л амархан бүтээд байгаа юм шиг санагдана. Эцэст нь урам хугарч, алдагдсан цаг болон хөрөнгөндөө харамсах болдог. Гэсэн ч алдаа, дахин шалгах болон гуравдагч хяналт нь шинжилгээ судалгааны гол шинж бөгөөд шинжлэх ухааны замнал юм. Хамгийн гол нь баталгаа багатай мэдээллийг шинжилгээний хийсвэр бодролын гинжин хэлхээнд оруулан бодож болохгүй. Үгүй бол хийсвэр бодрол нь буруу дүгнэлт юм уу мухардалд хүргэдэг.

Хамба, лам, гүрү болон томоохон эрдэмтэдтэй хийсэн ярилцлагатай харьцуулахад иймэрхүү ярилцлага “магадгүй”, “сайн мэдэхгүй байна”, “үгүй, яг ч тийм биш” гэх зэрэг тодорхойгүй хариултаар бага байдаг. Учир нь лам, свами, гуру нар нь дорны шашны ертөнцөд дэндүү байр суурь эзэлдэг учир тэдний хувьд гадаадын хэн нэгэн эрдэмтний сэтгэлд нийцэхийн тулд ямар нэгэн дуулиантай зүйл хэлэх нь сонин биш юм. Харин ч тэд европчуудын эрдэм



*Тару профессор*



*Тару эмэгтэй*



*Тару эрэгтэй*



шинжилгээний сонирхлыг өгөөдөхийн сацуу хүндэтгэсэн харьцаатай байдаг. Дорно дахины шашны хүмүүжил нь тэднийг шашны эртний зан заншил, мэдлэгийг хүндэтгэж, хамгаалж, хөгжүүлэхийг зааж сургадаг бөгөөд ерөөсөө мэдэмхийрэн ярихыг маш том нүгэл гэж үздэг. Ямар ч лам, гүрү, свами нар өөрийн мэдлэгтээ итгэл төгс бус л бол тайвнаар “үүнийг би санахгүй байна” гэж хариулаад. энэ талаар өөрөөсөө гүнзгий мэдлэгтэй гэж боддог өөр шашны зүтгэлтэнд очихыг зөвлөдөг. Энэтхэг болон Балбын эрдэмтэд ч ялгаагүй шашны маш гүнзгий хүмүүжилтэй учир тэдний өгсөн мэдээ баримтанд итгэж болох юм.

### **Будда гэж хэн бэ?**

Шашны шинж чанартай судалгаа хийж байх үед англи, орос хэлээр гарсан эрдэм шинжилгээний нэртэй ном зохиолыг хэрэглэх хүсэл маш их төрдөг. Гэхдээ эдгээр ном зохиолыг сэтгэхүйн онцгой бүтэцтэй, транс байдалд байх үедээ харсан зүйлээ хамгийн үнэн гэж үздэг хүмүүс бичсэн байдаг юм. Харамсалтай нь хүмүүс бясалгал хийж, транс байдалд орсон үедээ нэг юмыг маш олон янзаар хардаг учир эдгээр мэдээллийг баримт болгон ашиглахад нэлээд ярвигтай. Үүний үндсэн дээр бид шашны эх сурвалж болон Дорно дахинд агуу Гэгээрсэн хэмээн алдаршсан Елена Блаватскаягийн ном зохиолыг үндсэн суурь болгож ашиглахаар шийдсэн.

Буддаг судлах асуудалдаа эргэн орвол Буддаг ээж ааваас (тару) төрсөн гэж, тару омгийнхныг Буддагийн залгамжлагчид гэж үзэх нь эндүүрэл болно. Харин самади болон түүний ер бусын гадаад төрхийг эргэн санах аваас Буддаг Лямбинигийн ойролцоох нэгэн нуураас усны самадигаас гарсан, эсвэл ойролцоо орших уулсаас агуйн самадийн байдлаас гарсан гэж үзэж болох юм. Хоёрдахь хувилбарыг бид илүү үнэний хувьтай гэж үзэж байна. Учир нь Буддагийн тухай домог ярианд түүнийг нас бие гүйцсэн хойноо турж эцсэн хүн зэрлэг ой руу яваад тэндээсээ өөрчлөгдөн маш сайхан залуу болон эргэж ирсэн тухай гардаг. Огт ондоо хүн эргэж ирсэн бөгөөд хууль бусаар төрсөн тухай түүх нь зохиомол зүйл байхыг үгүйсгэхгүй.



*Будда гэгээрч буй нь*

түүнийг нас бие гүйцсэн хойноо турж эцсэн хүн зэрлэг ой руу яваад тэндээсээ өөрчлөгдөн маш сайхан залуу болон эргэж ирсэн тухай гардаг. Огт ондоо хүн эргэж ирсэн бөгөөд хууль бусаар төрсөн тухай түүх нь зохиомол зүйл байхыг үгүйсгэхгүй.

Бидний дээр хэлсэнчлэн (Бумба лам), энэ 30 мянган жилийн хугацаанд дэлхий дээр 1002 Будда ирэх ёстой.

*Энэ талаар бид Е.П. Блаватскаягийн номоос (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 529,530-р хуудас) дараах баримтыг олов: “ Будда бол бүх дэлхийн нийт хүмүүсийн ололт юм. Тэд бол түүхэн Мэргэн Ухаантнууд юм...97 Буддатай нэг хэсэг болон 53 Буддатай өөр нэгэн хэсэг бий...Нэн эртний “далдуу модны” навчин дээрх бичээс бүхий цааснууд нь маш нууц байдалд байдаг...Дараах зүйлүүдийг Их үерийн гэрч болж, Атлантын үндсэн их газрууд усанд автахыг харсан Тав дахь иргэншлийн эхний өдрүүдийн Буддагийн чулуун самбараас хуулан авч, ойлгомжтой хэлээр хөрвүүлэн дамжуулж буй юм”.*

- Елена Блаватская Буддагийн тухай бичсэнийг янз бүрээр ойлгож болно. Нэг талаас Буддаг “Түүхэн мэргэн ухаантнууд” гэж байгаа нь анхаарал татаж байна. Учир өөр нэгэн хэсэгт (440-



*Буддагийн хөшөө (М.Э.III зуун, Пакистан)  
Самадид буй хүнтэй төстэй байна*

р хуудас) Е.П.Блаватская “Адептууд буюу Гурав, Дөрөв, Тав дахь иргэншлийн Мэргэн хүмүүс газар доорх оромжинд амьдардаг байжээ...” гэж бичжээ.- “Түүхэн мэргэдүүд” болон “Мэргэн хүмүүс” гэдэг ойлголтууд нэг утгатай болж таарах нь. “Адептууд” ч гэсэн ижил утгатай болох нь. Тэгвэл адептууд гэж хэн бэ? Лам, свами нартай хийсэн ярианаас бид зуу, мянга болон түүнээс ч урт хугацаагаар самадид байж, үе үе энгийн амьдралд эргэн ирдэг хүмүүсийг “адептууд” хэмээн нэрийддэгийг нь мэдэж авсан юм.

Үүнээс үзэхэд сүүлийн Будда (ер нь бүх Будда нар) адептууд байсан бөгөөд хүний генийн сан болох самадигаас гарсан байжээ. Е.П. Блаватская “...97 Буддатай нэг хэсэг болон 53 Буддатай өөр

нэгэн хэсэг бий...” гэснийг ийн ойлгож болох юм.

Буддагийн ер бусын дүр төрх ч мөн түүнийг адепт-атлант юм уу адепт-лемур байсныг гэрчилнэ (Е.П.Блаватскаягийн үгийг эргэн санацгаая: “Адептууд буюу Гурав, Дөрөв, Тав дахь иргэншлийн Мэргэн хүмүүс...”). Газар дэлхий дээр хэн ч түүнд зааж өгөөгүй асар их мэдлэгтэй байсан нь атлантын юм уу, лемурчуудын мэдлэгийг эзэмшсэнийг харуулж байна. Үүнийг шууд бус ч Е.П.Блаватскаягийн “чулуун самбар” болон Их үерийн үеийн Буддагийн талаарх үг гэрчилж байна. Ер нь Е.П. Блаватская Буддаг шууд дөрөв дэх үндэстний буюу атлантын төлөөлөгч гэж хэлж байгаа юм: “...Дөрөвдэхь үндэстний аварга биетнүүдэд байдаг ерөнхий онцлог бүгдээрээ Будда нарт байдаг бөгөөд ихэнхдээ унжсан урт чихний дүрсээр гажуудуулсан байдаг ...”

Нөгөө талаас Е.П. Блаватскаягийн үгийг өөрөөр тайлбарлаж, бидний таамаглалыг няцааж болох л юм. Гэвч Дорнын шашны бүх зүтгэлтэн “Адептуудын талаар мэддэг. Тэр бүү хэл тэдэнтэй уулздаг” гэж ярьдаг! “Самади байдаг” гэдэг баримт нь дорно дахины “Будда нь хагас усны амьдралд зохицсон ер бусын гадаад төрхтэй, Будда асар өндөр мэдлэгтэй.” гэх мэттэй адил маргаангүй зүйлийн нэг юм. Гэсэн ч дээр дурдсан баримтуудыг таамаг төдийгөөр л авч үзэх боломжтой.

Хэрвээ бид энэ таамгийг үндэс болгоговол хүн төрөлхтний Генийн сан байдгийг ч гэсэн таамаглал гэж авч үзэх шаардлагатай болно. Үнэхээр байдаг юм гэж үү? Бидэнтэй зэрэгцээгээр газар доор, усан доор янз бүрийн иргэншлийн самадид байгаа хүмүүсийн ертөнц оршдог юм гэж үү? Будда болон бусад Гэгээнтнүүд газар дээр тэндээс гарч ирсэн юм гэж үү?

Сүүлийн Будда болон түвдийн сүмүүдийн ханан дээр нүд нь дүрслэгдсэн хүн хэн бэ гэсэн асуултын хариуг энэ бүлгийн судалгааны урьдчилсан дүгнэлт болгоё. Тэдний нүдэнд хийсэн шинжилгээ нь Буддаг орчин үеийн хүн болон түвдийн сүмүүд дээр нүдийг нь дүрсэлсэн хүний завсрын үеийн хүн гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Хавхлаг хэлбэрийн хамарнаас энгийн хамарт, таславч нь үгүй болсон зэрэг хагас усны амьдралын дасан зохицлоос бүтэн хуурай газрын амьдралын дасан зохицолтын шилжилт ч мөн ажиглагдаж байна. Түүнээс гадна Е.П.Блаватскаягийн бичсэнчлэн газар доорх оромжинд гурав дахь (лемурчууд), дөрөв дэх (атлантчууд) болон тав дахь (манай соёл иргэншлийн хүмүүс) үеийн үндэстнүүдийн адептууд байдаг.

Энэ бүхнээс үзэхэд Будда нь атлант байсан бөгөөд төвдийн сүмүүд дээр нүд нь дүрслэгдсэн хүн бол лемур эсвэл лемуро-атлант байсан байна.

Атлантчууд гэж хэн бэ? Лемурчууд гэж хэн бэ?

Долдугаар хэсэг

## Лемурчууд болон атлантчууд гэж хэн бэ?

**Судалгааны аргууд** Иймэрхүү судалгаанаас ямар нэгэн тодорхой баримт олоход хэцүү. Янз бүрийн эх үүсвэрээс олж авсан мэдээлэлд урьдчилсан харьцуулалт хийж, өөр өөр эх сурвалжид давтагдаж буй мэдээллийг тооцон, хийсвэр сэтгэхүйн аргаар нэгтгэх шаардлагатай.

Бидний бодлоор хамгийн эрсдэлтэй нь эрдэм шинжилгээний аргаар бичсэн ном зохиолуудыг шинжлэх явдал юм. Эдгээр ном зохиол зохиомж их боловч ийм аргаар бичигдсэн зарим нэг ном үлэмж үндэслэлтэй байдаг. Жишээ нь Лувсандамбын бичсэн “Билгийн нүд”, “Лхасын доктор”, “Эртний хүмүүсийн агуй” болон бусад ном. Уг номыг зохиогч нь багшаараа бясалгал хийхийг заалгаж сураад, Төвдийн самади-агуйнуудын нэгэнд самадид орж хэсэг хугацаанд байсан байна. Мөн түүнчлэн Джон Хислопын “Бхагаван Шри Сатья Саи Бабатай хийсэн ярилцлага” гэсэн Энэтхэгт Гэгээрсэн гэж үздэг төдийгүй зарим нутагт дэлхий дээрх бурханы хувилгаан гэж үздэг Их Саитай хийсэн ярилцлага маягаар бичсэн ном итгэл төрүүлж байсан. Рудольф Штайнерын бичсэн “Дэлхийн түүхээс” гэдэг нэртэй эртний Гэгээнтнүүдийн “Акашийн товчоо”-ны нууцыг дүрслэн бичсэн ном ч ихээхэн сонирхолтой. Эдгээр номоос авсан мэдээ баримтыг бид авч үзсэн юм.

Дорны шашны номууд бидний хувьд ойлгоход хэцүү хэлээр бичсэн гэдэг шалтгаанаас гадна дорны нууцлаг сэтгэхүйгээр бичигдсэн болохоор судлахад хүндрэлтэй байлаа. Дорны шашнуудын янз бүрийн урсгалын ном сударт өмнөх иргэншлийн хүмүүсийн амьдралыг дүрсэлсэн нь хоорондоо бараг ялгаагүй байв. Эдгээр мэдээ баримт нэрт Гэгээнтнүүд болох Е.П.Блаватская, Нострадамусын

ном зохиолд дүрслэгдсэн баримттай таарч байгаа нь маш их сонирхол татаж байна. Лам, гүрү, свами нар өмнөх соёл иргэншлүүдийн талаар мэддэг ч шашны судалгааны энэ хэсгийг санахгүй байгаа ч юм уу, энэ их нууцыг хадгалж байгаа гэсэн шалтгаанаар энэ тухай дэлгэрэнгүй ярихаас дургүйцдэг.

Их Гэгээнтнүүдийн ном зохиолоос бидэнд арай ойлгомжтой нь Е.П.Блаватская, Нострадамусын ном байлаа. Гэвч Нострадамусын зөгнөлүүд нь дөрвөн мөртөөр бичигдсэн байдаг бөгөөд эртний франц хэлнээс орос хэлээр алдаа мадагтай буулгасан байдаг учраас төөрөгдөлд хүргэж болзошгүй.

Е.П.Блаватскаягийн “Нууц бичээс” нь хэмжээ хийгээд хангалттай баримт мэдээлэл агуулснаараа агуу бүтээл юм. Түүнээс гадна энэ ном дээд төрөлтийн сэтгэхүйгээр бичигдсэн бөгөөд номын дунд хэсэгт санааны төгсгөлийг дурьдасанаа, сүүл хэсэгт санааны эхлэлийг, санааны дунд хэсгийг номны эхэнд бичсэн байдаг. Эхлээд уг номыг уншиж байх үед энэ нь ихээхэн эгдүү хүргэж байсан ч сүүлдээ би үүнд энгийн хүмүүн миний ухаан багахан ч атугай бүрэн гүйцэд ухаж ойлгохгүй Дээд Оюун ухааны гүн утга санаа нуугдан буйг ойлгосон юм. Уг номонд бичээтэй баримтуудыг нэгэн цогц болгох гэж арга ядсандаа би хуучны оюутан цагийн аргаа хэрэглэхээр шийдэв. Учир нь ихэнх оюутан ямар нэг зүйлийг хичээн судалж байх үедээ богино хугацаанд маш сайн тогтоогоод, дараа нь тайвуухан мартаж орхих чадвартай байдаг. Би номыг дахин нэг уншихдаа ихэнх хэсгийг нь тогтоогоод, цээжээрээ харьцуулаад хүний сэтгэхүйн явцад тааруулан номноос хуулж авсаны дараа эдгээр материалыг шинжилгээний сэтгэхүйн гинжинд холбож болохоор боллоо.

Гэгээнтнүүдэд итгэж болох уу гэдэгт тийм гэх ч юм уу, үгүй гэж хариулахад хэцүү. Гэсэн ч ухаант хүн ядахдаа үхэхийнхээ өмнө ч гэсэн бурханд итгэдэг. Хэрвээ Бурханыг буюу Дээд Оюун Ухааныг үгүйсгэхгүй бол Гэгээнтнүүдийн мэдлэгийг ч мөн үгүйсгэх аргагүй. Учир нь шашны мэдлэг бурхнаас гаралтай болохоор зарчмын хувьд Гэгээнтнүүдийн мэдлэгтэй таардаг. Шашны мэдлэгийг хагас боловсролтой хүмүүст ойлгомжтой



*Елена Петровна Блаватская  
(1831-1891)*

үлгэр домгийн хэлбэрээр өгдөг бол, Гэгээнтнүүдийн баримт нь түүх – шинжлэх ухааны мэдээллийн шинж чанартай байдаг. Хүн төрөлхтөн хөгжихийн хирээр Дээд Оюун ухаан зарим хүнийг Ертөнцийн ерөнхий мэдлэгт илүү гүнзгий нэвтрүүлж, үүгээрээ шашны анхдагч мэдлэгийг гүнзгийрүүлэн, ихэнх шашин номлогчийн ягшмал сурталыг эсэргүүцдэг гэж үзэж болно.

Гэгээнтнүүдийн мэдлэг олж авдаг үйл явцыг орчин үеийн физикийн үүднээс дараах байдлаар тайлбарлаж болох юм. Энэ хүмүүст “SoHm”-ын зарчим алдагддаг бөгөөд тэд сэтгэлийн энергиэ Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд тааруулдаг. Гэгээнтэн болгон уг мэдлэгийнхээ эх сурвалжийг ямар нэгэн дуу хоолой түүнд хэлж бичүүлсэн гэж дүрсэлдэг. Эдгээр хоорондоо харьцангуй адилхан мэдээллийг олж авах өөр эх сурвалж байдаг эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Шашны мэдлэг болон Гэгээнтнүүдийн мэдлэг нь Ертөнцийн Мэдээллийн орон гэсэн нэгэн эх сурвалжтай.

Маш олон хүн бясалгалын тусламжтайгаар өнгөрсөн болон ирээдүйг хардаг транс байдалд орох чадвартай байдаг. Магадгүй тэдэнд мэдээллийн зарим нэг суваг л нээгддэг учир тэдний мэдээлэл нь эмх замбараагүй байдаг байх. Гэгээнтнүүдийн мэдээллийн суваг нь харьцангуй өргөн байдаг учир тэдний мэдээлэл нь дэлгэрэнгүй бөгөөд миний дээр хэлсэнчлэн дээд төрөлтний сэтгэхүйгээр бичигдсэн байдаг юм.

Ямагт Их гэгээрсэн Е.П.Блаватскаягаас иш татаж буйг минь эрхэм уншигч өршөөх буй заа. Учир нь Гэгээнтэн бүр ерөнхийдөө ижил төстэй зүйлийн талаар ярьдаг бөгөөд Е.П.Блаватскаягийн бүтээл нь орос хэлээр байдаг учир хэлний тал дээр надад илүү дөхөм юм.

Эцэст нь бид дээр дурьдсан бүх баримтыг өмнөх соёл иргэншлийн хүмүүсийн гадаад төрхийн бүтэц-үйл ажиллагааны судалгаатай харьцуулан лемур болон атлантчууд ямар байсан бэ гэсэн асуултанд ямар нэгэн хэмжээгээр хариулахыг оролдлоо.

**Өмнөх иргэншлүүдийн  
талаарх ерөнхий  
мэдээлэл**

Энэ талаар Елена Блаватская (“Нууц бичээс”, 2-р боть, 169-р хуудас) ийн бичиж байжээ: *“...Анхдагч үндэстнүүдийн түүх нь Гэгээнтнүүдийн хувьд бус бүдүүлэг шинжлэх ухааны хувьд цаг хугацааны булшинд гүн булагдсан юм.”*

Дээр дурьдсан эх сурвалжуудад хэн нь ч хүн сүнс нягтрах аргаар үүссэнийг үгүйсгэхгүй байгаа юм. Орчин үеийн физикийн нэр томъёогоор тайлбарлавал долгион хэлбэрийн амьдрал нь (сүнс, нөгөө ертөнц г.м.) аажимдаа биежэн хүний бие махбодь болсон байна. Сүнс биежих үйл явц

болон сэтгэлийн энергийн бөөгнөрөл нь шидэт бүтээлгийн тухай үлгэрийг санагдуулдаг бөгөөд мэдээж үүнд итгэх аргагүй.

Гэвч нөгөө талаас дунд сургуулийн түвшний физикт хүртэл 2 гамма нь 1 электрон буюу долгионы элемент нь материаллаг элемент болон шилжих чадвартай гэдэг нь тодорхой байдаг. Уфа хотын иргэн Марат Фатхлисламов хоёр ч удаа Агуу аватар Сатья Саи Бабатай уулзаж бодол санааг бодит болгон, хоосноос нунтаг, будаа г.м. зүйлс үүсгэж байхыг хоёр нүдээрээ харжээ. Үүнээс гадна Марат Саи Бабагийн материализацийг харуулсан хэд хэдэн видео бичлэг авчирсан юм. Агуу аваторын явуулсан материализацийн үйл явцыг чадварлаг илбэ гэж ойлгож болох л доо. Гэхдээ хэтэрхий үнэмшилтэйн дээр түүнд итгэдэг хүн ч маш олон. Өдөр бүр 10 мянга орчим хүн түүнтэй уулзахаар ирдэг. 70 насных нь ойн баярт дэлхийн өнцөг булан бүрээс 1 сая орчим хүн цугларч байжээ. Ийм олон гэнэн тэнэг байна гэж бодоход хэцүү байгаа биз дээ.

Ямар ч байсан сэтгэлийн энерги бодитжих таамаглал нь органик молекул үүсч, тэдгээр нь аажимдаа нийлмэл болон хувирсаар газар дэлхий дээр амьдрал үүссэн гэсэн онолоос батлах боломжийн хувьд багагүй. Шашны болон Гэгээнтнүүдийн мэдлэгээр бол газар дэлхий дээр нийтдээ хүн төрөлхтний таван үндэстэн буюу соёл иргэншил байсан. Хамгийн эхний үндэстний хүн “өөрөө төрөгсөд” гэгддэг, сүнс маягийн 50-60 метр өндөртэй, одоо бидний гуравдагч нүд гэж нэрлэдэг нэг л нүдтэй, хуваагдаж үрждэг бодгаль байсан байна.

Хоёр дахь үндэстний хүн нь “хожуу төрөгсөд” буюу “мөнх” гэгддэг, арай нягт боловч мөн л сүнс хэлбэрийн, 40 орчим метрийн өндөртэй, мөн л ганц нүдтэй, спор үүсгэх болон нахиалах аргаар үрждэг биет байсан байна.

Гурав дахь үндэстний хүн болох “хоёр нүүрт”, “андрогин” буюу “лемурчууд” нь хамгийн удаан хугацаанд оршин тогтносон бөгөөд дотроо хамгийн их өөрчлөлтийг агуулсан байдаг. Энэ үндэстний түвшинд хүйсийн ялгаа гарч, яс үүсч, бие нь нягтран, 20 метр орчим өндөртэй, дөрвөн гартай, хоёр нүүртэй байснаа арай намхан, хоёр гартай, нэг нүүртэй болж хувирсан байна. Хөгжил цэцэглэлтийн хамгийн өндөр түвшинд хүрсэн нь хожуу үеийн лемурчууд буюу лемуро-атлантчууд юм.

Дөрөв дэх үндэстэн буюу атлантчууд нь хоёр гартай, нэг нүүртэй, 6-8 метр орчим өндөртэй, нягт биетэй байсан байна.

Тав дахь үндэстэн (манай соёл иргэншлийн хүмүүс) буюу аричууд эхэндээ өндөр биетэй байсанч аажимдаа одоогийн хэмжээнд хүртэл багассан байна.

Газар дэлхий дээр нийтдээ 7 үндэстэн буюу соёл иргэншил байсан гэх бөгөөд үндэстэн болгон нь 7 дэд үндэстэнийг агуулж байсан ба агуулах ч болно.

**Дэлхий дээр амьдрал  
хэзээ үүссэн бэ?**

Дээр дурьдсан бүх эх сурвалжид дэлхий дээрх амьдралыг, тэр тусмаа хүнийг олон сая жилийн өмнө үүссэн гэж үздэг.

*Энэ талаар Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 261-р хуудас) ийн бичжээ: “Яагаад бид луунуудын талаар ярьдаг юм бэ? гэж асуух байх. Юуны түрүүнд ийм амьтдын оршин тогтнож байсныг мэдэж буй нь хүний соёл иргэншил агуу эртний түүхтэйг гэрчилж байгаа юм.”*

*“Акашийн товчоо”-нд ийн бичигджээ: “Хүнтэй хөгжлийн түвшингээрээ нэгэн үе шатанд явж байсан амьтад байсан байна. Одоо үед тэднийг хэвлээр явагчдын бүлэгт багтаах байсан.” (Р. Штайнер. “Дэлхийн түүхээс”, 1992, 66-р хуудас)*

Мөн л Е.П. Блаватская “Нууц бичээс”-дээ (1937, 2-р боть) дэлхий дээрх өмнөх иргэншлүүдийн талаар нэлээд нарийвчлалтай зүйлсийг бичсэн байдаг: *“Лемур нь Гуравдагч Үе Шат эхлэхээс 700000 жилийн өмнө мөхсөн” (392-р хуудас), “...850000 жилийн тэртээ Атлантидын сүүлчийн хэсгүүдийг живүүлсэн Их Үер...” (416-р хуудас), “...12000 жилийн тэртээ Атлантын үндэстнүүдийн сүүлийн төлөөлөгчид усанд автсаны дараа...” (158-р хуудас), “...анхны агуу Арал буюу Их газар усанд автсан тэр үед аричууд (манай соёл иргэншил) нь 200000 жил амьдарч байсан юм...” (495-р хуудас).*

Тиймээс сүнс нягтрах замаар дэлхий дээр хүн төрөлхтөн үүсэх явц нь байгалийн олон сая жилийн хувьслын ажиллагаа шаарджээ. Энэ тухайд Е.П.Блаватскаягийн үгийг (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 329-р хуудас) иш татмаар санагдлаа: *“Оюун ухаангүй” нэг дэх соёл иргэншлийн үеэс оюун ухааны өндөр хүчин чадалтай хожуу үеийн Лемурчуудын соёл иргэншил үүсэх хүртэл хэдэн сая жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд Атлантчуудын хамгийн эхний соёл иргэншлийн үеэс түүхэн үе шат хүртэл мөн адил хугацаа өнгөрсөн юм”.*

Тэгэхээр олон сая жилийн өмнө дэлхий дээр амьдрал үүссэн бөгөөд хүн төрөлхтний соёл иргэншлүүд аажимдаа нийлмэл төвөгтэй болсоор, ээлж дараалан үүссээр иржээ. Гэсэн ч хүн төрөлхтний бүхэл бүтэн соёл иргэншлүүдийг ч устгаж орхисон дэлхийн хэмжээний гай гамшиг хүн төрөлхтний түүхэнд элбэг. Байгаль дэлхийн хувьслын явцад хүн төрөлхтний генийн сангийн үүсэл нь дэлхийг хамарсан гай гамшигийн үед баталгаа болох нь мөн л зүй ёсны явдал.



### **Материализм ба идеализм**

Матери санаа бодол хоёрын аль нь анхдагч вэ? Уг мөнхийн асуултанд хариулахдаа шашин болон Гэгээнтнүүдийн бүтээл идеализмыг анхдагч гэж үздэг.

Үүнд баримт нотолгоо бий юу? Бүх юм он цагийн уртад булшлагдсан учир шууд баримт нотолгоо олоход тун төвөгтэй. Гэсэн ч нарийн ертөнц болон бодит ертөнц зэрэгцэн оршдог нь хэнд ч маргаангүй зүйл болсон бөгөөд сэтгэлийн энерги буюу бодол санаа нь бодит байх үлэмж бололцоотой.

Нөгөө талаас органик молекул нийлмэлжин, эхлээд амьдралын энгийн хэлбэр үүсч, яваандаа хөгжсөн гэсэн онолыг үгүйсгэх аргагүй. Үүнд баталгаа бий юу? Зарим нэгэн лабораторын туршилтаар үүнийг бүдэг бадаг харуулж байгаа боловч үнэн мөн цаг хугацааны тоосонд дарагджээ.

Амьдралын материаллаг үүслийн талаарх хувилбар нь бидний хувьд илүү ойлгомжтой, итгэлтэй санагддаг. Амьдралын долгионы хувилбар нь ямар нэгэн ид шид үлгэрийн юм шиг санагддаг бөгөөд бид өнөөгийн түвшиндээ үүнийг маш муу ойлгон хүлээж авдаг учир “Ёстой гайхамшиг!” гэж дуу алдах юм уу эсвэл бүхнийг үгүйсгэх болдог. Амьдралын долгионы болон материаллаг хүчин зүйлүүд нь хоорондоо нарийн болон бодит ертөнцийн нэгэн адил холбоотой байдаг.

Бурхангүй үзэлтэн л биш бол шууд баримт нотолгоо байхгүй үед бурханы сургаальд л итгэх болдог. Хэрвээ шинжлэх ухааны хөгжлийг шашинтай харьцуулан үзвэл шинжлэх ухаан нь шашныг үгүйсгэж чадахгүйгээр үл барам шашны сургаалийн зөвийг баталсан баримт нотолгоо улам их олдох болсоныг анзаарч болно. Бид Дээд Оюун Ухааны нэгэн жижиг хэсэг бөгөөд шүүн тунгаах эрхгүй гэдгээ ойлгох хэрэгтэй. Өөрийгөө бурхан гэж үзэх нь хамгийн том нүгэл гэдэг нь тодорхой. Хэзээ ч юм хүрсэн ололт амжилтаа эцсийнх гэж үзэн шинээр гарч ирээд шинжлэх ухааны хүрээнд аль хэдийн яригддаг болсон санааг үгүйсгэж суудаг хуучинсаг үзэлтэй эрдэмтэд маш том нүгэл үйлдэж байгаа юм.

### **Лемурчууд**

Дээр дурьдсан эх сурвалжуудаас үзэхэд эртний тэр үед (хэдэн сая жилийн өмнө) газар дэлхий дээрх тивүүд нь огт ондоо байжээ. Лемурчуудын гол эх газар нь лемурчуудын тивийн үлдэгдэл гэгддэг Австралийн бүсэд байжээ. Энэ тухай “Нууц бичээс”-т дараахь зүйлийг бичжээ:

*“...Jukes ийнхүү бичжээ: Оолитын үеэс (Юрын эрин) Австрали нь бусад газрыг бодвол бага өөрчлөгдсөн (Е.П.Блаватская “Нууц бичээс”, 1937, 2-р боть, 248-р хуудас). “Тэр үед газар илүү сийрэг урсамтгай байсан” (Р.Штайнер “Дэлхийн түүхээс”1992, 48-р хуудас)*



*Энэтхэгийн 2 нүүр,  
4 гарт хүний дүрслэл*

*Гурав дахь соёл иргэншил нь хамгийн нууцлаг нь юм... Чухам хэрхэн хүйсийн ялгаа гарсан нууцыг нь бүрэн тайлбарлахад хэцүү... Гэвч Гурав дахь соёл иргэншлийн зарим хүн өөрсдийн бүрхүүл буюу өндгөндөө хуваагдаж эхэлсэн нь тодорхой..."*

Тэрээр мөн л (211-р хуудас) тэднийг ихэнх ургамал, хорхой, дунгийн нэгэн адил нахиалах аргаар үрждэг гэж бичсэн байдаг. "Акашийн товчоо"-нд "эм шинж тэмдэг давуу илэрсэн хүмүүс нь сэтгэлийн хувьд илүү хөгжилтэй бөгөөд эр шинж тэмдэг давуу илэрсэн хүмүүсийг хайрладаг байсан" гэж хүйсийн хуваагдлыг тайлбарлажээ (Р.Штайнер "Дэлхий түүхээс", 1992, 46,47-р хуудас).

Дээр хэлсэнчлэн эртний лемурчууд хос бэлэгтэн байх үедээ дөрвөн гар, хоёр нүүртэй байжээ. Хүйсний ялгаа гарч эхэлсний дараа толгойн ард байрласан

Хувьслын хувьд лемурчуудыг эртний болон хожуу үеийн (лемуро – атлантчууд) гэж хуваадаг.

Эртний лемурчууд нь аварга биетэй (20 метр орчим), дөрвөн гар, хоёр нүүртэй байсан. Тэдний бие нь эхэндээ маш зөөлөн эдээс тогтсон уян налархай байжээ. Чухам тэдэнд л хамгийн анх яс үүсч биеийг нь хүнд болгосон бөгөөд газрын амьдралд дасан зохицжээ. Гэвч зарим нэг эх сурвалжид (Лувсандамба "Лхасын доктор", 1994, 231-р хуудас) "Газар дэлхий тэр үед өөр тэнхлэгээр эргэдэг байсан ба хүндийн хүч нь хамаагүй хөнгөн байжээ. Янз бүрийн төрөл зүйлийн том том амьтан их байсан." гэсэн нь домогт үлэг гүрвэлүүд байсан юм болов уу? Үүнийг үгүйсгэх аргагүй. Учир нь эдгээр аварга хэвлээр явагчдыг лемурын соёл иргэншилтэй нэгэн үед оршин тогтнож байсан гэдэг.

Эртний лемурчууд ой тогтоолтгүй байсан ба тэдний яриа нь дууг санагдуулж, ихэвчлэн "бодол санааг унших" аргаар харьцдаг, сэтгэхүйг хөгжүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулдаг байжээ.

Эртний лемурчууд нь хоёр дахь иргэншлээс үүссэн учир эхэндээ мөн л хос бэлэгтэн байсан боловч сүүл үе рүүгээ тэдэнд эр эм хүйсний ялгаа гарч эхэлжээ. Энэ талаар Е.П.Блаватская ("Нууц бичээс", 1937, 2-р боть, 249-р хуудас) ийн бичжээ: "Хүн төрөлхтний

“билгийн нүд” гавлын дотогш орж эхэлсэнтэй холбоотойгоор арын хоёр гар нь хатангаршин үгүй болж эхэлжээ.

Толгойн арын хэсэгт байрласан “билгийн нүд” нь эртний лемурчуудыг хоёр нүүртэй мэт болгож байлаа. Энэ нүд нь эхний болон хоёр дахь иргэншлийн хүний нэг нүдний хувирсан хэлбэр байсан бөгөөд нарийн ертөнцийн долгионы давтамжийг буюу сэтгэлийн энергийг ертөнцөд (хэт өндөр давтамж) харах чадвартай байсан. Миний ойлгож байгаагаар энэ нь орчин үеийн ёгууд транс эсвэл самадийн байдалд орохдоо хардагтай адил үзэгдэл болов уу. Арын хоёр гар нь энэ билгийн нүдэндээ нүдэнд үйлчилдэг байжээ.

Лемурчуудын урд талын хоёр нүд нь тэд улам бүр материаллаг ертөнцөд ууссанаас бодит зүйлсийг харах шаардлагын улмаас үүссэн гэж бодож байна. Яваандаа бодит ертөнцийн хараа нь нарийн ертөнцийн хараанаас илүү үүрэгтэй болж эхэлжээ.

*Энэ талаар Е.П.Блаватскаягийн номонд (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 374-р хуудас): “Эхэндээ “Билгийн нүд” нь хүнийхтэй адил цорын ганц харааны эрхтэн байжээ. Урд талын бодит харааны эрхтэн нь Гурав дахь иргэншлийн эхэнд өнөөгийн сохор нугалмайтны түвшинд хүртэл хөгжсөн байсан бөгөөд урд хоёр нүд нь амьтанд ч тэр, хүнд ч тэр сүүлд хөгжиж эхэлсэн. Урд талын хоёр гар нь урд хоёр нүдэндээ үйлчилдэг байжээ”.*

Тэгэхээр эртний лемурчуудын гадаад төрх маш өвөрмөц байжээ. Аварга том биетэй, дөрвөн гар, хоёр нүүртэй байсан бөгөөд хүн төрөлхтний ой санаа нь энэ өвөрмөц дүр төрхийг Энэтхэгийн бурхдын дүр төрхөөр хадгалсан биз ээ. Ер нь эртний лемурчуудын бодит болон нарийн ертөнцийг харах чадвар маш төгс төгөлдөр байсан.

Хожуу үеийн лемур нэг нүүртэй хоёр гартай болсон. Арын “билгийн нүд” нь гавлын дотор орж, хойт хоёр гар нь аажимдаа хатангаршин үгүй болжээ. Гэсэн ч “билгийн нүд” нь үйл ажиллагаагаа явуулсаар байсан. Учир нь сэтгэлийн энергийн хувьд гавлын яс бол саад биш юм. Хожуу үеийн лемурчууд ихэнхдээ сэтгэл оюуны хөгжлийг илүү анхаардаг байсан. “SoHm”-ын зарчим үйлчилдэггүй байсан болохоор “билгийн нүд”-нийхээ тусламжтайгаар Ертөнцийн Мэдээллийн Оронтой холбоотой байжээ. Тэд маш өндөр оюуны хөгжилтэй үндэстэн байсан байна.

Хожуу үеийн лемурчуудын тухай баримтаас хамгийн сонирхолтой нь Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 247,248,249-р хуудас) номонд бичсэн дөрөв, тав дахь иргэншлийг дамжсан генийн өөрчлөлт ороогүй лемурчуудын шууд үр удам нь одоо хүртэл байдаг гэсэн баримт юм. Тэрээр: “Хэзээ ч юм хүчирхэг явсан энэ агуу үндэстний (гурав дахь иргэншлийн

лемурын) үр удмыг та нар одоо ч Австралийн зарим нэг хавтгай толгойт аборигенчуудаас харж болно”, “...Ургамал амьтны эртний аймгуудтай зэрэгцэн оршдог Австралийн зэрлэгүүд нь нэн эртний улс үндэстэнд харьяалагдах ёстой. Энэ битүүлэг ард түмний үүсэл гарлын тухай үндэстэн судлалд ямар нэгэн баримт байхгүй бөгөөд энэ нь нууцлаг битүү байдлыг нь тодруулна.” “...соёл иргэншлийг нь Эх Газартай нь устгасан усны их үерээс амь гарсан хожуу үеийн лемурчууд нь одоогийн зарим зэрлэг омгийн эх үүсвэр нь болсон”, болон “...өнөөгийн Австрали нь хуурай газрын хамгийн эртний улсуудын нэг юм...”

“Акашийн товчоо”-нд ч мөн ижил төстэй баримтууд бий: “Тэдний (лемурчууд) удам угсаа доройтож, тэдний үр удам нь одоог хүртэл манай дэлхийн зарим нэгэн өнцөг буланд зэрлэг ард түмэн гэгдэн оршсоор байгаа” (Р.Штайнер, “Дэлхийн түүхээс”, 1992, 22-р хуудас).

Үүнтэй холбоотойгоор лемурчуудын хамгийн том эх газрын нэгэн хэсэг болох Австралийн аборигенчуудыг судлах нь бидний хувьд ихээхэн сонирхол татсан зүйл байлаа. Магадгүй тэдэнд лемурчуудын бүтэц зүйн онцлог хадгалагдан үлдсэн ч юм бил үү. Магадгүй тэдний нөгөө хоёр гарын үлдэц нь байгаа ч юм бил үү. Өөр ямар нэг зүйл олох ч юм бил үү.

Гэвч хожуу үеийн лемурчууд буюу лемуро-атлантчууд хөгжил цэцэглэлтийн илүү өндөр түвшинд хүрсэн юм. Тэдний тухай тодорхой авч үзье.

## **Лемуро-атлантчууд**

Бүх эх сурвалжид лемуро-атлантчууд нь өвөг дээдэс болох лемурчууд болон үр удам болох атлантчуудаас үлэмж ялгаатай байсан гэж баталдаг.

Тэд аль алинаас нь илүү хөгжилтэй байжээ. Оросын нэг Гэгээнтэн хожуу үеийн лемурчуудын тухай надад ярихдаа тэдэнтэй харьцуулахад атлантчууд болон манай соёл иргэншлийн хүмүүс ухаан ороогүй балчир хүүхдүүд мэт гэж дүрсэлсэн юм.

“Акашийн товчоо”-нд (Р.Штайнер, “Дэлхийн түүхээс”, 1992, 46,56-р хуудас) бичсэнээр бол: “Атлантын соёл иргэншлийн эхэн үед сэтгэл оюунаараа Дээд Оюун Ухаантай холбоотой дэлхий дээрх бурханы хувилгаан болсон хүмүүс тэднийг тэргүүлдэг байжээ.”

Зарим таамгаар лемуро-атлантчууд нь одоо ч мөн нууцат Шамбалын орны гол төлөөлөгчид юм. Тэдний нисдэг төхөөрөмжүүдийг хүмүүс оньсогот нисдэг таваг байдлаар олонтаа олж хардаг.


Лемуро-атлантчууд ямар байсан бэ? Лемуро-атлантчуудын амьдрал үхлийн талаар тодорхой мэдээллийг бид Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937 он, 2-р

боть, 278,340,342,395, 397,427,429, 447, 530,537-р хуудас), Лувсандамбын (“Лхасын доктор”, 1994 он, 230-232-р хуудас) бүтээлүүдээс олов. Эдгээр эх сурвалжид бичсэнчлэн лемууро-атлантчууд нь бүхий л нууцлаг далд зүйлсийг нэвт харах чадвартай төрдөг байжээ. Тэдний хараа нь хязгааргүй байсан учраас тэд эд зүйлсийн мөн чанарыг агшин зуурын төдийд таньдаг байжээ. Тэдний хувьд орон зай, бодит зүйлсийн саад гэж байсангүй. Тэд байгаль дэлхийн нууц хийгээд анхдагч мэргэн ухаанд гүнзгий нэвтэрсэн хүмүүс байв. Тэднийг Бурхны Хүүдүүд гэдэг байжээ.

Лемууро-атлантчуудад номлол, итгэл бишрэл дээр үндэслэсэн үзэл баримтлал гэж байгаагүй. Тэдний билгийн нүд бүрэн нээлттэй байсан учир лемууро-атлантчууд нь өөрсдийгөө мөнхийн хүршгүй, үзэгдэшгүй болон мөнхийн үнэнтэй нэгдмэл, Ертөнцийн Бурхантай нэгдмэл гэдгээ мэдэрдэг байлаа. Энэ бол бурхан газар дэлхийгээр явж эгэл хүмүүстэй чөлөөтэй харьцдаг байсан балар эртний “алтан зуун” байв. Уг алтан зуун дуусч, бурхад алслан одож (өөрөөр хэлбэл харагдахгүй болж), дараа дараачийн үеийнхэн бурхдын хаант улс болох байгалийн хүчин зүйлсэд сөгдөн биширдэг болсон.

Лемууро-атлантчууд нь төмөрлөг, ховор эрдэс бодис, хар чулуу, гантиг зэргийг ашиглан аварга том хот суурин барьдаг байжээ.

Тэд чулуугаар өөрсдийн дүр төрхийг хэмжээ хэлбэрээр нь сийлэн



*Сфинкс - лемууро-атлантын бүтээл?*



*Лемууро-атлантчууд нисдэг төхөөрөмжтэй байв*

**Лемууро-  
атлантчуудын  
нисдэг төхөөрөмж  
нь тарнийн хүчээр  
ажилладаг байсан.**

түүндээ мөргөдөг байжээ. Эртний аварга том нэг нүдэт хөшөөний үлдэгдэл нь лемуро-атлантчуудын уран бүтээл юм. 500 тонн хүртэл жинтэй чулуун цутгамлуудыг ашиглан барилга барьдаг байжээ. Английн Солюсбергийн хөндий дэхь “Унжигч чулуунууд” болон Египетийн Сфинксийг лемуро-атлантчуудын бүтээл гэсэн таамаг байдаг.


Лемуро-атлантчуудын соёл иргэншил нь дэлхийн бөмбөрцөг дээрх хамгийн хөгжилтэй соёл иргэншил байсан юм. Тэд дэлхийгээс тасран хөөрөх чадвартай нисдэг төхөөрөмжүүдтэй байжээ. Энэ тухай Сатья Саи Баба (Джон С.Хислоп “Бхагаван Шри Сатья Саи Бабатай хийсэн ярилцлага”, 1994 он, 165-р хуудас) эдгээр нисдэг аппарат нь мантрын хүчээр буюу сэтгэл оюуны асар өндөр түвшинд хүрсэн хүний тарнийн хүчээр хөдөлдөг гэж үзжээ. Өөрөөр хэлбэл нисдэг төхөөрөмжүүдийн хөдөлгөгч хүч нь сэтгэлийн энерги юм.

Лувсандамба нь эртний атлантчуудтай цуг оршин байсан аварга биетэй хүмүүсийг дүрслэн бичсэн байдаг. Хэдийгээр атлантчууд нь өнөөгийн хүмүүсээс хоёр дахин өндөр байсан ч тэдгээр нь атлантчуудаас хамаагүй өндөр хүмүүс байсан гэж бичжээ. Эдгээр аварга биетнүүдийг Лувсандамба “Оюун ухааны хэт хөгжилтэй хүмүүс” гэж нэрлэжээ. Үүнтэй холбоотойгоор эдгээр “хэт оюунтан”-ыг лемуро-атлантчууд гэж үзэх олон нотолгоо байна. Лемуро-атлантчууд 6-8 метр, түүнээс ч өндөр биетэй байжээ.

Мөн л Лувсандамбын үзэж байгаагаар “хэт оюунтан”-ы амьдарч байсан үед газар Дэлхий дээрх уур амьсгал дулаан, ургамал амьтны аймаг нь илүү баялаг байжээ. Тэр үед дэлхий өөр тойрог замаар эргэдэг байсан ба ихэр-гаригтай байсан. Түүний бүтээлээс мөн л лемуро-атлантчуудын өөр өөр бүлэглэлийн хоорондын сөргөлдөөний талаар олж уншив.

Сөргөлдөөн нь Дэлхийн тэнхлэгийг өөрчилсөн аймшигт дэлбэрэлтийг дагуулсан дайнаар төгсжээ. Үүнээс хойш ихэр гариг нь Дэлхий рүү ойртосоор байгааг хүмүүс анзаарчээ. Уг гариг бүр ойртоход Дэлхийн далай тэнгис эргээсээ халин гарч, урьд өмнө үзэгдэж байгаагүй хүчтэй шуурга болжээ. Лемуро – атлантчууд тэмцэл маргаанаа мартан яаран сандран нисдэг төхөөрөмжиндөө сууж тэнгэрт хөөрөв. Тэд дэлхийг үүрд орхихоор шийджээ.

Дэлхий дээр аймшигт гамшиг үргэлжилсээр байлаа. Ойртосоор буй гариг улам бүр томорсоор, төдөлгүй дэлхий уг гаригтай асар том цог үсэргэн мөргөлджээ.



*Сар - дэлхийн шинэ дагуул*

Хар үүлс нүүн, цэвдэг хүйтэн болов. Ихэнх хүмүүс (атлантчууд) үхэцгээжээ. Үүнээс хойш Нар дорно зүгээс гарч өрнө зүгт жаргадаг болов. Дэлхий өөр тойрог замд шилжин өөр нэгэн дагуул - Сартай болжээ. Сүүлд нь хүмүүс гаригс мөргөлдсөний улмаас асар том хонхорхой\* үлдсэнийг олжээ.

Лемур-атлантчуудын үндэстэн нь Дэлхий дээрх хамгийн хөгжилтэй соёл иргэншил байсан тухай баримт нотолгоо олон байдаг.

Тэд бүр мөсөн устаж үгүй болсон юм гэж үү? Зарим нэгэн баримтаар бол тэд одоо хүртэл самадийн байдалд Хүний Генийн Сангийн төлөөлөгч болон оршсоор буй юм. Мөн өөр бусад эх сурвалжид лемуро-

атлантчууд нь хувьслын явцад нарийн ертөнцөөс бодит ертөнцөд шилжиж сураад оньсогот Шамбалын орны үндсэн бүрэлдэхүүн нь болсон гэжээ. Николай Рерих Шамбалын орныг дүрслэхдээ тус орны хүмүүс нь алга болох буюу үл үзэгдэгч болох удистай гэж нэг бус удаа бичсэн байдаг. Энэ бүхэнд итгэж болох уу? Мэдэхгүй л юм. Ямартаа ч нарийн болон бодит ертөнцийн хооронд шилжих боломжтой гэж бодож байна.



## Атлантчууд

Лувсандамбын бичсэнчлэн гаригуудын мөргөлдөөний улмаас үүссэн гамшгийн дараа амьд үлдсэн атлантчууд Дэлхийн өөрчлөгдсөн нөхцөл байдалд дасан зохицож эхэлжээ. Амьд гарахад нь тусалж чадах “хэт оюунтан” -уудын үндэстэн үгүй болсон байлаа. Тэдний дурсгал болж шашин шүтлэг үүсжээ. Бөө төлөгч нар сүсэг бишрэлийг нь ашиглан хүмүүсийг эрхэндээ оруулахыг оролдож байлаа.

Бронтозавр, арслан заан шинэ нөхцөл байдалд дасан зохицоогүйгээсээ болж Дэлхийн гадаргаас арчигдан үгүй болжээ. Урьд нь улаан байсан тэнгэр цэнхэр болон хувирчээ. Тэнгэрээс хаяа цас ордог болж, салхи мэдэгдэхүйц сэрүүсч, далайн түрлэг татлага үүсчээ. Аажимдаа хүний бие жижгэрэв.

Атлантчуудын бөө төлөгчид лемуро-атлантчуудын мэдлэггүйгээр нийгмийг хөгжүүлэх боломжгүйг ойлгож байлаа. Тэд лемуро-атлантчуудын эртний бичээсийг цуглуулж тайлан уншихыг оролдож байв. Эртний мэдлэгийн бусад эх сурвалжийг олж авах үүднээс малталт явуулдаг байжээ.

Эртний мэдлэгийг эзэмшсэнээр хөгжил цэцэглэлтийн үе эхлэв. Том жижиг олон хот баригдаж, эрдэмтэд байгалийг байлдан дагуулах шинэ шинэ аргыг олж байв. Хүмүүс өөрөө нисэгч төхөөрөмжийг бүтээн далавчгүй онгоцоор агаарт


\* - Эртний Полигайн тогоог хэлж байгаа болов уу.

хөөрдөг болжээ. Эдгээр онгоц нь чимээ шуугиангүй нисч, газар дэлхий дээр хаана ч хөдөлгөөнгүй зогсож чаддаг байлаа. Таталцлын нууцыг нээн, таталцлын эсрэг хуулийг ашигласны үндсэн дээр ингэх боломжтой болжээ. Хүмүүс алган дээр багтах багажийн тусламжтайгаар агаарт аврага том чулууг удирдаж чаддаг байжээ. Голдуу агаараар зөөж тээвэрлэдэг байсан ба ойрхон зайнд л газрыг ашигладаг, усан замаар зөөвөрлөлт хийх нь тун ховор байлаа.

Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 533-р хуудас) атлантчууд нисдэг төхөөрөмжтэй байсан тухай дурьдаж, мөн: *“Чухам Дөрөв дэх үндэстнээс л үнэт чулуу болон бусад чулуунуудын нууц увдисын талаар болон хими гэх зэрэг үнэт шинжлэх ухааныг өвлөн авсан...”*

“Акашийн товчоо”-нд (Р.Штайнер, “Дэлхийн түүхээс”, 1992 он, 20-р хуудас) атлантчуудыг “Амьдралын хүч”-ийг эзэмшсэн байсан гэж бичжээ. Жишээ нь тариан түрүү нь дотроо орших “амьдралын хүч”-ний тусламжтайгаар нахиалах шидтэй болдог. Атлантчууд уг амьдралын хүчийг техникийн хүч болгож, нисдэг болон бусад төхөөрөмжийн хөдөлгөгч хүч болгон ашиглаж байжээ.

Тэд таталцлын хүчинд үйлчилж, “амьдралын хүч”-ийг ашиглахаас гадна “билгийн нүд”-нийхээ тусламжтайгаар сэтгэлийн энергийг ашигладаг байжээ. Энэ талаар Нострадамус бичихдээ пирамид болон бусад байгууламжыг барихдаа атлантчууд “харцаараа” чулууг хөдөлгөдөг байсан гэжээ (“билгийн нүд”-нийхээ тусламжтайгаар чулууны долгионы хэсэгт тааруулснаар таталцлын хүчинд нөлөөлдөг байжээ). Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 375-р





хуудас) атлантчууд хувьслын явцдаа “билгийн нүд”-нийхээ үүргийг алдсан боловч “дотоод хараа”-ны үүргийг нь хиймлээр идэвхжүүлдэг байсан гэж бичжээ. (231-1)

Ингээд бидний хувьд ер бусын болох хүчин чадлуудыг эзэмшсэнээр атлантчууд нь өндөр хөгжилтэй, үлдэц олдворыг нь одоо ч олж болох соёл иргэншлийг байгуулсан байна. Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 538-р хуудас) атлантчуудын соёл иргэншлийн бидэнд үлдээсэн баримтын талаар ийн бичжээ: *“Египетийн Карнакийн пирамид болон бусад мянга мянган нуранги... Камбоджийн Начкон-Ватын хөшөө... Палейк болон Төв Америкийн Уксмалын нурангиуд...Люксорын ордны үл гандагч тиррийн улаан, нүд гялбам цэнхэр, тод ягаан гэх мэт өнгө нь будсан анхны өдрийнх шигээ л тод байна... Пирамидын нуршгүй цемент болон эртний аквадук, ишэндээ хугаралгүйгээр бөглөө сугалуур мэт эргэлдэх Дамаскийн сэлэм...өнгөт шилний юутай ч харьцууламгүй өнгө... давтац шилний нууц...”*

Лувсандамбын бичсэнчлэн (“Лхасын доктор”, 1994 он, 237-р хуудас) атлантчууд хоорондоо харьцахдаа бүгдийнх нь хувьд түгээмэл “хэл” болсон телепатийг ашигладаг байсан. Аажимдаа хэл яриа хөгжин, өөр өөр хэл үүсч хүмүүс бие биенийгээ ойлгох нь муудаж эхэлсэн. Бичиг үсэг зохиогдов.

“Акашийн товчоо”-нд атлантчууд нь маш сайн хөгжилтэй ой ухаантай ч хийсвэр сэтгэхүй муутайгаараа орчин үеийн хүмүүсээс ялгардаг байсныг тэмдэглэжээ. Тэдний настайчууд нь урт удаан амьдралынхаа туршлагыг эргэн харах боломжтойгоороо илүү нэр төртэй байж.

Атлантын соёл иргэншлийн үеийн тив дэлхийн газар зүйн байршил одоогийнхоос өөр байсан. Мөн л “Акашийн товчоо”-нд (17-р хуудас) атлантын тив газар нь өнөөгийн Америк Европ хоёрын дунд, Атлантын далайд байдаг байсан гэж бичжээ. Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 279, 280-р хуудас) нэг нь Атлантын далайд, нөгөө нь номхон далайд орших хоёр эх газар байсан гэжээ. Түүний бичсэнчлэн аварга том номхон далайн тив газрын үлдэгдэл нь Мадагаскар, Цейлон, Суматра, Ява, Борнео болон Полинезийн арлууд юм. Уг живсэн эх газрын гурван багана болсон Сандвичевийн арлууд, Шинэ Зеланд, Пасхын арлуудаас түүний ямар хэмжээтэй байсныг нь мэдэж болно. Эдгээр арлын зэрлэгүүд нэгнийгээ мэддэггүй ч бүгдээрээ л тэдний арал нь живэн алга болсон аварга том эх газрын нэгэн хэсэг юм гэж ярьцгаадаг. Энэ зэрлэгүүд бүгд нэг хэлээр ярьдаг, нэг ёс заншилтай нь ихээхэн сонирхол татсан.

Атлантидын хоёр дахь эх газар нь Атлантын далайд байсан бөгөөд эдүгээ түүний үлдэгдэл болж Азорын болон Канарын арлууд үлдсэн. Өнөөгийн Ази тивийн суурин дээр тэр үед хэдхэн арал байжээ.

Атлантчуудыг янз бүрийн үндэстэн ястнаас тогтдог байсан тухай мэдээ баримт байдаг. “Акашийн товчоо”-нд (Р.Штайнер, “Дэлхийн түүхээс”, 1992 он, 23-29-р хуудас) Атлантыг 7 дэд үндэстэнтэй байсан гэж бичжээ. Анхны дэд

үндэстэн буюу “Рмоагали” нь маш өндөр хөгжилтэй ой ухаан болон үгний шидээр ялгардаг байжээ. Хоёр дахь дэд үндэстэн буюу Главиатли нь үнэнч шударга зантай, үйлдсэн үйл, гавъяа, зүтгэл, бүтээлээ ой ухаандаа маш сайн хадгалдаг байсан. Гурав дахь дэд үндэстэн буюу Толтекчууд нь амжилт, мэдлэгээ үр удамдаа өвлүүлэн үлдээдэг болсонтой холбоотойгоор отог омог, тэргүүлэгч үүссэн байна. Дөрөв дэх дэд үндэстэн буюу Пратуранцчууд нь өөрийн эрх ашиг хүсэл сонирхолыг хөөдөг шинж чанартай байжээ. Тав дахь дэд үндэстэн болох Прасемитчууд нь шүүн тунгаах чадвараараа ялгардаг байв. Зургаа дахь дэд үндэстэн буюу Аккадийчууд сэтгэн бодох үйл ажиллагаагаа хөгжүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор шинэ содон зүйл, өөрчлөлт шинэчлэлтийг хүсэх болжээ. Долоо дахь дэд үндэстэн буюу Монголчууд сэтгэн бодох үйл ажиллагааг цааш нь хөгжүүлсэн боловч хамгийн эртнийх байх тусмаа хамгийн гүн утга санаатай байдаг гэдэг дүгнэлтэнд хүрцгээжээ.

Е.П. Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 278, 280, 281, 493, 532, 533-р хуудас) нь номныхоо нэг хэсэгт атлантыг Дэв, Перин гэсэн хоёр дэд үндэстэн болгон ангилаад, Дэвчүүдийг хүчирхэг аварга биетэн байсан гэж тодорхойлжээ. Номныхоо өөр нэгэн хэсэгт тэрээр атлантчуудыг Буддагийн төрхтэй хүмүүс болон Пасхын арлын чулуун хүний төрхтэй хүмүүс гэж ангилжээ. Тэгээд тэр Буддагийн төрхтэй хүмүүс нь Бурхны Хүүхдүүд байсан ба Пасхын арлын чулуун хөшөөний төрхтэй хүмүүсийг хорон муу санаат шидтэний хүүхдүүд гэж тэмдэглэжээ. Түүнээс гадна Е.П.Блаватская атлантчуудыг шар, хар, хүрэн ба улаан атлант гэж ангилжээ. Тэгээд, шар атлантчууд нь монгол, хятад, туранчуудын эх үндэс болж, хар атлантчууд нь африкийн негрүүдийн, улаан атлантчууд нь еврейчүүдийн эх сурвалж болсон гэсэн байна.

Мөн зохиогчийн бүтээлээс атлантчууд нь шинэ технологийг муу үйлд ашигласан нүглийн талаар бичсэнийг мөн олж уншиж болно (284, 378, 379-р хуудас). Бурхан байрлах ёстой Гэгээн цамхагийг сэтгэлийн янз бүрийн нүгэл үйлдсэн хүмүүсийн хөргийг тавьдаг газар болгосон байж.

Энэ бүх нүглийн шийтгэл болж атлантчуудын бүлэглэлүүдийн хооронд мөнхийн дайн дэгдэв. Лувсандамба (“Лхасын доктор”, 1994 он, 238,239-р хуудас) дайн дэгдсэний шалтгааныг атлантчуудын дунд олон янзын хэл үүссэнтэй холбон тайлбарлажээ.

Мөн тэрбээр атлантчууд шинэ төрлийн зэр зэвсэг бүтээсээр байсан гэж бичжээ. Хүмүүст гаж хувьслыг үүсгэгч туяан зэвсэг бүтээсэн байна. Дараа нь бактериологийн зэвсэг бүтээн хэрэглэсэн нь Дэлхий дээр олон төрлийн аймшигт өвчнийг үүсгэжээ. Удалгүй давхраа мандалд урьд өмнө үзэгдэж байгаагүй их үүлсийг үүсгэгч шинэ зэвсэг зохион бүтээжээ. Газар дэлхий чичирч тэнхлэгээсээ гарах шиг болов. Үер ус, гал түймэр, үхлийн туяа зэрэг нь хүмүүсийг сая саяаар нь устгалаа. Хүмүүсийн зарим нь усны мандал дээр хөвөгч битүү онгоцонд сууж, зарим нь нисэгч төхөөрөмжөөрөө агаарт хөөрөн амь гарахыг оролдож байв.

Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937 он, 2-р боть, 278, 439, 466, 534-р хуудас) атлантчуудын өөр хоорондын дайны талаар дараах зүйлийг бичжээ. Дэлхийн бодит сүнсний доод түвшинг удирдаж, нийт хүн төрөлхтний 2/3-ийг эзэлдэг байсан хар атлантчууд хүн төрөлхтний 3/1-ийг эзэлж бурханд үнэнч хэвээр үлдсэн шар атлантчуудтай дайтаж байлаа. Атлантчуудын энэ хоёр бүлэглэл хоорондоо биеийн байдлаараа төдийгүй мөн сэтгэл оюунаараа ихээхэн ялгаатай байжээ. Тэд бүгд анхдагч мэргэн ухаан, байгалийн нууц зэрэгт ихээхэн нэвтэрсэн боловч хоорондоо тэмцэлдэж байлаа. Шар арьстнуудын тэргүүлэгч нь цэвэр ариун хүмүүстэй нисдэг завиа ахан дүүс тэргүүлэгчиддээ дараах үгтэй захианы хамт илгээжээ (379-р хуудас): *“Шар арьстан болгон хар арьстан бүрт нойрыг илгээг. Тэд хүртэл бүү зовж шаналаг. Нарны Бурханд үнэнч хүн бүхэн сарны Бурханд үнэнч хүн бүхнийг хувь тавилангаасаа зугтаах чадалгүй болгон хүлэг... Хар арьстнууд сэсэн нэмэгдэж буй уснаас айхдаа виманагаа санахад үгүй болсон байг.”*

Тэгэхээр лемурчуудын соёл иргэншлийн дараа үүссэн атлантчуудын соёл иргэншил нь аажимдаа лемуро-атлантчуудын мэдлэгийг эзэмшин хөгжүүлснээрээ өндөр хөгжилтэй соёл иргэншил болж чаджээ. Гэвч энэ соёл иргэншлийн дотор дайнд хүргэсэн хагарал үүсчээ. Шинэ шинэ зэвсэг ашигласан мөнхийн дайн нь Атлантидыг мөхөлд хүргэжээ.

## **Атлантидын мөхөл. Ертөнцийн Их Үер**

Энэ тухай мэдээллийг бид Е.П.Блаватскаягийн агуу бүтээлээс олсон юм (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 158, 179, 276, 278, 279, 284, 364, 365, 378, 379, 392, 393, 416, 438, 439, 458, 466, 495, 501, 509, 514, 535, 536, 537, 541, 546-р хуудас). Зарим нэгэн нэмэлт зүйлийг Р.Штайнер (“Дэлхийн түүхээс”, 1992 он, 147-р хуудас), Лувсандамба (“Лхасын доктор”, 1994 он, 239, 240-р хуудас) нарын номоос оруулав.

Хожуу үеийн атлантчууд эцэс төгсгөлгүй дайн дажин дунд амьдарч, эцэстээ дэлхийн тэнхлэгийн тогтворт нөлөөлсөн хүчирхэг шинэ зэвсэг хэрэглэжээ. Дэлхийн бөмбөрцгийн тэнхлэг шилжсэнээр газрын гадаргууд өөрчлөлт орж, Атлантидын эх газрууд усанд автан живж, шинэ эх газрууд үүссэн байна.

Хар, шар атлантын хооронд болсон сүүлчийн үхлийн тулаан нь үер буух агшинд ховсын нөлөөн (телепатийн зэвсэг) дор байсан хар атлантчуудын мөхлөөр төгссөн юм. Шар атлантчууд нисдэг төхөөрөмжөөрөө (вимана) гал усны Орон болох Гималай, Төвд болон Говьд нисэн очиж амь гарчээ. Атлантидын эх газар бүгд живэн алга болжээ.

Ертөнцийн Их Үер нь “туйлууд өөрчлөгдсөн”-өөс болж үүсчээ. Е.Блаватскаягийн номоос “Гал усны Орон” гэдэг нь туйлын бүс байсныг ойлгож

авлаа. Үүнийг үндэслэвэл Атлантидын үед Хойд Туйл нь Гималай, Төвд, Говийн элсэн цөл нутагт байсан нь тодорхой болж буй юм. Тэнхлэг шилжих явцад Хойд Туйл одоогийн бүс рүү шилжжээ.

*“Ертөнцийн Их Үерийн үед дэлхий бүхэлдээ усан далай болон хувирч, зөвхөн Гималай, Төвд болон өндөрлөг газар болох Говь зэрэг л уснаас цухуйж байжээ. Говийн элсэн цөлд маш өргөн уудам дотоод тэнгис байжээ. Уг дотоод тэнгист манай иргэншлийн өмнөх соёл иргэншлийн хүний сүүлчийн төлөөлөгчид нутагладаг байсан үзэсгэлэн гоогоороо хорвоод хосгүй нэгэн арал байжээ. Энэ арал одоо ч Их Говийн элсэн цөлөөр хүрээлэгдэн оршоор байдаг гэсэн домог яриа бий.”*

“Хэт оюунтан”-уудын ивээлийг хүртсэн атлантчуудын нэгэн омог байсан. Тэд нэгэн тэнгисийн гайхамшигт эрэг дээр амьдардаг байсан тухай Лувсандамба бичсэн байдаг. Их үерийн дараа тэдний нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш хэдэн мянган тохой өндөрт өргөгдөж өндөр уулсаар хүрээлэгджээ (үүнийг Говь гэж таамаглаж болох). Энэ омгийн бөө төлөгчид их үерийг зөгнөн хэлдэг байжээ. Тэгээд тэд түүх, дэлхийн газрын зураг, одон орон болон шинжлэх ухааны тэргүүлэгч ололт амжилтыг алтан самбарт буулган урьдчилан бэлджээ. Эдгээр алтан самбарыг багаж төхөөрөмж, ном судар, болон бусад эд зүйлсийн дээжтэй цуг нэг нэгнээсээ алслагдсан чулуун агуйнуудад хийж, ирээдүйн хүмүүст өөрсдийн түүхээ мэдүүлэх зорилгоор нуужээ.

Энэ тэнгисийн ойролцоох хуурай газар өргөгдсөнөөс уур амьсгал нь өөрчлөгдөж, ихэнх оршин суугчид нь цочир хүйтрэлээс болж үхэцгээжээ. Амьд үлдсэн нэг нь өнөөгийн тэсвэр хатуужилт Төвдчүүдийн өвөг дээдэс болжээ. Чухам энэ л нутагт уулын ангал, хөндийд Мэдлэг нуугаастай байгаа. Шинэ бөө төлөгчдийн зарим нь эдгээр агуйд нэвтэрч чадсан. Устаж үгүй болсон соёл иргэншлийн талаарх үлдсэн баримтууд нь хэн ч харж хамгаалдаггүй Тянь Шань уулсын дунд буй хаягдсан хотод үлджээ.

Төвд болон Говийн агуйнуудад Их Мэдлэг булагдсан тухай Е.П.Блаватскаягийн бүтээлүүдээс ч мөн харж болно. Гэвч тэрээр алтан самбар, ном судрын тухай дурдаагүй, харин дэлхийн бөмбөрцгийн энэ хэсэгт самадийн байдалд буй хүмүүсийн тухай нууцлаг битүү зүйлийг бичсэн байдаг: “Ариун Арал живэхэд амьд үлдсэн Үхэшгүй хүмүүс нь Говийн Их цөлд очиж амь гаран, одоог хүртэл тэндээ Дайчин Сүнснүүдээр хамгаалуулан хэнд ч үл үзэгдэм оршоор буй (466-р хуудас)”, “Вараг байгуулж буй Аирьяна-Ваэдждод нэг жил нь нэгэн өдөр шөнө мэт санагдана...”(365-р хуудас), “... чи Варад эр эм хүмүүсийн үрийг, мөн төрөл бүрийн малын үрийг эдгээр хүмүүс Варад иртэл хадгалахаар авчир...”(364-р хуудас).

Эдгээрээс дэлхийн бөмбөрцгийн эргэлтийн тэнхлэг өөрчлөгдөж, дэлхийн туйлууд солигдсоноос болж үүссэн их үерийн үед атлантчуудын нэг хэсэг Гималай, Төвд, Говийн бүс нутагт очиж амь гарсан гэж дүгнэж болно. Атлантидын үед энэ нутаг нь туйл байсан бөгөөд өнөөгийн Хойд туйлын бүс нутгаас өөр уур амьсгалтай байжээ. Энэ хэсэгт өндөр хөгжилтэй атлантчуудын омог амьдардаг байжээ. Гэсэн ч энэ бүс нутгийн өндөр уулс, уулсын бэл амьдрахад хэцүү бэрх нөхцөл байдалтай байжээ. Амь гарсан атлантчуудын нэг хэсэг нь одоогийн Төвдчүүдийн өвөг дээдэс болсон бол нөгөө хэсэг нь самадид орон өөрийгөө, мэдлэг ухаанаа олон мянган жилээр хадгалжээ. Мөн эдгээр уулын агуй хөндийд атлантын соёл иргэншлийн мэдлэгийг гэрчлэх алтан самбар, ном, зэр зэвсэг нь булаатай байгаа.

Зохиогчид “цэвэр ариун” хүмүүс л аврагдсан гэж тэмдэглэсэн байдаг. “Цэвэр ариун” хүмүүс гэдэг нь “цэвэр ариун сэтгэлтэй хүмүүс” буюу самадид ороход зайлшгүй шаардлагатай сэтгэлийн сөрөг энергээсээ ангижрах чадвартай хүмүүс юм.

Атлантчуудаас битүү тусгаарлагдмал онгоцоор хөвж явсан хэсэг хүмүүс болон амьдарч байсан газартайгаа цуг далайн түвшнээс дээш өргөгдсөн хүмүүс л амь аврагджээ. Бусад нь усанд автан амь үрэгдсэн, эсвэл тэдний толгой дээрээс уулс ойчсон ч байж болох.

Атлантид хэзээ мөхсөн бэ? Энэ тухай мэдээллийг бид зөвхөн Е.П.Блаватскаягийн бүтээлээс л олов. Тэрээр номныхоо нэлээд хэдэн хэсэгт Атлантидын Эх газруудын мөхөл болон Их Үер 850000 жилийн тэртээ болсон гэж тэмдэглэсэн байдаг. Их Үерийн үед атлантчууд бүгд устаж үгүй болоогүй юм. Амьд үлдсэн нэг хэсэг нь 850000-700000 жилийн өмнө үхжээ. Үүнээс цааш зохиолч нэлээд зөрүүтэй зүйл бичжээ. Номныхоо нэг хэсэгт тэрээр 850000 жилийн өмнө олон арван үер болсоны сүүлийнх нь 100000 жилийн өмнө болсон гэж бичсэн боловч өөр нэг хэсэгт 850000-110000 жилийн хугацаанд дахин үер болоогүй гэж бичсэн байлаа. Тэрээр мөн 850000 жилийн тэртээ Атлантидыг сөнөөсөн Их Үер нь хүмүүсийн ой санаанд үлдэн Библид бичигдсэн Ногийн их үер юм. Жижиг хэмжээний үерүүд нь түүнтэй ямар ч холбоогүй гэжээ.

110000 жилийн тэртээ юу болсон бэ? Нострадамус, Е.Блаватская болон “Акашийн товчоо”-нд 850000 жилийн тэртээ Говь, Гималай, Төвдөөс гадна усанд авталгүй үлдсэн хэсэг газар нь Платоны тодорхойлон бичиж хаа сайгүй “Платоны арал” нэрээр алдаршсан Атлантын далай дахь нэгэн арал юм. Платоны арал дээр мэдлэг, технологио алдаагүй хэдэн атлант амьд үлджээ. Тэд далай тэнгисээс ил гарч буй шинэ шинэ эх газар дээр дөнгөж үүсч байсан манай иргэшлийн хүмүүсийн хөгжилд нөлөөлж байжээ. Е.П.Блаватская 78000 жилийн тэртээ Египет уснаас дөнгөж гармагц египетийн агуу пирамидуудыг платоны арлын атлантчууд барьсан гэж бичжээ. Тэрээр мөн эртний египетчүүдэд атлантчуудын үзүүлж байсан

нөлөөг “Нэн эртний египетийн хаант улс нь атлантчуудын бүх мэдлэгийг эзэмшсэн байсан ч судсаар нь атлантчуудын цус гүйж байгаагүй” гэж бичжээ.

110000 жилийн тэртээ Платоны арлын атлантчууд тэнгэрийн хаяанд нэгэн шинэ од байхыг харжээ. Нострадамусын бичсэнээр уг од нь аажимдаа томрон томорсоор удалгүй тэсэшгүй халууныг үүсгэжээ. Энэ бол Атлантын далайд унасан Тифоны (Нострадамусын хэлснээр) солир байлаа. Солир унаснаас Платоны арал живж, Дэлхий дээрх сүүлчийн атлантчууд сөнөсөн байна. Солир газрын гадаргууг цөмлөн, далай руу халуун лав урсжээ. Маш их хэмжээний уур, тоос шороо агаарт дэгдсэнээс олон жилийн хугацаанд дэлхий дээр түнэр харанхуй нөмөрчээ. Тэр үед дөнгөж үүсээд байсан манай соёл иргэншлийн хүмүүс амьдралын хүнд ширүүн нөхцөлтэй тулгарчээ.

Хятадын ном зохиолуудад *Ma li ga si ma* гэж нэрлэдэг Атлантидын тухай дүрслэл мөн гардаг бөгөөд тэднийг далайд живсэн гэж бичсэн байдаг. Амь аврагдсан Хятад Ной нь хүн төрөлхтний удмыг залгуулжээ. Атлантидын мөхлийн талаар бид хоёр таамаглалтай үлдсэн. Эхнийх нь (Е.Блаватская) Ертөнцийн Их Үерийн шалтаг нь газар зүйн гамшгаас болсон гэдэг. Хоёр дахь таамаглал нь (“Акашийн товчоо”, Лувсандамба, Нострадамус мөн Блаватская номныхоо өөр нэгэн хэсэгт) шинэ технологи, мэдлэгээ буруугаар ашигласан атлантчуудын нүглийн талаарх мэдээ сэлт юм.

Атлантидын мөхлийн шалтгааныг судлах явцад үечилсэн газар зүйн гамшиг болсныг үгүйсгэж болохгүй. Хэдийгээр хуучирсан шашны номлол мэт санагдаж буй ч атлантчуудын нүглийн хүчин зүйлийг мөн үгүйсгэж болохгүй.

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнд олж авсан мэдээллээс үзэхэд атлантчууд нь Ертөнцийн Мэдээллийн оронтой холбоотой байсан. Тэндээс мэдлэгээ байнга сэлбэж байв. Тэндээс (Бурхнаас - зохиолчийн тэмдэглэл) олж авсан мэдлэгээ дайны зориулалтаар ашиглах нь үнэхээр маш том нүгэл. Нарийн ертөнц (сэтгэлийн энергийн ертөнц) нь бодит ертөнцөд ямар нөлөө үзүүлдгийг бурхан л мэдэх байх. Магадгүй сэтгэлийн сөрөг энерги нь газар зүйн гамшигийг үүсгэдэг ч юм бил үү. Гэвч атлантчуудын үйлдсэн нүгэл нь манай иргэншлийн хүмүүст кармын хамгийн хүнд шийтгэл болох Дээд Оюун Ухааны “SoHm”-ын зарчмыг нэвтрүүлэхэд хүргэж, биднийг Ертөнцийн Мэдээллийн Орноос тасалснаар өөрсдөө боловсрохыг тулгасан юм. Зөвхөн зарим нэгэн Гэгээнтнүүд л дээд Оюун Ухаанд холбогдох азтай төрдөг.

Атлантчууд болон манай соёл иргэншлийн хүүсийн хоорондын харьцааны талаарх Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937 он, 2-р боть, 178, 278, 384, 387, 439, 440, 441, 495, 509, 532, 533, 536-р хуудас), “Акашийн товчоо” (Р.Штайнер, “Дэлхийн түүхээс”, 1992 он, 31, 33,38, 41, 46, 56-р хуудас) болон Лувсандамбын (“Лхасын доктор”, 1994 он, 240-р хуудас) бичсэнийг эмхтгэвэл маш сонирхолтой дүр зураг үүсдэг.

Манай соёл ирэншлийн хүмүүс (тав дахь буюу арийн үндэстэн) нь атлантын соёл иргэншлийн үед Их Үерээс (850000 жилийн тэртээ) өмнө 200000 жилийн өмнө буюу 1000000 орчим жилийн өмнө үүсчээ. Тэр үеийн атлантчуудаас ер бусын дүр төрхтэй хүүхдүүд төрж эхэлжээ. Чухам тэр хүүдүүд л манай иргэншлийн анхны хүмүүс байжээ. Эхлээд үүнийг тэд гаж үзэгдэл гэж үзэж байсан боловч ийм хүүхдүүд улам олон болж байлаа. Тэд атлантчуудаас биеэр жижигхэн байсан боловч өнөө үеийн хүнийг бодвол өндөр байжээ.

Хамтран амьдарч байсан үе буюу Их Үерийн өмнөх үед тэдэнд атлантчуудын нэгэн адил "SoHm"-ын зарчим үйлчилдэггүй, тэд ч гэсэн Ертөнцийн Мэдээллийн Оронтой холбогддог байжээ. Сүүлчийн илгээлт болох "SoHm"-ын зарчим нь Их Үерийн дараагаас үйлчилж эхэлсэн юм.

Их Үерийн дараа хар, шар, улаан, хүрэн зэрэг арьстнуудаас тогтсон цөөн тооны атлант амьд үлджээ. Мөн манай иргэншлийн хүмүүсээс цөөхөн хэд нь амьд үлдсэн байна. Тэднийг бүгдийг нь Е.Блаватскаягийн (278-р хуудас) атлант хэмээн нотолж байгаа Вайсвата Ману (Ной) аварсан байна.

Манай иргэншлийн хүмүүс Их Үерийн дараа ч тэр үлдсэн атлантчуудтай дайтсаар байлаа. Эдгээр дайн дажин нь хүмүүсийн ой санаанд ид шидийн хүчтэй ("Билгийн нүд"?) аварга биетнүүдийг (перчүүд болон девчүүд) ялан дийлж буй эрэлхэг зоригт баатруудын тухай домог яриа болон үлдсэн бололтой.

Гэсэн ч манай иргэншлийн хүмүүс болон атлантчууд бие биенээсээ тусдаа үржээд зогсохгүй мөн хоорондоо холилдон үрждэг байжээ. Энэ саармагжилт нь атлантчуудын сүүлчийн арал болох Платоны арал живэх хүртэл үргэлжилжээ. Энэ үед атлантчуудын дээд үе нь өөрсдийн ялгарах шинж чанараа улам бүр алдсаар, залуу үеийнхээ шинжтэй болсоор байлаа. Платоны арлын атлантчуудтай урт удаан хугацааны турш холилдон эвтэй амьдарч байсан эртний Египетийн соёл иргэншил нь атлантчуудын олон нууц мэдлэг, технологийг эзэмшиж чаджээ.

Цус холилдох явцад шар атлантууд хятад, монгол, тураанчуудыг үүсгэж, хар атлантууд негрүүдийг, улаан атлантууд еврейчүүдийг, хүрэн атлантууд европчуудыг үүсгэсэн бололтой. Хүн төрөлхтний үүсэл гарлын Төвд, Африк гэсэн хоёр эх сурвалж байна. Гэвч бидний бодлоор хүн төрөлхтний үүсэл гарлын Африкийн эх сурвалж 11000 жилийн тэртээ Платоны аралтай цуг устсанаар дэлхий дээр төвд эх сурвалжийн хүмүүс дийлэнх болон үлджээ (Үүнийг офтальмогеометрийн судалгаагаар бас баталсан).

Гэвч хамгийн сонирхуштай нь зохиогчид бүгдээрээ их үерийн дараа үлдсэн дөрөв, тав дахь үндэстний хүмүүсийг "бурханлаг хаад" захирдаг болсон тухай бичсэн байдаг. "Бурханлаг хаад" гэж хэн юм бэ? Эдгээр зохиогч лемура-атлантчуудыг "Бурханы хүүхдүүд" гэж нэрлэж байсныг эргэн санавал Их Үерийн

дараа Дэлхий дээр амьд үлдсэн дөрөв, тав дахь иргэншлийн хүмүүсийг лемуро-атлантчууд тэргүүлдэг байжээ гэж таамаглаж болох юм. Эдгээр тэргүүлэгчид амьд үлдсэн хүмүүсийг мэдлэгээ дээшлүүлэн, техник технологи хөгжүүлэх, газрын баялгийг ашиглах г.м. зүйлд сургажээ. Тэдгээр тэргүүлэгчид нь Дээд Оюун Ухаантай холбоотой байжээ. Тэгвэл Их Үерээс 1 сая орчим жилийн өмнө болсон их гамшгийн үед сөнөж мөхсөн лемуро-атлантчууд хаанаас гарч ирэв? Ингэхлээр шаардлагатай үед гарч ирдэг янз бүрийн соёл иргэншлийн төлөөлөгчдөөс тогтсон Хүн Төрөлхтний Генийн Сан байдаг гэсэн таамаглал өөрийн эрхгүй төрж байгаа юм.

## Дүгнэлт

Дэлхий дээр ээлж дараалан оршиж байсан Лемур болон Атлантид нь өндөр хөгжилтэй соёл иргэншлүүд байжээ. Гэвч эдгээр соёл иргэншлийн техникийн хэт өндөр хөгжил нь уг иргэншлээ мөхөлд хөтөлсөн дайн дажинд хүргэжээ. Дэлхий ертөнц лемурчуудыг болон атлантчуудыг устгасан хоёр гай гамшгийг даван туулсан.

Соёл иргэншил бүхэн өмнөх соёл иргэншлийнхээ нэмэрт үүсэн бий болдог. Гэвч эртний мэдлэг, технологи нь дараачийн соёл иргэншилдээ шилждэггүй байсан. Дэлхийн гамшгийн дараа хүн төрөлхтөн урьд өмнө байсан мэдлэг оюуны хөгжлөө алдан, амьдралын хүнд хэцүү нөхцөлд орж бүрэн зэрлэгших аюултай тулгардаг байв.

Агуйн мухарт нуугдсан мэдлэг, хаанаас ч юм гарч ирж байсан “Бурханлаг хаад” л хүмүүст тусалж, хөгжлийн замд нь хөтөлдөг байлаа.

Магадгүй гамшгийн дараа амьд үлдсэн хүмүүст хөгжихөд нь туслаж шинээр хүн төрөлхтөн үүсгэх зорилготой самадид буй янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсээс тогтсон генийн сан үнэхээр байдаг ч юм бил үү? Манай соёл иргэншилд ч мөн гамшиг учирч болно. Хүн төрөлхтний генийн сан одоо ч байдаг юм гэж үү? Тэнд, самеди-агуйд юу нуугдаж байгаа бол?



Наймдугаар хэсэг

## Самади-агуйд

Номондоо манай шинжилгээний ангийн шинжилгээ судалгааг он дарааллаар нь буулгахыг оролдсон юм. Өмнөх хоёр бүлэгтээ бид Буддагийн болон өмнөх соёл иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг дүрсэлсэн мэдээ баримтанд анхаарлаа хандуулан дарааллаасаа нэлээд хазайлаа. Бонпо-ламтай хийсэн урт ярилцлагын дараа би түүнтэй нүүр нүүрээрээ ярилцахаар нөгөө өрөөнд орсноор судалгааны тухай хүүрнэлээ түр завсарласан билээ.

### Би үүнийг Бурханд ч хэлэхгүй

Би Бумба ламтай юу ярьсан бэ? Би самади-агуйд орох эрхтэй Онцгой хүмүүстэй уулзаж, нууцат самади-агуйн талаар олж авсан бага ч гэсэн мэдээллээ шалгах хүсэл төрсөн гэдгийг уншигч та тааварлаж ядах юун. Бумба ламтай хийсэн уулзалтын дүнд бид уулзаж ярилцах ёстой олон хүний нэрсийн жагсаалтыг гаргахад хүрсэн юм. Эцсийн эцэст бид нэгэн самади-агуйн байрлалыг мэдэж аван, энэ самади-агуйг хамгаалдаг Онцгой хоёр хүний нэрийг мэдсэн юм. Энэ агуй хаана байдаг вэ? Түүнийг хамгаалж буй хүмүүсийг хэн гэдэг вэ? Энэ асуултанд би Онцгой хүмүүсийн үг болох “Би үүнийг бурханд ч хэлэхгүй!” гэсэн үгээр хариулна. Уншигч авгай намайг ойлгоно байх гэж найдаж байна. Дэлхий ертөнц дээрх хорон муу хүч дэндүү их, харин энэ бол хэтэрхий ариун зүйл юм.

### Самади-агуйгаас бид юу олж авахийг хүссэн бэ?

Самади-агуйд орохоор явж байх хугацаандаа бид түүнд ямар ч саадгүй орж, самадид буй манай иргэншлийн болон өмнөх иргэншлийн хүмүүсийг олж харахгүй л болов уу гэдгээ мэдэж байлаа. Сэтгэлийн энергэн саад

байдаг тухай олон арван баримт мэдээлэл зүгээр нэгэн зохиомж байсан нь юу л бол. Учир нь Генийн сангийн нэгэн хэсэг болж буйгаараа самади-агуйд сайн санаа агуулсан болгон орохгүй нь ойлгомжтой. Хэрвээ бид самади-агуйд орлоо гэж бодоход сэтгэлийн энергийн саадыг мэдрэх бол уу? Тэр нь ямар байх бол? Бид үхчихгүй байгаа?

Харамсалтай нь хүмүүс, ялангуяа үл итгэгчид өөрсдийгөө бүгдийг мэддэг, байгаль дэлхийн бүх нууц нээгдсэн гэж үзэх хандлагатай байдаг. Энергийн үл мэдэгдэх төрлүүдийн талаар, тэр тусмаа сэтгэлийн энергийн талаар ярихад хүнд. Цөмийн энергийн талаар юм мэдэгдээгүй байхад ураны орд газрын орчим амьдардаг хүмүүсийн нууцлаг үхлийн талаар олон тооны баримт илэрхий байсан манай зууны эхэн үед ч иймэрхүү үл итгэгчид байсан байх. Сэтгэлийн энергийг судлахад одоохондоо хүнд хэцүү учир магадгүй одоо ч иймэрхүү явдал тохиолдох биз.

Онцгой хүмүүс үүнийг хэрхэн хүлээж авдаг бол? Самади-агуйд орох үедээ юу хардаг тухайгаа тэднийг ярина гэж бодолтгүй. Бидний шинжлэх ухааны нэрийн өмнөөс яваа гэсэн итгэмжлэх бичиг огт ач холбогдолгүй бөгөөд тэд Бурханд ч хэлэхгүй гэж л хариулах байх гэсэн урьдчилсан таамаг байлаа. Атлантын зураг хамгийн гол найдвар минь байлаа. Магадгүй Онцгой хүмүүс иймэрхүү дүр төрхийг самади-агуйд орох үедээ харсан бол ямар нэгэн хэмжээгээр хариу үзүүлж болох юм. Онцгой хүмүүс биднийг Европын самади-агуйнуудын хамгаалагчид гэж ойлгон самадид буй хүмүүсийн дүр төрхийг “манайх ийм, харин танайх ямар вэ?” гэсэн зарчмаар харьцах ч юм бил үү. Өмнөх иргэншлүүдийн хүмүүсийн гадаад төрхийг шинжлэх ухааны үүднээс сэргээн бүтээж байгаа манай судалгаа тэдний сонирхлыг татаж, тэд засвар оруулах ч юм бил үү. Өөрөөр хэлбэл бид Онцгой хүмүүстэй шууд ярина гэж найдалгүй, дам аргаар агуу нууцыг дэлгэлгүйгээр бидэнд хэрэгтэй мэдээллийг авахыг хүссэн юм.

**Төвд тосгон** Уул толгод даван бид 3 мянган метрийн өндөрт байрлах төвдийн нэгэн жижигхэн тосгонд ирэв. Манай хэсэг уулын урт замыг саадгүй сайн туулав. Ямартаа ч Лобанков бид хоёр спортын аяллын мастер, бусад гишүүд маань туршлагатай аялагчид байлаа. Эвтэй найртай жуулчдын багийн гишүүд бид бүх Оросын нөхөн суулгавар, нүдний мэс заслын төвийг үүсгэн байгуулж байснаа эргэн дурсацгааж явав. Бидний хэсэг эмч эрдэмтэд спортын аяллаар идэвхтэй хичээллэхээ больсон ч, аялах сэтгэл маань одоо ч хэвээр явдаг.

Манай аяллын зорилго болсон Төвдийн жижигхэн тосгон бяцхан чулуун байшингууд, захдуу байх сүм дуганаас тогтож байлаа. Эндхийн хүмүүс дээш доош нь огцом шатаар холбож, давчуухан зайд шавааралдуулан барьсан, ханандаа цаас, шохой ч үгүй умгар өрөөнүүдэд тун даржин амьдрах аж. Оройдоо их сэрүүхэн.

Бид тэдний байранд оролгүй тосгонд ойрхон майхнаа босгов. Оршин суугчид нь биднийг маш их сониучирхаж байлаа. Хүүхдүүд майхны хажууд дөхөн биднийг чимээгүй хардаг байлаа. Тэд өгсөн чихрийг маань ичингүйрэн авснаа, даруй зугтаж одно. Хэн нь ч англиар ярьдаггүй болохоор бид орчуулагч Кирамын тусламжтайгаар л харьцах хэрэгтэй болж байлаа.

Эхлээд бид эндхийн уулнуудад агуй байдаг эсэхийг асуухад бүгд л маш олон агуй байдаг гэж байснаа самади-агуйн талаар асууж эхлэхэд хэн нь ч хариу хэлсэнгүй. Үүнээс өмнө инээмсэглэн ярьж байсан хүмүүс энэ асуултанд хариулалгүй дуугүй өнгөрөөж байв. Самади-агуйн нууцыг зөвхөн Онцгой хүмүүс ч бус мөн нутгийн ардууд тэр аяараа хамгаалдаг мэт сэтгэгдэл төрсөн.

Энэ тосгонд бид хоёр Онцгой хүнтэй уулзсан юм.

## Онцгой хүмүүс

Онцгой хүмүүсийн нэг нь 60 настай, нөгөө нь 95 настай байсан ч аль аль нь наснаасаа залуу харагдаж байлаа. Одоогоор самади-агуйд зөвхөн нэг Онцгой хүн л орж байгаа бөгөөд нөгөө нь нас өндөр болсны улмаас хэдэн жилийн өмнөөс самади-агуйд орохоо больсон нь тодорхой болов. Тэд хоёул гэр бүлтэйгээ цуг нутгийн ардуудын нэгэн адил байранд амьдарч байв.

Гурав хоногийн турш бид тэдэнтэй янз бүрийн сэдвээр ярилцаж үзсэн ч самади-агуйн талаар асуудал хөндөгдмөгц тэд дуугаа хурааж байлаа. Самади-агуйн талаар илүү шамдангуй тавьсан асуултанд тэд “Энэ бол нууц” гэж хариулж байлаа.

Алс холын энэ тосгонд ирсэн зорилго маань бүтэлгүйтлээ гэж санагдмаар байлаа. Онцгой хүмүүс биднийг зүгээр л тэдний амьдралыг сонирхож энэ тэрийг ярилцахаар ирээгүйг ойлгож байлаа. Бидний сонирхол бол тэдний хамгаалдаг самади-агуй гэдгийг тэд маш сайн мэдэж байв. Хэрвээ Онцгой хүмүүс бидний сонирхлыг маш их татаж байсан шиг бид ч мөн тэдний хувьд маш их сонирхууштай хүмүүс байсан байх. Алс холын Орос орноос ирсэн мөртлөө самадийн талаар мэддэг цагаан арьстай хүмүүсийг сонирхох нь улам бүр нэмэгдэж байлаа. “Тэдний нутаг Орос оронд ч мөн самади байдаг юм болов уу?”, “Самади-агуйн талаар тэд хаанаас мэдсэн юм бол?” – гэж тэд бодож байсан байх. Агуу нууцыг чандлан хадгална гэсэн ам тангараг нь юм ярих нь бүү хэл юм асуух ч боломжгүй болгож байлаа.

Сүүлчийн хувилбар бол атлантын зургийг Онцгой хүмүүст үзүүлээд ийм нүүр царайг агуйд харсан уу гэж асуух байсан юм. Гэсэн ч энэ хувилбарыг би хамгийн эцсийн хариуцлагатай мөчид хэрэглэхээр шийдэн хадгалсаар байв.

Онцгой хүмүүстэй дэлхий дээрх хүн төрөлхтний үүслийн талаарх хийсэн хоёр уузалтын дараа бидний харилцаа зөөлөрч харилцан итгэлцэл үүсч эхлэв. Үүнээс үүдээд би бага Онцгой хүнээс (тэрээр 60 настай) маргааш нь бидэнтэй

уулзаж, дахин нэг удаа самади-агуйн талаар ярьж өгөхийг зориг гарган хүсэв. Азаар тэр зөвшөөрч, уулзах цагаа товлов.

Уулзалтанд би, Валентина Яковлева болон орчуулагч Кирам бид гурав явав.

## Бага Онцгой хүн юу ярив?

Бид өөд өдөөсөө харан суухад би инээмсэглээд,

- Та жаран настай гэхэд их ануухан харагдаж байна. Энэ нь таны байнга ордог самади-агуйн нөлөө юу?

Бага Онцгой хүн инээмсэглээд:

- Би одоо хүртэл идэвхитэй бэлгийн амьдралаа үргэлжлүүлсээр байгаа. Би таван хүүхэдтэй гэж хариулав.

- Энэ чинь самади-агуйн нөлөө юу?

- Тийм гэж би бодож байна. Тэнд хэн нэгэнд нь үхлийн аюултай, хэн нэгэнд нь ашигтайгаар нөлөөлдөг янз бүрийн ер бусын хүчин чадал их байдаг.

- Та самади-агуйг аль хир удаан хамгаалж байгаа юм бэ?

- Лам нарын зөвлөл намайг сонгон туршилтын бясалгалд оруулснаас хойш маш олон жилийн турш би энэ агуйг хамгаалж байна,- гэж Бага Онцгой хүн хариулав.

- Туршилтын бясалгалыг даван гарна гэж юу гэсэн үг вэ?

- Бясалгалын байдалд байхдаа самади-агуйд орох зөвшөөрөл авах...

- Тэгээд хэн зөвшөөрөл өгдөг юм бэ?

- Тэр!

- Тэр гэж хэн юм бэ?

- Тэр гэж самади-агуйд байгаа хүн.


- Тэр гэж хүн юм уу?

- Тиймээ, самадид байгаа хүн.

- Тэр хүн чинь ер бусын дүр төрхтэй юм уу, жирийн нэгэн дүр төрхтэй юм уу?

- ...

- Та нар самади-агуйд орохдоо ганц ганцаараа ордог уу, эсвэл том Онцгой хүнтэйгээ цуг ордог уу?- гэж би сэдвээсээ хазайн асуухад,



Бага Онцгой хүний хамт

- Ганц ганцаараа ордог. Харин одоо би самади-агуйн цорын ганц хамгаалагч нь. Том Онцгой хүн дэндүү хөгширчээ. Түүнийг үхсэний дараа лам нарын цуглаан дахин хэн нэгнийг нэр дэвшүүлнэ. Мэдээж, хэрвээ тэрээр шалгуур бясалгалыг даван гарч чадах юм бол шүү дээ.- гэж бага Онцгой хүн хэлэв.

- Та тийшээ аль хир олон удаа ордог вэ?

- Би сард нэг удаа ордог.

- Орох бүрдээ та самади агуйд хэр уддаг вэ?

- Би дунджаар тэнд гурван цаг болдог.

- Та сарын аль өдөр нь тийшээ ордог вэ?

- Самади-агуйд зөвхөн тэргэл сартай үед л орж болдог. Эсвэл тэргэл сартай өдрөөс хойш 11, 12 хоногийн дараа мөн орж болдог. Би тэргэл сартай шөнө ордог. Агуйн бүх өрөө тасалгаа руу орж болдоггүй. Зөвхөн тодорхой нэг өрөө тасалгаанд л орох зөвшөөрлийг олгодог...

- Тэр өрөөнүүдэд ч мөн самадид буй хүмүүс байдаг уу?- гэж би тэсэлгүй асуучихав.

- Энэ бол нууц,- гэж бага Онцгой хүн хариулав.

- Миний ойлгосноор бол агуйд тас харанхуй байдаг. Та тийшээ орохдоо гар чийдэн авч ордог уу?

- Тиймээ, гэхдээ маш бүдэгхэн дэнлүү хэрэглэдэг. Үүнийг агуйн тасалгаа бүрт хэрэглэж болдоггүй.

- Агуйд орохдоо та мөргөл үйлддэг үү?

- Самади агуйд орохоос нэг долоо хоногийн өмнө би бясалгал хийж эхэлдэг. Самади-танхимаас багахан орцоор тусгаарлагдсан агуйн эхний өрөөнд ороод би залбираад, бясалгалаа улам нэмэгдүүлдэг. Тэгээд дараа нь би Бие рүү очиж болдог.

- Бие ямаршуу харагддаг бол?

- ...

- Залбиран, бясалгалаа нэмэгдүүлдэг агуйн эхний өрөөнд та ер бусын хүчний үйлчлэлийг мэдэрдэг үү?-гэж би самадид буй хүний тухай асууснаа булзааруулан асуув.

- Тиймээ,-гэж бага Онцгой хүн хариулаад,- чухам энэ өрөөнд л ер бусын хүчийг мэдэрч эхэлдэг. Залбиран, бясалгалаа гүнзгийрүүлдэг нь эдгээр хүчний нөлөөнд дасан зохицоход хэрэгтэй байдаг. Хэрвээ энэ нь бүтэлгүйтвэл агуйд орж болохгүйг мэдэрч эхэлдэг.

- Яагаад?

- Амиа алдаж ч болно.

- Ер бусын хүчнүүдийн үйлчлэлд дасан зохицож чадсангүй гэдгээ та хэрхэн мэдэрдэг юм бэ?

- Толгой өвдөж эхлээд... агуйд ормооргүй санагддаг.

- Ормооргүй санагддаг аа?

- Агуйгаас гармаар санагддаг. Дасан зохицож чадаагүйгээс бачимдах сэтгэл төрдөг. Хэрвээ чи бэлтгэлгүйгээр агуйд орвол аминд аюултай,- гэж бага Онцгой хүн улайран хэлэв.

- Ер бусын хүчний нөлөөлөлд дасан зохицож чадаагүй азгүйтэл аль хир олон тохиолддог вэ?

- Эхэндээ харьцангуй олон байсан. Хэрвээ би бүтэн сартай шөнө агуйд орж чадахгүй бол энэ оролдлогоо 11,12 хоногийн дараа дахин давтдаг. Яваа яваандаа азгүй оролдлогын тоо багассаар байсан. Одоо бол би оролдох болгондоо амжилттайгаар самади-агуйд ордог.

- Энгийн нэгэн хүн самади-агуйд орж чадах уу?

- Энэ чинь маш аюултай. Амиа алдах аюултай. Тэндхийн зам нь маш муу, могой ихтэй.

- Гэхдээ агуйн дулаан нь +4 хэм байгаа нь могойн хувьд маш хүйтэн юм биш үү?

- Энэ агуйд могойн хаан амьдардаг.

- ...?

- Энэ бол шидэт молгойнууд. Агуйд анир чимээгүй байдаг. Энэ “могой”-нууд орж ирсэн хүнд нөлөө үзүүлдэг.

- Ямар?

- Агуй руу ормооргүй санагдаж, толгой өвдөж эхэлдэг. Хэрвээ үүнийг даван туулах юм бол үхэх болно.

- Самади-агуйг арай дэлгэрэнгүй дүрсэлж өгөхгүй юу?- гэж би гуйхад,

- Эхний танхимд чи ер бусын хүчний үйлчлэлийг нэлээд хүчтэй мэдэрч эхэлдэг.- гэж бага Онцгой хүн хэлээд,- Тэнд самадид буй хүн байдаггүй. Хамгийн аюултай хэсэг нь эхний танхмийг бусад танхимтай холбодог өндөр нарийн орц бөгөөд тэнд ер бусын хүчнүүд их төвлөрсөн байдаг. Энэ орцны цаана зарим нэгэнд нь намайг орохыг зөвшөөрдөг самади-танхимууд байдаг.

- Самади-танхимуудад та юу харсан бэ?

- Энэ бол нууц.

- Самадид буй хүн аль танхимд нь байдаг юм бэ?

- Энэ бол нууц.

- Самади-танхимд ороод та самадид буй хүнтэй ярилцдаг уу?

- Би зөвхөн түүнийг харах эрхтэй, ярих эрхгүй. Самадид буй хүн ярьж болно, харин би болохгүй.

- Самадид буй хүн юун тухай ярьсан бэ?

- Энэ бол нууц.

- Ярихдаа самадид буй хүн амаа ангайдаг уу?

- Бага зэрэг нээдэг. Гэхдээ тэр ярих тохиолдол маш цөөхөн байдаг.

- Самадид буй хүний бие ямар харагддаг вэ?

- Яг л зүгээр нэг хүний бие шиг, гэхдээ ялимгүй шардуу.
- Самадид буй хүн хувцастай байдаг уу?
- Хувцастай байдаг. Гэхдээ хувцасгүй ч байж бас болдог.
- Юу гэж ойлгох вэ?

- ...

- Та самадид буй хүний “ билгийн нүд”-ийг нь харсан уу?
- Тэдэнд “гуравдагч нүд” гэж байдаггүй. Би хэзээ ч олж хараагүй.
- Самадид буй хүний биеийн хэмжээ нь ямар вэ? Том биетэй юу, эсвэл жирийн л биетэй юу?

- Энэ бол нууц.

- Самадид буй хүн ямар байрлалд хэвтэж байдаг вэ?- гэж би үргэлжлүүлэн асуусаар байв.

- Тэр суугаагаараа байдаг,- гэж бага онцгой хүн хариулав.
- Сууж байдаг?
- Тиймээ, тэр Буддагийн байрлалаар сууж байдаг.
- Хана түшээд үү?
- Үгүй.
- Та самадид буй хүний биед нь хүрч үзсэн үү?
- Тиймээ.
- Түүний бие нь ямар байсан бэ?
- Хүйтэн хатуу байсан.

- Та яагаад зөвхөн зарим нэгэн самади–танхимд орох эрхтэй байдаг юм бэ?

Бусдад нь юу байгаа хэрэг вэ?

- Би үүнийг Бурханд ч хэлэхгүй.
- Самадид буй хүний нүд нь ямар вэ?

- ...

- Тэр ямар хамартай вэ?

- Энэ бол нууц.

Тэгээд би таамгийн атлантын зургийг гарган бага Онцгой хүнд үзүүлэв. Тэрээр маш анхааралтай хараад, хэд хэд дахин нүдэндээ ойртуулснаа хажуудаа тавьчихав.

- Та үүний тухай юу гэж бодож байна?- гэж би асуув.

Бага Онцгой хүн хоёр дахиад нэгэн өгүүлбэрийг маш түргэн түргэн давтан хэлэв.

- Тэр юу гэсэн бэ?- гэж бид Кирамаас асуухад,

- Тэр ямар нэгэн шашны зүйл ярилаа. Би ойлгож чадахгүй юм байна. Гэхдээ түүний сэтгэл маш ихээр хөдөлж байна,- гэж орчуулагч Кирам хариулав.

Бага Онцгой хүнээс цаашид дахин юм асуух нь утгагүй боллоо. Тэрээр эсвэл хариулалгүй өнгөрөөж, эсвэл энэ бол нууц гэж хариулж байсан юм. Бид түүнд

талархсанаа илэрхийлээд зургаа аваад майхан руугаа явлаа. Буудалласан газраа болсон ярианы талаар ярихад маш олон янзын санаа төрж, халуун яриа өрнөв.

- Хэрвээ түүнд мөнгө санал болговол энэ нь бузар хэрэг болно.- гэж Сергей Селивестров хэлээд,- Тэд хичнээн ядуу амьдарч байгааг хараач! Гэхдээ мөнгөөр худалдан авдаггүй юм гэж бас байдаг юм. Сүнсэнд мөнгө хэрэггүй.

- Мөнгөөр худалдаж авч болох юм чинь ариун байж таарахгүй,- гэж Валентина хэлэв.

- Дэлхийн хамгийн баян хүн Рокфеллерыг үхэхэд түүнээс юу үлдсэн юм бэ? Авсандаа тэрээр 500 ногооны үнэтэй хувцастай хэвтэж байсан нь л түүний амьдралдаа хийсэн бүтээснийг нь илтгэж байсан биз. Тэр сүнсээ ямар нэгэн зүйлээр баяжуулаагүй л болов уу. Бүхий л амьдралаа мөнгө олоход зориулсан. ЗСБНХУ-д Ленин бурхан мэт байж, хүмүүс энэ хуурамч бурханд мөргөж байсан. Америкт цорын ганц бурхан бол доллар бөгөөд Рокфеллер бүх насаараа энэ хуурамч бурханд мөргөдөг байсан. Хүмүүс Рерихийн өвийг судалдаг бол хэн нь ч Рокфеллерын өвийг судалдаггүй. Лужков ч сайн юм аа. Аврагч Христийн сүмийг сэргээснээр алдар нэрээ мөнхөлж чадлаа.

- Ер нь бол,- гээд Валерий Лобанков үргэлжлүүлэн,- бага Онцгой хүн нууцаа нээлгүйгээр сэтгэлийн энергийн саад болон агуйд самадид буй хүн бийг баталсан.

- Миний бодлоор бол тус агуйд атлант байгаа.- гэж Венер Гафаров хэлээд,- та нарын яриагаар бол бага Онцгой хүнд бидний зураг нөлөөлсөн гээ биз дээ. Самади-агуй гэдэг чинь л “мастеруудын” орж сэтгэлийн энергээ тэтгэдэг “академи” болох Шамбалын орон юм шиг санагдаад байна.

Гэлээ ч ... маш олон “гэвч” гэсэн үг үлдээд байлаа. Дараа өдөр нь том Онцгой хүнтэй уулзахаар Валерий Лобанков бид хоёр явлаа. Бид зөвхөн шууд бус асуулт тавин болгоомжтой ярих хэрэгтэй гэдгийг маш сайн ойлгож байлаа.

## **Том Онцгой хүн юу гэж хэлэв**

Нэг нүд нь зүгээр боловч нөгөө нүдэндээ үүлтэй бээвийж бээцийсэн энэ өвгөн 90 хол давсан настай гэдэг нь ямар ч байсан мэдрэгдэж байв. Харин ухаан тод саруул, яг ч үгүй шог байрын тэрээр залуу сэтгэлгээгээр хурдан хурдан хүүрнэнэ.

Гэрт нь умгар өрөөнд орчуулагч Кирам, Валерий бид гурав сандал аван сууцгаав.

Би цүнхээ уудлан таамгийн атлантын зургийг гарган том Онцгой хүнд дуугүй сарвайв. Тэрээр эрүүл нүдэндээ ойртуулан маш анхааралтай харав. Валерий бид хоёр ч гэсэн түүнийг анхааралтай ажиглаж байлаа. Гэсэн ч түүний нүүрэн дээр ямар нэгэн өөрчлөлт илэрсэнгүй. Том Онцгой хүн зургийг холдуулан тавиад:

- Би самади-агуйн талаар юу ч хэлэхгүй. Энэ бол маш том нууц.

- Самади гэж юу вэ? Энэ талаар тайлбарлаж өгөхгүй юу?- гэж би гуйхад,



- Үүнийг ч мөн би хэлж чадахгүй нь. Энэ тухай би Бурханд ч хэлэхгүй. Нөгөө Онцгой хүн ч энэ тухай юм хэлэхгүй.

Валерий Лобанков бид хоёр нэгнийгээ хараад, эхнээсээ л бид азгүйтлээ гэж үү хэмээн бодов.

Тэгээд би том Онцгой хүнд дөхөж очоод боловсон гэгч нь атлантын зургийг



*Том Онцгой хүн орчуулагч Кирам, В. Лобанковтай цуг*

аваад түүний нүдэнд ойртуулан шаргуугаар:

- Олон жилийн хугацаанд бид ийм дүр төрхтэй самадид буй хүнийг хайж байгаа юм. Тэрээр маш жижигхэн хамартай, том нүдтэй, жижигхэн чихтэй, аварга том биетэй, маш хүчирхэг цээжтэй. Та самади-агуйд ийм хүнийг харсан уу?

Том Онцгой хүн намайг цорын ганц хардаг нүдээрээ нэг том харснаа буруу харан чангаар,

- Би тийм хүнийг хараагүй.

- Магадгүй та ийм хүнийг орох эрхтэй агуйн танхимууддаа хараагүй юм болов уу? Магадгүй, бусад танхимд нь ийм хүн байдаг ч юм бил үү,- гэж би мөн л шургуугаар асуугаад зургаа харуулав.

- Энэ бол нууц.

- Гэсэн ч ийм дүр төрхтэй хүн самади-агуйд байдаг гэдэгт би итгэлтэй байна.

- Миний орох эрхтэй агуйн танхимуудад ийм дүр төрхтэй хүн байдаггүй.

Төстэй хүмүүс бий...

Лобанков бид хоёр мөн л харц солилцоод, Валерий:

- Тэнд тэгвэл олон хүн байдаг юм байна! -гэж би шивэглэв.

- Хэрвээ таны орох эрхтэй танхимуудад энэ зурагтай төстэй дүр төрхтэй хүмүүс байдаг бол... -гээд би хэргээр үгээ таслав.



- Бүгд адилхан бишээ, - гэж том Онцгой хүн ууртай нь аргагүй хэлэв.

- Тэгвэл агуйн бусад танхимуудад,- гээд би үргэлжлүүлэн,- яг ийм дүр төрхтэй хүмүүс байх ёстой.

- Тэд ч гэсэн яг ийм биш л дээ. Гэвч энэ бол нууц,- гэж том Онцгой хүн хэлэв.

Тэгээд тэр зургийг гартаа дахин аваад гэнэтхэн,

- Үүнийг хараад би маш их догдолж байна! Та нар энэ зургийг хаанаас авсан юм бэ?

Би маш учир битүүлгээр дуугаа хураав.

- Би танаас нэг зүйлийг лавлан асуух гэсэн юм.- гэж би

асуултанд нь асуултаар хариулаад,-та самадид буй хүмүүсийг “гурав дахь нүд”-тэй байхыг харсан уу?

- Үгүй, тэдэнд “гуравдагч нүд” гэж байдаггүй. Энэ бол бэлгэ тэмдэг.

- Танай агуйд ийм том, бас дээд зовхи нь өвөрмөц нугалаатай нүдтэй самадид байгаа хүн байдаг уу?

Энэ болгоныг би зурган дээр харуулав.

- Зарим хүмүүс нь маш том өвөрмөц нүдтэй байдаг. Зарим нь жирийн л нүдтэй байдаг.- гэж том Онцгой хүн хэлэв.

- Та өөрийн агуйдаа ийм жижигхэн хавхлаган - сариу хэлбэрийн хамартай хүнийг харсан уу?

- Тэдний хамрын хэлбэр нь өөр өөр. Зарим хүний хамар нь жижигхэн, заримынх нь жирийн хүнийх шиг том байдаг.

- Таны орох эрхгүй бусад танхимд чинь ийм жижигхэн, хавхлаган-сариу хэлбэрийн хамартай самадид буй хүн байж болох уу?

- Энэ бол нууц.

Лобанков миний чихэнд,

- “Энэ бол нууц” гэдэг чинь “тийм” гэдэг шиг л сонсогдож байна,- гэж шивнэв.

- Агуйд байгаа хүмүүсийн чих нь том байдаг уу, эсвэл зурган дээр байгаатай адил жижигхэн байдаг уу?- гэж би бүтэц зүйн асуулгаа үргэлжлүүлэв.

- Агуйд байгаа хүмүүсийн чих нь том байдаг. Зарим нь маш том чихтэй байхад, зарим нь жирийн хүмүүсийнх шиг чихтэй байдаг. Харин энэ зурган дээрх шиг ийм жижигхэн чих би хараагүй юм байна.- гэж том Онцгой хүн хариулав.

Лобанков бид хоёр нэгнийгээ хараад “чихийг нь ч алдаж дээ” гэж бодоцгоов.

- Агуйд байгаа хүмүүс яг энэ зурган дээрх шиг ийм амтай юу?

Том Онцгой хүн зургийг дахин нэг хараад,

- Үгүй, тэд ийм амтай биш. Тэдний ам нь яг л жирийн хүнийх шиг. Гэхдээ... шал ондоо ч байж болно.

- Ямар?

- Энэ бол нууц.

Лобанков бид хоёр дахиад л харц солилцоцгоов.

Магадгүй энэ Онцгой хүний орох эрхгүй танхимуудад ийм жижигхэн хавхлаган-саруу хэлбэрийн хамартай, ер бусын амтай хүн байдаг юм болов уу? Төвд сүмүүд дээрх нүдний дүрсээр атлантын дүрийг бүтээхэд нүүрний чухам энэ хэсэг л хүндрэлтэй байсан юм. Бид алдсан байж болзошгүй. Онцгой хүмүүс орох эрхгүй байдаг агуйн танхимуудад нууцлаг лемуру-атлантыууд самадийн байдалд байдаг бөгөөд хүн орж болдог танхимуудад нь самадид буй атлантыууд болон манай иргэншлийн хүмүүс байж болох. Магадгүй, энэ Онцгой хүн агуйн хажуугийн танхимд самадид буй лемуру-атлантыг харсан юм болов уу? Ямартай ч түүний ярианаас ийм дүгнэлт хийж болохоор байна.

- Агуйд байгаа хүмүүс том цээжтэй юу, эсвэл жирийн л цээжтэй юу?

- Зарим нь том цээжтэй, зарим нь ердийн л цээжтэй байдаг.- гэж том Онцгой хүн хариулав.

- Тэдний биеийн өндөр нь ямар вэ?

- Тэд чинь сууж байдаг болохоор хэлж мэдэхгүй юм байна.

- Гэсэн ч агуй дахь хүмүүс том биетэй юу, эсвэл жижигхэн биетэй юу?

- Зарим нь том, зарим нь жирийн л хүмүүс шиг жижигхэн байдаг.

- Агуй дахь хүмүүсийн гавал нь том байдаг уу, жирийн хүмүүсийнх шиг байдаг уу?

- Тэдний гавал янз бүр байдаг. Зарим нь маш том гавалтай байхад зарим нь цамхаг мэт хэлбэртэй урт гавалтай байдаг. Зарим нь жирийн л хүнийх шиг гавалтай байдаг. Тэд бүгд маш урт үстэй байдаг.

Лобанков бид хоёр дахиад л харц солилцов. Агуйд самадийн байдалтай янз бүрийн соёл иргэншлийн хүмүүс байдаг мэт сэтгэгдэл төрж байлаа.

Гэтэл том Онцгой хүн гэнэт бидний атлантын зургийг гартаа аваад, бидний асуултыг хүлээлгүйгээр,

- Хэрвээ агуй дахь хүмүүс энэ зурган дээрх шиг ийм нүүртэй бол тэд маш том биетэй байдаг. Хэрвээ тэд энгийн нүүртэй бол тэдний бие нь ч мөн нарийхан байдаг.

Лобанков бид хоёр дуугаа хураачихав. Том Онцгой хүн шууд бус ч самади-агуйд манай таамгийн атлант шиг дүр төрхтэй (мэдээж, зарим нэгэн засвартайгаар) хүн байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

- Та тэдгээр хүмүүсийн гар хөлөнд сарьсан холбоос байхыг харсан уу?- гэж би алмайрсан байдлаасаа гаран асуув.

- Үгүй, хараагүй. Тэдний гар хөлний хуруунууд нь жирийн боловч маш урт хумстай байдаг.

- Та гар юм уу, хөлийн сарьсан холбоосыг харахын тулд дэлгэж үзэж байсан уу?

- Үгүй, дэлгэж үзэж байгаагүй.

Лобанков: “Чи гараа хумиад үзээч, сарьсан холбоос харагдахгүй байхсан” гэж шивнэв. Би толгой дохилоо. Хяналтын асуултуудаа тавих цаг болжээ. Шинжлэх ухаанд хоёрдогч, заримдаа гуравдагч хяналт хэрэгтэй байдаг юм. Өөрөөр хэлбэл би түрүүн асуусан гол асуултаа дахин хоёр удаа асууж, том Онцгой хүн нэг л хариулт хэлж байна уу, эсвэл бидний амыг дагуулаад байна уу гэдгийг шалгах шаардлагатай байлаа.

- Та тэр агуйд буй хүмүүст “билгийн нүд” байхыг харсан уу?- гэж би юу ч болоогүй мэт асуухад,

- Тэр чинь бэлгэ тэмдэг төдий зүйл гэж би хэлсэн шүү дээ. - гэж том Онцгой хүн хариулав.

- Магадгүй, том гавлын ястай хүмүүс “гуравдахь нүд”-тэй юм болов уу?

- Тэд өөрсдөө зурдаггүй л юм бол байхгүй,- гэж том Онцгой хүн жуумалзан хэлэв.

- Агуйд байгаа хүний нүд нь ямар вэ?

- Заримынх нь том, заримынх нь жирийн л хүмүүсийнх шиг байдаг.

- Агуйд байгаа том нүдтэй хүмүүсийн нүд нь ямар байдаг вэ?

- Би яг нарийн хэлж чадахгүй байна. Гэсэн ч энэ нь жирийн хүнийхээс өөр.

- Том нүдтэй хүмүүсийн дээд зовхи нь ер бусын нугалаатай байхыг та анзаарсан уу?

- Үгүй, би тэгтлээ нарийн ажиглаагүй юм байна. Самадийн үед нүд нь хагас аниатай байдаг болохоор тэр том нүд ер бусын гэдгийг л хэлж чадна.

Лобанков:

- Нээрээ л дээд зовхины ер бусын нугалааг зөвхөн нүдний эмч хүн л анзаарна даа. - гэж шивнэв.

- Та агуйд ер бусын жижигхэн хамартай хүн харсан уу?,- гэж би хяналтын асуултаа тависаар байлаа.

- “Агуй дахь зарим хүмүүсийн хамар нь жижигхэн, зарим хүмүүсийн хамар нь ердийн хүмүүсийнх шиг том байдаг” гэж би урьд нь хэлсэн шүү дээ.- гэж том Онцгой хүн хэлээд,- гэхдээ л тэдний хамар наад зурган дээрх шиг чинь байдаггүй.

- Та орох эрхгүй агуйн бусад танхимуудад ийм хамартай хүмүүс байдаг уу? Би зургаа харуулав.

- Энэ бол нууц.

Анир чимээгүй боллоо. Том Онцгой хүн худал хэлээгүй нь мэдрэгдэж байлаа. Түүний давтсан хариултууд нь эхнийхтэйгээ яг таарч байсан юм.

Гэнэт том Онцгой хүн бидний атлантын зургийг гартаа авснаа:

- Би энэ нүүрний дүрийг хараад маш их сэтгэл хөдөлж байна!-гэв.

- Агуйд байгаа хүмүүс ямар толгойтой вэ?- гэж би мөчөөгөө өгөлгүй хяналтын асуултаа тависаар байлаа.

- Миний түрүүн ярьсанчлан зарим нь том толгойтой, зарим нь цамхаг хэлбэрийн толгойтой, зарим нь жирийн л толгойтой.

- Агуйд байгаа янз бүрийн хүмүүсийн биеийн хэмжээ нь ямар байдаг вэ?

- Би үүнийг чинь хэлээ биз дээ,- гэж том Онцгой хүн ууртай нь аргагүй дуугарав.

Дахин хяналтын асуулт тавиад хэрэггүй юм байна гэдгийг би ойлгов. Лобанков дахиад л миний чихэнд:

- Худлаа яриагүй байна шүү! Үнэн ярьж байна...- гэж шивнэв.

Би сэдвээ өөрчлөн нөгөө талаас нь хяналтын асуултынхаа гуравдахь хэсгийг үргэлжлүүлэхээр шийдээд,

- Хүн төрөлхтний удмыг газар дэлхий дээр үргэлжлүүлэхэд самади их ач холбогдолтой юу?

- Хэрвээ бясалгал амжилттай болсон бол самадид орж болно. Хэрвээ амжилттай болоогүй бол самадид орж болохгүй. Хүн төрөлхтний хувьд самадид ямар үүрэг гүйцэтгэдгийг би ярьмааргүй байна. Энэ бол нууц! -гэж том Онцгой хүн хариулав.

- Өнөө үеийн хүн урт хугацааны гүн самадид орж чадах уу?

- Орчин үеийн хүн чадахгүй. Учир нь үүний тулд Бурхнаас хүчтэй байх ёстой.

Эртний хүмүүс самадид-агуйд урт хугацаагаар самадид орох чадвартай байсан.

- Агуйнуудаас маш эртний хүмүүсийг самадидын байдалд байхад нь олж болох уу?

- Энэ бол нууц.

“Тийм” гэсэн үг гэж Лобанков бид хоёр бодов.

- Том толгойтой, ер бусын нүдтэй, жижигхэн хамартай, том чихтэй, том биетэй, том цээжтэй хүмүүс маш эртний хүмүүс байх. Тийм үү?- гэж би асуув.

- Энэ бол нууц.

- Танай агуйд ийм дүр төрхтэй самадид буй хүнийг олж болох уу?

- Энэ бол нууц.

- Агуйнуудад өмнөх соёл иргэншлийн хүмүүс самадидын байдалд хадгалагдаж байж болох уу?

- Болно. Энэ бол боломжтой зүйл.

- Агуйд самадийн байдалд хүн аль хир удаан хадгалагдаж чадах вэ?

- Энэ нь сүнсний хүчээс шалтгаална. Хүн самадид мянга, сая, түүнээс ч олон жилээр байж болно. Би дөнгөж 95 насалж байгаа учир үүнийг хэлэхэд хэцүү байна,- гэж том Онцгой хүн хэлэв.

- Та аль хир удаан самеди-агуйг хамгаалагч Онцгой хүний үүргийг гүйцэтгэж байна вэ?- гэж би асуултаа тависаар байлаа.

- Маш олон жил.

- Яг хэдэн жил вэ?

- Маш олон жил.

- Энэ бүх хугацаанд та самадигаас хүн гарч байхыг ганц ч удаа хараагүй юу?

- Үгүй, тийм тохиолдол байгаагүй.

- Таны хамгаалдаг самеди-агуйд хэн нэгэн нь самадид орж байсныг та санаж байна уу?

- Үгүй, тийм зүйл ч байгаагүй. Миний агуйд Төвдийн зарим нэгэн хүн самадид орохыг хүсэж байсан удаа бий.

- Тэгээд яагаад энэ нь бүтдэггүй байсан юм бэ?

- Тэд шалгуур бясалгалыг давж чаддаггүй байсан. Орчин үеийн хүн маш сул сүнсний хүчтэй гэж би хэлээ биз дээ. Эртний хүмүүс сүнсний хүч чадал сайтай байсан.

- Өөрөөр хэлбэл,- гээд би үргэлжлүүлэн,- тэд самеди- агуйд орж чадаагүй юм уу?

- Тиймээ, хэдийгээр тэд бясалгалыг маш сайн эзэмшсэн, самадид орох туршлагатай байсан ч орж чадаагүй.- гэж том Онцгой хүн хариулав.

- Тэд сэтгэлийн энергийн саадыг давж чадаагүй юм!-гэж Лобанков надаа аяархан хэлэв.

- Хэн тэднийг агуйд оруулаагүй юм бэ?

- Тэр!

- Тэр гэж хэн юм бэ?

- Энэ бол нууц.

Валерий бид хоёр харц солилцоод, сэтгэлийн энергийн хүчин чадлаар илүү, өндөр хөгжилт лемуру-атлант л болов уу гэж бодов.

- Самадид олон дахин орж болно гэж та бодож байна уу?- гэж би асуухад.

- Би тийм юмтай учирч яваагүй.

- Гэсэн ч таны бодлоор бол олон дахин самадид орж болох уу?

- Би тийм зүйлтэй учирч явсангүй.

- Гэсэн ч таны бодлоор бол энэ боломжтой зүйл үү?

- Тийм хүмүүс байдаг гэж би сонссон. Гэхдээ энэ талаар лам нар илүү сайн мэднэ. Би тийм хүмүүсийг хараагүй.

- Самадийн байдлаас гарсныхаа дараа хүн ердийн амьдралаараа амьдарч чадах уу?

- Мэдэхгүй, би хараагүй юм байна.

- Гэсэн ч таны бодлоор бол?

- Би өөрийн нүдээр хараагүй болхоор тааж хэлж чадахгүй байна. Лам нараас асуу. Тэд мэдэх ёстой.

- Ердийн хүмүүстэй адилгүй дүр төрхтэй хүн самадигаас гарч болох уу?

- Би үүнийг хараагүй.

- Тэгэхээр,- гээд би үргэлжлүүлэн шалгааж,- таныг самади-агуйг хамгаалж байгаа энэ бүх хугацаанд ер бусын дүр төрхтэй эдгээр хүмүүс хөдөлгөөнгүй суусаар л байсан уу?

- Тиймээ, гэхдээ зөвхөн ер бусын дүр төрхтэй хүмүүс бус энгийн дүр төрхтэй хүмүүс ч гэсэн хөдөлгөөнгүй суудаг,- гэж Онцгой хүн хариулав.

- Тэд ердөөсөө хөдлөөгүй гэж үү?

- Үгүй.

- Та агуйд байгаа хүмүүстэй ярьж байсан уу?

- Энэ бол нууц.

- Ер бусын дүр төрхтэй хүмүүс самадигаас гарвал ердийн хүмүүсийн амьдралаар амьдарч чадах уу, та юу гэж бодож байна?

- Чадах л байх, гэхдээ арай өөрөөр.

- Яаж?

- Энэ тухай лам нар илүү сайн мэднэ.

- Будда ер бусын дүр төрхтэй байсан. Магадгүй Будда ч гэсэн аль нэг агуйд самадийн байдлаас гарсан юм болов уу?

- Үүнийг би мэдэхгүй.

- Агуй дахь ер бусын хүмүүс Буддатай адилхан уу?

- Зарим нь адилхан. Зарим нь үгүй.

Валерий Лобанков бид хоёрын хувьд энэ мэдээллийг сонсоход маш таатай байлаа. Учир нь гэвэл энэ ертөнцийн соёл иргэншил бүрийн төлөөлөгчдөөс бүрдсэн бүхэл бүтэн холимог агуй байдаг тухай бидний таамаглалыг баталж байгаа юм.

- Юу хүмүүсийг самадийн байдлаас таслахад хүргэдэг вэ? Та юу гэж бодож байна?- гэж намайг асуухад,

- Үүнийг лам нар сайн мэдэх байх.

- Хүмүүс хэдэн мянга, сая жилээр самадид ордгийн учир нь юу юм бол?

- Миний бодлоор ихэнх нь самадид орж, хадгалагдан ирээдүйг харах зорилготой байдаг.

Том Онцгой хүн самадид буй хүний тухай эгээ л эмч хүн өвчтөнийхөө тухай ярьж буй мэт энгийнээр ярьж байлаа. Үүнд Хүн Төрөлхтний Генийн Сан гэдэг хамаагүй гүн утга учир агуулагдаж байгааг тэр мэддэг болов уу?

- Самади-агуйн үүрэг юу вэ? Та юу гэж бодож байна? Ийм маягаар Хүн Төрөлхтний Генийн Сан буюу дэлхийг хамарсан гамшигийн үед хүн төрөлхтнийг эргэн сэргээх чадвартай сан хадгалагдаж байгаа гэж та бодож байна уу?

- Би зөвхөн самади-агуйг хамгаалах л үүрэгтэй, шүүн тунгаах албагүй.

- Гэсэн ч та бүх насаараа самади-агуйг хамгаалж байгаа болохоор нэг удаа ч гэсэн юу хамгаалдаг талаараа бодолхийлж байсан байх.

- Самади-агуйнууд маш сайн хамгаалагддаг учир энэ нь хүн төрөлхтний хувьд маш их ач холбогдолтой байх ёстой. Газар дэлхий дээрх хүн төрөлхтний хувьд самади-агуй ямар үүрэгтэйг лам нар сайн мэдэж байгаа. Гэсэн ч энэ нь маш том нууц.

- Яагаад самади-агуйд жирийн хүмүүсээс гадна та бидэнтэй адилгүй ер бусын хүмүүс байдаг юм бэ? – гэж би мөчөөгөө өгөхгүй шалгаасаар л байлаа.

- Ер бусын хүмүүс чинь маш эртнийх. Харин самади маш урт удаан хугацаанд үргэлжилж болно. – гэж том Онцгой хүн хариулав.

- Самади-агуйнуудыг хэн хамгаалдаг юм бэ?

- Сүнс.

- Хэний сүнс?

- Түүний.

- “Тэр” гэж хэн юм бэ?

- Энэ бол маш том нууц.

- Та самади-агуйд сар бүр гурван цаг орохдоо юу хийдэг вэ?

- Тэнд бүх юм хэвэндээ байгаа эсэхийг шалгадаг.

- Яг юуг? Чулуу унасан эсэх, самадид буй биес зөв байрлалтай байгаа эсэхийг үү?

- Зөвхөн энэ ч бус.

- Тэгээд өөр юуг гэж?

- ...

- Самадид буй хүмүүс ямар байрлалаар суудаг вэ?

- Агуйд буй хүмүүс бүгд Буддагийн суудлаар суусан байдаг.- гэж том Онцгой хүн хариулав.

- Өөрөөр хэлбэл хөлөө доороо нугалж завилаад уу? Тэгвэл гар нь яаж байрладаг хэрэг вэ?- гэж би нарийвчлан асуусаар байлаа.

- Тэдний гар нь өвдгөн дээрээ байдаг.

- Таны түрүүн хэлсэнчлэн тэдний нүд нь хагас аниатай байдаг. Тэгвэл нүдний алим нь ямар байрлалтай байдаг юм бэ?

- Дээш харсан байдаг учир зөвхөн нүдний цөцгий нь л харагддаг.



- Унтаж байгаа хүнийх шиг, - гэж би Лобанковт шивнээд, - харин үхсэн хүнийх чигээрээ харсан байдаг юм. Энэ нь самадид байгаа хүмүүс амьд байгаагийн нэг баталгаа юм.

- Самадид байгаа хүмүүс юун дээр суусан байдаг вэ?

- Ихэвчлэн тэд доороо барын арьс дэвсдэг.

- Яагаад заавал барын арьс дэвсдэг юм бол?

- Мэдэхгүй.

- Та самадид буй хүмүүст гар хүрч үзсэн үү?

- Мэдээж.

- Ямар мэдрэмж төрж байсан бэ?

- Бие нь хүйтэн хатуу байсан.

- Самадид буй хүмүүс амьд уу?

- Мэдээж.

- Таны үед самадид орсон хүнийг та мэдэх үү? Би танай агуйн талаар яриагүй байна. Та түрүүн танай агуйд хэн ч самадид ороогүй гэж ярьж байсан. Бусад газарт?

- Олон жилийн өмнө, энэ зууны үед, миний таних Сурадж Баджра гэдэг Балба хүн Төвдийн агуйд самадид орсон юм. Тэр одоо хир нь тэндээ байгаа, - гэж том Онцгой хүн хэлэв.

- Энэ Сурадж Баджра гэдэг хүн чинь тэгээд шалгуур бясалгалыг даван туулж самади-агуйд орсон юм уу?

- Би мэдэхгүй байна. Тэр миний агуйд самадид ороогүй. Тэрээр шалгуур бясалгал хийх шаардлагагүй энгийн агуйд ч орсон байж болох. Магадгүй тэр эртний хүмүүсийн нэгэн адил хүчирхэг сэтгэлийн энергитэй байгаад шалгуур бясалгалыг даван гарсан ч байж болох.

- Таны хэлсэн үгнээс зарим нэгэн самади-агуйнууд сүнсээр хамгаалагдсан, зарим нэг нь хамгаалагдаагүй байдаг гэж ойлгож болох уу? Маш эртний хүн самадийн байдалд оршиж байгаа тэдгээр самади-агуйнуудийг л сүнс хамгаалсан байдаг юм уу?

- Энэ бол нууц.

- Дэлхий дээр өөр самади-агуйнууд байдаг уу?

- Байдаг. Ийм агуйнууд Төвд, Балба, Хятад, Энэтхэгт байдаг.

Хэдийгээр Лобанков бид хоёр том Онцгой хүн үнэн ярьж байна гэдэгт итгэлтэй байсан ч гуравдахь хяналтын асуултыг тавих цаг болсон байлаа.

- Агуйд буй хүмүүс ямар нүдтэй вэ?- гэж би ямартаа ч асуухад,

- Зарим нь ер бусын том, зарим нь жирийн л хүмүүсийнх шиг энгийн гэж хэлээ биз дээ.- гэж том Онцгой хүн ууртайгаар хариулахад,

- Тэд ямар гавалтай юм бэ?- гэж би асуухад,

- Зарим нь цамхаг хэлбэрийн гавалтай, зарим нь ердийн , зарим нь том гавалтай гэж хэлсэн биз дээ,- гэж бүр гайхаж орхисон том Онцгой хүн хэлэв.

- Тэгвэл агуйн хүмүүс ямар хамартай юм бэ?
- Миний түрүүний хэлсэн болгон үнэн,- гэж миний үгийг таслан тэрээр хэлэв.
- Тэгвэл ямар чихтэй вэ?

Том Онцгой хүн намайг учир ойлгохгүй нялх хүүхэд харж буй мэтээр харж байлаа.

- Болно! Уур нь хүрчихнэ!- гэж Лобанков шивнэв.
- Бид самади-агуйд орж болох болов уу?- гэж би гол асуудалдаа эргэн оров. Чимээгүй болцгоолоо. Том Онцгой хүн ийм юм асууна гэж бодоогүй бололтой.

- Та нар шалгуур бясалгалыг даван гарахгүй шүү дээ, - гэж тэрээр хариулаад,- бага Онцгой хүн бид хоёроос өөр хэн ч үүнийг агуйд орохын өмнө даван гарч чадаагүй юм шүү дээ.

- Гэсэн ч?
- Энэ чинь аминд аюултай.
- Бид сайн санаа агуулж байгаа...
- Энэ чинь ямар ч ач холбогдолгүй.
- Гэсэн ч оролдоод үзэж болно биз дээ?

Том Онцгой хүнд бид маш их таалагдсан нь харагдаж байлаа.

- Би бодоодхоё, маргааш ирээрэй.- гэж тэр хариулав.

Бид том Онцгой хүнтэй их л дотноор салах ёс гүйцэтгээд, түүнд атлантын зургаа дурсгаад явлаа.

Гадаа гарсан хойноо Лобанков:

- Бид яасан азтай юм бэ! Тэр яасан мундаг юм бэ? Бүх л насаараа самадид буй хүмүүстэй шууд харьцаж байсан хүнээс гайхамшигтай мэдээлэл олж авлаа. Хамгийн гол нь тэнд өөр өөр соёл иргэншлийн олон хүн байдаг байна. Энэ чинь л хүн төрөлхтний Генийн Сан байна! Биднийг тийшээ оруулах болов уу?

Маргааш нь Лобанков бид хоёр том Онцгой хүнтэй уулзаж, ядахдаа самади-агуйг харах зөвшөөрөл гуйв. Тэгээд бид самади-агуйд фото болон видео төхөөрөмжүүдийг хэрэглэх нь хатуу хориотой гэж лам нараас мэдсэнээ яриу.

- Эхний самади-танхимд ороход ч аминд аюултай гэдгийг дахин сануулмаар байна.- гэж том Онцгой хүн хариулав.

- Бид үүнийг ойлгож байна.

- Би бага Онцгой хүнтэй ярьж үзсэн л дээ. Та нарын нэгэнд нь агуйн эхний танхимд орохыг зөвшөөрлөө. Цаашаа тэртэй тэргүй явж чадахгүй. Та нар шалгуур бясалгалыг даван гарч чадахгүй. Үүнийг хэн ч даван гарч чадаагүй юм! – гэж том Онцгой хүн хэлэв.

- Баярлалаа.

- Гэхдээ,- гэж тэрээр нэмж хэлээд,- хэрвээ бие чинь эвгүй болох юм бол буцаад явах хэрэгтэй! Эс тэгвэл үхнэ. Ойлгосон уу?

- Гар чийдэн авч явж болох уу?- гэж Лобанков хэлэв.

- Болно. Гэхдээ бүдэгхэнийг болно.

## **Биднийг самади-агуйд оруулах болов уу?**

Буудалласан газраа эргэн ирээд бид яагаад зөвхөн нэгийг нь оруулах болсон шалтгааныг бодож олохыг хичээж байлаа.

- Тэдэнд биднийг агуйн эхний танхимд оруулан цааш орж чадахгүй гэдгийг харуулах нь биднийг сэрэмжлүүлэхээс илүү амархан байх. Бид өөрсдөө самади-агуй хаана байдгийг олж мэдээд өөрсдөө очоод үхчихвэл яана!- гэж Лобанков хэлэв.

- Тэд биднийг бөөнөөрөө тийш явчихна гэж болгоомжилж байгаа байх,- гэж би таамаглаад,- нэг талаас бид бүгдээрээ үхээд тэдэнд маш том төвөг учруулах болно. Нөгөө талаас бидний торсын орнууд нэгдэж агуйд буй самади-хүмүүст нөлөөлж болох юм. Хятадын цэргийн хороо самади-агуйд хэрхэн орсоньг эргэн сана даа!

- Тэд биднийг Орост самади-агуйг хамгаалдаг Онцгой хүн гэж үзээд, Оросын Онцгой хүн түвдийн самади-агуйд орж чадах нь уу гэж шалгаж байж ч болох юм,- гэж Лобанков үргэлжлүүлээд,- Өөрөөр хэлбэл бидний хийж чаддаг юмыг харийн хүмүүс та нар хийж чадах уу гэж байгаа хэрэг.

- Магадгүй л юм.

Орой нь самади-агуйд намайг оруулахаар болж тогтов.

Бага Онцгой хүн, Лобанков, орчуулагч Кирам бид дөрөв тосгоныг орхин явлаа. Хоёр гурван километр газар бид уулын бэл дагсан жижигхэн жимээр явсаар дараа нь бага Онцгой хүн нэгэн үл анзаарагдам жимээр эргэн уулын өөд өгсөж эхлэв. Чулуугаар бүрхэгдсэн бүсийг өнгөрөөд хад асганы хаант улсад ирлээ. Бага Онцгой хүн хад асга дамжин явсаар биднийг нэгэн жижигхэн агуйн үүдэнд авчирлаа.

- Энэ чинь тэгээд өнөөх самади-агуй юу?

- Тийм,- гэж бага Онцгой хүн хариулав.

Лам нар самади-агуйнууд нуугдсан байдалтай байдаг гэж ярьж байсныг санах. Үнэхээр ч эргэн тойрны хүн амьтангүй зэлүүд уулын бэлд иймэрхүү агуйн үүднүүд зөндөө байх аж. Тэгэхээр иймэрхүү агуйн ангал сав бидний харж буй уулсын дотор хичнээн байгаа бол?!

## **Самади-агуйд**

Бид ирчихлээ,- гэж бага Онцгой хүн дахин хэлэв.

Бид амьсгаа даран түр сууж би самади-агуйд орохоор бэлдэж эхлэв. Үд дунд болж байлаа. Онцгой хүмүүс агуйд ордог бүтэн сартай шөнө биш байсан нь харамсалтай.

Би гортекс хүрэм өмсөөд халаасандаа цанын малгай хийж, хэрэг болж магадгүй гэж бодоод олс авав. Бүдэг гэрэлтэй чийдэн ажиллаж байгаа эсэхийг шалгалаа.

Миний орсон багавтархан ам хэдэн метрийн дараа өргөслөө. Би буцаж яваад агуйн амнаас толгойгоо цухуйлган миний зургийг авахыг хүслээ. Самади-агуйн үүдний зургийг авахыг эрс хориглож байсан бага Онцгой хүн миний зургийг авахыг зөвшөөрлөө. Лобанков миний зургийг нэг л удаа дарав.

Бүгд самади-агуйн гадаа үлдлээ. Би дотогш оров. Дээр дурьдсан өргөссөн хэсгийн цаана хоёр гурван метрийн өргөнтэй нарийн хонгил эхэллээ. Түүгээр 20-30 метр яваад түнэр харанхуйн дунд бүр ч нарийн хэсэгт цоожтой төмөр хаалгатай таарав. Би гайхшаа баран зогсов.

Гэнэт миний ард хөлийн чимээ гарлаа. Зогтосов. Би чийдэнгээ тусгаад бага Онцгой хүнийг олж харлаа. Тэрээр үг дуугүй (орчуулагчгүйгээр бид ойлголцож чадахгүй байв) ойртон ирж цоожийг онгойлгоод мөн л үг дуугүй буцаад явав.

Чийдэнгийн гэрэлд би хаалгыг анхааралтай ажив. Уг хаалгыг тав зургаан миллиметрийн зузаантай төмрөөр хийж улаан, хүрэн, шар будгаар будсан байлаа. Эдгээр будагнууд нь ойролцоогоор нүдийг санагдуулам гурван дүрс үүсгэж байлаа. Хаалгыг хаданд тогтоон, цементээр бэхэлсэн байв.

Тонгойн хаалгаар ороход яагаад ч юм миний араас хэн нэг нь хаалгыг хаачихгүй байгаа гэсэн бодол төрлөө.

Хэдэн метр яваад би уужим танхимд орж явчихав. Хүйтэн байсан тул би цанын малгайгаа өмслөө. Танхимаар 15-20 метр яваад мэдрэмжээ чагнан түр зогсов. Нэг их юм мэдэгдсэнгүй. Чийдэнгээ унтраан агуйд л байж болох түнэр харанхуй, анир чимээгүйн дунд хэдэн минут зогслоо. Дахин өөрийн биеэ чагнахад бүх юм хэвийн зөвхөн зүрх минь л жигдхэн цохилон амьд байгааг минь сануулна. Айдас төрөхгүй байлаа. Олон жилийн спортын идэвхитэй амьдрал болон хүнд хэцүү үед төвлөрч чаддаг мэс засалч эмчийн туршлага маань хэрэг болов бололтой.

Би чийдэнгээ асаагаад цааш явав. Удалгүй танхимын эсрэг талд хоёр метр орчим өргөнтэй бас нэгэн хонгил байхыг олж харав. “Самеди-агуйн сэтгэлийн энергийн саад үйлчилж эхэлдэг хонгил нь энэ байх даа” гэж би бодов.

Биеэ анхааралтайгаар чагнасаар би энэ хонгилд дөхөн ирэв. Бүх юм тайван байлаа. Гэтэл хонгилд ороход хоёр гурван метр дутуу байх үед би хөнгөн түгшүүр мэдэрч эхэллээ. Эхлээд ямар ч байсан айж байгаа юм байна даа гэж бодоод энэ мэдрэмжээ давахыг хичээж байлаа. Хонгилд орох тэр мөчид би үл ойлгогдох аймшигийг мэдэрч эхэлсэн нь хонгилоор хэдэн арван алхам явсны дараа үүссэн шигээ л гэнэт алга болж, оронд нь үл ойлгогдох хүчтэй ундууцлаар солигдов. Дахин хэдэн арван алхам явсны дараа толгой өвдөж эхэллээ.

Уул нь ч би өөрийгөө хулчгар хүн гэж боддоггүй л дээ. Уул, агуйд би анх удаагаа орж буй нь энэ биш. Энэ аймшиг, ундууцал нь нэг л хиймэл, өөрөөр хэлбэл шалтгаан нь надад бус байсныг би мэдэрч байлаа.

Дахин хэдэн алхамын дараа ундууцлын мэдрэмж нэмэгдэж, толгойн өвчин тэвчихийн аргагүй болж ирлээ. Эдгээр мэдрэмжүүдийг даван би урагшаа дахин

10 метр орчим газар явав. Толгойн өвчин нэмэгдэж тэсэхүйеэ бэрх боллоо. Би чийдэнгээ унтраагаад түнэр харанхуйн дунд бууж өгөхгүй байгаа толгойн өвчнийг даван гарч сэтгэлээ төвлөрүүлэхийг хичээж байлаа. Тэгээд би хүн суурьшсан нутгаас 200 км-ийн алсад орших Саяны уулсад аяллаар явж байх үедээ хөлөө өвдөгний үений холбоос шөрмөсөө таслаж, тойгоо гэмтээчихээд тэсэшгүй бэрх өвдөлтөө дарахын тулд үе үе зогсон анхаарлаа төвлөрүүлж байснаа хүчээр санахыг оролдов.

Гэвч Саянд байхад энэ арга нь тус болж байсан бол энд, агуйд ямар ч үр дүн өгсөнгүй. Толгой ангалзан хүчтэй лугшиж, одоохон задрах гэж буй мэт санагдана. Гэвч тэвчихэд хамгийн бэрх нь толгойн өвчин бус, харин үл ойлгогдох ундууцал байлаа. Сэтгэлийнхээ гүнд би энэ нь хиймэл мэдрэмж гэдгийг мэдэрч яагаад уурлан ундууцаад байгаагаа ойлгохгүй байлаа. Сэтгэл чинь ундууцан агуйгаас гарахыг хүсэж байгаа мэт мэдрэмж төрж эхэллээ. Удалгүй би нууцлаг самуди-агуйн гүн рүү орж яваадаа ундууцаж байгаагаа ойлгов. Энэ үйлчлэлд миний тархины сэтгэл ханамжийн эсрэг мэдрэмж болох ундууцлыг хариуцсан хэсэг нь өртжээ.

Би чийдэнгээ асаан үлдсэн бүх хүчээ шавхан дахин хэдэн алхам урагшлав. Гэнэт бие сулран, толгой аймшигтай өвдөж, ундууцан амар заяа үзэхээ байлаа. Цаашаа явж болохгүй, тэгвэл үхнэ гэдгийг ойлгон дэмий л чийдэнгийн гэрлээ урагшаа тусгав. Яагаад ч юм урагш сунгасан чийдэнтэй гараа мэдрэхээ больж эхлэв. Агуйн хүйтэнд яагаад ч юм чийхраад байгаа хүйтэн хөлс нүдийг бүрхэнэ.

Чийдэнгийн гэрэл хонгилын үзүүр, түүний цаадах агуйн танхимыг сулхан гэрэлтүүлнэ. Өвдөлт, сэтгэлийн эмх замбараагүй байдлыг эс тоон би урагшаа харж эхлэв. Гэрэл яасан их дутагдаж байнаа! “Онцгой хүмүүс зөвхөн бүдэг чийдэн авч орохыг зөвлөсөн нь ийм учиртай юм бий!” – гэж би бодов.

Чийдэнгийн бүдэгхэн гэрэлд хэсэг чулуу болон шалнаас дээш төвийх хэдэн дүрс харагдлаа. Энэ юу вэ? Самадийн байдалд сууж байгаа хүмүүсийн дүрс биш биз дээ? Тиймээ, хүний дүрс шиг байна. Чийдэнгийн бүдэгхэн гэрэлд тэд аварга том болж харагдаж байлаа.

Өөр юу ч хэлж чадахгүй нь. Би эргээд арай ядан хөлөө зөөн буцаад алхлаа. Хонгилоос эхний танхимд орох үедээ бүдэрч ойчоод урьд нь гэмтээж байсан өвдгөө цохичихов.

Би эхний танхимын голд үйлчлэлээрээ миний гайхшийг төрүүлсэн хонгил руу нуруугаа харуулан зогсож байлаа. Аажимдаа би амьд байгаагаа мэдэрч эхэллээ. Бодол санаа саруулсаж, толгойн өвчин намдан, уур ундууцал ариллаа. Урагшаа дахин жоохон явсан бол үхэх байснаа ойлгож байлаа. Самуди-агуйд ч бай, үхнэ гэсэн бодол мэдээж намайг баярлуулсангүй.

“Лемурчууд, атлантчууд! Тэд чинь амьд юм байна. Хэдэн сая жил амьдарсаар байгаа юм байна! Тэд дэлхийн хүн төрөлхтний төлөө өөрсдийгөө хамгаалж байгаа юм байна! Тэдэнтэй харьцуулахад би юу юм бэ? Судалгааны сониуч

зандаа хөтлөгдсөн бяцхан элсний ширхэг төдий л нэг муу эрдэмтэн!- гэж бодож байлаа. Самади-танхимд орох хонгилд төрсөн мэдрэмж бүхнээ эргэн санаа. “Тэр ч их хүчтэй юм аа! Нууцлаг Тэр гэж хэн бэ? Лемуро-атлант юм уу? Нэгэн Гэгээнтэн Шамбалын орныг хамгаалах хэрэггүй. Тэр чинь дэлхий дээрх хүнээс хамаагүй дээд, ангид зүйл гэж ярьж байсныг санаа. Сэтгэлийн энергийн хүчин чадлыг мэдэрснийхээ дараа л би түүний хүчин чадлыг ойлгож эхэллээ. Би Түүнээс зөвшөөрөл л авдаггүй юм бол хэзээ ч түүнийг даван дийлж чадахгүй юм байна!”- гэсэн бодол миний толгойд эргэлдэж байлаа.

Гэсэн ч бяцхан эргэлзэл үлдсэн байлаа. Би сэтгэлийн энергийн хүчийг хэтэрхий мэдрэгээр хүлээн авсан юм бол уу? Агуйн аниргүйд энэ бүхэн надад зөвхөн санагдсан бол яах вэ? Би дахин самади-танхимд хүргэдэг хонгил руу орохоор явлаа.

Бүх зүйл мөн дарааллаараа давтагдав. Хонгилд орохын өмнө бяцхан түгшүүр үүсэв. Би энэ мэдрэмжийг чагнан түр зогсов. Энэ нь хиймэл гэдэг нь тодорхой боллоо. Учир нь одоо бол энэ мэдрэмж өмнө хүлээж буй үл мэдэгдэх зүйлстэй холбоотой байж таарахгүй. Дараа нь аймшиг төрж, энэ нь хэдийн танил болсон ундууцлаар солигдов. Мөн л толгой лугшин өвдөж эхэллээ. Урагшлах тусам, ундууцал, толгойн өвчин хоёр нэмэгдэж барагцаалвал мөн л өнөөх газраа хүрээд тэсэшгүй болж байлаа. Гараа өргөн гэрэл тусгах чадалгүй болсон байв. Би буцаад явлаа.

Би эхний танхимын голд дахиад л зогсож мөн л чийдэнгээ унтраав. Бүх л мэдрэмж аажимдаа намдаж байсан ч, бие сулрах нь нэмэгдсэн байлаа. Энэ бүх мэдрэмж нь стрессийн үр дүн биш, харин самади-агуйн сэтгэлийн энергийн саадны үйлчлэл гэдэгт эргэлзэхээ бараг болилоо.

Гэсэн ч шинжлэх ухаан гурвалсан хяналтыг илүүтэйд тооцдогийг бодон үлдсэн бүх хүчээ шавхан самади-танхимд хүргэгч хонгил руу чиглэв. Түгшүүр, аймшгийн танил “бүс”-үүдийг туулаад цаашлан толгойн өвчин, ундууцлын “бүс”-эд хүрсэн ч эдгээр мэдрэмж хамгийн их мэдрэгдэж байсан хэсэгт хүрэх чадал үлдсэнгүй. Биеийн хүч, тамир хүрсэнгүй.

Би буцаад явлаа. Чийдэнгийн гэрэлд агуйн эхний танхимыг хараад санаа амарч, дотогш орон эсрэг талын хананд нь гарах гарцаа хайж эхэллээ. Нэгэн хар толбонд дөхөн очтол хонхорхой төдий л байв. Дараачийн хар толбо нь жинхэнэ гарц байлаа. Хаалга энэ байна! Түүнийг өнгөрөөд би агуйн эцсийн хонгилд оров. Бие сулран зовоож байлаа. Елена Блаватскаягийн “Эдгээр хонгилыг Сүнсний Дайчид хамгаалдаг...” гэсэн үг санаанд оров.

Өдрийн хурц гэрэл нүд өвдтөл гялбуулав. Валера Лобанков гүйн ирж гараас минь чанга атган

- Анд минь, чи амьд уу?- гэв.

- I'm alive (би амьд байна) гэж би яагаад ч юм англиар хариулав.

## **Нууцын хөшиг дөнгөж нээгдэж байна**

Тосгоны дэргэдэх буудалласан газраа ирэхэд толгой өвдөн бие суларч байлаа. Венер Гафаров миний судасны лугшилт, цусны даралтыг хэмжиж, зүрхийг чагнав. Лугшилт арай түргэсэн, даралт хэвэндээ, зүрх зүгээр ажиллаж байлаа. Хоёр хоногийн дараа бие сулрахаа больж би жирийн хүний цовоо сэргэлэн байдалдаа эргэн оров. Харин толгой л дахиад хэдэн өдөр өвдөв. Хожим Орост эргэн ирсэн хойноо сайтар шалгуулахад бүх юм хэвийн түвшинд байсан юм.

Буцахдаа бид цүнхэндээ хамаг юмаа хийж далдлан, мөрөндөө үүрцгээгээд, Онцгой хүмүүстэй салах ёс гүйцэтгэхээр тосгон руу явав. Салах ёс гүйцэтгэж байхдаа Онцгой хүмүүс бүх насаа зориулсан зүйлийг нь ихэд сонирхсон явуулын улс буцлаа гээд харамссан ч юм шиг, эсвэл энэ явуулын хүмүүс тэдний хадгалдаг агуу нууцыг дахин сонирхохгүй болсонд сэтгэл нь амарсан ч юм шиг харж байлаа.

Сэтгэлд минь эсрэг тэсрэг бодол эргэлдэн зовоож байлаа. Нэг талаас энэ нь ямар ч байсан бид онцгой хүмүүстэй уулзаж ярилцан, самади-агуйд орж, тэр ч бүү хэл алдарт сэтгэлийн энергийн саадыг өөрийн биеэр мэдэрч чадсантай холбоотой баярын мэдрэмж, нөгөө талаас самадид буй хүмүүстэй уулзаж судлахад хэдхэн метр дутуу байхад чадаагүй гэсэн сэтгэл дундуур байдал байсан юм. Нөлөөллийг нь өөрийн биеэр мэдэрсэн сэтгэлийн энерги нь надад нууцлаг, агуу хүчирхэг зүйл мэт санагдсан. Самади агуй их нууцынхаа зөвхөн хөшгийг нь нээсэн боловч бүхэлд нь задлаагүй юм. Хүн төрөлхтний энэ агуу нууцыг хэзээ нэгэн цагт хэн нэгэн хүн нээх болов уу? Мэдэхгүй юм даа. Гэсэн ч онцгой хүмүүстэй хийсэн ярилцлага, самади-агуйд орсон сэтгэгдлээс судалгааны дараах дүгнэлтийг хийж болох болсон мэт.

1. Самади-агуй үнэхээр оршдог.

2. Самади-агуйнуудад янз бүрийн дүр төрхтэй (магадгүй, янз бүрийн соёл иргэншлийн) хүмүүс самадийн байдалд оршдог.

3. Самади-агуйнууд нь сэтгэлийн энергийн саадаар хамгаалагдсан байдаг бөгөөд энэ нь аймшиг, ундууцал, түгшүүрийн мэдрэмжийг идэвхжүүлж, толгойн өвчин үүсгэж, биеийг сулруулдаг. Бэлтгэлгүй хүнд сэтгэлийн энергийн саад нь нэвтрэшгүй зүйл.

4. Самадийн байдалд байгаа янз бүрийн хүмүүсийн дүр төрхийн талаар мэдээлэлтэй болсон. Эдгээр мэдээ баримтыг өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг эргэн сэргээхэд ашиглаж болно.

Шинжилгээний эдгээр дүгнэлтээс гадна өмнөх иргэншлүүдийн хүмүүсийг нүдээрээ харж хүн төрөлхтний генийн сан байдгийг батлахыг хичнээн их хүсэж байна гээч! Гэвч орчин үеийн хүний боломж нь үлэмж хязгаарлагдмал бөгөөд судалгааны сониуч зан нь хүн төрөлхтний Генийн сангийн их үүргийн хажууд юу ч биш юм. Тэгэхээр агуу нууцыг нээх цаг нь болоогүй байгаа гэсэн үг. Том Онцгой хүний хэлсэн “орчин үеийн хүн гүн самадид орж чаддаггүй. Учир нь сүнс нь

чадалгүй” гэсэн үгийг санацгаая. Тийм ч учраас орчин үеийн хүмүүсээс ганц ч хүн самади - агуйд орж хүн төрөлхтний Генийн санд нэвтрээгүй аж. Цаг нь ирэхэд хүн төрөлхтний Генийн сангийн нууц нээгдэх байх.

Орчин үед бодит ертөнцөөс гадна нарийн ертөнц буюу сэтгэлийн энергийн ертөнц гэж байдаг нь тодорхой болсон. Энэ энергийн ертөнцийн хүчин чадал болон үүргийг бид одоохондоо маш муу ойлгож байгаа. Миний бодлоор сэтгэлийн энергийн саад нь одоохондоо даван туулшгүй. Гэвч түүнийг даван туулах цаг мөч ирэх байх.

Орон судлаач, физикч Валерий Лобанков сэтгэлийн энергийн саад нь хүний сэтгэлийн торсын оронг сөрөг чиглэлд нь эргүүлэх замаар үйлчилдэг гэж үздэг. Муу муухай санаа бодол болон өвчин нь хүний торсын оронг сөрөг чиглэлд нь, харин сайн санаа бодол болон эрүүл мэнд нь эерэг чиглэлд эргүүлдэг. В.М.Лобанковын онолоор бол самади-агуйд орох үедээ миний мэдэрсэн зүйлсийг торсын орны түгшүүр, айдас болон ундууцлыг хариуцсан хэсгийг сөрөг чиглэлд эргүүлсэн гэдгээр тайлбарлаж болох аж. Өөрөөр хэлбэл сэтгэлийн саадын үйлчлэл нь нарийн ертөнцийн хүрээнд явагддаг бөгөөд толгойн өвчин, бие сулрах зэрэг нь энэ үйлчлэлийн бодит үр дагавар юм. Түүнээс гадна В.М.Лобанков хүний сэтгэн бодох үйл явц нь сүнсний ментал биений торсын орны түвшинд үйлчилдэг. Харин тархи сэтгэлийн энергийн хэсгийг бодит мэдрэлийн сэрэл болгон хувиргадаг цахим тооцоолуурын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хүний бодит биеийг удирддаг гэж үзэж байна.

Үүргэвч маань нурууг тааламжтайя дарж, нууцат самади-агуй алхам алхмаар алслан холдсоор байлаа. Үүргэвчтэйгээ байхад орон зайн тухай бодоход таатай байдаг юм. Энэ агуйд бодитоор нь үзсэн өмнөх иргэншлийн хүмүүсийнхээ гадаад төрхийн талаар Онцгой хүмүүс ямар ч байсан зарим нэг зүйлийг хэлж өглөө. Одоо бол лемуро-атлант болон атлантчуудын гадаад төрхний шинжилгээг нарийвчлалтайгаар эргэн сэргээж, засварлаж болохоор боллоо. Тэд ямар байсан юм бол?



Есдүгээр хэсэг

## Өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрх

Өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийн талаар өөрсдийн төсөөллөө “Атлантчууд болон лемурчууд гэж хэн бэ?” гэсэн бүлэгтээ дүрслэх нь илүү утга төгөлдөр байхсан билээ. Гэсэн ч бид самади-агуйн нэгэнд ордог Онцгой хүмүүсээс авсан шууд мэдээллийг тайлагнах зорилгоор энэ тусгай буланг гаргасан юм.

### Ном зүйн мэдээ баримт

Мэдээж, уншигч авгай тус номны өмнөх бүлгүүдээс өмнөх иргэншлийн хүмүүсийн тухай бичсэнийг уншсан болохоор лемурчууд болон атлантчууд ямар дүр төрхтэй байсныг тодорхой хэмжээнд төсөөлж байгаа буй заа. Гэвч ном зүйн баримтад суурилсан эдгээр дүрслэлээс ерөнхий мэдээлэл болсон биеийн өндөр, биеийн төрх болон эртний лемурчуудын дөрвөн гар, арын нүд зэрэг өвөрмөц онцлогуудыг мэдсэн байх. Хэн ч өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг таамгаар сэргээх гэж оролдож байгаагүй. Энэ нь ч ойлгомжтой. Их Гэгээнтнүүдийн (Нострадамус, Е.Блаватская) Ертөнцийн Мэдээллийн Орноос хүлээн авсан мэдээлэл нь мэдлэгийн хүрээ өргөнөөс шалтгаалан үлэмж ерөнхий шинж чанартай байдаг бөгөөд нүдний, хамрын хэлбэр, гавлын хэмжээ гэх мэт шинж тэмдгээр нарийвчлах нь боломжгүй зүйл бөлгөө. Гадаад шинж тэмдгийг нарийвчлан авч үзэхийн тулд өмнөх иргэншлийн хүнийг нүдээрээ харах шаардлагатай байдаг бололтой. Зөвхөн самади-агуйд орох юм уу эсвэл тэд Номлогчдын (жишээ нь, Будда) дүрээр дэлхий дээр гарч ирж буй тохиолдолд л ингэх боломжтой.

Ямар ч байсан ном зохиолуудаас үзэхэд хожуу үеийн лемурчууд (лемүр-атлантчууд) нь 7-8 метр хүрсэн аварга биетэй байсан. Атлантчууд ч мөн адил 3-5 метр хүрсэн том биетэй байхад, харин манай иргэншлийн хүний биеийн өндөр нь 2 метрээс хэтрэхгүй (Шри Сатья Саи Баба- Д.Хислоп. “Бхагаван Шри Сатьятай хийсэн ярилцлага”, 1994 он, 164-р хуудас; Е.П.Блаватская “Нууц бичээс”, 1937

он, 2-р боть, 425, 426-р хуудас). Гэвч эдгээр хүмүүсийн хөргийг бүтээчих ямар ч мэдээ баримт алга.

Хоёр баримт ихээхэн сонирхол татдаг. Эхнийх нь, Лувсандамба (“Гурав дахь мэлмий”, 1992, 192-р хуудас) орчин цагийн агуу өгч болохынхоо хувьд самади-агуйн нэгэнд хэсэг хугацаанд самадийн байдалд орсныгоо дүрслэн бичихдээ: *“Миний өмнө гурван нүцгэн бие хэвтэж байлаа. Хоёр эрэгтэй, нэг эмэгтэй хүний бие байсан бөгөөд эдгээр бие аварга том байлаа. Эмэгтэй нь 3 метрээс багагүй, арай том биетэй эрэгтэй нь 5 метрээс багагүй өндөртэй байсан. Орой нь конус хэлбэрийн том толгойтой, шовх эрүүтэй, жижигхэн ам, нимгэхэн уруул, гүн хөнхөр нүдтэй бөгөөд урт нарийхан хамартай байсан. Тэднийг үхсэн гэж хэлж боломгүй, эгээ л унтаж буй мэт байлаа.”*

Лувсандамба хэнийг дүрсэлсэн юм бол? Миний бодлоор тэрбээр самадийн байдалд буй атлантчуудыг дүрсэлсэн байх. Энэ зураглалд нь нухацтай хандаж болно гэж үү? Би бүрэн баталсан хариулт өгч чадахгүй нь. Гэсэн ч энэ дүрслэл нь ерөнхийдөө Онцгой хүмүүсийн яриатай таарч байгаа тул анхааралдаа авч болох л юм.

*Өөр нэгэн онцлог мэдээлэл нь Е.П.Блаватскаягийн (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 280,281-р хуудас) номонд бичсэнчлэн “...Пасхын арал дээрх хөшөөнүүд нь балар эртний аваргуудын сонгодог дурсгал юм...эдгээр хүн-хөшөөнүүдийн толгойг судлахад л Дөрөв дэх үндэстний аварга биетнүүдийн шинж тэмдэг, дүр төрхийг харах болно...”*

Цаашлан тэрээр Буддагийн хөшөөний талаар ийн бичиж байв: *“...эдгээр урт унжсан чихний дүрээр гутаагддаг Будданууд нь Пасхын арал дээрх хүн-хөшөөнүүдээс үлэмж ялгаатай нь харагдаж байгаа юм. Тэд нэгэн үндэснийх байж болох...”*

Их Гэгээрсэн Е.П.Блаватскаягийн бичсэн уг дүрслэл нь Пасхын арлын хүн-хөшөөнүүдийн дүр төрх болон Буддагийн дүр төрхийг дөрөв дэх үндэстэн болох атлантын дүр төрхтэй харьцуулсан байна. Пасхи арлын хүн хөшөө болон Буддагийн дүр төрх нь үлэмж ялгаатай байгаа учир Буддагийн дүр төрхтэй нь шар атлантчууд, Пасхын арлын хүн-хөшөөний төрхтэй нь хар атлантчууд юм гэсэн таамаг дэвшүүлж болох мэт.

Энэ бүх ном зохиолын баримт сэлтийг бид өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг эргээж сэргээхдээ ашигласан болно.

## **Өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг сэргээн бүтээх аргачлал**

Өмнөх иргэншлүүдийн хүмүүсийн дүр төрхийг эргээж сэргээх зорилгоор бид судалгааны дараах цогц аргуудыг хэрэглэсэн:

1. Төвд сүмийн дээр дүрсэлсэн нүдээр тус хүний дүр төрхийг бүтээх. Нэг талаас уг хөрөг зураг нь үзүүлээд ярилцах боломжтойгоороо судалгааны ажилд маш их ач холбогдолтой бөгөөд нөгөө талаас Балба, Төвдийн сүм дугана бүрийн ханан дээр дүрслэгдсэн нүд нь Дорны ёс жаягаар бол манай соёл иргэншлийн өвөг дээдэс гэгддэг Бумба Будда буюу Рамагийн нүд юм.

2. Ер бусын хүмүүсийг самади-агуйд өөрийн нүдээр хардаг Онцгой хүмүүсийн яриа.

3. Буддаг өөрийн нүдээр харсан хүмүүсийн дүрслэл. Буддагийн ер бусын дүр төрх болон Е.П.Блаватскаягийн түүний дүрийг дөрөв дэх үндэстний хүмүүстэй харьцуулсанаас үзэхэд энэ нь атлантын дүр төрхийн тодорхойлолт юм.

4. Дээр дурдсан ном зохиол дахь өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийн талаарх мэдээ баримт.

Энэ бүгдийг нэгэн цогц болгон судлахдаа бид зөрөлдөж байгаа талуудыг орхиж, олон талаас шинжлэхэд хоорондоо таарч байсан бүхнийг авч үзэхийг хичээсэн.

Газар дэлхий дээр таван соёл иргэншил байсан нь тодорхой. Эдгээр соёл иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг эргээн сэргээхдээ бид 1, 2-р иргэншил болон эрт үеийн лемурчуудын дүр төрхийг сэргээхэд үлэмж бэрхшээлтэй тулгарсан. Учир нь Е.П.Блаватская болон Р.Штайнерын бүтээлүүд дэх тасархай дүрслэлүүдээс өөр баримт мэдээ байгаагүй. Тийм ч учраас бид хожуу үеийн лемурчууд буюу лемуро-атлантчуудын дүр төрхийг эргэн бүтээхдээ бүх хүчээ дайчилсан.

## **Лемуро-атлантчуудын дүр төрх**

Бид Төвдийн сүмийн ханан дээрх нүдний дүрсийг ашиглан тус хүний дүрийг эргэн сэргээхэд том нүд, том гавалтай, “гурав дахь нүдтэй” бөгөөд хавхлаган-сариу хэлбэрийн хамартай ер бусын хүний дүр төрх бий болоход бидэнд “энэ хэн бэ?”

гэсэн асуулт өөрийн эрхгүй төрсөн нь ойлгомжтой. Бид түүнийг өмнөх иргэншлийн хүн буюу атлант гэж бодож байлаа. Шинжилгээний ангиар явсан бүхий л хугацаандаа бид тэгэж бодсоор ирсэн нь маш бүдүүлэг алдаа байсан юм.

Шинжилгээний ангиар явах үед Онцгой хүмүүс болон лам нар хэдийгээр атлантчуудын тухай бүгдийг мэддэг хирнээ бидний зурган дээрх хүнийг Тэр гэж нэрлэж байсан нь бидэнд зарим нэгэн эргэлзээ төрүүлж байсныг хэлэх нь зүйтэй болов уу.



*Төвд сүмийн дээрх нүднээс гаргасан хүний төрх*

- Та – Гэгээрсэн хүн үү?
- Тиймээ.

Энэ хар өмсгөлтэй хүнтэй ярихад маш хялбар байлаа. Би яриагаа эхлэнгүүт л тэрээр миний бодлыг өлгөн авч үргэлжлүүлэн ярьж байлаа. Тэрээр манай шинжилгээний ангийн гишүүн байсан мэт сэтгэгдэл төрж байсан юм. Би маш их гайхаж байсан. Гэсэн ч энэ хүний тухай би дараа нь, Шамбалын орны тухай бүлэгтээ тодорхой ярья. Өмнөх иргэншлийн хүний дүр төрхийн тухайд гэлэнтэй хийсэн яриа цааш ийн үргэлжлэв:

- Яагаад та түүнийг атлант биш, лемур гэж бодож байгаа юм бэ?- гэж би атлантын зургийг гартаа барин түүнээс асуув.

- Атлантчууд өөр байсан. Тэдний дүр төрх нь орчин үеийн хүнийхтэй төстэй байсан юм. Одоо тэд хүн төрөлхтний Генийн санг бүрдүүлж байгаа. Самадид буй хүмүүсийн ихэнх нь атлантчууд юм. Харин энэ бол,- гээд тэрээр зургийг заан,- лемур юм! Атлантчууд чинь лемурчуудын хажууд юу юм бэ? Бүхий л соёл иргэншлүүдээс лемурчууд л хамгийн өндөр хөгжилтэй хүмүүс байсан, байх ч болно! Тэд Шамбалын орон болон Агартын орныг үндэслэсэн юм.

- Лам нар болон Онцгой хүмүүс самади-агуйн тухай яриандаа байнга л хэн нэгнийг “Тэр” гэж нэрлээд байдаг юм. Тэр нууцлаг “Тэр” нь лемур юм болов уу? Та юу гэж бодож байна вэ?

Шинжилгээний ангиар явж ирсэний дараа Оросын томоохон шашны зүтгэлтнүүдийн нэг нь (тэрээр нэрээ бичүүлэхийг хүсээгүй) эцсийн эргэлзээг минь сарниулсан юм. Би түүнд зургаа үзүүлэн энэ бол бидний таамаглаж буй атлант гэж танилцуултал уг гэлэн миний үгийг таслан:

- Энэ чинь атлант биш ээ! –гэв.

- Тэгээд таныхаар бол энэ хэн гэж?-гэж би асуухад,

- Энэ чинь лемур байна,- гэж тэрээр хариулав.

- Та яагаад тэгж бодож байгаа юм бэ?

- Би үүнийг мэдэж байна.

- Та хаанаас ийм мэдлэг олж авсан юм бэ?-гэж би гайхшаа баран асуухад,

- Энэ бол мэдлэг биш, харин “сургаал”- гэж гэлэн хариулав.

- “Сургаал” гэдэг чинь юу юм бэ?

- Сургах гэсэн үгнээс үүдэлтэй. Өөрөөр хэлбэл намайг мэдлэгт сургадаг юм.

- Тиймээ.

- Эртний буюу дөрвөн гартай, гурван нүдтэй лемурчууд ба, хожуу үеийн лемурчууд гэж байсан нь тодорхой. Хожуу үеийнхийг нь Е.П.Блаватская лемуро-атлант гэж нэрлэж буй юм. Энэ,- гээд би зургаа заан,- эрт үеийн лемур юм уу, хожуу үеийн лемур юм уу?

- Хожуу үеийнх, лемуро-атлант.

- “Гурав дахь нүд” нь духан дээрээ үнэхээр байдаг байсан юм уу, эсвэл энэ нь зөвхөн бэлгэ тэмдэг төдий зүйл юм уу?

- Лемурчуудын “гурав дахь нүд” нь маш өндөр хөгжилтэй байсан боловч гавлынхаа гүнд нь байрладаг байсан. Духан дээр байгаа нь зөвхөн бэлгэ тэмдэг юм,- гэж гэлэн хариулав.

Ингээд би энэ ярилцлагыг өмнөх иргэншлийн хүмүүсийн гадаад төрхийн талаар эргэцүүлсэн бодлоороо таслах шаардлагатай боллоо.

Тэгэхлээр Төвдийн сүмүүд дээр дүрслэгдсэн нүдээр тус хүний гадаад төрхийг эргэн сэргээсэн нь атлантын бус, харин хожуу үеийн лемурын (лемуро-атлант) дүр төрх болж таарах нь. Нэгдүгээрт, ном зохиолд Буддаг атлант байсан гэсэн шууд баримт байдаг (Е.Блаватская, “Нууц бичээс”, 1937 он, 2-р боть, 281-р хуудас). Гэтэл Буддагийн дүр төрх манай зурган дээрх хүний дүр төрхтэй адилгүй байгаа юм.

Хоёрдугаарт, Буддагийн гадаад төрхний багагүй шинж тэмдэг нь түүнийг хагас усны амьдралтай байсныг гэрчилнэ. Жишээ нь сэлүүр хэлбэрийн хөл, хуруунууд хоорондын таславч, том цээжний хөндий г.м. Хэрвээ үүнийг төвдийн сүм дээрх нүдээр эргэн сэргээсэн дүр төрхтэй харьцуулвал сүүлийн тохиолдолд усны амьдралын илүү их зохицлыг харж болно. Энэ нь хавхлаг хэлбэрийн хамар (усны амьтдад байдаг шинж) болон өвөрмөц хэлбэртэй нүд юм. Үүнээс хүн төрөлхтөний усны амьдралаас цэвэр хуурай газрын амьдралд дасан зохицсон хувьсал ажиглагдаж байна. Хагас усны амьдралд зохицсон дүр төрхтэй хүн нь атлант бус харин илүү эртний буюу лемурын үеийн хүн юм.

Гуравдугаарт, төвдийн сүмүүд дээр дүрслэгдсэн нүд нь манай иргэншлийг төрүүлэгч өвөг дээдсийн нүд бололтой. Энэ нь бидний олж авсан мэдээллээр 18013 жилийн өмнө манай иргэншлийг төрүүлэхэд нөлөө үзүүлсэн Бумба Будда буюу Рама юм. Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937, 2-р боть, 439-р хуудас) манай тав дахь үндэстэн “бурханлаг хаадаар” буюу хожуу үеийн лемурчуудаар (лемуро-атлант) удирдуулан үүсэн бий болж байжээ гэж бичсэн байдаг. Үүнээс үзэхэд, самадид хадгалагдаж байсан хөгжингүй соёл иргэншлийн хүмүүс болох лемуро- атлантчууд тав дахь соёл иргэншлийн үүсэл хөгжилтөнд нөлөөлжээ. Тийм ч учраас эдгээр “бурханлаг хүмүүс”-ийн нүдийг бэлгэ тэмдэг болгон төвдийн сүмүүд дээр дүрсэлжээ.

Бидний дэлгэн тавьж буй баримтууд үнэмшилтэй эсэхийг би шүүх эрхгүй. Эрхэм уншигчид маань шүүн тунгаах биз ээ. Гэсэн ч бидний бодлоор бол төвд

сүмийн ханан дээрх нүдний дүрсээр эргэн бүтээсэн хүний дүр төрх нь атлантынх бус, харин лемуру-атлантынх юм.

Үүнээс гадна, Онцгой хүмүүсийн яриа болон Венер Гафаровын судалгааны дүгнэлтээс уг хөрөг зурганд нь зарим нэг өөрчлөлт орохоор болов. “Билгийн нүд”, чих болон амны завсарт өөрчлөлт орууллаа.

Духан дээрх “гурав дахь нүд”-ийг бид зурагнаас зайлуулахаас аргагүй болсон юм. Учир нь лам нар болон Онцгой хүмүүсийн ярианаас үзэхэд энэ нь зөвхөн уг нүдний өмнөх соёл иргэншлүүдийн хүмүүсийн амьдралд ач холбогдол ихтэйг харуулсан бэлэгдэл төдий зүйл юм. “Билгийн нүд” нь гавлын хөндийд, боргоцой хэлбэрийн булчирхай байгаа газарт байсан нь тодорхой.

Онцгой хүмүүс агуй дахь ер бусын хүмүүсийн чих нь том гэж шууд хэлсэн учир чихний хэмжээг бид ямартай ч томруулахаар шийдсэн.

Амны завсарын тухайд гэвэл эрүү нүүр болон шүдний мэс заслын мэргэжилтэн В.Г.Гафаров үр хөврөлийн хөгжлийн үе шатан дахь нүүрний ясны босоо заадсыг судалсан юм. Үр хөврөлийн хөгжил нь хүний газар дэлхий дээрх хөгжлийг давтдаг нь тодорхой. Ингэхдээ нүүрний гавал зүүн баруун хоёр талаасаа хөгжсөөр аажмаар төвдөө нийлж нүүрний ясан суурийг бүрдүүлдэг. Үүнээс гадна хүний биеийн бүх ясны хөгжил нь 20 насанд төгсдөг бол нүүрний ясны хөгжил нь 25 насанд л төгсдөг байна. Үүнийг эрүү нүүр судлаач эрдэмтэд хүн амын бараг 100% шүд хорхойтох, пародонтоз зэрэг өвчтэй байдаг мөн “туулайн уруул”, “чонын ам” зэрэг нүүр амны хэсэгт үүсдэг гажиг өөрчлөлтүүд их гардагтай холбож тайлбарладаг.

“Туулайн уруул” (салаа дээд уруул), “чонын ам” (дээд эрүүний завсар) зэрэг нүүрний гавлын гаж хөгжил нь үр хөврөлийн хөгжлийн эрт үед нүүрний гавлын хоёр тал нь нийлж ургаагүйгээс болж завсар үүссэнээс бий болдог байна. Үр хөврөлийн хөгжил нь Дэлхий дээрх түүхэн хөгжлөө давтан явагддагийг тооцон үзвэл эртний хүмүүс голоороо бүрэн гүйцэд нийлж ургаагүй нүүрний ястай байжээ гэсэн дүгнэлтэнд хүрч болно.

Эртний хүмүүсээс хэн нь нүүрнийхээ голд завсартай байсан байж болох вэ? Нүүрнийхээ голд завсартай байна гэдэг нь нэн эртний шинж тэмдэг болж буйг болон анх лемурчуудад яс үүссэнийг (Е.П.Блаватская, “Нууц бичээс”, 1937, 2-р боть, 208-р хуудас) тооцон үзвэл лемурчууд дээд эрүү болон дээд урууландаа завсартай байсан гэж дүгнэж болно. Төвдийн сүмүүд дээрх ер бусын нүд, сариа хэлбэрийн хамар, завсар нь доош үргэлжилсэн амны сүвтэй (дээд уруул гэж тооцож болно) нийлсэн хамар дүрслэгдсэн байсан нь үүний баталгаа болж буй юм.

Ам, хамарны сүвийг холбосон завсар нь лемурчуудад хагас усны амьдралд зайлшгүй шаардлагатай тодорхой үүрэг гүйцэтгэж байжээ. Уг завсарын хоёр талд буюу өнөөгийн хүний хоншоорын хөндийн (хамрын дайвар) байранд усанд удаан байхад нь цусыг нь хүчилтөрөгчөөр хангах үүрэгтэй жижигхэн заламгай байдаг байжээ. Амаар сорогдон орсон ус нь эдгээр заламгайгаар дамжиж уг босоо завсараар буцаж гардаг байж. Мөн усан дор удаан байх, уушгиндаа их хэмжээний

агаар хадгалах зорилгоор том цээжтэй байсан байна. Ийм маягаар лемурчуудад “загасны” болон “сүүн тэжээлтний” усны амьдралын зохилдлогоо хосолжээ. Харин хоншоорын хөндий лемурчуудын бяцхан заламгайн үлдэц эрхтэн болон орчин үеийн хүмүүст үлджээ.

Хамар ам хоёрыг холбосон босоо завсрын хоёр талд заламгай байдаг нь дууны хөвчийг дуу гаргах үүрэггүй болгожээ. Энэ тохиолдолд дуу гаргах үүргийг хамрын хэсэг гүйцэтгэх шаардлагатай болж байгаа юм. Номын эхний хэсэгт Энэтхэгийн мастер Ананта Кришна их эртний хүмүүс хамраараа ярьдаг байсан бөгөөд авиаг зөвхөн энгийн дууны түвшинд ч бус мөн хэт ягаан туяа болон хэт авианы түвшинд үүсгэдэг байсан гэж ярьж байсныг эргэн саная.

Яагаад лемурчуудын дуу гаргах хавхлаг хэлбэрийн хамар нь түүхэн хувьслын явцад атлантчууд болон манай иргэншлийн хүмүүст байдаг энгийн хамраар солигдсон юм бол? Энэ сэдвээр В.Г.Гафаровтай ярилцаад бид лемурчуудын зөөлөн хавхлаг хэлбэрийн хамар нь маш амархан гэмтэж амьсгалын болон ярианы үйл ажиллагааг алдагдуулж байсан тул эдгээр чухал хэрэгцээг хадгалахын тулд түүхэн хувьслын дагуу хэдийгээр заламгай хувьсан өөрчлөгдсөнтэй холбоотойгоор усанд удаан хугацаагаар сэлэх боломжгүй болсон ч яс, мөгөөрсөн хамгаалалттай энгийн хамар үүсэн бий болсон байна. Энэ тохиолдолд авиа үүсгэгч тогтоц нь заламгайн оронд (хоншоорын хөндий) дууны хөвч болон хувирч, ам хамрын хөндийн хоорондох завсар нь битүүрчээ. Ингээд бидний үзэж байгаагаар хожуу үеийн лемурчууд буюу лемуро-атлантчууд нь дараах гадаад шинж тэмдэгтэй болжээ.


- 7-8 метр, түүнээс ч өндөр нуруутай
- том гавалтай
- дээд зовхины давхар нугалаатай ер бусын том нүдтэй
- хамрын шаантаггүй сариа маягийн хавхлаган хамартай
- жижигхэн хөндлөн амтай
- харьцангуй том чихтэй
- жижигхэн доод эрүүтэй
- хүчирхэг хүзүүтэй
- хүчирхэг том цээжний хөндийтэй
- харьцангуй урт гартай
- сэлүүр маягийн хөлтэй
- дундаа хүртэл сарьсан таславчтай урт хөл гарын хуруутай
- шаравтар өнгийн арьстай

Бид ямар нэгэн зүйл дээр алдаж, зарим нэгэн зүйл дээр оносон биз ээ. Гэвч өмнөх иргэншлийн хүмүүсийн дүр төрхийг эргэн бүтээх нь баримт мэдээлэл дутмагаас болж хамгийн сайн хийсвэр сэтгэхүйгээр ч гэсэн яг нарийн зөв тогтооно гэж байхгүй.



Хожуу үеийн лемурын нарийвчилсан дүр төрх (бидний хэлснээр зураач В. Куприянов бүтээв)






*Самадийн байдалд байгаа хожуу үеийн лемур  
(зохиогчийн зураг)*

## Атлантчуудын дүр төрх

Энэ судалгаандаа бид ном зохиолуудаас олж авсан Буддагийн гадаад төрхийн онцлогийг үндэс болгон аваад атлантчууд нь хагас усны амьдралаас хуурай газрын амьдралд дасан зохицсон түүхэн хувьслын шилжилтийн үеийн хүн гэж үзэн үүнтэй уялдуулахыг зорьсон юм.



*Самадийн байдалд байгаа атлант  
(зохиогчийн зураг)*

Янз бүрийн үзүүлэлтийн нарийвчилсан судалгаагаар уншигчдынхаа толгойг эргүүлэхээ болиод өөрсдийн үзэж байгаагаар атлантчуудын гадаад төрхийн үндсэн онцлог шинжүүдийг дараах байдлаар сийрүүлье:


- 3-5 метр өндөртэй
- цамхаг хэлбэрийн юм уу, том бөөрөнхий толгойтой
- том ер бусын нүдтэй, гэвч дээд зовхины нугалаа нь лемурчуудынхаас бага
- жирийн, шулуун хамартай
- ам хамрын дунд босоо завсаргүй
- жижигхэн амтай
- манай иргэншлийн хүнийхээс бага эрүүтэй
- харьцангуй том чихтэй
- хүчирхэг хүзүүтэй
- хүчирхэг цээжний хөндийтэй
- өвдгөндөө хүрсэн харьцангуй урт гартай
- сэлүүр хэлбэрийн тавхайтай боловч энэ нь лемурчуудынхаас бүдэг
- хуруунуудынхаа дунд хүртэл сарьсан таславчтай
- эр бэлэг эрхтэн нь дотогш харсан
- хар, шар, улаан эсвэл хүрэн арьстай

Эдгээр судалгааны үр дүнд атлантчууд ч гэсэн лемурчуудын нэгэн адил хагас усны амьдралд дасан зохицсон шинжтэй байна. Жишээ нь сэлүүр хэлбэрийн хөл, хуруунууд хоорондын сарьс, том цээж, дээд зовхины давхар нугалаа гэх мэт. Лемурчуудаас ялгаатай нь атлантчуудад хуурай газрын амьдралын шинж тэмдэг илүү илэрсэн: хавхлаг хэлбэрийн хамар нь энгийн шулуун хамраар солигдож, заламгайтай хамар ам хоёрыг холбосон босоо завсар нь алга болсон. Үүнтэй холбоотойгоор авиа үүсгэгч тогтоц нь хамарнаас төвөнхөд шилжсэн. Атлантчууд нь лемурчуудаас бага хугацааг усанд өнгөрөөдөг байсан нь тодорхой (заламгай нь алга болсон).

Атлантчуудын болон лемурчуудын том гавал нь тэдний тархины хөгжлийг илэрхийлж байгаа бөгөөд мөн тэдний гавлын хөндийд байрласан “билгийн нүд”-ний хөгжлийг гэрчилж байгаа юм. Үүнээс үзэхэд атлантчууд нь лемурчуудын нэгэн адил амьдралын янз бүрийн асуудлыг шийдэхдээ “билгийн нүд”-нийхээ хүчийг ашигладаг оюуны өндөр чадавхитай хүмүүс байжээ.

## **Манай иргэншлийн хүний дүр төрх**

Мэдээж бид хэрхэн харагддагаа мэдэлгүй яхав. Гэсэн ч, энэ тухай ном зохиолыг судлахад 850000 жилийн өмнө Атлантидын мөхлийн үед амьдарч байсан тав дахь иргэншлийн хүмүүс нь 3-4 метр өндөр биетэй байжээ. Дараа нь яваандаа хүмүүсийн бие нь жижгэрч, 10-18-р зууны үед хамгийн намхан болжээ. Одоо акселераци буюу хүмүүсийн өндөрсөл явагдаж байна.



*Самадийн байдалд байгаа ари хүн (манай иргэншлийн хүн)  
(зохиогчийн зураг)*

Хүний нурууны өндрийн уг хэлбэлзэл нь саяхан болтол сэтгэл оюуныг үгүйсгэн бодит зүйлсийн үүрэг үнэ цэнэ нэмэгдэж байсантай холбоотой бөгөөд одоо энэ үе өнгөрч сэтгэлийн хүчин зүйлийн үүрэг нэмэгдэж буй монетар үечлэлтэй зэрэг явагдаж байна. Үүнээс хүн төрөлхтний сэтгэл оюуны хүчин зүйл хөгжих тутам түүхэн хувьслын хувьд өндөрсдөг гэсэн таамаг төрж байгаа юм. Сэтгэл оюуны асар өндөр хөгжилтэй байсан лемурчууд болон атлантчууд нь бидэнтэй харьцуулахад аварга биетэй байсан нь ийм учиртай.

Манай иргэншлийн хүмүүсийн гадаад төрхнөөс үзэхэд хагас усны амьдралын (лемурчууд болон атлантчууд) дасан зохицсон хэлбэрээс, цэвэр хуурай газрын амьдралд дасан зохицсон түүхэн хувьсал явагдсан нь харагдаж байна. Үүнийг хуурай газар явахад зохицсон хөлийн ул, хуруунууд хоорондох сарьс, нүдний бүтэц зэрэг нь гэрчилж байдаг.

Лемурийн болон Атлантидын үед эх газрын хэмжээ бага байсан учир өмнөх соёл иргэншлийн хүмүүс амьдралдаа далай тэнгисийг ашиглах шаардлагатай болжээ.

Өнөө үеийн хүн нь “билгийн нүд”-нийхээ үүргийг алдсан. “Билгийн нүд” нь боргоцой хэлбэрийн булчирхай хэлбэртэй үлдэц эрхтэн болсон нь тодорхой. Өндөр хөгжилтэй “билгийн нүд” нь атлант, лемурчуудын гавлын хөндийд маш их зай эзэлдэг байсан нь тэдний гавлын хэмжээ том байхад нөлөөлсөн бололтой. Гавлын хэмжээ нэмэгдэхэд лемурчууд болон атлантчуудын оюун ухааны өндөр хөгжил ч бас нөлөөлсөн.

Яагаад сэтгэлийн энергийг эзэмшихэд их үүрэгтэй эрхтэн болох “билгийн нүд” нь манай иргэншлийн хүмүүст аажимдаа буурах болсон юм бол? Нэг соёл иргэншлээс нөгөө соёл иргэншилд шилжих түүхэн хувьслын явцад “билгийн нүд” улам бүр хөгжих ёстой байтал харин эсрэгээрээ хөгжил нь бууран доройтоод байсан нь сонирхолтой. Учир нь “билгийн нүд”-ий тусламжтайгаар таталцлын хүчинд нөлөөлж, бодол санаагаа телепатын аргаар дамжуулах зэрэг үйлийг хийх боломжтой болно шүү дээ.

Манай иргэншлийн хүмүүсийн “билгийн нүд”-ий хөгжил буурсаны шалтгаан нь бидний үзсэнээр бол сүүлчийн илгээлт болох “SoHm” юм. Энэ нь хүний сүнсний Ертөнцийн Мэдээллийн Оронтой байнга холбогддог байсныг болиулсан юм.

Өмнөх иргэншлүүдийн үед “билгийн нүд” нь Ертөнцийн Мэдээллийн Орны (Нөгөө Ертөнц) давтамжинд тааруулагчийн үүргийг гүйцэтгэдэг байсан. Энэ нь “билгийн нүд”-ий хамгийн гол үүрэг нь байсан бөгөөд Ертөнцийн Мэдээллийн Орноос манай иргэншилд “SoHm”-ийн зарчмаар энэ үүргийг нь таслахад “билгийн нүд”-ий хөгжил нь буурч эхэлсэн бололтой. Зөвхөн зарим нэгэн тусгай хүмүүс л “SoHm”-ын саадыг даван Ертөнцийн Мэдээллийн Оронд холбогдох боломжтой үлдсэн. Ийм тусгай хүмүүс бол Гэгээнтнүүд юм. Тэдний хувьд лемурчууд болон атлантчуудын бүгдээрээ эзэмшсэн байсан тэр мэдлэгийг эзэмших боломжтой юм.

Сүүлчийн илгээлт болох “SoHm”-ын үр дагавар нь “еерөө боловсор” гэсэн зарчим бөгөөд энэ нь манай иргэншлийн хөгжилд маш их нөлөөлсөн. Дээд Оюуны эхлэлээс тасарсан бид өөрсдийгөө бодит ертөнцөд давуутайгаар хөгжүүлсэн нь гадаад төрхөнд маань нөлөөлжээ.

Аравдугаар хэсэг

## 300 жил амьдарч буй хүн

Самади-агуй руу орсныхоо дараа бид Катмандуд 3 хоносон юм. Намайг шинжилгээний тэмдэглэлээ эмхэлж байх хооронд В.М.Лобанков шинжилгээний ангийн бусад гишүүнтэй цуг хоёр сонирхолтой уулзалт хийсэн юм.

### Ведад бичсэн зүйл

Манай шинжилгээний ангийн гишүүн Шесканд Ариэль Балбын их сургуулийн профессор, санскрит хэлний багш Шиварайя Ачаридом Кавнданияанатай уулзалт зохиосон юм.

Веда гэж юу юм бэ? Энэ бол шашинтай төстэй боловч илүү дэлгэрэнгүй нэн эртний үндэслэлтэй бичээс юм. Зохиогч нь үл мэдэгдэх энэ бичээсийг атлантчуудын ярьж байсан эдүгээ мөхсөн хэл болсон санскрит хэлээр бичсэн байдаг.

Ведын сургаал нь ер бусын, хүний сэтгэхүйгээс огт ондоо сэтгэхүйгээр бичигдсэн бөгөөд ойлгоход хүнд, ухамсарлахад хэцүү. Тийм ч учраас Шаварайя профессорын өгсөн Ведын сургаалийн үндсэн мөн чанар нь маш үнэтэй мэдээлэл байсан юм.

Шиварайя профессорын Лобанковт хэлсэнчлэн эрт дээр үед нэгэн ертөнцийг эзэлсэн их усан үер болсон бөгөөд үр дүнд нь өмнөх иргэншлийн хүн төрөлхтөн (атлантчууд) мөхжээ. Гималайн өндөр оргилын нэгэнд

бясалгал хийн самадид орох чадвартай Ману хэмээх нэгэн эр л амьд үлдсэн байна. Ус татарч эхлэхэд тэрээр самадигаас гарчээ. Ману бурхан биш ч маш хүчтэй энергитэй байсан. Тэрээр загасны хэл мэддэг байсан ба тэднээс өөр нэгэн уулан дээр түүнийг Сид хэмээх нэгэн хүн хүлээж байгаа тухай мэджээ. Сид бол удамшлын бөөгнөрөл\* байсан ба тэрээр хүн, амьтан, ургамал, гэх мэт бүхий л зүйлсийн үрийг өөртөө багтаадаг байжээ. Ману Сид хоёр хамтран хүн төрөлхтний соёл иргэншлийг үүсгэжээ. Ману хүн төрөлхтнийг эргэн бүтээхэд тус болсон маш олон Буддаг төрүүлсэн байна.

Профессор Шиварайягийн танилцуулсан ведын сургаалийн энэ нэгээхэн хэсэг нь их үерийн дараа хүн төрөлхтнийг эргэн төрүүлсэн амьтан ургамал болон хүний Генийн сан байсныг гэрчилж байна. Харин Будда нар нь самадигаас гаран хүн төрөлхтнийг цаашид хөгжлийн замаар хөтөлдөг байжээ.

Лобанков профессороос самадийн талаар маш сайн асуужээ. Самадийн ойлголтын талаар Ведийн сургаалд бүрэн мэдээлэл байдаг. Самадид хүн өөрийн ухамсарыг цэвэр байлгаж, бодит зүйлсээс ангижруулсны дараа ордог. Ингэхэд бодисын солилцоо тэгтэй тэнцэж энергийн солилцоо зогсдог. Богино хэмжээний самадийг галын дэргэд л биш бол өөр хаана ч хийж болно. Самадид ороход хамгийн тохиромжтой газар нь ууланд мөнхийн цасны хязгаарт орших ариун дагшин газар буюу Sadbala юм. Урт хугацааны самадид ороход хамгийн тохиромжтой нь агуй юм. Хүн самадид хүссэн хугацаагаараа удаан байж болно.

- Шамбал гэж юу юм бэ?- гэж Лобанков асуув.

- Ведийн сургаалиар бол Шамбал гэдэг нь самадид буй хүнтэй агуй,- гэж профессор хэлэв.

- Шамбала нь үнэхээр дэлхий дээр оршдог уу?

- Тиймээ, байдаг.

- Самадид буй хүмүүсийг үнэхээр оршдог гэдгийг хүмүүст батлахын тулд аль нэгэн самади-агуйд орж болох уу?- гэж Лобанков асуув.

- Та нар хэзээ ч самадид буй хүмүүсийг оролдож, барьж үзэж, зургийг нь авч чадахгүй. Учир нь хамгаалагдсан байдаг. Энэ нь яг л тоо бодлоготой адил. Бодлого бодож байхдаа бид баримтыг олдог боловч хэзээ ч бодитоор барьж үзэж, оролдож чаддаггүй,- гэж профессор Шиварайя хэлэв.

Сонин л харьцуулал байна, “тоо бодлого” шиг гэнэ шүү! Нэг талаас самадид буй хүмүүс үнэхээр бодит ертөнцөд оршдог боловч нөгөө талаас түүнд хүрч судлаж болохгүй. Дэлхий дээрх амьдралыг хангахад самади үнэхээр их үүрэгтэй.

## Гуру Ношари Нат

Чухам түүнээс В.М.Лобанков В.Г. Яковлева нар 300 жил амьдраад одоо ч амьд сэрүүн байгаа хүний тухай сонссон юм.

Тэрээр Балбын томоохон ашрамын (бясалгалын сургууль) нэгийг удирддаг бөгөөд энэ улсын үлэмж хүндэтгэл хүлээсэн хүмүүсийн нэг нь байсан юм. Өдөрт тэрээр 100 гаруй хүмүүсийг хүлээн авдаг. Тэрээр мөн санскрит, прарит, палт болон Балба гэсэн эртний хэлүүдийг судалдаг сэтгэл оюуны нийгэмлэгийн тэргүүн юм.

Гуру Ношари Нат Балба, баруун Төвдийн нутгаар маш их аялж байсан бөгөөд 1992 онд аялж явахдаа тэрээр алмас буюу цасны хүнтэй таарч, гадаад төрхийг нь зурж авчээ. Лобанков Яковлева хоёр энэ зургийг харсан бөгөөд түүн дээр үсэрхэг аварга биетэй, бөгтөр, урт гартай, богинохон хөлтэй хүн маягийн амьтан дүрслэгдсэн байсан гэж ярьцгаалаа.



Мөн 1992 онд Гуру Ношари Нат баруун түвдэд газар дэлхий дээр 300 жил амьдарч буй хүнтэй уулзсан байна. Түүний нэрийг Гунгаадорж Лам гэдэг. Ихэвчлэн 8-р сарын тэргэл сартай шөнө тэрээр агуйд орж самадид ордог. Зургаан сарын дараа эргэн ирж, нэг сар хиртэй жирийн хүний амьдарлаар амьдардаг. Энэ хугацаандаа тэрээр зөвхөн үнээний сүү, сома хэмээх ургамлын навчаар хооллодог байна. Тэгээд дараа нь дахин зургаан сараар самадид орохоор явдаг.

Гуру Ношари Нат энэ агуйн бүсэд байхад баруун төвдийн уугуул нутгийн нэгэн лам түүнд эл 300 жил амьдарч буй хүний тухай ярьсан байна. Тэгээд Гуру Гунгаадорж Ламтай уулзах зөвшөөрөл гуйв. Түүний шашны өндөр цол хэргэм болон сэтгэл оюуны өндөр түвшинг нь харгалзан үзээд баруун төвдийн лам түүнийг агуй руу оруулжээ. Агуйд ороод Гуру тун удалгүй тэндээ Гунгаадорж Ламыг самадид байхад нь олжээ. Тэрээр түүнтэй яриа өрнүүлээд түүний 300 жилийн настай гэдэг нь үнэн гэдгийг мэдэж авчээ.

Өөрсдийн судалгааны гол хэсгийг түүнд яриад Лобанков Яковлева хоёр Гуруд шууд хэдэн асуулт тавьжээ.



- Самадийн ойлголт нь газар дэлхий гамшигт өртөхөд самадигаас гарч хүн төрөлхтний төрлийг үргэлжлүүлэх буюу дэлхий дээрх амьдралыг баталгаажуулах даатгал болдог уу?

- Тиймээ,- гэж Гуру лам хариулав.

- Төвд Гималайд самади-агуй олон бий юу?

- Тиймээ, олон бий.

- Агуйд самадид буй хүмүүсийг олж үзэж болох уу?

- Болно. Би Гунгаадорж Ламтай уулзсан гээ биз дээ,- гэж Гуру хариулав.

- Тантай цуг Гунгаадорж Ламын байгаа самади агуйд орж болох уу? – гэж Лобанков асуув.

- Болно,- гэж Гуру хариулаад,- Гэхдээ самади-агуйд Гунгаадорж Ламын дэргэд орших нь түүний хувьд аюултай. Учир нь та нар бэлтгэгдээгүй бөгөөд бясалгал хийж чадахгүй шүү дээ.

- Яагаад бид байлцах нь Гунгаадорж Ламын хувьд аюултай гэж? Бидний амин эрчим түүний самадийн байдлыг тэнцвэргүйжүүлэх хэрэг үү?

- Тиймээ.

- Гэсэн ч, - гэж Лобанков шалгаан,- самадид буй Гунгаадорж Ламыг хэзээ ч юм олж уулзаж болно биз дээ?

Гуру хэсэг бодолхийлснээ:

- Гунгаадорж Ламын буй агуйд жилийн аль ч улирал, аль ч сарын 10-11 цагийн хооронд орж болно. Гэхдээ хамгийн тохиромжтой нь дөрөвдүгээр эсвэл аравдугаар сар юм.

Лобанков Яковлева хоёр Гуру Ношари Натыг манай шинжилгээний хэсэгт Гунгаадорж Ламтай уулзалт зохион байгуулж туслаач гэж хүсжээ. Гуру амалсан боловч, 3-4 сарын дараа түүнтэй дахиж уулзан зарим нэг зүйлийг тодруулахаар болжээ.

### **300 гаруй жил амьдарч буй хүнтэй уулзаж чадах болов уу**

Шинжилгээний хэсгийн ажил дууссанаас хойш 4 сарын дараа Лобанков Ношари Наттай уулзаж, 300 гаруй жил амьдарч буй хүнтэй зохион байгуулах уулзалтын талаар ярилцахаар Балба явав.

Бид яагаад энэ хүнтэй уулзахыг ингэж зориод буй юм бэ? Шинжилгээний ажлын үеэр олж авсан мэдээллийн үр дүнд бид сэтгэлийн энергийн саадын улмаас самадид буй өмнөх иргэншлийн үеийн хүнийг олж уулзах боломжгүй юм гэдгийг ойлгосон юм. Энэ тохиолдолд боломжоороо самадид буй манай иргэншлийн хүнийг үзэж судлах нь үлэмж сонирхол татаж байлаа. Манай иргэншлийн хүн буй самади - агуйд сэтгэлийн энергийн саад байх ёсгүй гэдгийг

бид ойлгож байв. Тийм ч учраас ийм уулзалт боломжтой зүйл мэт санагдаж байсан юм.

Гуру Ношари Нат Лобанковт зарим нэгэн шинэ мэдээлэл авсан гэж хэлжээ. 300 жил амьдарч буй хүн дадлаа өөрчлөн 1997 оны 6-р сарын тэргэл сартай үеэр 2 хоногийн хугацаагаар самадигаас гараад дараа нь эргэн гүн самадид орох болсон гэв. Энэ хоёр хоногийн хугацаанд л түүнтэй уулзахад тохиромжтой байлаа. Өөр үед бол Гунгаадорж Ламтай уулзаж ярилцахад маш их бэрхшээлтэй болох байлаа. Түүнээс гадна Гуру Ношари Нат биднийг лам болж хувцаслах, бясалгалын болон ламын ёс жаягт суралцах шаардлагатай гэв. Тэрээр мөн энэ агуй нь Кайлас уулын орчим байрладаг учир уг аялал нь аюултай баж болох юм гэв.

## Нууцлаг Кайлас уул

Кайлас уулын ойролцоо “ясан хөндий” гэж битүү араг ясаар хучигдсан нэгэн хөндий байдаг нь тодорхой боллоо.

Уфагийн иргэн, Сатья Саи Бабатай хоёр ч удаа уулзаж байсан шашны болон оккульт шинжлэх ухааны гайхам мэдлэгтэй Марат Фатхлисламов Кайлас уулын бүс нь хүмүүс үхэхээр очдог газар гэж хэлэв. Энэ уулын бүсэд Ертөнцийн Мэдээллийн Оронтой Дэлхийг холбодог энергийн багана байдаг бөгөөд хэрвээ хүн энд үхэх юм бол түүний сүнс нь уг энергийн баганаар дамжин хялбархан Нөгөө Ертөнцөд очдог ажээ.

Цаашлан судлах тусмаа бид Кайлас уулын ойролцоо ер бусын энерги байдаг талаар мэдээлэл улам бүр их авах болов. Зарим нь энэ хэсэгт Шамбалд орох орц байдаг гэж ярьж бичиж байхад зарим нь уг орц нь өөр газарт байдаг гэж зааж байлаа.

Уг уулын ер бусын энергийн талаарх мэдээллүүдээс хамгийн таагүй хэсэг нь Кайлас уулын бүсэд маш олон тоогоороо хүмүүс үхдэг тухай мэдээлэл байсан юм. Санкт-Петербургийн эмч нар бидэнд Кайлас ууланд авиралт хийсэн оросын таван уулчин авиралтаас хойш 1-1,5 жилийн дотор бүгд нэгэн үл мэдэгдэх өвчний улмаас нас нөгцсөн гэж мэдээллээ. Энэ уулын бүсэд 200 даяанч ийш тийш таран зугтаж, бүгд ууланд хөлдөж үхсэн тухай болон бусад сэрэмжлүүлэг баримт ирлээ.

Энэ бүхэн үнэн эсэхийг нь мэдэхгүй юм. Би Энэтхэгийн эрдэмтэд рүү утасдан энэ талаар асуув. Тэд Кайлас уулын орчим олон хүн амиа алддаг баримт үнэхээр олон тохиолддог ч энэ нь хүчилтөрөгчийн дутмаг байдлаас болон бага хэмийн улмаас болдог гэж хэлээ. Энэ дүгнэлт нь эргэлзээ төрүүлж буй юм. Учир нь Кайлас уул дөнгөж 2000 метрийн өндөрт байрласан бөгөөд бүх насаараа өндөр ууланд амьдарсан даяанч нар тийм ч амар ийш тийш таран ганц ганцаараа үхэхгүй. Даяанч нарт хүний сэтгэхүйд үл ойлгогдох аймшиг, бүр зүрх зогсолтонд хүргэдэг



*Кайлас уул*


мэгдэл сандралыг төрүүлдэг хэт улаан туяаны үйлчлэлээр нөлөөлснийг үгүйсгэх аргагүй юм.

Европчууд бид дэлхий ертөнц дээрх бүх зүйлийг мэддэг гэж ойлгох дуртай байдаг. Гэвч энэ зууны эхэн үед тодорхой нэгэн газруудад очсон хүмүүс битүүлгээр удаан өвчлөөд, амьсгал хурааж байсан тохиолдол их байсныг эргэн санацгаая. Тэр үед эдгээр нь ураны нөөцтэй газар байсан учраас туяаны өвчний улмаас үхэлд хүрч байсныг хэн ч мэдээгүй юм. Одоо зууны төгсгөлд ч мөн адил бид энергийн эх үүсвэрүүдийг бүгдийг нь мэднэ гэж итгэлтэй хэлж чадахгүй юм. Кайлас уулын ойролцоо орчин үеийн шинжлэх ухаанд үл мэдэгдэх, хүн аминд халтай энергийн эх үүсвэр байдгийг үгүйсгэхийн аргагүй.

Тэгвэл Гунгаадорж Лам яагаад заавал энэ бүсэд самадид орох болсон юм бол оо? Магадгүй, энэ энергийн бүс нь ариун самадид буй хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулахгүй нэгэн саад ч болдог юм бил үү. Учир нь шинжилгээний ажлын үр дүнгээс харахад манай иргэншлийн хүмүүс нь өмнөх иргэншлийн хүмүүсийн нэгэн адил хамгаалах сэтгэлийн энергийн саадыг босгож чадахгүй нь тодорхой юм.

Уулын спорт болон аялал нь удирдагчаас маш их шалтгаалдаг. Чухам удирдагч л аяллын зүг чигийг тогтоогоод зогсохгүй мөн багийн гишүүн бүрийнхээ

амь насыг хариуцдаг юм. Энэ удаа ч гэсэн би шинжилгээний ангийн удирдагчийнхаа хувьд ангийнхаа гишүүн бүрийн амь насыг хариуцаж явав. Бидэнд одоохондоо Кайлас уулын талаар баримт мэдээ тун цөөхөн байгаа мэт надаа санагдаж байна. Сайтар учрыг нь олох хэрэгтэй. Үүний тулд маш их мэдээ баримт цуглуулах шаардлагатай байна.



Дөрөвдүгээр бүлэг

**Дэлхий бидний  
бодож байснаас  
илүү төвөгтэй**  
(баримтуудыг гүн ухааны  
үүднээс эрэгцүүлэх нь)

Нэгдүгээр хэсэг

**Би бичсэн зүйлдээ итгэж байна уу?**

Хоёрдугаар хэсэг

**Хүн төрөлхтний Генийн сан**

Гуравдугаар хэсэг

**Шамбал болон Агарт**

Дөрөвдүгээр хэсэг

**Дэлхий дээрх хүн төрөлхтний  
түүх**

Тавдугаар хэсэг

**Зэрлэгшил нь түүхэн хувьсалын  
буурах хүчин зүйл болохынхоо хувьд**

Зургадугаар хэсэг

**Орос орны дээрх сөрөг бүрхүүл**

Долдугаар хэсэг

**Сайхан санаа, хайр сэтгэл болон  
хорон муу санаа**

Нэгдүгээр хэсэг

## Би бичсэн зүйлдээ итгэж байна уу?

Энэ номны түрүүчийн хэсгүүдэд би хүмүүсийн нүдийг шинжлэх ухааны үүднээс судалснаа, лам, гуру, свами болон Дорны эрдэмтэдтэй хийсэн ярилцлага болон боломжтой ном зохиолуудаас авсан баримуудыг дэлгэрэнгүйг танилцуулсан билээ.

Баримт мэдээлэл, ном зохиолоо шинжилж дуусаад үр дүнгээ гаргасны дараа би өөрийн эрхгүй эдгээр дүгнэлтэд эргэлзэх болов. Учир нь эдгээр нь дэндүү ер бусын байсан бөгөөд яагаад ч миний сэтгэлд багтахгүй байлаа. Хэрвээ миний дээр бичсэн зүйлсийг авч үзэх юм бол газар дэлхий дээрх амьдралыг баталгаажуулдаг Хүн төрөлхтний Генийн сан байдгийг, манай соёл иргэншил сүүлчийн илгээлт “SoHn”-оос шалтгаалдгийг, нарийн ертөнцөд амьдралын өвөрмөц хэлбэр байдгийг (Нөгөө ертөнц) гэх мэтчилэн өөр маш олон зүйлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болно. Ингэхээр миний өмнө “би бичсэн зүйлдээ итгэж байна уу?” гэсэн асуулт зүй ёсоор тулгарлаа.

### **Материалист эрдэмтний үүднээс хандахад**

байхдаа л өөрийн эрдэм шинжилгээ судалгааны ажлаа эхэлснээр би хожим нүдний мэс засалч болсны дараа шинжлэх ухааны судалгаа хийхэд үлэмж хэрэг болдог онолын анагаах ухааны зарим хэсгүүдийг (бүтэц зүй, гистологи, гистохими, биохими) эзэмшсэн байлаа. Манай эрдэмтдийн бүлэг хүний биеийн эдийг (цусны судас, хучуур эд, эвэрлэг, арьс зэрэг) нөхөн төлжүүлдэг нөхөн суулгавар материал болох аллоплантыг зохион бүтээсэн юм. Биднээс өмнө хэн ч үүнийг хийж байсангүй. Өөрийнх нь эдийг “ургуулах” энэ боломж нь урьд өмнө найдваргүй

20 жилийнхээ эрдэм шинжилгээний ажлын дүнд би материалист эрдэмтэн болон төлөвшсөн байх юм. Анагаах ухааны бүтэц зүйн институтын дэргэдэх оюутны дугуйланд

гэгдэж байсан өвчтөнүүдэд тус болох мэс заслын эмчилгээний шинэ арга замуудыг нээсэн юм. Бидний судалгаа 30 гаруй орны сонирхолыг татсанаар аллопланттай мэс засал бүх дэлхийгээр тархаж эхэлсэн юм.

Шинжлэх ухааны бодит аргад суурилсан анагаах ухааны энэ шинэ чиглэл тайлбарлахад хэцүү хоёр хэсгийг агуулдаг.

Эхнийх нь нөхөн суулгавар эд нь маш түргэн хугацаанд эерэгээр үйлчилж эхэлдэг бөгөөд энэ нь нүдний хагалгаанд онцгой үр дүнтэй. Жишээ нь би нэгэн ахимаг насны итали эмэгтэйд нөсөөт бодисын торлог бүрхэвчийн өвчлөлтэй (тахиаан сохор) холбоотойгоор хагалгаа хийсэн юм. 5 жилийн турш гэрлийг харанхуйгаас арай ядан ялгаж байсан тэр эмэгтэй хагалгаанаас хойш 3-4 цагийн дараа л өөрөөсөө гурван метрийн алсад байгаа гарын хуруунуудыг тоолж эхлэв. Үүнийг юугаар тайлбарлах вэ? Энэ нь эдийн нөхөн төлжилтийн онолоор яавч тайлбарлагдахгүй байв. Учир нь эдийн нөхөн төлжилтэнд хамгийн багаар бодоход 1-2 сар шаардлагатай. Ямар нэгэн хэмжээгээр таарч буй тайлбар бол нөхөн суулгавар эдийн амин орны үйлчлэл юм. Аллоплантыг суулгаснаар эсийн урвалд нөлөөлж, эдгээр эсийн амин орон нь нүдний торлог бүрхэвчинд эерэгээр нөлөөлдөг бололтой. Гэсэн ч амин орны талаарх бидний мэдлэг хомсоос шалтгаалж уг үзэгдлийг сайтар тайлбарлах боломжгүй байсан юм.

Хоёр дахь ойлгомжгүй зүйл нь нүдний зовхины хорт хавдрын үед аллоплантын үзүүлж буй үйлчлэл юм. Хавдрын энэ хэлбэр нь янз бүрийн эмчилгээний дараа өвчтөнүүдийн 30 гаруй хувьд нь хавдар дахин үүсч, энэ нь нүүрээр тархаж, нүдний аяганд орсноор тархинд тархаж үхэлд хүргэдэг. Зовхины хавдрыг аллоплантаар эмчлэхдээ бид аллоплант нь хавдрын өсөлтийг нэмэгдүүлэх байх гэж түгшиж байсан юм. Гэвч, хавдрыг авч хаясны дараа үүссэн эдийн дутагдлыг ямар нэгэн зүйлээр нөхөх шаардлагатай байсанд бидэнд аллоплантыг хэрэглэхээс өөр аргагүй байлаа. 183 эмчлүүлэгчид ийм хагалгаа хийж, 8 жил хүртэлх хугацаанд үр дүнг нь хянасны эцэст бид маш сонирхолтой дүгнэлтэнд хүрсэн юм. Эдгээр хагалгааны үр дүнг нь үнэхээр сонирхол татмаар байв. Учир нь хавдрын дахилт 30%-аас 1.2% хүртэл буурсан байлаа.

Зовхины хорт хавдрыг мэс заслын аргаар эмчлэхэд өгсөн аллоплантын ийм эерэг үйлчлэлийг юугаар тайлбарлах вэ? Хагалгааны үед хавдрыг эцсийн эс хүртэл бүрэн бүтэн авч чаддаггүй бөгөөд ихэнхдээ энэ нь ясандаа хүртэл ургасан байдаг тул түүнийг авч хаях боломж байдаггүй. Тэгвэл яагаад аллопланттай хийсэн мэс заслын дараа үлдсэн хавдрын эс нь дахин ургадаггүй юм бэ?

Эмчлүүлэгчийн эрүүл эс нь ургаснаар хавдрын эсийн төлжилтийг саатуулдаг гэдгээр үүнийг ямар нэгэн хэмжээнд тайлбарлаж болох л юм. Бид энэ талаар хийсэн туршлагаас зарим нэгэн тайлбар олсон боловч хавдрын эс бүрэн мөхсөний шалтгааныг олоогүй юм. Нөхөн төлжилтэнд оролцож байгаа хэсгийн хавдрын эсүүдээр зогсохгүй мөн нөхөн төлжиж буй эд эсээс харьцангуй алс

орших хавдарын эсүүд мөн үхэж байсан нь юугаар ч тайлбарлагдашгүй сонин зүйл байлаа. Үүнээс үндэслээд ургаж буй эрүүл эсүүд нь өвчтэй хавдрын эсийг мөхөлд хүргэх хүчтэй амин оронтой гэсэн дүгнэлт хийхэд хүргэв.

Ер нь бол ургаж буй эд эсийн амин орон нь янз бүрийн өвчнийг эмчлэхэд сайнаар нөлөөлдөг нь шинжлэх ухаанд тодорхой болсон зүйл л дээ. Хабаровскийн Цзян эмч өвчтөнүүдийг ургамалын амин орноор шарж эмчилдэг “Биотрон” гэдэг төхөөрөмж зохиосон. Би өөрөө түүгээр эмчлүүлсэн эмэгтэйтэй уулзаж, ургаж буй ургамлын амин орноор эмчилсэн нь үлэмж үр дүнтэй эмчилгээ болсныг нүдээрээ харсан. Үүнээс үзэхэд төлжиж буй эс нь биеийн бусад эсийг бодвол илүү хүчтэй амин оронтой байдаг бололтой. Мөн аллоплантаар идэвхжсэн хүний өөрийнх нь төлжиж буй энгийн эсүүдийн амин орон нь хүний биеэс ангид ургамлын амин орноос илүүтэй нөлөөлдөг гэж үзэж болох юм.

Үсэрхийлэгч хорт хавдрын үед аллоплантыг хэрэглэж үзэх хорхой хөдөлсөөр байлаа. Гэвч энэ амин орны мэдээллийг хэрхэн үсэрхийлсэн хавдрын эс болгонд хүргэх вэ? Судалгааны явцад найдваргүй болсон олон янзын хавдартай өвчтөнүүдэд аллоплантыг хэрэглэх санаа төрж байлаа.

Гэвч... шинжлэх ухаанд байдагчлан аливаа санаа өвчтөн дээр бодит биеллээ олтол бас ч гэж урт удаан замыг тууллаа. Бидэнд амин орны талаар мэдлэг үнэхээр дутагдаж байгааг ойлгосон юм. Харамсалтай нь энэ талаарх мэдээ сэлт шинжлэх ухааны ном зохиолд үнэхээр бага байдаг ажээ.

Хүний амин орны талаарх мэдээллийг олж авахын тулд янз бүрийн үзмэрч, шидтэн, ховсчдод хандах хэрэгтэй юм гэж үү? Харамсалтай нь тэдний ихэнх нь хууран мэхлэгчид байдаг.

Орчин үеийн анагаах ухаан зөвхөн хүний амин орныг судалснаар эмчилгээний шинэ шинэ боломжийг нээж болохыг ойлгож эхэлж байна. Гэтэл Дорны улс орнуудад (Энэтхэг, Балба, Төвд) амин орны эмчилгээний аргуудыг дээр үеэс хэрэглэсээр иржээ. Европ анагаах ухаанд “бие махбодийн энергийн хүрээ” гэдэг ойлголт нь ойлгомжгүй бас хийсвэр зүйл байхад төвдийн анагаах ухааны хувьд энэ нь хэдэн мянган жилийн эмчилгээний үйл ажиллагааны үндэс болж буй юм.

Эмч хүн үүнд хоёр аргаар хандаж болно. Нэг талаас тэрээр Төвд анагаах ухааныг судалснаар түүнийг бүрэн бүтэн дагагч болж болно. Нөгөө талаас тэрээр Төвд анагаах ухааны онол, арга зүйгээс эзэмшиж, харин судалгааныхаа үндсэн анхаарлыг сэтгэлийн энерги, сэтгэл, сүнсний үйл ажиллагаа хэрхэн явагддаг хандуулж, тодорхой асуудалд ерөнхий байр сууринаас хандаж болно.

Шинжилгээ судалгааны замналаар явахдаа би үргэлж хоёрдогч аргын үүднээс буюу эрдэмтэн хүн ерөнхий зүйлээс тусгай зүйлд ханддаг аргыг хэрэглэсээр ирсэн. Тийм ч учраас анагаах ухааны асуудалд, тэр дундаа хорт хавдрыг эмчлэхэд бид өөрийн эрхгүй сэтгэлийн энерги болон үүнтэй холбоотой



хүний үүсэл гарал болон дэлхийн үүслийн талаарх асуудлыг хөндөх хэрэгтэй болсон юм.

Үүнээс гадна, дээр дурьдсанчлан бидний судалгааны чиглэл болсон офтальмогеометр нь хүн төрөлхтний үүсэл гарлыг дэлгэрэнгүй авч үзэхэд хүргэсэн юм.

Ийм материаллаг эхлэлтэй гэхээр хоёр асуудал биднийг (хавдрын асуудлыг шийдвэрлэх болон хүн төрөлхтний үүсэл гарлыг судлах) Энэтхэг, Төвд, Балбад шинжилгээний ангиар явж судалгаа хийхэд хүргэсэн билээ. Шинжилгээний ангиар явахаас өмнө бол бид хувь тавилангийн эрхээр оккульт шинжлэх ухаанд орж, шинжлэх ухааны үүднээс шашны мэдлэгийг тайлбарлах юм гэж санасангүй.

Шинжилгээний ангиар явж байх хугацаандаа хүн төрөлхтний Генийн сан болон сүүлийн илгээлт “SoHm”-ийн тухай мэдээлэл олж аваад би айж билээ. Цэвэр материаллаг шинжлэх ухааны салбарт ажиллаж сурсан, тэр дундаа өдөр болгон хагалгаа хийж, орон зайн асуудлын талаар бодох ч завгүй явдаг би гэдэг хүн өөрийн эрхгүй өөрийгөө байж болох бүхий л төрлийн оккульт болон эзотерик шинжлэх ухааныг номлогч амьдарлаас тасарсан хүн мэтээр мэдэрч эхлэв. Би иймэрхүү хүмүүст хэзээ ч нүүр өгч байгаагүй ч тэдний эмх замбараагүй яриаг сонсож, судлах шаардлагатай болсон юм. Би бүхий л амьдралынхаа туршид хуучинсаг үзэлд нь эргэлзэх шаардлагагүй эрдэмтдэд судалгаа шинжилгээний ажлынхаа зөвийг батлах шаардлагатай тулгардаг байсан бөгөөд хуучинсаг үзэл бол маргаанаас үнэн төрдөг гэдэг утгаараа сайн зүйл юм гэж боддог байсан.

### **Толгой дээр нь алим унасан цагт л тэрээр Ньютоны хуулинд итгэнэ**

Шинжилгээний ажлын үндсэн үр дүнг “Аргументы и факты” сонинд нийтэлснээс хойш бид маш олон захиа хүлээж авав. Эдгээр захидлын дотор нэртэй эрдэмтэдийн захиа хүртэл байлаа. Хэдийгээр хачирхалтай ч ихэнх эрдэмтэн эрдэм шинжилгээний ангийн олж авсан баримтанд эерэгээр хандсан юм. Бидний явуулсан нэлээд хэдэн удаагийн хэвлэлийн бага хурлаар бид видео болон слайдын материал танилцуулахад үг хэлсэн ихэнх эрдэмтэн бидний хийсэн дүгнэлт, үр дүнг сайнаар үнэлж, бидэнд талтай хандаж байлаа. Бид шууд нотолгоо ололгүйгээр зөвхөн хийсвэр сэтгэхүй дээр үндэслэн хажуугийн шууд бус баримт дээр тулгуурлаж буйг үл харгалзан хүмүүс агуйд өмнөх иргэшлийн хүмүүс самадийн байдалд байдаг гэх мэтчилэн толгойд багтамгүй зүйлийг маш сайн хүлээж авч байлаа. Хүмүүс хийсвэр сэтгэлгээнд итгэж, ухамсарынхаа далдын далд хүн бол бүх ертөнцийн амьдралын зөвхөн нэгээхэн хэсэг нь бөгөөд байгалийн эзэн биш юм гэдгийг, хүн төрөлхтний хийсэн нүглийн улмаас газар дэлхий дээрх амьдралыг баталгаажуулдаг цогц болох Хүн төрөлхтний Генийн сантай шууд холбоотой байх боломжоо алдсан гэдгийг мэдэрдэг ажээ.

Энэ нь миний хувьд огт санаанд оромгүй зүйл байлаа. Учир нь би бүрэн эс ойлголцолыг, бут цохисон том том нийтлэлийг болон намайг “юмтай болчихож”

гэсэн тодорхойлолт өгөхийг хүлээж байсан юм. Цорын ганцхан “Воскресная” гэдэг хүмүүс зөвхөн зурагтын мэдээ харах гэж авдаг жижигхэн гудамжны сонин манай шинжилгээний ангийн ажлын зарим нэгэн үр дүнг баримт нотолгоо багатай гэж буруушаасан нийтлэл байн байн хэвлэх болсон юм. Намайг таамгийн лемуротлантын зургийг миний бүдүүвчээр зурж өгсөн зураачаас хулгайлсан гэж хүртэл буруутгав. Би зурж чадна л даа. Гэвч мэргэжлийн хүн арай илүү байх болов уу. Зураач В.Куприянов бид хоёр биднийг хэрхэн муудалцуулахыг оролдсоныг шоолон баахан инээлдэж билээ. Энэ сонины уур хилэнгийн шалтгаан нь сүүлд илэрсэн юм. Учир нь уг жижигхэн сонин хамгийн анхнаасаа л манай шинжилгээний ангийн баримт мэдээллийг хэвлэн нийтлэх онцгой эрх эдлэхийг хүссэнд бид уг эрхийг Оросын хамгийн нэртэй сонин болох “Аргументы и факты” сонинд өгсөн явдал байв.

“АиФ”-ийн нийтлэлүүдийг оросын болон хилийн чанадын олон сонин хуулбарлан нийтэлсэн. Тэдгээрийн нэгэнд ч хуучинсаг шүүмж буруушаасан зүйл байгаагүй. Надад зориулсан шүүмж нь санаа авууштай зөвлөмжийн шинжтэй байсан. Жишээ нь самади агуйн сэтгэлийн энергийн саад нь хортой ууршмал зүйлтэй холбоотой гэж, хүний үүсэл гарлыг судлах нь мэс заслын эмчийн хувьд миний нэр хүндэд муугаар нөлөөлнө гэж бичигцээсэн байлаа.

Шинжлэх ухааны хуучинсаг үзэлтнүүд шүүмжлэн устгахад нэн тохиромжтой бай болох бидний Төвдэд хийсэн судалгааг яагаад тойрон гарсан юм бол? Миний үзэж байгаагаар үүний шалтгаан нь бидний судалгаа аль ч эрдэмтний сонирхолтой харшилдан түүний гаргасан баримтыг няцаагаагүйд оршино. Эрдэмтэд эрдэм шинжилгээний ажлынхаа амжилтаас болж толгой нь эргэн, хийсэн бүтээснээ хөдлөшгүй үнэн (тийм юм гэж байдаггүй нь тодорхой) гэж ойлгон хуучинсаг үзэлтэй болж эхэлдэг. Бусад эрдэмтдийн зүгээс гарах түүний санааг дэмжих, хөгжүүлэх, үгүйсгэх гэсэн оролдлого болгоныг тэрээр сэлэмтэй угтдаг. Учир нь энэ тохиолдолд мөнхөд шинжлэх ухааны манлай байхыг хүсэж байсан түүний бүх насны амьдрал дэмий өнгөрсөн юм шиг санагдах болно. Ийм хуучинсаг үзэлтэй эрдэмтэд шинжлэх ухаан гэдэг бол зах хязгааргүй мэдлэгийн орноос шинэ соргог болгоныг эрэлхийлсэн хөдөлгөөнт үйл явц гэдгийг, түүний судалгаа өөр шинэ шинэ санаанд түлхэц өгдгөөрөө ашигтай гэдгийг ойлгодоггүй.

Хуучинсаг үзэлтэй эрдэмтний бас нэгэн жишээ бол алим толгой дээр нь унасан тохиолдолд л Ньютоны хуулинд итгэдэг “бурхангүй Бумаа” нар юм. Ийм эрдэмтэд зөвхөн самади-агуйгаас гарган ирж бүгдийн нүдэн дээр амь орсон атлант гэх мэт шууд нотолгоог л хүлээн зөвшөөрдөг. Тэгсэн ч энэ чинь атлант юм уу гэх зэрэг олон эргэлзээ түүнд төрнө. Эрдэмтдийн энэ төрөл нь судалгааны хийсвэр сэтгэлгээг эзэмшээгүй, хажуугийн баримт мэдээллийг хамруулан нэгэн гинжин хэлхээ болгож чаддаггүй сайн таамаг дэвшүүлэх гэдэг нь цагаасаа түрүүлж алхах чиг зорилгыг тодорхойлж, эрэл хайгуул явуулахад туйлын тустай тул бараг л ажлынхаа талыг нугалсан гэсэн үг гэдгийг ойлгодоггүй. Жишээ нь Эйнштейний

харьцангуйн онолын баталгаа амьдрал дээр их биш ч аль хэдийн Сансрын уудмыг эзэмшихэд хэрэглэгдэж байна. Түүнчлэн самадийн ололт дээр тулгуурласан Хүн төрөлхтний Генийн сангийн тухай таамаглалыг бодисын солилцоонд орны үйлчлэх үйлчлэл, эрхтэнүүдийг хадгалах шинэ аргын талаар, биеийн усны гүйцэтгэх үүрэг, янз бүрийн чиглэлд сэтгэлийн энергийг ашиглах зэрэг чиглэсэн судалгааг идэвхжүүлэхэд ашиглаж болно. Харин “бурхангүй Бумаа”-гийн хувьд биологийн талаас мэдрэх боломжгүй уг зүйлийг батлахаар хүч, цаг заваа баралгүйгээр, түүнийг тайван зөнд нь орхих нь хамгийн зүйтэй арга юм.

Хуучинсаг үзэлтэй эрдэмтний гуравдахь төрөл бол хуучинсаг үзэл нь арилжааны ашиг сонирхолын үүднээс үүсдэг бүлэг эрдэмтэд юм. Янз бүрийн улс оронд аллоплантыг танилцуулж байх үедээ бид ийм эрдэмтэдтэй таарч байлаа. Жишээ нь чихрийн шижингийн улмаас үүссэн нүдний өвчинд аллоплантыг хэрэглэх нь маш үр дүнтэй байдаг. Эдгээр өвчтөнүүдэд мэс засалын энэ аргыг нэвтрүүлэх нь тун чухал юм. Гэвч, ингэсэн тохиолдолд үр дүн муутай нүдний дусаалга, лазер болон бусад төхөөрөмжийг үйлдвэрлэгч компаниуд дампуурах магадлалтай. Зөвлөгөө өгөгч эрдэмтэд болох зарим нэгэн нэр төр байр суурьтай эрдэмтэд эдгээр компаниас мөнгө саадаг учир нэгэн дуугаар аллоплантыг үр дүн муутай, хортой гэж муулж эхэлдэг. Аллоплантыг нэвтрүүлснээр тэдний халаас нимгэрнэ гэдгийг тэд ойлгож байгаа хэрэг. Азаар Генийн сангийн тухай таамаглал нь танин мэдэхүйн шинжээр илүү учир арилжааны ухаантай эрдэмтдийн анхаарлаас хол байна. Гэсэн ч цаг хугацаа өнгөрөхийн хирээр хуучин аргаас өвчтөнүүд татгалзаж, энэ таамаглалын үндсэн дээр эмчилгээний шинэ арга, төхөөрөмж бүтээгдэнэ. Тэгэхээр энэ аминд халтай шүүмжлэлд зөвхөн энэ арга аргачлалууд бус, мөн тэдгээр аргуудыг төрүүлсэн таамнал хүртэл өртөх болно.

Миний хувьд хуучинсаг үзэлтэй эрдэмтэдтэй харьцах нь ердийн үзэгдэл байсан бол домч, илбэч, шидтэнтэй харьцах нь шинэ зүйл байлаа.

### **Шидтэнүүд, илбэчид, ховсчид**

*Шидтэнүүд, илбэчид, ховсчид* Иймэрхүү хүмүүс бидний судалгааг машид сонирхож байлаа. Үнэнийг хэлэхэд эрдэмтэн хүний хувьд ид шидийн гэх мэтийн сэдвээр ярилцах нь ичгэвтэр байв.

Эрдэм шинжилгээний ертөнц үүнийг тууштай үгүйсгэдэг юм. Харин орчин үеийн ховсчид илбэчид бидний судалгаа тэдний ер бусын чадавхийг баталж байгаа гэж ойлгосон бололтой баярлацгаасан юм. Хүн төрөлхтний Генийн сангийн тухай асуудлыг шинжлэх ухааны болон танин мэдэхүйн талаас авч үзэх нь тэдэнд огт хамаагүй байлаа. Тэдний хувьд сэтгэлийн энергийг чиглүүлэгч эрхтэн болох “билгийн нүд”-ий талаарх мэдээлэл хамгийн чухал байсан юм. Үүнээс тэд хувь заяаг урьдчилан тааварлах, өвчнийг илааршуулах, үүл хөөх г.м. чадварт шинжлэх ухааны үндэс олох гэнэ.

Мэдээж зарим хүмүүс бусдыгаа бодвол үнэхээр хүчтэй сэтгэлийн энергийн чадавхитай байхыг би үгүйсгэхгүй.

Гэвч хамгийн осолтой нь ийм хүмүүсийн ихэнх нь залилан мэхлэгчид байдаг. Өнөөдөр манай улсад удирдах байгууллагаасаа эхлээд залилан мэхлэгчид дүүрэн байхад шидтэн-мэхлэгчид бол зүгээр л хүүхдийн тоглоом мэт санагдах болжээ. Ямар ч байсан тэдний учруулж буй хохирол, жишээ нь “МММ” компанийн луйварчдын учруулах хор хохиролтой харьцуулахад юу ч биш. Гэсэн ч чиний эрдэм шинжилгээний таамгийг заль мэхний үндэс болгон ашиглах нь туйлын таагүй хэрэг гэдэгт итгээрэй!

Өнөөдөр Орост төлбөрийн чадвартай үйлчлүүлэгчийг булаацалдан хоорондоо өрсөлдөх “ардын домчид” их болжээ. Заримдаа энэ өрсөлдөөн нь хүний ёс зүйн хэм хэмжээнээс ч давдаг. Жишээлэхэд хүнд ойртон очиж зургаа дахь мэдрэхүйгээрээ түүнийг хорт хавдраар өвчилснийг мэдэрч буйгаа хэлдэг хоёрын ч зэрэг “ардын домч”-ийг би мэдэх юм байна. Буйр суурьтай мэхлүүлэгч нь өөрөөсөө аймшигт өвчнийг хайж, эцсийн эцэст эдгээр “домчдоод” хандан зохих үнийг төлж уг “хавдраа” эмчлүүлдэг байна. Үүнийг гэмт хэрэг гэхээс өөрөөр нэрлэшгүй. Тэгээд ч хуульгүй - бүхнийг хийх эрх чөлөөтэй болсон өнөө үед ийм зүйл юу ч биш болж дээ.

Өөрийгөө нүд эмчлэх мэргэжилтэй гэх нэгэн “домч”-ийг манай институтэд ирж, чадавхиа нүдний эмчийн хяналтан доор үзүүлэхийг хүсэхэд тэр шууд татгалзсан юм.

Иймэрхүү маягийн хууран мэхлэлт бол арай л дээр зүйл юм. Үүнээс долоон дор юм нь эдгээр домч, шидтэнгүүдийн зарим нь маш хүчтэй сөрөг энергитэй байдаг бөгөөд тэд нэг л ер бусын өвөрмөц хүнд нүдтэй байдаг. Тэд эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй юм. Манай хүрээлэнгийн нэгэн ажилтан эмэгтэйд болсон явдлыг үүнийг баталгаа болгон танилцуулья. Шидтэн, илбэчид оролцсон нэгэн уулзалт хуралдааны үеэр тэрээр гэнэтхэн бие нь суларч, энэ нь хоёр хоногийн дараа л зүгээр болжээ. Ховсчдын нэг нь түүний хүрднүүдийн нэг нь гэмтсэн байна гэж оношилсон юм.

Гэвч бүх зүйл дандаа муу байдаггүй. Ховс, домч нар сэтгэлийн эерэг энергийнхээ тусламжтайгаар үнэхээр хүний биед сайн нөлөө үзүүлж болох үндэслэлтэй. Ийм жишээ ч олон байдаг.

Үнэхээр домчоос хууран мэхлэгчийг хэрхэн ялгах вэ? Харамсалтай нь одоогоор тийм арга зам байхгүй байна. Үүний тулд хүний сэтгэлийн мөн чанарыг судалдаг шинжлэх ухааныг хөгжүүлж юуны түрүүнд шинжлэх ухааны үүднээс шашны болон дорно дахины анагаах ухаанд хандах хэрэгтэй. Сэтгэлийн энергиэр хүний биед асар хүчтэй нөлөөлж болдог гэдэгт эргэлзэлтгүй. Учир нь самадийн байдалд бясалгалын хүчээр л орж болдог шүү дээ!

Нэгэнтээ л бид хүний сэтгэлийн энергийн хүчин чадлын талаар ярьж эхэлсэн юм бол эрүүл бус сэтгэхүйтэй хүмүүсийг ч мөн дурьдахгүй өнгөрч болохгүй нь.

## **Сэтгэцийн гажигтай хүмүүс болон харьцагчид**

Манай шинжилгээний ангийн материал нийтлэгдсэн нь маш олон эрүүл бус сэтгэхүйтэй хүмүүсийн анхаарлыг татсан юм. Бид цөөнгүй захиа хүлээн авсаар байсан бөгөөд өөрийн “дотоод” бодол санаагаа хуваалцаж надтай уулзахаар алс холоос мөн цөөнгүй хүмүүс ирж байлаа.

Сэтгэл мэдрэлийн гажигтай хүмүүс (шизофреник) гэж анагаах ухаанд мөрөөдөхийн дэмийрэл болон аугаа ихийн дэмийрэл гэсэн сэтгэцийн хоёр том гажигтай хүмүүсийг хэлдэг. Энэ өвчин нь даамжрах явцтай бөгөөд ерөнхийдөө сэтгэцийн энэ гажгаас үүдсэн оюун ухааны хомсдолоор төгсдөг. Зарим нэгэн сэтгэцийн “гажуудалтай” (дуугүй битүү хүмүүс, зүй тогтолгүй бодол санаатай хүмүүс зэрэг) хүмүүс бүрэн гүйцэт шизофреник бололгүйгээр энэ үе шатандаа байсаар байдаг. Эдгээр хүмүүсийг шизоид маягийн хүн гэдэг.

Шизофреник болон шизоидууд нь эргэцүүлэн бодох чадавхи дутмаг бөгөөд өөрсдийн бодол санааг дэлхийн хэмжээний нээлт гэж ярьдаг онцлогтой. Жишээ нь алсаас надтай уулзахаар зорьж ирсэн нэгэн хүн өөрийн “агуу нээлт” болох бурхан гэдэг бол ганц гэдгийг хуваалцаж (хэдийгээр үүнийг хүн бүхэн мэдэг боловч!) үүнийгээ НҮБ-д уламжилж өгөхийг хүсч байв. Өөр нэг хүн намайг ертөнцийн үүсэл гарлын талаар бичихгүй байхыг гуйн, үгүй бол тэрээр маш ихээр сэтгэл хөдлөн галзуурчих гээд байна гэв (тэрээр аль хэдийн “галзуурчихсан” байсан).

Уулзаж ярилцсан иймэрхүү хүн болгонд би ямартай ч “Та үүнийг хаанаас мэдсэн юм бэ?” гэж асууж байлаа. Энэ асуулт тэднийг ямагт алмайруулах агаад тэд энэ асуултанд ер хариулж чаддаггүй байлаа. Тэд бүгдээрээ л өөрсдөдөө чин үнэнчээр итгээсэй гэж хүснэ. Гэвч ...ийм юм гэж яаж байх вэ дээ...

Эдгээр шизофреник, шизоидуудын дунд цөөнгүй “харьцагчид” байлаа. Зарим нь зүүдэндээ бидний таамгийн лемуро-атланттай төстэй хүн жолоодсон сансрын хөлөг харсан гэж ярьж, зарим нь Дээд оюун Ухаантай харьцсаны дараа түүнийг самадийн байдалд буй янз бүрийн соёл иргэншлийн хүмүүстэй агуйд оруулсан гэж харсан тухайгаа ярьж байхад, бас өөр нэг нь агуй дахь эртний хүмүүстэй телепатын харьцаанд орсон тухайгаа ярьж байлаа.

Шизоидууд заримдаа үлэмж ухаалаг хүний сэтгэгдэл төрүүлдэг. Гэвч ойртоод ярилцах явцад тэдэнд шинжилгээний ухаан байхгүй, хийсвэрээр сэтгэн бодох, баримтыг цуглуулах чадваргүй нь харагддаг. Тэд ер бусын зүйлтэй тохиолдох үедээ хачирхалтай нэгэн гүний дотоод мэдрэмжээрээ удирдуулдаг бөгөөд тэд уг мэдрэмжийнхээ үнэн зөвд бүрэн итгэлтэй байдаг.

Материалист үзлийн үүднээс шизофреник болон шизоидуудыг эмгэг болон хэвийн бус үзэгдэлд тооцдог. Магадгүй эгэл жирийн хүмүүс бид шизоидуудыг ойлгодоггүй байж болох? Магадгүй шизоидууд нь сэтгэцийн хувьд илүү дэвшилттэй хүмүүс юм бол уу?

Шашны үзэж буйгаар бол монетар мөчлөгийн дагуу хүн төрөлхтний хөгжил материаллаг өсөлтийн хязгаар цэгээ хэдийн өнгөрөөд сэтгэл оюуны хөгжлийн үе шатаа эхэлсэн. Өөрөөр хэлбэл хүн төрөлхтний сэтгэл оюуны хөгжил түүхэн хувьслаараа явагдаж буй юм. Гэвч ямар ч түүхэн хөгжил алдаа, сул талтай байдаг бөгөөд миний бодлоор шизофреникүүд болон шизоидууд нь түүхэн хөгжлийн нэгэн “алдаа” юм. Тэдэнд үнэхээр л сэтгэл оюуны ямар нэгэн гоц юм байх боловч тэр нь ашиг муутай гаж зүйл байдаг. Эдгээр “түүхэн хувьслын золиоснууд” нь дотроо ямар нэгэн гүн гүнзгий зүйлийг мэдрэх чадвартай төрсөн хэдий ч үүнийхээ утга учир, ач холбогдлыг ухамсарлан ил гаргах чадваргүй.

Түүхэн хувьслынхаа хувьд шизофреникийг холын хараа муутай хүмүүстэй адилтган харьцуулж болох юм. Одоо дэлхий дээр орчин нөхцөл байдалд дасан зохицсон ойрын хараа сайн, холын хараа муу байх үйл явц түүхэн хувьслын замаар хөгжиж байгаа юм. Гэвч зарим хүнд энэ нь хөгжиж буй үйл явц болдог буюу жил бүр л шинэ шинэ диоптри нэмэгддэг. Энэ бол эмчлэх шаардлагатай өвчин юм. Миний бодлоор эд ч гэсэн нэгэн төрлийн “хувьслын золиос” юм.

Хэзээ нэгэн цагт манай иргэншлийн хүмүүс ч гэсэн атлант лемурчуудын хүрсэн шиг сэтгэл оюуны өндөр түвшинд хүрэх биз. Гэвч одоохондоо бидэнтэй зөвхөн хувьслын золиос болсон шизофреникүүд болон шизоидууд л таарч явна. Зөвхөн тун цөөн хүмүүст л маш өндөр сэтгэл оюуны хүчин чадал заяажээ.

### **Сэтгэл оюуны өндөр хөгжилтэй хүмүүс**

Миний дээр ярьсанчлан сүүлчийн илгээлт болох “SoHm” манай иргэншлийн хүмүүст Ертөнцийн Мэдээллийн Оронд (Нөгөө Ертөнц) нэвтрэлгүйгээр өөрөө боловсрох шаардлагыг тавьсан. Зөвхөн зарим нэгэн хүмүүс л Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд таарч, тэндээс мэдээлэл авах чадвартай байдаг. Ийм хүмүүсийг Гэгээрэгсэд гэдэг. Гэгээрсэн хүмүүсийн жишээ цөөнгүй байдгаас Дорнын зарим мастер, Е.П.Блаватская, Л.Н.Толстой (Саи Бабагийн үзэж байгаагаар), Е.Рерих, А.Бейли г.м хүмүүсийг нэрлэж болно.

Гэгээрэгсдийн ярьж буй зүйлд итгэж болох уу гэсэн асуулт төрөх нь дамжиггүй. Бид оюун дүгнэлтээ Гэгээрсэн хүмүүсийн мэдээ баримт дээр үндэслэн хийсэн тул бидний хувьд энэ асуулт нь онцгой чухал байв. Тийм ч учраас “Би бичсэн зүйлдээ итгэж байна уу?” гэсэн асуулт маань тодорхой хэмжээнд “Гэгээрэгсдийн мэдээ баримтанд би итгэж болох уу?” гэсэнтэй утга адил юм.

Жишээ болгож миний байнга иш татан бичих дуртай Е.П.Блаватскаяг авч үзье. Түүний энэ агуу мэдлэгийн үндэс нь юу вэ? Энэ асуулт зөвхөн миний сонирхлыг татаад зогсоогүй. Лондоны сэтгэгц судлалын нийгэмлэгийн хуралдааны зарим нэгэн мэдээг иш татан бичсэн захидлыг Самараас А.Н.Степанов явуулжээ. Үүнд бичсэнээр манай зууны эхэн үед Лондоноос уг нийгэмлэгийн гишүүн болох Ходгсон гэгч нэгэн эр Орос орон руу “Блаватскаягийн

үзэгдэл”-ийг судлах зорилготой явсан байна. Ходгсоны хийсэн дүгнэлтийг үзвэл “ Елена Блаватская бол дэлхий дээрх хамгийн боловсролтой, хурц ухаантай, сонирхолтой хууран мэхлэгч юм” гэжээ.

Үнэхээр тийм гэж үү? Мэдээж Лондоны эрдэм шинжилгээний нийгэмлэгүүд дэлхийд үлэмж нэр хүндтэй гэдэг нь ойлгомжтой. Аливаа нэгэн нийгэмлэгийн байр суурь өндөр байх тусмаа түүний гишүүдийн өөрийн мэдлэгээ төгс төгөлдөр гэдэгт итгэж хуучинсаг үзэлд мухраар баригдах боломж их байдаг. Эрдэм шинжилгээний нийгэмлэгийн гишүүн Ходгсон ч мөн энэ хувь заяаг тойрч гарсангүй, Е.П.Блаватскаягийн мэдлэг өөрийнх нь өгөршсөн мэдлэгийн хүрээнээс хол даван гарч байсан учир түүнийг хууран мэхлэгч хэмээн буруутгажээ. Биеэ ихэд санаж, бэтгээ цатгаланд бодсон Ходгсон Е.П.Блаватскаяг өөрөөс нь зуу дахин ухаалаг гэдэгтэй эвлэрч чадсангүй. Мэдээж Ходгсонд Блаватскаягийн далай ухаан шашны сургаалтай ойролцоо юм гэдгийг төсөөлөх ч ухаан хүрсэнгүй. Мөн тэрээр Дорны ихэнх улс орон хүний хөгжил, үүсэл гарал, дэлхийн үүслийн талаар Блаватскаятай ижил ойлгоцтой байдгийг үл ойшоожээ. Түүний өндөр алдар нэр нь үүнийг ойлгоход саад болжээ. Үүнээс хойш бараг зуун жил өнгөрсөн боловч хэн Ходгсоныг мэдэж байна вэ? Бараг хэн ч мэдэхгүй шүү дээ. Е.П.Блаватскаяг харин бүгд мэддэг.

Оросын ард түмэн урт хугацааны турш хаалттай нийгэмд оршсоныхоо хувьд гадаадын эрдэм шинжилгээний нэр хүндтэй нийгэмлэгүүдийн өмнө эрхгүй толгой бөхийх болсон. Би ч мөн адил урьд өмнө нь Барууныхны хэлсэн бүгдийг толгой гудайлган сонсдог байсан. Гэвч сүүлд нүдний мэс заслын буянаар дэлхийн талыг туулахдаа Лондоны юм уу Нью-Йоркийн мэдэмхийрэл үнэн чанартаа эцсийн үнэн биш гэдгийг ойлгож билээ. Уншсан лекцийнхээ үед жишээ нь Нью-Йоркт би энэ ихэрхэл мэдэмхийрлийг няцаахыг хичээн, Нью-Йоркийн нүдний мэс заслын албанд зарчмын шинэ сэтгэлгээ дутагдаж байсныг эвтэйхэн шургуулж орхисон юм. Үүнийг сонсоход таагүй нь мэдээжийн хэрэг байсан ч нэр төрдөө хайртай эрдэмтэд анхааралтай сонсоод халуун яриа өрнүүлж эхэлсэн. Яриа өрнүүлж байна гэдэг нь сайн хэрэг. Мэдэмхийрэл, цэцэрхлийг няцааж байх нь зүйтэй. Эс бөгөөс тэд ийм байр сууриа зүгээр л нэг арилжааны хэрэгсэл болгодог. Жишээ нь жилд 100 доллар төлөөд Нью-Йоркийн эрдэм шинжилгээний академийн гишүүн байх эрхийг (академич болно гэсэн үг) авч үнэмлэх гардах болно. Энэ “академи” нь мөнгө хурааж үнэмлэх тараадаг албан тасалгаа болж байна гэдгийг хэн нь ч анхаардаггүй.

“Блаватскаягийн үзэгдэл”-ийг нухацтай авч үзэхэд түүний агуу их мэдлэгийн эх үүсвэр нь анхаарал татаж байна. Түүний хоёр боть номондоо бичсэн болгонд эртний эх сурвалжаас иш татсан нь маш олон тул ургуулан бодох юм уу, уран зөгнөхийн аргагүй юм. Е.Блаватскаягийн бичсэн зүйлсийг янз бүрийн шашны номонд гардагтай тулгаж үзэхэд шашны ухагдахуунууд нь далд утга санаа,

эгтлөлын хэлбэртэй болохоос гол утга санаа нь ижил байдаг. Ведын номлолтой харьцуулж үзвэл гол санаа нь нэг байгаа бөгөөд свами, лам, гуру нараас авсан мэдээлэлтэй мөн утга нэг байсан юм. Нострадамусын бичээсүүдтэй харьцуулахад ч мөн л нэгэн утга санаа илэрхийлж байгаа нь харагддаг.

Үүнээс үзэхэд ертөнцөд европын материалист шинжлэх ухаанд үл мэдэгдэх нэгэн том мэдээллийн эх сурвалж оршдог бөгөөд түүнээс янз бүрийн улс үндэстний янз бүрийн хүмүүс бие биенээсээ үл хамааран мэдлэг олж авдаг мэт. Мэдээллийн нэг эх сурвалж байдаг гэж үзэх нь өөр өөр улс орны хүмүүс бие биенээсээ үл хамааран гайхалтай төсөөтэй, урнаар зөгнөн бичсэн гэж бодсоноос илүү үнэнд дөхүү байгаа юм. Уг мэдээллийн эх сурвалж нь Ертөнцийн Мэдээллийн Орон (Нөгөө ертөнц) бололтой. Тийм ч учраас эрдэмтэн хvний хувьд би Гэгээрэгсдийн үлдээсэн болон шашны нотолж буй зүйлийг үл тоомсорлон хаяж үл чадмой.

Хүн төрөлхтний сэтгэл оюуны хөгжлийн дагуу ийм Гэгээрэгсдийн тоо цаашдаа нэмэгдэж холын ирээдүйд бүх хүмүүс “SoHm”-ын зарчмыг огоорон, Ертөнцийн Мэдээллийн Орны мэдлэгийг ашиглаж чаддаг болно. Мөн сэтгэл оюуны хөгжлийн үе шатанд Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд хэсэгчлэн тааруулж чаддаг хүмүүс үүсч, тэндээс зөвхөн зарим нэгэн мэдээллийг авч ашиглах боломжтой хүмүүс ч төрөх магадлалтай. Би ганц нэг ийм хүнийг таньдаг. Тэд хүний сэтгэл оюуны талаарх ном зохиолыг маш сайн мэддэг бөгөөд тэдэнд самади-агуйн тухай, эдгээр агуй дахь сэтгэлийн энергийн саадын талаар, адептуудын тухай г.м. мэдээлэл байдаг. Эдгээр мэдлэгийн эх сурвалжийн талаар лавлахад тэд юм хэлж чаддаггүй.

Ийнхүү сэтгэл оюуны түлхүү хөгжилтэй хүмүүс байдаг бөгөөд эрдэмтэд бид тэдний ярьж буй зүйлийг анхааралдаа авч болох юм. Ингэхдээ маш болгоомжтой хандаж өөр өөр улс оронд дахин дахин давтагдаж байгаа, шинжлэх ухааны нарийн логик уялдаа холбоотой мэдээллүүдийг л авч үзэх хэрэгтэй. Аливаад алтан дунджаар хандах нь дээр.

**Алтан дундаж** Материалаа танилцуулах болон судалгааны ажлын үед алтан дундгийн зарчмыг баримтлах нь зүйтэй гэж бодож байна. Цэвэр материаллаг байр сууриар хүмүүжсэн хүний толгойд бидний шинжилгээний ажлын үр дүн багтаж өгөхгүй юм. Гэсэн ч бид одоохондоо хүмүүсийн толгойд багтахгүй байна гээд хойшуулж болохгүй. Хийсвэр сэтгэлгээ гэдэг бол шинжлэх ухааны хатан хаан бөгөөд нийтэд түгсэн ойлголтын үүднээс логик зарчмыг зөрчих эрхгүй. Нөгөө талаас бид логик шинжилгээнд батлагдаагүй чухал бус баримтыг оруулах эрхгүй. Алтан дунджийг нь олох хэрэгтэй.

Шинжлэх ухаанаас гадуур хоцорсон шашин нь одоогоор хүний амьдралд бие авч явах байдал болон амьдралын хэв маягийг (жишээ болгож



христийн шашинтан болон лалын шашинтаны амьдралыг харьцуул даа) тодорхойлж өгөхөөс өөр мэдлэг хүнд өгөхөө больсон. Би хувьдаа шашныг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах ажлыг алхам алхамаар урагшлаасай гэж хүсэх байна. Гэвч үүний тулд цаг хугацаа шаардлагатайгаас гадна биднийхтэй төстэй судалгаа хийх хэрэгтэй.

Иймэрхүү тодорхой баримт нотолгоотой бус болохоор янз бүрийн эх сурвалжт, янз бүрийн мэдээ баримттай тулгарсан эрдэмтэн хүн эдгээр баримт мэдээллээс алтан дунджийг нь олж, юунд итгэж болох юунд итгэж болохгүйг олох шаардлагатай гардаг. Ямартаа ч бид уг алтан дунджийг олохыг хичээн хэд хэдэн таамаг (Хүн төрөлхтний Генийн сангийн тухай, Шамбал болон Агартын тухай, газар дэлхий дээрх хүн төрөлхтний түүхийн тухай, түүхийн ухрах хувьсалын дагуу хүмүүс зэрлэгших тухай болон Нөгөө ертөнцийн бүтцийн тухай) дэвшүүлээ.

Би шинжлэх ухааны хийсвэр сэтгэлгээ, уялдаа холбоонд итгэдэг. Ерөнхийдөө эдгээр таамаг үнэн зөв гэдэгт итгэдэг. Ирээдүйд эдгээр таамгын зарим нэгийг үгүйсгэх юмуу зарим нэг зүйлийг нь өөрчлөх болно. Гэвч доор бичигдсэн зүйл ихэнхдээ үнэн зөв байна гэдэгт би баттай итгэж байна.

Хоёрдугаар хэсэг


## Хүн төрөлхтний Генийн сан

Ингээд шинжилгээний ажлын үр дүнгээс бид газар дэлхийд гамшиг тохиолдох үед дэлхий дээрх амьдралыг үргэлжлүүлэх эсвэл хүн төрөлхтний хөгжил ухрах чиглэлд явагдах үед эртний мэдлэгийг ашиглах замаар хөгжлийн замд нь хөтлөхөөр хэдэн мянга, хэдэн сая жил хадгалагдсан самадийн байдлаасаа гардаг янз бүрийн иргэншлийн хүмүүсээс тогтсон Хүн төрөлхтний Генийн сан байдаг гэдэг урьдчилсан дүгнэлтэнд хүрсэн юм.

### **Генийн сангийн хүн төрөлхтний амьдралд гүйцэтгэх үүрэг**

Хэрвээ шашин болон Гэгээрсэн хүмүүсийн нотолж байгаагаар хүн нь сүнс нягтарших замаар үүсчээ. Эхний иргэншлийн хүмүүс сүнс хэлбэртэй байсан. Тэд аажмаар нягтарсаар гурав дахь иргэншлийн (лемурчууд) үед хангалттай нягттай болж, дөрөв дэх иргэншлийн үед бүр илүү нягт болж, хамгийн нягт нь манай иргэншлийн хүмүүс буюу тав дахь иргэншлийн хүмүүс болсон байна. Бодит ертөнцөд сүнс нягтрах замаар хүний бие махбод үүсэх нь байгалийн түүхэн хувьслын урт удаан хугацаа шаардсан төвөгтэй явц байлаа.

Гэвч дэлхийн гадаргуу дээр амьдарч буй хүн төрөлхтөн газар зүйн болон сансрын гай гамшгаас, мөн шинжлэх ухаан техник хангалттай хөгжсөн нөхцөлд хүн төрөлхтнийг сөнөөж ч болзошгүй бүлэглэл хоорондын мөргөлдөөнөөс болж галав юүлэх зэрэг аюул гамшгаас баталгаатай ангижраагүй байна. Дэлхий дээрх хүн төрөлхтөн бүрэн устсан тохиолдолд дахин байгалийн түүхэн хувьслын нөр их ажиллагааны дүнд сүнс нягтран хүн бий болох шаардлагатай болно.



Хүн төрөлхтөний генийн сан (зохиогчийн зураг)

Тийм ч учраас баталгаажуулагч бүтэц болох Генийн санг бүтээх нь хүн төрөлхтнийг устсан тохиолдлолд нүсэр их хүчээр дахин хүний биеийг сүнсний нятгралын замаар үүсгэх байгалийн үйл явцнаас хамаагүй төсөр юм.

Ном зохиолуудад дурьдагдсанаас үзэхэд хүн төрөлхтөн устаж болзошгүйн анхны шинж нь лемурын соёл иргэншлийн үед илэрч эхэлсэн байна. Хүн төрөлхтний Генийн сан чухам энэ үед үүссэн юм гэж үү? Энэ талаар шууд заасан зүйлсийг бид ном зохиол дээрээс олсонгүй. Гэвч Хүн төрөлхтний Генийн санд лемурчууд ч мөн байдаг тухай багагүй мэдээ баримт буй учир чухам энэ үед л уг Хүн төрөлхтний Генийн сан үүссэн гэсэн төсөөлөл төрж байна. Гэгээрсэн хүмүүсийн бичсэнээр эдгээр аварга биетэй хүмүүс самадийн байдалд агуйд оршоор байдаг бөгөөд нууцлаг Шамбалын орны үндэс нь болж буй юм. Гэвч энэ талаар дараа ярья.

Атлантчуудын соёл иргэншлийн үед Хүн төрөлхтний Генийн сан атлантчуудаар дүүрч эхэлсэн бөгөөд манай соёл иргэншлийн хүмүүс хөгжлийнхээ эхэн үед л Генийн сангийн бүрэлдэхүүнд ордог байсан байна. Учир нь самадид ороход зайлшгүй шаардлагатай “билгийн нүд”-ний хөгжил нь сүүлчийн илгээлт болох “SoHm”-ын зарчим хэрэгжихтэй зэрэгцэн буурч эхэлжээ.

Үүнээс үзэхэд хүн төрөлхтний Генийн сан нь сүүлчийн гурван үндэстнийг багтааснаараа дэлхий дээрх хэдэн сая жилийг эзэлсэн нэлээд эрт үеийн үзэгдэл аж. Хүмүүсийг ийм урт удаан хугацааны туршид хадгалж байгаагаараа самади нь байгалийн гайхам төгс төгөлдөр бүтээл мөн. Бидэнд самадийн талаар ярьсан Дорны шашны зүтгэлтнүүдийн хэн нь ч самадийг цаг хугацааны хязгаартай гэж хэлээгүй билээ.

Судар номуудад Хүн төрөлхтний Генийн сангийн үүслийг шууд заасан баримт мэдээ цөөнгүй байдаг. Е.П.Блаватскаягийнхаар бол үүнийг Ахура Мазда буюу бодит ертөнцийг үүсгэгчийн тушаалаар бүтээжээ. Ахура Мазда гурван иргэншлийг бэлгэдэгч Иима буюу газрын сүнсэнд Вараг (“хаалттай газар” эсвэл “оромж” эсвэл Арчха) бүтээхийг тушаасан байна. Е.П.Блаватская “Вара” гэдэг үгээр самадийн байрыг, өөрөөр хэлбэл Хүн төрөлхтний Генийн сангийн байрыг заажээ. Ахура Мазда хүний хамгийн агуу сайн төрлөөс шилсэн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үрийг болон энэ хүмүүс Варад байх хугацаанд тэнд хадгалагдах янз бүрийн мал адгуусны үрийг Варад авчирахыг тушаасан гэж зохиогч бичжээ.

“Хүн төрөлхтний Генийн сан” (Gene Pool of Humanity) гэсэн ойлголтыг бид дэвшүүлсэн юм. Хаана ч хэзээ ч бид ийм хэллэгийг сонсож байсангүй. Гэсэн ч бидний уулзаж ярилцсан Гэгээрсэн гэж үзэж болох лам, гуру, свами зэрэг хүмүүс бид чухам юуг Генийн сан гэж нэрлээд байгааг маш сайн ойлгож байсан. Тэд энэ хэллэгийг мэдээд зогсохгүй мөн байнга хэрэглэдэг мэт сэтгэгдэл төрж байлаа. “Хүн төрөлхтний Генийн сан гэж байдаг уу?” гэсэн шууд асуултанд тэд ихэнхдээ баталсан хариулт өгч байлаа. Эдгээр хүмүүсийн хувьд Хүн төрөлхтний Генийн сан оршдог нь ойлгомжтой мэдээжийн үзэгдэл мэт сэтгэгдэл төрж байлаа.

Гэвч энэ үзэгдлийн гайхам нууцлаг байдал, ариун дагшин байдал нь байнга ажиглагдаж байсан.

Хэлсэн зүйлийнхээ баталгаа болгон дээр дурьдсан мэдлэгийн эх сурвалжаа “сургаал” хэмээн нэрлэсэн Оросын шашны зүтгэлтэн - гэлэнтэй хийсэн ярилцлагынхаа удаах хэсгийг толилуулья.

- Эрхэм гэлэн минь, бид дэлхий дээр Хүн төрөлхтний Генийн сан байдаг гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм. Та энэ талаар юу бодож байна?- гэж би асуув.

- Тиймээ, Хүн төрөлхтний Генийн сан гэж үнэхээр байдаг. Энэ бол объектив бодит байдал бөгөөд зайлшгүй шаардлагатай зүйл юм.- гэж гэлэн хариулав.

- Үүнийг та хаанаас мэддэг юм бэ?

- Надаа энэ талаарх сургаал бий.

- Та хэзээ нэгэн цагт хэн нэгэнд Хүн төрөлхтний Генийн сангийн тухай ярьж байсан уу?

- Үгүй.

- Яагаад?

- Хүмүүс үүнийг мэдэж яах юм бэ? Энэ бол хэтэрхий ариун зүйл . Хүмүүс Хүн төрөлхтний Генийн сангийн үүргийг ойлгодог болтол багагүй цаг хугацаа өнгөрнө.

- Хүн төрөлхтний Генийн сангийн үүрэг нь юу юм бэ?- гэж намайг асуухад,

- Дэлхий дээрх хүний амьдралыг хадгалан баталгаажуулах,- гэж гэлэн хариулав.

- Хүн Төрөлхтний Генийн сангийн бүтэц нь ямар вэ?

- Түүний үндэс нь лемурчууд байдаг. Атлантчууд ч мөн их байдаг. Хэдийгээр атлантчууд олон байдаг ч тэдний үүрэг нь лемурчуудынхаас хамаагүй бага. Хэрвээ Хүн төрөлхтний Генийн сан хэрэг болох юм бол чухам лемурчууд л хүн төрөлхтнийг аврах болно. Учир нь тэд дэлхий дээрх хамгийн хөгжилтэй хүмүүс байсан.

- Манай иргэншлийн хүмүүс тэгээд яах билээ?

- Тэд ч гэсэн Хүн төрөлхтний Генийн сангийн бүтцэд ордог боловч тэдний үүрэг нь тун бага. Манай иргэншил гэдэг бол хүний хөгжлийн мухардалд орсон зэрлэг үе шат юм. Манай иргэншлийн хүмүүс сэтгэлийн хүчгүй, муу санаатай, тэд Генийн санд тохирохгүй.

- Өөрөөр хэлбэл ийм хүмүүсийг Генийн санд авдаггүй. Манай иргэншлийн эхэн үеийн төлөөлөгчид л Генийн сангийн бүтцэд орсон бол уу гэж таамаглаж байна. Учир нь тэр эрт үед сэтгэл оюуны өндөр хөгжлөө алдаагүй байсан юм. Гүн самадид орох гол шалгуур нь нигүүлсэхүй, өрөвдөхүйн хүчээр сэтгэлээ сөрөг энергиэс чөлөөх явдал биз дээ. Жишээ нь гол барааныхаа үндсэн үнэн дээр 100-200%-ийг зуучилсны хөлс болгон нэмж мөнгө саадаг “шинэ Орос”-уудаас нигүүлсэхүйн сэтгэл ундран гарч тэднийг ариусгана гэж төсөлөгдөхгүй л байна,- гэж би хэлэв.

- Манай иргэншил бол,- гээд гэлэн үргэлжлүүлэн,- бүтэлгүй туршилт болсон юм. Эртний мэдлэгээс тусгаарлагдан өөрөө боловсрох ёстой хүн маань атаа

жөтөө уур хилэн шунал тачаалийнхаа өмнө хүчин мөхөдсөн юм. Манай иргэншил азгүйгээр сөнөх ёстой...

- Тиймээ, дэлхий дахинд ялангуяа Орос орны дээр сөрөг энергэн бүрхүүл үүссээр байгаа нь эрүүгийн хэргүүдийг бах болгон, дайн дажинтай киногоор хүчирхийллийг сурталчлан шүтэн биширч хууран мэхлэлт, луйвардалт амьдралын хэм хэмнэл болсоноос үүдэлтэй. Сөрөг бүрхүүл нь сансрын болон газар зүйн гай гамшигийг урин далладаг гэж лам нар ярьж байсан нь үнэн үү? – гэж намайг асуухад,

- Ийм жишээ маш олон байдаг. Жишээ нь Армян- Азербайджаны хямралын үед Армянд газар хөдлөлт болсныг эргэн сана даа! Газар дэлхий дээр сөрөг энергийн үүл хуримтлагдсанаар хүн төрөлхтнийг мөхлийн гамшигт эсвэл хэн нэгнийг цөмийн бөмбөгийн товчлуураар тоглоход хүргэнэ. Миний бодлоор манай иргэншил удахгүй сөнөх ёстой. Учир нь энэ бол маш азгүй үе шат...- гэж гэлэн хариулав.

- Тэгээд...Хүн төрөлхтний Генийн сан шаардлагатай болно.- гэж би хэлэв.

- Тиймээ, газар дэлхий дээрх нөхцөл байдал амьдралд тохиромжтой болох үед.

Гэвч Хүн төрөлхтний Генийн сангийн үүрэг нь гагцхүү газар дэлхий дээрх амьдралыг баталгаажуулахад бус мөн түүнийг Гэгээнтнүүдийн тусламжтайгаар хөгжлийн замд нь хөтлөхөд оршино. Будда, Исвс, Мухаммед, Моисей нарыг хүн төрөлхтний түүхэнд бага үүрэг гүйцэтгэсэн гэж хэн хэлэх юм бэ? Хэн ч чадахгүй. Гэгээнтэн болгон хүмүүст асар их нөлөө үзүүлсээр хүн төрөлхтөн тэдний үйлчлэлийн дор лалын, христосын, буддын шашинтай улс болж хуваагдсан ...

Гэгээнтнүүд гэдэг нь самадигаас гаран Хүн төрөлхтний Генийн сангаас ирсэн хүмүүс гэдэгт бараг эргэлзэх зүйл үлдсэнгүй. Бид дээр бичсэнчлэн 850000 жилийн өмнө Атлантидын үндсэн эх газрууд усанд автсан байхад харин өвөрмөц бөгөөд атлантын гадаад төрхийн талаарх бидний төсөөлөлтэй ижилхэн төрхтэй Будда дэлхий дээр 2044 жилийн өмнө мэндэлсэн байдаг. Лемурчууд хэдэн сая жилийн өмнө мөхсөн байхад гадаад төрх нь бүр ч илүүтэй өвөрмөц бөгөөд хожуу үеийн лемурчуудын гадаад төрхтэй төстэй Бумба Будда буюу Рама нь дэлхий дээр 18013 жилийн өмнө морилсон. Исвс Христос агуйд мэндэлсэн бөгөөд удаан хугацааны турш Төвдэд суралцаж байсан гэсэн мэдээ баримт ч байдаг.

Газар дэлхий дээр гэгээнтнүүдийн дүрээр янз бүрийн иргэншлийн төлөөлөгчид ирдэг байсан бололтой. Жишээ нь, лемуро-атлант (Бумба-Будда), атлант (Будда) болон манай иргэншлийн хүмүүс (Иисус Христос, Мухаммед, Моисей). Бид Хүн төрөлхтний Генийн сангаас гарсан хүн болгоныг мэддэггүй бололтой. Учир нь тэд бүгдээрээ хүн төрөлхтний хөгжилд дээр дурдсан гэгээнтнүүд шиг үйлчлэл үзүүлж чадаагүй аж.

Гэсэн ч иймэрхүү “тодроогүй харь гаригийхан”-ы талаар мэдээлэл ном зохиолд хангалттай бий. Жишээ нь, 921-922-р онуудад Ижил мөрөн лүү хийсэн

аяллынхаа тухай номондоо Ахмед Ибн Фадлан (А.П.Ковалевский “Ахмед ибн Фадланы ном”, 1956 он, 138-139-р хуудас) ер бусын аврага биетэн хаанаас ч юм Булгар хаант улсад гарч ирсэн талаар ийн бичсэн байдаг: “...тэрээр таваас илүү тохой өндөртэй (5 метрээс илүү гэсэн үг - зохиогч тэмдэглэв), толгой нь хамгийн том тогоо мэт, хамар нь дөрөвний нэгээсээ том, хуруу болгон нь дөрөвний нэгээс том... тэрээр усаар хөвж ирсэн бөгөөд түүн рүү хүүхэд хармагц үхдэг, жирэмсэн эхнэр хармагцаа л зулбадаг, заримдаа тэрээр хүнийг хоёр гараараа барьж үхтэл нь баздаг байлаа...бид түүнийг алсан юм...”

Хүн төрөлхтний Генийн санд янз бүрийн соёл иргэншлийн маш олон хүн байдаг бололтой (бидний өмнө бичсэнчлэн самади-агүй маш олон байдаг бөгөөд тэр бүрт янз янзийн, маш олон хүн самадийн байдалд байдаг). Хүн төрөлхтний Генийн санд янз бүрийн соёл иргэншлийнхэнээс хамгийн шилдэгүүдийг сонгон авсан байдаг боловч түүний үүрэг хэтэрхий ахадсан бөгөөд дахин бодит амьдралд ороход түүнийг угтан авах орчин, нөхцөл байдал (амьдарч дассан уур амьсгал, тоног төхөөрөмж, орчин тойрон зэрэг хүчин зүйлс үгүй болсон) тэс ондоо байсанд тэд тэр бүр өөрт ноогдсон чухал үүргээ төгс төгөлдөр гүйцэтгэж чаддаггүй байна. Тийм ч учраас тэд бүгд энэ сорилтыг туулж, ялангуяа тэдний хөгжлийн замд нь хөтлөхөөр дахин дэлхий дээр гарч ирсэн муу санаатай, нэр төрд дуртай бяцхан хүмүүсийн эсэргүүцлийг даван гарч чадаагүй юм.

Хүн төрөлхтний Генийн сангийн төлөөлөгч байна гэдэг нь хүний агуу зорилгуудын нэг бөгөөд ингэхдээ хүн өөрийгөө үгүйрэл ядуурал амьдарлын маш хүнд нөхцөлд эртнээс золиосолж байгаа юм. Өөрийгөө хэдэн сая жилийн дараа огт өөр нөхцөл байдалд хагас зэрлэг омгуудын дунд гагцхүү өөрийн мэдлэг болон сэтгэлийн энергийг удирдах чадвартаа тулгуурлан амьдрана гээд төсөөлөхөд л хангалттай. Манай соёл иргэншлийн амьдралын нөхцөлд Хүн төрөлхтний Генийн сангаас ирсэн хүний нүдний бүтэц нь цэнхэр тэнгэрийн нөхцөлд харах чадваргүй бөгөөд хатуу чулуун хөрсөн дээр сарьсан таславч нь гэмтэн, хатуу амтгүй хоол идэн царай муутай, намхан атигар хүнэнцэрүүдтэй цуг амьдрана гэдэг тэдэнд ямар аятай байхсан билээ. Атлант төрөлх улаан тэнгэр, зөөлөн чийглэг хөрс, дотор нь тариагаа тарьдаг байсан дулаан нуур далай, өөртэй нь ижил том биетэй хань нөхрөө үгүйлж л таараа.

Ягаад зарим тохиолдолд лемуро-атлантчууд, заримдаа атлантчууд, заримдаа манай соёл иргэншлийн хүмүүс гэгээнтний дүрээр ирдэг байсан юм бол? Энэ асуултанд хариулахад хэцүү байна. Зөвхөн Дээд Оюун Ухаан л үүнийг мэдэх байх. Гэсэн ч энэ үед дэлхийн амьдралд хэн нь хамгийн их дасан зохицох чадвартай байна, хэн нь хүмүүст хамгийн их нөлөө үзүүлж чадахаар байна, энэ хугацааны туршид хэнийх нь мэдлэг илүү тохиромжтой байна зэрэг маш олон хүчин зүйлийг авч үзсэн нь ойлгомжтой. Хүн төрөлхтний Генийн сан нь хоорондоо үлэмж ялгаатай гурван үндсэн соёл иргэншлийн төлөөлөгчдөөс тогтдог нь сонголт хийх боломж олгодгоороо онцлог юм. Газар дэлхий дээрх амьдралын нөхцөл

байдал ямагт солигдож байх тул газар дэлхийн амьдралыг засах, үргэлжлүүлэх, илүү дасан зохицсон хүмүүсийг сонгоход ч мөн олон янз байх ёстой биз.

Аль ч иргэншлийн хүн гэгээнтний дүрээр эх дэлхий дээр морилохдоо хүмүүст эртний мэдлэгийн тусламжтайгаар нөлөөлж, эдгээр мэдлэгийг зааж сургах нэгэн нэгдмэл үүрэгтэй байдаг. 2000 оныг Кали-Юга (11000) Сатья-Югаар солигдож хүмүүс эртний мэдлэгийг нээж эхлэх алтан үе болно гэж ярьцгаадаг. Эртний мэдлэгийн мөн чанар нь юу юм бэ? Лемурчууд болон атлантчуудын амьдралын талаарх баримт мэдээллийг шинжилж байх явцад тэдний мэдлэгийн мөн чанар нь сэтгэлийн энергийг эзэмшихэд оршдог нь тодорхой болсон юм. Хүний сүнс нь нарийн ертөнцийн бүтээгдэхүүн болохынхоо хувьд агуу их хүчин чадалтай. Эртний хүмүүс нь сэтгэлийн энергийг буюу нарийн ертөнцийн энергийг эзэмшсэн байсан гэж итгэлтэй хэлж болно. Нарийн ертөнцийн энерги нь телепат болон гипнозын үйлчлэлээр зогсохгүй өвчин эмгэгийг эмчлэх, таталцлын хүчинд нөлөөлөх (хүнд жинтэй зүйл зөөвөрлөх), агаарт хөвөх шинэ зарчмыг болон бусад олон салбарт шинэ шинэ арга аргачлалыг нээх боломж олгоно.

Гэвч сэтгэлийн энергийг эзэмшихэд зарчмын том шаардлага тулгардаг. Энэ нь цэвэр ариун бодол санаа болон хар хоргүй сэтгэл оюун юм. Миний бодлоор энэ нь нарийн ертөнцийн амьдралын зүй тогтол юм.

Үүний баталгаа болгож В.Мегрегийн (“Анастасия”, 1997 он 17-43-р хуудас) ойд ганцаараа амьдардаг сибирийн ер бусын үзэсгэлэнт бүсгүй Анастасияг дүрслэн буй нэгэн хэсгээс иш татья. Энэ бүсгүй маш олон телепат болон ховсын эрдмийг эзэмшсэн бөгөөд өвлийн хүйтэнд хувцасгүй амьдарч чаддаг, ан амьтдын хэлийг ойлгодог, өнгөрсөн болон ирээдүйг зөгнөн хэлэх чадвартай байжээ. Эдгээр ер бусын чадавхынхаа эх үндсийг тайлбарлахдаа тэрээр хүн болгон ийм чадвартай байдаг боловч түүнийг биетжүүлэхийн тулд бодол санаа цэвэр ариун байх шаардлагатай. Харин хүний сэтгэлийн энергийн хүч нь ариун гэгээн мэдрэмжээс шалтгаална гэжээ.

“Ариун гэгээн мэдрэмж”, “цэвэр сэтгэл” зэрэг үгс нь анх харахад ямар нэг байдлаар бүдэг бүрхэгдүү, утга уянгын халилтай санагддаг. Гэвч гүн самадид орохын тулд мөн л “сэтгэлээ цэвэрлэх”, өөрөөр хэлбэл сөрөг чиглэлд эргэсэн торсийн оронгоос ангижрах шаардлагатайг эргэн санацгаая. Ийнхүү сэтгэлээ цэвэрлэсний үр дүнд хүний бие нь хэдэн мянга, хэдэн сая жилээр амьдаараа хадгалагдах ер бусын гайхамшигтай чадвартай болдог.

Хүн төрөлхтний Генийн сангаас гарсан хүмүүс цэвэр ариун сэтгэлтэй бөгөөд сэтгэлийн энергийг төгс төгөлдөр эзэмшсэн байсан нь ойлгомжтой (эс бөгөөс тэд самадийн байдалд орж чадахгүй байхсан). Боловсрол багатай, хагас зэрлэг хүмүүст сэтгэлийн энергийн хүчин чадлыг харуулахдаа тэд уялдаа холбоо бүхий өөдлөн дэвжих үйл явцын шинжтэй, юуны түрүүнд сэтгэлийн энергийн шинж чанартай эртний мэдээллийг дамжуулахыг оролддог байжээ. Ингэснээр шашин үүссэн бололтой. Мэдээж Библи ч бай, Коран ч бай, Талмуд ч бай харанхуй хүнд



зориулан ёгт үлгэрийн хэлбэрээр бичигдсэн байдаг ч, одоо тэдгээрт бичсэн зүйлсийн ихэнхийг сэтгэлийн энергийн үүднээс тайлбарлаж болохоор болоод байна.

Ингээд Хүн төрөлхтний Генийн сангийн үүрэг ач холбогдлын талаарх бодролоо дараахь хоёр дүгнэлтээр төгсгөө.

- Хүн төрөлхтний Генийн сан нь газар дэлхий дээр амьдралыг үргэлжлүүлэх баталгаа болдог.

- Хүн төрөлхтний Генийн сан нь газар дэлхийн өөр өөр соёл иргэншлийн мэдлэгийн өв хөмрөг болж, аль нэгэн соёл иргэншлийн төлөөлөгч соёлыг түгээх зорилгоор тэндээс мэндэлдэг.

Хүн төрөлхтний Генийн сангийн давхар үүргийг анхааралдаа аван тэмдэглэхэд самадид буй хүний тоо олон байдаг нь юуны түрүүнд газар дэлхий дээрх амьдралыг хангах үүрэгтэй холбоотой. Учир нь удамшлийн хуулиар хүн төрөлхтнийг эргээн сэргээхийн тулд аль болох олон, өөр өөр хүйсний хүмүүс байх шаардлагатай. Бидний хэрэглэж болох ном зохиолоос үзэхэд газар дэлхий дээрх өөр өөр иргэншлийн түүхэнд дэлхий дээр амьдарч буй хүн төрөлхтөн бүрмөсөн устсан түүх үгүй. Тийм учраас Хүн төрөлхтний Генийн санд нэг ч удаа хүн төрөлхтөнийг бүрэн аврах зорилт шаардагдааггүй бөгөөд одоохондоо хүн төрөлхтний хөгжлийн чиглэлийг засан залах, магадгүй зарим нэгэн хүмүүсийг эргэн төрүүлэх зорилготойгоор хэрэглэгдэж иржээ.

Гэвч, хэн мэдэх вэ, газар дэлхий дээрх хүн төрөлхтнийг зөвхөн Хүн төрөлхтний Генийн сангаар л аврах цаг ирэх ч юм бил үү.

## **Хүн төрөлхтний Генийн сангийн бүтэц**

Бидний ойлгож буйгаар Хүн төрөлхтний Генийн сан гэдэг нь самадийн байдалд буй янз бүрийн иргэншлийн хүмүүсээс тогтсон бүхэл бүтэн газрын эсвэл усан доорх улс гүрэн юм. Эдгээр самадид буй хүмүүс салангид бус, харин Ертөнцийн Мэдээллийн Орны шууд хяналтан доор хоорондоо холбоотой байдаг байна.

Самадийн үед сүнс бие махбодио орхин Ертөнцийн Мэдээллийн Оронтой (Нөгөө Ертөнц) шууд холбогддог тухай баримт мэдээлэл цөөнгүй бөгөөд энэ тухай бидний уулзаж ярилцсан лам, гуру, свами нар бүгд ярьж байлаа. Ингэхдээ сүнс нь “мөнгөн утсаар” дамжин биетэйгээ холбоотой байсаар байдаг. Үүнээс үзэхэд Хүн төрөлхтний Генийн санд хүний амьдралын хоёр хэлбэр болох нарийн ертөнцийн (сүнс) болон бодит ертөнцийн (бие махбодь) хэлбэрүүд нь нэгдмэл байдлаар оршдог.

Бараг бүх ном сударт Хүн төрөлхтний Генийн санг газар доор буюу агуйд эсвэл пирамидуудад байдаг гэжээ. Түүгээр ч үл барам лам, гуру болон Онцгой хүмүүс бүгд л самади-агуинуудыг Төвд Гималайн бүс нутагт байрладаг гэдэг. Яагаад чухам тэнд гэж? Энэ асуултны хариуг бид Е.П.Блаватскаягийн номонд

Вараг дэлхийн бөмбөрцгийн туйлд бүтээсэн гэж бичсэнээс олсон юм. Тэрээр мөн Түвд Гималайн бүс нутаг нь галав юүлэхээс өмнө дэлхийн Хойд туйл болдог байсан ба дэлхийн тэнхлэг өөрчлөгдсөний улмаас шилжсэн гэжээ.

Гэвч хүн төрөлхтний Генийн сан нь дэлхийн бөмбөрцгийн бусад өнцөгт ч мөн байрладаг бололтой. Бид маш олон хэзээ нэгэн цагт шалгууштай нэмэлт мэдээлэл их цуглуулсан.

Бидний мэдэж буйгаар самадийн зайлшгүй шаардлагатай нэг нөхцөл нь +4 хэмийн дулаан юм. Энэ нь агуй, усны гүн болон пирамидуудын доторх дулааны хэм юм. Тиймээс самадийн байдалд буй хүмүүс агуйнаас гадна пирамид болон усан доорх агуй маягийн нүхэнд байх боломжтой.

Пирамидуудыг самадид буй хүмүүсийг хадгалах зориулалттай тухай шууд биш ч баримт олж болно. Е.П.Блаватская пирамидуудын доорх байгууламжинд гурав, дөрөв, тав дахь иргэншлийн хүмүүс байдаг гэж бичсэн байдаг.

Гэвч усны гүний давхаргуудын хувьд иймэрхүү мэдээлэл байхгүй ч, лемурчууд, атлантчуудыг хагас усны амьдралтай байсныг тооцон үзвэл усны самади ч мөн байх ёстой.

Бидний дээр бичсэнчлэн Хүн төрөлхтний Генийн сан нь лемурын, атлантын, болон манай иргэншлийн гэсэн сүүлчийн гурван иргэншлийн хүнийг багтаасан байдаг. Е.П.Блаватская гурав дөрөв тав дах иргэншлийн хүмүүс газар доорх оромжинд амьдарсаар буй гэж шууд заасан байдаг. Зарим хүн Хүн төрөлхтний Генийн сангийн гол бүрэлдэхүүн нь атлантчууд ба манай иргэншлийн хүн маш цөөхөн байдаг гэж үздэг.

Атлантчууд Хүн төрөлхтний Генийн сангийн гол бүрэлдэхүүн нь болдог гэсэн үзэл нь арай магадлал ихтэй. Монетар мөчлөгөөр бол атлантчууд сэтгэлийн өндөр хөгжлийн түвшинд байсан бөгөөд гүн самадийн байдалд харьцангуй хялбархан орж чадахуйц байжээ. Атлантчуудын байнга явуулдаг байсан дайн нь дэлхийг хамарсан их гамшгийн урьдчилгаа болсноор Хүн төрөлхтний Генийн санг дүүргэх хэрэгцээг идэвхжүүлсэн биз.

Миний бодлоор манай соёл иргэншлийн хүмүүсийг сэтгэл оюуны хөгжил багатайгаар нь далимдуулж Хүн төрөлхтний Генийн санд ороход тохиромжгүй гэж үзэх нь буруу юм. Манай иргэншилд ч мөн сэтгэлийн өндөр хүчин чадалтай, Гэгээрсэн хүн цөөнгүй байдаг. Энэтхэг, Балба, Төвд улсыг багтаасан манай дэлхийн нэгэн хэсэг нь бясалгалын сургууль, самади, ёгын сургууль г.м. хачин зүйлийн тусламжтайгаар хүний сэтгэл оюуныг шүтэн бишрүүлж хөгжүүлдэгээрээ манай иргэншлийн сэтгэл оюуны төв болжээ. Эдгээр улс орон бодит эд баялгийг үл хайхран сэтгэл оюуны хөгжлийг өндөрт мандуулж сүүлийн илгээлт болох "SoHm"-ын зарчмын дагуу сэтгэлийн энергиэ өөрөө хөгжүүлэх ёстойг ямагт сануулан, ирээдүйд Хүн төрөлхтний Генийн санг манай иргэншлийн хүмүүсээр дүүргэх зорилго агуулдаг бололтой.

Хүн төрөлхтний Генийн сангийн бүрэлдэхүүн болсон лемурчууд нь гол зангилаа үүргийг гүйцэтгэдэг. Юуны түрүүнд энэ хүмүүс илүү өндөр хөгжилтэй болохоороо газар дэлхий дээрх амьдралыг ухаалгаар чиглүүлэн залах хүн төрөлхтнийг дахин үүсгэх чадвартай. Лемурчууд нь бодитжих болон эс бодитжих чадвартай учир газар дэлхий дээрх амьдралын нөхцөл байдал тохиромжгүй үед “газрын доорх оромжин”-доо буцаж орж, буцаж гарч ирэх чадалтай.

## **Самади – агуй дахь сэтгэлийн энергийн саад**

чулуун саадыг давдаг байсан бөгөөд Хүн төрөлхтний Генийн сангийн лемурын хэсэг нь далд буюу чулуун хавтангийн цаана байх ёстой.

Хүн төрөлхтний Генийн сангийн лемурын хэсэг нь Генийн санг Шамбалын оронтой холбодог. Өөрөөр хэлбэл самадид буй чулуун-хөшингө лемурчууд телепати холбооны журмаар өндөр хөгжилтэй Шамбалын орны лемурчуудтай харьцдаг байна. Гэвч энэ тухай хожим жич ярья.

Чухам лемурчууд л Хүн төрөлхтний Генийн санг тэргүүлж удирддаг байх. Самади-агуйд орох эсэх зөвшөөрлийг өгдөг лам нарын “Тэр” гэдэг нь лемурчууд бол уу.

Миний бодлоор Хүн төрөлхтний Генийн сангийн лемурчууд нь илүү хөгжилтэй соёл иргэншлийн (манай соёл иргэншилээс мянга дахин хөгжилтэй) бүтээгдэхүүн болдгоороо Генийн сангийн үнэт хэсэг юм. Тийм ч учраас тэд манай иргэншлийн хүмүүс болон атлантчуудын хүчин чармайлт үр дүнгээ өгөөгүй үед хамгийн сүүлчийн найдвар болон оршдог. Үүний жишээ нь 18013 жилийн өмнө Бумба Будда залран ирсэн явдал юм.

Зурагт үзүүлсэнчлэн Генийн сангийн лемурчуудын бие нь хагас усны амьдралд бүрэн дасан зохицсон шинжтэй тул манай гаригийн дийлэнх хэсэг нь усан бүрхүүлтэй болсон тохиолдолд л газар дэлхий дээрхи амьдралыг дахин үүсгэхээр уригдах болно.

Хүн төрөлхтний Генийн сангийн атлантчууд нь хагас усны амьдралд дасан зохицсоныхоо хувьд мөн л дэлхийн гадаргуу усанд автсан тохиолдолд залрах боломжтой. Зурагнаас үзэхэд тэдний бие нь лемурчуудын шинж чанарыг агуулсан боловч хуурай газрын амьдралд илүү дасан зохицсон байжээ. Гэвч атлантчуудын соёл иргэншлийн хөгжлийн дутмаг байдал нь тэдний хүн төрөлхтнийг дахин сэргээх оролдлогыг удаа дараа бүтэлгүйтүүлснээр Лемурын мөхлийн дараа атлантын соёл иргэншил дөнгөж үүсэх үед Бурхны Хүүдүүдийн тусламж шаардлагатай болсон шиг л лемурчуудийн тусламж зайлшгүй хэрэгтэй болоход хүрсэн байна. Үүний л нэгэн адил манай соёл иргэншил буюу арийн соёл иргэншил үүсэх үед атлантчууд болон арийн гэгээнтнүүдийн зэрлэгшлийн түүхэн

хүчин зүйлтэй тэмцэх олон арван бүтэлгүй оролдогын дараа Бумба Будда (лемур) нь чиглүүлэгч үүргийг гүйцэтгэснийг эргэн санаж болно.

Сүүлчийн зуунуудыг шинжлэхэд аричуудын сэтгэл оюуны хөгжил дээшилж олноороо Хүн төрөлхтний Генийн санд орох боломжтой болжээ. Үүний нотолгоо нь сүүлийн хэдэн зууны турш гүн самадид орсон хэдэн хүний тухай лам, гуру нарын өгсөн (Мозе Дзял Дзян болон бусад) баримт мэдээлэл юм.

Гэвч аричууд нь газрын амьдралд илүү дасан зохицсон болохоор цэвэр хуурай газрын амьдралын нөхцөлд (элсэн цөл зэрэг) гэгээнтний үүргийг гүйцэтгэхэд нэн тохиромжтой. Газар дэлхийн хуурай уур амьсгалтай нөхцөлд ч мөн ижил юм.

Ийм маягаар хүн төрөлхтний Генийн сан нь дараах бүтэцтэй гэсэн урьдчилсан дүгнэлтэнд хүрсэн юм:

- хожуу үеийн лемурчууд (лемуро-атлантчууд),
- атлантчууд,
- аричууд (манай иргэншлийн хүмүүс)

Бидний дээр хэлсэнчлэн Хүн төрөлхтний Генийн сан нь агуй, пирамид, усны гүнд байрладаг. Одоохондоо Генийн сангийн голлох байрлалын хувьд самади-агуйнуудын талаар л дэлгэрэнгүй ярьж болохоор байна.

Энэ нь, бидний бодлоор бол гурван төрөл байдаг:

1. Зөвхөн өмнөх иргэншлийн хүмүүстэй самади-агуй:
  - лемурын самади-агуй,
  - атлантын самади-агуй,
  - лемуро-атлантын холимог самади-агуй

2. Зөвхөн манай иргэншлийн хүмүүстэй самади-агуй (арийн самади-агуй).

3. Холимог самади-агуй (лемуро-атлант-арийн самади-агуй).

Самади-агуйн сүүлчийн төрөл нь газар дэлхий дээрх амьдралын нөхцөл байдлын дагуу Генийн сангийн төлөөлөгчдийг зохицуулж болдгоороо илүү давуу талтай мэт.

Хоёр дахь төрлийн самади-агуй нь удаан насгүй. Учир нь сэтгэлийн энергийн саад байдаг эсэх нь маргаантай юм. Лам нар аричууд нь лемурчууд болон атлантын үүсгэсэн сэтгэлийн энергийн саадыг даван тэдний агуйд самадид орохыг хичээдэг гэж бидэнд хэлсэн.

Хүн төрөлхтний Генийн сангийн газар доорх ертөнц нь сэтгэлийн энергийн саадаар хамгаалуулсан байдаг. Хэрэв энэ саад үгүйсэн бол Генийн санд гадны хүн ороход тээглэх зүйлгүй байхсан бизээ. Генийн санд гадны хүн орох нь муу санаа зорилго болон хязгааргүй сониуч занг дагуулаад зогсохгүй тэр хүмүүсийн торсын орны улмаас самадийн байдал тэнцвэрээ алдах аюултай.

Сэтгэлийн энергийн саадыг бид зайны ховсын үйлчилгээгээр тайлбарлахыг оролдсон. Гэвч самадид буй бодисын солилцоогоо тэгтэй тэнцүүлсэн хүний тархинд хэрхэн ийм хүчтэй сэтгэц нөлөөлөл үүсч байна вэ гэсэн асуулт зүй ёсоор

гарч ирнэ. Энэ асуултанд Нарийн ертөнц дэх амьдрал нь энергийн хүчин чадалгүйгээр явагдаж болно гэж үү? гэсэн асуултаар хариулж болно гэж би бодож байна. Мэдээж үгүй. Харамсалтай нь нарийн ертөнцийн энергийг эрдэмтэд маш бага судалсан бөгөөд түүний тухай төсөөлөл маш бүдэг бадаг, нууцлаг мэт санагддаг. Гэвч уг энергийн илрэлийг бид өдөр тутамын амьдралдаа ашигладаг төдийгүй Төвд анагаах ухааны нэр томъёо болон хэт мэдрэмжийн үйлчлэл, энергийн вампир, энергийг тэтгэгч, улс орны дээрх эерэг болон сөрөг бүрхүүл гэх мэт зүйлстэй тулгардаг.


Түүнээс гадна өмнөх иргэншлийн хүмүүсийн амьдралаас харахад тэд ихэвчлэн дээр дурдсан гэлэнгийн хэлсэнчлэн, бодит ертөнцөөс хамаагүй өндөр хүчин чадалтай нарийн ертөнцийн энергийг ашигладаг нь тодорхой. Үүнээс үзэхэд самади-агуйнуудын сэтгэлийн энергийн саад нь нарийн ертөнцийн энергийн үйлчлэл болох нь.

Иймэрхүү үзэгдлийг сонирхон судалдаг Уфа хотын Марат Фатхлисламов гэдэг хvн самади-агуйн бүсэд транс үедээ асури гэгчийг харсан гээд, ёгууд энэ талаар ямар санаа бодолтой байдаг талаар ярьсан юм. Эдгээр асури гэгч нь сүүлтэй шанаганцарын төрхтэй нарийн ертөнцийн хамгаалагч хэсэг гэнэ. Гадны хүн ирмэгц эдгээр асури нь идэвхжин орж ирсэн хүний энергийг сорж, айдас, түгшүүр, ундууцал, толгойн өвчин болон бие сулралыг үүсгэдэг. Онцгой хүмүүс нь бясалгалын аргаар асуритай холбоо тогтоодог. Тийм ч учраас дорны шашны бүх эх сурвалжид (тэр дундаа Лувсандамбын бүтээлд) Гэгээрэгсдээс өөр хэн ч самадийн байдалд буй хүмүүсийг харах боломжгүй тухай бичсэн байдаг. Сүнсний энерги болон нарийн ертөнцийн энерги нь үүнд саад болдог .

Гэсэн ч самади-агуйн сэтгэлийн энергийн саадыг нарийн ертөнц үүсгэдэг гэж бид хичнээн яригч уг энергийг самадийн энэ бүс нутагт чиглүүлдэг хэн нэгэн хүн байх ёстой. Тэгвэл энэ хэн нэгэн тэгээд хэн юм бэ? Энэ асуултанд хоёр янзаар хариулж болно:

- Уг саадыг самадийн байдалд буй хүмүүсийн сэтгэлийн энерги үүсгэдэг.
- Уг саадыг Шамбалын орон үүсгэдэг.

Эхний хувилбарын зүй тогтолыг шүүн үзэхдээ лам свами нартай гүн самадийн үйл явцын талаар хүүрнэснээ эргэн санацаагай. Гүн самадид буй хүний сүнс нь Нөгөө Ертөнцөд байдаг бөгөөд бие махбодтойгоо “Мөнгөн утас”-аар холбоотой байдаг. Нөгөө Ертөнцийн долгионы шинжтэй амьдрал нь уг “мөнгөн утас”-аар газарт буун самади-агуйн бүсэд нөлөө үзүүлдэг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл самадид буй хүний сүнс нь “Мөнгөн утас” хэмээгч уг сувгаар өөрийн биеийг болон эргэн тойрноо хянаж, самади-агуйд ирсэн “урилгагүй зочдод” энергийн үйлчлэл үзүүлдэг. Е.П.Блаватская “самади-агуйг дайчин сүнснүүд хамгаалдаг...” гэж бичиж байсан нь учиртай. Тэрээр гүн самадийн байдалд буй хүн болгон өөрийн сүнсний тусламжтайгаар саад босгодог гэж хэлсэн байж болзошгүй.



Сэтгэлийн энергийн саад толгор (зохиогчийн зураг)

Самадид буй хүний сүнс Нөгөө Ертөнцөд буюу Нөгөө Ертөнцийн долгион хэлбэрийн амьдрал оршдог орон зай цаг хугацааны өөр хэмжүүрт байдаг. “Мөнгөн утас” нь самадид буй хүний онцлог бөгөөд үүгээрээ тэрээр нас нөгцсөн хүнээс ялгагдана. Уг “мөнгөн утасны” тусламжтайгаар сүнс нь хадгалагдан буй биеэ эргэн олж, биендээ эргэн шингэж, газар дэлхийн амьдралд оруулдаг. Гэвч байгаль дэлхийн хуулиар хүний биений өчүүхэн жижиг эд эрхтнээс эхлэн долгионы бүтэц болох сэтгэл хүртэл хэзээ ч дан ганц үүрэгтэй байдаггүй. Тийм ч учраас “мөнгөн утас” нь мөн л сүнсийг бие махбодтой нь холбох болон Нөгөө Ертөнцийн энергийн хүчээр бие махбодио хамгаалах гэсэн хоёр үүрэгтэй байх нь.

Самади-агуйн сэтгэлийн энергийн саадыг Шамбалын орон үүсгэдэггүй гэж үгүйсгэж болохгүй. Бодитжих, эс бодитжих үзэгдлийг ашигладаг лемурчуудын газар доорх амьдралын үндсэн хэлбэр болохынхоо хувьд Шамбалын орон нь газар дэлхийн амьдралын хамгийн ариун хэсгийг хамгаалах үүрэгтэй. Хамгийн ариун хэсэг нь газар дэлхийн гурван соёл иргэншлийн төлөөлөгчдийг хадгалж, өнгөрсөн одоо ирээдүйн мөнхийн баталгаа болдог Хүн төрөлхтний Генийн сан юм. Тийм ч учраас газар доорх Шамбалын хаант улс нь дайн дажин, салхи шуургаас хэдэн зуун метр газрын гадаргуугаар тусгаарлагдсан газар доорх Хүн төрөлхтний Генийн санг хянаж байдаг байна.

Ямартаа ч Нөгөө Ертөнцөд бус харин дэлхий дээр амьдардаг Шамбалын орны оршин суугчид нь самадид буй хүмүүсийн сүнсийг залж, самади-агуйн сэтгэлийн энергэн саадыг улам боловсронгуй, хүчирхэг болгох чадвартай. Мөн Шамбалын орон нь самади агуйн саадыг босгох, бэхжүүлэхэд энергийн түвшнээрээ оролцдог байх магадлалтай.

Ямар энергийн тусламжтайгаар, мөн мэдээллийн ямар эх үүсвэрээр Шамбалын орон самади агуйн хамгаалалтанд оролцдог юм бэ? Гэвч үүнийг нууцлаг Шамбалын орон болон Агартын орны тухай авч үзэх дараачийн бүлэгтээ дэлгэрэнгүй ярилцъя.

Бид дээр бичсэнчлэн самади- агуйн сэтгэлийн энергэн саад нь орж ирсэн “зочны” бие махбодид аажмаар сөрөг нөлөө үзүүлэн үйлчилдэг. Уг үйлчлэлийн эцсийн үе шат нь үхэл. Хамгийн эхэнд хүнд өвдөлт үүсгэхгүйгээр үргээх зорилготой айдсын мэдрэмж төрүүлнэ. Хүнийг ариун агуйг орхиход хүргэдэг хоёр дахь мэдрэмж нь уур ундууцал юм. Зөвхөн эдгээрийн дараа л бодит мэдрэмжүүд болох толгойн өвдөлт, бие сулралт тэгээд үхэл гэсэн мэдрэмж энэ дарааллын дагуу үүсдэг.

Сэтгэлийн энергийн нөлөөллийн бүхий л үйл явц нь чиний сониуч зан ямар ч үнэ цэнэгүй ариунаас ариун Хүн төрөлхтний Генийн санд нэвтэрч байгаа тул зайлшгүй үхэл рүү бүү яв гэсэн сануулга маягаар үйлчилдэг.

Самади-агуйн сэтгэлийн энергийн саад нь уг чанартаа тийшээ явж болохгүй гэж дөрвөнтээ сануулж буй сайн энергийн илрэл юм. Тэгээд хэрэгт дуртай сониуч зангийн эцсийн шийтгэл болж, эцэст нь үхэл хүлээж байдаг. Учир нь уг зочны

сониуч зан нь Хүн төрөлхтний Генийн сангийн үүрэгтэй харьцуулахын аргагүй өчүүхэн зүйл.

Онцгой хүмүүсийн “Тэр” гэгч л энэ сонинч занг хангах эсэхийг шийддэг. “Тэр” гэгч чухам хэн болохыг хэлэхэд хэцүү! Миний бодлоор “Тэр” гэгч нь Шамбалын орны хүн байх магадлалтай. Гэвч энэ тухай дараачийн бүлэгтээ өгүүлэе.

## Нууцлаг адептууд

Адептууд гэгчийн тухай Дорны шашин, ном зохиолд маш олон мэдээ баримт байдаг. Адептууд гэж хэн бэ? Ном зохиолуудыг шинжилж байх эхэн үедээ би үүнийг ойлгодоггүй байв. Зарим нь адептууд гэж Дорнын ариун сэтгэлт урт настнуудыг хэлж байхад зарим нь гүн самадийн байдалд буй хүмүүсийг хэлж байлаа. Нэлээд хожуу самадид орох чадвартай хүнийг адепт гэдгийг би ойлгосон юм. Энэ нь хоёр төрлийн самадийг нэгтгэсэн ойлголт аж. Үүнд:

- Самадийн байдалд буй хүний сүнс Нөгөө Ертөнцтэй харьцаж бие махбоди нь сүнстэй харьцаа холбоогоо таслахгүйгээр чулуун - хөшүүн байдалд ордог жирийн гүн самади.

- Самадид буй хүмүүсийн Сүнс нь Нөгөө Ертөнцтэй харьцсан ч бие нь бодит ертөнцөд үйл ажиллагаагаа явуулсаар байх самади буюу сахаджа-самади.

Урьд өмнө бидний тэмдэглэж байснаар самадийн эхний хэлбэр нь хэдэн мянга, сая жилээр үргэлжилж болно. Самадийн хоёр дахь хэлбэр нь хэдэн зуу, мянган жилээр үргэлжилж болно гэж бидний олж үзсэн баримт мэдээлэлд дурьдсан байна. Өөрөөр хэлбэл хоёр дахь хэлбэрийн самадид оршигч хүмүүс бол 300, 400, 1000, 2000 жил амьдарч буй даяанч нар юм.

Хэрвээ хүн эхний хэлбэрийн самадид орсон бол бие нь үүрд мөнх амьдарна гэдэгт итгэж болох юм. Гэвч хоёр дахь хэлбэрийн самадид байдаг хүмүүсийн талаар мөн цөөнгүй баримт байна. Жишээ нь Балбад 3 жил гаруй амьдарсан Л.В.Печуров (Москва) захиандаа нутгийн ардуудын яриагаар бол 100, 200, 300 жил амьдарч буй хэд хэдэн даяанчыг дүрслэн бичжээ. Энэ хүмүүс уулын тэсгим хүйтэнд ч нимгэн хувцастай байсан нь уг захианы эзнийг гайхшруулжээ. Тэрээр онцгойлон нэгэн адепт эмэгтэйг дүрсэлсэн байсан. Уг эмэгтэйн гадаад төрхнөөс үзвэл 35-аас илүүгүй настай болов уу гэмээр бөгөөд ихэнх хугацаагаа дугана дотор барын арьсан дээр Буддын завилгаагаар сууж өнгөрөөдөг. Тэрээр бараг хоол унд хэрэглэдэггүй, зөвхөн ногоо идэж, тэр дундаа сама хэмээгч ургамлыг байнга хэрэглэдэг байжээ. Нутгийн ардууд түүнийг 300 гаруй жилийн настай гэж ярьцгаадаг гэнэ.

Адептын бас нэгэн жишээ бол Энэтхэгт алдартай Бабаджи юм. Түүнийг гаднаас нь харахад 17 настай л болов уу гэмээр боловч үнэн хэрэгтээ 1700 жил амьдарч буй гэж ярьцгаадаг байна.



Адептуудын дунд хоёр дахь хэлбэрийн самадигаас нэгдүгээр хэлбэрийн самадид шилжих болон эргэн шилжих үзэгдэл байдаг. Энэ номны гурав дахь хэсэгт дүрсэлсэн (10-р бүлэг) 300 жил амьдарч буй хүн нь эхэндээ газар дэлхийн амьдарлаар амьдарч байснаа сүүлдээ ихэнх цагийг агуйд самадийн байдалд өнгөрүүлдэг болжээ. Адептудыг ч мөн Хүн төрөлхтний Генийн сангийн нэгэн онцлог хэсэг гэж үзэж болно. Тэд хүн төрөлхтний Генийн сангаас гарч хэсэг хугацаанд хүмүүсийн дунд амьдраад эргэн Генийн сандаа нэгддэг байж болно.

Адептууд ямар үүрэгтэй вэ? Тэд хүн төрөлхтөнд нөлөөлөх нь үлэмж бага учир тэднийг Гэгээнтэн гэж нэрлэж болохгүй юм. Адептууд хэмээн зөвхөн манай иргэншлийн хүмүүсийг дүрсэлсэн байдаг. Атлантчууд ч юм уу, лемурчуудтай төстэй гадаад төрхтэй хүмүүс адептуудын дунд огт дүрслэгдээгүй байна. Адептууд нь өнөө үед газар дэлхий дээр амьдарч байгаа хүн төрөлхтөн болон Хүн төрөлхтний Генийн санг хооронд нь холбох үүргийг гүйцэтгэдэг байж болзошгүй.

**Сэдвээсээ бага зэрэг  
хазайн адепт, урт  
наслалт болон  
хавдраар  
өвчлөгсдийн талаар  
хийсэн зарим нэгэн  
эргэцүүлэл**

Самадийн эхний болон хоёр дахь хэлбэр хоорондоо шилждэг нь аль ч тохиолдолд урт наслалтын үйл явц нь ижил төстэй гэдгийг харуулж байна. Үүнд бодисын солилцоогоо тэгтэй тэнцүүлж биеийг чулуун–хөшингө байдалд оруулах хүчин зүйлсээс гадна мөн хөгшрөлтийн явцыг удаашруулах амин орны онцгой байдал ч чухал ач холбогдолтой бололтой. Гэвч хүний биеийн эс нь амьдралын нарийн мөчлөгт захирагддаг нь шинжлэх ухаанаар батлагдсан зүйл. Тийм ч учраас биеийн эсүүдийн амьдралын мөчлөг олон дахин нэмэгдэн уртасдаг гэж төсөөлөхөд бэрх. Тэгвэл үүнийг хэрхэн тайлбарлах вэ?

Манай нөхөн суулгавар эд буюу аллоплант нь хүний биеийн эдийн төлжилтийг нэмэгдүүлэн, ургаж буй эсүүдийн амин орон нь эмгэг төлжилтийг дарангуйлж, өвчтэй эсийн үйл ажиллагааг засах чадвартай гэж дээр дурьдсан билээ.

Адептуудын урт наслалтын үндэс нь ч мөн иймэрхүү үйл явц байдаг болов уу гэж би бодож байна. Тодруулбал адептууд бясалгалын аргаар эмгэг хөгжлийг зогсоож, өвчтэй эсүүдийн үйл ажиллагааг эрүүлжүүлж, биеийн эсүүдийн нөхөн төлжилтийг идэвхжүүлдэг амин орныг онцгой төлөвт хүргэдэг. Өөрөөр хэлбэл адептуудын урт наслалтын нууц нь эсийн амьдралын мөчлөгийг нэмэгдүүлэхэд бус харин үхсэн эсүүдийг шинээр солих болон тэднийг хавдрын эс болон хувьсахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Ахимаг настай хүмүүсийн үхлийн гол шалтгаан нь амьдралын мөчлөгөө дуусгаж буй эсүүд хавдрын эс болж хувьсах явдал байдаг. Өтөлж буй эсүүд хавдрын эс болон хувьсахаас сэргийлж, хөгширсөн эсүүдийг шинэ эрүүл эсээр

солих үйл явцыг хангаж, эрүүл эсийн нөхөн төлжилтийг амин орноороо идэвхжүүлж чадах юм бол хүний бие махбодийг залуугаар нь хэдэн зуу, хэдэн мянган жилээр нь хадгалж нөхөн сэргээх боломжтой болох мэт.

Гэвч хөгжил өндөртэй эсүүдэд (тархи, торлог бүрхэвч, зүрхний булчин зэргийн эсэд) нөхөн төлжилт явагддаггүй бөгөөд зөвхөн эсийн амьдралын мөчлөгийн туршид үйл ажиллагаагаа явуулдаг.

Энэ зөв үү? Сүүлийн үеийн судалгаагаар (La Vail, Factorovich, 1991) торлог бүрхэвчийн эсүүд гэх мэт өндөр түвшинд ялгаран хөгжсөн эсүүд хүртэл фибробластын өсөлтийн хүчин зүйлийн үйлчлэл доор нөхөн төлжих чадвартай байдаг нь батлагдаад байна. Энэ хүчин зүйлийг нөхөн төлжиж буй эсүүд ялгаруулдаг. Нөхөн төлжиж буй эсүүд шүү! Үүнээс үзэхэд аль нэгэн эсийг нөхөн төлжихөд хүргэж чадах юм бол химийн урвалын тусламжтайгаар бусад эсийг тэр дундаа өндөр түвшинд ялгаран хөгжсөн эсийг хүртэл нөхөн төлжилтэнд оруулж болдог байна.

Хэрвээ өндөр хэмжээнд ялгаран хөгжсөн эсүүдийг нөхөн төлжүүлж болдог бол хүний биеийн эсүүдийг байнга шинэчлэх үйл явц боломжтой болно. Энэ нь мөнхийн залуу нас болон урт удаан амьдралд хүргэх арга зам юм.

Бие махбодийн эд эсийг шинэчлэх байнгын цогц үйл явцыг хэрхэн ажиллуулах вэ? Энгийн хүмүүс үүнийг ашиглаж болох уу? Шинжлэх ухаан удахгүй үүнийг хэрэгжүүлэх байх. Харин одоогоор хүний бие махбодийн идэвхит цэгүүдэд аллоплантыг суулгах нь ихээхэн найдвар төрүүлж буй юм. Эрүүл эсүүдийн нөхөн төлжилтийг идэвхжүүлэх нь хүний амин оронд эерэгээр нөлөөлж эсүүдийн шинэчлэгдэх үйл явцыг үүсгэх ёстой. Түүнчлэн өсөж буй залуу махбодийн амин орны хүрээлэлд оруулах нь ихээхэн ирээдүйтэй. Энэ талын туршилт шинжилгээг хэдийнээ хийж эхэлжээ.

## Агуй болон пирамид

Самадид орход ямар агуй тохиромжтой вэ? П.Нилаям (1993 он) Гуфа-ашрамыг дүрслэхдээ самади-агуй нь хуурай байх ёстой гэж бичсэн байдаг. Дарам хамба самади-агуй нь өндөр ууланд мөнх цасны зааг дээр байх ёстой гэж заасан. Бумба лам самади-агуй нь гадны хүний нүднээс далд байдаг гэж ярьсан.

Дэлхийд маш олон агуй байдаг. Гэвч зарим нэгэн агуй нь самадид ороход онцгой тохиромжтой байдаг. Марат Фатхлисламовын нотолж байгаагаар Энэтхэгийн Бадринат хотын ойролцоо “Ёгуудын бүхэл бүтэн улс орон” байдаг. Тус газраас холгүй “Вишнугийн мөр” буюу аварга том хавтгай хөлт хүний хөлийн мөр байдаг аж.

Их Гэгээрсэн Лувсандамбын бичсэнээр бол самади-агуйнууд нь голчлон Төвд, Гималай, Египет, Өмнөд Америк болон Сибирийн зарим газарт төвлөрсөн байдаг. Тэрээр ихэнх сүм дуган самади-агуйнуудын дээр баригдсан гэж бас бичжээ.

Пирамидууд ч ялгаагүй Хүн төрөлхтний Генийн сангийн байр болох талаар олон мэдээ баримт байдаг. Энэ тухай Энэтхэгийн свами болон төвд лам нар ярьж байсан. Е.П. Блаватская 3, 4, 5 дахь иргэншлийн адептууд пирамид маягийн байгууламжийн доор оршдог гэж бичжээ.

Хэт авианы төхөөрөмжийн тусламжтайгаар пирамидуудын доор үнэхээр хөндий орон зай байгааг тогтоосон. Пирамидууд нь тэдний доорх хөндийд байрласан Хүн төрөлхтний Генийн санг илэрхийлэгч болдог юм биш биз?

Үүнийг огтхон ч үгүйсгэх боломжгүй. Ямартаа ч пирамид нь Хүн төрөлхтний Генийн санг хадгалагчийн үүрэг гүйцэтгэдэг гэсэн таамаг нь пирамидыг фараонуудын бунхан эсвэл гариг эрхсийн байгууламжийн үүрэгтэй гэсэн таамгаас хамаагүй хүндлүүштэй юм. Жишээ нь Хеопсийн пирамидын 50 тонны жинтэй чулуун хавтангуудыг орчин үеийн ямар ч техник дааж дийлэхгүй байгаа билээ. Барилга байгууламжуудын аварга том хэлбэр хэмжээ нь түүнийг байгуулах зорилгын агуу эсэхийг илэрхийлдэг. Тэгвэл Хүн төрөлхтний Генийн сангаас илүү агуу зорилт гэж юу байхсан билээ.

Е.П.Блаватскаягийн үзэж байгаагаар египетийн пирамидууд 75-80 мянган жилийн настай, харин цацраг идэвхит нүүрстөрөгчийн шинжилгээгээр бол тэдгээр нь 4-5 мянган жилийн настай юм. Хэрвээ Е.П.Блаватскаягийн заасан хугацаанд итгэх юм бол египетийн пирамидуудыг Платоны арлын атлантчууд сэтгэлийн энергийг ашиглан барьсан болж таарч байна (Нострадамус атлантчуудыг “билгийн нүд”-нийхээ тусламжтайгаар чиглүүлсэн энергээр таталцлын хүчинд үйлчилж пирамидуудыг барьсан хэмээн бичсэнийг санацгаая). Платоны арлын атлантчууд египетийн соёл иргэншилтэй нягт холбоотой байсан нь тодорхой.

11 мянган жилийн өмнө Платоны арлын атлантчууд Тифоны солирын улмаас мөхөхөд нууцлаг оккульт шинжлэх ухаан нь гүн гүнзгий нууцын хөшигний цаана орсон юм. Үүнийг сансрын гамшгаас болж Хүн төрөлхтөн хүнд хэцүү байдалд орсноор Хүн төрөлхтний Генийн санг нууцалсан гэж тайлбарлаж болох уу? Үгүйсгэх аргагүй л юм.

Пирамидын дотор хүмүүс хялбархан олоод үзчих египетийн фараон буй нь пирамидын доор байрласан гол нууцаас хүмүүсийн анхаарлыг холдуулан нууцлах санаа байсан бололтой.

Платоны арлын атлантчууд гариг эрхсийн хөдөлгөөнийг ажиглаж байсан бөгөөд сансрын гамшгийн улмаас мөхнө гэдгээ урьдчилан мэдэж байжээ. Тийм ч учраас газар доорхи сүмд тус иргэншлийн төлөөлөгчид самадийн байдалд орон нуугдаж болохуйц асар том байгууламж -пирамидуудыг барих ажлаа урьдчилан эхэлсэн байна. Үүнээс үзэхэд пирамид доороос (египетийн, магадгүй мексикийн) самадийн байдалтай Платоны арлын атлантчуудыг (өөрөөр хэлбэл их үерээс газар дэлхий дээр үлдсэн сүүлийн атлантчууд) олж болох юм.

Гэвч энэ таамаглал нэг сул талтай. Газар доорх сүмүүд рүү ордог үүд нь битүү хаалттай эсвэл гүнээс гүнд газрын доор байгаа. Тэгвэл атлантчууд хэрхэн

тэндээсээ гарах вэ? Энэ асуултанд өмнөх иргэншлийн хүмүүсийн талаар лам нарын хэлсэн “Чулуу тэдний хувьд саад биш юм!” гэсэн үгээр хариулмаар байна. Үнэхээр ч таталцлын хүчинд нөлөөлөх сэтгэлийн энергийн үйлчлэл нь (Нострадамусын хэлснээр пирамид хэрхэн баригдсаныг санацгаая!) бидний хувьд ойлгомжгүй өвөрмөц аргаар газар дэлхийн гадаргуу дээр гарах гарцыг нээж болох юм.

Египетийн фараон үнэхээр үхсэн байсан гэж үү? Тэр самадийн байдалд байсан юм болов уу? Ямартаа ч энэ таамгийг бүрэн үгүйсгэж болохгүй нь. Учир нь бунханаас нь гарган үзмэрийн танхимд байрлуулснаас хойш фараоны хатаамал бие (муми) нурж эхэлсэн юм. Хэрвээ бунханаас нь гаргахаас өмнө египетийн фараон самадийн байдалд байсан гэж үзэх юм бол дулааны хэм (+4 хэм нь ерөөний хэмээр солигдсон) алдагдах нь самадийн байдлаас үхэлд хүргэсэн гэж таамаглаж болох.

Эртний египетчүүд самадийн байдалд хиймэл аргаар орохыг оролддог байсан гэсэн таамаглалыг мөн үгүйсгэхийн аргагүй. Тэд самадийн талаар хөрш зэргэлдээ орших Платоны арлын атлантчуудаас мэддэг байсан төдийгүй пирамидын үүргийн талаар ч мэддэг байжээ. Гэвч тэдний хувьд гүн самадид ороход бэрхшээлтэй байсан бололтой. Хиймлээр (химийн бодисын тусламжтайгаар) самадийн байдалд орохыг оролдож, тэдний фараонууд эргэн амь орно гэж итгэцгээдэг байжээ. Тийм ч учраас тэдний хажууд ахуйн хэрэгслүүд болон үнэт эдлэлийг нь тавьдаг байсан байна.

Мэдээж бидний одоог хүртэл нууцыг нь тайлаагүй бие махбодийг тослох арга хэрэглэж байсан гэсэн ихэд түгсэн таамгийг ч мөн үгүйсгэх аргагүй.

Эдгээр таамгын аль нь зөв бэ? Энэ асуултанд хариулахад маш хэцүү. Самади онолын зарчмаар пирамидууд болон фараонуудын хатаамлыг судлах хэрэгтэй.

Энэ бүхний зэрэгцээ пирамид болон эртний байгууламжуудад маш хайр гамтай хандах шаардлагатай нь ойлгомжтой. Хеопсын пирамидын маш нарийхан орцуудын нэгэнд нь германы эрдэмтэн Рудольф Гантенбрикк дуран авайн төхөөрөмжөөр тоногдсон жижигхэн өөрөө явагчийг оруулжээ. Уг өөрөө явагч нь орцыг гэтлэн явсаар цаана нь амьд биет байна хэмээн таамаглаж буй нэгэн хаалганд тулж очжээ. Тэрээр өөрөө явагчийг нэвтлэгч туяагаар тоноглож өнөөх хаалганд нүх гарган нэвтлүүлэхийг оролдсон байна. Энэ хаалганы цаана самадийн байдалд байгаа өмнөх иргэншлийн хүн байгаа бол яана?

Сэтгэлийн энергийн саад нь уг нэвтлэгч туяанд нөлөөлөх нь юу л бол, харин самадийн тэнцвэр алдагдах болно. Бидний сониуч зан ийм үнэ цэнэтэй дүйцэх ёсгүй! Бидний сониуч хүслийг хангах гэж эртний хүн самадийн байдалд орж, хэдэн мянга, хэдэн сая жилийг өнгөрөөгөөгүй! Шинжлэх ухааны сониуч зан бол хөгжлийн хөдөлгүүр боловч бурханы бүтээлд механик гараар хүрэх эрх зөвхөн

Бурхдад буй. Харин эрдэмтэн хүн бурхан биш. Учир нь эртний хүн Хүн төрөлхтний Генийн сангийн төлөөлөгч байх хамгийн агуу эрхэм үүргийг хүлээн самадийн байдалд орсон юм.

## **Самади болон цаг хугацаа**

Пришанти Нилаям (“Сатья Саи ба Нара Нираяма Гуфа-ашрам”, 1993 он, 17-р хуудас) самади-агуйд самадигаас хэрхэн гарах, орохыг дүрслэн бичжээ. Тэрээр самадийн байдалд өнгөрүүлсэн 18 хоног нь 48 минут мэт өнгөрсөн хэмээн бичжээ.

Үүнээс энгийн тоо бодлогын үйлдлээр самадийн байдалд цаг хугацаа аль хир хурдан өнгөрдөгийг тооцон олж болно. Самадийн байдал дахь цаг хугацаа жирийн цаг хугацааны урсгалаас 717 дахин хурдан өнгөрдөг болж байна. Энэ нь Нөгөө Ертөнцийн оршин тогтнодог цаг хугацааны урсгал бололтой.

## **Самадид буй хүн юу мэдэрдэг вэ?**

Энэ асуултын хариуг Гэгээрэн самадид орох боломжтой болсон Лувсандамба үлэмж дэлгэрэнгүй дүрсэлсэн байдаг. Тэрээр лам нар түүнийг агуйд оруулан, агуйн нууц хонгилоор дагуулан явсан гэж бичжээ. Лам нар түүнд гурван аврага том хүний биеийг (2 эрэгтэй, 1 эмэгтэй) үзүүлжээ. Эмэгтэй нь гурван метр гаруй өндөр, эрчүүд нь таван метр гаруй өндөртэй байв. Тэд маш ер бусын өвөрмөц дүр төрхтэй бөгөөд үхсэн бус харин унтаж буй мэт сэтгэгдэл төрүүлж байлаа.

- Хүү минь, үүнийг хар,- гэж лам нарын нэг нь хэлээд,- тэд бидний энэ газар нутаг дээр амьдарч байсан юм (Түвдэд-Э.М.). Тэр үед уулс байгаагүй, тэнгэрт өөр одод гялалзаж, далайн ус эргээ даван хальж байсан цаг.

Дараа нь Лувсан Дамба самадид хэрхэн орсноо ийн дүрсэлжээ:

“...Би хэдэн жил сурсан амьсгалын дасгалаа хийж эхлэв. Нам гүм болж түнэр харанхуй сэтгэлийг дарангуйлна. Энэ бол жинхэнэ булшинд л байдаг анир чимээгүй байлаа. Гэнэтхэн бие хөвчрөн, бүх булчин чангарав. Хөшсөн үе мөч бүхэн хөрч эхэллээ. Би газрын гадаргаас 100 гаруй метрийн гүнд үхэж буй мэт сэтгэгдэл төрж байлаа. Аймшигт түс тас хийх чимээ шуугиан гарав.

Алгуурхан юм бүхэн хачин цэнхэр өнгөөр хүрээлэгдэж эхлэв. Би өөрийн бодит биеийнхээ дээр нисч байгаагаа мэдэрлээ. Яг л л утаа шиг дээш хөөрсөөр байлаа. Миний биеийн дотроос нэгэн цэнхэр мөнгөн утас гарч, амьд мэт чичирхийлэн хөдөлж гялалзсаар байв.

Би аврага биетнүүдийн биенээс холгүй хэвтэж буй өөрийн бие махбодио олж харлаа. Эрэг мөргөн шуугих далайн давалгааны чимээ аажим ойртож эхэллээ. Хүний дуу хоолой сонсогдоход би наранд борлосон хөгжилтэй аврагуудыг олж харлаа. Аваргууд! Тэд яг л нэг хүн шиг жигдхэн өндөр аврага том биетэй байлаа.

Хэсэг хугацааны дараа миний харж байсан эдгээр дүр зураг бүдгэрсээр алга боллоо. Нэгэн таагүй мэдрэмж төрж, маш их даарч буйгаа мэдрэхдээ л хүйтэн чулуун хавтан дээр хэвтэж буйгаа саналаа. Миний тархи эгээ л галзуу юм шиг ажилласаар байв. Өндийхдөө үе мөчөө хичнээн их хөшсөнийг мэдэрлээ. Өлссөнөөсөө болоод бие сулран ухаан алдах дөхөн чичирч байв.

- Чи энэ хавтан дээр гурван өдрийн турш хэвтлээ,- гэж ламтан хэллээ...”

Энд өөр зүйл нэмж нуруших нь илүүц бол уу.

Гуравдугаар хэсэг

## Шамбал болон Агарт

“Шамбалын орон” гэдэг үг нь ихэнх хүмүүст танил бөгөөд хүмүүс үүнийг ямар нэгэн нууцлаг учир битүүлэг зүйл хэмээн төсөөлдөг ч чухам яг юу боллох талаар гадарладаг ч үгүй. “Агартин орон”-ы талаар ямар нэгэн ойлголт байдаггүй. Гагцхүү Төвдийн эртний түүхийн мэргэжилтэн л дэлхий дээр “Шамбалын орон”-ы зэрэгцээ нууцлаг нэгэн “Агартин орон” байдаг гэж хэлж чадна.

### Шамбалын орны мөнхийн нууц

Би анх хэзээ хаана “Шамбалын орон” гэдэг үгийг сонссоноо ч санахгүй байна. Магадгүй оюутан байхдаа Алтайд очиж байсан аялагч залуустай ярилцахдаа л сонссон биз. Хожим би өөрөө Алтайд аялал хийж байхдаа аялагчдын жимийн хажууханд хадан дээр “Шамбалын орон” гэж бичсэнийг харж, “Шамбалын орныг” хайж байна гэх ойлгомжгүй сэтгэхүйтэй, хорвоогоос тасарсан мэт дүртэй хэсэг бүлэг хүмүүстэй таарч байлаа. Тэд мөнөөх л “Шамбалын орныг” эрж байсан Николай Рерихын замаар явж байгаагаа ярьцгаана.

Энэ хорвоогийн амьдралаас тасарсан мэт нэгэн залуу эр:

- Зөнчдийн урьдчилан хэлснээр бол Шамбалын орныг манай зууны сүүл үед л олно гэсэн. Энэ үнэн байх аа. Тэгээд л бид олохгүй байгаа юм, - хэмээн ярьж байсан нь тодхон.

Спортын аяллыг сонирхдог миний хувьд эдгээр Шамбалын хайгуулч нэг таагүй сэтгэгдэл төрүүлдэг байлаа. Тэд аяллын дэгийг сахидаггүй, бөөнөөрөө явж, даваа давах аргыг хүртэл мэддэггүй, чихэр юм уу, давсаа дуусахад хүнээс гуйдаг байсан юм. Тэр үед хожим би өөрөө Шамбалын орны хайгуулч болно гэж төсөөлсөн ч үгүй.

Николай Рерихын талаар би бүүр дээр сонссон бөгөөд аялагчийн хувьд түүнийг машинд хүндэлдэг байсан. Би Төвд, Гималай зэрэг сонирхолтой бүс нутгуудад хэд хэдэн хэцүү аялал зохион байгуулсан түүнд цагаахнаар атаархдаг ч миний эх орон нэгтэй гэдгээрээ бахархдаг байлаа. Хаалттай, коммунист дэглэмтэй орны уугуул иргэн болохын хувьд хилийн чанадад аялал хийнэ гэдэг нь нэг л үлгэрийн мэт бүтэшгүй зүйл санагддагаас Н.Рерих миний хувьд биелсэн бурхан аятай сэтгэгдэл төрүүлдэг байсан.

Н.Рерихын зохиолуудыг уншихыг хэдэн удаа оролдож үзсэн ч юу ч ойлгоогүйн улмаас үргэлж хойшлуулдаг байв. Түүний Шамбалын орон болон цэвэр ариун сэтгэлийн талаарх эргэцүүллийг миний тархи хүлээж авахгүй байсан бөгөөд миний сэтгэл зүрхэнд ойрхон төвдийн ууланд хийсэн аяллыг дүрсэлсэн спортын хэсэг нь уг номны үлэмж багахан хэсэг байсан юм.

Офтальмогеометрийг судалж эхлэх үедээ уг цэвэр тооны шинж чанартай шинжлэх ухаан мөн л Н.Рерих болон Шамбалын оронд хүргэнэ гэж би төсөөлөө ч үгүй нь ойлгомжтой. Төвд үндэстний “Статистикийн дундаж нүд” нь Алтай руу хийсэн аяллыг, Шамбалын орны хайгуулчид болох хорвоогоос тасархай хүмүүсийг өөрийн эрхгүй санагдуулж байв. Би Н.Рерихийн номыг дахиад уншиж эхлэв. Гэсэн ч мөн л юу ч ойлгосонгүй. Цэвэр сэтгэл, анхаарлаа эерэг (хайр, ухамсар) бодол санаанд төвлөрүүлэх, сөрөг бодол санааг (амиа бодох, шунахайрах г.м.) үгүйсгэх, бодитжих(биежих) эс бодитжих(сарних) чадвартай дээд төрөлтийн тухай бичсэн зүйлд нь сэтгэлийнхээ гүнд итгэж байсан учир би Рерихыг суут оюун ухаантай хүн гэдгийг хүлээн зөвшөөрч байсан юм. Рерихын ер бусын мэдлэгийн хүрээнд мушгиж ороолдуулан ёгт маягаар бичсэн зүйлс нь ойлгомжтой байдгийг цаагуураа би мэдэрч байлаа. Рерих нь бидний нээх эрхгүй, зөвхөн ертөнц оршин тогтнодог сэтгэл оюуны хүчин зүйлийг ойлгоход хүрэлцэхүйц хэмжээгээр бага зэрэг олж харах л эрхтэй Хүн төрөлхтийн агуу нууцын талаар бичсэн байна гэдгийг би бас мэдэрч байлаа.

Судлаачийн сэтгэлийн хөөрөлд автан Энэтхэг, Төвд, Балбад шинжилгээний анги зохион байгуулан явах болсон бид лам, гүрү, свами нарын сэтгэхүйд өөрийн мэдэлгүй нэвтрэн, тэдний мэдлэг Рерихын болон бусад олон мэдлэгийн нууцыг нээх түлхүүр нь болохыг ойлгосон юм. Тэр дундаа Шамбалын орны тухай Рерихын өндөр утга учиртай өгүүлбэрүүд нь уг шинжилгээний ажлын дараа арай л бодитой, ойлгомжтой болж эхэлсэн. Жишээ нь зөвхөн цэвэр ариун сэтгэлтэйгээр л (өөрөөр хэлбэл сөрөг сэтгэлийн энергээс ангижирсанаар л) самадийн байдалд орох боломжтойг ойлгосон маань мөнхийн амьдрал, газар дэлхий дээрх амьдралыг баталгаажуулах цогц зэрэг маш олон зүйлийг ухаарах үндэс болсон юм. Энгийн хүмүүс бидэнд огт тодорхойгүй сэтгэлийн энергийн ертөнцөд өөрийн гэсэн хууль зарчим байдгаас бидэнд шивэгнэх төдий нь л тодорхой болж буй бөгөөд эдгээр хуулийг мэдсэнээр олон зуун оньсогыг зөв тааж, тэр ч бүү хэл, (ямар нэгэн хэмжээнд) Шамбалын орны нууцыг хүртэл тайлах болно



## Гитлер ба Шамбалын орон

Дорны эртний нууцууд нь Адольф Гитлерийн сэтгэхүй бүрэлдэн тогтоход асар их нөлөө үзүүлсэн тухай багагүй баримт мэдээлэл ном зохиолд байдаг. Л.Повель болон Ж.Бержье (Франц) зэрэг түүхчийн судалгаанаас үзэхэд Дэлхийн нэгдүгээр дайны дараа Германд Шамбалын орон болон өмнөх иргэншлийн хүмүүсийн талаарх эртний Төвдийн домогт үндэслэсэн нийгмийн янз бүрийн урсгал бүрэлдэж эхэлсэн байна. Данцигийн сенатын ерөнхийлөгч байсан Раушнинг “Герман хүн болгон нэг хөлөөрөө Атлантидад зогсож байгаа юм. Тэгээд тэндээ илүү хувь заяа, илүү өв хөрөнгийг хайж байгаа юм.” гэж бичжээ.

1933 онд Берлинд “Врилийн нийгэмлэг” хэмээх нууц нийгэмлэг байгуулагджээ. Вриль! Вриль гэдэг нь хүний бурханлаг эсэхийн хэмжүүр, Ертөнц түүгээр ханасан агуу их энерги юм. Врилийг эзэмшсэн хүн биеийнхээ, бусад хүмүүс болон бүх дэлхийн эзэн нь болно. Энэ нийгэмлэгийн гишүүд “дээд төрөлт хүмүүс буюу Гималайн нуувчинд алтан бүрхүүл доор эсвэл гүн агуйд байнга нуугдан унтаж буй аварга хүмүүс врилийг төгс эзэмшсэн” гэдэгт итгэдэг байжээ. Эдгээр дээд төрөлт хүмүүс хүн төрөлхтнийг удирдахаар удахгүй гарч ирнэ. Ертөнцийн хаад газар доороос гарч ирэхэд ертөнц тэр аяараа өөрчлөгдөнө. Хэрэв бэлтгэлтэй байж тэдэнтэй эв найрамдал тогтоохгүй бол бүх юм, тэр дундаа энгийн хүмүүс ч боол нь болж, “Шинэ цаг үе” цэцэглэх болно.

“Врилийн нийгэмлэг” нь Гитлерийн ертөнцийг үзэх үзэл бүрэлдэн тогтоход маш ихээр нөлөөлсөн гэдэг. Гэвч үүнээс ч илүү нөлөөллийг Гитлерт Ганс Горбигер сансрын мөсний (товчлон “Вель”) онолоороо үзүүлсэн юм. Ганс Горбигерийн онолоор бол манай иргэншлийн өмнө үеийн хүн-бурхад, хүн-аврагууд хүчин чадал хэмжээгээрээ үлгэрийн мэт агуу, хэдэн мянга, хэдэн сая жил үргэлжилсэн соёл иргэншлийг цогцлоож байсан гэнэ. Аврагууд боол эзэмшдэг байсан. Аврагуудын соёл иргэншил нь их үерийн улмаас мөхсөн. Хэзээ ч юм манай иргэншилийн хүмүүс ч бас агуу их гай гамшиг, гаж хувьслыг даван гарсаар өөрсдийн эрт эдүгээгийн өвгөд дээдэс шигээ хүчирхэг болно. Сансрын бүхий л зүйл мөчлөгийн хуульд захирагддаг бөгөөд хүн төрөлхтнийг аврах болон шийтгэх мөчлөгийн хууль мөн байдаг гэж Горберг үзэж байсан бөгөөд хүн төрөлхтнийг аврахын тулд эрх мэдлийг илүү хүчирхэг, хатуужилтай хүмүүст өгөх хэрэгтэй гэж тэрээр үздэг байжээ. Түүний бодлоор ийм хүмүүс нь өвгөд дээдэс нь цас мөсөнд хатуужсан нордийн үндэстэн болох аричүүд гэнэ. Гитлер төрийн эрхэнд гарахаасаа өмнө Берлинд амьдардаг байсан нэгэн Төвд ламтай байнга харьцдаг байжээ. Энэ ламыг “ногоон бээлийтэй хүн” гэж нэрлэдэг байж. Хутагт Гэгээнтнүүд түүнийг “Агартин вант улсын их сангийн нярав” гэцгээдэг байлаа.

Агартин гэдэг нь Герман хэлээр “Азгарди” юм. Нууцлаг Агартин вант улстай шашны хүчирхэг байгууллага болох “Фулегийн Нийгэмлэг” холбоотой байжээ. Уг

нийгэмлэгийг германы эрдэмтэд болох Экард, Гаусгоффер нар үндэслэжээ. Тэд мөн л Гитлерийн сэтгэхүй бүрэлдэн тогтоход асар их нөлөө үзүүлсэн юм. “Фулегийн нийгэмлэг” нь 30-40 зууны өмнө говийн их элсэн цөлийн нутагт хүчирхэг нэгэн соёл иргэншил цэцэглэж байсан гэдэг домгийг үйл ажиллагааныхаа үндэс болгосон. Говийн гамшгийн үед уг иргэншлийн хүмүүсээс амьд үлдсэн нэг хэсэг нь Гималайн агуйнуудад очиж, тэндээ 2 хуваагджээ. Нэг хэсэг нь өөрсдийн төвөө Агарту буюу баялгийн нууц газар хэмээн нэрлэж, бясалгал даяанчлалд өөрсдийгөө зориулан газар дэлхийн амьдарлаас тасарсан байна. Нөгөө хэсэг нь Шамбалын орныг буюу зөвхөн нууцад нэвтэрсэн хүмүүс л мэдэх ер бусын хүчний орших байр болох газрыг үндэслэжээ (хүчин чадал, хүчирхийлэл, хүмүүс болон байгалийн хүчийг удирдах төв). Говийн их гамшгийн дараа амьд үлдсэн өндөр соёл иргэншилт хүмүүсийн өөр нэгэн хэсэг нь Европын хойд хэсэг болон Кавказын нутаг руу дүрвэсэн байна. Говиос дүрвэн ирсэн эдгээр хүмүүс ари үндэстний эх сурвалж болсон гэдэг. Тийм ч учраас ари үндэстэн л Агарту болон Шамбалын оронтой нэгдэж, хүчирхэг эртний хүч чадлыг эзэмшиж чадах юм. “Фулегийн нийгэмлэг” нь Зүүн Европ, Кавказ, Памир, Төвд болон Говийг эзлэх шаардлагатай. Төвд Говь хоёр бол дэлхийн цөм нь болсон бүс нутаг бөгөөд түүнийг эзэмшигч нь Шамбалын орны хүчин чадлыг эзэмших болно хэмээн үздэг байсан байна.

Төвд рүү Шамбалын орон болон Агарту орныг хайх зорилготой шинжилгээний ангийг явуулсан Ананербын хүрээлэн Гитлерийн тушаалаар Германд байгуулагджээ. Эдгээр санаанд үндэслэн Гитлер шидэт социализмын онолоо боловсруулжээ. Уг онолоор бол хүн төрөлхтөн 700 жил тутам хэлбэрээ өөрчлөн шинэ үе шатанд ордог байна. Хэлбэрээ өөрчлөх нь тэмцлийн явцад үүсдэг бөгөөд өөрчлөлтийн урьдчилсан шинж тэмдэг нь Бурхны Хүүдүүд бий болох үзэгдэл байлаа. Энэ үед аврага биет шидтэнгүүд бий болж бүтээлээ өөрчлөх үйл явц үүсдэг буюу энэ нь хүн төрөлхтнийг гүн гүнзгий гаж хувьсалд оруулдаг. Ингэснээр устан үгүй болж буй хуучин үндэстний оронд шинэ хөгжингүй үндэстэн үүсдэг байна. Энэ үндэстэн нь мөн л Шамбалын орны хүчин чадлыг мэдрэх болно.

Эдгээрээс үүдээд Гитлер дараачийн мөчлөгийг тогтоох эрхтэй жинхэнэ дээд үндэстэн буюу арийн үндэстэн гэж байдаг гэсэн аймшигт дүгнэлтэнд хүрсэн. Энэ үндэстний эрхэм зорилт бол “Дээд үл мэдэгдэгчид”-ийн удирдлагыг хэрэгжүүлэх явдал юм. Бусад хүмүүс бол доод үндэстнүүд бөгөөд зөвхөн төрхөөрөө л хүнтэй адил боловч аричуудаас, амьтдаас ч илүү хоцрогдмол юм. Тийм ч учраас бусад үндэстнийг (цыган, еврей, негр болон бусад) устгах нь хүн төрөлхтний эсрэг үйлдсэн гэмт хэрэг болохгүй гэжээ.

Гитлерийн цэрэг Ижил мөрний эрэг дээр ялагдал хүлээхэд Геббельс: “Ойлгоцгоо л доо! Санаа бодол тэр аяараа, ертөнцийг үзэх үзэл тэр аяараа ялагдал хүлээж байна...” гэж бичиж байлаа. 1943 оноос Гитлер амь өрсөн

дайныг дахин эхэлжээ. Яагаад? Нацист удирдагчид Горбигерийн урьдчилан хэлсэн их үерийг хүлээж байлаа. Гитлер бурхдын шүүн цээрлүүлэхийг, шидэт-хүн ирэхийг хүлээж байв. Хүний хүчээр хийж дийлээгүй зүйл биеллээ олох нь! Тэнгэрийн өшөө хонзонг дуудахын тулд Гитлер Берлиний метрог дэлбэлэхийг тушаалаа. Тэнд 300 мянган герман хүн амиа алдсан байна.

Олон улсын нэг хуралд сууж байхдаа гитлерчүүд хэрхэн нисдэг тавагтай төстэй нисдэг төхөөрөмжүүдийг бүтээх эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлж буй тухай америкийн дүрс бичлэгийн кино үзсэн юм. Хоёр харьцаа тогтоогч эмэгтэй (нэг нь югослав, нөгөө нь герман) өмнөх иргэншлийн хүмүүсийн нисдэг төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны зарчим болон зургийг Гитлерт өгчээ. Энэ киноноос үзэхэд Гитлерийн эрдэмтэд үнэхээр нисдэг төхөөрөмжүүдийг бүтээж, нисгэж чаджээ. Гэвч уг үйл хэргээ дуусгаж чадалгүй, дайн дуусжээ. Ингээд Гитлерийн шидэт коммунизмыг авч үзэхэд хоёр дүгнэлт төрдөг.

Нэгдүгээрт, Гитлерчүүд гүн ухааны хувьд сөнөөж мөхөөх нь муу муухай, бүтээн босголт бол сайн сайхан юм гэдэг маш энгийн үнэнийг ойлгосонгүй. Бүр түрүүчийн соёл иргэншлийн үед дэлхийг хамарсан гамшиг тохиолдоход зориулж Хүн Төрөлхтний Генийн Сан, Шамбал Агарт хөөрыг бүтээсэн юм. Шашны болон бусад ном зохиолд Генийн Сангаас гарсан хүмүүс (бидний таамаглаж буйгаар) нэгэн үндэстнийх нь хөгжил цэцэглэлтийн төлөө нөгөө үндэстнийг нь устгах гэх мэт хорон муу санаа агуулдаг тухай нэг ч баримт байхгүй байна. Бумба Будда, Гаутама Будда, Иисус ч бай тэд бүгд л итгүүлэх, номлох аргаар л үйл ажиллагаагаа явуулж байснаас, хэн нь ч хүчирхийллийн аргаар үйл ажиллагаагаа явуулж байгаагүй. Шамбалын орны хүчин чадал бол хэзээ ч муу муухайн төлөө нээгдэхгүй. Энэ нь зөвхөн сайн сайхны төлөө зориулагдана. Дэлхий ертөнц дээр Шамбалын хүчнээс илүү хүч байхгүй учир Шамбалын орныг эзэмдэх хүч Дэлхий ертөнц дээр байхгүй. Харин бурхан хэзээ ч муу муухайн холбоотон болохгүй. Учир нь бурхан нь сайн сайхны билэгдэл билээ.

Хоёрдугаарт, Гитлерт тохиолдсон энэ явдал нь (Сталин ч мөн адил) шизоид хэлбэрийн хүмүүс эрх мэдлийг гартаа авахад ямар аюул үүсгэдгийг харуулж байдаг. Эдгээр "түүхэн хувьслын золиосууд" нь хэтэрхий хийрхүү хэнээтэй бөгөөд байгалийн нууцлаг үзэгдлийг бахдал болгон тайлбарлах сонирхолтой байдаг. Тэдэнд хийсвэрлэн сэтгэхүй хөгжөөгүй, салангид баримтуудыг нягтлан шинжлэх чадваргүй байдгаас гадна аль нэгэн, ялангуяа, нууцлаг ер бусын шинжтэй баримтуудыг хэт дөвийлгөх хандлагатай байдаг. Эрх мэдэл шизоидуудад очих нь нэн аюултай. Эрх мэдлийг гартаа авсан шизоидууд мөн л шизоид хэлбэрийн тойрон хүрээлэгчидийг бүрдүүлснээр нийгмийг гаж хөгжлийн замаар хөтөлдөг. Харин нийгмийн гаж хөгжил нь зайлшгүй гунигт төгсгөлд хүргэдэг.

Шамбалын орныг судалж байх явцдаа байгалийн энэ агуу нууцад соронзонгоор татагдах мэт сонирхдог шизоид сэтгэлгээтэй хүмүүсээс болгоомжлох хэрэгтэй.

## Шамбалын болон Агартийн орны тухай таамаглал

Миний бодлоор Шамбалын орон болон Агартийн орны оршин тогтнох үндэс нь байгалийн хоёр хүчин зүйл юм. Үүнд:

- Бодитжих болон эс бодитжих;
- Хүн төрөлхтний Генийн сан;

Юмс үзэгдлийн бодитжих болон эс бодитжих нь анх харахад үлгэрийн, уран зөгнөлийн мэт санагддаг. Үнэхээр бодмогц л дээр нь янз бүрийн идэш ууш үүсдэг шидэт бүтээлэгт итгэж болно гэж үү? Аватар Саи Баба нунтаг, бөгж, будаа зэргийн талаар бодонгуут л эдгээр зүйл бий болдог гэдэгт итгэж болно гэж үү?

Гэсэн ч “гайхамшгийг” зөвхөн илбэчид л бүтээдэг гэсэн ахуйн ойлголтоосоо түр ангижран энэ талаар гүн ухааны үүднээс арай өргөн хүрээтэйгээр авч үзье. Миний бодлоор бодит ертөнцөөс гадна нарийн ертөнц бас оршдог гэсэн баримттай хэн ч маргахгүй болов уу. Зэрэгцээ оршдог уг хоёр ертөнцийн хооронд холбоос байх ёстой. Учир нь долгионы энерги бодит зүйл болон хувирч, мөн эсрэгээр хувирах үзэгдэл байгаль дээр байнга байдаг. Жишээ нь, сургуулийн физикийн хичээлээс  $2 \text{ гамма} = 1 \text{ электрон}$  гэдгийг бүгд мэднэ.

Нарийн ертөнц буюу сэтгэлийн энергийн ертөнц (хэт өндөр давтамжийн ертөнц) нь бодит ертөнцтэй долгионы энерги материд шилжих харилцан уялдаатайгаар харилцан шилжих зарчимтай байх ёстой. Өөрөөр хэлбэл бодит зүйлс эс бодитжин сарниж, бодол санаа нь бодит зүйлс болон хувирах үзэгдэл байх ёстой. Орчин үеийн физикчид бодол санаа бол бодит юм гэдгийг байнга онцлон тэмдэглэсээр ирсэн бөгөөд энэ нь ч үнэний хувьтай.

Эдгээрээс үзэхэд балар эрт цагаас уламжлагдаж ирсэн үлгэр домог бодит үнэнд үндэслэсэн байдаг бололтой. Ер нь хүн ор мөргүйгээс ургуулан зөгнөх чадваргүй бөгөөд үлгэр домгийг түүнд кармын зөн совин буюу өмнөх амьдралын зөн нь шивнэдэг.

Үүнээс гадна үндсэндээ йог бясгалгалын талаархи дорнын бүхий л бүтээлд хүн бодитжих эс бодитжих чадвартай болохуйц сэтгэлийн хөгжлийн түвшинд хүрэх нь бясгалгалын дээд хэлбэр болдог тухай заасан байдаг. Орчин үеийн йогч дунд тийм хүн хараахан байхгүй мэт. Гэвч урьд өмнө нь ийм чадвартай хүмүүс цөөнгүй байсан бололтой. Дорнын ном зохиолд хормын дотор орон зайд шилжих чадвартай хүмүүсийн тухай баримт их байдаг. Магадгүй энэ бол уран зөгнөл байх. Гэвч бодитжих болон эс бодитжих замаар хүн өөрийн бодсон газраа очдог байсан байж болох. Бодол санаа нь хормын төдий хугацаанд хаана ч шилжих чадвартай билээ. Шамбалын орны талаар дүрслэхдээ Николай Рерих түүнд хүрэх замд хаанаас ч юм хөл хүрэмгүй хад асган дээр гэнэт гарч ирж мөн хаашаа ч юм нууцлагаар алга болох чадвартай хүмүүсийн талаар их бичсэн байдаг. Эдгээр хүмүүсийг ч мөн бодитжих болон эс бодитжих чадвартай үзэж болно.

Бодитжих болон эс бодитжихоос гадна Шамбал, Агартийн орон оршин тогтнохын үндэс болсон байгалийн нэгэн үзэгдэл бол бидний таамаглаж буйгаар

бол Хүн Төрөлхтний Генийн Сан юм. Шамбалын орон болон Агартгийн орны талаархи таамагт үндэслэн уг хоёр хүчин зүйлийн хоорондын харилцан холбоог авч үзье.


Хэрвээ бодитжих болон эс бодитжих үзэгдлийг үндэс гэж үзвэл Хүн Төрөлхтний Генийн Сан оршдог нь маргаантай болно. Хүмүүсийн бие махбодийг нарийн ертөнцөөс бодитжуулж болдог байхад Самадийн байдалд хэдэн мянга хэдэн сая жилээр хадгалах ямар шаардлага байна?

Гэхдээ хүний бие махбодь сүнс нягтарших замаар үүссэн тухай шашны онолоор бол хүний бие махбодь үүсэх нь байгалийн түүхэн хувьслын асар том үйл ажиллагаа шаарддаг. Хүний бие махбодийг генийн цогцууд бүхий л зарчмийнхаа дагуу бүтээсний дараа (хүүхэд төрөх) Нөгөө Ертөнцийн мэдээллийн оронд хүний бие махбодийн мэдээлэл код хэлбэрээр цуглардаг бөгөөд түүний үндсэн дээр хүн бодит ертөнцөөс нарийн ертөнц рүү, мөн эсрэгээр нь, өөрөөр хэлбэл бодитжуулах болон эс бодитжуулах боломжтой болдог байна.


Нөгөө ертөнцийн үйл ажиллагааны зарчмийг бид мэдэхгүй ч Нөгөө Ертөнцийн мэдээллийн гайхам багтаамжтай торсын орон нь урт удаан хугацааны турш хүний бие махбодийн “Мэдээллийн код” –ийг (Эс тус бүрийн, молекул тус бүрийн бүтцийн талаархи мэдээллийг) алдаагүй хадгалж чадна гэдэг нь зүй ёсоор эргэлзээ төрүүлж буй юм. Тийм ч учраас уг “мэдээллийн код”-ыг эс бодитжсон байдалд хязгааргүй урт хугацааны туршид хадгалах боломжгүй тул үе үе хүнийг эргэн бодитжуулж, Нөгөө ертөнц дэх “Мэдээллийн код” –ыг засварлах үйл ажиллагаа байнга явагддаг байна.

Хүн Төрөлхтний Генийн Сан оршин тогтнодог нь үүгээр тодорхойлогдож байна. Бүх дэлхийг хамарсан гамшгийн үед газар дэлхийн бүх хүмүүс амь үрэгдсэн тохиолдолд ч “Мэдээллийн код”-ийн бодит үндсийг Хүн Төрөлхтний Генийн Сан нь бодит ертөнцөд хадгалах чадвартай юм. Самадийн байдалд буй янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсээс тогтсон Хүн Төрөлхтний Генийн Сан нь нарийн болон бодит ертөнц дэх амьдралын хэлбэрүүдийн харилцан холбоотой орших чухал нөхцөл нь болдог. Самадид буй хүмүүс Нөгөө Ертөнцтэй шууд холбоотой байдаг учир “амь орсон” үедээ “SoHm” зарчимд баригдсан энгийн хүмүүсийг бодвол өөрийн бие махбодио бодитжуулж, мөн эс бодитжуулах чадвараар өндөр байдаг. Хүн Төрөлхтний Генийн сан нь бүх иргэншлүүдийн сэтгэл оюуны хувьд хамгийн шилдэгүүдээс бүтсэн тул тэдний бие махбодь бодитжих эс бодитжих өндөр боломжтой.

Хүний бие махбодийг эс бодитжуулах нь сүнсэнд бие махбодийн бүтцийн талаархи нэмэлт мэдээлэл өгдгөөрөө сүнсэнд мэдээллийн асар их дарамт учруулдаг. Тийм ч учраас Нөгөө Ертөнцийн бусад бүтцийн туслалцаагүйгээр эс бодитжих нь боломжгүй зүйл юм. Үүнээс үзэхэд хүний бие махбодийг бодитжуулах болон эс бодитжуулах нь хүүхэд төрөх үед түүний бие махбодид сүнс орох



Эс бодитжих (зохиогчийн зураг)



*Бодитжих (зохиогчийн зураг)*

энгийн үйл явцаас Дээд Оюун Ухааны хамаагүй өндөр хяналтан доор явагддаг байна.

Хүний бие махбодийг бодитжуулах эс бодитжуулах үзэгдэл ямар ач холбогдолтой юм бэ? Самадид байгаа хүн тэртэй тэргүй Нөгөө Ертөнц болон Дээд Оюун Ухаантай сүнсээрээ холбоотой байдаг. Уг асуултанд бодитжих болон эс бодитжих үзэгдэл нь газар доорхи амьдралыг газар дэлхий дээр явуулахад хэрэгтэй гэж хариулж болно.

Төвд лам нарын хэлсэн “Чулуу тэдний хувьд саад биш юм!” гэсэн үгийг эргэн санацгаая. Эхэндээ би энэ өгүүлбэр нь өмнөх иргэншлийн хүмүүсийн чиглэсэн сэтгэлийн энергийн хүчээр таталцлын хүчинд нөлөөлөх чадварын талаар ярьж буй юм гэж ойлгодог байлаа. Хожим энэ үг нь бодитжих болон эс бодитжих үзэгдлийн талаар ярьж буй юм гэдэгт улам бүр үнэмших болсон юм. Үүнээс үзэхэд бодитжих болон эс бодитжих үзэгдлийг газар доорх амьдралыг оршин тогтноулахын тулд байгаль бий болгосон бололтой.

Газар доорхи амьдрал гэж юу вэ? Уг судалгаанаас үзэхэд газар доорхи амьдрал гэдэг бол юуны түрүүнд Хүн төрлөхтний Генийн сан юм. Газар доогуур газрын гадаргатай холбоогүй маш олон хөндий орон зай байдаг бололтой. Магадгүй ихэнх агуйн үүд хаалга он цагийн эрхэнд нурж газарт орсон биз. Пирамидуудын доор орших газар доорх сүмүүд нь газрын гадаргууд гарцгүй юм (Е.П.Блаватская). Тэгэхээр самадид буй хүн хэрхэн гарах хэрэг вэ? Бие махбодио эс бодитжуулан газрын гадаргууд гарсан хойноо дахин бодитжуулж бий болно гэсэн ганцхан хариулт буй юм. Өөрөөр хэлбэл тэд хоосон зүйлээс бий болж буй мэт үүсэх юм.

Хүн төрөлхтөний Генийн сан нь .самадид буй янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсийг газрын гадаргууд гарцтай агуйнуудад хадгалаад зогсохгүй мөн гарцгүй агуйнуудад мөн хадгалдаг бололтой.

Мөн газар зүйн гамшгийн үед (тектоник бүрхэвчийн шилжилт гэх мэт) хүний бие махбодийн бодитжих болон эс бодитжих үзэгдэл нь самадид буй хүний биеийг арай аюулгүй агуйд шилжүүлэх боломжийг олгож байгаа юм. Бодол санааг бодитжуулах чадавхи нь самадид буй хүмүүсийн бие махбодид гарсан гэмтлийг “засварлан” бие махбодийн бүрэн бүтэн байдлыг өндөр түвшинд хадгалах боломж олгоно.

Гэвч ном зохиолууд, лам свами нартай хийсэн ярилцлагад газар доор техникийн өндөр хөгжилтэй хүмүүсийн соёл иргэншил байдаг тухай өгүүлдэг. Эхэндээ энэ бол цэвэр үлгэр туульс мэт санагдаж байлаа. Гэсэн ч дээр дурдсан зүйлсийн үндсэн дээр уг баримтууд үнэн зүйл мэт санагдаж, эдгээрт арай л нухацтай хандах болсон юм. Үнэхээр ч хүний бие махбодийг эс бодитжуулах нь газар доогуур орж, гарах арга болж болох юм гэж би бодож байна. Үүнийг үндэс болгон авч үзвэл Н.Рерихийн хэлсэн хадан дээр хаанаас ч юм гарч ирэн, мөн хаашаа ч юм алга болдог хүмүүсийн талаарх мэдээлэл ойлгомжтой болж буй



юм. Техникийн өндөр хөгжилтэй, шинжлэх ухааны өөр зарчмаар бүтсэн машин тоног төхөөрөмжтэй эртний мэдлэгийн үндсэн дээр суурилсан газар доорх соёл иргэншил байдаг тухай Хутагт Гэгээн Виссарион, лам, свами, гүрү нарын яриаг ч үүгээр тайлбарлаж болно.

Бодитжих эс бодитжихийн талаар бодол эргэцүүлэлд толгой нь эргэсэн уншигч Шамбалын болон Агартийн орон гэж чухам юу юм бэ гэсэн асуултын хариуг тэсэн ядан хүлээж байгаа буй за. Харин уг асуултын хариу нь нарийн болон бодит ертөнцийн хоорондын харилцан уялдааны 2 хувилбараас харагддаг. Үүнд:

Нэгдүгээр хувилбар: Сүнс нь сэтгэлийн энергийн мэдээллийн бөөгнөрөл болохын хувьд бодит ертөнцөд хүн болон мэндэлж байгаа хүүхдэд нисэн орж, бие махбодитой нь цуг амьдран бие махбодь нь үхсэний дараа нарийн ертөнц рүүгээ буцан оддог бөгөөд хожим дахин нэгэн шинэ бие махбодид ордог байна.

Хоёрдугаах хувилбар: Нарийн ертөнцөд оршиж буй хүчирхэг сүнс урт удаан хугацааны турш /зуу, мянга, сая жилийн турш/ нэг эсвэл хоёрдугаар хэлбэрийн самадид буй хүний биеийн махбодитой холбоогоо хадгалсаар байдаг. Энэ тохиолдолд сүнс нь нэгдүгээр хэлбэрийн самадийг хоёрдугаар хэлбэрийн самадид оруулах буюу чулуун хөшингө биеийг үйл ажиллагааны хэлбэрт оруулна. Сүнс нь мөн махбодийг бодитжуулах, эргэн эс бодитжуулах чадвартай юм.

Нарийн болон бодит ертөнцүүдийн уялдаа холбооны эхний хувилбар нь дэлхий дээрхи энгийн амьдралын буюу жирийн хүмүүсийн амьдралын шинжтэй юм.

Бидний үзэж байгаагаар хоёр дахь хувилбар нь хүн бараг мөнх амьдралыг олох газар доорх буюу усан доорхи амьдарлын шинжтэй. Уг хувилбараар бол Шамбалын болон Агартийн орнууд гэдэг нь ихэвчлэн газар доогуур /усан доогуур/ байрласан дэлхий дээр бидэнтэй зэрэгцэн орших амьдарлын цогц юм. Уг орнуудын хүмүүс нь мөнх амьдардаг /чулуу хөшингө Самади эсвэл идэвхтэй Адептүүд/ бие махбодио бодитжуулах эс бодитжуулах чадвартай болон үйл ажиллагааны хайнга байдлаас үйл ажиллагааны идэвхтэй хэлбэрт шилжих зэрэг онцлогуудтай.

Шамбалын болон Агартийн орнуудад ямар хүмүүс амьдардаг вэ?

Энэ асуултанд үндэслэлтэйгээр хариулахын тулд амьдралын хоёр дахь хувилбарыг лемурчууд, атлантчууд зэрэг өмнөх иргэншлийн хүмүүсийн амьдралтай харьцуулж үзье. Энэ харьцуулалтаас харахад өмнөх иргэншлийн хүмүүс болох атлантчууд ялангуяа хажуу үеийн лемурчуудын амьдралын зарчим нь маш олон тал дээр дэлхий дээрхи амьдралын хоёрдугаар хувилбартай төстэй байгаа юм.

Жишээ нь: Тэд ертөнцийн мэдээллийн оронтой шууд холбогдох боломжтой бөгөөд биеэ дотоод энергийн тусламжтайгаар эдгээдэг, тэдний технологи нь

нарийн ертөнцийн энергийг ашиглахад үндэслэгдсэн байдаг г.м. Лемурчууд болон Атлантчууд мөнх амьдрал болон бодитжих эс бодитжих чадварт хүрч чадсан бол уу? Энэ асуултанд шууд хариулах нь хэцүү хэдий ч ном зохиолд энэ талаар бүдэг бадаг баримтууд байдаг. Ямартай ч лемурчууд болон атлантчуудын зарим нэг нь л ийм чадвартай байсан бололтой.

Гэсэн ч өмнөх иргэншлийн хүмүүсийн амьдрал технологи нь тэдний сүнс хүчирхэг байдалд үндэслэгдсэн нь анхаарал татаж байгаа юм. Дэлхий дээрхи амьдралын хоёр дахь хувилбар нь /Шамбал ба Агарты/ мөн л тэдний хүчирхэг сүнсний чадавхид тулгуурласан.

Уг харьцуулалтаас үзэхэд Шамбалын орон болон Агартын орныг өмнөх иргэншлүүдийн хүмүүс болох лемурчууд, атлантчууд бүрдүүлж байгаа юм. Тэдний хэн нь Шамбалын орон болон Агартын орны үндсэн хүн ам нь болдог юм бол? Бидний үзэж байгаагаар атлантчуудын бодитжих, эс бодитжих үзэгдлийг ашиглах чадвар нь арай бага бөгөөд тэдний оршин байх төлөв нь /идэвхгүй самади, идэвхит самади, эс бодитжих зэрэг/ ихэнхдээ хөгжлөөрөө арай давуу лемурчуудын хяналтан доор байдаг. Лам нар болон онцгой хүмүүс ихэвчлэн нууцлаг “Тэр” гэгчийг дурсаж байсныг эргэн санацгаая. Уг хүн газар доорхи Хүн төрөлхтний Генийн сантай холбоотой болгоныг шийддэг бөгөөд самади-агуйд орох зөвшөөрлийг өгдөг юм. Магадгүй нууцлаг “Тэр” Шамбалын орон болон Агартын орны, Хүн төрөлхтний Генийн сангийн уг хэсгийн хянаж байх ёстой лемур байж болох.

Манай иргэншлийн хүмүүсээс Агартын болон Шамбалын орны бүрэлдэхүүнд ордог уу? Ордог бол зөвхөн чулуун хөшингө байдалд буй лемурчуудын эрхэнд байдаг хүмүүс юм. Үүнийг Хутагт Гэгээнтнүүд, тэр дундаа Иисүс Христос Төвдэд, Шамбалын оронд сургалт хийж байсан тухай мэдээллүүд гэрчлэх юм. Самади агуйгаас гарч буй Хутагт Гэгээнтнүүд техникийн өндөр хөгжилт соёл иргэншил болох Шамбал болон Агартын оронд нэмэлт мэдлэг мэдээлэлийг олох ёстой гэж үзэж болох юм.

Шамбалын орон болон Агартын орны тухай бидний таамаг нь зарим нэгэн Хутагт Гэгээнтнүүдийн баримт нотолгоотой таарч байлаа. Жишээ нь Дээр дурдагдсан Оросын сүмийн гэлэнгийн хэлснээр Шамбалын болон Агартын орон нь нэгдмэл газар доорхи ертөнцдөө өөр өөр соёл иргэншлийн хүмүүсийг багтаадаг гэсэн баримт юм. Шамбалын болон Агартын орныг манай иргэншлийн хүмүүс, тэр ч бүү хэл атлантчуудаас ч хамаагүй өндөр түвшинд хөгжсөн лемурчууд удирддаг. Атлантчууд нь лемурчуудын хажууд эгээ л хүүхэд шиг бөгөөд манай иргэншлийнхэн түүнээс бүр долоон дор түвшинд буй юм. Чухам лемурчууд л нарийн ертөнцийн энергийг бүрэн эзэмшсэн билээ. Хэдэн сая жилийн өмнө дэлхий дээр болсон аймшигт гамшгийн үеэр лемурчууд соёл иргэншлээ газар дор оруулж авархуйц хэмжээний өндөр хөгжилд хүрсэн байжээ. Одоо ч газар дор буй лемурчууд техникийн асар өндөр түвшинд бүтээгдсэн тоног


төхөөрөмжтэй. Лемурчууд Хүн төрөлхтний Генийн сангийн үндэс нь болж, түүнийг хамгаалж байдаг. Маш эрт дээр үед газар доорхи лемурчууд нь Шамбалын болон Агартын гэсэн 2 улс болон хуваагджээ. Агартын орон Шамбалын орноос илүү сайн үйл, сайхан сэтгэлтэй юм.

Окульт шижлэх ухааныг эзэмшсэн Уфа хотын угуул Марат Фатхлислимовын хэлсэнчлэн 30000 жилийн өмнө Хүн төрөлхтний Генийн сангийн лемурчуудыг Шамбалын оронд эсвэл Агартийн оронд шилжүүлэх тухай зааврыг Дээд Оюун Ухаан өгсөн гэнэ. Тэнд газар доогуур тэд бодит эсвэл нарийн байдалд оршдог. Лемурчууд газар доор ажиллаж амьдран, нисдэг таваг г.м. төхөөрөмжийг эзэмшдэг. Лемурчуудын зарим нь самадийн байдалд Хүн төрөлхтний Генийн Санд байдаг юм. Атлантчууд нь “Х” цаг үеийг буюу эртний мэдлэг хүмүүс нээгдэх тэр хоёр дахь “Алтан зуун” болох чин үнэний цагийг үеийг хүлээж, Хүн төрөлхтний Генийн санд байнга самадийн байдалд оршдог ажээ.

Чин үнэний зууны үед Атлантчууд самадигаас гарч, газар дэлхий дээр ирж манай иргэншлийн хүмүүст амьдралын зарчмыг сургах явдал олширно. Манай иргэншлийн хүмүүс ч мөн адил самадийн байдалд Хүн Төрөлхтний Генийн санд орох болно.

Шамбалын болон Агартийн оронд буй лемурчууд ямар технологийг эзэмшдэг вэ? Тэдний бүхий л технологи нь одоогоор бидэнд ойлгомжгүй өөр энергийн зарчимд тулгуурладаг байх ёстой. Шамбалын орон, Агартийн орон нь нарийн ертөнцийн энергийг хэрэглэдэг байх. Бидний үзэж байгаагаар Шамбалын орон болон Агартийн орны технологийн илрэл бол бүхний мэдэх үл таних нисдэг биет (ҮТНБ) буюу нисдэг тавагнууд юм. Дэлхий дээр ҮТНБ байдаг гэдэгт эргэлзэх хэрэггүй биз ээ. Учир нь түүний тухай дэндүү олон мэдээ баримт хуримтлагдсан юм. Уг нисдэг төхөөрөмж нь итгэхэд ч бэрх хурдтайгаар чимээгүй нисэх, чиглэлээ огцом өөрчлөх, агаарт зогсох, газарт буух, усанд шумбах болон гэнэт бий болж алга болох чадвартай нь хэдийн тодорхой болсон. ҮТНБ –ийн аварга том хөлгүүдээс эхлээд жижигхэн таваг хүртэл маш олон дүрийг дүрсэлсэн байдаг. Хүмүүс аварга том хүн маягийн амьтнаас эхлээд жижигхэн одой хүртлэх бүх төрлийн хүн дүрстнүүдтэй учирч байжээ.

Эртний лемурчууд болон атлантчуудын нисдэг төхөөрөмжний (вимана) дүрслэлийг ҮТНБ-ий тухай мэдээ баримттай харьцуулж үзье. Ном зохиолуудаар бидэнд уламжлагдан ирсэн мэдээллээс үзэхэд эртний лемур, атлантчуудын вимана ч мөн адил хавтгай хэлбэртэй, газар ус агаарт тогтох чадвартай, чиглэлээ огцом өөрчилдөг чадвартай байв. Өөрөөр хэлбэл орчин үеийн ҮТНБ болон эртний вимана хоёрыг маш нарийвчлалтайгаар адилгаж болохоор байна. Үүнээс үзэхэд ҮТНБ-ийг лемурчуудын эртний технологийн дагуу өнөө үед Шамбалын болон Агартийн оронд бүтээсэн, бүтээсээр байгаа гэсэн таамаг дэвшүүлж болох нь. Шамбал, Агартийн орны техникийн өндөр хөгжилт лемурын соёл иргэншил нь нисдэг төхөөрөмж бүтээх эртний технологио гээгээгүй бололтой. Өнөө үеийн



Шамбалын орон (Зохиогчийн зураг)

хүмүүс биднээс яагаад хэн нь ч ҮТНБ-ийг нарийн судалж чадаагүй юм бол? Яагаад ҮТНБ хамгийн эцсийн шийдвэрлэх мөчид нууцлагаар алга болдог юм вэ? ҮТНБ ч мөн бодитжих болон эс бодитжих чадвартай бололтой. Газрын гадаргуу дээр ҮТНБ-ийн суурь нь олдоогүй болон нууцлагаар ҮТНБ алга болдог зэргийг өөрөөр тайлбарлах аргагүй юм. ҮТНБ-ийн үйлдвэрлэл газар доор буюу Шамбалын болон Агартийн орнуудад төвлөрч явагддаг. Харин ҮТНБ газрын гадаргуу дээр гарч ирэх, буцаж орохдоо эс бодитжих аргыг ашигладаг бололтой.

ҮТНБ-ийг сансрын зочдын хөлөг гэж үзсээр ирсэн боловч ҮТНБ нь техникийн хөгжингүй Шамбалын болон Агартийн орны ололт гэсэн бидний таамаг мөн л үнэн зөв байх магадлалтай. Хэрвээ газар доогуур техникийн өндөр хөгжилт лемурчуудын соёл иргэншил байдаг гэсэн таамгийг үндэслэл болговол тэдгээр лемур юугаар хооллодог тухай асуулт зүй ёсоор төрөх болно. Учир нь хүнсний бүтээгдэхүүнийг газар доор бий болгох бололцоогүй юм. Бидний охорхон мэдлэгийн түвшинд энэ талаар ярихад бэрх боловч лемурчууд хүнсний бүтээгдэхүүнээ бодол санааг бодитжуулах аргаар гарган авдаг байх гэж таамаглаж байна. Сатья Саи Баба будааг болон бусад хүнсний зүйлийг бий болгодог тухай болон Гуфа-ашрам дахь даянчдын амьдралын тухай зэрэг олон янзын орчин үеийн баримт мэдээллүүд нь уг таамгийн баталгаа болж болох талтай.

Шамбалын оронд орох үүдний талаар зарим нэгэн мэдээлэл байдаг. Жишээ нь: Марат Фатхлисламовын үзэж байгаагаар бол Шамбалын орны үүд нь энэтхэгийн Гималайд байдаг бөгөөд гэрэлтэгч бөмбөлгийн хэлбэртэй саадаар хамгаалагдсан байдаг ба Виссарионы бичсэнээр бол Шамбалын орны хаалганы бүсэд (Гималайд) үл мэдэгдэх энергийн асар хүчтэй урсгал үйлчилдэг юм байна. Магадгүй Шамбалд хүрэх үүд үнэхээр байдаг байж болох ч энэ нь голлох үүргийг гүйцэтгэдэггүй. Учир нь бодитжих болон эс бодитжих чадвар нь газар доорх орондоо үүдгүйгээр нэвтрэх боломжийг олгож буй юм. Ном зохиолд “Шамбалын орны эзэн”-ий тухай их зүйлийг бичсэн байдаг юм. Бараг бүхий л шашинд “Шамбалын орны эзэн” газар дэлхийд ирэх талаар зөгнөсөн байдаг. Лалын шашинтнууд түүнийг Имам Махди, Библид Христос эргэж ирнэ гэж, Буддын шашинд Майдар эргэж ирнэ гэж бичсэн байдаг. Урьдчилан таамаглаж буйгаар “Шамбалын орны эзэн” нь аварга том биетэй бөгөөд тэрээр Европт өөрийгөө бурхан хэмээн зарлаж төрөх Антихрист дэлхий дээр ирэхтэй холбогдон дахин төрөх ёстой ажээ. “Шамбалын орны эзэн” бүхнийг хайрлах сэтгэлийг номлож, Антихристыг эсэргүүцэх болно.

Үнэн хэрэг дээрээ юу болохыг хэлэхэд хэцүү. Гэвч хэрвээ “Шамбалын орны эзэн” дэлхий дээр ирэх юм бол энэ нь юуны түрүүнд Шамбалын орны эсвэл Агартийн орны лемур байх магадлалтай. Гэвч Хүн төрөлхтний Генийн сангаас атлант юм уу, манай иргэншлийн хүн гарч ирэх боломжийг мөн үгүйсгэх аргагүй.

Шамбалын орон болон Агартийн орны талаар таамагласнаар Шамбал, Агартийн орон нь нарийн болон бодит ертөнцүүдийн хоорондын харилцаан дээр, юуны түрүүнд бодитжих болон эс бодитжих үзэгдэл дээр үндэслэсэн янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсээс (лемурчууд, атлантчууд болон манай иргэншлийн хүмүүс), тогтсон газар доогуурх, (усан доогуурх?) амьдралын цогц бүтэц юм гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Шамбалын, Агартийн оронд үхэлд амьдрал сүлэлдэн нэгдэж, янз бүрийн иргэншлийн хүмүүс хамтран амьдарч, цаг хугацаа өөрөөр урсдаг. Шамбал, Агартийн орон нь лемурын соёл иргэншлийн үед болсон дэлхийн гамшигтай холбоотойгоор анх үүссэн бөгөөд цаашдаа дэлхий дээрх амьдралыг баталгаажуулах үүргийг гүйцэтгэдэг болжээ. Шамбал, Агартийн орон нь газар доогуур маш найдвартай байрласан учир сансрын, газар зүйн зэрэг ямар нэгэн гай гамшигт өртдөггүй. Шамбал, Агартийн орны амьдрал нь газрын гадарга дээрх амьдралаас олон дахин найдвартай хамгаалагдсан байдаг.

Шамбалын болон Агартийн орон нь доорх 2 үндсэн хэсгээс бүтнэ.


1. Хүн төрөлхтний Генийн сан.
2. Техникийн өндөр хөгжилт лемурчуудын соёл иргэншил.

Техникийн өндөр хөгжилт лемурчуудын соёл иргэншил нь Хүн төрөлхтний Генийн санг хамгаалах үүргийг гүйцэтгэдэг. Бодитжих болон эс бодитжих чадварынхаа тусламжтайгаар Шамбалын орны лемурчууд Хүн төрөлхтний Генийн сангийн янз бүрийн түвшинд үе үе ил гарч самадид буй хүмүүсийн биеийн байдлыг хянадаг байна. Чухам тэд л хүмүүсийг самадигаас газрын гадаргад гарахад тусалдаг.

Исүс Христ болон бусад Хутагт Гэгээнтнүүдийг сургасан шиг техникийн дэвшилтэд соёл иргэншлийн төлөөлөгч-лемур нь газар дээрх амьдрал байдлын талаар тодорхой мэддэгийнхээ хувьд самадигаас гарсан гэгээнтнүүдийг сургадаг байна. Газар дээр үзэгдсэн лемурчуудын соёл иргэншлийн нисдэг төхөөрөмжүүд нь газрын гадарга дээрх амьдралын явцыг техник, улс төр, биологийн болон бусад талуудаас нь байнга судалж байдаг. Эдгээр мэдээллүүдээ газар дэлхий дээр үйл ажиллагаагаа явуулж буй Хутагт Гэгээнтнүүдэд хүргэдэг.

Онцгой хүмүүсийг самади-агуйд оруулах эсэхийг шийддэг нууцлаг “Тэр”- гэгч бол техникийн өндөр хөгжилт соёл иргэншлийн төлөөлөгч мэт сэтгэгдэл төрж байна. Онцгой хүмүүс бидний таамналын лемурын зургийг хараад ихэд догдолж байсныг сар бүр самадид буй хүмүүсийн биеийг эргэх үүргээ гүйцэтгэдэг Онцгой хүмүүсийн өмнө тус зурган дээрх хүн гэнэт бодитжин бий болсоноор тайлбарлаж болно.

Тэдний харсаар дассан самадид хадгалагдаж буй хүмүүсийн дунд гэнэт газар доороос ургах мэт аврага биетэн гарч ирэхэд Онцгой хүмүүсийн сэтгэл хичнээн хөдөлдгийг төсөөлж болох.



«Тэр» (зохиогчийн зураг)

Бидний үзэж байгаагаар техникийн өндөр хөгжилт Шамбалын орны лемурчууд нь үе үе чулуун хөшингө идэвхигүй самадид орж Генийн санг дүүргэдэг бол харин лемурчууд Хүн төрөлхтний Генийн сангаас гарч газар доорх техникийн өндөр хөгжилт соёл иргэншилд нэгддэг байна. Өөрөөр хэлбэл Хүн төрөлхтний Генийн сан болон лемурчүүдийн газар доорх соёл иргэншлийн хооронд уялдаа холбоо ба харилцан шилжих үзэгдэл байдаг.

Техникийн өндөр хөгжилт лемурчуудын газар доорх соёл иргэншил нь Хүн төрөлхтний Генийн сангаас түүний идэвхит хэсэг болж дараах шалтгаануудын улмаас салбарласан байна.

- Хүн төрөлхтний Генийн сангийн илүү үр дүнтэй хамгаалах

- Лемурын соёл иргэншлийн технологийг (дэлхий дээрх хамгийн өндөр түвшний технологи) хадгалах хөгжүүлэх

- Газар дээрх хүний амьдралд нөлөөлөх Гэгээнтнүүдийн болон бусад нөлөөллүүдийг засварлах зорилгоор газрын гадарга дээрх амьдралын явцыг идэвхитэй судлах.

Ийм маягаар Хүн төрөлхтний Генийн сангийн болон техникийн өндөр хөгжилт газар доорх лемурчуудын соёл иргэншил нь газар дээрх зэрэгцээ амьдралын нэгдмэл цогцыг бүрдүүлнэ. Чухам үүнийг л Шамбалын орон болон Агартийн орон гэж буй юм.

Шамбалын орон болон Агартийн орон нь юугаараа ялгаатай юм бэ? Энэ талаар хоёр таамаг байх магадлалтай.

1. Шамбалын болон Агартийн орон нь хоорондоо газар зүйн зарчмаар ялгагддаг. Ном зохиолуудаас үзэхэд Шамбалын орон нь Төвд, Гималай болон ойролцоо орших бүс нутагт байрладаг. Харин Агартийн орон хаана байдаг юм бэ? Магадгүй Египетийн пирамид болон ойролцоо орших бүс нутагт (Арабын арал, Африк болон бусад) байрладаг байж магадгүй. Хүн төрөлхтний Генийн сан, техникийн өндөр хөгжилт лемурчуудын соёл иргэншлээс бүтсэн боловч байршлаараа өөр Шамбалын ба Агартийн орон гэсэн газар доорх хоёр их гүрэн байдаг гэж дүгнэж болно.

2. Хэрвээ Их Говийн өндөр хөгжилт соёл иргэншил нь Гималайн агуй руу ороходоо Шамбалын ба Агартийн гэсэн хоёр үндсэн салбар болон хуваагдаж, эхнийх нь буюу Шамбалын орон хүчин чадал, үл танигдах агуу хүчний төв болж байхад, хоёр дахь нь бясалгал болон сайн санааны нууц төв болдог гэсэн Фулегийн нийгэмлэгийн үзлийг үндэс болговол Шамбалын орон бол лемурчуудын техникийн өндөр хөгжилт соёл иргэншил бөгөөд Агартийн орон бол Хүн төрөлхтний Генийн сан юм гэсэн дүгнэлтэнд хүрч болно. Энэ тохиолдолд “Шамбалын орон ба Агартийн орон” (өөрөөр хэлбэл “лемурчуудын газар доорх соёл иргэншил+Хүн төрөлхтний Генийн сан”) нь Төвд ба Гималайд төвтэй бөгөөд тэндээс бүх дэлхийгээр тархдаг бололтой.



Дээрх хоёр таамналын аль нь зөв бол? Хэлэхэд хэцүү л юм. Гэвч юуг хэрхэн нэрлэж байгаадаа бус харин газар доорх зэрэгцээ амьдралын цогц ямар ч гэсэн оршдог л гол мөн чанар нь оршдог бөгөөд уг зэрэгцээ амьдралын үндэс нь Хүн төрөлхтний Генийн сан юм.

## **Тэд биднээс илүү хүчтэй**

Дээр өгүүлсэн Оросын нэг сүмийн хамба ламтай хийсэн ярилцлагын үеэр би Хүн төрөлхтний Генийн сан болон Шамбалын орныг элдэв халдлагаас хамгаалах хэрэгтэй гэсэн санааг илэрхийлж эхэлтэл хамба лам миний үгийг таслан:

- Тэднийг хамгаалах хэрэггүй. Тэд биднээс хүчтэй. Хамаагүй илүү хүчтэй...- гэсэн юм.

Тэр үед би хүний биеийг бодитжуулах болон эс бодитжуулах нөхцөл байдлыг шинжилж дүгнэлт хийгээгүй байсан болохоор маш олон зүйлийг ухаараагүй байсан юм. Би түүний үгийг эсэргүүцсэн зүйл хэлэхэд:

- Нарийн ертөнцийн энерги гэж юу болохыг та ойлгохгүй байх шиг байна,- гэж хамба хэлээд,- Энэ бол аварга том чулууг орон зайд харцаараа шилжүүлэн, бүх нийтийг ховсдон унтуулах гэх мэт ер бусын үйлдлийг бүтээж чадахуйц тэр хүчин чадал юм,- гэв.

Үүнийг сонсоод надад нэгэн эргэлзээ төрлөө. Хэрвээ Шамбалын орон биднээс илүү хүчтэй юм бол тэд яагаад газар доорх хөндий агуй зэргээс илүү амьдралын нөхцөл байдал сайтай газрын гадаргыг байлдан эзэлдэггүй юм бэ? Гэвч тэр үед миний сэтгэл зүй энгийн хүний ахуйн төсөөллийн хүрээнд байсан бөгөөд нууцлаг үл мэдэгдэхүй рүү шинжлэх ухааны хийсвэрлэх сэтгэхүйгээр нэвтрэн арай өөрөөр сэтгэх хэмжээнд хүрээгүй байлаа. Шамбалын орны хүчин чадлын талаар хамбын хэлсэн үг нь миний төсөөлөлд лемурчууд манай иргэншлийн эсрэг аймшигт дайн хийж байна гэж төсөөлөхөд хүргэв.

Тэгвэл техникийн өндөр хөгжилт Шамбалын орны лемурчуудын бидний эсрэг хийж буй дайныг төсөөлөхийг оролдоцгооё. Энэ нь бидэнд Шамбалын орны үнэн хүчин чадлыг ойлгон ухамсарлахад туслах болно.

Аль нэг улс, жишээ нь оросын аль нэг хотод, жишээ нь Москва хотын төвд, Улаан талбайд, хүн ард олноор цугларсан үед, жишээ нь улс тунхагласны баяраар, газраас ургаж буй мэт 7-10 метрийн өндөртэй, ер бусын дүр төрхтэй аврага хүн гэнэт гарч ирчихээд (бодитжин) байна хэмээн төсөөлцгөөе. Бүх хүмүүс цочирдолд орно. Аврага биетэн эргэн тойрноо тойруулан хараад, харцаа нэгэн зүйл дээр, жишээ нь Лениний бунхан дээр тогтооно.Түүний харц нь хүндрэн, хүмүүс ямар нэгэн ер бусын хүчийг мэдрэхэд уг бунханы хананаас нэгэн хэлтэрхий нуран унаж, дараа нь бунхан хөзрөн байшин мэт нурж унахыг харах болно. Аварга биетэн харцаараа гантиг хананы нэгэн хэсгийг өргөн, олон тонн жинтэй

энэ чулуугаараа агаарт хэсэг наадсанаа харцаа шилжүүлэхэд чулуун хананы хэлтэрхий хүмүүсийг даран Улаан талбайд нүргээнтэйгээр унана.

Дараа нь аврага биетэн өөрийг нь цоо ширтэн буй хүмүүсийн харцыг мэдрэн, тэдэн рүү харахад хүмүүс үл ойлгогдох шалтгаанаар биеэ сулралыг мэдрэн газарт унаснаа тэр дороо унтаад өгцгөөнө. Кремлийн хамгаалалтын албаны нэгэн хүн аврагыг буудахаар гар буугаа чиглүүлэхэд аврага биетэн агшин зуурын дотор мэдээд (бодлыг нь уншиж) түүн рүү харахад өнөө муу аз муут нөмөрт нь зогсож байсан ханатайгаа цуг агаарт цацагдах болно. Дуудагдан ирсэн цэргийн хороо аварга биетний харсан даруйд л сахилга дэг журмаа алдаж, хамгаалалтын тоног төхөөрөмжийн хамт нэгэн үл мэдэгдэх хүчний нөлөөгөөр хол шидэгдэнэ. Хуягт танкууд эгээ л өд мэт агаарт эргэлдэн байшин барилгыг нураан дээрээс нь унах болно. Хэргийн газар ирсэн нисдэг тэрэгний нисэгчид тэдний нислэгийн тоног төхөөрөмж нь хүчтэй соронзон орны урсгалд орсон мэт ажилгүй болохыг анзаарна. Удалгүй нисгэгчид толгойн өвчин, биеэ маш хүчтэй сулрахыг мэдэрнэ. Нисдэг тэрэгнүүд байшин барилга дээрээс унаж дэлбэрнэ. Харин аврага биетэн үйл явдал хэрхэн өрнөхийг тайвнаар ажиглаж талбайн голд зогссоор л байх болно. Газарт хэвтэж буй хүмүүсийн нэг нь толгойгоо өндийлгөн харвал аврага биетэн хэд алхсанаа бие нь хөвчрөн ул мөргүй алга болохыг үзнэ. Гагцхүү газар хэвтээ хүмүүс, нурж сүйдсэн байшин барилга, дүрэлзэн асах гал л түүнийг энд ирсэний гэрч болон хоцроно.

Аврагууд дэлхийн бөмбөрцгийн янз бүрийн хотод үе үе үзэгдэж хүмүүсийн дунд аймшиг, эмх замбараагүй байдлыг үүсгэх болно. Үй олноор ховсдох арга хэрэглэж, бүхэл бүтэн улс орноор нь ховсдох болно. Аврагуудыг дийлэх гэсэн цэргийнхний бүх оролдлого үр ашиггүй болно. Учир нь аврагас гэнэт бий болох, гэнэт алга болох чадвартай нь хотуудад хамгаалалт босгох боломжгүй болгож байгаа бөгөөд зэвсэглэсэн дайралт нь үргэлж ялагдал хүлээх болно. Цэргийнхэн бодол санаа нь агшин зуурын дотор уншигдаж байгаагаас шалтгаалан эмх замбараагүй байдал үүсч, зэвсгийн хүчийг үл мэдэгдэх нэгэн хүчин үгүй болгож, аврагуудыг дайрах дайралт зохион байгуулахад тэд нууцлаг байдлаар алга болж буйг ажиглах болно.

Цаашилбал хотуудын, ялангуяа цэргийн байгууламжууд дээр хэлбэр дүрсээрээ тавагтай төстэй нисдэг төхөөрөмжүүд үзэгдэнэ. Эдгээр нисдэг төхөөрөмж нь агаарт тогтон цахилгаан эрчим хүчээр ажилладаг тоног төхөөрөмжид нөлөөлнө. Эдгээрэс ялгарч буй үл мэдэгдэгч энергийн нөлөөнд машин, галт тэрэг, усан онгоц, нисэх онгоцны хөдөлгүүр унтарч, байшингуудын гэрэл тасран, эмнэлгийн тоног төхөөрөмж болон цахим тооцоолуурууд эвдэрч, цахилгаан станцын үйл ажиллагаа зогсож, байшин барилга халаалтгүй болно. Удирдлагагүй болсон цахилгаан станцууд газар дэлхийг хорт хаягдлаараа бохирдуулан дэлбэрч эхлэнэ. Аврагуудын нисдэг төхөөрөмжийг пуужингийн тусламжтайгаар сөнөөх бүхий л оролдлого талаар болно. Учир нь пуужин нь

энергийн орны хүчтэй нөлөөнд орж хазайна эсвэл чиглэсэн энергийн туяагаар устгагдах болно. Аврагуудын нисдэг төхөөрөмж асар хурдтай үедээ гэнэт чиглэлээ өөрчлөн нисэх чадвар нь тэднийг оновчтой буудахад хүндрэл үүсгэнэ. Мөн эдгээрийн гэнэт алга болж, гэнэт бий болох чадвар нь (бодитжих, эс бодитжих) дайны үйл ажиллагаанд гэнэдүүлэх чухал үүрэгтэй байна. Аврагуудын нисэх төхөөрөмжийн суурь байршлыг олох боломжгүй нь (газар дээр) тэдэнтэй тэмцэхэд ялагдал хүлээх бас нэгэн хүчин зүйл болно.

Аврагуудын нисэх төхөөрөмжийн тоо олширч, тун удалгүй манай гаригийн эрчим хүчний бүхий л цогцолбор үйл ажиллагаагүй болж зогсоно. Цөмийн хүчин чадал устгагдана. Галт тэрэг нисдэг онгоцнууд явахаа больж, өвчтөн эмчлэгдэхгүй, эрдэм шинжилгээ судалгааны ажил зогсож бүхий л үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зогсож хүмүүс лаагаар орон байраа гэрэлтүүлж, юу олдсоноо түлэх болно. Өлсгөлөн өвчин зовлон эхлэнэ. Хүмүүс сая саяараа амь үрэгдэж, амьд үлдсэн хүмүүс аажимдаа зэрлэгшсээр хэдэн үеийн дараа хүн төрөлхтөн цөөхөн хэдэн хагас зэрлэг омог болж хувирна.

Манай иргэншил устан үгүй болох болно. Бодит ертөнцийн мэдлэг дээр тулгуурласан бидний ололт амжилт нарийн ертөнцийн хуулинд тулгуурласан тэдний ололтыг эсэргүүцэх чадваргүй. Нарийн ертөнцийн энерги нь хавьгүй хүчирхэг. Манай соёл иргэншлийг устгахад лемурчууд ямар ч хохирол амсахгүй. Тэд биднээс хамаагүй илүү хүчирхэг юм.

Шамбалын орны техникийн өндөр хөгжилт лемурчууд бидний соёл иргэншил рүү дайрах магадлал бий юу? Хүчтэй нь хүчгүйгээ дийлдэг байгалийн жамаар үүнийг үгүйсгэх аргагүй юм. Гэсэн ч энэ асуудлыг түүхийн үүднээс авч үзэцгээе!

Лемурчуудын соёл иргэншил олон сая жилийн өмнө Ертөнцийн Мэдээллийн Орны мэдлэгт тулгуурлан үүсч хөгжиж эхэлсэн. Учир нь тэр үед "SoHm"-ын зарчим байгаагүй. Өөрөөр хэлбэл лемурчууд хөгжил цэцэглэлдээ Нөгөө Ертөнцийн буюу нарийн ертөнцийн мэдлэгийг ашигладаг байсан. Тийм ч учраас тэд юуны түрүүнд нарийн ертөнцийн энергийг эзэмшсэн байгаа. Лемурчуудын соёл иргэншил нь газар дэлхий дээр дайнгүй хөгжлийн хамгийн урт хугацааг туулсан тул тэд хамгийн дээд түвшний хөгжилдөө хүрчээ. Гэсэн ч өндөр соёл иргэншлийн хэвлийд сөргөлдөөн үүсч, нарийн ертөнцийн энергийг ашигласан дайн болон өргөжсөн юм.

Тэд нөгөө Ертөнцийн ариун мэдлэгийг бүтээх босгохын тулд бус харин сүйрэл сүйтгэлийн тулд ашигласнаар агуу том нүгэл үйлдэх нь тэр.

Бүх дэлхийн гамшгаас сэрэмжилж, сэтгэл оюуны хувьд арай илүү хөгжсөн лемурчууд агуйд самадийн байдалд орж, Хүн төрөлхтний Генийн санг үүсгэв. Тэдний шилдэгүүд нь хүний биеийн бодитжих болон эс бодитжих үзэгдлийг эзэмшсэн байсан бөгөөд лемурын соёл иргэншлийн техникийн ололт амжилтыг хөгжүүлэн хадгалах болон бий болсон Хүн төрөлхтний Генийн санг хамгаалах зорилготойгоор газар доор техникийн өндөр хөгжилтэй иргэншлийг байгууллаа.

Газар доорх лемурчууд биеийн эсүүдээ шинэчлэх үзэгдлийг эзэмшсэнээр бараг мөнх амьдралтай болов. Ингэж Шамбалын болон Агартийн орон бий болсон байна.

Дэлхийн гамшгийн дараа Лемурын соёл иргэншил мөхөхөд Шамбал, Агартийн орны лемурчууд (“Бурхны Хүүдүүд”) атлантын соёл иргэншлийн хөгжилд нөлөөлж байсан байна. Атлантчуудын сэтгэл оюуны хөгжил хангалттай хэмжээнд хүрч, зарим атлантчууд Хүн төрөлхтний Генийн Санд орж эхлэхэд Шамбал, Агартийн орны лемурчууд эртний Лемурын мэдлэгийг нээж өгч эхэлжээ. Эдгээр мэдлэгийн үндсэн дээр атлантын соёл иргэншил хурдтайгаар хөгжиж эхэлсэн боловч бас л хоорондын сөргөлдөөнөө дайн дажингүй аргаар шийдвэрлэж чадсангүй. Нөгөө Ертөнцийн ариун мэдлэгийг муу муухайн төлөө ашигласан аймшигт нүгэл дахин үйлдсэний улмаас атлантын соёл иргэншлийг мөхөлд хүргэсэн дэлхийн гамшиг тохиолдлоо.

Хоёр ч давтагдсан энэ их нүгэлийг авч үзсэний үндсэн дээр Дээд Оюун Ухаан тав дахь иргэншилд Нөгөө Ертөнцийн мэдлэгийг хаасан “SoHm”-ын зарчмыг нэвтрүүлжээ. Шамбалын болон Агартийн орны лемурчууд Хүн төрөлхтний Генийн сангаас гарч буй Хутагт Гэгээнтнүүдийг ашиглан манай соёл иргэншлийг зөв замаар хөтлөхийг хичээж байсан ба хичээсээр ч байх болно.

Гэвч атлантчуудаас болж хэрэгжсэн “SoHm”-ын зарчимын улмаас бид бие даан Ертөнцийн Мэдээллийн Оронд нэвтэрч, Нөгөө Ертөнцийн мэдлэгийг ашиглаж чадалгүй хоцорсон. Бид бүхлээрээ Шамбалын, Агартийн орноос шалтгаалдаг. Тэд бидэнд эртний мэдлэгийг хэдий хир нээж өгнө, төдий хирийг л бид мэдэх болно. Манай соёл иргэншил нь атлантын соёл иргэншлээс ч илүү Шамбалын болон Агартийн соёл иргэншлээс хамаардаг болов.

Дээрхээс үндэслэн манай иргэншил нь атлантчуудын соёл иргэншлийн нэгэн адил Шамбалын болон Агартийн орны үр төл юм гэсэн дүгнэлт хийж болно. Хэн өөрийнхөө хүүхэдтэй дайтах билээ? Хэн ч тэгэхгүй.

Шамбалын болон Агартийн оронд газрын гадарга дээрх хүн төрлөхтний соёл иргэншлүүдийг зохицуулах, Хүн төрөлхтөний Генийн ариун санг хамгаалах зэрэг дэлхий дээрхи амьдралыг удирдах онцгой үүрэг ноогддог. Шамбалын орны техникийн өндөр хөгжилт лемурчууд өөрсдийн агуу ихэмсэг мөнхийн амьдралыг газар дэлхийн энгийн амьдралаар хэзээ ч солихгүй нь ойлгомжтой. Тийм ч учраас лемурчууд хэзээ ч бидэнтэй дайтахгүй.

## **Шамбалын орныг олж болох уу?**

Биднийг Трансгималайн шинжилгээний ангиар явахаар завдаж байх үед маш олон хүн биднээс:

- Шамбалын орныг олохоор явж байгаа юм уу?- гэж асууж байлаа.

Шинжилгээний ангийн ажлын явцад Хүн төрөлхтний Генийн сан байдаг гэсэн дүгнэлтэнд хүрэх үедээ бид Шамбалын орон бол Хүн төрөлхтний Генийн сан юм

гэж бодсон. Гэвч хэд хэдэн ном зохиол болон нэмэлт мэдээ баримтуудыг судалснаар Хүн төрөлхтний Генийн сан гэдэг бол Агартийн болон Шамбалын орны нэгэн хэсэг төдий л (үндсэн) бөгөөд Шамбал, Агартийн орон нь үүнээс гадна Хүн төрөлхтний Генийн сангийн идэвхитэй хэсэг болох техникийн өндөр хөгжилт лемурчуудын соёл иргэншлийг багтаадгийг, Шамбал, Агартийн орнууд нь газрын дээрх амьдралын бүхэл бүтэн цогц юм гэдгийг ойлгосон.

Миний бодлоор бол Шамбалын орныг эрж олох боломжгүй юм. Энэ нь бидний дээр ч, доор ч, дэргэд ч оршиж нууцлаг битүүлгээр бидэнтэй зэрэгцээгээр амьдран биднийг судалсаар байна. Шамбалын оронд очих (“зочлох”) боломжгүй. Учир нь өндөр хөгжилт лемурчуудын газар доорх соёл иргэншлийн хувьд бид дэлгэсэн ном шиг илэрхий учир тэдэнд бид хэрэггүй. Бардам зангаа ардаа орхин хэлэхэд манай иргэншил оюуны болон технологийн хөгжлөөрөө чулуун сүхээр зэвсэглэсэн балар эртний хүнээс бид ялгардаг тэр хэмжээгээр Шамбалын орон биднээс ялгардаг.

Шашины өгүүлж буйгаар бол хэзээ ч юм “Алтан зуун” буюу Үнэний зуун болж хэзээ ч юм лемурчуудын соёл иргэншлийн агуу байдлыг тодорхойлоод зогсохгүй, атлантчуудын соёл иргэншлийг хүчирхэгжүүлсэн Шамбал болон Агартийн оронд ариунаар хадгалж буй Лемурын эртний мэдлэг нээгдэж эхлэх юм. Гэсэн ч эдгээр мэдлэг ч гэсэн атлантчуудыг лемурын гайхамшигт технологийг муу үйлд, нэр төрийн тулд ашиглахыг зогсоож чадаагүй бөгөөд энэ нь тэдний соёл иргэншлийг мөхөлд хүргэснийг Шамбалын болон Агартийн орон тооцож үзэх нь лавтай.

Энэ “алтан зуун” ирэх болов уу? Бүх юм биднээс л шалтгаална. Хэрвээ бид энгийн уриа болох “цэвэр ариун сэтгэлтэйгээр амьдрах хэрэгтэй”-г амьдралдаа ойлгож чадах юм бол, цэвэр ариун сэтгэхүй бидэнд суурьшин төлөвшиж бидний оршихуйн үндэс нь болж чадваас бидний хэн нэг нь (магадгүй ихэнх нь) Шамбалын оронд нэвтэрч, тэнд ертөнцийг сууриар нь өөрчлөх чадвартай ер бусын мэдлэгийг олж аван, ирээдүйн гайхам ертөнцийг нүдээрээ харах болно. Дахин хэлэхэд Шамбалын орон биднийг судалж, бидний талаар бүгдийг мэддэг учир Шамбалын орны гайхам технологид хүрэх цорын ганц зам бол бүгдээрээ цэвэр ариун сэтгэлтэй байж, сайн сайхныг санаж бодсоноор тэдний итгэлийг олох явдал юм.

Самади-агуйд биеэрээ амссан сэтгэлийн энергийн саадыг Шамбалын орон илгээсэн мэт санагдаж байна. Би Шамбалын орныг үзээгүй ч түүний хүчин чадлыг нь мэдэрсэн юм. Хэрвээ чи цэвэр ариун санаа бодолтой л бол Шамбалын оронд нэвтэрнэ гэж бодох нь буруу. Шамбалын орон нь олон нийтийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Газрын гадарга дээрх энэ агуу ертөнцөд олон түмний хүсэл тачаал, шунахайрлын дунд нэг хүн юуг ч төлөөлөн шийдэхгүй. Хэрвээ Шамбалын орны зарим мэдлэг нэгэн хүний гарт орж шинэ технологи боловсрууллаа гэхэд тагнуул туршуулын үйл ажиллагаа эхэлж, цэргийнхэн ятгасаар... шинэ технологи

нь аймшигт шинэ зэвсэг болж хувирна. Шамбалын орон атлантидын гунигт туршлагыг санан нууцаа газар дэлхий дээр бүх нийтийн сайн санаа, сайхан сэтгэл ялан дийлтэл ариунаар нь хадгалах болно.

Бид үүнд хүрч чадна гэж үү? Би мэдэхгүй байна. Харин одоохондоо Шамбалын орон газар дэлхий дээрх амьдралыг баталгаажуулж буй юм. Техникийн өндөр хөгжилт газар доорх лемурчуудын соёл иргэншил нь бидэнд итгэхгүй бөгөөд одоогоор бидний дунд цэвэр ариун сүнс маш бага байгаа учир Хүн төрөхтний Генийн сангаа хамгаалах ариун үүргээ биелүүлж буй юм.

Одоохондоо гагцхүү шинжлэх ухааны хийсвэрлэх аргаар л Шамбалын орон гэж юу болхыг тааварлан суух учиртай. Гэвч бодол санаагаараа тааварлан ойлгосон маань ч гэсэн бид газар дээр цор ганцаараа бишийг, бидэнтэй зэрэгцэн өөр амьдрал урссаар байдгийг, сайн санаа болон сэтгэлийн цэвэр ариун байдал нь хөгжилт цэцэглэлтэнд хүргэнэ гэдгийг урхамсарлуулснаараа үр дүнгээ өгнө.

Шамбалын орны хүмүүс болор мэт цэвэр тунгалаг сэтгэлтэй байдгийг санах хэрэгтэй. Шамбалын орны үл үзэгдэгч хүч гэдэг бол хүний болор тунгалаг сэтгэлийн хүч юм.

Харин Шамбалын орныг ямар нэгэн археологийн олдвор мэт олно гэдэг нь боломжгүй зүйл. Шамбалын орон түүнээс дээгүүр оршдог.

Дөрөвдүгээр хэсэг

## Газар дэлхий дээрх хүн төрөлхтний түүх

Өмнөх бүлгүүддээ би үе үе энэ асуулттай тулгарахдаа шашин, Хутагтуудын баримт нотолгоо (Е.П.Блаватская, Л. Дамба), лам свами нараас авсан мэдээллүүд зэрэг янз бүрийн эх сурвалжийг иш татсан билээ. Тийм ч учраас уншигчид хүн төрөлхтний үүсэл гарал, хөгжлийн тухай тодорхой төсөөлөлтэй болсон байх.

Эдгээр төсөөлөл нь бидний дунд сургуульд үзэж байсан түүхийн хичээлээс үндсээрээ ялгаатай буйг уншигч та анзаарсан биз ээ. Бидний шинжилж үзсэн бүх эх сурвалжаас “Хүн нь анх сүнс нягтарших замаар үүссэн. Газар дэлхий дээр таван үндэстэн байсан бөгөөд дараачийн иргэншил нь өмнөх иргэншлийнхээ хэвлийд үүсч аажимдаа түүнийг халдаг нь” тодорхой байна. Энэ бүлгийг бичихдээ материализм идеализмын хоорондын хүний үүслийн талаарх мөнхийн маргааныг шинжлэхийг зорилго болгосонгүй. Орчин үеийн шинжлэх ухаан хүнийг сармагчнаас үүссэн хэмээдэг Дарвины онолын хэт бүдүүлгийг, шашин гэдэг бол эртний мэдлэгийг үлгэрлэн буулгасан зүйл гэдгийг ойлгож, шашныг шинжлэх ухааны түвшинд хүлээн авах түвшинд хэдийнээ хүрчихээд байна.

Энэ бүлэгтээ би газар дэлхий дээрх хүний үүсэл хөгжлийг ертөнц үүсэхээс эхлээд өнөөдрийн өдрийг хүртэл товч буулгахыг хүслээ. Аль нэгэн хэсэгтээ алдаж, хаа нэгтээ онох л байх. Алаг цоог баримтууд дээр үндэслэсэн түүхэн судалгааны хувь заяа ийм байдаг гэлтэй.

### **Ертөнцийн үүсэл, хүний хөгжил**

Эртний хүмүүс материйг хоосноос үүссэн гэж үздэг байжээ. Оросын суут физикч, физикийн вакуум буюу абсолют хоосон (Абсолют)-ийг илэрхийлэгч томъёг гаргасан Геннадий Шипов

үүнтэй санал нэг байна. Мөн саналыг бидний шинжилгээний ангийн нэг гишүүн орны физикийн мэргэжилтэн, техникийн ухааны дэд эрдэмтэн Валерий Лобанков хуваалцаж буй юм. Валерий Лобанков бид хоёр энэ талаар маш их ярилцаж байсан юм. Юу ч биш гэдэг бол Юугаар ч юм бэ дүүргэгдсэн хоосон орон зай юм. Юугаар дүүргэгдсэн нь одоогоор шинжлэх ухаанд тодорхойгүй байгаа юм. Г.Шиповын үзэж байгаагаар бол бөөм болон эсрэг бөөм нь Абсолютаас үүсдэг. Үүсээд мөргөлдсөний улмаас харилцан устгагддаг. Ингэж Абсолют өөрийн тэнцвэрт байдлаа хадгалдаг. Гэвч олон сая жилд нэг л өдөр үүссэн бөөм, эсрэг бөөмүүд нь орон зайд тархах мөч ирдэг. Ингэж Абсолютаас бодит матери үүсдэг.

Мөн замаар Абсолют хоосноос торсын (эргэсэн) болон антиторсын (эсрэг эргэсэн) хэт өндөр давтамжийн орнууд үүсч, харилцан устгагдаж, Абсолютын тэнцвэрийг хадгалж байдаг. Харилцан бие биеэ устгадаг эдгээр торсын орон сарних мөч ирнэ. Ингэж Абсолют хоосноос нарийн ертөнц үүснэ. Г.Шиповын таамгаар бол нарийн ертөнцийн торсын орнууд болон ухамсарын хооронд шууд холбоо оршдог. Учир нь торсын орнууд нь сүнс болон сэтгэлийн бодит зөөгч нь болдог. Үүнээс үзэхэд Абсолют хоосноос бодит болон нарийн гэсэн хоёр ертөнц үүссэн.

Аажимдаа бодит ертөнцийн бүтэц нийлмэл болж од эрхэс, гариг, галактик гэх мэт зүйлс үүсжээ.

Янз бүрийн торсын орноос тогтсон нарийн ертөнцийн бүтэц ч мөн нийлмэл болсон. Ямар замаар нарийн ертөнц нийлмэлжиж төгс төгөлдөр болсныг хэлэхэд төвөгтэй.

Гэвч орон зайд эргэлтийн орны (торсын орон) мэдээллийн эзлэхүүн цаг улирах тутам улам нэмэгдэж байлаа. Өөрөөр хэлбэл илүү их мэдээллийг өөртөө багтаах чадвартай болжээ.

Магадгүй (геометрийн үүднээс авч бодох юм бол) олон үетэй торсын орнууд үүсэх боломжтой. Магадгүй торсын орны нийлмэлжилт нь өөр шинжтэй байсан байж ч болно. Түүхэн хувьслын явцад нарийн ертөнцөд сүнс бий болохдоо асар их хэмжээний мэдээллийг өөртөө багтаах чадвартай торсын орны бөөгнөрөл үүсгэжээ. Олон зуун сүнс хоорондоо мэдээллийн холбоо тогтоосноор Ертөнцийн Мэдээллийн орон буюу бидний бурхан хэмээдэг удирдлагын төв болох Нөгөө Ертөнц бий болжээ.

Ингэж нарийн ертөнцөд амьдрал үүсжээ. Нарийн ертөнцөд төгөлдөржих, хадгалагдах, зөөгдөх үйл явц ид өрнөж байхад зэрэгцээ орших бодит ертөнц үхмэл, өнгөгүй байсаар байлаа.

Үүссэн амьдрал оршихуйн шинэ шинэ газрыг эзлэн тархахыг оролдоно. Бодит ертөнц дахь амьдралыг эзлэхийн тулд нарийн ертөнцийн торсийн оронгийн амьдралын хэсгийг бодит ертөнцийнх мэт нягтаршуулах шаардлагатай. Ингэж сүнс нягтаршин бодит ертөнцөд хүний бие махбодь үүсжээ.



Амьдралын аль ч хэлбэр үүсэхэд үе дамжуулан мэдээллийг хадгалах, уламжлуулах явдал үндсэн үүрэг болдог.

Бодит ертөнц дэх хүний бие махбодид энэ үйл ажиллагаа нь генийн цогцын тусламжтайгаар, магадгүй эдийн доторх усны тусламжтайгаар явагддаг. Миний бодлоор бол генийн цогц (эсвэл ус?) нь хүний биеийн бүтэц зүйн талаарх мэдээллийг үе дамжуулан уламжлуулах чадвартай ДНХ-ийн молекулыг бий болгож бөөмсийг зохион байгуулах боломжтой торсын орнуудаас тогтсон сүнсний мэдээллийн багтаамж (эзлэхүүн) ихтэй хэсэг нь нягтаршсаны дүнд үүссэн.

Цорын ганц эр бэлгийн эс болон өндгөн эсэд хүний бие махбодын эс болгоны, молекул болгоны бүтцийн тухай мэдээлэл хадгалагддаг генийн аппаратыг нягтаршлийн замаар үүсгэх чадвартай сүнсний нарийн нийлмэл бүтцийг төсөөлж болохуйц юм.

Хүний бие махбодыг бүхлээр нь генийн цогцыг нарийн ертөнцийн энергийн тусламжтайгаар бүтээж чадсан нарийн ертөнцийн амьдралын хэлбэр хичнээн төгс төгөлдөр, түүхэн хувьслын хувьд хичнээн эртнийх болох нь ойлгомжтой. Эртний хүмүүс хүн бол макрокосмын микрокосм (хүн бол ертөнцийн бичил хувилбар) юм гэж ярьдаг нь учиртай.

Нарийн ертөнцийн хүчин чадлаар хүн үүссэнтэй зэрэгцэн бодит ертөнцөд амьдралын энгийн хэлбэр болох амьтан, шавьж, ургамал зэрэг ч мөн үүсч байжээ. Амьтны болон ургамлын ертөнцийн үүслийн зарчим ч ялгаагүй Нөгөө Ертөнцийн энгийн торсын орнууд нягтарших замаар үүссэн.

Хүн бодит ертөнцдөө Нөгөө Ертөнцгүйгээр амьдарч чадах уу? Сүнс генийн цогцыг бүтээн, түүнийхээ тусламжтайгаар газар дэлхий дээр хүний хөгжлийн үйл явцыг эхлүүлмэгцээ гол сэтгэн бодох үүргийг нь үлдээсэн бололтой. Шашны нотолж буйгаар бол хүүхэд төрөх үед түүнд сүнс нисэн орж уг хүний сэтгэн бодох чадварыг тодорхойлдог... Өөрөөр хэлбэл бид нарийн ертөнцөд оршин буй сүнснийхээ тусламжтайгаар сэтгэдэг. Хүний тархи нь бодит ертөнцийн энергийг (хоол хүнс) ашиглаж нарийн ертөнцийн торсын орныг эргүүлж сүнсний сэтгэн бодох үйл ажиллагаанд тусладаг. Үүнээс гадна тархи нэмэлт торсын орныг цуглуулан сүнсийг астрал, ментал, эфир болон бусад бие болгон хувиргадаг. Эдгээр биеүд нь хүний бие махбодын үйл ажиллагаанд оролцдог байна. Бие махбодын үхлийн дараа сүнсний бүтцийн ихэнх хэсгүүд (астрал, ментал, эфир болон бусад) устаж үгүй болон сүнс нь Нөгөө Ертөнц рүү нисэн одож, дахин шинэ бие махбодод орохоо хүлээн тэндээ үргэлжлэн амьдардаг. Ингэж нарийн ертөнцийн “хүчин зүтгэлээр” бодит ертөнцөд үүссэн хүн нь бодит болон нарийн ертөнцийн амьдралын хэлбэрүүдийн цогц болдог.

Карма буюу өмнөх амьдралуудаас үлдсэн “үйлийн үр”-ийн тухай ойлголт хүн бүхэнд байдаг. Бодит ертөнцөд газрын амьдралын үе шатыг өнгөрүүлж буй сүнс хөгжиж төгс төгөлдөржиж ч болно, доройтож ч болно. Сайн санаа, шинжлэх

ухааны ололт амжилт зэрэг нь сүнсийг төгөлдөржүүлж, муу санаа, залхуурах, зүгээр суух зэрэг нь сүнсийг доройтоход нөлөөлдөг. Чухам сэтгэн бодох цогц сүнсийг төгөлдөржүүлснээр нарийн ертөнц дэх амьдралын хэлбэрийг мөн төгөлдөржүүлэх үүрэгтэйгээрээ л хүн амьтнаас ялгардаг. Өөрөөр хэлбэл хүн гэдэг бол бодит ертөнц дэх нарийн ертөнцийн үр төл бөгөөд бодит ертөнцөөр дамжуулан нарийн ертөнцийн хөгжилд нөлөөлөх үүрэгтэй. Үүний тулд л түүнийг бүтээсэн билээ.

Нарийн ертөнц дэх амьдралын хэлбэр нь (Нөгөө Ертөнц) бодит ертөнц дэх амьдралын хэлбэртэй харьцууламгүй дээд түвшинд байдаг нь маргаангүй. Сүнс үхэшгүй мөнх гэдэг нь л үүний баталгаа болж чадах юм. Хэрвээ хүний бие махбодын амьдралын хугацаа 70-80 жил биш, харин 1000-2000 жил байсан бол бодит ертөнцөөр дамжин сүнс төгөлдөржих нь илүү боломжтой байхсан. Учир нь нэг биеийг орхин нөгөө биед шилжих үйл явц нь удаан хугацааны туршид сэтгэн бодох идэвхи багатай үе шаттай (хүүхэд нас, хөгшрөлт) холбоотой байдаг юм. Тийм учраас бодит ертөнц дэх амьдралын хэлбэрийн хөгжил нь хүний нас уртсах замаар явагдах бололтой. Үнэхээр ч хэдэн зууны өмнө хүний дундаж наслалт 30-40 жил байсан бол одоо 70-80 жил болж уртасжээ.

**Амьдралын хугацааг хэрхэн уртасгах вэ?** Сайн сайхан, хайр ивээл болон мэдлэгийг шүтэх аргаар урт наслалтанд хүрч болно гэсэн хариулт хачирхалтай санагдаж болох юм. Дашрамд хэлэхэд бүх шашин, аваторууд ( Саи Баба) чухам үүнийг л номлодог билээ. Анх харахад хайр ивээл, сайн санааны талаарх эцэс төгсгөлгүй яриа нь зарчимын хувьд утгагүй мэт санагдаж болох боловч үүнд агуу утга учир оршдог. Сайн санаа болон мэдлэг нь нарийн ертөнцийн торсын орныг хөгжилд, зүгээр суух болон хорон муу санаа нь доройтолд хүргэдэг гэсэн зарчмаар Нөгөө Ертөнц зохион байгуулагдсан. Амьдралыг үхлээр байн байн солих нь амиа бодсон муу санаатай сүнсийг Нөгөө Ертөнцөд “шийтгэл ноогдуулсны” хүчинд дараа дараачийн реинкарнацын үед дээрдэж, тус сүнсийг сайхан сэтгэлтэй болгон өөр хүнээр бушуухан солих эрмэлзэлтэйгээр явагддаг. Тийм ч учраас там, диваажингийн тухай домог яриа нь үнэний хувьтай бололтой.

Хэдэн зууны өмнөх хүн төрөлхтөнд бүх нийтийг хамарсан муу муухай нь одоогийнхоос их байсан нь ойлгомжтой (эцэс төгсгөлгүй дайн тулаан, галд шатаах шийтгэл, цаазаар авах г.м.) зүйл. Энэ нь хүний дундаж наслалт нэмэгдсэнээр илэрсэн. Гэвч гол үүргийг ганц нэгэн сайн санаат хүн гүйцэтгэхгүй. Сайн санаа хорон муу үйлийн талаарх бүр нийтийн сэтгэл зүй маш их үүрэг гүйцэтгэдэг. Тийм ч учраас “муу сүнсийг шийтгэхээр” амьдралыг үхлээр байн байн солих нь Нөгөө Ертөнцийн хууль биз ээ. Ингэж Нөгөө Ертөнц сүйрлийн хүчин чадалтай сэтгэлийн сөрөг энергийн нөлөөнөөс өөрийгөө хамгаалдаг.

Ертөнцөд “бүх нийтийн сайн сайхан” нэмэгдэх үйл явц өсөж байгаатай холбоотойгоор дундаж наслалт нэмэгдэж байгаа мэт сэтгэгдэл төрж байна. Нөгөө Ертөнц сайн сайхны тэнцвэрт байдалд маш мэдрэгээр хариу үйлчилж хүний дундаж наслалтыг нэмэгдүүлдэг байна.

Миний бодлоор Дэлхий дээрх хамгийн өндөр хөгжилтэй соёл иргэншил болох лемурын соёл иргэншилд юуны түрүүнд сайн сайханд, мэдлэгт тэмүүлэх үзэл давамгайлж байснаас хөгжлийн замаар тууштай урагшилж байсан. Тийм ч учраас тэдний дундаж наслалт нь 1000-2000 жил байсан бололтой. Лемурчуудын “бүх нийтийн сайн сайхан, цэвэр ариун сэтгэл” нь Нөгөө Ертөнцөөс тэдний дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд хүргэсэн бөгөөд урт удаан амьдралын туршид сүнс төгөлдөржих боломж ихтэйгээрээ утга төгөлдөр юм.

Сэтгэлийн сөрөг энергээс бүрэн ангижрах нь мөнхжүүлэгч гүн самадид орох нэгэн нөхцөл болдогийг бид мэднэ. Гэвч идэвхгүй самадийн (чулуун-хөшингө байдлын) үед уг хүний бие нь идэвхгүй байдалд буй учир сүнсний түргэн төгөлдөржилт явагддаггүй. Идэвхитэй самадийн үед (100,200, 300 жил амьдарч буй бөгөөд бидний үзэж буйгаар биеийн эсүүд байнга шинэчлэгдэж байдаг) сүнс арай л хурдацтай төгөлдөрждөг боловч, ямартай ч лемурчуудынхаас бага хөгжилтэй байх болов уу.

Бидний үзэж буйгаар сэтгэлийн цэвэр ариун байдал, мэдлэгт тэмүүлэх идэвхээрээ бараг үхэшгүй мөнхийн амьдралыг бий болгосон Шамбалын болон Агартийн орны лемурчууд нь хүний хөгжлийн оргилд хүрчээ. Тэд идэвхитэйгээр бодит ертөнцийн амьдралд ч оролцож сүнс төгөлдөржихөд Нөгөө Ертөнцөд маш том хувь нэмрийг оруулдаг. Шамбал, Агартийн орон нь газар дэлхий дээрх хамгийн хөгжилтэй соёл иргэншлийн шилдэгүүдээс тогтдог нь учиртай юм. Дээд Оюун Ухаан газар дэлхий дээрх дараа дараачийн иргэншлүүд лемурчуудын түвшинд очихгүйг мэдээд лемурын соёл иргэншлийн ололт амжилтыг хадгалах, хөгжүүлэх зорилготойгоор зэрэгцэн газар доор орших амьдралын энэ цогцыг бүтээсэн мэт сэтгэгдэл төрж байна.

Хүний хөгжлийн туйлын зорилго бол хүн төрөлхтөн бүхлээрээ Шамбалын түвшинд хүрэх явдал гэж би бодож байна. Газар дэлхий дээр хүн төрөлхтний хөгжсөн түүхийг он дараалан товчхон сийрүүлье.

Хүний хөгжлийг сүнс-хий үзэгдэл маягийн хүн, лемурчууд, атлантчууд, манай иргэншлийн хүнийх хэмээн хэд хэдэн үе шат болгон хувааж болно.

## **Сүнс-Хий үзэгдэл маягийн хүмүүсийн үе шат**

Олон сая жилийн өмнө сүнс нягтаршсанаар дэлхий дээр 60 гаруй метр өндөр сүнс маягийн бүтэц үүссэн байна. Эдгээр сүнсэн хүмүүс чулуу, хана гэх мэт саадыг нэвтлэн гарч чадахуйц сийрэг байжээ.

## Лемурын соёл иргэншлийн үе шат

Хий үзэгдэл маягийн хүмүүсийн бие нь улам нягтаршсанаар 20 метр өндөртэй, 2 нүүр, 4 гартай эрт үеийн лемурууд үүсжээ. Урд талын 2 гар нь бодит ертөнцөд хардаг 2 нүдэнд үйлчилж, хойд талын 2 гар нь нарийн ертөнцөд харах зориулалттай 1 нүдэнд үйлчилдэг байжээ. Эртний лемурчууд хана нэвтэлж чаддаггүй байсан боловч 4 гарынхаа тусламжтайгаар бодит ертөнцөд идэвхитэй үйлдэл хийдэг болжээ. Тэд нарийн ертөнцийн энергийг (таталцлын хүчинд үйлчлэх, амьтдад сэтгэцээрээ нөлөөлөх гэх мэт) бүрэн дүүрэн ашигладаг байсан ба бодит ертөнцийн энергийг ч (булчингийн хүч, гал ус гэх мэт) мөн хангалттай хэмжээнд ашигладаг болжээ. Генийн цогц нь эр эм хүйс ялгах хэмжээнд хүрч төгөлдөржсөнөөр хүүхэд төрж эхэлжээ. Эртний лемурчууд үлэг гүрвэлийн үед байсан гэж бодогдож байна.

Бие нягтарших үйл явц үргэлжилснээр хожуу үеийн лемурчуудын (лемуро-атлантчуудын) бие нь жижигрэн 10 орчим метр болжээ. Билгийн нүд нь гавлын хөндий рүү орсон ч Нөгөө Ертөнцийн долгионд тохируулагч эрхтнийхээ үүргийг хадгалсаар байсан юм. Билгийн нүдэнд үйлчлэгч арын хоёр гар нь алга болжээ. Хожуу үеийн лемур нь хагас усны амьдралтай байсан ба жижигхэн заламгай нь усан доор амьсгалахад нь тусалдаг байжээ. Тэд аврага том хотуудыг босгож, техникийн хөгжлөө агуу өндөр түвшинд хүргэж, шинжлэх ухаан нь дээд түвшинд хүрч, бие махбодын өвчин зовлонгоо дотоод энергийнхээ тусламжтайгаар эмчилдэг байв. Тэд 1000-2000, түүнээс ч илүү насалдаг байлаа.

Хожуу үеийн лемурчууд нь бодит ертөнцийн энергийг бүх талаар ашигладаг байсан боловч тэдний технологи нь нарийн ертөнцийн хуулийн мэдлэг дээр суурилдаг байжээ. Тэд харьцангуй самадид хялбархан ордог байв. Хожуу үеийн лемурчуудын хөгжингүй хэсэг нь бодитжих, эс бодитжих чадвартай болжээ. Тэд мөн левитацийг эзэмшиж (таталцлын хүчийг дийлэн өөрийн биеийг газраас хөндийрүүлэх) агшин зуурын дотор агаарт шилжих чадвартай болжээ. Мөн нисдэг төхөөрөмж болон бусад биетийг бодитжуулах, эс бодитжуулах аргыг эзэмшсэн байна.

Хүнийг бүтээсэн Нөгөө Ертөнц өөрийн бүтээлээр бахархаж болохоор байлаа. Лемурын соёл иргэншлийн үед хүн бодит ертөнцийн энергийг эзэмшин амьдралын бодит хэлбэрийг батлаад зогсохгүй шинжилгээ, судалгаа болон сайн үйлээрээ Ертөнцийн Мэдээллийн Орны торсийн оронгуудыг мэдээллээр баяжуулж байлаа.

Нарийн ертөнцийн амьдралын хөгжил цэцэглэлд нөлөөлөхүйц өндөр түвшний амьдралыг бодит ертөнцөд үүсгэх зорилт биелж байлаа.

Лемурын үе шат нь хүн төрөлхтний түүхэнд хамгийн өндөр хөгжилтэй, урт настай нь байв. Хэдэн сая жилийн турш сайн сайхан, мэдлэг оюуныг шүтэн ирсэн нь Нөгөө Ертөнцийн хүнийг бүтээх шалтгаан болсон хөгжил цэцэглэлд хүргэв.

Гэсэн ч лемурын агуу өндөр хөгжилт соёл иргэншилд ч мэдлэгийг тахин шүтэх нь аажимдаа эрх мэдлийг тахин шүтэх үзлээр солигдож эхэлжээ. Эрх мэдэлд хүрэхийн тулд мэдлэгийг ашиглаж эхэлсэн нь сайн сайхныг нураан муу муухай бүхнийг үүсгэжээ. Зэвсэг үйлдвэрлэж, лемурчууд хэсэг бүлэг болон хуваагдаж, нэг нэгнээ сүрдүүлж эхлэв. Газар дэлхий дээр сөрөг энергийн бүрхүүл үүсэв. Лемурчуудын сайн сайхан үйлээс Ертөнцийн Мэдээллийн Оронд мэдлэг, эерэг энерги шингээд зогсохгүй, Нөгөө Ертөнцийн торсын орныг нураах үйлчилгээтэй сөрөг сэтгэлийн энерги ч шингэж эхэлжээ. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад хуримтлагдан, Нөгөө Ертөнцийн торсын оронд шингэсэн газар дэлхий дээрх амьдралын талаарх бүх мэдээлэл устаж эхэлсэн юм.

Лемурчуудын мэдлэгийг тахин шүтэх үзэл нь ямар учраас эрх мэдлийг тахин шүтэх үзлээр солигдсон юм бол? Яагаад ийм зүйл тохиолдсоныг хэлэхэд бэрх. Гэвч бодит болон нарийн ертөнцийн үйл ажиллагааны хуулийг төгс эзэмшин үл итгэм өндөрлөгт хүрсэн хүмүүс өөрсдийгөө байгаль дэлхийн бүрэн эрхт эзэн хаан мэт төсөөлснөөр бүр их эрх мэдэл олж авахыг хүссэн бололтой. Өөрөөр хэлбэл лемурчууд Бурхан болон Бурханы бүтээсэн Нөгөө Ертөнц тэднийг төрүүлсэн гэдгийг мартан өөрсдийгөө бурхан мэт өргөмжлөн агуу нүгэл үйлджээ. Тэгээд бүх лемурчуудаас нэг нь л “Бурхан” байх учиртай тул эрх мэдлийн төлөөх тэмцэл эхэлжээ. Лемурчуудаас арай хөгжингүй зарим нь (бодитжих, эс бодитжих, левитаци болон орон зайд шилжих чадварыг эзэмшсэн зарим нь) Нөгөө Ертөнцийн торсын орнуудад буй газар дэлхийн амьдралын талаарх “бүх мэдээллийн сан хөмрөг”-ийг нурааж буй сөрөг сэтгэлийн устгагч үйлчлэлийг Бурхан удаан тэвчихгүйг ойлгоцгоож байв. Бодит болон нарийн ертөнц Абсолют хоосон хэмээх нэгэн эхээс үүссэн бөгөөд нарийн ертөнц нь бодит ертөнцөөс урьтаж хөгжсөн учир Абсолютад илүү их нөлөөлөн сансрын биетүүдийн (гариг, од эрхэс) байршлыг өөрчилвөл газар дэлхий дээр аюул гамшиг нүүрлэнэ гэдгийг тэд мөн мэдэж байлаа.

Гай гамшиг тохиолдох нь гарцаагүйг ойлгосон ихэнх лемурчууд агуйд самадийн байдалд орцгоон Хүн төрөлхтний Генийн санг үүсгэсэн байна. Хөгжингүй хэсэг лемурчууд бодитжих болон эс бодитжих үзэгдлийг ашиглан тоног төхөөрөмж, машин механизмаа аван газар доогуур орж Шамбалын болон Агартийн орныг үүсгэснээр лемурын соёл иргэншлийн технологийг хадгалах, хөгжүүлэх, Генийн санг хамгаалах боломжтой болжээ. Сансрын гамшиг ч болдгоороо болж, үр дүнд нь газрын гадарга дээрх лемурчуудын соёл иргэншил мөхжээ. Мэдлэг боловсролыг эрх мэдлээр сольсны үр дүнд ингэжээ.

Дээд Оюун Ухаан газар дэлхий дээрх амьдралын тухай “мэдээллийн сан хөмрөгийг” устгуулж түвдсэнгүй. Зөвхөн Агартийн болон Шамбалын орон л агуу лемурын соёл иргэншлийн бэлэг тэмдэг болон одоо ч Нөгөө Ертөнцийг мэдлэгээр хангасаар оршдог.

Гэвч аюул гамшиг учрахаас өмнө лемурын нийгэмд нуруугаар жижиг, өөр дүр төрхтэй хүүхэд төрж эхэлжээ. Эдгээр жижиг биетэй (ердөө л 3-5 метр) хүмүүсийн тоо улам бүр нэмэгдсээр байлаа.

Эд бол газар дэлхийн дараачийн соёл иргэншил болох атлантчуудын эхний төлөөлөгчид байлаа. Тэдний нэг хэсэг нь лемурын их гамшигийг даван туулж,\* цөөн хэдэн омог үүсгэжээ.

## **Атлантын соёл иргэншлийн үе шат**

Лемурын соёл иргэншлийн үед атлантчууд бүхий л зүйл дээр “ах” нар буюу өөрсдийнх нь нэрлэдгээр Бурхны Хүүхдүүдийн мэдлэг технологид тулгуурладаг байжээ. Атлантчууд бие даасан амьдралыг төсөөлөх ч үгүй байлаа. Лемурын соёл иргэншил мөхсөний дараа атлантчууд арай гэж амьд үлджээ. Учир нь “ах” Лемур байхгүй ба дэлхий дээр амьдрах нөхцөл маш их хувьсан өөрчлөгджээ. Гамшгийн дараа үлдсэн Атлантчуудаас цөөхөн хэд нь л оршихуйн хагас зэрлэг байдалд байгалийн жамаар шилжин амьдарсаар үлджээ. Атлантчууд нь Лемурчуудын нэгэн адил хөгжил сайтай билгийн нүдтэй байсан учир Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд тааруулан Лемурчуудын мэдлэгийг олж авах боломжтой байлаа. Гэвч торсын оронд бичигдсэн лемурчуудын мэдлэг атлантчуудад яаран нээгдэхгүй байлаа. Тиймээс Атлантидын амьдралд хагас зэрлэг байдал харьцангуй удаан үргэлжилжээ.

Яагаад атлантчууд Ертөнцийн Мэдээллийн Орны мэдлэгийг ашиглаж чадахгүй байсан юм бол? Энэ талаар 2 янзын таамаглал байж болох юм:

- Атлантын тархи лемурынхаас бага хөгжилтэй байсан учир Ертөнцийн Мэдээллийн Оронд холбогдсон ч юуны тухай ярьж буйг ойлгох чадваргүй байжээ. Түүхэн урт хугацааны турш лемурчуудад найдаж сурсан зан нь мэдлэгт өөрсдөө дүн шинжилгээ хийж, амьдралаа хөгжүүлэхэд ашиглах боломж олгосонгүй.

- Дээд Оюун Ухаан атлантчуудыг Ертөнцийн Мэдээллийн Орноос салгасан “SoHm”-ын “өөрөө боловсрогтун” гэсэн зарчмыг нэвтрүүлсэн. Нөгөө Ертөнцийн мэдээллийн орныг сөнөөгч сэтгэлийн сөрөг энергиэс тусгаарлахын тулд лемурын соёл иргэншлийн үед сөргөлдөөн болон эрх ашгийн төлөөх тэмцэл цэцэглэж байх үед “SoHm”-ын зарчмыг нэвтрүүлж эхэлсэн байх. Атлантчуудын соёл иргэншлийн эхэн үед тусгаарлагч болсон “SoHm”-ын зарчмыг зайлуулсангүй. Учир нь атлантчууд эерэг сэтгэлийн энергийн эх үүсвэр болно гэдэгт бүрэн итгээгүй юм. Гагцхүү мэдлэг сайн санааг шүтэн биширсээр ирсэн Шамбал, Агартийн орон Нөгөө Ертөнцийн мэдлэгийг хаадаг “SoHm”-ын зарчмын үйлчлэлээс гадуур үлдсэн байна.

Энэ хоёр таамгийн аль нь зөв бэ? Дээд Оюун Ухаан их хэмжээний сэтгэлийн сөрөг энерги Нөгөө Ертөнцийн Мэдээллийн бүтцэд шилжихэд ямар нэгэн хариу

үйлчлэл үзүүлэх ёстой байсан тул хоёр дахь таамаг зөв гэж би бодож байна. “SoHm”-ын зарчим нь зөвхөн манай соёл иргэншлийг тодорхойлогч шинж чанар бус, харин Нөгөө Ертөнцийн мэдээллийн орныг эвдэх оролдлогоос урьдчилан сэргийлэх Дээд Оюун Ухааны түгээмэл “зэвсэг” юм. “SoHm”-ын зарчмыг хэрэгжүүлсэн нөхцөлд хүн төрөлхтөн Нөгөө Ертөнцийн мэдлэггүйгээр өөрөө боловсорч “өөрөө өөртэйгөө” үлдэх ёстой юм. “SoHm”-ын зарчим нь юуны түрүүнд газар дэлхийн хамгийн өндөр хөгжсөн соёл иргэншил болох Лемурын соёл иргэншлийн цэцэглэлтийн үед олж авсан (торсын оронд бичигдсэн) мэдлэгийг хамгаалдаг. Зөвхөн Шамбалын болон Агартгийн орнуудын хувьд л эдгээр мэдлэгүүд мөнхөд нээлттэй байх юм.

Хүн ардад эртний мэдлэг нээгдэх “Алтан зуун” гэсэн ойлголт шашинд байдаг. Энэ нь хүн төрөлхтөнд “SoHm”-ын зарчим үйлчлэхээ больж Лемурын мэдлэгт нэвтрэх боломжтой үе юм. Атлантчуудын соёл иргэншил “өөрөө боловсрох” нөхцөл байдалд маш удаан хөгжиж байлаа. Хүмүүс бодит энергийн зарим хэлбэрийг эзэмшин байшин барьж, хоолоо голчлон далайгаас олж, хагас усны амьдралаар амьдардаг байлаа. Шамбалын орон, Агартгийн орон нь Атлантуудыг сэмхэн ажиглан байснаа Хүн Төрөлхтний Генийн сангаас Лемуруудыг Хутагт Гэгээнтэн болгон гаргав. “Бурханы хүүхдүүд эргэн ирлээ!” гэж Лемурын үеийн хүчирхэг аварга биетнүүдийн тухай үлгэр домог ой тойнд нь дурсамж болон үлдсэн Атлантчууд дуу алдаа биз. Гэвч Хутагт Гэгээнтэн Лемурчууд Атлантчуудад өөрсдийн мэдлэг технологийг хялбар өгөхийг хүссэнгүй. Харин хайр дурлал, сайн сайхан сэтгэлийг хүн төрөлхтний хөгжлийн үндэс хэмээн номлож байлаа.

Яваандаа Лемур Гэгээнтнүүдийн хүчин чармайлтаар Атлантчуудын эрх мэдлийг тахин шүтэх үзэл нь мэдлэг, сайн сайхан, хайр энэрлийг тахин шүтэх үзлээр солигджээ. Ингэснээр хөгжин дэвших үйл явц эхлэв. Бодит энергийн өөр олон хэлбэрийг эзэмшсэнээр хотууд илүү үзэсгэлэнтэй сайхан болж, хүн ам өсч эхэлжээ. Гэсэн ч Атлантчууд нарийн ертөнцийн энергийг эзэмших болоогүй байлаа. Шамбал, Агартгийн орон Атлантчуудын хөгжлийг үнэлэн Ертөнцийн Мэдээллийн Орны удирдлагын төвд “SoHm”-ын зарчмыг хүчингүй болгож, нарийн ертөнцийн хүчин чадлыг эзэмшсэнээр бүр илүү дэвшин хөгжих боломж олгох тухай мэдээлдэг байв. Ингэснээр Нөгөө Ертөнцийн мэдлэгийн хаалт хүчингүй болов. Лемурын соёл иргэншлийн агуу их мэдлэг тэдний хувьд ч бас нээлттэй болжээ.

Ингээд атлантчуудын соёл иргэншил хөгжил дэвшлийн замаар огцом өгсөж эхэллээ. Телепати, таталцлын хүчинд сэтгэлийн энергиэр нөлөөлөх, тарнийн хүч зэрэг нарийн ертөнцийн энергийг эзэмшив. Харцаараа хүнд юм зөөж, хот тосгон барьж, бие махбодио дотоод энергийн хүчээр эмчлэн эдгээж, тарнийн хүчээр агаарт хөвдөг болжээ. Аврага том хотууд барьж, тэнгэрт дахин хүчирхэг виманууд нисэлдэн, усан доор гайхамшигтай тариалангийн талбайнууд бий

болж, аварга том хөшөө дурсгалууд сүндэрлэн боссон нь атлантчуудын соёл иргэншлийн хүчирхэгийг гэрчилнэ. Ертөнц хурц улаан өнгөтэй байлаа.

Энэ үед мэдлэг боловсрол хайр энэрлийг тахин шүтэх нь атлантуудын амьдралын үндсэн дүрэм нь байлаа. Гэвч атлантчууд билгийн нүднийхээ тусламжтайгаар Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд тааруулан телепацийн аргаар өмнөх иргэншил болох лемүрүүдийн мэдлэгийг хялбархан олж авч байсан тул мэдлэг боловсролыг дээдлэх үзэл бүрэн баталгаажихгүй байлаа. Атлантчуудын хүүхдүүд сургууль, их дээд сургуульд явах шаардлагагүй байсан. Учир нь тархи хөгжихийн хирээр мэдлэг Ертөнцийн Мэдээллийн орноос тархинд аяндаа орж байлаа.

Нөгөө Ертөнцийн торсын оронд бичигдсэн лемурын соёл иргэншлийн мэдлэг нь атлантчууд шинжлэх ухааныг цааш хөгжүүлэх ямар ч шаардлагагүй, зах хязгааргүй их байлаа. Энэ их мэдлэгийн далайн ядахдаа талыг нь ч болов хэрэглэхсэн! Ингээд тэдний хувьд “шинжлэх ухааны амралт” эхэлжээ.

Шинжлэх ухаан гэдэг бол нэр их ярвигтай хөдөлмөр, хэцүү бэрх шинжилгээ судалгаа, хамтрагсдынхаа мулгуу зантай хийх эрдэмтний шургуу тэмцэл, мэдлэгийн төлөө өөрийгөө золиослох сэтгэл оюуны ариун чанад зорилтоос үүснэ. Чухам ингэж л лемурчууд шинжлэх ухааны толгой эргэм өндөрлөгт хүрч, эрдэм шинжилгээ судалгааг идэвхжүүлдэг (тэтгэдэг) мэдлэгийг шүтэн дээдэлдэг болжээ. Тэдний үед телепатаар Нөгөө Ертөнцтэй холбогдмогц олж авдаг бэлэн мэдээлэл байхгүй байлаа. Харин атлантчуудын үед лемурчуудын боловсруулж өгсөн бэлэн мэдлэгийн цогц бий болсон байжээ.

Нөгөө Ертөнцийн мэдээллийн санд нэмэх гүн мэдлэгийг тахин шүтэх үзлийг атлантчуудын “шинжлэх ухааны амралт” дэмжин тэтгэж чадсангүй. Хүн төрөлхтний амьдралын хамгийн хүнд хэсэг бол шинэ мэдлэгийг хүлээж авах явдал бөгөөд энэ нь илүү хөгжингүй, чадварлаг хүмүүсийн төөрөг тавилан нь болдог. Харин атлантчуудын хэн нь ч гэсэн Нөгөө Ертөнцийн долгионы давтамжинд тааруулснаар ядах юмгүй мэдлэг олж авдаг байсан учир эдгээр мэдлэг нэр алдарт дуртай мулгуу хүмүүсийн гарт очин эрх ашгийн төлөө ашиглагдахад хүрч эхлэв.

Ийнхүү мэдлэгийн шүтээний оронд эрх мэдлийн шүтээн бий болжээ. Сайн сайхан үзэл нь эрх ашигт дурласан сөрөг эрмэлзлийг зогсоож хүчирсэнгүй. Хүний зорилго эрмэлзэл гэдэг бол эсэргүүцэхэд тун хүнд асар их хүчин юм. Хүний эрмэлзлийг зогсоож болдоггүй. Харин чиглэлийг нь өөрчлөн мэдлэг олж авах эрмэлзэл болгож болно. Хэрвээ атлантчууд мэдлэг боловсролыг тахин шүтэх үзэлтэй байсан сан бол тэдний хүсэл эрмэлзэл нь эрх мэдэлд бус хязгааргүй уудам, мөнхийн мэдлэгт чиглэхсэн билээ.

Хүнийг (лемур, атлант, бид ч ялгаагүй) үргэлж ямар нэгэн зүйлд тэмүүлж байхаар бүтээсэн. Хүн гэдэг бол өөрөө хөгжих мөн чанартай амьтан юм. Тийм ч учраас хүний ямар нэгэн зүйлд хүрэх гэсэн эрмэлзэл нь маш чухал зүйл. Юунд



хүрэх гэж тэмүүлэх вэ? Хариулт нь маш энгийн: мэдлэг боловсрол, сайн сайханд! Сайн сайхны төлөө эрмэлзэж дээрээс нь мэдлэгийг шүтэж дээдлэх үзлийг нэмэх юм бол энэ нь хүн төрөлхтний хөгжил дэвшлийн гол бүрэлдэхүүн хэсэг болох юм. Үгүй бол эрх мэдлийг шүтэх үзэл бий болж түүнтэй хамтаар муу муухай, муу муухайг дагалдан үхэл мөхөл ирэх болно.

Атлантчуудын эрх мэдлийг тахин шүтэх үзэл улам бүр газар авч байлаа. Тэд хоорондоо байнга дайтдаг хэд хэдэн хэсэг бүлэг болон хуваагдсан байна. Хэзээ ч юм лемурчуудын олж авсан Нөгөө Ертөнцийн мэдлэгийг зэр зэвсэг бүтээхэд ашиглаж эхлэв. Эцэс төгсгөлгүй дайн тулаан эхлэв. Нөгөө Ертөнцийн торсын оронд их хэмжээний сөрөг энерги орж эхэллээ.

Их гамшиг болохыг мэдэрсэн хөгжингүй атлантчууд Хүн төрөлхтний Генийн санд нэмэгдэн агуйд самадид орцгоожээ. Атлантчуудын хувьд самадид орох нь олон нийтийн шинж чанартай үзэгдэл байсан. Хүн төрөлхтний Генийн сангийн үндсэн бүрдэл хэсэг нь одоо ч атлантчууд юм.

Шамбал, Агартин орнууд дэлхийн гамшигийг саатуулж чадахгүй бөгөөд сайн сайхан, мэдлэг боловсролыг шүтэн дээдлэх үзэл нь цэрэг дайны хүч хэрэглэхэд нь саад болж байлаа.

Атлантчууд өндөр хөгжилт газар доорх лемурын соёл иргэншилтэй нэгдсэн гэдэгт би эргэлзэж байна. Учир нь тэд Шамбалын ба Агартин оронд амьдрахад шаардлагатай бодитжих, эс бодитжих үзэгдлийг эзэмшиж чадаагүй.

850000 жилийн өмнө гай гамшиг тохиолдсон. Дэлхийн тэнхлэг байрлалаа өөрчилж, туйлууд шилжин, дэлхийг бүхэлд нь хамарсан их үер болжээ. “SoHm”-ын зарчим дахин хэрэгжиж эхэллээ.

Гэсэн ч атлантын соёл иргэншил шууд мөхсөнгүй. Тэдний нэг хэсэг нь (шар атлантчууд) агаарын хөлөг онгоцондоо (вимана) суун Гималай, Төвд, Говийн бүс рүү буюу их үерээс өмнө Хойд туйл байсан дэлхийн бөмбөрцгийн өндөрлөг бүс нутаг руу нисэж амжжээ. Говийн элсэн цөлийн буйран дээр байсан Дотоод Тэнгисийн эрэг, арлууд дээр тэд суурьшин дахин хэдэн арван мянган жилийг өнгөрүүлжээ. Гэвч хүн амын дутмагшил, тусгаарлагдсан байдал, хамгийн гол нь Ертөнцийн Мэдээллийн орны мэдлэг болох “шидэт саваа” үгүй болсон (“SoHm”-ын зарчим нэвтэрсэн) нь нийгмийг доройтол, зэрлэгшил, мөхөлд хүргэжээ. “Шинжлэх ухааны амралт” эдэлж сурсан зан нь атлантчуудыг амиа авран гарахад нь саад болж байлаа.

Атлантчуудын нөгөө хэсэг нь (хар атлантчууд) африк тивийн өндөрлөг газрууд дээр амьд үлджээ. Гэвч тэд мөн ийм шалтгаанаар маш хурдан зэрлэгшин мөхжээ. Эдгээр хар атлант өнөөгийн хар арьстан бүрэлдэн бий болоход зохих хувь нэмэр оруулсан гэсэн таамаг байдаг.

Атлантын далайд оршдог Платоны арал дээр атлантчуудын гурав дахь хэсэг нь амь гарчээ. Энэ хэсэг атлантууд илүү хөгжингүй байсан ба “SoHm”-ын зарчмын улмаас Ертөнцийн Мэдээллийн оронтой харьцах боломжгүй болсон нөхцөлд ч

мэдлэг ухаанаа алдалгүй эрдэм шинжилгээний судалгаа хийн технологио хөгжүүлж, Нөгөө Ертөнцийн шууд нөлөөгүйгээр хүмүүсээ сэтгэл оюуны хөгжилд хүргэж чаджээ.

Платоны арлын атлантчууд газар дэлхийн шинэ нөхцөл байдалд тогтворжин 85000 жилийн өмнөөс 11000 жилийн өмнөх үе хүртэл урт удаан хугацаанд амьдарсан байна.

Энэ хугацаанд их үерийн үеэр Дэлхийн гадарга дээр тогтсон их ус татарч, хуурай газар томорч, уг шинээр үүсэн бий болж буй эх газар, арлууд дээр тав дахь иргэншлийн хүмүүс суурьшиж эхэлж байлаа. Эдгээр шинэ хүмүүс атлантчуудын хувьд маш жижигхэн, тэнэг бас ууртай мэт санагддаг байжээ. Платоны арлын атлантчууд эдгээр шинэ хүмүүсийн заримтай нь байлдаж, заримтай нь эв найрамдалтайгаар харьцдаг байсан байна. Жишээ нь Платоны арлын атлантчууд эртний египетчүүдтэй маш ойр дотно харьцаж, тэдэнд мэдлэг технологио дамжуулан, хүнд зүйлсийг таталцлын хүчинд сэтгэлийн энергээр үйлчлэн зөөвөрлөж, египетийн пирамидуудыг хамтран бүтээжээ. Пирамидуудыг 75-80 мянган жилийн өмнө барьсан. Пирамидуудыг барьж дууссаны дараа атлантчуудын ихэнхи нь, мөн зарим нэгэн египетчүүд пирамидуудын доорх оромжинд гүн самадид орж Хүн төрөлхтний Генийн санг нэмэгдүүлжээ.

11000 жилийн тэртээ Платоны арлын атлантчуудын одон орон судлаачид Тифоны солир удахгүй дэлхий дээр унахыг мэджээ. Солир ойртсоор Атлантын далайд унав. Атлантчуудын сүүлийн тив болсон Платоны арал далайн давалгаанд живэн оджээ. Ингэж атлантчуудын соёл иргэншил бүрмөсөн мөхсөн байна.

Атлантчуудын соёл иргэншил лемурчуудын соёл иргэншлээс хамаагүй богино хугацаагаар оршин тогтносон бөгөөд лемурын хүрсэн хөгжлийн түвшингийн талд нь ч хүрээгүй байна. “Шинжлэх ухааны амралт” тэднийг мөхөлд хүргэжээ.

### **Аричуудын үе (манай соёл иргэншлийн хүмүүс)**

Яагаад ч юм бид германчуудыг ари үндэстэн гэж хэлж сурсан байдаг. Гэвч энэ нь буруу юм. Учир нь эртний бүх ном зохиолд аричууд гэж манай соёл иргэншлийг бүхэлд нь нэрлэдэг хэмээн бичсэн байдаг.

Атлантын соёл иргэншлийн хэвлийд ойролцоогоор 1 сая жилийн өмнө аричууд үүссэн. Атлантчуудын дунд жижигхэн биетэй, том хамартай, сарьсан таславчгүй том хөлтэй хүмүүс төрж эхэлжээ. Тэд хуурай газрын амьдралд илүү дасан зохицсон байсан учраас атлантчуудыг бодвол давуу талтай

байжээ. Эдгээр ер бусын гадаад төрхтэй хүмүүс ажиллах чадвар сайтай, маш идэвхтэй байсан боловч сэтгэл оюуны хувьд, ялангуяа сэтгэлийн энергийн үйлчлэл үзүүлэх талаараа атлантчуудаас хавьгүй сул дорой байлаа. Гэсэн ч тэдний сэтгэл оюуны хөгжил нь өнөөгийн хүнийхээс хавьгүй дээр байжээ. Анхны аричууд нь өөрсдийн эцэг өвгөд болох атлантчуудаас нарийн ертөнцийн энергийн зарим нэгэн төрлийг эзэмшиж самадид орж, телепати, телекинезийн үйлчлэл үзүүлж сурчээ.

Анхны аричууд 2-3 метрийн өндөртэй, орчин үеийн хүмүүстэй харьцуулбал аврага хүмүүс байсан ч атлантуудын хувьд жижигхэн биетэй санагддаг байжээ. Анхны аричууд үүссэн атлантчуудын соёл иргэншлийн сүүлийн үе шатанд “SoHm”-ын зарчим хэрэгждэггүй байсан. Тиймээс тэдгээр аричууд нь атлантчуудын нэгэн адил Нөгөө Ертөнцийн мэдлэгийг ашиглах боломжтой байжээ. Анхны ари хүүхдүүд мөн л тархиныхаа хөгжлийн хирээр Ертөнцийн Мэдээллийн орноос мэдээлэл хүлээн авдаг, сургуульд явах шаардлагагүй байжээ. Анхны аричуудын “билгийн нүд” орчин үеийн хүнийхээс илүү хөгжилтэй ч атлантчуудынхаас үйл ажиллагааны хувьд дутмаг байжээ. Тэд атлантчуудыг бодвол илүү бодитжсон, газрын амьдралд дасан зохицсон хүн байлаа.

Анхны аричуудын үүсэл цаг хугацааны хувьд атлантчууд хоорондоо эрх мэдлээ булаацалдан сөргөлдөж, дайтан тулалдаж байсан үе шаттай таарчээ. Анхны аричууд эрх мэдлийг тахин шүтэх үзлийг атлантуудаас уламжлан авсан нь өнөөг хүртэл бидний арийн соёл иргэншилд хадгалагдсаар. Атлантчуудын хамтаар анхны аричууд омог хоорондын дайнд оролцдог байжээ. Тэд атлантаас илүү тэсвэр тэвчээртэй бүдүүн баараг байв.

Атлантчууд ч мөн дэлхийн гамшиг ойртож буйг мэдэж байсан боловч эрх мэдлийг тахин шүтэх үзэл нь дийлжээ. Дэлхийн гамшиг болохын өмнөхөн аричуудын ихэнх нь гүн самадид орж Хүн төрөлхтний Генийн санд хувь нэмрээ өргөжээ. Тийм ч учраас Хүн төрөлхтний Генийн сангийн аричуудын хэсэг нь голчлон эдгээр анхны аричуудаас тогтдог ба тэд “SoHm”-ын зарчим хүчингүй байхад амьдарч байсан учир Нөгөө Ертөнцийн үндсэн мэдлэгийг эзэмшсэн байсан ба зарим нэгэн сэтгэлийн энергийн үйлчлэлийг (амилуулах, өвчнийг анагаах гэх мэт) мөн үзүүлж чаддаг байжээ. Бидэнтэй адил төстэй гадаад төрхтэй Гэгээнтнүүд (Моисей, Мухаммед, Исүс Христос гэх мэт) их үерийн өмнө гүн самадид орсон анхны аричууд юм. Анхны аричууд Шамбал, Агартийн орны талаар мэддэг, тэдэнд мөргөдөг, лемурчуудыг “Бурхны Хүү” хэмээн шүтэцгээдэг байжээ.

Дэлхийн гамшигийн өмнө анхны аричууд самадид Хүн төрөлхтний Генийн санг дүүргэх гэж бус, харин агуйд уг гамшигийг өнгөрүүлэх зорилготой ордог байжээ.

Их үерийн үеэр (850000 жилийн тэртээ) ихэнх ари атлантуудын нэгэн адил амь үрэгдсэн. Хуурай газрын ил үлдсэн багахан хэсгүүд дээр л цөөн хэдэн атлантчууд болон аричууд амь гарцгаажээ. Байр байшин, технологи, тоног төхөөрөмж бүгд үгүй болсон хүнд хэцүү цаг үе иржээ. Гэвч "SoHm"-ын зарчимд нэвтэрч, хүмүүс Нөгөө Ертөнцийн мэдлэгээс тусгаарлагдсан нь л хамгийн хэцүү зүйл байлаа. Зэрлэгшсэнээс болж амьдрал анхдагч хэлбэрт шилжжээ. Ийм нөхцөлд амьд үлдсэн аричууд атлантчуудтай байнга дайтаж байлаа. Аричууд нь амьдралын хатуу ширүүн нөхцөлд илүү дасан зохицсон байсан болохоор хуурай газрын томоохон бүсүүдээс атлантчуудыг түрсээр байлаа. Тэд их үерийн дараа ил гарч ирж буй хуурай газруудад суурьшин, хот тосгон барьж байлаа. Харин атлантчууд тусгаарлагдсан омог үүсгэн амьдарч, хүн ам цөөн, цус ойртсон гэрлэлтээс болоод аажмаар мөхөцгөөж байлаа.

Их Үерийн дараа маш удаан хугацааны туршид газар дэлхий жижиг жижиг чулуурхаг арлуудаас бүтэж байсан тул хашигдмал байдал, цус ойртсон гэрлэлт нь аричуудын удамшлын үзүүлэлт муутгасан зэрэг шалтгааны улмаас арийн нийгэм хэдэн зуун мянган жилийн турш хөгжсөнгүй. Энэ үед хүн төрөлхтний Генийн сангаас цөөнгүй Хутагт Гэгээнтнүүд (Будда нар) гарч ирсэн тухай баримт мэдээлэл байдаг. Гэвч тэдний үйл ажиллагаа амжилт олсонгүй. Учир нь арийн нийгмийн доройтох үйл явц илүү хүчтэй байсан бололтой. Аричуудын бие жижгэрэн 1.5 орчим метр болж тэд улам бүр зэрлэг омгийн төрхтэй болж байлаа.

100-200 мянган жилийн тэртээ газар дэлхий дээр Төвд, Африкийн өмнөд хэсэг, Газрын дундад тэнгисийн бүс нутагт тархсан аричуудын гурван үндсэн бүлэг байсан мэт сэтгэгдэл төрж буй юм.

Эхний хоёр бүлэг нь яваандаа бүрэн доройтож зэрлэгшин, зөвхөн газрын дундад тэнгисийн бүлэг л хөгжсөн нь эртний египетийн соёл иргэншлийг үүсгэжээ. Эртний египетийн соёл иргэншил бүрэлдэн тогтоход зөвхөн Гэгээнтнүүд ч бус мөн Платоны арлын атлантчуудтай ойр дотно харилцаатай байсан нь нөлөөлсөн бололтой. Египетийн соёл иргэншил хөгжлийн өндөр түвшинд хүрчээ. Магадгүй египетийн пирамид нь тэдний атлантуудтай хамтарсан хөдөлмөрийн үр бүтээл биз. Хэзээ, яагаад египетийн соёл иргэншил мөхсөн бэ? Хэлэхэд хэцүү л юм. Эртний египетчүүд Тифоны солир дэлхийг мөргөсний уршгаар мөхсөн Платоны арлын атлантчуудын сүйрлийг даван туулж чадаагүй бололтой.

18013 жилийн өмнө Төвд Гималайн нутагт нэгэн шинэ Хутагт Гэгээнтэн бий болжээ. Зарим нь түүнийг Ману, зарим нь Рама, зарим нь Бумба Будда гэдэг байжээ. Энэ хүн аврага биетэй, ер бусын дүр төрхтэй байжээ. Чухам түүний нүдийг л Төвдийн бүх сүм дээр дүрсэлсэн юм шиг байна. Дээр

бичсэнчлэн энэ нүдийг шинжлэхэд лемурын нүд гэдэг нь тодорхой болсон. Ингээд Хүн төрөлхтний Генийн сангаас Хутагт Гэгээнтэн болж лемур хүн өөрөө гарч иржээ.

Арийн соёл иргэншил оршин тогтнож буй Их Үерээс хойши энэ бүх хугацаанд Хүн төрөлхтний Генийн сангаас зөвхөн атлантчууд, эртний аричууд л гарч ирж байсан. Тэдний дунд лемур байсангүй. Эдгээр гэгээнтний хөдөлмөр ямар нэг үр дүнд хүрээгүйгээр үл барам улам бүр доройтсоор байжээ. 1800 жилийн тэртээх үед хүн төрөлхтөн зэрлэг, хагас зэрлэг омгуудаас тогтож, хөгжих найдвар улам бүр багассаар байлаа. Зөвхөн египетийн соёл иргэншил энэ бүгдээс ялгарч байсан боловч мөн л доройтлын шинж тэмдэг илэрч байжээ.

Арийн соёл иргэншилд болж буй үйл явцыг судлан Шамбалын болон Агартийн орон эцэстээ лемур хүнийг Гэгээнтэн болгон илгээхээр шийджээ. Ингээд 18013 жилийн өмнө дэлхий дээр Бумба Будда заларчээ. Тэрээр Төвдийн бүс нутагт байхдаа юуны түрүүнд аричуудаас эрэгтэй эмэгтэй хүмүүсийг шилэн авч тэднийг хагас зэрлэг омгийнхоноос тусгаарлаж, яаж амьдрахыг зааж сурган, үржиж олшрох, дэлхийн бөмбөрцгөөр тархахад нь нөлөөлж байлаа. Бидний үзэж буйгаар чухам эдгээр хүмүүс бол “статистикийн дундаж нүд”-тэй (төвд үндэстэн) юм. Эдгээр хүмүүс л дэлхийн бөмбөрцгөөр тархан хагас зэрлэг омгийнхныг шахан зайлуулж байлаа. Чухам эдгээр хүмүүсийн нүүдлийн замыг бид офтальмогеометрийн бүдүүвчээр хөөн олж, харин үлдэж хоцорсон хагас зэрлэг омгууд нь (офтальмогеометрийн бүдүүвчинд багтаагүй) одоог хүртэл хагас зэрлэг хэвээр үлдсэн хэрэг. Лемур Гэгээнтнүүдээр ном заалгасан эдгээр хүмүүс л аажмаар хөгжиж эхэлсэн байна.

Арай илүү хөгжингүй болохоор тэд хагас зэрлэг омгуудтай хийсэн газар нутгийн төлөөх тэмцлийг ялан гарч, ихэнх нутгаас хагас зэрлэг аричуудыг шахан зайлуулжээ. Зарим нутагт тэд хагас зэрлэг хүмүүстэй холилдсон боловч зарим нутагт үндэстний цэвэр байдлаа хадгалж оршин буй газар нутгийнхаа нөхцөл байдлын дагуу гадаад төрх нь өөрчлөгджээ. Зарим хагас зэрлэг омог бөглүү алслагдсан газар нутаг болох Амазонк, Африкийн ширэнгэн ой, номхон далайн бүс нутгийн зарим арлууд зэрэгт үлдэж хоцорсон бололтой. Гэсэн ч офтальмогеометрийн баримтуудаас үзвэл Төвдээс гаралтай арийн зарим бүлэглэл ч гэсэн зэрлэгшсэн (Өмнөд Америк, Полинезийн арлууд зэрэг). Гэлээ ч хагас зэрлэг омгуудтай холилдсоноос, мөн бүс нутгийн шинжтэй зэрлэгшилт явагдсаныг эс тооцвол Төвдөөс гаралтай аричууд манай иргэншлийг аажимхан ч хөгжлийн замд хөтөлсөн юм. Лемур Гэгээнтэн ари үндэстний доройтох явцыг тасалж чадсан учир тэрээр хүмүүсийн ой санаанд үүрд үлдэж, харин түүний нүд хөгжлийн бэлгэ тэмдэг болон төвд сүм бүрийг чимдэг аж.

Гэвч ари үндэстэн аймшигт нэгэн шалгуурыг даван туулах ёстой байлаа. Атлантын далайд Тифоны солир унасны дараа агаарт асар их хэмжээний тоос (хайлмаг зэрэг) босож, газар дэлхийг түнэр харанхуй нөмөрчээ. Зарим зохиолчид энэ түнэр харанхуй 1000-2000 жил үргэлжилсэн гэж, зарим нь түүнээс арай бага хугацаанд үргэлжилсэн гэж бичигцгээдэг.

Энэ гамшгийн дараа манай гариг дээр амьдрах нөхцөл ямар болсныг нарийн хэлж мэдэхгүй ч үлэмж хатуу уур амьсгалтай байсан гэдгийг таамаглаж болно. Амь тэмцсэн ийм нөхцөл байдалд Төвдөөс гаралтай аричууд илүү хөгжингүй давуу талаа ашиглан байшин барилга барьж, дулаацах хувцас оёж, мал аж ахуй эрхлэх чадвартай байжээ. Ихэнх зэрлэг, хагас зэрлэг омгууд мөхсөн нь дэлхийг болон хүн төрөлхтнийг доройтлоос цэвэрлэжээ. Ямартаа ч цөөн хэдэн хагас зэрлэг омог амь гарсан нь одоо ч тэр түвшиндээ байсаар байна.

Тифоны солир унаснаас болж газар дэлхий дээр үүссэн нөхцөл байдал аажимдаа хэвийн болжээ. Гэвч нийгмийн хөгжил хүмүүсийн хооронд эрх мэдлийн төлөөх тэмцэл өрнөж, сайхан сэтгэл, мэдлэгийг дээдлэх үзэл ард хоцорсоноос болж байнга зогсонги байдалд орох болов. Эцэс төгсгөлгүй дайн тулаан нь сүүлдээ бүр байлдан дагуулагч баатар ба хамгаалагч баатар эрийн үлгэр жишээ дүр зураг бий болгосон байна. Шуудхан хэлэхэд Нөгөө Ертөнцийн мэдлэгийг ашиглуулдаггүй “SoHm”-ын зарчим нь мэдлэгийг нэмэхэд огт нөлөөлөөгүй юм. Мэдлэгийг шүтэн бишрэх үзэл доройтож эхэлсэн нь хүмүүсийг шашнаа мартахад хүргэн, зөвхөн “кармын шивнээ” л сэтгэл оюунтайг нь сануулж байлаа. Тиймээс хүмүүс бөө мөргөлийн ёсыг даган, онгон шүтээнд мөргөх нь ихэсчээ. Хүн төрөлхтөнд Бурханы мэдлэг дутагдаж эхлэв.

Шамбал болон Агартин орон ч үүнд оролцолгүй үлдсэнгүй. 2000 жилийн тэртээ хэсэг Хутагт Гэгээнтэн гарч ирж (Будда, Исүс, Мухаммед, Моисей, Озоастр болон бусад) Нөгөө Ертөнцийн мэдлэгийг хүмүүст номлож эхэлжээ. Гэгээнтнүүдийн үйл ажиллагааны үр дүн нь илхэн байв. Буддын, индуист, загалмайтны, лалын гэх зэрэг шашнууд үүслээ.

Үүнтэй холбоотойгоор дэлхий дээр мэдлэг оюун, сайн сайхныг шүтэх үзэл нэмэгдсэн боловч эрх мэдэлд шунах хүслийг дийлэхгүй байлаа. Өөр хоорондын дайн тулаан нь шашны дайн болж хувирчээ. Шашны зарчмын дагуу газар нутаг хуваагдаж эхэллээ. Хүн төрөлхтөн дахин хөгжлийн чиг шугамаасаа хазайсны гол буруутан нь эрх мэдэлд дурлах явдал байлаа. Арийн соёл иргэншилд лемурын эртний баялаг мэдлэгийн өв санг нээх тухай санахын ч гарз байлаа.

Гэвч манай эриний 8-12-р зууны үед дэлхийн зарим хэсэгт, ялангуяа Европт аливааг бурхны номлолын үүднээс тайлбарлахыг оролдолгүй, бодит

ертөнцийг судалсаны үндсэн дээр бий болсон ер бусын мэдлэгийн сан хөмрөг бий болж эхлэв. “SoHm”-ын зарчмаас үл шалтгаалан маш хурдацтай хөгжиж эхэлсэн байна. Аричууд Нөгөө Ертөнцийн мэдлэггүйгээр ч техникийн дэвшилд хүрч болдгийг харуулав.

Гэвч ийм мэдлэгийг тахин шүтэх үзлийн үр дүн нь тун сэжигтэй. Учир нь эдгээр мэдлэгийг эрх мэдлийн тусын тулд олборлож байлаа. Эдгээр мэдлэгийг эрх мэдэл олж авахын тулд ашиглах аюул тулгарлаа. Үнэхээр ч гай гамшиг дэлхийн хоёр ч дайны хэлбэрээр нүүрлэсэн юм. Дэлхийн хоёрдугаар дайны дараа хүмүүс шинэ мэдлэгт үндэслэн бүтээсэн зэвсэг хичнээн аюултай болохыг мэдэрцгээжээ. Мэдлэгийн өв сан, эрх мэдлийг тахин шүтэх үзэлтэй яв ч нийцэхгүй нь гэдгийг хүн төрөлхтөн анзаарч, энэ тухай бодолхийлж эхэлжээ. Дэлхий дээрх дайн дажины тоо цөөрөв.

Дашрамд дурдахад 2000 орчим жилийн өмнө үүссэн янз бүрийн шашин “нөлөөллийн хүрээнээс” болж дайн дэгдээх нэг хүчин зүйл болж байсан.

Өнөөг хүртэл цэцэглэн буй эрх мэдлийг тахин шүтэх ёс нь шашны янз бүрийн урсгалыг үүсгэснээр аюул нүүрлүүлж байна. Бүх шашны эх үүсвэр нэг гэдгийг хүмүүс боддог ч үгүй. Шашнууд нэгдэн нэгэн Нэгдмэл Шашин үүсгэх цаг болжээ. Дайн дажин, гай гамшиггүйгээр үүнийг хийж болох болов уу? Хэлж мэдэхгүй л юм.

1999 онд Кали-Юги төгсөж, Сатья-Юги эхлэсэн. Маш олон Гэгээнтэн энэ үед ертөнцийн төгсгөл болно гэж зөгнөн хэлсэн байдаг. Нострадамус, Вара Брахмандра болон зарим хутагт 1999 оны 8-р сарын 12-нд ямар нэгэн урьдчилсан шинж тэмдэггүйгээр нар хиртэн, энэ нь маш удаан үргэлжлэх болно гэж бичсэн байдаг. Ертөнц түнэр харанхуйд умбана. Үүний дараа хэд хэдэн аюул гамшиг болох боловч хамгийн аймшигтай нь Дэлхий дээр солир буюу сүүлт од унах ба аврага том далайн давалгаа АНУ-ын дорнод эрэг болон Европын ихэнх нутгийг живүүлэх болно. Үүнийг дагалдан далай давалгаалж, шуурга, хуй салхи босох болно.

Хүн төрөлхтний 2/3 нь үхэж үрэгдэн зөвхөн 1/3 нь л амь гарах болно хэмээн зөгнөсөн байдаг. Шинэ Гэгээнтнүүд ирж (Шамбалын удирдагч гэх мэт) шашнуудыг нэгтгэн хайр элбэрэл, сайн сайхны үндсэн дээр нэгдмэл нэг шашныг үүсгэнэ.

Антихристын илгээсэн хуурамч Гэгээнтнүүд мөн үүснэ. Гэвч яваандаа “Чин үнэний зуун” болж хүн төрөлхтөнд эртний мэдлэг нээгдэх болно.

Харин зарим хүн, жишээ нь аватар Сатья Саи Баба “хүн төрөлхтний хөгжилд сэтгэл хангалуун байгаа. Ертөнцийн төгсгөл ирэхгүй. Бүх шашин аажимдаа нэгдэн нэг шашин үүсгэх болно.” гэж үздэг.

## **Ертөнцийн төгсгөл ирэх үү?**

Энэ асуултанд хариулахад хүнд байна. Ирээдүйг урьдчилан хэлдэг хүмүүс Ертөнцийн Мэдээллийн орны мэдлэг дээр тулгуурладаг бололтой. Гэвч Ертөнцийн Мэдээллийн оронд ирээдүйд зайлшгүй болох ёстой үйл явдал гинжин хэлхээс мэт байдаггүй бололтой. Үгүй бол өөрөө хөгжигч эхлэлийн аргаар үүссэн хүний үүслийн үндсэн зарчим нь худал болохсон. Миний бодлоор Ертөнцийн Мэдээллийн оронд ирээдүй нь хүн төрөлхтний хөгжлийн эерэг сөрөг урьдчилсан таамаг маягаар байдаг болов уу.

Эерэг таамаг нь үнэн байх болов уу, сөрөг нь үнэн байх болов уу? Энэ нь биднээс өөрсдөөс маань шалтгаална. Сайн сайхан болон мэдлэг боловсрол нь хүний хөгжлийн талаар эерэг таамгийг үнэн болоход нөлөөлж, харин муу муухай болон эрх мэдэлд дурлах явдал нь ирээдүйдээ ертөнцийг мөхөөх аюул гамшиг эсвэл хүн төрөлхтнийг зэрлэгшүүлдэг түүхэн хувьслын доройтлын хүчин зүйл бүрдэхэд таатай нөхцөл бүрдүүлдгийг ямагт санаж явах хэрэгтэй.



Тавдугаар хэсэг

## **Зэрлэгшил нь түүхэн хувьслын буурах хүчин зүйл болохынхоо хувьд**

Хүн төрөлхтний хөгжлийн түүхийг авч үзсэн өмнөх бүлэгт хүмүүс зэрлэгшин бүхэл бүтэн улс үндэстэн хагас зэрлэг, зэрлэг омгууд болон хувирсан баримттай олон удаа тулгарч байсан билээ. Үүнээс үүдээд зэрлэгшил бол үүргийг нь хэрхэвч үгүйсгэж болохгүй түүхэн доройтлын хүчин зүйл юм гэсэн сэтгэгдэл төрж байна.


Хоёр жилийн өмнө би Индонези руу тус улсын ерөнхий нүдний эмчийн урилгаар очсон юм. 100 орчим нүдний эмч нар цугларч. би тэдэнд лекц уншин, нүдний шинэ хагалгаа, нөхөн суулгавар эдийн хагалгааг үзүүлэв. Хөгжилтэй, шаламгай, шинэ соргог болгонд маш мэдрэг ханддаг Индонези эмч нар соёлтой өндөр боловсролтой хүмүүс мэт санагдаж, надад маш их таалагдсан. Гэсэн ч сургуульд байхдаа сонсож байсан тус улсад ихэд дэлгэрсэн хүн идэх ёсны талаар асуумаар санагдаад ер болохгүй байлаа.

- Танай улсад хүн иддэг үү?- гэж би тэсэлгүй ерөнхий эмчээс нь аминчлан асуув.

- Яалаа гэж. Одоо манай улс соёл иргэншилт нийгмийг цогцлоосон. Хүн иддэг байсан цаг өнгөрсөн хэмээн ерөнхий эмч хариулав.

- Зэрлэг омгуудын зэрлэг ёс заншлыг ийм амархан дийллээ гэж үү хэмээн намайг шалгаахад,

- Ер нь бол ч,- гэж ерөнхий эмч эвгүйцэн хэлээд,- Индонезийн бүрэлдэхүүнд 13000 орчим арал ордог. Зарим арал дээр хүн иддэг ёс одоо хүртэл байдаг.



Зэрлэгшил (зохиогчийн зураг)

Гэхдээ манайд хүн идэхтэй тэмцдэг тусгай цагдаа нар байдаг. Хэрэв аль нэгэн арал дээр хүн идэх л юм бол тэд шууд л нисч очоод зэрлэгүүдийг шийтгэдэг.

- Та нар зэрлэгүүдэд боловсрол олгож, тэднийг арай соёлтой амьдрахад сургахыг оролддоггүй юм уу?

- Мэдээж оролддог., - гэж ерөнхий эмч хариулаад, - төрийн тусгай төлөвлөгөө ч бий. Гэвч миний бодлоор энэ нь нэмэргүй зүйл. Зэрлэгүүд мэдлэгийг маш муу хүлээж авдаг. Тэд яг л амьтан шиг зөн совингоороо амьдардаг. Магадгүй олон зуун жилийн өмнө эдгээр арлууд арай л соёлтой байсан биз. Гэвч одоо бол эргэлт буцалтгүйгээр зэрлэгшсэн. Тэд соёлжсон нийгэм бүрэлдүүлж чадна гэдэгт би л хувьдаа эргэлзэж байна. Харин соёлт нийгмийн хүмүүст шахагдсаар удалгүй мөхөцгөөх нь илүү үнэний хувьтай байх.

- Таны үгнээс би хэрвээ хүмүүс нэгэнт л зэрлэгшин амьдралын бүдүүлэг хэлбэрт шилжсэн тохиолдолд эргээд соёлжих боломжгүй гэдгийг ойлголоо.

- Тиймээ, би яг тэгж бодож байна, - гэж ерөнхий эмч өгүүлээд, - Би өөрөө ийм омгуудад очиж тэдний нүдийг эмчлэхийг оролдож байсан. Гэвч тэд чинь юу ч ойлгодоггүй юм. Тэдний тархи нь маш муу хөгжсөн байдаг.

Би дуугаа хураалаа. Хүн төрөлхтний түүхээс үзэхэд Индонезийн арлуудын байран дээр хэзээ ч юм Атлантидын үндсэн эх газар оршиж, түүн дээр агуу соёл иргэншил цэцэглэн байжээ. Эдгээр мэдлэг бүгд мартагдлаа гэж үү? Зэрлэгшил үйл явцыг зогсоож болохгүй гэж үү? Зэрлэгшил эргэлт буцалтгүй явагддаг юм гэж үү?

## **Хүн сармагчнаас уу, сармагчин хүнээс үү?**

Сургуульд түүхийн хичээл дээр бид бүгд сармагчнаас үүссэнээ мэддэг. “Акашийн товчоо”-г шинжилж судалсан Рудольф Штайнер (“Дэлхийн түүхээс”, 1992, 67-68-р хуудас) үзэж буйгаар бол сармагчин нь хүнээс үүсчээ. Зохиогч дараах зүйлийг бичжээ:

*“Хүн гэдэг амьтан нэгнийхээ доройтолд суурилан нөгөө нь хөгжсөнөөр цаашдын хөгжил нь явагдах боломжтой болсон юм. Эхлээд сэтгэл оюунаар хомсхон нэгнийгээ золиосонд гаргах болжээ. Үржихийн тулд арай дээр хөгжилтэй нэгнийг нь хөгжлөөр доройтой нийлүүлэх нь хөгжингүй хүмүүсийг тэдний түвшинд аваачих болно. Тийм ч учраас сүнс, сэтгэлийг хүлээж авах чадвартай бүх хүнийг тэднээс тусгаарласан юм. Үүний үр дүнд дорой хөгжилтэй нь улам бүр доошилсоор амьтны түвшинд очжээ. Ингэж хүнтэй зэрэгцээгээр хүн төрхт амьтад үүсэв. Хүн хөгжих замдаа ах дүү нараа орхиж, өөрөө улам дээшилсэн байна. Буцах хөгжлийг туулсан, улирагч он цагийн хүн бол сармагчин юм. Хүн хэзээ ч юм одоог бодвол төгс бус байсантай нэгэн адил сармагчин хэзээ ч юм одоогийнхоос боловсронгуй байжээ.”*

Хэрвээ Рудольф Штайнерын энэ өгүүллэгт итгэх юм бол сармагчин хүнээс үүссэн бөгөөд Индонези, Амазонк, Африкийн зэрлэгүүд бол сармагчин төрлийн амьтдад шилжих үе шатандаа явж буй юм. Мөн алмасыг зэрлэгшсэн хүний нэгэн хэлбэр гэж үзсэн ч болох юм.

Энэ үнэн үү? Иймэрхүү зүйлийг батлахад тун хүндрэлтэй байдаг. Ямартаа ч сармагчин хүнээс үүссэн тухай таамгаас дутуугүй үнэний хувьтай юм. Учир нь байгаль дэлхий дээр түүхийн хөгжих хувьсалаас гадна доройтох хувьсал бас оршдог бөгөөд энэ нь хүнд зэрлэгших үзэгдлээр илэрдэг.

### **Дэлхий дээрх хүн төрөлхтний түүхэн дэх зэрлэгших үзэгдэл**

Дорны ном зохиолуудаас ойлгосноор бол хүмүүс нийтээрээ зэрлэгших нь дэлхийн гамшгуудын үечлэлтэй холбоотой. Нийтээрээ зэрлэгших үйл явцад атлантчууд ч тэр, аричууд ч тэр өртөж байсан. Гагцхүү лемурчууд л зэрлэгшилд өртөөгүй хэдий ч тэдний дунд хэсэгчилсэн зэрлэгшил үүсч байсныг үгүйсгэх аргагүй. Лемурын үед болсон дэлхийн гамшгаар ихэнх лемур амь үрэгдсэн. Гэхдээ лемурчуудын бодитжих, эс бодитжих үзэгдлийг эзэмшсэн шилдэг хэсэг нь газар доор Шамбалын болон Агартин орныг үүсгэжээ. Газар дэлхий дээрх зэрэгцээ амьдралын цогц нь (Шамбал болон Агартин орон) хөгжлийн дээд түвшинд хүрсэн юм. Лемурчууд зэрлэгшсэн тухай мэдээллийг бид ном зохиолоос олсонгүй.

Атлантчууд нийтээр зэрлэгших үйл явцад хоёр ч удаа өртжээ. Лемурын соёл иргэншлийн хэвлийд үүсээд, лемурын гамшгаас амьд үлдсэн атлантчууд лемурын удирдлагагүй болсноор амьдралын бүдүүлэг хэлбэрт аажмаар орж эхэлжээ. Лувсандамбын бичиж буйгаар бол (“Лхасын доктор”, 1994 он, 236-р хуудас) атлантчуудын бүтэн зэрлэгшсэн омгууд арай хөгжингүй нэгэндээ шахагдсаар, эртний лемур бичээс олдтол энэ нь үргэлжилжээ. Эртний лемур бичээст үндэслэн атлантчуудын соёл иргэншил хөгжиж эхэлжээ.

850000 жилийн өмнө болсон Их Үерийн дараа Атлантчууд хоёр дахь удаагаа нийтээр зэрлэгшжээ. Лувсандамба (“Лхасын доктор”, 1994 он, 239-р хуудас) *“Хүмүүс соёлоо мартан зэрлэгшлийн үе шатанд ахин орсон бөгөөд тэд амьтны арьсаар хувцас хийж, жимсээр хооллон, төмөр үзүүртэй бороохой биедээ авч явдаг болжээ”* гэж бичсэн байдаг.

Ингээд Их Үерээс амьд үлдсэн атлантчууд ихэнх тохиолдолд зэрлэгшиж, аричуудын омогт шахагдан яваандаа мөхжээ. Гагцхүү Платоны арлын атлантчууд л зэрлэгших үйл явцаас гадна үлдэж, соёл иргэншлээ 11000 жилийн өмнөх үе хүртэл хадгалж, эцэстээ сансрын гамшигаас болж мөхсөн.

Атлантын соёл иргэншлийн хэвлийд үүссэн Аричуудын нэг хэсэг нь их үерээс амь гарч, мөн л нийтээр зэрлэгших үйл явцад өртжээ. Энэ талаар Е.П.Блаватская

(“Нууц товчоо”, 1937, 2-р боть, 532-р хуудас), Лувсамдамба (“Лхасын доктор”, 1994 он, 239-р хуудас) болон бусад ном зохиолын эх сурвалж бүгд үүнийг нотолдог. Аричуудын дунд явагдсан зэрлэгших үйл явц нь саяхан буюу 18000 жилийн өмнөөс удааширч эхлэн, Гэгээнтнүүд доройтон буй түүхэн хувьслын явцыг зогсоож, хүн төрөлхтнийг хөгжилд хөтлөх хэмжээний асар өргөн гүнзгий үйл явц болсноор зогсчээ. Мөн 11000 жилийн өмнө Тифоны солир дэлхийд унасны дараа хүн төрөлхтний бүх нийтээр зэрлэгших үйл явц тэсрэлт мэт явагдсан нь газар дэлхий дээрх амьдралын нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой.

Зэрлэгшсэн хүн болгон үхээгүй, бидний л нэгэн адил газар дэлхийн олон өнцөг буланд оршоор л буй нь тодорхой.

## **Зэрлэгүүд гэж хэн бэ?**

Өнөө үед зэрлэг болон хагас зэрлэг омгуудтай Индонези, Шинэ Гвиней, Австрали, Вьетнам, Чили, Бразили болон Африкийн олон улсуудад таарч болно.

Ном зохиол судалсны дүнд орчин үеийн зэрлэгүүдийн дунд газар дэлхийн гурван үндэстний буюу лемур, атлант, ари үндэстний төлөөлөгчид байдгийг олж мэдлээ.

Өнөө үеийн зэрлэгүүдийн дунд алс холын агуу хүчирхэг лемурын үр удам ч байж болох нь үлэмж сонирхол татаж байгаа юм. Е.П.Блаватская (“Нууц бичээс”, 1937 он, 2-р боть, 286-р хуудас) Австралийн хавтгай толгойт аборигенчууд нь лемурчуудын шууд үр удам гэж бичиж, харин дорны шашны зарим ном сударт (Pillai, 1956, Zvelebil, 1973 гэх мэт) Шри ланкийн тамилчуудыг ч лемурын шууд удам угсаа юм хэмээн бичсэн байдаг.

Олон сая жилийн өмнө амьдарч байсан лемурчуудын үр удам өнөөг хүртэл амьдарсаар буй гэдэгт итгэж болох уу? Энэ асуултанд хариулахад үлэмж хүнд байна. Учир нь тэдгээр зэрлэгүүдийг палеоанатомийн үүднээс огт судалж байгаагүй. Магадгүй Австралийн эдгээр хавтгай толгойт зэрлэг хүнд лемурын гадаад төрхтэй төстэй ямар нэгэн шинж тэмдэг (хоншоорын хөндий, шүд, дал, гар хөл гэх мэт) олох ч юм бил үү?

Мөн л Е.П.Блаватская номынхоо зарим хэсэгт (“Нууц бичээс”, 1937 он, 2-р боть, 532,482,577-р хуудас) Номхон далайн зарим арлуудын аборигенчууд нь атлантчуудын шууд үр удам юм хэмээсэн байдаг. Эдгээр арлын байран дээр хэзээ ч юм Атлантидын үндсэн эх газар оршиж байсан юм. Атлантид живсэний дараа хэсэг бүлэг арлууд үлдэж, дээр нь өнөөг хүртэл амь гарсан атлантчууд зэрлэгшин амьдарсаар байна.

Энэ зөв үү? Атлантчуудын шууд үр удмын талаарх асуудал мөн л судлагдаагүй. Бүтэц зүйн харьцуулсан судалгаа болон Будда гэх мэтийн дүртэй адилтгасан судалгааг явуулах хэрэгтэй.

Мэдээж хэрэг лемур болон атлантын үр удам нь (хэрвээ тэд үнэхээр байдаг бол!) хэдэн мянга, сая жилийн дараа ихэд өөрчлөгдөж аричуудтай адил болсон боловч ялгагдах өвөрмөц шинж чанараа алдаагүй байж болно. Гэсэн ч миний бодлоор зэрлэгүүдийн ихэнх нь манай соёл иргэншлийн хүмүүс буюу аричууд байдаг.

Миний бодлоор тусгаарлагмал бүс болох Номхон далайн арлууд дээр их үерийн дараах анхны мянганы балар эрт цагт зэрлэгшсэн эртний аричүүдийг олж болно. Харьцангуй эртний аричүүд нь мөн офтальмогеометрийн бүдүүвчинд багтаагүй Африкийн зарим нэгэн зэрлэгүүд байж болох талтай. Офтальмогеометрийн бүдүүвчээс үзэхэд Өмнөд Америк, Австрали, Шинэ Зеланди, Индонези, Сибирийн зарим зэрлэгүүд 18000 жилийн өмнө Төвдөөс дэлхийн бөмбөрцгөөр тархсан харьцангуй хожуу үеийн аричууд болох нь харагдаж байна.

Уул нь манай арийн соёл иргэншлийн хөгжлийг Төвдчүүд эхлүүлсэн боловч дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрт тарсан овог аймаг бүхэн зэрлэгших түүхэн доройтлын хувьслаас зайлсхийж чадаагүй юм. Жишээ нь Амазонкийн аборигенчууд офтальмогеометрийн бүдүүвчээр япон, финнчүүдтэй нэг үндэс угсаатай боловч бүрэн зэрлэгшсэнээрээ ялгарч байна.

Ингээд зэрлэгүүдийн талаарх асуудал ярвигтай ч басхүү сонирхолтой бөгөөд судлаачаа хүлээсээр байгаа шинжлэх ухааны хөндөгдөөгүй сэдвийн нэг юм.

## **Зэрлэгүүд**

### **цаашдаа**

### **амьдарсаар байх**

### **уу?**

Энэ асуултанд хариулахын тулд би хоёр жишээ татъя. Нэлээд хэдэн жилийн өмнө А.Ю.Салихов бид хоёр Амазонкийн ай савын төвд нь орших Манаус (Бразили) хотод нүдний шинэ хагалгаагаа үзүүлэхээр уригдсан юм. Долоо хоног хагалгаа хийж маш шургуу ажилласны дараа биднийг амазонкийн ширэнгэн ойн гүн рүү нутгийн содон амьдралыг үзүүлэхээр авч явав.

Шөнө бидэнд матар агнахыг санал болгов. Галоген чийдэнгийн гэрэлд матрын нүд ногооноор гэрэлтдэг аж. Хөдөлгүүрт завиар матарт тулж ойртож болдог юм байна. Гэрэлд нүд нь гялбасан матрыг саваагаар хатгаж, жижигхэн матрыг бол гараараа бариад авч болох байв. Матар агнах нь хориотой байсан тул бид зүрх зогсоом аймшигтай, аварга хэвлээр явагчдын тав тухыг алдагдуулсанаар энэ удаагийн ангаа хязгаарлав. Гэвч бараг 100-200 метр тутамд тааралдах эдгээр гэрэлтсэн ногоон нүдтэй амьтад хичнээн олон болох нь гайхаш төрүүлж байлаа.

Өглөө нь А.Ю.Салихов эмч хоолны ширээний үлдэгдлээр пиран загас барив. Бид хагас амьтай пиранийн аманд нь хуруу зузаан саваа шургуулахад аймшигтай хүчит эрүүнийхээ хөнгөхөн хөдөлгөөнөөр юу ч үгүй зажилж орхив. Цаашлан

бидэнд нутгийн уугуул иргэд болох хагас зэрлэг индианчуудыг үзүүлэхээр шийдэв. Бяцхан тосгонд ойртон ирэх үед хөтөч маань бидэнд өчигдөр энд 20 метр орчим урттай аврага том анаконд могой харснаа ярив.

Эрэг дээрх шонгууд дээр банзаар барьсан тахианы байр мэт индианы оромжууд туйлын ядуу зүдүү байдлыг илтгэнэ. Тэд ялгадсаа шалан дээрх нүхээр гаргаж, мөн л тэр нүхээрээ ундны усаа авна. Чийрс, хэдхэн сав суулга тэдний бүх эд хогшил байлаа. Дотоож, нимгэн цамц хоёр тэдэнд шаардлагатай бүх хувцас нь юм. Амазонкийн цаг агаар тогтмол, 30-35 хэмийн хооронд хэлбэлздэг. Энд шумуул мэтийн цус сорогч шавьж байхгүй байлаа.

Амазонкийн индианчууд загас барьж, каучук модны сүүн шүүс цуглуулан амь зуудаг. Тэд 300 кг жинтэй порарук загасанд олс, дээсэн тор тавьж, хэрвээ загас баригдвал тосгон даяараа идэж, баригдахгүй бол бүгд өлсөнө.

- Матар, анаконд хоёр хүмүүс рүү байнга дайрдаг уу? – гэж би англиар муухан ярьдаг нэгэн индиан эрээс асуутал,

- Мэдээж, - гэж тэр хариулаад, үргэлжлүүлэн, - матрууд эмэгтэйчүүдийг идэж, анаконд эрчүүдийг иддэг гэв.

- Заавал тэгж сонгодог нь ямар учиртай юм бэ?

- Тэр миний хоёр дахь эхнэрийг хар даа, - гээд индиан эр голын зүг заан, - тэр эрэг дээр сав суулга угааж байна. Матар сэмээрхэн гэтэн ирж миний анхны эхнэрийг залгихад тэр ч мөн л ингээд сав суулгаа угаагаад сууж байсан юм. Матар ирээд түүнийг тас татаж хаясан юм даа.

- Ийм явдал их тохиолддог уу?

- Их тохиолдоно. Бүр байнга. Матар манай хөршийн хоёр ч эхнэрийг ч ингэж идсэн.

- Тэгээд хоёр дахь эхнэрийг чинь ч гэсэн идчихнэ гэж санаа зовдоггүй юм уу?

- Мэдээж санаа зоволгүй яах вэ. Түүнийг ч мөн матар идэх биз. Нэг удаа дайрахад нь тэр зугтан гарч чадсан юм. Эмэгтэй хүн чинь эрэг дээр сав суулга угаах ёстой шүү дээ. Хэрвээ матар түүнийг идэх юм бол, би гурав дахь эхнэрээ авна даа! - гэж индиан эр баргар царайлан өгүүлэв.

- Харин анаконд могой эр хүн рүү дайрдаг нь ямар учиртай юм бол?

- Ширэнгэн ойд маш олон эрчүүд анакондоос болж амиа алддаг.

- Яагаад?

- Ширэнгэн ой маш өтгөн шигүү ургасан байдгийг та хараа биз дээ! Түүгээр явахад заавал нарийхан жимээр ар араасаа цувах шаардлагатай байдаг. Бүх амьтан энэ жимээр явдаг. Эрчүүд бид ч гэсэн энэ жимээр явж сүүн шүүс хураадаг. Харин анаконд могой хүн ч бай, тапир ч бай (зэрлэг гахай) амьд болгон руу дайрдаг. Жишээ нь өнгөрсөн жил могой миний үеэлийг залгичихсан. Ганцхан малгай нь л үлдсэн. Үүнээс өмнө түүний хүү нь бас алга болж байсан. Бас л анаконд...

- Анаконд том уу?

- Маш том ч бий, зөвхөн хүүхдүүдийг иддэг арай бага ч бас бий.
- Та нарт бие хамгаалах ямар нэгэн зэвсэг бий юу?
- Байхгүй. Бидэнд ганцхан энэ л бий,- гээд индиан эр урцаа заав.
- Яагаад та нарт буу зэвсэг байхгүй байгаа юм бэ?
- Тэр чинь маш үнэтэй зүйл.

- Буу зэвсэг олж авах тийм хэцүү гэж үү?- гэж би шалгаагаад,- ядахдаа л загасаа бүгдээрээ идэхийнхээ оронд утаж давслаад хотод аваачин зарж болно шүү дээ! Эсвэл улаан мод ашиглан тавилга хийж зарж ч болно. Модноос ямар нэгэн дүрс зорж эсвэл пираны чихмэл хийж ч болно. Зэрлэг үр жимс түүгээд зарж болно. Мальс, чихрийн манжин, кофе, какао, хан боргоцой тарьж болно... та нар яагаад энэ бүгдийг хийдэггүй юм бэ?

- Бид энэ болгоныг чинь хийж чаддаггүй юм,- хэмээн индиан эр гунигтайгаар хариулав.

- Та нар дунд боловсролтой хүн бий юу?
- Байхгүй.
- Бүгдээрээ ямар ч боловсролгүй юм уу? Та уншиж чаддаггүй юм уу?
- Чадахгүй...
- Та нарт удирдагч бий юу?
- Бий.
- Тэр уншиж бичиж чаддаг биз дээ!
- Үгүй, тэр чинь бидний л адил амьдардаг гэж тэр хариулав.
- Та тэгээд англи хэл яаж сурсан юм бэ?

- Жаахан хүүхэд байхдаа би хотод, олон жилийн турш жуулчдын буудлын дэргэд амьдардаг байсан юм. Тэнд би англиар ярьж сурсан.

- Та хотод юу хийдэг байсан юм бэ?- гэж би түүнээс үргэлжлүүлэн шалгаасаар байлаа.

- Гуйлга гуйж, ачаа зөөж, хог түүдэг байсан гэж индиан эр хариулав.
- Тэгээд хаана амьдардаг байсан юм бэ?
- Гадаа гудманд ...Дараа нь хайрцгаар байшин барьсан.
- Танай улс чинь та нарт боловсрол олгож, цагаан арьстанууд шиг амьдрахыг зааж сургадаггүй гэж үү?
- Сургадаг. Гэвч бид цагаан хүмүүс шиг амьдарч хэзээ ч чадахгүй.

Би дуугүй боллоо. Аргагүй мухардал энэ хүнээс нэвт үнэртэж байх шиг байлаа. Түүнийг өрөвдөх сэтгэл төрж байв. Тусламаар санагдаж байлаа. Эдгээр хүмүүс цагаан арьстангуудтай харьцах дургүй, учир нь тэд хүчин мөхөс гэдгээ улам бүр мэдэрч сэтгэл зүйн дарамтанд ордог болохоор бүр хурдан доройтож мөхдөг. Энэ хүмүүс арай ч нэгмөсөн доройтчихоогүй, хараахан зуун хувь зөн совингоосоо хараат болчихоогүй, дутуу хөгжилтэйгээ, доройтож яваагаа ухаарах



чадвартай л юм байна. Магадгүй тэд зэрлэг байгалийн дунд өөрсдийгөө тэргүүлэгч гэдгээ мэдэрч, онгон байгаль дунд амьдрахдаа аз жаргалтай байдаг ч юм бил үү? Бусад хүмүүс урагшаа хол явж, машин механизм, боловсролыг бий болгон хот орон босгож буйг гадарлаа ч үгүй байх. Магадгүй сэтгэлийнхээ гүнд тэд цаг хугацаа эргэлт буцалтгүй алдагдсаныг, түүхэн хөгжлийн доройтох замаар алгуурхан, ягуухнаар уруудан, агуу өвөг дээдсээ улам бүр умартан, зэрлэг, оюун ухаангүй байгальд ойртсоор яваагаа бүдэг бадаг ч ухамсарладаг байх. Мэдээж тэд түүхэн хөгжил тогтмол байдалд дургүйг, хөгжил эсвэл доройтол гэсэн хоёрхон зам байдгийг, харин хөгжлийн замаар явахын тулд маш их хүч чармайлт гаргах хэрэгтэй гэдгийг мэдэхгүй яваа.

Биднийг завинд суулган буудалд хүргэж өгөхөөр явав. Цаашлан биднийг машинаар Амазонкийн нөгөө эрэгт гаргах татлага онгоцонд хүргэж өгөв. Би онгоцон дээр гарч эргэн тойрноо ажвал Амазонк мөрний эргээр тосгоны өрөвдмөөр урц оромжууд шавааралдах нь харагдана. Миний хажууд “Ковбой” гэсэн утгагүй бичээстэй хиртэй цамц өмссөн жаалхүү зогсож байлаа. Оромжуудыг гунигтай нүдээр харахыг нь ажвал мөн л тэндээс гаралтай нэгэн бололтой.

Би жаалхүүг хараад тэр хэзээ ч боловсрол олж авахгүй, хувь заяаг нь эртний өвөг дээдсийнх нь доройтох сэлгүүцэл тодорхойлоод өгчихсөн, тэр эдгээр оромжуудын нэгэнд матарт идүүлчихгүй л бол энэ насаа элээнэ дээ гэж бодлоо. Жаалхүү миний харцыг мэдрээд зусардан инээмсэглэв. Би түүний дэргэд өндөр, цагаан, өөртөө итгэлтэй нэгэн зогсож байлаа. Миний өвөг дээдэс шургуу хөдөлмөрлөж, хөгжлийн замаар замнасан нь миний аз болж.

Сибирт болсон өөр нэг явдалыг иш татъя. Бидний аяллын маршрут туйлын хүнд байсан ба хүний хөл хүрээгүй газарт оччихов. Цас бороо холилдон орж байлаа. Эргэн тойронд чулуун ангалаар зүсэгдсэн тайга. Маш хүйтэн байсан тул нэвт үлээх салхинаас нуугдмаар санагдаж байв.

Гэнэтхэн тайгын дунд бид цаатны урц байхыг олж харлаа. Бид баярлан урцанд ойртон очвол нохой хуцаж, урцнаас бугын арьсаар хийсэн хувцастай хэдэн хүн гарч ирэв. Тэдний арай ахимаг насны нэгэн эр цээжээ дэлдэн:

- Дарга(начальник),- гэв.

Би үүргэвчээ буулгаад, мөн л цээжээ дэлдэн:

- Дарга (начальник), - гэлээ.

Цаатан урц руу заан:

- Сайн байна(хорошо),- гэв.

Бид урцанд орж бугын арьсан дээр суув. Дулаахан боллоо. Би мөн л:

- Сайн байна.- гэв.

Энэ урцны эзэн нь дээрх хоёрхон үгийг л оросоор мэддэг нь тодорхой байлаа. Тэрээр над руу хараад, бугын мах чанаж байгаа тогоог зааж:

- Дарга, сайн байна.- гэв.

Бид хооллож эхэллээ. Би үүргэвчээ авчран, архитай дашмагаа гарган түүнийгээ эзэнд үзүүлээд:

- Дарга сайн байна,- гэлээ.

Эзэн ширүүн харцаар өөрийн гэр бүлээ болон манай залуусыг тойруулан хараад, өөрийгөө болон намайг зааж:

- Дарга сайн байна.- гэв.

Энэ үгнээс нь би зөвхөн дарга нар буюу бид хоёр л ууж болно гэж ойлголоо. Бид архи аягалж ууцгаав. Эзний царай нь ягааран:

- Дарга сайн байна.

Би бугын махаар даруулангаа мөн л,

- Дарга сайн байна,- гэлээ.

“Яриа” сунжрах төлөвтэй боллоо. Шөнө болж, унтахаар хэвтэцгээв. Гэнэт эзэн урцан дахь эмэгтэйчүүдийн нэгийг нь заагаад тодоор:

- Дарга сайн байна,- гэх нь тэр.

Хойд нутгийнхны ийм ёсны тухай дуулсан байсан би эвгүйцэн, нойр хүрч буйгаа гараараа занган ойлгуулж:

- Дарга сайн,- гэлээ.

Эзэн эмэгтэйд ойртон очиж, түүний нуруун дээр нь алгадаад:

- Дарга сайн,- гэв.

Сүүлдээ эзэн намайг ятгасаар залхав бололтой, бид унтацгаав. Өглөө нь эзэн бидний нэг үүргэвчийг өргөж үзсэнээ дуу алдан хүнд байна гэж үзүүлээд нөгөө эмэгтэйд дөхөн очиж түүний мөрийг алгасанаа зэмлэнгүйгээр:

- Дарга, сайн байна,- гэв.

Бид аяллынхаа маршрутыг даган цааш явав. Нэлээд хэдэн Км –ийн дараа ангал гэтлэж яваад бид ганцаараа чаргаар явж буй цаатантай таарлаа. Тэр оросоор давгүй сайн ярьдаг байлаа. Зогсон яриа өрнүүлцгээв. Тэрээр нэлээд хэдэн жил сууринд амьдрахдаа бүр архинд орсон. Одоо бидний зочилсон цаатны гэр бүлтэй цуг нүүдэллэн амьдардаг гэж ярилаа.

- Өвгөн (дарга) маш ухаантай хүн. Тэрээр хамгийн хүнгүй зэлүүд газраар нүүдэллэж, цагаан арьстан хүмүүстэй таарахаас зугтдаг. Манай ард түмэн цагаан арьстнуудтай харьцахаараа архинд орж үхдэг гэдгийг тэр сайн мэддэг. Би цагаан арьстнуудтай амьдарч байсан бол өдийд үхсэн байх байсан. Өвгөн миний амийг аварсан юм. Гэвч тайгад одоо маш олон цагаан арьстан ирдэг болжээ. Нисдэг тэрэг, цаснаа явагчаар байнга хөлхөлдөцгөөх юм. Бид улам бүр хойшлон явсаар одоо бүр явах ч газаргүй болох нь.

Ингээд бодоход зэрлэгүүд болон хагас зэрлэгүүд амьд үлдэх болов уу? Тэдэнд хүлэмжийн нөхцөл байдал бүрдүүлж өгөх нь утгагүй юм. Учир нь ирээдүйн төлөөх хүндрэл бэрхшээлийг даван туулж тэмцэх хүсэл, сэтгэлийн тэнхээтэй байж

л урагш хөгждөг жамтай. Эрт холын өвөг дээдсийнх нь доройтол, цалгар байдал нь аажимдаа зэрлэгших үхлийн нүгэл болон хувирчээ.

## **Зэрлэгших хүчин зүйл**

Бидний дээр тэмдэглэсэнчлэн зэрлэгших гол хүчин зүйл бол эртний өвөг дээдсийнх нь цалгар байдал юм. Хүн нь өөрөө хөгжигч эхлэл маягаар бүтээгдсэн тул цалгар байдал нь үргэлж доройтлыг үүсгэдэг. Үе дамжин цалгар байдалд дассан хүмүүсийн сэтгэл оюун зарим талаар доройтож, юуны түрүүнд сэтгэлийн хүчээ алдаж буйгаа, дараа нь тархи нь хүртэл доройтон байгааг анзаардаг ч үгүй. Үеэс үед чадварлаг хүмүүс улам бүр багасаж, амьтны зан араншин (идэх, унтах, үржих гэх мэт) улам бүр нэмэгдсээр байна.

Зэрлэгшлийн өөр нэгэн хүчин зүйл бол тусгаарлагдмал түгжигдмэл байдал юм. Үүнийг тусгаарлагдсан жижиг арлуудын ихэнх оршин суугчид зэрлэгшсэн жишээ нотолж байна. Үүнтэй холбоотойгоор зарим нэгэн жижиг улс үндэстнүүдийн, жишээ нь Чечень бие даасан тусгаар улс болох хүсэл нь доройтуулагч хүчин зүйл болж болно. Учир нь цус холилдох болон их гүрний доторх илүү хөдөлгөөнтэй амьдрал нь үргэлж хөгжилд нөлөөлж байдаг.

Зэрлэгшлийн дараагийн хүчин зүйл бол зарим нэгэн улс, омог дахь тоталитар удирдлагын хэлбэр юм. Удирдагч нь ямар нэгэн онол эсвэл баримтыг номлож (коммунизм, бөөгийн ёс, золиос гаргах гэх мэт) уг баримт эсвэл онолд итгэсэн итгэл дээр тулгуурласан тоталитар нийгмийг бүрдүүлдэг. Үүнийг зөвшөөрдөггүй болгоныг мөрдөж мөшгин устгана. Мөрдөлт мөшгөлтөнд арай илүү чадварлаг, сэтгэл оюуны хөгжил нь даган дуурайж, бишрэх үзлээс дээгүүр оршдог хүмүүс юуны түрүүнд өртдөг ба удирдагч дээдсүүд нь тэдэнд атаархаж явдаг юм. Яваандаа чадварлаг хүмүүсийн тоо цөөрсөөр нийгэмд зэрлэг хууль дүрэм, зэрлэг ёс жаяг улам бүр газар авдаг. Иймэрхүү явдлын жишээ ЗСБНХУ (Ленин, Сталины хавчлага мөрдлөгө нь юуны түрүүнд тосгоны ард түмнийг огцом уналтанд хүргэж улс орныг үр тарианы томоохон нийлүүлэгч байснаа импортлогч болгон хувиргасан), Ирак (лалын ёс заншлыг хэт шүтэн биширдэг улс) юм.

Зэрлэгшлийн эцсийн гол хүчин зүйл нь амьд үлдсэн хүмүүсийн үйлдвэрлэлийн бүдүүлэг нөхцөл байдалд амь гарахыг тулгадаг дэлхийн аюул гамшиг юм. Зөвхөн агуу их сэтгэлийн хүч ба бүтээлч байдал л хүмүүсийг түргэн зэрлэгшихээс аврах юм.

## **Самади бол зэрлэгшлийг тэнцүүлэх хүчин зүйл**

Хэрвээ хөгжил гэдэг нь түүхэн урт удаан хугацааны, хүнд үйл явц байдаг бол зэрлэгшилд шилждэг доройтол нь арай хөнгөн бөгөөд илүү богино хугацаанд явагддаг үйл явц мэт сэтгэгдэл төрж байлаа. Мөхөөх үйл явц тэр дундаа түүхэн хөгжлийн сүйтгэх үйл явц нь бүтээх үйл явцаас бага хүч чадал шаарддаг нь ойлгомжтой. Хүн төрөлхтний түүхэнд бүх нийтээр нь бүрмөсөн доройтуулж, зэрлэгшүүлэх боломж

цөөнгүй байсан биз ээ. Үүнийг антропогенезийн талаар бичсэн шашны болон уран зохиолын бүх эх сурвалжид нотолж бичсэн байдаг.

Эдгээр эх сурвалжаас харахад хүн төрөлхтөн эргэлт буцалтгүй доройтох үе шатанд шилжих тэр мөчид хаанаас ч юм Гэгээнтнүүд гарч ирэн, сүнсний хүчин чадлынхаа тусламжтайгаар доройтлын өсөлтийг зогсоож хүн төрөлхтнийг бүтээлч эхлэлийн замд хөтөлдөг байжээ.

Гэгээнтнүүд Хүн төрөлхтний Генийн сангаас газар дээр гарч ирдэг гэсэн таамаг гаргасан. Үүнээс үүдээд Хүн төрөлхтний Генийн сан, түүний үндэс болох самадийг газар дэлхий дээр зэрлэгшлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүтээсэн гэж дүгнэж болох юм.

Ухаалаг мэргэн Шамбал, Агартийн орон биднийг шинжлэн, сүүлийн гурван соёл иргэншлийн шилдэг хүмүүс төвлөрсөн Хүн Төрөлхтний Генийн ариун сангаас тусламж шаардлагатай болох үеийг тодорхойлж байдаг. Зарим нэгэн цалгардан зэрлэгшсэн улс үндэстнүүд доройтох түүхэн хувьслын үйл явцдаа тахил өргөн, зарим нь Их Бүтээгчийн болон Шамбалын орны агуу мэдлэгийн шинж тэмдгийг тодорхой харагддаг Гэгээнтнүүдийн сэтгэлийн нөлөөнд автдаг.

Зэрлэгшлийн тухай энэ бүлгийг дуусгаж байх үедээ би нийгэм ба хүн эсвэл бүр улс орны дээр сөрөг бүрхүүл (аура) үүссэн тохиолдолд, өөдрөг үзэл нь гутранги үзлээр солигдож, сэтгэлийн сөрөг энерги нь амьдралын сөрөг талуудыг илэрхийлэн дөвийлгөсөн тохиолдолд л нийгэм доройтож эхэлдэг юм байна гэсэн бодол гэнэт орж ирэв. “Орос орны дээр сөрөг аура үүссэн байна шүү дээ” гэж би өөрийн эрхгүй бодох болж, үүнээс болоод өөрийн эрхгүй эвгүйцэх сэтгэгдэл төрж билээ.

Зургадугаар хэсэг

## Орос орны дээрх сөрөг бүрхүүл

Ямар ч гадны хүнд Орос орон хоёр өөр сэтгэгдэл төрүүлдэг. Нэг талаас Орос орон аврага том нутаг дэвсгэртэй, оюун ухаан, шинжлэх ухааны хүчин чадлыг илэрхийлдэг бол нөгөө талаас оросууд арай илүү тохирсон тохилог амьдралыг бүтээх чадваргүй юм шиг өрөвдөм байранд амьдарч, утаатай орцоор орон, шавар шавхайтай гудамжаар явдаг. Орос хүний хачирхалтай ааш араншинг сибирийн хүйтэн, өргөн уудам нутаг дэвсгэр, сэтгэл санааны дорны нэгэн хөг гэх мэтийн зүйлтэй холбож тайлбарладаг.

Орос орныг энэ номын сэдвийн үүднээс авч үзэцгээе л дээ!

### ***Нострадамус Орос орны талаар юу гэж хэлсэн бэ?***

Францын алдарт далдыг харагч Нострадамус 20-р зууны эхэнд Аквилоны улсад (Оросд-Э.М.) Антихрист ирж, энэ улсыг төрсөн он сар өдөр нь 9 жил 9 сар 9 цагаар ялгаатай хоёр дүрээр захирах болно гэж бичсэн байдаг. Нострадамусыг судлаачдын үзэж буйгаар Ленин, Сталин 2-ын төрсөн өдөр гурван 9-ийн зөрөөтэй байдаг. Мөн эдгээр судлаачдын үзэж байгаагаар Ленины сүнс Сталины дорой сүнсийг хөөн зайлуулж биед нь шингэсэн аж. Нострадамус мөн Аквилон улс дахь Антихристийн засаглал нь улс орны дээр сөрөг сэтгэлийн бүрхүүл үүсгэж, хүмүүс бие биенээ устгах болно гэж бичжээ.

Би Нострадамусын зөв эсэхийг шүүн тунгаах гэсэнгүй. Агуу далдыг харагчийн судлаачдыг би зөв ойлгосон эсэхээ мэдэхгүй байна. Гэвч энэ нь большевикуудын үүсэл болон засаглалтай таарч байгаа нь сонирхолтой юм.

Би амьдарлаа коммунизмыг бүтээн босгоход зориулсан хижээл насны олон хүмүүсийг гомдоохыг хүсэхгүй байна л даа. Гэвч Сталин, Ленины дарамт шахалт нь Оросын шилдгүүдийн амь амьдарлыг үгүй болгосон гэдэг нь хэзээд үнэнээр л үлдэх юм.

Эрх мэдлийг тахин шүтэх нь туйлдаа хүрч, түүний төлөө хамгийн сайн тариачдаа (нударган тариачид), шилдэг зохиолчдоо, тэргүүний эрдэмтдээ, оросын эртний язгууртан, сурвалжтныг ч хайрлаагүй юм. “Эрх тэгш байдал” гэсэн сүржин уриан дор дунд эгнээний борчуулаас дээгүүр орших бүх хүмүүсийг хяргаж, “Пролетариатын захиргаа” (гүйцэтгэгчийн диктатур учир ямар ч эргэлзээгүй шал утгагүй зүйл) гэсэн уриан дор ажилчдыг сэхээтнүүдтэй зэрэгцүүлсэн нь эрх мэдлийг тогтворжуулж байжээ. Бүрмөсөн бүгдийг нийгэмчилсэн нь хүнд хувь хүн талаасаа хөгжих боломж олгосонгүй. Намын яршигтай тамга хүмүүсийн тархинд эгээ л маань мэгзэм мэт шингэсэн байлаа. Шашин шүтлэг хуулиар хориотой байв.

### **Орос орны дээрх коммунизмын сөрөг бүрхүүл**

Ягаад эргэлзээгүй хүний эсрэг мөн чанар болох коммунизм ийм олон жил тогтсоор ирсэн юм бэ? Ертөнцийн мэдээллийн орны онолын үүднээс авч үзвэл коммунизм нь сэтгэлийн сөрөг энергийн ямар нэгэн маш хүчирхэг хэлбэрийг ашигладаг байсан нь ихэнхдээ сэтгэлийн энергийн эерэг илрэлийг давж байсан бололтой. Миний бодлоор коммунизмын үзэл суртал нь үндэс сууринд нь атаархал байдаг бүх нийтийн сэтгэлийн сөрөг энергийн хэлбэрийг ашигладаг байсанд оршино.

Атаархал гэдэг бол хүмүүс бидний дунд ихэд тархсан үзэгдэл билээ. Сул дорой нэг нь хүчирхэгтээ, гоо үзэмжээр тааруу эмэгтэй үзэсгэлэн төгөлдөр нэгэндээ, хир тааруу нэг нь авьяаслаг нэгэнд, ядуу нь баяндаа атаархдаг гэх мэт бүгд нэг нэгэндээ атаархаж байдаг. Атаархал нь бидний амьдралд албан тушаал хөөх, авьяас чадварыг гутаан доромжлох зэрэг олон сөрөг талын үндэс суурь нь болдог. Нийгэм атаархлын бүх шинжтэй янз бүрийн хууль дүрэм гаргаж тэмцэхийг оролддог. Эс бөгөөс хөгжиж буй бүхнийг атаархлын зөн совин устгах болно. Атаархуу хүн авьяаслаг хэн нэгэнд атаархсан сэтгэлээсээ болоод өдөр шөнөгүй шаналж, амар тайван байдаггүй. Хэрвээ атаархах сэтгэлээ дарж чадах юм бол ямар нэгэн хэмжээнд тайван амьдарч чаддаг боловч уг мэдрэмж нь эргэн сэргэх төдийд л энэ нь эмгэг хүнд өвчин болж хувирна. Бидний судалгаа бүтэлгүйтэх үед нэгэн хүрээлэнгийн захирал надад “Чиний хагалгаанууд чинь хүмүүст ашиг тусаа өгдөг гэдэгт би эргэлзэхгүй байна л даа. Гэсэн ч би чамтай тэмцэх болно, Мулдашев, би чамайг устгана. Бүх юмаа алдсан ч хамаагүй” гэж хэлж байсныг санаж байна.

“Эрх тэгш байдал” –ын тухай коммунист үзэл санаа нь энэ бүхний зэрэгцээ сул дорой нэгнийг хүчирхэгтэй нь, баян нэгнийг ядуутай нь тэнцүүлдэг учир сул нэгнийг хүчтэйдээ, хоосон нэгнийг баяндаа, тэнэгийг арай ухаалагтаа атаархах мэдрэмжийг хуульчилж өгсөн юм. Атаач хүн тэгш эрх бол адил тэгш боломж биш гэдгийг сэтгэлийнхээ гүнд ойлгон, энэ тэгш эрхээ атаач ашиг сонирхлын үүднээс ашиглаж эхэлдэг. Чухам тийм учраас коммунистууд хэдхэн сарын дотор

сэхээтнүүд, эрдэмтэд, нударган баячуудын эсрэг шахалт дарамт үүсгэж чаджээ. Сэтгэлийн сөрөг энерги нь тэдний холбоотон болсон юм. Миний бодлоор Нөгөө Ертөнц, хүнийг бурхан бүтээсэн гэдгийг болон сэтгэлийн эерэг талуудыг (Хайр, Сайхан сэтгэл гэх мэт) номлодог учраас шашин тэдний сэтгэлийн сөрөг энергийг дөвийлгөх үзэлд харшилдагийг коммунистууд сэтгэлийнхээ гүнд ойлгож байсан. Тийм учраас коммунистууд бурхан шашныг устгаж, Ленин, Сталин зэрэг атаархлын бурхадыг бүтээжээ. Эрх мэдлийг тахин шүтэх нь туйлдаа хүрч Дээд Оюун Ухааныг үгүйсгэн, тэднийг шүтээн болсон удирдагчдаар сольжээ. Эерэг үзэгдлүүдээс коммунистууд устгахаас айсан цорын ганц үзэгдэл бол мэдлэг юм. Тэдэнд мэдлэг боловсрол нь “Дэлхийн хувьсгал” хийхэд хэрэгтэй байжээ. Эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд коммунист үзэл бодлыг номлох нь маш их байсан ба шилдэг ур чадвартай ч эрх чөлөөг эрхэмлэдэг эрдэмтэд (Вавилов гэх мэт) дарамт шахалтанд өртөж байлаа. Гэсэн ч коммунист дэглэмийн үед амьдарч байсан хүн бүхнийг тэр үед улс орныг бүрхэж байсан сэтгэлийн сөрөг энергийн хуулийг тууштай баримтлагч гэж хэлж болохгүй. Харин ч ихэнх хүмүүст үүссэн сөрөг урсгалыг эсэргүүцэх дотоод мэдрэмж төрж, ил, далд тэмцэж, амьдралын эерэг талууд ямар нэгэн хэмжээнд ялан дийлээсэй гэж зарим нь хүсч эхэлж байсан. Жишээ нь: Социалист нийгмийн үед эрдэмтэд өрөвдмөөр бага цалин авч, шинжлэх ухаан ертөнцөөс тусгаарлагдмал байдалд орсон ч Орос оронд шинжлэх ухаан хурдацтай хөгжиж байлаа. Магадгүй мэдлэг бурханлаг бөгөөд зайлшгүй шаардлагатай хэмээн Карма нь шивнэж байснаас ядахдаа мэдлэг олж аван өөрийгөө тогтворжуулах чин хүсэлдээ тэд хөтлөгддөг бололтой. Мөн аялал жуулчлал маш их хөгжсөн. Учир нь хүн уул эсвэл ой тайга руу явахдаа бооцоонд нь үр дүн бус харин амь насаа тавьж, ая тал засан бууж өгдөггүй зэрлэг байгальтай хийсэн тэмцлээр өөрийгөө тогтворжуулдаг байжээ.

Чухам ийм хүмүүс коммунист дэглэмийн үед бүтээгч эерэг энергээ хадгалсанаар Орос орныг устгахаас аварснаар барахгүй дэлхийн хэмжээнд Аугаа улс хэмээх нэр төрөө хадгалахад нөлөөлжээ. Тэд бол эерэг сэтгэлийн энергээрээ нийгэмд сэтгэлийн сөрөг энерги бүрэлдэн тогтохоос хамгаалж байсан юм. Орос орныг Куба, Камбож гэх мэт дорой буурай, хагас өлсгөлөн, залхуу улс болгож хувиргаагүй энэ хүмүүсийг баатарлаг гавъяатан гэж болно (Би дээрх улс орноор зорчиж байсан тул үүнийг бүрэн итгэлтэйгээр хэлж чадна). Ийм хүмүүсийн дунд эрдэмтэд, эмч, багш нар, ажилчид мөн намын ажилтнууд ч байсан. Энэ хүмүүс зүгээр нэг бүтээгээгүй, харин сөрөг энергийн ноёрхлын хар өдрүүдэд бүтээж байсан учир бид тэднийг хүндэтгэн толгой гудайх ёстой. Тэр хүнд үед тэдэнд байсан намын батлах бүтээх үйлд нь саад болж чадаагүй юм.

Харин одоо энэ бүлгийн эхэнд дурссан Орос хүний хачирхалтай зан төрхийн талаарх асуултанд хариулахыг оролдъё. Хариулт аяндаа төрж байна. Сөрөг муу бүхэнтэй тэмцэхтэй зэрэг амьдралын эерэг талыг бүтээсээр ирсэн Оросууд шинжлэх ухаан соёлыг өндөр түвшинд хадгалсаар ирсэн бөгөөд харин коммунист

дэглэмийн үед сэтгэлийн сөрөг талуудад дийлдсэн Оросууд нь хор шартай хүйтэн сэтгэлтэй архичид болж хувирсан юм. Тэд өөрсдөө ч дунд нь орших нийгмийн юм бүхнийг үнэн голоосоо үзэн ядаж нулимж байлаа.

За, ингээд коммунист дэглэм нурж, капитализм эхэллээ. Одоо хэрхэх билээ?

## **Орос орны дээрх капитализмын сөрөг бүрхүүл**

Коммунист бүхнийг, бидний гавъяат үйлс хэмээн үзсэнийг хүртэл муулж байлаа. Улс орны дээрхи сөрөг бүрхүүлийг арилгах ямар нэгэн эерэг бүтээлч оролдлогогүйгээр коммунист өнгөрснийг гутаан доромжлох явдал үүслээ. Бараг ерөнхийлөгч, депутат болон эрх барих байгууллагын бусад алба тушаалд нэр дэвшсэн бүх хүн мөрийн хөтөлбөрийнхөө дагуу бус харин өнгөрснөө аль хир муулж байгаагаас шалтгаалан сонгогдож байлаа.

Улс орон сөрөг бүрхүүлээсээ салж чадаагүй байна. Олон жилийн ноёрхлын дүнд сөрөг бүрхүүлтэйгээ байх нь илүү таатай санагдах болж муу муухайн тухай яриа нь шинэ нийгмийг байгуулах жинхэнэ шургуу хөдөлмөрөөс илүү сайхан санагдах болжээ. Улс орон даяар сонсогдохоор “Идэхээ больцгооё! Ажиллацгаая!” хэмээн хашгирах хүн олдсонгүй. Улс орон коммунизмаас сөрөг мөн чанарт нь илүү тайлбар хэрэггүй зэрлэг капитализмд орлоо.

Энэ үед би ОХУ –ын ардын төлөөлөгч байсан юм. Олон орноор хэрэн явсандаа тулгуурлан харьцуулалт хийх боломжтой байсан учир хөрөнгөтний зэрлэг нийгэм юунд хүргэж болохыг би төсөөлж байлаа. Хурлын индэр дээр үг хэлэх эрх олж аваад би ерөнхийлөгчийн суудалд сууж байсан Б. Н. Ельцинд хандан:

- Борис Николаевич! Би Колумбад очиж байсан болохоор тэдний нийгэм автомат манааны шовгортой цамхаг маягийн орд харштай хэт баян хүмүүс, дээрэмдэх чадвартай эрүүгийнхэн, ядуу зүдүү ард түмэн дээр суурилдгийг сайн мэднэ. Хэрвээ бид үнэ ханшаа бүтэн чөлөөлж, улс төрийн хяналтыг багасгах юм бол Колумб маягийн хөгжлийн замд тун удахгүй орох болно. Коммунист дөнгөнөөсөө салсан хоёр хүний нэг нь хулгайч болох болно. Учир нь бидний дээр одоо хүртэл сөрөг бүрхүүл байсаар байгаа бөгөөд коммунист нийгэмд сурсан зангаараа хатуу дэглэмгүйгээр бүтээлч ажиллаж чадахгүй. Таны ярьж байгаа цэвэр эдийн засгийн төслүүд чинь ихэнхдээ барууны орнуудаас хуулбарласан болохоор манайх шиг коммунист дэглэмтэй байсан улс оронд тохирохгүй байх. Япон, Хятадын хөгжлийн хувилбарыг анхаарч үзэх хэрэгтэй. Жишээ нь, Дэн Сяо Пин. . .

- Та коммунистуудын төлөө саналаа өгөх юм уу, Ельцины төлөө саналаа өгөх юм уу? – гэж хэн нэг нь танхимаас миний яриаг таслан хашграв.



- Тиймээ, та хэний төлөө саналаа өгөх вэ? – гэж Б.Н.Ельцин асуув.
- Би Ельцины төлөө саналаа өгнө гэж хариулав.

Маргааш нь төв телевизын “Цаг Үе” хөтөлбөр миний ярианы Ельцины төлөө саналаа өгнө гэсэн хэсгийг нь онцгой анхааран нэвтрүүлэв. Тэр үед манай нийгэм хоёр туйл болон хуваагдаж, бүтээлч эерэг ажлын талаар ч мартан, улс төрийн тэмцэлд бялууран байсан цаг. Тэр үед нийгмээрээ хөрөнгөтний нийгэм гэдэг бол шидэт бүтээлэг биш, хатуу хяналт дэглэмийн дор босдог гэдгийг ойлгох чадваргүй байжээ. Улс орны дээрх коммунизмын сөрөг бүрхүүл нь устаж үгүй болсонгүй, харин ч зэрлэг капитализмын эйфорон сөрөг бүрхүүллээр солигдсон юм.

Одоо бид зэрлэг эрүүгийн хөрөнгөт нийгэм бүтээчихсэн хэмээн тун ч бардамаар хэлж чадна. Чадварлаг хулгайч бүхнийг чөлөөтэй хийж болох болон нэр төрөө дөвийлгөх үзэгдэл дээр үндэслэсэн сэтгэлийн сөрөг-эйфор энергийн нийгмийг улс орон хилийн чанад руу гаргасан тэрбум доллараар, үйлдвэрлэлийн уналтаар, нөөцийн шавхалтаар, цэргийн хүчний сулралаар, хуучин Орос орны уналтаар төлсөн юм.

Харин сэтгүүлчид галд тос нэмсээр ирсэн билээ. Манай сонин хэвлэлийг хар л даа. Хаа сайгүй сөрөг муу бүхнийг амтархан таашааж, ярилцлага хийхдээ сэтгүүлчид эмзэг сэдвийг хөндсөн асуулт илүүтэй тавьж, бараг хүн бүхнийг муу талаас нь илүү авч үзэх болсон. Муу муухайн хар өнгө сонин хэвлэлийн үндсэн өнгө болоод зогсолгүй, сэтгүүлчид хар өнгийг амтархан муулж, бардамнан бичиж хоорондоо өрсөлддөг болсон. Хэрвээ сэтгүүлчид нэг хором ч болсон гагцхүү “сөрөг үнэн” хэрэгтэй бус, амьдралын эерэг талуудыг ч мөн хүмүүст хүргэх хэрэгтэй гэж боддогсон бол тэд хоёр чухал зүйлд хүрэхсэн билээ. Нэгдүгээрт амьдралын эерэг үзэгдэлтэй харьцуулсан “сөрөг үнэн” нь илүү үр дүнтэй эерэг “талтай” үнэн болохсон. Хоёрдугаарт эерэг мэдээллийг уншсан хүмүүс сэтгэлийн эерэг энерги цацруулснаар Орос орны дээрх сөрөг бүрхүүлтэй өрсөлдөх чадвартай болох юм. Уул нь манай улсад эерэг, сайн сайхнаар бичих зүйл: дэлгүүрт хүнсний зүйл элбэгшсэн, шилдэг аж ахуй эрхлэгчид бий болсон, шинжлэх ухааны ололт амжилт гарсаар буй зэрэг бишгүйдээ л байна л даа. Оросын эх оронч сэтгэлийн тухай бичиж, бага зэрэг магтан дуулсан ч илүүдэхгүй. Энэ нь сөрөг бүрхүүлийн доор байсаар залхсан оросуудын сэтгэлийг тэтгэж дэмжихсэн.

Сэтгүүлчдийн талаар бичсэн дээрх зүйлс телевизүүдэд ч мөн хамааралтай юм. Дөрөвдөгч засаглал болсон олон нийтийн хэвлэл мэдээллийн алба нь дан ганц сөрөг муу бүхнийг лавшруулах бус харин түүнтэй тэмцэх ёстой юм. Засаглал болохынхоо хувьд армид дайчин гэгддэг чин зориг, эрмэлзэлийн талаар сэтгэлийн энергийн хуулиудын үүднээс бага ч атугай мэддэг байх ёстой.

Хэрвээ Нөгөө Ертөнц тийм л их хүчирхэг бөгөөд хүнийг бүтээсэн юм бол яагаад Оросын дээрх сөрөг бүрхүүлээсээ салахад нь Орос оронд туслаж болдоггүй юм бол оо гэсэн асуулт төрөх нь гарцаагүй. Энэ асуултанд би хүн бол

Нөгөө Ертөнцийн халамжинд байх нялх хүүхэд шиг биш, харин өөрөө боловсорч хөгжих замаар явах ёстой эхлэл хэлбэрээр бүтээгдсэн юм гэж хариулмаар байна. Баталгаажуулах дээд цогц болсон Хүн төрөлхтний Генийн сан болон Шамбалын орон зөвхөн хамгийн хүнд үед (бүх нийтийн зэрлэгшил, дэлхийн гамшиг г.м.) л туслах болно.

## Бохир орц

Н. гэдэг слесарь залуу 9 давхар байрны 6 давхарт 34 тоотод амьдардаг гэж бодъё. Шөнөжин 7 давхрын хөрш нь согтуугаар “агсамнан цамнасанд” уур нь хүрч унтууцаж хоносон тэрээр өглөө эрт гэрээсээ гарч хамгаалалтын төмөр хаалгаа 20 см-ын том түлхүүрээр түгжив. Тамхины иш, самрын ясан дээгүүр гишгэлэн Н. слесарь цахилгаан шатанд дөхөн очиж, тамхины галаар түлсэн дуудлагын товчыг дарлаа. Цахилгаан шат хүлээн зогсохдоо орцны жижүүрийн дөнгөж энэ жил шороон ногоон өнгөөр будсан боловч аль хэдийн “Fuck you” гэх мэтийн ёс бусын үгсээр “чимэглэгдэж” амжсан ханыг харж зогслоо.

Орцны цонхыг хэн нэг нь хагалаад бараг жил болж буй тул даарч эхэллээ. “Ямар новш нь энэ цонхыг хагалдаг байна! Жижүүр нь юугаа харж байдаг юм бэ? Түүнд ч ямар хамаа байх биш дээ!”- гэж Н. слесарь бодно.

Сэнгэнэсэн салхи хогын савны “шүүслэг” үнэрийг авчирна. “Хог дамжуулагч дахиад л эвдэрчихсэн юм байх даа. Эвдрээгүй ч ялгаагүй гадуур нь асгаж орхидог хойно доо! Ямар сонин хүмүүс вэ? Хогын саван дотор амьдарч байгаа юм шиг байх юм!”- гэж бодоод, муудсан лоолийг өшиглөн, шатны хаалга руу нулимав.

Цахилгаан шатны хаалга онгойв. Цахилгаан шатанд орж мөн л тамхины галаар нүхэлсэн нэгдүгээр давхарын товчлуурыг шалан дээрх шээсэн шалбаагийг гишгэчихгүйг хичээн хамраа чимхэсээр дарав. Тэгтэл шээснээс ч илүү юм олж харлаа.

“Дөнгөж өчигдөр ш...чихсэн байсан, тэгтэл өнөөдөр бүр б...сан байх юм. Хүн биш, гахай л гэсэн үг! Амьдарч байгаа газраа б...гаад л! Жорлонд явж байгаа юм шиг л байх юм.” – гэж слесарь бодоод, ой нь гутсанаасаа болж нүдээ эргэлдүүлтэл хана нь дээр нь мөн л “fuck you” гэх зэргийн үг голлосон уран бүтээл харагдлаа.

Цахилгаан шатны ханан дээрх бохинд наалдсан тохойгоо салгаж авсаар, арай гэж гарлаа. Сайн зүхэж аваад тааламжтай нь аргагүй амьсгаа автал тэрээр хэн нэгний орхисон хайрцганд бүдэрч орхив.

- Ямар хачин амьтад вэ! Ёстой нэг... юм,- гэж Н.слесарь үглээд орцны хэмхэрсэн хаалгыг өшиглөн гадаа гарч ирэв. Гадуур цацагдсан дүүрэн хогийг хараад гудамжинд гарав. Н. слесарь цардмал зам дээрх мөнхийн нүх сүвнүүдэд үүссэн шалбаагийг тойртол зүлэг байсан газар зогсоод зэвүүн төрхтэй бярууны

чинээ том нохойг салхилуулж яваа резинэн углааштай хөөрхөн бүсгүйг эргэн харлаа. Нохой Н.слесарийг үнэрлэж чангаар хуцав.

- Джесси боль! – гэж углааштай бүсгүй хашгирав.

“Цахилгаан шатны үнэр авсан юм байлгүй,- гэж слесарь бодоод,- үгүй мөн сонин нохой тэжээцгээх болжээ. Үлэг гүрвэл л гэсэн үг. Гадаа гарч ч болохооргүй болж, энэ амьтан хөл биш бүр т...-г хүртэл залгичихна шүү!”

Трамвайн буудал орох замд дээгүүр нь банз хаячихсан шуудуу таарлаа. Банзаар дамжин шуудууны дээгүүр гарч явахдаа тэрээр “Ядахдаа энэ банзандаа нэг бариул хийчихгүй, уначихвал яах юм бэ? Хичнээн согтуу амьтан ийшээ ойчиж байсан бол? Бүтэн жил болж байхад булчихгүй юм ямар хачин засаг захиргаа вэ? Гомдол бичдэг юм бил үү?” хэмээн бодно. Шуудууг гаталж явахдаа тэрээр дөнгөж өчигдөрхөн угаасан өмдөө шууж, орчин тойрны хагас км газар дүүрэн байгаа шавар шавхайнд өмдөө заваан болгочихгүйг хичээн алцагнасаар явав.

Арай гэж цэвэрхэн зам дээр гараад хөлөө хооронд нь үрэн гутлаа цэвэрлэв. Өмдөө хараад слесарь сэтгэл хангалуунаар:

“Бэлхүүсээ хүртэл заваарлаа. Зүлгүүрчин Васька өчигдөр бүр чихэндээ хүртэл шавар болчихоод ирсэн шүү. Ямар хачин хүмүүс байдаг юм бэ? Яг л гахай шиг шавар шавхай дунд амьдарч байна шүү дээ! Нэг муу шуудууг булчихад тийм л хэцүү байгаа юм байх даа! Яасан хаашаа засаг захиргаа вэ?”

Трамвай хүлээн зогсохдоо тэрээр буудал дээр зогсож буй хүмүүсийг ажна. Уур бухимдал нь нэгэн бөөн хар юм болж дээш огшоод ирлээ.


“Эд л цахилгаан шатан дотор б...ж, шуудуу ухдаг байх даа. Хүн биш мал л гэсэн үг”- хэмээн бодов.

Хэн нэгнийг өвдтөл нь түлхээд Н. слесарь трамвайд орлоо. Сул суудал байхыг хараад бушуухан шиг суугаад авав. Хажууд нь тор барьсан нэгэн эмгэн ирж зогслоо. Н. слесарь буруу харан, гадаа болж буй зүйлс тэгтэл сонирхолыг нь татаж буй мэт цонхоор ширтэн сууна.

“Энэ яажгий юм хар үүрээр тор бариад хаачих гэж байгаа юм бол” гэж бодоод,- “Гэртээ л сууж байхгүй. Жорлон цахилгаан шатаа андуурдаг баахан архичин-новшнуудыг төрүүлчихээд бас хүндлүүлэх санаатай!”

Үйлдвэрийнхээ санжсан эргэдэг хаалгаар ороод Н. слесарь ажилдаа орлоо. Бэлтгэх бүтээгдэхүүнээ бахинд хавчуулаад Н.слесарь зүлгүүр барин залхуутай нь аргагүй үрж эхэллээ.

“Юуны төлөө зүлгэж байгаа юм бол? Энэ цалингийн төлөө юу? Үрээд л байдаг үрээд л байдаг, амьдрал ч гэж нохойнх шиг хэвээрээ л байх юм.” – гэж Н. слесарь бодов. Тэрээр хагас литрийн шилээ аваад тамхилах өрөөнд орж шилэндээ ус хийгээд цайны ханд нэмэв. Тамхи татчихаад цайгаа шилнээс нь оочив.



Орос орон дээрх сөрөг бүрхүүл (зохиогчийн зураг)

“Яг л хамгийн адгийн новш шиг цай ууж байна даа,- гэж тэр бодоод,- жорлонгийн дэргэдэх тамхины өрөөнд суугаад л тамхи татаж байх юм. Ажилчин хүнийг ер анхаарахгүй шүү! Ядахдаа тагтай шилэн аяга аваад өгчихгүй. “

Илт өөрийгөө албадсаар Н. слесарь ажлынхаа байранд очиж сэлбэгээ үргэлжлүүлэн зүлгэв. Үдийн цайны цаг болжээ.

“Цайны газар ордог юм бил үү” – гэж бодсоноо, - “За тэгээд дугаарлаж зогссоор байгаад өлсөөд үхчихнэ. Тогооч нь бүгд хулгайч. Талхтай гахайн өөхөөр котлейт хийчихнэ. Ядахдаа өмх мах хийчихгүй. Зууш нь бүгд өчигдрийнх . . . Хөнгөн цагаан сэрээнүүдийг нь яг л ороомог шиг болтол нь мушгиж болдог. Манай энэ хавийнхан шиг л новшнууд ажилладаг байхдаа. Тамхины өрөөнд орж хачиртай талх цайтай идье дээ. Цайны газар орж нэг халбага л авах хэрэгтэй байна даа. Минийхийг бас нэг гай нь хулгайлчихаж. “

Үдийн цайны дараа тэрээр мөн л үлгэн салган ажилламар аядаж байснаа жорлон орохоор явлаа.

“Цахилгаан шатнаас ч өмхий юм - гэж Н. слесарь бодоод, - суултуур дээр гарч суунгаа халааснаасаа сонин гаргав – энэ суултуурны захуудыг бас л бузарлацихаж. Суултгүй болгочихож! Тэгээд л өндөг дарж байгаа тахиа шиг сууж байгаад мэдээж онохгүй зөрж орхино. Ядахдаа ариун цэврийн цаас ч байхгүй шүү. Энэ сонинг чинь хорт хавдар үүсгэдэг гэх юм билээ. Үнэгүй оруулдаг нь бас яах вэ. Тэр галт тэрэгний буудлын бүх жорлон үнэтэй шүү. Мөнгөгүй бол тэгээд өмдөндөө б...х юм уу! Ямар новшнууд нь тэнд ажилладаг бол хажууд нь б . . сан ч мөнгөгүй бол оруулахгүй шүү! “ – гэж тэр санаа алдав.

Усаа атахаа мартаад Н. слесарь жорлонгоос гарч сэлбэгээ үргэлжлүүлэн зүлгэв. Санаа сэтгэл тун онцгүй, ажил нь нэг л явж өгөхгүй байлаа. Хийсэн сэлбэгээ гортигоор хэмжиж, зурагтай нь харьцуулаад жинхэнэ гологдол хийчихсэнээ мэдэв. Газар луу хүчтэй нулимаад Н. слесарь байрныхаа бохир орц, өмхий цахилгаан шат, гал зуухны мушгирсан хөнгөн цагаан сэрээ төлбөртэй жорлон зэргийг санаад:

“За за энэ сэлбэг ч яах вэ? Энэ новшнуудад бол таарч л орхино. Тэдний машин тэрэг нь энэ сэлбэгтэй ямбийрч нэг новш нь цахилгаан шатанд б . .ж байхын оронд засаж сууг! “ гэж бодов. Ажлын өдрөө дуусгаад Н. слесарь гаран, сэтгэл санаагаа засахын тулд дэлгүүрээс нэг шил архи авав. Зүлгүүрчин Васька, олон үүрэгт Колькатай цуг гурвуулаа нөгөө шил юмаа уучих газар хайн явлаа.

“Гадаадад ажилчид шил юм уух гэж ресторанд ордог гэж ярьцгаадаг. Манайд ресторан нь бараг алтан, тэгээд ч үүдэн дээрх бух шиг юмнууд нь оруулахгүй .” гэж бодон тэрээр Колька, Васька хоёртой нөгөө шил юмаа буланд сууж байгаад хөнтөрчихөв.

Нэлээд согтсон Н. слесарь гэр лүүгээ явж банз тавьсан шуудуу дээгүүр гарч яваад хальтран тэртээ тэргүй заварчихсан өмдөө бүр мөсөн завартуулж орхилоо. Харааж зүхсээр орцондоо оров. Хэн нэг нь чийдэнг нь авчихсан тул орц хав харанхуй. Цахилгаан шат ирэхгүй удна.

“Ямар гичий нь энэ “явдаг жорлонд” зугаалаад байгаа юм бол оо! -

гэж тэр бодоод, - Аягүй бол гэрээ хүртэл тэсэхгүй б...ж яваа биз! Новш гэж!” Цахилгаан шат арай гэж нэг юм ирж, хаалга онгойв. Н.слесарь цахилгаан шатны шар шалбааг хатчихсан, харин “нөгөө ноцтой юм” дээр нь хэн нэг нь гишгичихсэнийг сэтгэл хангалуунаар харлаа.

“Одоо харин, - гэж бодоод Н. слесарь өмдөө тайлан цахилгаан шатанд шээгээд, - маргааш ядахдаа өөрийнхөө шээсийг үнэрлэж явъя даа.”

Н. слесарь бохир орцондоо орсноосоо эхлэн бүх л өдрийн турш энгийн ахуйн зүйлүүдээс баахан сөрөг сэтгэлийн хөдлөл авсан нь ойлгомжтой. Түүний дээр сэтгэлийн сөрөг бүрхүүл үүссэн нь Н. слесарийн ажлын бүтээлд муугаар нөлөөлсөн. Сөрөг бүрхүүлийн нөлөөллийн үр дүнд Н. слесарь архи ууж, өөрөө ч мөн сүйтгэж, үүнээсээ таашаал авч эхэлж байна. Тэрээр өөрөө амьдралаа өөрчлөх гэж хуруугаа ч хөдөлгөхгүй мөртлөө ажил амьдралын таатай нөхцөл бүрдүүлж өгөх ёстой засаг захиргааг түүнийг сэлбэг зүлгүүлж зогсоосонд нь харааж зүхнэ.

Уул нь өөрчлөлт шинэчлэлийг эдийн засгийн төсөл төлөвлөгөөнөөс бус харин хувь хүмүүсийн амьдрах хөдөлмөрлөх ая таатай орчноо өөрсдөө бүрдүүлж, өөрсдийгөө хүндэлж сургахаас эхлэх ёстой байсан юм. Тиймээ хүмүүсийг өөрсдийгөө хүндэлж сургах хэрэгтэй. Ядахдаа Япончуудаас жишээ авъя л даа.

Япон ажилчин слесарь ч бай, зүлгүүрчин ч бай, хог зөөгч ч бай ажилдаа цагаан цамц зангиатай явдаг. Учир нь тэр ажиллаж байгаагаараа бахархдаг. Ажилдаа ирээд хувцсаа тусгай хувцсаар сольж өмсөөд ямар ч ажлыг өөдрөг сэтгэлээр хийж гүйцэтгэдэг.

Учир нь тэрээр өөрийгөө болон уг ажлыг хийж өгч буй хүмүүсийг хүндэлдэг. Ажлын дараа тэд хувцсаа солиод заавал нэг ресторанд орж (харьцангуй хямд) пиво юмуу, сакэ уугаад, хөгжилтэйгээр харихаар явцгаадаг. Японд шуудуу татсан бол тэр өдөрт нь буцааж булдаг. Хэн ч цахилгаан шатыг жорлон болгон ашиглах талаар боддоггүй. Япон орон, япончууд эерэг сэтгэлийн бүрхүүл дунд оршиж буй юм.

Яагаад Оросын ерөнхийлөгч болон засаг захиргаа Оросуудыг сэтгэлийн сөрөг бүрхүүлээс нь салгахыг боддоггүй юм бэ? Гол учир нь миний бодлоор тэд сөрөг бүрхүүлийн талаар ойлгодоггүйгээр ч үл барам үүсгэж байгаа шалтаг шалтгааныг ч анзаардаггүй байна. Жишээ нь: Кремлийн бүх жорлонд аль хэдийн халдвар судлалын албаныхны халдвар тараах аюултай хэмээн хэрэглэхийг хориглосон гар нүүрний алчуур одоо хүртэл өлгөөстэй байдаг. Их хурлын гишүүд, захиргааны бүх ажилтан түүнд гараа арчицгааж, эгээ л Н. слесарь шиг жорлонгийн суултуур дээр нь гардаг. Ариун цэврийн цаас тун цөөхөн газар байдаг бөгөөд оронд нь янз бүрийн байгууламжуудын төсөл төлөвлөгөөг ихэвчлэн хэрэглэдэг.

Хотын уран барилгын нэгэн өндөр мэргэжилтэн маш гоёмсог албан тасалгаанд суудаг ч тасалгааных нь хаалга байшин тэр аяараа доргитол тасхийтэл савдаг байсан юм. Харин жижүүр авгайн чих нь дүлийрчээ.

Соёлын сайд хэзээ ч кино найруулагчдад хэдий үнэн ч амьдралын сөрөг талуудыг л амтархан шүүмжилж, эцэс төгсгөлгүй үнэн, шавар шавхай, муу муухайг сурталчилж болохгүйг, саарал, үзэмжгүй цамц өмссөн бүдүүлэг эрчүүдийг оронд өндөр гуалиг жүжигчид сонгох хэрэгтэй гэдгийг хэлж байсангүй. Н.слесарь ийм кино үзээд өөрийн үнэн дүр төрхөө олж харан шоолох боловч үүнээс зөвхөн сөрөг чанар, аргагүйдсэн мухардал л нэмэгдэх нь гарцаагүй. Миний бодлоор ямар нэг хэмжээгээр Холливуудын киноны марзан боловч тансаг байдал, аз жаргалтай төгсгөлөөс нь жишээ авах хэрэгтэй.

Оросын нэгэн нэртэй сонинд Москвад газрын хөрснөөс бүхэл бүтэн барилга байгууламжуудыг ч арилган үгүй болгох чадвартай шидтэн Копперфильд ирэхтэй холбогдуулан Москвагийнхан Улсын Думын байрыг бүх төлөөлөгч гишүүдтэй нь цуг алга болгож өгөхийг хүссэн тухай бичсэн байдаг. Слесарь Н. сонинноос үүнийг гарчиглавал ард түмний сонгосон хүмүүсийг газрын хөрснөөс арчина гэдлэг чинь цаад утгаараа ард түмнийг арчихтай адил гэж бодох байх. Сонгогдсон хүмүүс ч бас над шиг новшнууд биз гэж тэр бодох байх. Ямартаа ч төлөөлөгч гишүүдийг эцэс төгсгөлгүй муулж, тэнэг мэтээр байнга харуулах хэрэггүй л болов уу!

Орос орны дээрх сөрөг бүрхүүл нь 1997 онд Эрхүү хотын захирагчийн сонгуулийн үеэр оргил цэгтээ хүрчээ. Хотын захирагчийн суудалд хулгайч, хүчингийн хэрэгтэн, “цэнхэр” гурав өрсөлдөж байлаа. Нэр дэвшигч болгоны “давуу талуудын” тухай орон нутгийн сонингууд байнга мэдээлж байв. Ард түмэнд хулгайч нь “цэнхэр”, хүчингийн хэрэгтэн хоёроосоо илүү санагдсан бололтой түүнийг сонгожээ.

- Бид ямар хаашаа янзын хүмүүс вэ?- гэж Эрхүүчүүд дуу алдан,- хулгайч, “цэнхэр”, хүчингийн хэрэгтэн гурваас захирагчаа сонгох болох юм аа!

Гэхдээ бидний амьдрал зөвхөн муу муухай дээр тогтдоггүй шүү дээ! Сайн зүйлс ч бас бий. Гэвч сөрөг бүрхүүлийн ноёрхлын үед сайн сайхан бүхэн мартагддаг.

## **Орцны уран бүтээл**

Волгодонск хотоос ирсэн 19 настай донын хасаг бүсгүй миний нарийн бичгээр ажилладаг байлаа. Хэзээ ч билээ нэг хар тамхичин бүсгүйчүүд рүү үрлэн сумтай буугаар буудахад сумны хэлтэрхий нүдийг нь оносон юм. Бид түүнд гурван хүнд хагалгаа хийж байж харааг аварч, нүдтэй нь үлдээсэн юм.

Түүнийг манай эмнэлэгт байх үед манай эмч нарыг Иринагийн ер бусын аялгатай яриа ихэд зугаацуулдаг байлаа. Яриа нь чамгүй олон зүйр цэцэн үг, ёж хэллэгээр дүүрэн байдгаас гадна ер бусын эелдэг зөөлөн хэллэгээрээ ялгарч байлаа. Жишээ нь, эмч нарыг Оросын төв нутагт бүдүүлгээр “эмч-авгай “ гэж нэрлэдэг бол Ирина эмчээ:

- Лилия Фуатовна бол маш сайн эмэгчэн,- гэдэг байлаа.

Нэг удаа тэр нүднийхээ боолтыг аван:

- Хараач тэр, хун кэрээ сууж байна,- гэхэд нь хотод хун байхгүй дээ гэж би их гайхлаа. Гэтэл хэрээг хэлсэн юм байж. Шаазгайг тэр ховч шувуу гэдэг байв. Тэнгэрийн од түүнийхээр одон , халбага нь *хашиг* байлаа. Шөнө болжээ гэхийн оронд сөө болчихож, өглөө гэдэг үгийг *өрүндэ* гэхээс өөрөөр хэлдэггүй. Халаасыг өвөр гэж, харин жижигхэн халаасыг *бичгэн өвөр* гэж гэдэг байлаа.

- Халиагийч! (хараач.- Э.М.), тэнгэрт төөмгуа одонтоо, битүү сартай сөө байна,- гэж тэр ярина.

Би Иринад Н.слесарийн тухай бүлгийг уншиж өгөн түүний бодлыг асуутал,

- Орц болгон тийм биш ээ. - гэж хариулаад, - Би Уфагийн орцондоо ороход зүүлээд эхэлдэг (ой гутаад- Э.М.) юм. Өргөст хэмх, өөр бас янзан бүрийн хог *новш* шалаар нэг хөглөрөөд л... *Шумар* (гэрэл.- Э.М.) аваад явчихсан юм уу хаашаа юм, байдгаараа *бэмбээнээд* гэртээ ормагц хаалгаа *хэрж авдаг* (хаалгаа түгжиж.- Э.М.). Буратино юм уу, бүгдээрээ эврайн юмаа баллатлаа баяжчихаа юу гэж гайхдаг юм. Харин манай Волгодонскийн орц бол ёстой гоё зургаар дүүрэн байсан шүү.

- Янз бүрийн эсэн бусын зургаар уу?

- Үгүй дээ. Доны бид чинь *сэхээтэй* (ухамсартай) юм. Энэ орц чинь *бүхнээ* (нийтийн) юм бол энэ чинь бас минийх ч мөн гэдгийг бид ойлголгуа яахав. Эцэг эхчүүд маань мөнгөө нийлүүлээд будаг, цемент авч, хүүхдүүд бид бүх *нүкэнийг* (нүх.-Э.М.) нь цементээр таглаж, аавууд өөрсдөө ханыг будсан юм. Харин ганцхан *хумхай* (харамч.- Э.М.) хүн л мөнгө өгөөгүй дээ. Дараа нь бид за, хүүхдүүдээ ажлаа *кийгээт* (ажлаа эхэлцгээе,- Э.М.) гээд ажилдаа орон ханан дээрээ зураг зурж эхэлсэн. Нэг .....гэдэг көвүүн байсийм. Тэр ханан дээр зургийн экийг гаргаж, бид түүний нь буддаг байсийм. Би такь, оцон шувуу гээд нэлайн кэдэн юм зурсан. Хүн бүр л зургаа илүү *кийхийг кичээж* (хийхийг хичээж,- Э.М.) байсийм.

- Тэгээд ийм зурагтай орц ямар сэтгэгдэл төрүүлж байсан юм бэ дээ?

- Өө, - гэж Ирина дуу алдаад,- орж ирсэн хүн бүр л "*шишчүү*(гайхсаны тэмдэг,- Э.М.), энэ чинь орц биш уран зургийн үзэсгэлэн байш дээ" гэж байсныг би итгэлтэй *кэлэх* байна. Манай орцны бүх хүүхэд мэдлэг, *амьтай* (боловсролтой,- Э.М.) сайн хүмүүс болсон. Ганц ч хар тамхичин байхгүй шүү. Учир нь өөрсдийн гараар гоо үзэсгэлэнг бүтээсийм чинь. Манай орцны хүүхдүүдийн хамгийн том нь л гэхэд Наташка одоо нөхөрт гарчихсан, *сувай шаргачин шиг* (махалчихсан) болчихсон ч одоо хүртэл орцондоо шинэ зураг *кийсээр* л байгаа. Манай орцонд орсон хэн ч *чимээгуа өнгөрдөгүа* (дуугүй өнгөрдөггүй,- Э.М.), биднийг магтдаг, *хамаагуа* (тайван байна) байна гэж байдаггүй юм. Бусад орцны хүүхдүүд ч мөн манай орцыг хараад *сэкээрэн* (санаа авцгаан,- Э.М.) орцондоо янз бүрийн зураг *кийж* эхэлсэн. Хэн ч орцныхоо хаалгыг *кэрхээ* (түгжихээ) байсан.



- Танай орцыг бузарлаж байсан удаа бий юу?

- Байлгүй яах вэ! Хоёр ч удаа. Эхнийх нь зах дээр бөөнөөр нь гурван зоосоор зарсан ч болохоор архичдын нэг нутгийн архичин Петрович байсныг манай залуус олж барин (илрүүлсэн, - Э.М.), балбуурдаж (зодож, - Э.М.), түүн шиг иймэрхүү юмнуудыг бөөн бөөнөөр нь орцноосоо гаргаж хаях болно гэж кэлцгээсэн. Одоо нэг качийм (хачин, - Э.М.) чимээгуа яваад, бас экнэрайн багтай хорхой гэж молигдоод (худал яриад, - Э.М.) явдаг юм. Архаг (архаг архичин, - Э.М.) юмтай амьдарч байгаа эмэгэй хүн сайхан байж чадахгүй гэдгийг ойлгодоггүй юм.

- Хоёр дахь нь тэгээд хэн байсан юм бэ?

- Манай нэг есаул-хөршийнд нэг келдүүс (хойд нутгийн хүн, - Э.М.) ирээд заваарч эхэлсэн юм. Тэр үед би бичкэн (бага, - Э.М.) байсан ч, бузарлаж байгааг нь хараад гаргүй, хөлгүй, толгойгүй болно доо гэж омогшиж (харааж, - Э.М.), түүн шиг амьтныг манай орцноос хөөдөг юм гэж хэлэхэд тэр бас дүлээ (дүлий, - Э.М.) байж, над руу чичилж (уурлаж) хайкирав. Энэ үед аав маань гарч ирэн хүүхдийг гомдоож байгаа хүн өчигдөр үхдэг. Харин түүн шиг муу юмнуудыг мөглөндөх (шоронд суулгах, - Э.М.) хэрэгтэй гэсэн.

- Ирина чиний бодлоор бол Оросын хойд нутгийн ард түмэн урд нутгийн ард түмнээс илүү соёлтой юу?

- Үгүй, би тэгж хэлмээргүй л юм байна. Энд хүйтэн л юм. Би энд 12 сард ирэхэд бүх дэлхээн хэмжигчид ч эвдэрмээр тийм хүйтэн, эрүү шүд зодолдож, хамаг шүдээ хугалмаар хүйтэн байсан шүү. Манай тэнд ч усан үзэм ургаад л дулаахан шүү. Гэхдээ би энд ажилдаа дуртай, өвчтнүүддээ хайртай.

Үнэхээр ч энэ бүсгүйн эргэн тойронд эерэг бүрхүүл байдаг юм. Оросын өнцөг булан бүрээс ирсэн өвчтнөөр хүрээлүүлдэг энэ бүсгүй хэзээ ч сонгодог маягийн хүйтэн хөндий нарийн бичгийн дарга мэт аашилдаггүй. Үргэлж хүнд хэлэх ямар нэгэн дотно үгтэй, халуун цайтай, намайг хүлээгээд сууж байгаа хүмүүст хагалгааны дараа ядарсан байгаа тул хүлээх хэрэгтэй гэдгийг учирлаад ойлгуулчихдаг байсан юм.

Хүмүүс бидэн дээр сүүлчийн найдвараа тэээ ирдэг гэдгийг Ирина сайн ойлгодог, энэ найдварыг нь бөхөөхгүйн тулд байдгаараа хичээдэг байсан юм. Өвчтнүүд ч түүнд хайртай байдаг байлаа. Ингэснээр эмчилгээний нэгэн гол тулгуур хүчин болох эерэг бүрхүүл нэмэгддэг байсан. Украинаас ирсэн нэгэн өвчтөн нарийн бичигтэй утсаар ярихад өөрийг нь дахин хараа орно гэдэг бүрэн итгэл төртөл ярьсан болохоор энд ирсэн гэж хэлж билээ. Тэрээр үнэхээр ч хараа орсон юм. Харин Ростов нутгийн өвчтнүүд хүндэт өвчтөний жагсаалтанд орсонсон.

Зурагт орц Иринагийн сэтгэл бүрэлдэн тогтоход ямар нөлөө үзүүлснийг хэлэхэд хэцүү. Гэвч эцэг эх, хүүхдүүд нөхцөл байдлыг эерэг тал руу нь эргүүлж, нийтийн бузар газрыг хүүхдийн уран бүтээлийн төв болгож чадсан нь эндээс илт

харагдаж байгаа юм. Хамгийн гол нь тэд үүнийг Н.слесарийн адил засаг захиргаа, ард түмэн рүү чихэлгүй өөрсдөө хийж чадсан юм. Мэдээж энэ орцны оршин суугчдад сайн нь мууг ялснаас үүдэлтэй эерэг бүрхүүл үүссэн байх.

Харин донын хасаг Ирина бүсгүйд яг л энэ чигээрээ үлдэж, эелдэг доны аялгуут орос хэлээ бүү мартаарай гэж хэлэх байна.

Тэгвэл оросын орц хонгилуудыг яах хэрэг вэ? Орцон дахь бохир заваан, эмх замбараагүй байдалд уг орцны оршин суугчдыг торгох хэрэгтэй гэж би бодож байна. Уул нь засвар хийж, зохион байгуулж өгөх ёстой ОСНАА –ийн байгууллагуудыг чангалах хэрэгтэйсэн. Гэвч ингэж мөрөөдөлтгүй биз дээ. Засвар хийдэг ОСНАА-ийн ажилтнуудад аль хэдийн сөрөг бүрхүүл, тэр ч бvн хэл тэдний бүдэг ногоон будгаар будсан хана туургыг нь хараалын vг, шvлс зэргээр vнэлдэг оршин суугчдыг vзэн ядах сэтгэл хэдийн тогтсон. Ийм тохиолдолд мөнгө амлаад ч хэрэггүй. Амь өрсөн хулгай хийчихээд, нулимж, бузарладаг хvмvвсийн төлөө тэд харин юу ч хийхгүй. Сөрөг бүрхүүл гэдэг чинь биднээс хvчтэй зvйл.

Хэрвээ бохир орцнуудын оршин суугчдыг торгож эхэлвэл тэд хамгийн заваан суудаг хvмvвсийг тэр дор нь олж, тэднээр торгууль төлүүлж, хийх юмаа олж ядсан тэтгэврийн хөгшдийн нэгээр жижvвр тавьж, өөрсдөө мөнгө нийлvвлэн, засвар хийвэл дахиад бузарлахаа болих биз ээ. Удалгүй өрсөлдөөний зөн совинд нь нөлөөлснөөр хэний орц илvv вэ гэж өрсөлдөцгөөж эхэлнэ.

Би л гэхэд орцондоо байнга шээдэг хvнийг дор нь олсон. Хэдэн жаалуудад дөхөн очиж ширvvnээр:

- Та нар цахилгаан шатанд шээдэг уу?

- Vгvй, бид биш ээ, хоёр давхарын Дима, - гэж жаалууд толгойгоо унжуулан хэлэв.

Жаалууд миний гуйлтаар хоёр давхрын Димаг зодсоноор цахилгаан шатыг жорлон болгодог замбараагүй байдал зогссон. Гэтэл хагас жилийн дараа дахиад л хэн нэгэн цахилгаан шатанд шээж эхлэв. Жаалууд долоон давхарын нэгэн архичин ингэдэг гэж хэллээ. Миний хvсэлтээр хэсгийн цагдаа тvвнд шаардлага тавьсан боловч нөгөөх нь энэ талаар тохирсон хууль дvрэм байхгvйг ашиглан цахилгаан шатанд шээсээр байлаа. Тэгэхээр нь би тосон харандаа аваад “Цахилгаан шатанд шээдэг хvн бол жинхэнэ .....” гэж бичив.

Жаалуудын хэлснээр нөгөө архичин миний бичсэнийг арилгаад дахиад л цахилгаан шатанд шээж орхисон байлаа. Би дахиад л биччихэв. Архичныг орцноос гарах орох болгонд нь “.....” гэж дууддаг жаалуудын гавьяагаар энэ нэрнээсээ салахгvй байсаар орцонд шээхээ больсоноор vл барам удалгvй энэ орцноос нvвгээд явчихав. Түүнд бага ч гэсэн өөрийгөө хvндэтгэх vзэл vлдсэн бололтой.

Дээрх бичээсээр бvх цахилгаан шатнууд зэвсэглээсэй гэсэндээ би vвнийг бичсэнгvй. Гэвч хvн бузарлахаасаа айдаг байх ёстой. Энэ тал дээр М.Зоценкогийн яриа маш сонирхуштай юм:

“Оросын нэгэн зохиолч бохир гудам, шавар шавхай, вхсэн муурын дүр зурагнаас дур нь гутан явдаг байжээ. Гэтэл түүнд Герман рүү явах боломж олджээ. Тэрээр Германы гудамжаар яван цэвэр цэмцгэр байдлыг нь гайхан биширч өөрийн ард түмнээ хараан зүхэж явлаа. Жорлонд ороод цэвэр цэмцгэр байдал болон цонхны тавцан дээр байрлуулсан цэцгийг бахдан харсаар “ажлаа” дуусаад өмдөө татан гарах гэтэл хаалга нь онгойсонгүй. Зохиолч маань хашгирч эхэлжээ. Германчүүд цуглан ямар нэгэн юмийг өөрсдийн хэл дээр шулганан байв гэнэ. Удалгүй тэд оросоор ярьдаг нэгэн хүнийг олж ирэхэд:

- Чи усаа татчихаач, бузарлаад орхичих юм, тэгвэл наад хаалга чинь өөрөө онгойно,- гэжээ.

Тэр үед Орос зохиолч соёлтой германууд хүртэл цэвэрч нямбай байхын тулд янз бүрийн арга хэрэглэдэг юм байна гэдгийг ойлгосон ажээ.”

Хүмүүсийг соёлтой байлгахаас бүү ай. Соёл өөрөө олдохгүй соёлыг олж авахын тулд тэмцэх хэрэгтэй.

Хэрвээ ЗЦГ-ын үүрэг нь аюулгүйн бүсээ товчлоогүй эсвэл хурд хэтрүүлсэн жолоочийг амдан торгох төдийхнөөр хязгаарлагдалгүй гадаа хамаа замбараагүй нүх шуудуу ухагч, усан дээр цардмал зам тавдаг манай замын “мэргэжилтнүүд”-тэй тэмцдэг байсан сан бол манай зам тун удалгүй Европын орнуудын нэгэн адил болохсон. Хэрвээ ЗЦГ-ын ажилтнууд зүлгэн дээр машинаа тавиад, тэндээсээ хар шороо наасаар хотод орж ирдэг жолооч нарыг торгодог байсан бол борооны үед машин тэрэг маань цэвэрхэн, өмд маань шавар шавхайгүй байхсан.

Хэрвээ гудамжаа трактор юм уу, гахай шувуу л явж болохоор болгодог тосгоны оршин суугчдыг шийтгэдэг байсансан бол тэд аль хэдийн хайрга авчран аятайхан зам тавьчихсан байгаа даа.

Хэрвээ зусланд гардаг айлууд зөвхөн өөрийн зуслангийн хэсгээсээ гадна түүн рүү хүрэх замд жоохон ч атугай хөрөнгө оруулалт хийдэгсэн бол тэд намар болоход гагцхүү газар уснаа явагчаар зусландаа очих гэж зовохгүй болохсон.

Харамсалтай нь бид бүгд Н.слесарийн нэгэн адил засаг захиргаанаасаа бүхнийг шаардаж, үглэн сөрөг бүрхүүлээ нэмсээр байна.

Бид яг ийм маягаар бүх насаараа үглэсэн ч чадна. Биднийг өөрсдөө амьдрах орчноо өөрчлөн, эргэн тойрондоо эерэг бүрхүүл үүсгэх хэрэгтэй. Өөрсдөө ухамсартайгаар хичээсэн тохиолдолд л сөрөг бүрхүүлээ эерэг бүрхүүлээр солих боломжтой.

## **Улсын ерөнхийлөгчийн үүрэг**

“Яагаад улсын ерөнхийлөгч ийм их эрх дархтай байдаг юм бэ?” гэсэн асуултанд хариулцгаая. Ерөнхийлөгч тэнэг, ухаантай, муухай санаатай, сайхан сэтгэлтэй, хүчтэй, дорой гээд хэнбугай ч бай асар өндөр эрх мэдэлтэй байдаг. Аль ч улсад ерөнхийлөгчөөс илүү ухаалаг чадварлаг хүмүүс байгаад, тэд хэдий өдөр болгон зурагтаар үг хэлж, тэдний

нийтлэл өдөр болгон сонинд хэвлэгддэг ч байлаа гэсэн ерөнхийлөгчийн эрх мэдлийн өчүүхэн хэсэгт ч хүрэх мэдэлтэй болж чаддаггүй. Яагаад?

Орос Улсын засгийн газар ганхаж эхэлж байсан тэр үеийг санацгаая. Жишээ нь, М.С.Горбачёвын засаглалын сүүлийн саруудад түүний хэлсэн үг юунд ч нөлөөлөх хүчгүй, зөвхөн хүний инээд хүргэдэг болсон. Яагаад урьд өмнө хэлсэн үг бүрийг нь хүндэтгэлтэйгээр тушаал мэт хүлээн авдаг байсан шүтээн маань ийм марзан алиалагч болж хувирав аа?

Ямар нэгэн дээд хүч хэсэг хугацааны турш ерөнхийлөгчийг дэмжиж, хүн олон нийтийг захирах хүчин чадлыг нь идэвхжүүлж өгдөг байснаа хэсэг хугацаанд түүнийг ерөнхийлөгчийн индэр дээрх өрөвдөм хүүхэлдэй болгон хүмүүсийн санаа сэтгэлийг урвуулдаг юм шиг сэтгэгдэл төрж байв.

Миний бодлоор тухайн улсын ард түмний сэтгэлийн энерги өөрсдийн сонгосон ерөнхийлөгч дээр төвлөрч, удирдах тэргүүлэх эрхийг нь олгоод зогсохгүй мөн хүн тус бүрийн хувь заяанд оролцох эрхийг олгодоогоор ерөнхийлөгчийн хэмжээгүй бүрэн эрх тайлбарлагдаж буй юм. Хүн тус бүрийн итгэл найдвар, хүсэл зориг нь удаан хугацааны турш биеллээ олохгүй байвал хүмүүсээс гарсан сэтгэлийн энерги суларч, үр дүнд нь ерөнхийлөгчийн эрх мэдэл мөн суларч эхэлдэг.

Өөрөөр хэлбэл улс орны ерөнхийлөгч гэдэг бол ахуйн асуудалтай тулгардаг жирийн нэг хүн гэдгээсээ гадна итгэл найдвараа биелүүлэхийг хүлээж суугаа тус улсын ард түмний сэтгэлийн энергийн төвлөрөл гэдгээ хэзээ ч мартаж болохгүй юм. Улс орон хэдий чинээ том байна ерөнхийлөгч нь төдийчинээ их сэтгэлийн энергийн төвлөрөл болдог. Ерөнхийлөгч болж буй хүн ерөнхийлөгчөөсөө гадна улс орны сэтгэлийн энергийн төвд нь ордоогоороо чанарын хувьд сэтгэхүйн өөр төлөвт орж шилждэг. Дээр хэлснийг нотлохын тулд М.С. Горбачёвын одоогийн болон арван жилийн өмнөх яриаг харьцуулж үзье. Үнэн чанартаа тэрээр нэг л зүйлийг ярьж байсан юм. Улс орны сэтгэлийн энергийн төвд байх тэр үед түүний яриа сэтгэлийг асар их хөдөлгөдөг байсан бол энэ эпицентрээс хол байгаа өнөө үед хэлсэн үг нь ямар ч сэтгэгдэл төрүүлдэггүй байна.

Ерөнхийлөгч хүн улс орны сэтгэлийн энергийн төвөөс гарна гэдэг нь маш аймшигтай зүйл юм. Чухам энэ эпицентр л түүнд хязгааргүй их эрх дархыг олгож, чухам энэ эпицентр л өөрийгөө ач холбогдолтой хүн гэдэгт сэтгэл хангалуун байх мэдрэмж өгдөг. Эпицентрт байх нь маш тааламжтай боловч, түүнийг алдах нь хүчтэй шаналал авчирдаг тул огт энэ эпицентрт ороогүй нь дээр биз ээ.

Эпицентрт байр сууриа хэрхэн хадгалах вэ? Энэ номонд бичсэн зүйлд үндэслэвэл “Ерөнхийлөгчийн албыг байр суурь, эрх мэдлээ бататгахад хэзээ ч бүү ашигла. Харин сайн сайхан хайр энэрлийг бататга.” гэж зөвлөмөөр байна. Газар дэлхий дээрхи соёл иргэншил бүхэн эрх мэдлийн төлөөх үзэл ноёрхсноос болж мөхөцгөөж байсныг санах хэрэгтэй. Эрх мэдлээр давамгайлах үзэл бол

сэтгэлийн сөрөг энергийн илрэл бөгөөд мэдлэг, сайн сайхан, хайр энэрлийг шүтэн дээдлэх үзэл нь эерэг сэтгэлийн энергийг араасаа дагуулдаг юм.

“Эрх мэдлийг ямар ч хамаагүй үнээр олж ав” гэсэн зарчим нь хүмүүсээс муу муухай болгоныг өдөөн гаргаж, улс орны дээр сөрөг бүрхүүл бүрэлдэн тогтоход нөлөөлдөг. Харин мэдлэг сайн сайхан, хайр энэрлийг шүтэн дээдлэх нь эерэг бүрхүүл бүрэлдэн тогтоход нөлөөлснөөр эрчимтэй хөгжлийн замд оруулдаг.

Коммунизмийн үед удирдагчид эрх мэдлийг шүтэх үзлийг ашиглаж байсан ч мэдлэг, сайн сайхан хөгжих бага ч атугай орон зай үлдээж байсан нь үнэн. Тэгэхэд Б.Н Ельцин юу хийв? Харамсалтай нь коммунизмийг ялан дийлсэн энэ хүн нэр их хөдөлмөрийн дүнд олдсон эрх мэдлээ амтархан таашааж, эрх мэдлийг шүтэх үзлээсээ ангижирч чадсангүй.

Энэ хүн үнэхээр ардын баатар болж, ард түмний итгэл найдварын эпицентрт зүй ёсны дагуу орсон боловч үүнийг ухаалагаар ашиглаж чадсангүй. Ард түмэн түүнээс агуу бүтээлч үйлс гарна хэмээн итгэж байсан ч Ельцин эдийн засгаа төсөл төлөвлөгөөний нэгэнд даатган, бүх хүчин чармайлтаа хувийн эрх мэдэл, эрх ашгаа хадгалж бататгахад зориуллаа. Парламентаа, ардын хурлаа тэр ч бүү хэл холбоот улсаа золиосолсны хүчинд тэрээр эрх мэдлээ хадгалж, бэхжүүлж чадсан билээ. Гэвч хэрвээ улс орны сэтгэлийн энергийн төвд байхдаа тэр эрх мэдлээ тогтоох гэж чармайлгүй бүтээлчээр ажиллаж байсан бол түүний эрх мэдэл одоогийнхоос улам хүчтэй болох байсан гэдгийг ойлгосонгүй. Егор Гайдар болон түүний эдийн засгийн онол нь сэтгэлийн энергийн төвөөс гарч, харин энэ байр суурийг эзэлж байсан Ельцин ард түмнээ өдөр тутмын бүтээлч үйлсэд бус харин улс төрийн хуваагдал, тэмцэлд уриалан дуудсан. Ельцин үүнийг ойлгоогүй, ойлгох ч үгүй байх гэдэг нь маш харамсалтай. Чухам түүний засаглалын үед хээл хахууль, эрүүгийн гэмт хэрэг, ард түмнийг мөлжигч “МММ” мэтийн байгууллагууд үүсч, Чеченьд иргэний дайн эхэлж, банкууд эрх дураараа аашлах нь туйлдаа хүрсэн билээ. Үүнтэй зэрэгцээгээр төв рүү буюу ерөнхийлөгч руу чиглүүлсэн ард түмний сэтгэлийн эерэг энерги суларсаар уур хилэн, сөрөг муу бүхнээр чигчигдэж, ерөнхийлөгч ардын баатар байснаа цаасан хүүхэлдэй болж хувирсан. Эрх мэдлийн төлөөх тэмцэлдээ Ельцин түүнийг итгэл найдварын төлөө илгээсэн ард түмнээ мартсан юм. Ард түмнийг тэгтэл залхаасан хоосон лангуу, тасалбарын хоолтой коммунист дэглэм коммунист Зюгановтай цуг эргэн ирнэ гэж айсандаа л ард түмэн түүнийг хоёр дахиа сонгосон.

Гэсэн ч Орос оронд эрх мэдлийг шүтэх үзлийн хор уршгийг ойлгож энэ шүтээний өмнө сөгдөхийг хүсээгүй хүмүүс ч бас байна. Жишээ нь ийм хүмүүсийн тоонд Башкир, Татарстаны ерөнхийлөгчид Муртаза Рахимов, Ментимер Шаймиев нар орно. Тэд үндэсний бэлэг тэмдэг гэсэн нэрийдлийн дор хууль дүрэм болон эрх мэдлийг шүтэх үзлээр нэвчсэн Оросын сөрөг бүрхүүлээс улсаа тусгаарлан бүхэлдээ бүтээн босгох үйл явцад оруулсан билээ.



Итгэл найдварын төв (зохиогчийн зураг)

Эд өөрсдийнхөө байр сууринд сууж болзошгүй өрсөлдөгч нараа мөрдөж мөшгих биш, харин хүмүүс, аж ахуй, байгууллага, сангийн аж ахуй, фермер гэх нэгжүүдээ хамгаалан тэтгэх ажилд бүх анхаарлаа хандуулжээ.

М.Рахимов Башкирийн бүхий л нефть олборлогч, боловсруулагчид болон эрчим хүчний компаниудыг нэгдмэл нэг зорилготой цогц болгон нэгтгэснээр завсрын “утсан дээр бөөн бөөнөөрөө унждаг” хүмүүсийн тоог эрс бууруулжээ. Энэ нь үр ашгийг завсрын зуучлагч нарын халаасанд тарааж өгөх бус харин үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулах боломжтой болгожээ. Чухам ийм л учраас Башкир Оросын бусад нутгыг бодвол тогтвортой эдийн засагтай болжээ. Рахимовын эдийн засгийн бодлогод нэлээд сонирхолтой ер бусын хэсэг байдгийг ардын хар яриагаар илэрхийлвэл “Ферм бол хулгай хийх газар биш юм.” гэсэн өгүүлбэр болно. Энэ үг хэр ортойг би сангийн аж ахуйн нэгэн ферм эрхэлдэг Фанис гэгчтэй хийсэн яриагаар үзүүлье.

- Фанис, чиний энэ аж ахуйгаас тэжээл алга болдоггүй юм уу? -гэж би асуув.

- Алга бололгүй яах вэ! Бараг тэн хагасыг нь хулгайлчихдаг юм.

- Хэн

- Тосгонд амьдарч байгаа хүн бүхэн... Тэжээлгүйгээр яаж үхрээ өсгөх вэ? Бидэнд газар өгөхгүй. Машин техник бүгд л сангийн аж ахуйнх... Даргатай нь ярилцаж болох биш! Тэгээд л хулгай хийж байхгүй юу...

- Үгүй, тэгээд, Фанис...Оросын хуулиар бол ямар ч аж ахуйтан газар авч, юу дуртайгаа тарьж болно гэдэг биз дээ! Хүнийхийг хулгайлж байснаас өөрөө тэжээлээ тарьж байсан нь дээр биш үү?

- Тэр чинь огт боломжгүй зүйл. Дарга газар өгөхгүй. Хэрвээ бүх газраа тараагаад өгчих юм бол түүнд ямар ч эрх мэдэл үлдэхгүй шүү дээ! Түүнд эрх мэдэл хэрэгтэй. Тэгээд л бүгд хулгайлахаас өөр мэхгүй болж байгаа юм.

- Дарга өөрөө хулгайлдаг уу?

- Бүр яаж хулгайлдаг гэж санана. Тэр хичнээн олон үхэртэй гээч.

- Тэгэхээр саальчид ажиллаад л бусад нь хулгайлаад л байдаг юм биз дээ?

- Тиймээ, саальчид өглөө 5 цагаас эхлээд борви бохисхийлгүй ажилладаг.

Гэртээ байгаа үхрээ ч бас маллана. Тэгээд бас ферм рүү ирэх гэж 3 км газар шавар шавхай туучих болдог.

- Та тэгээд саальчдаа эргүүлдэг үү?


- Үгүй, хэн ч тэднийг эргүүлдэггүй.

- Яагаад, Фанис?

- Тосгон тэр аяараа мэдэх болно шүү дээ!

- Яагаад? Ферм дээр шөнө хэн ч юу ч мэдэхгүй шүү дээ! Чи чинь тэндээ өрөөтөй юм байгаа биз дээ!

- Ферм дээр болохгүй...



Эрх мэдэл (зохиогчийн зураг)



- Яагаад тэр вэ, Фанис?

- Саальчин бүсгүйг шөнө фермдээ дагуулаад ирэх л юм бол хэн нэг нь тэжээл хулгай хийх гэж ирээд л барьчихна шүү дээ!

Бүх тариачин, аж ахуй эрхлэгчид даргаас айсандаа үг дуугүй захирагдаж хулгайч царайлан нийтийн өмчөөс хумсалдаг энэ тогтолцоог М.Рахимов эвдэж чаджээ. Башкирийн ерөнхийлөгч тун олон газар энэ цогцыг нурааж, олон зуун тариачныг хувьдаа газар авч, ажиллан, өөрсдийгөө хүндэлдэг болгосон. Түүнээс гадна тэрээр хадлангийн талбайг хагалах, голын эрэг дээр ферм байгуулах, ойд мал хариулах гэх мэтийг зогсоож чадсан. М.Рахимов бүтээн босгох үйлсэд эрх мэдлээ бүрэн дүүрэн ашигласан. Тэр эрх мэдлээ муйхраар барьж тогтооход бус, харин бүтээн босгоход бүрэн ашигласан юм.

Татарстан улсын ерөнхийлөгч М.Шаймиев бүтээн босгох үйлсдээ татварын уян налархай систем ба “сул доройд нь бус харин хүчтэйд нь тусал” гэсэн хоёр зарчмыг хэрэглэжээ.

Уян налархай татварын системийн тусламжтайгаар М.Шаймиев маш олон байгууллагуудыг гарцаагүй дампуурлаас аварчээ. Жишээ нь зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа Татарстанд нефть олборлох нь ашиггүй болсон бөгөөд үүний улмаас 10 мянган нефть олборлох салбарынхан ажилгүйчүүдийн эгнээнд нэмэгдэх байлаа. Татарстаны ерөнхийлөгч нефть олборлогчдыг бүх татвараас чөлөөлж, гагцхүү орлогын татварыг цалингаасаа төлж байхаар болгожээ. Ийм нөхцөл байдалд нефть олборлогчид сэргэж, удалгүй тогтворжин, одоо салбараа авч үлдэж чадсан идэвхитэй татвар төлөгчид болцгоожээ. Мөн зүйлийг дэлхийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн бусад үйлдвэртэй амжилттай өрсөлдсөөр байгаа Казаний эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрийн талаар ч хэлж болно.

Мөн цэргийн үйлдвэрүүд, жишээ нь, нэг нь л 1 тэрбумын үнэтэй хэт авианы бөмбөгдөгчийн үйлдвэрийн талаар хэлж болох юм.

“Хүчтэйд нь тусал” гэсэн зарчим нь зөвхөн “хүчтэй” хүмүүс буюу сангийн аж ахуй, фермер, албан байгууллагуудад хөрөнгө оруулалт хийснээр “хүчтэйчүүдийг” түргэн хөл дээр нь босгож, “сул дорой” нь бүрэн дампууралд оруулж, тэднийг “хүчтэйчүүд” залгадаг. “Хүчтэний” гарт орсон “сул доройчууд нь” тэднээс богино хугацаанд сайн үр дүнтэй ажиллах аргыг сурдаг. Үр дүн нь маш хурдан илэрч 1996 онд үр тарианы ургац 1 га газраас 28 центнерийг хураан (Кубаас их), ихэнх бүсэд бүр 60 центнерээс давсан (Голландаас их) байна.

Ард түмнийхээ итгэл найдварын төвд буй М.Шаймиевын үйл ажиллагааны үр дүн гэвэл нэлээд хэдэн жил Татарстаны эдийн засаг жилд дунджаар 4.5 хувиар өсч байхад оросын бусад бүс нутгуудаар жил бүр тогтмол унаж байгаа нь ажиглагдаж байна. М.Шаймиев эрх мэдлийн төлөөх тэмцлийн хор уршгийг ойлгож, эрх мэдлийг тахин шүтэх үзлээс холдож чаджээ. Тийм ч учраас тэрээр татар ч

бай, орос ч бай бүх ард түмний хайрыг булааж, тийм ч учраас дараачийн сонгуульд Татарстаны хүн амын 96 хувийн саналаар ялжээ. Эрх мэдлийн төлөө огт тэмцээгүй хүн ямар ч хүчин чармайлтгүйгээр, зөвхөн ард түмний хайр хүндэтгэлийг хүлээж чадсанаараа дахин эрх мэдэлтэй болов. Хэрвээ эрх баригчид, ерөнхийлөгчид өөрсдийгөө алдаж болшгүй ард түмний итгэл найдварын төвд байгаагаа мэддэгсэн бол, хэрвээ эрх мэдлийг зөвхөн эрх мэдлийн төлөөх тэмцлээр бус, харин бүтээлч үйлсээр олж болдгийг ойлгодогсон бол хөгжил цэцэглэлт, ард түмний хайр хүндэтгэл зайлшгүй ирэх жамтай.

### **Оросын ерөнхийлөгчийн оронд байсан бол би юу хийх байсан бэ?**

Ямар нэг зааварчилгаа өгөх нь биеэ тоосон байдлын нэгэн илрэл болдог тул даруу занд харшилдаг юм. Гэсэн ч энэ номонд тайлагнасан шинжилгээнд тулгуурлан өөрийн бодол санаагаа хэлэх гэсэн юм.

1. Ерөнхийлөгч хүн ард түмний итгэл найдварын төвд оршин буйгаа, ард түмний итгэл найдварыг бүтээлч үйлсээр бататгах ёстойгоо ухамсарлах хэрэгтэй. Эрх мэдлийн төлөөх тэмцэл нь хорхой хүргэм бөгөөд үргэлж анхаарлын төвд байдаг юм. Гэсэн хэдий ч энэ нь ард түмний хувьд утгагүй зүйл бөгөөд зөвхөн эрх баригч эсвэл эрх мэдэлд тэмүүлэгч хоёрын хувьд л утга төгөлдөр бөлгөө. Бүтээлч үйлс нь үл анзаарагдам бөгөөд урт удаан хугацаа шаарддаг боловч энэ нь ерөнхийлөгчийн хангах ёстой хөгжил дэвшлийг үүсгэгч цорын ганц хүчин зүйл юм. Хувьсгал болон эрх мэдлийн төлөөх тэмцэлд өөрийгөө зориулсан төрийн тэргүүний нэр түүхэнд бичээстэй үлддэг бол бүтээлч үйлс болон хөгжил дэвшилд бүхнээ зориулсан төрийн тэргүүн ард түмний хувьд гавьяа зүтгэлтэй баатар болдог.

2. Ерөнхийлөгч хүн сэтгэлийн энергийн ертөнц гэж байдаг ба үүнтэй холбоотойгоор улс орон сөрөг эсвэл эерэг сэтгэлийн энергийн бүрхүүлд орж болохыг ойлгох ёстой. Улс орны дээрх сөрөг бүрхүүлийг эерэг болгох нь удирдах байгууллагуудын улс орноо хөгжил цэцэглэлтийн замд оруулах үүргийн үндэс суурийг тавьдаг.

3. Оросын ерөнхийлөгч нь дээр өгүүлсэн бусдын муу муухайг жигшин зэвүүцэвч өөрөө мөн муу муухай үйл хийж буй Н. слесарь мэт коммунизмын дараа үеийн хүмүүс одоогийн байдлаар улс орны ихэнх хувийг эзэлсэн байдгийг ойлгох ёстой. Эдгээр хүмүүсийн аар саар зүйлд бухимдах, үглэх, чанаргүй хөдөлмөрлөх нь улс орны дээр сөрөг бүрхүүл үүсэхэд чамгүй нөлөөлдөг. Ийм хүмүүсийг дахин хүмүүжүүлэх хэрэгтэй. Үүний тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглаж, хүүхдийн зурсан зургаар чимсэн орцны хана мэт нийтийн эзэмшил газрыг байгуулсан үлгэр жишээг өргөн сурталчлах хэрэгтэй. Ерөнхийлөгч болон засаг захиргааны байгууллага орц, жорлон, гудамж талбай, зам гүүр, хот

тосгон, цэцэрлэгт хүрээлэн зэргийн ариун цэврийг сахиулаагүй санаачлаагүй байдлыг халж, энэ чиглэлд сайн ажиллаж буй хүмүүсийг дэмжин урамшуулах хууль тогтоол гаргах нь зүйтэй. Хүмүүсийг “олон нийтийн газар дахь цэвэр цэмцгэр, дэг журамтай байдлыг өөрийн гараар бүтээнэ” гэсэн зарчмын дагуу ажиллуулж сургах нь аажимдаа сайхан сэтгэл давамгайлж, соёлын түвшин, хөдөлмөрийн чанар сайжрахад хүргэх юм.

4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг үнэхээр “дөрөвдөгч засаглал” болох, ард түмний өмнө тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг болохыг нь ойлгуулах хэрэгтэй. Олон нийтийн мэдээллийн байгууллагуудын удирдлага нь үргэлжийн эрх мэдлийн төлөөх эцэс төгсгөлгүй зодооныг сурталчлах, амьдралын эерэг тал, шинжлэх ухааны ололт амжилт, хүний идэвхи санаачлага зэрэгт хангалтгүй анхаарах нь улс орны дээр сөрөг бүрхүүл үүсэхэд нөлөөлдөгийг ойлгох нь чухал. Хагас тэнэг хүмүүст зориулсан, ой гутам зажилж буй бохины реклам, эсвэл энэ ертөнцийн цорын ганц аз жаргал бол эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэл мэт зарлах рекламуудыг багасган реклам сурталчилгааны чанарыг сайжруулах хэрэгтэй.

5. Ерөнхийлөгч, хотын захирагч, ардын хурлын төлөөлөгчид зэргийг сонгох сонгуулийн компани ажлын өртгийг хязгаарлаж өгөх хэрэгтэй. Энэ нь зүгээр нэг үрэгдсэн мөнгө бус, харин хор уршиг дагуулсан мөнгө юм. Учир нь шар будаа тараах явдлаар өнгөлөн далдлалт хийсэн худал магтаалаар улс орны том том албан тушаалд хээл хахууль авч баяжсан хүмүүс гарч ирж байна. Сонгуульд өрсөлдөгч талуудыг ижил хэмжээнд санхүүжүүлэх хууль батлан, түүнийгээ хатуу мөрдөх нь энгийн хүмүүсийн эрх баригчдад ханддаг сөрөг хандлагыг урьдчилан сэргийлэх болно. Сонгууль нь шидэт бүтээлгийн зарчмаар хэрэгждэг, хорхой хүргэм амлалтаар бүтээлч хөдөлмөрөөс олон түмний анхаарлыг холдуулдаг, өрсөлдөгчтэй боловч үргэлж шударга байдаггүй тоглоом болон хувирчээ.

6. Эдийн засгийн бодлогын хувьд М.Шаймиевын туршлагыг бүх оросын хэмжээнд хэрэглэх, Татарстанд үр ашгаа өгсөн уян хатан татвар, “хүчтэйд нь туслах” зарчмыг хууль тогтоомжид тусгаж өгөх боломжийг судалж үзэх нь утга төгөлдөр байхсан биз ээ. Холбоот улс байна гэдэг нь холбоот улсын татварыг хасан нийтийн хүчин чадлыг төлөөлсөн бүс нутгуудын бие даасан байдал юм гэдгийг ойлгох хэрэгтэй. Бүс нутгаас төв рүү мөнгийг шахаж, буцааж тусламж болгон олгох болдог одоог хүртэл байсаар буй хэт төвлөрсөн дэглэмт эдийн засаг нь бүс нутгийн удирдагч нарт Москвагийн оршин суугчид сэтгэлгүй цэвдэг хүнд сурталтанууд мэт санагддаг болтол нь залхаажээ. Эдийн засгийн аргаар аажимдаа Москва руу чиглэсэн сөрөг урсгалаас салж, төв засаг захиргааны нэр хүндийг нэмэгдүүлж, салан тусгаарлах санаа бодлоос урьдчилэн сэргийлэх хэрэгтэй.

7. “Шинэ орос” гэсэн ойлголт нь шинэ маягийн үйлдвэрлэл гэсэн үг огт биш, харин наймааны үйл явцын дунд өөрсдийн ердөө л 100-300-хан хувийг нэмэгдүүлэх чадвартай завсрын зуучлагчийг хэлнэ. “Шинэ оросууд” мөнгийг хялбар аргаар олддог бөгөөд тэдний хувь гэдэг ер нь бол хүн болгоны халааснаас хулгайлж буй мөнгө юм гэдгийг ард түмэн ойлгодог юм. Тийм ч учраас тэдний мерседес, хотын гаднах амины орон сууц, банкны гоёмсог барилгууд зэрэг нь ард түмэнд тустай хөдөлмөрөөс бус харин хулгайгаар олдсон эд зүйлс мэтээр олны санаанд буудаг болохоор улс оронд сөрөг урсгалыг нэмэгдүүлдэг. Чухам эдгээр завсрын зуучлагчид дэлгүүрийн хоосон лангууг дүүргэсэн гавьяатай боловч зуучлах явцаас олж буй хязгааргүй орлогийг хязгаарлах арга хэмжээ авах нь зүйтэй. Өрсөлдөөн нь ихэнхдээ монополичлолыг зогсоож чаддаггүй учир үнэ ханшыг багасгаж, эсвэл тогтвортой болгож чаддаггүй байна. Тийм ч учраас ихэнх капиталист орнуудад үйлдвэрлэлийн (шатахуун, гэрэл цахилгаан, талх, төмөрлөг гэх мэт) үндсэн бүтээгдэхүүнүүд буюу бусад үйлдвэрлэл шууд хамаардаг бүтээгдэхүүний үнийн дээд хязгаарыг тогтоож өгсөн байдаг. Зуучлагч нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран үнийн дүнгийн 7-30%-ийг завсраас нь нэмж, өөртөө авах эрхтэй ба үүнээс хэтэрсэн тохиолдолд хуулиар мөрдөгддөг байна. Энэ арга нь үнийг багасгаж, ханш уналтыг зогсоон, зуучлагчдын хязгааргүй орлогыг болон үүнтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийг хязгаарлаж, хамгийн гол нь “ав-зар” гэгчийн бус харин үндсэндээ үйлдвэрлэгчдэд ашигтай байдлыг бий болгодог. Ерөнхийлөгч болон засаг захиргаа дээр хэлсэнийг тэдний үр хүүхэд хамаатан садан нь хувьцаа эзэмшигч нийгэмлэг, пүүс компаниудад зуучлагчдын үүрэг гүйцэтгэдгийг эс харгалзан ойлгох байх гэж би бодож байна. Мөнгө хий хоосноос үүсдэггүй. Харин нэг халааснаас нөгөө рүү урсан ордог юм. Халаасандаа хэмжээ хязгааргүйгээр мөнгийг хүүдийлэгч зууч нь “хуулийн дагуу” хүмүүсээс мөнгө булаадаг учир олон нийтэд дэндүү хор уршигтай. Гэтэл хийснийхээ хирээр л мөнгө олох ёстой. “Ав-зар” системд үүссэн үйлдвэрлэлийн сөрөг сэтгэлгээ сайн юманд хүргэдэггүй. Завсрын зууч нь улс орныг баллах аюултай.

8. Орост ноёрхож байгаа банкны эрх дураараа аашлахыг ерөнхийлөгч таслан зогсоох хэрэгтэй. Энэ тохиолдолд АНУ-ын зэрлэг капитализмын үед түр зуур ихэнх банкны эздийг баривчлан, шалгалт хийсэн Рузвельтыг дурсаж болно. Шалгалтын дүнд ихэнх банкуудыг хааж, тэдний мөнгийг сайн ажилласан банкинд шилжүүлж өгсөн байна. Үүний дараа улс орон хөгжиж эхлэн, нийгэмд хээл хахууль багасаж, гэмт хэрэг ч цөөрсөн байна. Банкны нийгэмд гүйцэтгэх үүргийг ойлгохын тулд Москва болон бусад хотууд дахь гоёмсог байшингуудыг сайн ажиглацгаая! Энэ бол бүгдээрээ л банкны барилгууд билээ. Тус бүрийнх нь үнэ хэдэн арван сая доллараар хэмжигдэнэ. Эдгээр барилга хүчин чадал, мөнгө баялгийн бэлэг

тэмдэг болон сүндэрлэж, амьдралын жинхэнэ эзэн нь хэн болохыг чимээгүй илтгэнэ. Банкны ажилтны амьдрал ойлгоход бэрх нууцлаг ид шид эзэмшсэн мэт байдаг. Банкууд эдгээр гоёмсог барилгуудыг бариулах мөнгө хаанаас авдаг хэрэг вэ? Энэ мөнгийг банкууд хэт өндөр хүү болон үйлчилгээний хэт өндөр хөлс зэргээс олж авдаг. Харьцуулцаая л даа. Хөгжингүй орнуудын банкны хүү нь 3-7% байхад Орос 100-300% байна. Өөрөөр хэлбэл банкнаас авсан рубль болгондоо та багаар бодоход 2 рубль өгөх хэрэгтэй. Мэдээж банкинд орлого тэнгэрээс бороо мэт орж харин банкны хөрөнгө оруулалтгүйгээр оршин тогтнохгүй байгууллагууд банкинд нэмж өгөх ёстой нэг юм уу, хоёр рублээ олох гэж хуруу хумсаа хуйхлан зүтгэдэг. Эдгээр байгууллага хэлэх аргагүй тийм их шударга бус үйлдэл хийдэг. Банк хоорондын өрсөлдөөнөөр хөрөнгө оруулалтын хувь багасна гэдэг нь санааны гарз. Учир нь банк мөнгө эргүүлэх тогтолцоотой (хэн тэнгэрээс өөрөө унаад ирэх мөнгөнд дургүй байх билээ). Банк дампуурсан тохиолдолд эзэн нь хохирч үлдэх нь юу л бол. “Алга болсон” мөнгийг гадаадад буй дансандаа шилжүүлж амжсан байдаг бололтой. Оруулсан мөнгөний тэр дундаа хулгайн мөнгөний нууцыг сайтар хадгалж буй Швейцарийн банк буюу офшор бүсэд л дэлхийн гамшиг оршиж байна. АНУ-ын банкнуудыг өвдөг сөхрүүлэн, хээл хахууль, гэмт хэрэг ард түмний засаг захиргаандаа хандах сөрөг үзэгдэл зэргийг араасаа дагуулсан банкны эрх дураараа байдлыг зогсоож чадсан Рузвельт ямар зоригтой байв аа. Манайд ч мөн ийм зориг гаргах Оросын Рузвельт олдоно гэдэгт би итгэлтэй байна. Тэгвэл банкны гоёмсог барилгууд хүмүүсийн халаасанд хуруу дүрэгч нууцлаг эрхэмийн орон байр мэт санагдан ард түмний бухимдалыг төрүүлэхээ больж, ард түмний жинхэнэ бахархал болон сүндэрлэж болох юм.

9. Орос орон үргэлж л өндөр хөгжилтэй шинжлэх ухааны ололт, гайхамшигтай эрдэмтдээрээ алдартай байсан. Зэрлэг капитализмын өнөө үед оросын шинжлэх ухаан шоовдорлогдож, арифметикийн энгийн нэмэх хасаж үйлдлийг л хийх чадвартай “шинэ орос”-ууд профессоруудаас ч хэдэн зуу дахин баян болсон. Ерөнхийлөгч, засаг захиргаа нуран унаж буй оросын шинжлэх ухааныг эргэн сэргээх нөхцөл бололцоог эрж хайх хэрэгтэй. Тиймээ, шинжилгээ судалгаа бүхэн, тэр тусмаа суурь судалгаа болгон түргэн хугацаанд үйлдвэрлэлд нэвтэрч, ашиг орлогоо өгдөггүй нь үнэн. Гэвч шинжлэх ухаан гэдэг бол спортын нэгэн адил улс орны нүүр царай болдог юм. Анагаах ухааны судалгаа шинжилгээний төвд 46 сая долларын хөрөнгө оруулснаар Казаньд бүх Оросоос, бүх дэлхийгээс эмчлүүлэхээр өвчтөнүүд ирэх нь Татарстаны нүүр царайг илтгэж, улмаар улс орны эдийн засагт хөрөнгө оруулна гэж хэлсэн М.Шаймиевыг дурсахгүй байхын аргагүй. Мөн манай бүх Оросын Нүдний ба Нөхөн суулгавар мэс заслын төвийг Башкирын бус харин Оросынх гэдгийг нь ч үл харгалзан шинэ

цогцолбор бариулж буй Рахимовыг хэрхэн дурсахгүй байх билээ. Гэвч шинжлэх ухаан гэдэг бол зөвхөн нүүр царай, нэр төр биш юм. Шинжлэх ухаан нь мэдлэгийн ноёрхлыг тогтоосноор сэтгэлийн энергийн хуулиар сөрөг сэтгэлийн үзэгдлүүдийг эсэргүүцдэг байна. Жишээ нь хэрвээ телевиз юм уу, сонинд “Эрдэмтэнтэй хийсэн ярилцлага” булан оруулах юм бол, энгийн хүмүүс, тэр дундаа Н.слесарь маргааш нь бохир орцныг харааж зүхэх бус, харин тус сэдвийн талаар цоглогоор хөөрөлдөх болно. Мэдлэгийн ноёрхол нь сайн санаа, хайр энэрэл зэрэг үзэгдлүүдтэй зэрэгцэн оршдог бөгөөд эдгээр нь Нөгөө Ертөнцийн торсын орны (долгион хэлбэрийн амьдралын) үндэс нь болдог. Харин бид бол газар дэлхий дээрх амьдралын бодит хэлбэр төдийгүй мөн Нөгөө Ертөнцийн хүүхдүүд юм.

10. Ерөнхийлөгч улс оронд эх оронч үзлийг төрүүлэх ёстой. Америкчүүд үүнийг аль эрт ойлгож, хүмүүсийн тархинд өөрийн улсын тугийг гэртээ байлгах, улс орны сүлд дууг дуулах зэргийг оруулж өгсөн байна. Орос орны эх оронч үзэл нь тэр гэхийн тэмдэггүй болтлоо унасан. Эх оронч үзлийн үүргийг хэзээ ч үгүйсгэж болохгүй юм. Учир нь энэ нь армид бол цэргийнхний сэтгэлийн дэм, улс орныхоо тусын тулд хөдөлмөрлөх хүсэл, эх орноо хайрлах үзэл гэх мэт гараар баригдахгүй ч улс орны амьдралд асар их нөлөө, ач холбогдолтой бусад олон зүйлс юм. Эх оронч үзэл гэдэг нь аймшигт сөрөг бүхнийг эсэргүүцэгч эерэг сэтгэлийн энергийн нэг хэлбэр юм. Орост эх оронч үзлийг хэрхэн дэлгэрүүлэх вэ? Нэгдүгээрт олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нь ерөнхийлөгч болон засаг захиргааг инээдмийн тэнэг байдалтай мэтээр байнга харагдуулах нь эх оронч үзэл ба эх орноо хайрлах сэтгэл бүрэлдэн тогтоход сайнаар нөлөөлөхгүй нь ойлгомжтой. Хоёрдугаарт ерөнхийлөгч, засаг захиргаа, гишүүд өөрсдөө хүмүүсийн итгэл найдварын төвд оршиж буй учир хүн ардын эх оронч үзэл нь тэднээс ихэнхдээ шалтгаалдгийг ойлгох хэрэгтэй. Гуравдугаарт телевиз, радио болон сонин сэтгүүлийн удирдлагууд уран бүтээлдээ эх оронч үзлийг байнга шингээж өгч байх нь зүйтэй. Эх оронч үзэл ба Эх орноо гэсэн сэтгэл төлөвшсөн улс орныг бүгд маш их хүндэлдэг. Эрт дээр үеэс оросын хот байсан Севастополийн төлөө Ю. Лужков эх орончоор үг хэлэхэд бидэнд хичнээн сайхан санагдаж байлаа. Тэгэхэд Украйны үндэсний үзэлтнүүд Москвагийнхныг хараан зүхэж суусан. Хэрвээ оросын эх оронч үзэл өндөр хэмжээнд байсансан бол хэн ч оросыг хараан зүхэж зүрхлэхгүйсэн. Орос орон хэдийнээсээ ард түмнийхээ эх оронч үзлээр алдартай орон, энэ сэтгэлгээг бэхжүүлэх хэрэгтэй.

Ингээд эх орноо эргэн зохион байгуулах талаар энэ бүлэгтээ дүгнэлт гаргахдаа би энэ дүгнэлтийн ихэнх нь хүмүүст ойлгомжгүй, зөвхөн зөн совингоороо л мэдэрг болох хүний сэтгэлийн энергийн талаархи зүйлс байсанд маш их гайхсан. Нөгөө Ертөнцийн долгионы хэлбэрийн амьдралын үр төл болох бидэнд нарийн ертөнцийн хууль дүрэм хүний амьдралын “идэх”, “унтах”, “уух”

зэргээс ч илүү нөлөөлдөг бололтой. Гималайд шинжилгээний ангиар явсны дараах одоо үед би газар дэлхий дээрх амьдралыг Нөгөө Ертөнц бодит ертөнцийг эзэмших зорилгоор үүсгэсэн бөгөөд тийм ч учраас үүнийг эзэмших явцдаа бид цэвэр бодит аргаас гадна (хөрөөдөх, зүлгэх гэх мэт) хайр энэрэл, сайн сайхан санаа болон мэдлэг боловсролд үндэслэдэг зарчмыг мөн ашиглах хэрэгтэй гэдгийг ойлгосон.

Харин коммунизмын дараах үеийн үглээ Н.слесарь нийтийн орцыг гоёдог Донын хасаг бүсгүй Ирина шиг болох тэр үед Орос орон дэлхийн хүчирхэг гүрнүүдийн нэг болох юм гэж би бодож байна.

Долдугаар хэсэг

## **Хайр энэрэл, сайн сайхан болон хорон муу санаа**

Номоо төгсгөхдөө би дурдсан баримт нотолгоо, хийсвэр бодролуудад дүгнэлт хийе гэж бодож байсан юм. Гэвч миний бичсэн байгалийн тэр гайхам үзэгдлүүдийн үндсэнд (агуйд хадгалагдаж буй хүмүүс, Шамбал, сүүлчийн илгээмж гэх мэт) бүгдэд тодорхой “сайн сайхан, хайр энэрэл, муу муухай санаа бодол” гэсэн ойлголтуудын нэгдэл болон тэмцэл оршиж буйг би гэнэт ойлгоод өөрөө ч гайхлаа. Тэгээд энэ талаар эрдэмтэн хүний үүднээс бодох тусам ертөнцийн шашин бүрийн өгүүлдэг “хайр”, “нигүүлсэнгүй сэтгэл”, “муу үйл”, “нүгэл” гэсэн энгийн үгс улам бүр гүн гүнзгий яруу утга санаатай болж ирлээ.

Энэрэнгүй сайхан сэтгэл гэж чухам юу юм бэ? Муу санаа гэж юу юм бэ? Эдгээр ойлголтод бид гагцхүү амьдралаас иш татсан ахуйн тодорхойлолт л өгч чадна.

Сайн санаат хүнийг бид дотно үгс, гүндүүгүй зан чанар, зовсон нэгэндээ туслах өрөвч сэтгэл гэх мэт бусад олон сайн чанараар нь дүгнэж чадна.

Муу санаат хүнийг бид атаач, албан тушаал хөөцөлдөгч, гэмт хэрэгтэн, урвагч гэх мэт олон муу шинж чанартай холбож ойлгодог.

Харин хайр дурлалыг бид бүгд мэдэрч явсан. Энэ бол сэтгэлийн хөөрлийн мэдрэмж, эрч хүчний агуу их урсгал, өөр нэгнийг бурхан мэт дээдэлж, амь амьдралаа ч түүнийхээ л төлөө золиослохоос буцдаггүй гэгээн эрмэлзэл, олон арван нойргүй ч жаргалтай шөнийн бодрол юм гэдгийг санаж байгаа.



Хэрвээ “хайр”, “сайн санаа”, “хорон муу санаа” зэрэг ойлголтыг анхааралтай авч үзэх юм бол эдгээр мэдрэмжийг ямар нэгэн бодит хэмжүүр юм уу, шинжилгээгээр тодорхойлох боломжгүйг мэднэ. Энэ мэдрэмжүүд нь ухамсарын түвшинд байдаг ба зөвхөн бүдэг бадаг зөн совин л мэдрэмжийн сүлжээг тайлахад тус болдог. Гэвч энэ зөн совингийн шивнээ нь зарим тохиолдолд бүхлээрээ сэтгэлийн асуудлаа шийдэх хүсэлдээ хөтлөгдөж, бүхэлдээ сэрэл мэдрэмжиндээ ноёрхуултлаа хүчтэй байдаг. Жишээ нь ганцхан хайр дурлалаас болж бүхэл бүтэн улс орон мөхөж, хүмүүс үхэж, дэлхийн хэмжээний олон нээлт хийж байсан. Эрх мэдэлд дурлах хийгээд атаач үзэл нь доройтуулж, сая сая хүнийг үхэлд хөтөлж байсан. Биднийг хайр сэтгэл, сайн үйлс, муу муухайд даллан дуудагч зөн совингийн энэ их хүчин чадал хаанаас гарч ирж байна вэ? Энэ асуултанд хариулахын тулд уг номонд дурдсан ертөнцийн үүсэл, хүний хөгжлийн үндсэн хэсгүүдийг энэ талаас нь авч үзэцгээе!

Абсолютаас үүссэн матери нь нарийн болон бодит гэсэн 2 ертөнц болж хуваагдсан. Бодит ертөнц нь аажимдаа од, гариг эрхэс болон гариг хоорондын хий хоосныг бүрэлдүүлсэн. Нарийн ертөнц ч мөн адил өөрчлөгдөж байсан боловч уг өөрчлөлт нь арай өөр аргаар явагдсан юм. Нарийн ертөнцөд яваандаа нийлмэл болж байсан эргэлдсэн олон орон (торсын орон) үүсч байлаа. Өөрөөр хэлбэл нарийн ертөнц нь хэт өндөр давтамжтай торсын орны хөгжил маягаар хувьссаар иржээ. Чухам эдгээр торсын орон л бидний өдөр бүхэн зөн совингоороо мэдэрдэг үндсэн мэдрэмж болох хайр сэтгэл, сайн санаа, муухай сэтгэлийн эх үүсвэр болдог гэж бид үзэж байна.

## **Сайн санаа, мэдлэг болон муу санааны үүсэл**

Торсын үйлчлэл буюу хэт өндөр давтамжийн орны эрчлээс нь түүхэн хувьсалд маш их ач холбогдолтой байсан юм. Учир нь уг эрчилсэн оронд мэдээлэл хадгалагддаг. Энэ мэдээлэл нь торсын оронд мэдээллийг сайтар хамгаалах зорилгоор бүтцийг нь нарийн нийлмэл болгож, эргэн үйлчилж байжээ. Дашрамд хэлэхэд мэдээллийн оронд хадгалагдаж, дамжуулах нь ямар нэгэн ер бусын үзэгдэл биш ажээ. Ядаж л телевиз, радиог санацгаая!

Нарийн ертөнцөд ноёрхож байсан зарим хүчин хэт өндөр давтамжийн орныг эрчлүүлж байсан бол өөр нэгэн хэсэг хүчин уг эрчлээсийг задалж байлаа. Эрчлүүлж байсан хүчнүүд нь мэдээллийг хадгалан ашигтай үйл хийж байсан тул эерэг байсан ба эрчлээсийг задалж байсан хүчнүүд нь мэдээллийг устгаж байсан тул муу үйлийг хийдэг сөрөг хүчнүүд болжээ.

Физикчдийн тогтоосноор сэтгэлийн энерги (бодох, мэдрэмж, зөн совин гэх мэт) нь хэт өндөр давтамжийн үелзлэлд оршдог бөгөөд нарийн ертөнцөд шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл бодох үйлийнхээ үед бид нарийн ертөнцийн энергийг ашигладаг ба уураг тархи нь сэтгэлийн торсын орныг эргүүлэхэд нөлөөлж өгдөг.

Тийм ч учраас олон физикчид (Г.Шипов, В.Лобанков) нарийн ертөнц ба сэтгэлийн энергийг шууд адилтган үзэж, хүний сүнс буюу сэтгэлийг эрчилсэн орон хэлбэртэй нарийн ертөнцийн энергийн бөөгнөрөл гэж үздэг.

Эдгээрээс үзэхэд нарийн ертөнцөд мэдээллийг хадгалан орныг эрчлүүлж буй үйл явцыг бид сайн сайхантай уялдуулан, харин мэдээллийг арчин, орны эрчлээсийг задалж буй үйл явцыг муу муухайтай холбож ойлгодог юм байна. Бид дан ганц бодит ертөнцийн бус, мөн нарийн ертөнцийн бүтээгдэхүүн учир сайн мууг ялгаж чаддаг. Сайн сайхныг мэдрэх нь бидний сэтгэлийн торсын оронд мэдээлэл хадгалагдахыг мэдрч байгаа хэрэг бөгөөд муу муухайг мэдрэх нь сэтгэл оюун дахь мэдээлэл устгаж буйг мэдрч байна гэсэн үг.

Ийнхүү сайн муу хоёр нь нарийн ертөнцийн хөгжил хувьслын үндсэн хоёр суурь хэлбэр юм. Хэрвээ сайн санаа ялан дийлэх юм бол нарийн ертөнцийн торсын оронд мэдээлэл хадгалагдан мэдлэг үүсдэг. Хэрвээ муу муухай ялан дийлэх юм бол мэдлэг устаж үгүй болдог. Сайн муугийн тэмцлийн талаарх мэдээллийг агуулж буй мэдлэг нь сайн сайхан ялан дийлэхэд нөлөөлж түүхэн хөгжлийг үүсгэдэг. Тиймээс мэдлэг ба сайн сайхныг Энэрэнгүй сэтгэл + Мэдлэг гэсэн нэгэн цогц хэлбэртэй болгон авч үзэж болно.

**Анхдагч,  
хоёрдогч,  
гуравдагч....  
Сайн ба Муу**

Нарийн ертөнцийн түүхэн хөгжлийн эхэн үед анхдагч сайн сайхан, анхдагч муу муухай л байсан гэж би бодож байна. Тэдний хоорондын тэмцэл нь “үхэх сэхэхээ үзсэн” тулаан байсан юм. Хэрвээ сайн сайхан ялвал тэрээр бүр мөсөн ялах ба хэрвээ муу муухай ялах юм бол энэ нь сайн сайхныг устгаж байлаа. Энэ харилцан буулт хийдэггүй дайнд сайн сайхан нь мэдлэгтэй хавсарч байсан учир ялж байлаа. Муу муухайг ялан дийлж эхэлжээ.

Гэвч муу муухай устаж эхэлтэл нарийн ертөнцийн түүхэн хөгжлийн явц ч мөн зогслоо. Учир нь мэдлэг нь юуны өмнө сайн муугийн хоорондын тэмцлийн талаарх мэдээлэл байсан юм.

Муу муухай ч гэсэн мөн адил түүнтэй тэмцэхийн тулд мэдлэгийг ашиглаж байсан ба сайн сайхантай тэмцэх гэдэг түүхэн хөгжлийн явцтай байжээ. Миний бодлоор бол хоёрдогч муу муухай үүссэн байх ёстой. Хэрвээ анхдагч муу муухай нь торсын оронг задалж, бичигдсэн мэдлэгийг арчдаг нарийн ертөнцийн энергийн нэг хэлбэр байсан бол, хоёрдогч муу муухай нь нарийн ертөнцийн хэт өндөр давтамжит долгионыг сайн сайхнаас нөгөө тийш эргүүлдэг энерги байлаа. Ингэж үүссэн муу муухай буюу сөрөг торсын орон ч мөн адил муу муухайн сайн сайхантай хийсэн тэмцэл дунд олж авсан мэдлэгийг хадгалах чадвартай байжээ. Хоёрдогч муу муухай үүссэнтэй зэрэгцэн хоёрдогч сайн сайхан мөн үүссэн нь хоёрдогч муу муухайтай тэмцэх тэмцлийн явцад олж авсан мэдээллийг хадгалдаг илүү нарийн бүтэцтэй эерэг чиглэлд эргэсэн торсын орон байлаа.

Сайн сайхан болон муу муухайн тухай мэдлэгүүд хоорондоо тэрсэлдэж эхлэв. Хоёрдогч сайн сайхан үүсмэгц үүнтэй тэрсэлдэн, тэмцлийн тухай илүү мэдлэг шингээсэн, илүү төвөгтэй эрчлээс бүхий сөрөг торсын орон болох гуравдагч муу муухай үүссэн. Энэ мэтчилэн дөрөвдөгч сайн сайхан үүнтэй тэмцэхээр дөрөвдөгч муу муухай, тавдагч, зургаадагч гэх мэтээр сайн муугийн мөнхийн тэмцлийн илрэл болж торсын орны бүтэц улам ээдрээтэй болох замаар нарийн ертөнцийн түүхэн хөгжил бүрэлдэж иржээ.

Энэ нь цаашдаа асар их эерэг, сөрөг мэдээллийг агуулсан нарийн ертөнцийн торсын орны үелэж тогтсон адармаатай нарийн нийлмэл бүтцийг бий болгосон.

Сайн муу санаа тэрсэлдэхийн сацуу сайн муугийн тухай хуримтлагдсан мэдлэг оюун хоорондоо тэмцэлдэж байв. Эдгээрээс нарийн ертөнц дэх торсын орон жам ёсны дагуу төгс төгөлдөржин хөгжихэд муу бодол санааны мөнхийн оролцоо ямагт шаардагдаж иржээ. Тэгвэл сайн сайхан болон муу муухай энэ тэнцүү хэрэгтэй гэж үү? Тэгвэл яагаад бид сайн сайхныг дээдлэн биширч, хөгжил дэвшлийг сайн сайхантай холбодог юм бол?

Эдгээр асуултанд хариулахын тулд нарийн ертөнцийн торсын оронд анхдагч сайн сайхан, анхдагч муу муухайн хооронд амь дүйсэн мөнхийн тулаан болж, улмаар хоёрдогч гуравдагч сайн сайхан муу муухайн мөнхийн тэмцэл шатлан үргэлжилсэн нь аливаа хөгжил дэвшлийн хөшүүрэг болжээ. Харин анхдагчуудын тулаанд муу муухай санаа бодол ялвал нарийн ертөнцийн торсын оронд эвдрэл хямрал үүсч мэдээлийн сүйрэл нүүрлэнэ. Энэ тохиолдолд байгаль ертөнцийн хууль бүхнийг эхнээс нь эхлүүлэх болно. Иймээс муу муухай санаа бодолтой эвлэрэх, хүлцэнгүй хандах нь уруудан доройтох, унах мөхөхийн эх буюу.


## **Хайр гэж юу вэ?**

Аль ч тохиолдолд мэдлэг үүсгэдэг сайн муугийн тэмцлийн явцад сайн сайхны дэнсийг хүндрүүлдэг нэгэн зүйл байдаг нь хайр энэрэл юм.


Нарийн ертөнцийн торсын орны тухай дээр өгүүлсэн таамаглалын үүднээс авч үзвэл хайр гэж юу вэ? Миний бодлоор бол хайр гэдэг нь өөр нэгэн эерэг торсын орны үйлчлэл доор эерэг торсын орны эрчлээс нэмэгдэж, чангарах үйл явц юм. Өөрөөр хэлбэл хоёр эерэг торсын орон харилцан үйлчилсний улмаас бие биенийхээ эрчлээсийг нэмж, муу муухайг эсэргүүцэх чадвар нь ихэссэнээр мэдээллийг илүү хадгалж, шинэ мэдээлэл хүлээж авах боломж ихэсдэг.

Муу муухай торсын орнуудын харилцан үйлчлэл эрчлээсийнхээ түвшинг нэмэгдүүлэх чадваргүй. Тийм учраас муу муухайд хайр энэрэл гэж байдаггүй, зөвхөн амиа бодох үзэл л байдаг. Учир нь нэгэн торсын цогцод (сэтгэл) буй сөрөг торсын орны анхдагч, хоёрдогч, гуравдагч болон бусад түвшин нь нэгнийгээ нэмэгдүүлэх чадвартай юм.

Сайн ба муу (зохиогчийн зураг)



Хайр (зохиогчийн зураг)



Хайр энэрэл бол эерэг торсын орны хамгийн гол буюу анхдагч түвшинд үйлчилж, түүнд муу муухай шингэхээс болон мэдээлэл арчигдаж, сүнсийг гэмтээхээс хамгаалж байдаг. Сайн ба муугийн мэдлэгийн хэмжээ адил тэнцүү тохиолдолд хайр энэрэл л сүнсийг аврах хүчин зүйл нь болдог. Чухам хайр энэрэлийн тусламжтайгаар л эцсийн бүлэгтээ сайн сайхан ялан дийлдэг. Чухам хайр энэрэл л нарийн ертөнцийн долгион, амьдралын үндсэн хэлбэр болохынхоо хувьд мэдээллийг хүлээж авах хадгалах баталгаа болж өгдөг.

### **Нөгөө Ертөнц ямар зохион байгуулалттай вэ?**

Энэ номыг бичих явцдаа орчин үеийн физикийн болон шашны судар бичээст үндэслэн Нөгөө Ертөнц гэдэг бол нарийн ертөнц дэх сансрын долгионы шинжтэй амьдралын нэг хэлбэр юм гэсэн дүгнэлтэнд хүрэв. Энэ бүлэгтээ Хайр, нигүүлсэнгүй сэтгэл, мэдлэг, муу муухай гэсэн ойлголтыг шинжлэх үед эдгээр нь Нөгөө Ертөнцийн үйл ажиллагааны үндэс юм гэсэн таамаглал надад төрсөн юм.

Сансрын долгионы шинжтэй амьдралын хэлбэр! Ийм юм оршин байдгийг төсөөлөхөд ч бэрх байна. Амьдрал гэж юу юм бэ? Амьдрал гэдэг бол юуны түрүүнд бодит субстратын мэдээллийг хадгалах, дамжуулах (уламжлуулах) болон хөгжлийн замаар явж, өөрөө төгөлдөржих чадвар юм. Хэрвээ газрын амьдралын мэдээллийг хадгалж, дамжуулах үйл явц нь генийн цогцоор бүрэлддэг бол, сансрын долгионы шинжтэй амьдралд энэ үүргийг нарийн ертөнцийн торсийн орон гүйцэтгэдэг ба харин долгион хэлбэрийн амьдралын хөгжил нь сайн санаа (сэтгэлийн эерэг энерги) ба муу муухайн (сөрөг сэтгэлийн энерги) нэгдэл, тэмцлийн үр дүнд явагддаг байна.

Анхдагч, хоёрдогч, гуравдагч дөрөвдөгч гэх мэт сайн ба муу үйл үүссэнээр, мөн “эерэг” торсын орнуудын хоорондын харилцан үйлчлэлээр (хайр сэтгэл) эрчлээс нь чангарснаар Нөгөө Ертөнцөд мэдээллийг (мэдлэг) хадгалж, дамжуулаад зогсохгүй мөн өөрөө хөгжиж, төгөлдөржих чадвартай нарийн нийлмэл бүтэцтэй орнууд үүсч эхэлжээ. Эдгээр нарийн ертөнцийн нийлмэл бүтэцтэй энергийн бөөгнөрлийг олон давхар торсын орон мэтээр төсөөлж болох бөгөөд энэ нь сэтгэл оюун юм. Сэтгэл оюуны хамгийн чухал мэдээллийг хадгалдаг гол хэсэг бол сүнс юм. Шашин нь сүнс бол үхэшгүй мөнх гэж үздэг билээ. Өөрөөр хэлбэл, нарийн ертөнцийн торсын оронд түүхэн хувьслын үр дүнд бий болж, хадгалагдсаар ирсэн гол мэдээлэл нь үхэшгүй мөнх юм. Сэтгэлийн торсын орон болон (эфир бие гэх мэт) дотор нь хадгалагдаж буй мэдээлэл алга болж болно. Гэсэн ч сэтгэлийн гол торсын орон нь буюу сүнс нь мөнх үлддэг.

Шашинд сайн санаатай, муу санаатай хоёр төрлийн сүнс байдаг гэсэн ойлголт байдаг. Үнэхээр ч тийм бололтой. Зарим сүнс нь эерэг торсын орноос тогтдог байхад зарим нэг нь сөрөг торсын орноос тогтдог байна. Нөгөө Ертөнц

дэх түүхэн хөгжил нь сайн муугийн тэмцэл дээр үндэслэдэг учраас сүнс болгон нь сайн ба муу эхлэлтэй байдаг бөгөөд зарим тохиолдолд сайн нь дийлж байхад зарим тохиолдолд муу нь дийлдэг байна. Гэсэн ч сайн сүнс нь төгөлдөржих боломж илүү их байдаг байна. Учир нь эерэг торсын орны эрчлээсийг өөр эерэг орны үйлчлэлээр (хайр сэтгэл) нэмэгдүүлэх боломжтой. Тийм ч учраас шашин нь хайр сэтгэлийг амьдрал, хөгжлийн үндэс хэмээн номлодог.

Сүнснүүдийн харилцан үйлчлэлийн үр дүнд сайн үйлийг нэмэгдүүлдэг хайр сэтгэлийн үүрэг нь Нөгөө Ертөнцийн түүхэн хувьслын явцад сүнснүүд хоорондоо харьцан аажимдаа Ертөнцийн Мэдээллийн Оронд нэгдсэний дүнд бүрэлдэн тогтсон байх. Цахим тооцоолуурын сүлжээ маягийн сүнсний нэгдмэл сүлжээ үүссэн нь бүх сүнсэнд ерөнхий шинжтэй мэдээлэл төвлөрөхөд хүргэжээ. Сүнс болгон түүхэн хөгжлийн явцад төгөлдөржих тусам нэгдмэл мэдээллийн ач холбогдол улам бүр их болж байлаа. Учир нь сайн муугийн тэмцлээр үүссэн хөгжлийн явц нь зөвхөн сүнс тус бүрийн хэмжээнд тохироод зогсохгүй мөн Ертөнцийн мэдээллийн орны түвшинд бүх нийтээр засварлагдах ёстой болж байлаа. Нэгдмэл үүрэг нь уг нийтийн шинжтэй мэдээллийг торсын орондоо бичиж авсан арай хөгжингүй хэсэг сүнсэд шилжиж эхэллээ. Ертөнцийн Мэдээллийн орныг, түүнд нэгдсэн бүх сүнснүүдтэй нь удирдаж эхэлсэн нь хөгжлийн явцыг түргэсгэн эдгээр нийтийн шинжтэй торсын орнуудыг нарийн нийлмэл бүтэцтэй болгожээ. Түүнд асар их хэмжээний мэдээлэл цугларч, үүнийгээ Нөгөө Ертөнц дэх долгион хэлбэрт амьдралыг удирдахад хэрэглэж байлаа. Мэдээллийн болон сэтгэн бодох агуу чадвартай нарийн ертөнцийн энергийн ийм бөөгнөрлийг маш олон давхар торсын орон мэт төсөөлж болох бөгөөд үүнийг л бид Бурхан хэмээн нэрлэдэг гэж би бодож байна.

Бурхан гэдэг бол сансрын долгион хэлбэртэй амьдралын буюу Нөгөө Ертөнцийн удирдлагын төв юм. Бурхан гэдэг бол мөн чанартаа Сансрын Оюун Ухаан юм. Шашны ном зохиолд Бурханд тэрсэлсэн бүх л муу үйлийг удирддаг муу муухайн Агуу сүнсний тухай багагүй бичсэнийг олж үзэж болно. Үүнээс үзэхэд сансрын долгионы хэлбэрийн амьдралыг удирдагч эерэг төв (Бурхан) ба сөрөг төв (муу муухайн Агуу сүнс) гэсэн хоёр удирдлагын төв байдаг мэт төсөөлөл төрж байна. Үнэхээр тийм гэж үү?

Миний оюун ухаан Сансрын Оюун Ухаантай харьцуулахад хариугүй өчүүхэн тул энэ тухай дүгнэхэд хүнд байна. Гэсэн ч миний бодлоор сайн муу гэсэн 2 бурхан байдаггүй, гагцхүү нэгэн нэгдмэл Бурхан байдаг. Дээрх хийсвэр бодролоос үзэхэд сайн сайхан ба муу муухайн хоорондын тэмцэл нь Нөгөө Ертөнцийн түүхэн хөгжлийн үндэс болдог. Сүнс бүхэн өөртөө сайн ба муу гэсэн хэсгүүдийг агуулдаг ба энэ нь мөнхөп төгөлдөржих гол нөхцөл болдог гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Түүнчлэн Бурхан нь агуу хүчирхэг сүнс болохынхоо хувьд сэтгэлийн энергийн эерэг сөрөг хэсгүүдийг ч мөн агуулдаг. Бурхан гагцхүү сайн санаатай

байж болохгүй. Учир нь ертөнцийг удирдахаг сайн үйлсээс гадна шийтгэх шаардлага гардаг бөгөөд сайн ба муугийн хоорондын тэмцэл нь сансрын долгион хэлбэрт амьдралын хөгжлийн үндсэн нөхцөл болдог.

Бурханы сайн үйлийг бид сайн ба муугийн хоорондын тэмцлийн төлөө ноогдож байгаа хамгийн дээд магтаал хэмээн хүлээж авах хэрэгтэй юм. Харин Бурханы муу үйлийг бид муу муухайтай тэмцэхээс татгалзсан мууг устгаж буй шийтгэл гэж ойлгож болно. Гэвч Бурхан хэзээ ч муу муухай үйл хэргийг бүрэн үгүйсгэхгүй. Учир нь сайны муутай хийсэн тэмцлийн дүнд мэдлэг буюу ертөнцийн үүслийн үндэс бүрэлдэн тогтдог. Тийм ч учраас “Бурхан нэгдмэл” гэсэн үг нь бүх шашин нэгдмэл байх ёстойг хэлж буй бус мөн сайн үйл болон шийтгэлийн утга учир нэгдмэлийг зааж байгаа юм.

Бурхан хайр энэрлийн агуу хүчийг агуулдаг. Учир нь Бурхан өөрөө хайр сэтгэлийн үр дүн (өөрөөр хэлбэл сайн үйлийг дэмжиж, мэдлэгийг хадгалагч сүнснүүдийн хоорондын харилцан холбоо) юм. Бурханаас үүдэлтэй сайн үйл нь ч тэр, шийтгэл нь ч тэр, аль ч тохиолдолд жинхэнэ агуу дурлалын илрэл болдог. Бурхан сайн сайхан муу муухайг ялан дийлсэний үр дүн учраас юуны түрүүнд сайн сайхны эхлэл юм.

Мэдлэг бол юуны өмнө сайн муугийн хоорондох тэмцлийн үр дүн юм. Харин мэдлэгийг олж авах, хадгалах нь амьдралын үндэс суурь болдог. Чухам үүгээр л амьд матери үхсэнээсээ ялгардаг.

Уг нь Бурхан ч гэсэн хөгжихийн тулд эсрэг эхлэлтэй байх ёстой. Эсрэг хүч нь түүнд өөрт нь байдаг ба энэ нь сайн ба муу юм. Магадгүй өөр хэмжүүрт, орчлонд буй өөр “бурханы” дүрээр ч энэ эсрэг дүр нь байдаг байж болох юм. Гэвч энэ бол хүний ахархан ухаан хүршгүй хэсэг билээ.

Ингээд дүгнэж үзвэл, Нөгөө Ертөнцийн үйл ажиллагааны үндсэн зарчим дараах мэт:

- Эерэг сөрөг сэтгэлийн энергийн нэгдэл, тэмцэл мэт үүссэн Нөгөө Ертөнц нь нарийн ертөнцийн торсын орны сайн, муугийн тэмцлийн үр дүнд бий болсон мэдлэгийг хадгалах, хөгжүүлэх түүхэн хувьслын явцад хөгждөг. Шинэ мэдээллийг олж авах нь сайн ба муугийн тэмцэлд нэмэр болдог.

- Хэрвээ муу муухай бүрэн ялан дийлэх юм бол бүх л мэдээлэл арчигдаж мэдээлэл “үхэж” эхэлнэ. Тийм ч учраас сайн муугийн түүхэн тэмцэлд сайн сайхан давамгайлдаг. Уг давамгайллыг хайр энэрэл өгдөг юм. Учир нь хайрын хүчээр эерэг торсын орнууд (“сайн сайхан”) харилцан үйлчилж, эрчлээсний түвшингээ нэмэх (тийм ч учраас сөрөг торсын орныг эсэргүүцэх чадвартай болдог) боломжийг олгодог.

- Хайр нь гол мэдээллийг хадгалагч сэтгэлийн энергийн бөөгнөрлийг (сүнснүүдийг) нэгдмэл цогц (Ертөнцийн Мэдээллийн Орон) болгоход нөлөөлж, агуу хүчит сүнс (Бурхан) мэдээллийн орны удирдлагыг үүсгэдэг. Хайр энэрэл Бурханыг үүсгэжээ.

## **Нөгөө Ертөнц ба газар дэлхийн амьдрал**

Эдгээр зарчмын дагуу Нөгөө Ертөнц, бодит ертөнц гэх мэт материйн бусад хэлбэрүүдийг эзэмших чадвартай сансрын долгион хэлбэртэй амьдрал үүсжээ.

Газар дэлхий дээрх бодит амьдрал нь сүнсний нягтралаар үүссэн гэдэгтэй би бүрэн дүүрэн санал нэг байна. Газар дэлхий дээрх амьдрал нарийн бүтэцтэй молекулууд өөрөө үүсэж, амьд биет болон нэгдсэн гэдэг онолуудыг нь шашны үүднээс ч тэр, орчин үеийн физикийн үүднээс ч тэр огт тайлбарлаж болдоггүй. Эдгээр онолын огт тайлбарлаж чаддаггүй зүйл нь юу вэ гэвэл орчин үеийн шинжлэх ухаанд өчүүхнийг нь ч тайлж болдоггүй нарийн төвөгтэй бүтэцтэй генийн цогц хэрхэн үүссэн талаарх асуудал юм. Үнэхээр ч цорын ганцхан эсийн ДНХ-ийн молекул хүний бүхий л бие махбодийн, тэр ч бүү хэл эд эс, молекул болгоны талаарх мэдээллийг агуулдаг гэж итгэхэд ч бэрх байдаг. Ийм сонирхолтой, мэдээллийн их багтаамжтай ДНХ-ийн молекул өөрөө үүссэн нь бүр ч сонирхолтой асуудал.

Хэрвээ газар дэлхий дээрх амьдрал нь сүнс нягтарших замаар үүссэн гэж үзэх юм бол дээр хэлснийг хялбархан тайлбарлана. Нөгөө Ертөнц дэх сайн муугийн нэгдэл, тэмцлээс болж нарийн ертөнцийн торсын оронд мэдээллийг бий болгох, хадгалахаас үүдсэн түүхэн хөгжлийн үйл явцаар нарийн ертөнцөд дээд зэргийн бүтэц зохион байгуулалттай биет буюу сүнс үүсэхэд хүрчээ. Төвийн агуу хүчирхэг сүнс буюу Бурхан нь сүнсийг орон зайн өөрчлөлтөнд оруулж, бодит ертөнцийн материд сүнсийг нягтруулан оруулах арга олсон байна.

Бид нарийн ертөнцийн зохион байгуулалтыг хараахан бүрэн ойлгохгүй байгаа тул зөвхөн түүний материйн мөн чанарын талаар таамаглах төдий байна. Гэвч дорнын шашинд бодол санааг бодитжуулах үзэгдэл, өөрөөр хэлбэл нарийн ертөнцийн материйг бодит субстанц болгон шилжүүлэх үзэгдэл машид тархсан байдаг. Үүнтэй холбоотойгоор газар дэлхий дээрх бие махбодийн генийн цогц нь сүнснүүдийн нарийн субстанцыг бодитжуулах замаар бий болсон гэж би бодож байна.

Өөрөөр хэлбэл газар дэлхий дээрх бие махбодийн генийн аппарат нь сүнсний нарийн бүтцийн шууд хуулбар юм. Гэвч миний бодлоор газар дээрх бие махбодийн генийн аппарат нь сүнснээс хамаагүй энгийн бөгөөд сүнсний зөвхөн зарим нэг шинж чанарын хуулбар болдог бөгөөд сэтгэн бодох болон бусад олон чадвар нь үл үзэгдэм байдлаар хүн болгонд оршдог сүнсэнд харъяалагдсаар байдаг. Нөгөө Ертөнц сүнсийг бодитжуулан нягтруулснаар маш сайн өөрөө үйлдвэрлэгч бүтцийг буюу хүн (сүнс), бодит ертөнцөд оршиж ургамал амьтан зэрэг хүрээлэн байгаа орчныг бүрдүүлэх чадвартай хүний бие махбодийг үүсгэжээ.



Газар дэлхий дээрх амьдрал нь сансрын долгион хэлбэрт амьдралыг бодитжуулснаар үүссэн гэдэг таамаг нь зарчмын хувьд шинэлэг мэт боловч сүнс нягтрах үзэгдлийн талаарх шашны үзлийн нэг хувилбар байж болох юм. Гэвч энэ тийм ч чухал биш. Хамгийн гол нь энэ таамаг нь урьд өмнө тайлагдаагүй маш олон баримтын нууцыг тайлж, хүн төрөлхтний түүхийг шинээр авч үзэх боломж олгож буйд байна.

Газар дэлхий дээр сүнс нягтрах үйл явц олон сая жилийн турш үргэлжилсэн байна. Анхны хүмүүс (сүнс маягийн хүмүүс) бодит бие махбодь гэхээсээ илүү сүнсэтэй төстэй байжээ. Гэхдээ тэд ч бас маш сийрэг бодит бие махбодийнхоо мэдээллийг нахиалах, хуваагдах замаар дамжуулах зориулалттай анхдагч генийн цогц байсан юм. Анхны хүмүүс Нөгөө Ертөнцөөс тусгаарлагдаагүй сансрын долгионы хуулиар амьдардаг байсан ч газар дэлхийн бодит бие махбодийн бүрхэвч хэдийнээ үүссэн байв. Тэд өөрсдийгөө газар дэлхийн хүмүүс гэхээсээ илүү Нөгөө Ертөнцийн элч төлөөлөгч мэтээр төсөөлдөг байлаа. “Сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” гэсэн ойлголт тэдний хувьд газар дэлхийн бодит асуудлаас хамаагүй чухал байжээ.

Хоёр дахь иргэншлийн (хий үзэгдэл маягийн) хүмүүс үндсэндээ нэгдүгээр иргэншлийн хүмүүс мэт амьдардаг байсан ч тэдний газар дэлхийн бодит бүрхүүл нь илүү нягт, бие махбодод уламжлуулан дамжуулах генийн цогцын аргачлал нь илүү төгс төгөлдөр байжээ.

Гурав дахь иргэншлийн хүмүүс (лемурчууд) нь илүү нягт, төгс төгөлдөр бодит биетэй, эхэн үедээ дөрвөн гар, хоёр нүүртэй аваргас байсан ба хожуу үедээ хоёр гар, нэг нүүртэй аврага биетэн болсон байна. Лемурын биед шингэсэн сүнс Нөгөө Ертөнцтэй холбоогоо бүрэн хадгалж байжээ. “SoHm”-ын зарчим үйлчилдэггүй байлаа. Лемур хүн нь илүү өндөр зохион байгуулалттай Нөгөө Ертөнцийн хууль, зарчмаар амьдардаг байсан ч бодит ертөнц дэх идэвхтэй үйл ажиллагаа нь түүнийг энгийн ахуйн асуудалд ч мөн анхаардаг болгожээ.

Дөрөв дэх иргэншлийн хүмүүс (атлантчууд) Нөгөө Ертөнцтэй холбоогоо хадгалсаар байсан боловч газар дэлхийн энгийн ахуйн асуудал тэдэнд илүү ойр дотно болжээ. Нөгөө Ертөнцийн “Сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” болон бусад ойлголт хойш ухарч, бодит бие махбодийн хэрэгцээ болох идэх, уух, унтах гэх мэт зүйлс илүү сонирхол татдаг болжээ.

Тав дахь иргэншлийн хүмүүс биднийг физик биеийнхээ боол гэж үзэж болно. Нөгөө Ертөнцөөс “SoHm”-ын зарчмаар тусгаарлагдсан сүнс Нөгөө Ертөнцтэй холбох нэгтгэх үүргийг бус харин бие махбодийг оршин тогтнох үүргийг гүйцэтгэдэг болжээ. Нөгөө Ертөнцийн гол оршихуй болсон “сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” зэрэг үзэгдэл зөвхөн зон совингийн шивнээ төдийгөөр илэрдэг болов.

Эрт дээр үеийн хүмүүс “хүн бол макрокосмосын микрокосмос юм” хэмээн ярилцдаг байсан. Энэ нь ч үнэн бололтой.

Ингээд сүнсний нарийн матери бодитжих нь дэлхий дээр өөрөө төрөгч бие махбодь хийгээд хүрээлэн буй орчныг үүсгэжээ. Гэсэн ч газар дэлхий дээрх амьдрал нь Нөгөө Ертөнцийн оролцоогүйгээр явагдах боломжгүй. Учир нь хүн бүхэнд газар дэлхий дээрх гоёхон машинаар буюу хүний бие махбодиор зорчдог сүнстэй. Газар дэлхийн хүмүүс бид сансрын долгион хэлбэрт амьдрал газар дэлхийг эзэмшсэний үр дүн юм.

Мөн түүнчлэн сансрын долгион хэлбэрт амьдрал нь (Нөгөө Ертөнц) Ертөнцийн бусад гариг эрхэс дээр ч мөн адил амьдралыг үүсгэсэн байх гэж бодож болох юм. Уг харь гаригийн амьдрал нь тэгээд ямар байдаг бол? Магадгүй сүнсийг биежүүлэхийн тулд гариг тус бүрд тохирсон өөр өөр химийн элемент болон молекулыг ашигласан байх. Магадгүй гариг тус бүрийн амьдралын нөхцөл байдал нь (агаар мандал, уур амьсгал, хүндийн хүч зэрэг) харь гаригийнхны бие махбодийн хэлбэр хэмжээ, эд эрхтний зохион байгуулалтанд нөлөөлсөн биз ээ. Гэвч харь гаригийн хүн ч гэсэн сүнс бодитжуулах Нөгөө Ертөнцийн бүтээлч үйл ажиллагааны үр дүн учир ерөнхийдөө газрын хүнтэй адилхан байх ёстой. Миний бодлоор бол харь гаригийн хүн нь сансрын долгион хэлбэрийн амьдрал болон Сансарын Оюун Ухааны нэгдмэл зарчим болох хайр энэрэл, сайн сайхан, муу муухайг ч мөн мэдэрдэг байх. Тийм ч учраас газар дэлхийн хүмүүс телепатын аргаар бодол санааг дамжуулж сурсныхаа дараа бусад гаригийн ахан дүүстэйгээ Нөгөө Ертөнцийн үндсэн арга болох сүнс хоорондоо харьцах аргаар харьцдаг болж болох юм.

Ихэнх Хутагт Гэгээнтэн эрт дээр үед газар дэлхийн хүмүүс хөгжил сайтай байсан учир янз бүрийн гариг дээрх бодит амьдралын бүх хэлбэрийг манлайлдаг байсан тухай бичсэн байдаг. Энэ манлайлал лемурчуудын амьдралын үе шаттай таардаг.

## **Лемурын үзэгдэл**

Лемурын соёл иргэншил хөгжлийн итгэмээргүй оргилд хүрсэн байв. Тэд нарийн ертөнцийн энергийг эзэмшиж, анир чимээгүй нисдэг төхөөрөмжүүдээрээ бусад гаригт зорчин, бодол санаагаа дамжуулах аргаар хоорондоо харьцдаг байсан гэх мэт их олон амжилтанд хүрчээ. Нөгөө Ертөнцийн мэдлэг тэдний хувьд нээлттэй байсан ба газар дэлхийн амьдралаас тэдний олж авч байсан мэдлэг ч мөн Нөгөө Ертөнцийн мэдлэгийн санд ордог байсан. Чухам лемурын соёл иргэншлийн олж авсан мэдлэг л Нөгөө Ертөнцийн мэдлэгийн санг газар дэлхийн амьдралын талаарх мэдээллээр хангасан нь одоог хүртэл газрын ололт амжилтуудын хэмжүүр нь болсоор байна. Дараачийн соёл иргэншлүүд болох атлантчууд болон бид лемурчуудын хүрсэн түвшний багахан хэсэгт нь ч хүрээгүй явна.

Лемурчуудын амьдралын энэ агуу ололт амжилтын нууц нь юундаа байсан юм бэ? Лемурчууд нь газар дэлхий дээр амьдарч байхдаа өөрсдийгөө Нөгөө

Ертөнцийн хүүхдүүд мэт бодон, юуны түрүүнд Нөгөө Ертөнцийн хууль зарчмуудыг ашигладаг байжээ. Тэд сэтгэлийн энерги нь хүчин чадал, үүргийнхээ хувьд бодит энергээс хавьгүй илүү бөгөөд хүний бие махбодь болон сүнс нь газар дэлхий дээрх дээдийн дээд бүтээл болохынхоо хувьд гайхамшигийг бүтээх чадалтай гэж үздэг байжээ. Тийм ч учраас тэд хөгжлийнхөө бүх л чармайлтаа хүнийг боловсронгуй болгох, өөртөө нуугдаж буй энергийг эзэмшихэд чиглүүлжээ.

Өөрийгөө Нөгөө Ертөнцийн хүүхэд юм уу, бүтээл мэтээр мэдрэх нь маш чухал. Учир нь чухам энэ мэдрэмж л хөгжил дэвшлийн замыг сонгосон үгүйг тодорхойлдог. Ингэснээр Нөгөө Ертөнцийн хүүхэд эцэг өвгөдөөсөө суралцан (Бурханаас) өөрийгөө бурхан мэт үзэх их нүглийг үйлдэхгүй. Тэгвэл Нөгөө Ертөнцийн хүүхэд генийн цогцын молекул өөрөө цугларсан, хүн сармагчнаас үүссэн, өөрийгөө байгаль дэлхийн эзэн нь гэж бодохгүй байхсан. Хүн бол макрокосмосын микрокосмос юм гэдгийг Нөгөө Ертөнцийн хүүхэд ойлгох ёстой.

Манай иргэншил одоохондоо сансрын энергийг ашиглаж чаддаггүй. Гэтэл энэ энерги маш агуу хүчтэй билээ. Орчин үеийн зарим физикч 1м куб Абсолют нь 40 дүнчүүр (триллион) цөмийн бөмбөгний хүчин чадалтай тэнцэхүйц хүчтэй гэж үздэг. Тийм ч учраас газар дэлхийн энергийн эх үүсвэрийг (нефть, нүүрс гэх мэт) ашиглах ямар ч шаардлагагүй болно. Зөвхөн хүн л макрокосмын микрокосм болохынхоо хувьд энэ энергийг эзэмшиж чадна.

Сансрын энергийг эзэмшсэн лемурчууд үүнийгээ ашиглахын тулд Нөгөө Ертөнцийн аргуудыг хэрэглэдэг байжээ. Эдгээр аргын үндсэнд нь (хичнээн хачирхалтай хэдий ч) энгийн ахуйн ойлголт болох “хайр энэрэл”, “сайхан сэтгэл” хоёр оршиж байлаа. Нарийн ертөнцийн торсын орон нь агуу их хүчин чадалтай бөгөөд торсын орны гол шинж нь болсон сайхан сэтгэл болон муу муухай нь агуу их хүчин чадлыг агуулдаг гэдгийг лемурчууд сайн ойлгож байлаа. Хүн нь макрокосмын микрокосм учраас сайн санаа, муу үйл хоёроор нарийн ертөнцийн торсын орныг бодитжуулах чадвартай. Гэвч лемурчууд мэдээллийг устгагч тэсрэлт маягийн үйлчлэл үүсч болох учраас муу муухайн (сөрөг энергийн орныг) энергийг үүсгэхэд ашиглах нь маш аз туршсан хэрэг гэдгийг сайн ойлгож байжээ. Тийм ч учраас энэ зорилгодоо тэд сайн үйлийг ашигладаг байв. Түүнчлэн тэд эерэг торсын орнуудаас олж авсан энергийн үйлчлэлээ бусад эерэг торсын оронуудтай харьцсаны үндсэн дээр нэмэгдүүлэхийн тулд хайрыг ашигладаг байжээ.

Лемурчууд өөрсдийгөө макрокосмын микрокосм гэдэг утгаар нь бүрэн төгөлдөржүүлж чаджээ. Тэд хүн бол хайр энэрэл, сайн үйлээрээ нарийн ертөнцийн энергийг эзэмших чадвартай газар дэлхий дээрх хамгийн хүчирхэг бүтээл юм гэдэг утгаар нь өөрсдийгөө бүрэн хөгжүүлж чаджээ. Хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл зэрэг нь лемурчуудын хувьд утгагүй мэдрэмж төдий зүйл байсангүй. Харин ч хүн төрөлхтний амьдралыг хангах, энергийг хангах хүчирхэг цогц байсан юм.

Аричууд бидний хувьд хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэл зэрэг ойлголт нь энгийн тааламжтай мэдрэмж төдий л зүйл болж хувирчээ. “SoHm”-ын зарчмаар тусгаарлагдсан, бодит материд эргэлт буцалтгүй шигдсэн бид анх сонсоход энгийн мэт энэ үгс нь ямар их хүчин чадал агуулдгийг мэддэг ч үгүй. Лемурчуудын хувьд энэ үгс нь энгийн бус, харин гайхам хүчин чадлыг агуулж тэдний амьдралын үндэс болж байсан.

Яагаад нарийн ертөнцөд оршдог Нөгөө Ертөнц өөрийн энергиэ газар дэлхийн хэрэгцээг хангахын тулд Дэлхий рүү илгээдэг юм бэ? Нэгдүгээрт, газрын амьдрал нь Нөгөө Ертөнцөөс үүсэлтэй. Хоёрдугаарт, Нөгөө Ертөнцийн энерги нь ямар нэгэн сайн үйлийг бүтээхэд зориулагдсан ба харин бодол санааг бодитжуулах нь Нөгөө Ертөнцийн мэдээллийн орон зайг дүүргэдэг.

Лемурын энергийн үндсэн үзэгдлүүд нь миний бодлоор бол шашны ихэнх эх сурвалжид бичсэнчлэн тарнийн хүчээр явагддаг. Лемурчууд нисдэг төхөөрөмжүүдээ тарнидан нисгэдэг байсан нь зүйрлэн хэлбэл эдгээр төхөөрөмжийнхөө тэжээлийг нарийн ертөнцийн энергээр цэнэглэдэг байсанд байгаа юм. Мөн энэ аргаар тэд өөрийгөө илүү хүчирхэг энергийн үүсгүүр болгон ашиглаж, газрын өөр олон тоног төхөөрөмжийг энергизэр хангадаг байжээ.

Нарийн ертөнцийн энерги нь таталцлын хүчийг давж гарч чаддаг гэдгийг лемурчууд мэддэг байсан. Үүнд тэдний барилгын ажил суурилж, том том чулуун хавтанг харцаараа шилжүүлдэг болжээ. Алган дээр багтам жижигхэн торсын үүсгүүрээр агаарт аварга том чулуунуудаар наадаж байлаа.

Хүн бол макрокосмын микрокосм юм гэсэн зарчмыг ашиглан лемурчууд өөрсдийгөө төгөлдөржүүлдэг байжээ. Тэд нарийн ертөнцийн энергийн таталцлын эсрэг үйлчлэлийг ашиглан левитацын буюу хүний биеийг агаарт хөөргөх үзэгдлийг эзэмшжээ. Одоогоор бидэнд огт ойлгомжгүй зарчмыг ашиглан орон зайд шилжиж газар дэлхий дээрх байрлалаа өөрчилж чаддаг байсан. Тэд бие махбодио дотоод энергийнхээ хүчээр анагаадаг байлаа.

Гэсэн ч лемурчуудын хамгийн гол ололт бол бодитжих, эс бодитжих үзэгдлийг эзэмшсэн явдал байлаа. Тэд хүний бие махбодь нь сүнс бодитжсоноор үүссэнийг бодож үзээд уг үзэгдлийг эсрэгээр нь буюу хүний бие махбодийг эргэн эс бодитжуулах үзэгдлийг эзэмшихийг оролджээ. Энэ нь хүний бие махбодийн, тэр ч бүү хэл молекул эд эс болгоны талаарх агуу мэдээлэл сүнсний торсийн оронд бичигддэг энэ үзэгдлийг “мэдээллийн шилжилт” гэж нэрлэж болох байлаа. Лемурчуудын агуу хөгжингүй сүнсний хүчин чармайлтаар бие махбодийн талаарх мэдээлэл бичигддэг сүнсний торсын орны нэмэлт чөлөөт бүрхэвчүүд бий болсон гэж үзэж болно.

Бие махбодийнхоо бүхий л мэдээллийг бичсэн сүнс хүссэн газраа очин (газар доор, орон зайд шилжих гэх мэт), уг хураагдсан мэдээллийнхээ дагуу бие организмаа дахин бодитжуулдаг. Бодитжуулахад атом болон энгийн

молекулуудыг (ус гэх мэт) ашигладаг учраас бие махбодийг ямар ч тохиолдолд, ямар ч нөхцөл байдалд бодитжуулж болдог байна.

Бодитжил хоёр янз байдаг:

- Түүхэн бодитжил
- Мэдээллийн шилжилт

Түүхэн хувьслын бодитжил нь хэдэн сая жилийн турш явагдсан бол мэдээллийн шилжилтийн үеийн бодитжил нь бараг л агшин зуурын дотор бүтдэг байжээ. Газар дэлхийн амьдралыг түүхэн хувьслын явцад лемурчууд Нөгөө Ертөнцийн сүнснүүдийн мэдээллийн шилжилтийн аргаар бодитжих эс бодитжих үзэгдлийг эзэмшихүйц хэмжээний мэдээллийн багтаамжтай, бодит материд үзүүлэх үйлчлэлтэй болж чаджээ.

“Бодитжих эс бодитжих” үзэгдлийг лемурчууд зөвхөн бие махбодидоо бус мөн тоног төхөөрөмжид мөн хэрэглэжээ. Энэ нь тэдний нисэгч төхөөрөмжийг гэнэт алга болж, гэнэт бий болох боломжтой болгодог.

Лемурчууд иргэншлийнхээ төгсгөл ирэхэд “бодитжих эс бодитжих” үзэгдлийг ашиглан Шамбал болон Агартгийн орныг үүсгэжээ. Тэд дэлхийг хамарсан сансрын гамшиг ойртон буйг гадарлан энэ үзэгдлийнхээ тусламжтайгаар газар доор орж, техникийн өндөр хөгжилтэй газар доорх лемурын соёл иргэншлийг үүсгэжээ.

Лемурчуудын нэг хэсэг нь, ялангуяа Шамбалын орны лемурчууд бараг мөнхийн амьдралд хүрч чаджээ. Тэд дотоод энергиэ ашиглан эсүүдийн, тэр дундаа мэдрэлийн эсүүдийн нөхөн үржилтийг идэвхжүүлснээр үүнд хүрчээ. Бие махбодио ч мөн байнга шинэчилж байлаа.

Лемурын гайхамшгийн үндэс нь Нөгөө Ертөнцийн хөдөлгөгч хүч болсон хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл, муу муухайг ухамсарласан явдал болон хүний мөн чанарыг макрокосмын микрокосм гэж тодорхойлсонд оршино. Хүний сүнс бол сайн муугийн тэмцлээс өөрөө хөгжигч эхлэл, элемент болж үүссэн болохоор байнга хөгжих шаардлагатай гэдгийг ойлгосон лемурчууд хүний сүнсний хэсгийг доройтолд оруулагч хүчин зүйл болох муу муухайгаас салсан байна. Назгай залхуу байдал гэдэг нь муу муухай бөгөөд харин амьдралын хөгжлийн төлөө шургуу хөдөлмөрлөх нь хүний эн түүрүүний үүрэг гэдгийг ойлгосон нь лемурын иргэншил уналт, гамшиггүйгээр хөгжлийн асар өндөр түвшинд хүрэхэд хүрэлцэхүйц байсан юм. Лемурчууд сайн муугийн сохор тэмцэл гаргадаггүй байлаа. Тэд хайр энэрэл, нигүүлсэхүйн агуу хүчин чадлыг дотроо нэгтгэхэд үүсэх торсын үйлчлэлийг муу муухайтай тэмцэх мухар тэмцэлд бус харин газар дэлхий дээрх хүн төрөлхтний амьдралыг хөгжүүлэхэд бүрэн дүүрэн зарцуулж байсан юм.

Байнга хөгжих шаардлагатайг ойлгох нь ямар чухал юм бэ! Хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэл муу муухайтай мухар сохроор тэмцэх нь утгагүйг ойлгох

нь ямар их ач холбогдолтой юм бэ! Зүгээр налайж сууна гэдэг чинь ямар аймшигтай үг вэ?

Лемурчууд энэ бүхнийг ойлгодог байсан ба Бурхантай ч ярилцахуйц хэмжээний өндөр хөгжилд хүрсэн байна. Тийм ч учраас тэд үнэхээр газар дэлхий дээрх бурханлаг бүтээл болсон юм.

Тэдэнтэй юу тохиолдсон юм бол? Яагаад тэдний соёл иргэншил (Шамбал, Агартийн орноос бусад нь) мөхсөн юм бэ? Энэ нууц харанхуй хэвээр байна. Магадгүй мөн тэдний ч эгнээнд үхлийн назгай байдал ноёрхож эхэлсэн ч юм бил үү.

### **Нигүүлсэнгүй сайхан сэтгэл, хайр энэрэл болон самеди**

Гүн самадид хэрхэн орох вэ? Үүний тулд хүн төрөлхтнийг тэр аяар нь хайрлах хайр дээр төвлөрөх (бясалгах) хэрэгтэй гэж бүх лам нар номлодог тухай би урьд нь бичиж байсан. Би лам нараас үүнийг сонсоод гүн гүнзгий утга учиртай гэдгийг нь ойлгоогүй. Зөвхөн ямар нэгэн маш чухал мэдрэмж гэдгийг зөн совин маань надад шивэгнэж байлаа.

Одоо бол би самадид орох үндсэн зарчмыг бараг ойлгосон гэж бодож байна. Тиймээ, уншигч авгай та энэ номыг уншаад ойлгож эхэлсэн биз ээ. Хайр сэтгэл гэдэг бол сайн сайхныг идэвхжүүлэгч юм. Хайр сэтгэл, ялангуяа хүчтэй хайр сэтгэл эерэг торсын орны эрчлээсийг нэмж, сөрөг сэтгэлийн энергийг хөөдөг. Хайр нь сэтгэлийг сөрөг энергээс бүрэн чөлөөлж чадахуйц хүчтэй байх ёстой.

Сөрөг сэтгэлийн энергээс чөлөөлөгдсөн хүний сэтгэлийг цэвэр тунгалаг сэтгэл гэдэг. Чухам цэвэр тунгалаг сэтгэл л гайхамшигийг бүтээх чадвартай. Цэвэр ариун сэтгэлд сэтгэлийн эерэг энерги муу муухайтай муйхраар тэмцэхийн оронд ямар нэгэн зорилгыг бүрмөсөн биелүүлэхэд зориулагдаж болно. Жишээ нь хүний бие махбодийг хэдэн мянга, хэдэн сая жилээр хадгалах зорилт буюу самадид ороход зарцуулж болно. Самадийн үед сэтгэлийн торсын орон нь машид чангаран хүний бие махбодийн усны молекул болгоныг дөрөв дэх үл мэдэгдэх төлөв байдалд оруулснаар бодисын солилцооны үйл явцыг бүхэлд нь зогсоон бие махбодийг хатуу болгодог. Ус нь эерэг сэтгэлийн энергийн гол шинж нь, бодит субстрат нь болдог тул сөрөг сэтгэлийн энергийн ямар нэгэн илрэл сэтгэлд байвал бүрэн самадид орох боломжгүй. Зөвхөн цэвэр ариун сэтгэлтэн л самадийг үүсгэх чадвартай.

Энэ бүхнээс үзэхэд цэвэр ариун сэтгэлт лемурчуудын үүсгэн бий болгосон газар доор оршиж, бусад иргэншлийн шилдэг хүмүүсээр байнга сэлбэж байдаг Хүн Төрөлхтний Генийн Сан нь хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэлийн үр дүн мөн.

## **Адептууд бол бидний ирээдүй**

Миний өмнө нь бичиж байсанчлан манай арийн бодит амьдралд ууссан соёл иргэншлийн хэвлийд Балба, Энэтхэгийн хаана ч юм ертөнцийн амьдралаас тасарсан мэт ер бусын дүр төрхтэй, маш энгийн хувцастай, өөрсдийгөө 300, 500, 1000 түүнээс ч өндөр настай хэмээн нэрлэдэг хүмүүс байдаг гэж ярьцгаадаг. Энэ хүмүүс бол адептууд.

Мэдээж тэдэнд итгэхэд хэцүү л дээ. Үнэхээр ч итгэмээргүй сонсогдож байна. Гэвч чухам энэ хүмүүс бол бидний ирээдүй юм. Чухам энэ хүмүүс л хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэлийн хүчээр өөрсдийгөө эрүүлжүүлж, насаа нэмж чадсан юм. Бурханыг хайрлан шүтэж, энэ чиглэлээр бясалгал хийнгээ эдгээр хүмүүс хайрлах сэтгэлийнхээ тусламжтайгаар сэтгэлийн эерэг энергийн хүчийг нэмэгдүүлж, сэтгэлийн сөрөг энергээсээ салдаг буюу сэтгэлээ ариусгадаг байна.

Миний бодлоор бол хавдрын эмгэг эсүүд нь сэтгэлийн сөрөг энергийн бодит илрэл болдог бол харин өсөж буй эрүүл эсүүд нь эерэг сэтгэлийн энергийн бодит илрэл юм.

Хүний бие махбодид сайн муугийн тэмцэл байнга явагдаж байдгийн нэгэн адил энгийн өсөж буй эсийн болон хавдрын эсүүдийн хооронд байнга тэмцэл явагдаж байдаг. Тийм ч учраас сэтгэлийн эерэг эхлэлийг идэвхжүүлдэг хайр сэтгэлийн тусламжтайгаар бие махбод дахь хавдрын эсүүдийг байнга устгаж, бие махбодийнхоо эсүүдийг байнга шинэчлэснээр наслах хугацаагаа уртасгаж болно.

Эмчлэх зорилгоор хэрхэн хайрлаж сурах вэ? Өөрийгөө хайрлах нь утгагүй юм. Учир нь аминдаа хайртай байх гэдэг нь сөрөг чанар билээ. Бурханыг, газар дэлхийн амьдралыг үүсгэгчийг, амьдралыг хайрлаж сурах хэрэгтэй. Хэрвээ энэ хайр нь хүчтэй бөгөөд хорон муу санаа агуулаагүй бол эмчилгээний үр дүн аяандаа илрэх болно. Гэвч газар дэлхийн, ахуйн бүхий л асуудлаас хөндийрч, Бурхныг болон амьдралыг хайрлах бясалгал, залбиралд амьдралаа зориулах хэрэгтэй учраас ингэж хайрлаж сурах их хэцүү.

Энгийн бүтээлч амьдралаас татгалзсан нь орчин үеийн адептуудыг бидний нүдэнд маш энгийн мөн ер бусын харагдуулдаг.

Хүн төрөлхтөн аль хэдийн сансрын монетар мөчлөгийн “бодит амьдралын хонгил”-ыг (бодит амьдралын хамгийн гүн цэг) даван гарсан байгаа бөгөөд одоо сэтгэл сүнсний хөгжлийн замаар явж байна. Тийм ч учраас өнөөгийн адептууд хэзээ нэгэн цагт хүн төрөлхтний нийгмийг сэтгэл сүнсний хөгжлийн замаар хөтлөх сайхан удирдагчид болох болно.

## **Хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэл болон бид**

Коммунист улсад төрж өссөний хувьд би бүх насаараа шашнаас хол хөндий байсан билээ. Миний эцэг өвгөд шашны зүтгэлтнүүд байсан учир Лениний үеийн хэрцгий дарангуйлалд өртсөн юм. Оюутан байхдаа “материализм ба хаант засаглалыг эсэргүүцэх үзэл” гэх мэт хичээл ороод бурхангүй үзлийн шалгалт өгөх гэж байхдаа шашны номлолыг ямар их хилэнтэйгээр нурааж орхисонд дандаа гайхаш тасардаг байлаа.

“Яагаад ингэх хэрэгтэй юм бол,- гэж би гэнэхнээр боддог байлаа. “Шашин чинь сайхан сэтгэл, хайр энэрэл, Бурханыг хайрлахыг л номлодог шүү дээ”.

Тэр үед би нигүүлсэнгүй сэтгэл хайр энэрэл нь, юуны түрүүнд Бурханыг хайрлах сэтгэл нь коммунистуудын хувьд жинхэнэ багалзуурт нь барьсан хутга байсныг мэдсэнгүй. Учир нь тэдний үйл ажиллагааны гүн утга нь өөрсдийн “бурхан”-ыг ( Ленин, Сталин гэх мэт) бий болгох байсан юм. Тэд өөрсдийн бурханаа шүтэхийг албадаж байсан нь хүн төрөлхтний байгалийн жамаас зөрж байлаа.

Хожим шашны ном судар судалж эхлэхэд хүний анхаарлыг сайн сайхан, хайр энэрэлд төвлөрүүлэхийг эцэс төгсгөлгүй, бүр ядаргаатай гэмээр номлож байсан нь миний гайхшийг төрүүлсэн. Хүний нүдэн дээр гайхамшигийг бүтээгч хүчирхэг Сатья Саи Бабагийн номоос би түүний агуу сэтгэлгээний үндэс нь хайр болохыг ойлгосон юм.

“Хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэлийн талаар ингэж их ярих хэрэг юу байна?”- гэж би гэнэхнээр боддог байж билээ.

Тэр үед би энэ энгийн ахуйн үгсийн цаана бидний амьдралыг орвонгоор нь эргүүлэх чадвартай агуу хүчирхэг энерги нуугдаж байсныг гадарлаа ч үгүй явсан юм.

Гималайн шинжилгээний ангийн ажлын үр дүнд шинжлэх ухааны хийсвэр сэтгэхүйг ашиглан гүн ухааны дүн шинжилгээ хийж дуусаад л би шашны, Саи Бабагийн, болон бусад олон арван хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэлийг номлодог зүйлсийн гүн гүнзгий утга санааг ойлгож эхэлсэн юм. Хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл нь хүний амьдралын хамгийн гол бүтээлч эхлэл юм гэсэн гүн гүнзгий утга санаатай байжээ.

Би бол материйн мөн чанарт гүн шигдсэн арийн соёл иргэншлийн жирийн нэгэн төлөөлөгч билээ. Миний тархи, сэтгэлгээ агуу лемур, тэр тусмаа Сансрын Оюун Ухаантай харьцуулшгүй өчүүхэн билээ. Гэсэн хэдий ч миний өчүүхэн оюун ухаан ч салангид баримтуудыг нэгтгэн жирийн хүний хувьд ер бусын хайр энэрэл болон нигүүлсэнгүй сэтгэл нь хүний амьдралын хөгжлийг тодорхойлдог суурь хүчин зүйл юм гэсэн гайхалтай дүгнэлтэнд хүрэхэд хангалттай байлаа.



Урьд нь би “сэтгэлээ ариусгах”, “сэтгэлдээ нүгэл хураахгүй байх”, “нүглээ наминчлах” зэрэг зүйлст огт ач холбогдол өгдөггүй байлаа. Эдгээр нь надаа ойлгомжгүй, утгагүй зүйлс мэт санагддаг байсан юм. Гэвч Николай Рерихийн бүтээлийг уншиж байтал дахиад л “цэвэр ариун сэтгэл” гэсэн ойлголттой тулгарсан юм. Рерих Шамбалын орныг цэвэр ариун сэтгэлтэй хүмүүс байгуулдаг гэж бичсэн байдаг.

“Цэвэр ариун сэтгэл гэж юу юм бэ? Яагаад бүх шашин цэвэр ариун сэтгэлтэй байхын чухлыг номлодог юм бол?”- гэж би боддог байв.

Би таньдаг гэлэнгээсээ хүртэл энэ тухай асууж үзэв. Хариуд нь нөгөө гэлэн маань эрдэмтэн би огтхон ч ойлгохооргүй номлол айлдав. Мэдээж, бүх л айлтгал, сургаалиа цээжилчихсэн захын нэгэн гэлэн мэдээж “цэвэр ариун сэтгэл” гэдгийн үндсэн утгыг шууд тайлбарлаад өгч чадахгүй нь ойлгомжтой. Гэвч шүтээн байсаар ирсэн Рерих ч гэсэн байнга үүнд анхаарч чухалчилдаг байсан юм. Яагаад?

Одоо бол энэ асуултанд би бүдүүн тойм ч гэсэн хариулах чадвартай болсон гэж бодож байна. Цэвэр ариун сэтгэл гэдэг нь хүний сүнсний болон сэтгэлийн чанарын өөр төлөв байдал бөгөөд энэ төлөв байдлын үед торсын орны эерэг энерги нь (хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл) муу муухайтай тэмцэхэд бус харин бүхлээрээ бүтээлч үйлсэд зарцуулагддаг. Цэвэр ариун сэтгэлд тэмцлээр мэдлэг, хөгжлийг үгүйсгэдэг муу муухай санаа бодол байдаггүй. Цэвэр ариун сэтгэлтэнд муу муухай санаа бодлыг идэвхжүүлэгч нөлөө нь байнга хөгжих шаардлагатайг гүн гүнзгий ухамсарлахуйгаар солигддог. Цэвэр ариун сэтгэлийн гол дайсан бол назгайрал юм.

Урьд өмнө би хэзээ ч назгай залхуу байдлын талаар бодож яваагүй. Амьдралаа зүгээр л сэлгүүцээд өнгөрөөж буй хүмүүс хэзээ ч надаа таалагдаж байгаагүй. Гэвч назгай залхуу байдал нь цэвэр ариун сэтгэлийн аймшигтай дайсан, устгагч нь билээ. Зүгээр сууж буй хүн хичнээн сайн санаа агуулсан ч назгай байдлаараа өөрөө хөгжигч эхлэл маягаар бүтээгдсэн хүний мөн чанарын эсрэг байдаг. Назгайрлаас болж эзэнт гүрэн, улс тэр аяараа мөхөж, хувь заяа эргэж байлаа.

Тийм ч учраас лам свами нарын ярьсанчлан цэвэр ариун сэтгэлд зөвхөн өөрөө өөртэйгээ маш их ажилласны дүнд, өөрийгөө таних замаар, тэр ч бүү хэл өөрийгөө золиосолж л хүрэх юм. Гэвч энэ бүгд нь өөрийгөө бататгах гэсэн зорилгын үүднээс бус зөвхөн нийт хүн төрөлхтний тусын тулд байх ёстой. Лам нар хүн төрөлхтнийг хайрлах, хүмүүсийг өрөвдөн нигүүлссэнээр “цэвэр ариун сэтгэл”-тэй болж болно гэж ярьдаг. Анх сонсоход энэ үгс ямар ч утгагүй мэт санагдаж байв ч үүнд л “цэвэр ариун сэтгэлд” хүрэх гол утга учир буюу хэн нэгэн тодорхой хүнийг, хамгийн гол нь өөрөө өөрийгөө хайрлан нигүүлсэх бус бүх хүн төрөлхтнийг хайрлан нигүүлсэх ёстой гэдгийг тусчээ. Хүн өөрийгөө золиослон

байж хүрэх тэр зорилго нь заавал ч үгүй нийт хүн төрөлхтнийг хамарсан байх ёстой. Үүнд хүрэхэд хэцүү. Тун хэцүү.

Орчин үеийн нийгэмд цэвэр сэтгэлтэй хүмүүс байхгүй билээ. Цэвэр ариун сэтгэлтэй хүмүүст хамгийн ойр нь миний бодлоор бол эрдэмтэд юм. Эрдэмтэн хүн (гэвч жинхэнэ эрдэмтэн хүний тухай ярьж буй юм шүү!), жишээ нь анагаах ухааны эрдэмтэн хүн тоогүй олон нойргүй шөнө, өчүүхэн бага цалин зэргийг ч үл хайхран бүтээлч санаагаа хэрэгжүүлэхийн тулд хуучинсаг үзэлтэй тэмцэж юуны түрүүнд бүх л өвчтэй хүмүүсийг энэрч, өрөвдсөндөө тэдний тусын тулд өөрийгөө золиосолдог. Өвчтөний яс үндэс, баян ядуу, гадаад үзэмж зэрэг нь жинхэнэ эмч-эрдэмтэн хүний хувьд ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй. Тэрээр энэ тэмцэл, зовлонтой нүсэр их хөдөлмөрөөрөө хэдэн мянга, хэдэн сая өвчтэй хүнд тусалж чадсанаараа сэтгэлийн таашаал авдаг байна. Тийм ч учраас “Жинхэнэ эрдэмтэдийг хайрлаж, хамгаалж яваарай! Тэд хүний төлөө өөрсдийгөө боловсруулж, золиосолж байдаг юм шүү!”- гэж хэлмээр байна.

Муу муухайтай тэмцэх тэмцлээс ангижирсан цэвэр ариун сэтгэл гайхамшгийг бүтээх чадвартай. Ийм гайхамшгийн нэг бол самади юм. Лам свами нар самадид орохын тулд хүн төрөлхтнийг хайрлах нигүүлсэх сэтгэлтэй байх ёстой. Харин самадийн зорилго бол хэзээ нэгэн цагт шинэ соёл иргэншлийг үүсгэх эсвэл Хутагт Гэгээнтэн болох зорилготойгоор Хүн Төрөлхтний Генийн Санд орох явдал юм гэж ярьж байсныг санацгаая. Өөр нэгэн гайхамшиг бол “бодитжих-эс бодитжих” үзэгдэл юм. Гурав дахь гайхамшиг бол хүний насыг уртасгаж, мөнх наслах явдал юм.

Эртний хүмүүсийн мэдлэг болон шашны үзэж буйгаар хүн төрөлхтний хөгжлийн гол зам болсон сэтгэлийн ариусал, цэвэр ариун сэтгэлтэй байх явдал юм. Ингэж чадсан тохиолдолд нарийн ертөнцийн эерэг энергийг хүн удирдаж чаддаг болж, түүнд Нөгөө Ертөнцийн мэдлэг нээгдэн, хүн өөрөө макрокосмын микрокосм учир энергийн агуу хүчин чадлаа мэдрэх болно. Газар дэлхий дээр урьд өмнө ийм тохиолдол лемурчуудтай тохиолдож байсан юм. Харин сэтгэлээ ариусгахын тулд хайрлаж сурч, өрөвдөж нигүүлсэхээс айхгүй байж, агуу зорилгод хүрэхийн тулд өөрийгөө ч зовоохоос буцахгүй байх ёстой. Хүн анхнаасаа л өөрөө хөгжих эхлэл маягаар үүссэн болохоор өөрийгөө хайрлах хэрэггүй. Үүнийг шинжлэх ухааны ололтонд хүрэхийн тулд өөрийгөө үл хайрлан ажилласан ч өтөл насандаа хурц сэргэлэн оюун ухаан, залуу насны эрч хүчээ хадгалсаар байсан олон эрдэмтний жишээ нотолж байгаа юм. Тэд ямар нэг хэмжээгээр сэтгэлээ ариусгаж чаджээ. Хамгийн аймшигтай нь амжилтанд хүрчихээд үр дүнг нь хүртэн зүгээр суух явдал юм.

Гэвч уншигч авгай хүн төрөлхтөнд Ленин, Гитлер, Наполеон мэтийн хорон муу санаагаа онол болгон боловсруулж, эргэн тойрондоо үхэл тарьсаар

ертөнцийг орвонгоор нь эргүүлэх чадвартай, муу санаат суут ухаантнууд ч бас байдаг гэж маргах буйзаа.

“Эдгээр муу санаат суут ухаантнууд дайн сүйтгэлийн утга учиргүйг ойлгодоггүй юм байх даа? Тэд чинь уул нь суут ухаантнууд шүү дээ!”- гэж би хүүхдийн гэнэн зангаар бодож байлаа.

Мэдээж тэр үед би бидний эх болсон нарийн ертөнцөд эерэг болон сөрөг сэтгэлийн энерги нь харьцаат хэмжээтэй оршдог, мэдээлэл нь сайн муугийн тэмцлийн дүнд үүсдэг гэдгийг мэддэггүй байжээ. Муу муухай ч гэсэн торсын орондоо сайн сайхантай хийсэн тэмцлийн талаарх мэдээллийг хадгалж, муу үйл үйлдэхдээ ашиглах чадвартай. Оршин буй харьцаанаасаа болж сайн сайхан байнга ялан дийлж чадалгүй, хааяа муу муухай мэдлэг ялан дийлснийг эдгээр муу санаат суут ухаантан ашигладаг байна. Гэвч муу муухайн ялалт гэдэг бол хуурамч ялалт юм, учир нь бид дээр хэлсэнчлэн анхдагч муу муухай, сайн сайхны түвшинд муу нь бүрэн ялан дийлэх л юм бол бүхий л торсийн давхарга дээрээс мэдээлэл арчигддаг өөрөөр хэлбэл мэдээллийн сүйрэл болдог билээ. Үүний баталгаа болгон ямар ч муу санаат суут ухаантны үйл хэргийн төгсгөлийг ямар байсныг санацгаая. Тэд бүгд сүйрсэн. Наполеон дайнд ялагдан арчаагүй байдалтай үхсэн бол Гитлер европыг түйвээж орхиод амиа хорлон амьдралаа эцэслэсэн. Ленины гутамшигт үйл болох коммунист нийгэм нь мөн л гутамшигтайгаар төгссөн.

Хэрвээ муу муухай мэдлэгээр зэвсэглэсэн суут ухаантнууд ертөнцийн үүсэл, хүний хөгжлийн талаар ямар нэгэн мэдээлэлтэй байсан бол түүхэнд эцсийн ялалт нь зөвхөн сайн сайхан бодол санаа л байдгийг ойлгох байсан. Тэгвэл магадгүй тэд суут ухаанаа бүтээлч үйлсэд зориулах байсан бизээ.

Ямар тохиолдолд муу муухай ялан дийлдэг вэ? Миний бодлоор бол муу муухай нь зөвхөн сайн үйлсийн идэвхжүүлэгч болсон хайр энэрэл дутмаг тохиолдолд л сайн сайхныг ялан дийлдэг. Хайр энэрэл (эмэгтэй хүнийг, төрөл саднаа, ард түмнээ) цэцэглэн буй нийгэмд муу санаат суут ухаантан хэзээ ч ялан дийлэхгүй.

Тэгвэл сайн санааг муугаас нь яаж ялгах билээ? Сайн муугийн хэмжүүр нь юу юм бэ? Эдгээр асуулт хүн болгоныг зовоож байдаг болов уу гэж бодож байна. Би ч мөн адил энэ талаар олон удаа тунгаан бодож байсан боловч хариултыг гэнэт Тарковскийн суут уран зөгнөлт кино “Сталкер”-аас олсон юм.

Хэрвээ та уг киног үзсэн бол агуулга нь санраас ирсэн зочид дэлхий дээр орсон хүн нь шууд үхдэг бүс байгуулсныг санаж байгаа байх. Уг бүс нутаг хүний хамгийн гол мэдрэмжийг нэмэгдүүлдэг байжээ. Энэ мэдрэмж нь ухамсар байсан. Хүмүүсийн ухамсар цэвэр байгаагүйгээс болж тэд үхдэг.

Тиймээс хүний сайн муу үйлийн хэмжүүр бол ухамсар юм гэж би бодож байна. Ухамсар гэж юу юм бэ? Ухамсар гэдэг нь сэтгэлийг муу үйлд хөтлөх сөрөг

энерги үүсч байна гэсэн мэдрэмж юм. Шинжлэх ухааны хэлээр ярих юм бол сэтгэлийн торсын орнууд сөрөг чиглэлд эргэж байгаа мэдрэмж юм. Ухамсартаа хар толботой байна гэдэг нь ямар нэг хэмжээгээр, тодорхой нэг агшинд ямар нэг шалтгаанаар сэтгэлийн торсын орны энерги сөрөг чиглэлд эргэснээс үлдсэн ул мөр юм. Энэ ул мөр болж үлдсэн мэдээлэл нь адил төстэй тохиолдол бүрт дахин ингэж болохгүй гэж үргэлж анхааруулж байдаг. Энэ мэдээлэл маш таагүй, зовлонтой мэдээлэл юм. Ийм мэдээлэл агуулаагүй нь дээр. Өөрөөр хэлбэл ухамсрынхаа эсрэг ямар нэг зүйл хийгээгүй нь дээр.

Тиймээс амьдралд ухамсрынхаа шивнээг сайн сонсож байх хэрэгтэй. Хүний сэтгэл зүрхний энэ мэдрэмж үргэлж үнэнийг хэлж байх болно. Хэрвээ нэг ч гэсэн удаа ухамсрынхаа үгийг сонсолгүй эсрэг үйлдэл хийх юм бол сэтгэл зүрхэнд чинь энэ нь томоос том бохир толбо үүрд үлдэх болно.

Би шинжилгээ судалгааны сайн нөхцөл бололцоо, их мөнгө амлаж байсан Америкт амьдрахаар явалгүй Орост үлдсэндээ баярлаж явдаг. Би тийшээ зөвхөн ухамсраас болоод яваагүй юм. Би “тэнэг судалгаа шинжилгээнээсээ болоод” бүхнээ алдчихаад байсан хүнд үед минь ухамсраа сонсон бүхнээсээ хагацан намайг дагасан нөхдөө (Амир Салихов, Сагит Муслимов, Ришат Булатов, Клара Захваткина, Рафик Нигматуллин, Натан Сельский, Валя Яковлева, Венера Галимова, Ляля Мусина, Неля Нигматуллина, Слава Малоярославцев, Юра Васильев болон бусад олон найз) орхин явж зүрхлээгүй юм.

Оюутан байхад бурхангүй үзлийн тухай хичээл дээр байнга “нөгөө ертөнц” гэдэг ойлголтыг шүүмжилдэг байсныг санаж байна. Хүмүүс энэ хорвоогийн баячуудад зарцлагдан, шулуулж, борви бохисхийлгүй ажиллаж байсан хүнд хэцүү үеэ жаахан ч гэсэн уясган зөөлрүүлэх гэж үлгэр домог зохиох чадвартай гэдэг байлаа.

“Тэгвэл яагаад “нөгөө ертөнцөд” зарагдаж байгаа хүмүүсээс гадна мөн зарж байгаа хүмүүс ч итгэдэг байсан юм бэ? Яагаад дэлхийн бүх шашин “нөгөө ертөнц”-ийн талаар нэгэн зэрэг ярьдаг юм бэ? Яагаад бүх улс үндэстний хэлэнд “нөгөө ертөнц”, “диваажин”, “там” зэрэг үгтэй юм бэ?”- гэж би тэр үед гайхшаа барсаар, бурхангүй үзлийн хичээлийн шалгалтыг өгдөг байж билээ.

Коммунист номлолоор өвч хордсон ухаан санаанд минь “Овоо босгоогүй бол шаазгай суудаггүй” гэсэн энгийн үнэн бууж байсангүй. Тэнгис далайгаар тусгаарлагдсан янз бүрийн хүмүүс бүгд нэг зүйлд итгэдэг гэж үү! Тэгэхээр үнэхээр л бидний сэтгэлийн гүнд нууцлагдсан, эрт дээр үед бүх хүн төрөлхтнийг үүсгэсэн нэгдмэл үндэс байсан бололтой. Бурхан, Нөгөө Ертөнц, там, диваажингийн тухай Хутагт Гэгээнтнүүдийн түгээж, шашны дэлгэрүүлсэн мэдлэг нь хүний дотоод ухамсарын мөн чанартай нь таардаг байсан тул хүмүүс түүнийг нь хялбархан хүлээж авч байлаа. Зүгээр л зохиосон үлгэр домог ингэж олныг хамарч чадахгүй байсан байх.

Энэ бүлгийн эхэнд би шинжлэх ухааны дүн шинжилгээнд тулгуурлан Нөгөө Ертөнцийн бүтэц, зарчмыг дүрслэн бичихийг оролдлоо. Би ямар нэгэн зүйлийг баталж нотлох гэсэнгүй. Учир нь би дөнгөн данган “бурханы зарц” төдийхөн байтал харин миний судалж буй зүйл нь амьдрал, байгалийн мөн чанараараа надаас хамаагүй дээгүүр оршиж буй билээ. Нөгөө Ертөнцийн бүтцийн талаарх бодролоо төгсгөхдөө би оршин буйд нь өөрөө үнэхээр итгэдэг болсон гэдгийг л би хэлж чадах байна. Тийм ээ, бидний бодит бие махбодь үхсэний дараа бидний сүнс үхэлгүй Нөгөө Ертөнцөд үргэлжлэн амьдарсаар байдагт би одоо итгэдэг болсон. Газар дэлхий дээрх амьдрал эцэслэхэд бид энэ дэлхий дээр амьдарч байх үед эх болсон Нөгөө Ертөнцтэй холбоо тогтоох боломж өгдөггүй байсан “SoHm”-ийн зарчмаас чөлөөлөгдөх болно. Нөгөө Ертөнцөд бид хүний сүнсний мөн чанарыг тод мэдэрч, Нөгөө Ертөнц бидний эртний дээд эх нутаг маань учир дотно санагдах болно.

Бид бүгдийн нэгэн адил би “SoHm”-ын зарчмаар хязгаарлагдсан. Гэсэн ч там диваажингийн тухай үлгэр ч бас үнэн гэдэгт би итгэдэг. Нөгөө Ертөнцийн өндөр зохион байгуулалтанд газар дэлхий амьдралын үе шатыг хэрхэн өнгөрүүлснийх нь төлөө шийтгэх эсвэл шагнах бүтэц бүрэлдэн тогтсон байх ёстой. Эс бөгөөс Нөгөө Ертөнцийн болон Бурханы удирдлага алдагдаж, газрын амьдрал хаягдсан байх биз ээ. Газар дэлхий дээр амьдарч байх үеийн муу үйл, хүйтэн хөндий, назгайрсаны балгаар Нөгөө Ертөнцөд шийтгүүлж, харин сайн үйл, хайр энэрэл, өөрөө боловсорсон нь шагнуулах ёстой байдаг бололтой. Дараа дараачийн амьдралдаа газар дээрх хүн төрөлхтнийг алдаа бага гаргуулахын тулд үүнийг хийсэн. Шагнах, шийтгэх үйл явц хэрхэн явагддаг бол? Мэдэхгүй юм. Гэхдээ бид бүгдээрээ Нөгөө Ертөнцөд очсон хойноо үүнийг мэдэх болно. Зөвлөж чадах цорын ганц зүйл бол “Хайрлацгаа! Нигүүлсэнгүй өрөвч сэтгэлтэй байцгаа!” гэх байна.

Амьдралын хүрд (амьдрал- үхэл-амьдрал-үхэл) эргэлдсээр л байна. Хүмүүс бид, газар дэлхийн амьдралын үедээ “SoHm”-ын зарчмын нөлөөн дор эх болсон Нөгөө Ертөнцөө мартан, дараа нь дахин тэндээ эргэн очиж, хожим мөн л газар дэлхийн амьдралд, “SoHm”-ын зарчмын нөлөөн доороо эргэн ирж, дахин Нөгөө Ертөнцдөө эргэж очих маягаар тасралтгүй үргэлжилсээр хүн төрөлхтөн тасралтгүй хөгжсөөр байдаг.

Лемурчууд биднээс азтай байсан юм. Тэдний нийгэмд хорон муу санаа бага, сайн сайхан их байсан учир тэдэнд “SoHm”-ын зарчим нөлөөлдөггүй байсан. Тэд газар дэлхий дээр амьдарч байхдаа хүртэл өөрсдийгөө Нөгөө Ертөнцийн хүүхдүүд гэдгээ мартдаггүй бөгөөд айлтгүйгээр төрсөн нутагтаа эргэн очиж, бодит хэлбэрийн амьдралыг алхам алхамаар эзэмшихийн тулд дуулгавартайгаар газар дэлхий рүү эргэн ирдэг байлаа.

Ирээдүйд газар дэлхий дээрх эерэг хүч нь сөрөг хүчээ ялж, ямар ч гай гамшиг тохиолдохгүй байх гэж найдаж байна. Ингэсэн тохиолдолд газар дэлхий дээрх хүний нийгэмд Нөгөө Ертөнцөөс тусгаарлагч “SoHm”-ын зарчим нөлөөлөхгүй болж, цэвэр ариун сэтгэлтэй хүмүүс улам олон төрөх болно. Эдгээр хүмүүс хүн төрөлхтний амьдралыг үндсээр нь өөрчлөх нарийн ертөнцийн энергийг авчрах болно. Эд газар дэлхий дээр хүний гол мөн чанарыг буюу хүн бол макрокосмын микрокосм юм гэдгийг батлах болно. Тэгээд хэрвээ хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэл хоёр газар дэлхийн амьдралын муу муухайг үнэмлэхүй түвшинд ялан дийлэх юм бол “SoHm”-ын зарчмаас хүн төрөлхтөн тэр аяараа чөлөөлөгдөх болно. Тэр үед бүх хүн өөрсдийгөө Нөгөө Ертөнцийн хүүхдүүд гэдгээ мэдэрч, түүний агуу мэдлэгийг ашиглахын сацуу өөрсдийн мэдлэгийг ч мөн Нөгөө Ертөнцийн мэдээллийн оронд нэмэрлэх болно.

Тун ч ойрын ирээдүйд үлгэрийн мэт дүрслэлд үндэслээгүй, жинхэнэ шинжлэх ухааны үндэслэлтэй нэгдмэл нэгэн шашин үүснэ гэж би бодож байна. Улс гүрнүүдийн хил хязгаар арилж, нэг хэлтэй болно. Бодол санаагаараа харилцах арга хөгжиж эхлэнэ. Нөгөө Ертөнцийн удирдлагын төвийн буюу Бурханы жишгээр газар дэлхийн амьдралын нэгдмэл удирдлага бий болно. Хүмүүс Бурханаас яаж удирдахыг сурна. Тэд Бурханы нэгэн адил удирдахдаа муу муухайг бус зөвхөн сайн сайхан, хайр энэрэл дээр тулгуурлах болно.

Хөгжлийн хүчтэй, хурдацтай үйл явцаар хүмүүс бөөнөөрөө Бурхан, Нөгөө Ертөнцөд итгэдэг болж, өөрсдийгөө түүний нэгэн хэсэг нь гэдгээ мэдэрч эхлэнэ.

Номынхоо төгсгөлд би бичсэн бүхнээ дүгнэсэн зөвлөгөө өгмөөр байна. Гэсэн ч зөвлөгөө маань шашны жирийн номлол мэт болсныг би гэнэт ухаарав. Шүтэн биширсэн саарал хоолойгоор номлол айлдаж буй гэлэнгийн дүр зураг үүссэнд бүр сэтгэл хямарч орхилоо байна. Шашин ч тэр, бид ч тэр хүн төрөлхтнийг хөгжүүлэх зорилготой хүний өөрөө төгөлдөржих аргуудын талаар нэгэн дүгнэлтэнд хүрсэн учир ийм л байх ёстой гэдгийг ойлгосон юм. Зөвхөн үүний дараа л би Бурханд үнэн голоосоо итгэж, хэдэн мянган жил үргэлжилсэн зэрлэгшил, бүдүүлэг байдлын дундуур үнэн мэдлэгийг авч гарсан шашны зүтгэлтнүүдийг хүндэлдэг болсон юм.

Гэсэн ч хэдэн зөвлөгөө өгөхгүй бол тэвчишгүй нь ээ. Өглөө гадаа гарахдаа таарсан нэгнээ дулаахан харцаар шагнаж, таатай үг хэлэхийг хичээгээрэй. Хүмүүс тан руу зовлон жаргалаа ярин ирдэг болоход та өөрийгөө аз жаргалтайг мэдрэх болно. Үл ойлголцол болон муу муухайтай таарахдаа битгий бухимдаж, мууг муугаар хариулаарай. Ингэхгүй байх нь таны эрхэмсэг, бардам чанарыг илтгэх болно. Битгий хий хоосон номлогч болоорой. Ингэх нь утгагүй зүйл юм. Хөдөлмөр, үйл ажиллагаагаараа сайн сайхан тэртэй тэргүй муу муухайг ялан дийлнэ гэдгийг харуулаарай! Муу муухайтай тэмцэхгүйгээр яагаад ч хөгжихгүй. Сайн муугийн тэмцэл бол хүний мөн чанар юм гэдгийг ойлгоорой. Бусад хүмүүсийг муу муухай



*Бид цөм нөгөө ертөнцийн хүүхдүүд*

зүйл хийснийх нь төлөө эргэлзэлгүй шийтгэж байгаарай. Учир нь муу үйлийн төлөө хүнийг шийтгэх нь сайн хэрэг бөгөөд харин огт тоомсорлохгүй байх нь муу үйл юм. Өөрийн ухамсарт итгэж бай. Өөрийгөө ч хайрлахгүй шаргуу хөдөлмөрлө. Хүнийг өрөвд, хайрла, дурла...

Лемурын соёл иргэншлийг төсөөлөөд үз дээ! Тэдний үлгэрийн мэт соёл иргэншлийн үндэс нь болсон хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхэн сэтгэл ямар гайхалтай хүчтэй оргилж байсан юм бэ! Тэгвэл Бурханыг хийгээд тэдийг бүтээсэн Нөгөө Ертөнцөд хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл ямар санаанд багтамгүй хүчтэй ундарч байсан бол! Энэ бүхнийг бид тэнд очсон хойноо л үзэх болно...

### **Бид хэнээс үүссэн бэ?**

Уг асуултанд шууд утгаар нь хариулах юм бол аричууд бид атлантчуудаас үүсчээ. Харин газар дэлхий дээрх бүх хүн төрөлхтнийг Бурхан болон Нөгөө Ертөнц бүтээсэн. Хүн бол муу муухайг хайр энэрэл, нигүүлсэнгүй сайхан сэтгэл ялан дийлсэний үр дүн бөгөөд харин хайр энэрэл, нигүүлсэнгүй сэтгэл нь хүний боловсрон хөгжих гол үндсэн нөхцөл болдог.

Манай бодит ертөнцөд одоохондоо муу муухай дэндүү их байна. Тийм учраас биднийг баталгаажуулан даатгадаг юм. Газрын гүнд янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсээс бүрдсэн Хүн төрөлхтний Генийн Сан оршдог. Бидний хагас зэрлэг сониуч зан маань ямар ч үнэ цэнэгүй учраас тэднийг сониучирхан оролдож болохгүй. Хэрвээ бид мөхвөл тэд гарч ирэн газар дэлхийд шинэ амьдралын үрийг тарих болно.

Ийм юм бүү болоосой гэж хүсэж байвал маргааш гэрээсээ гарахдаа хүмүүсийг хайр энэрэлийн харцаар харахыг хичээгээрэй.

### **Төгсгөл**

Үүгээр бидний өгүүлэл төгсөөгүй. Шинэ шинжилгээний анги зохион байгуулж, олон шинэ судалгаа хийсээр байх болно. Энэ тухай та “Аргументы и Факты” сонин, шинээр хэвлэх номуудаас минь уншиж мэдээрэй.